# ӨНГӨРСӨНӨӨ ХАМГААЛЖ, ӨНӨӨГ ХАДГАЛЖ ҮЛДЭЭЕ

## ОЮУ ТОЛГОЙ ТӨСЛӨӨС ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ “ӨМНӨГОВЬ АЙМГИЙН СОЁЛЫН ӨВИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ” ТӨСЛИЙН НЭГДҮГЭЭР ҮЕ ШАТНЫ ТАЙЛАН


ЕРӨНХИЙ РЕДАКТОР Б.ГҮНЧИНСҮРЭН, ЖЕФФРЕЙ Х. АЛТШУЛ, ЖОН В. ОЛСЕН

Тайлан боловсруулсан:

SUSTAINABILITY EAST ASIA LLC

Састэйнабилити Ийст Азиа ХХК

Монгол Улсын ШУА-ийн Археологийн хүрээлэн

Статистикийн Судалгааны Төв

THE UNIVERSITY OF ARIZONA

Аризонагийн Их Сургууль




# Оюу Толгой ХХК

## СОЁЛЫН ӨВИЙН ХӨТӨЛБӨР
## ТӨСЛИЙН НЭГДҮГЭЭР ҮЕ ШАТНЫ ТАЙЛАН

**Тайлангийн дугаар.** IMM033_CHP_201103 PHASE 1 REPORT_MON_REV0

Тайлан боловсруулсан:

SUSTAINABILITY
EAST ASIA LLC

Састэйнабилити Ийст Азиа ХХК


**ТАЙЛАН БИЧСЭН:**

Б.ГҮНЧИНСҮРЭН

Ч.АМАРТҮВШИН

С.ЧУЛУУН

Ж.ГЭРЭЛБАДРАХ

Х.ЦОГТБААТАР

ЖЕФФРЕЙ Х.АЛТШУЛ

ВИЛЛИАМ И. ХЭЙДЕН

ЖЕФФРЕЙ А. ХОМБУРГ

ЖОН В.ОЛСЕН

Хамтран ажилласан:

Монгол Улсын ШУА-ийн Археологийн Хүрээлэн

Статистикийн Судалгааны Төв

THE UNIVERSITY OF ARIZONA

Аризонагийн Их Сургууль

**Хүснэгтийн тайлбар ....................................................................9**
**Зургийн тайлбар ....................................................................10**
**1. ТАНИЛЦУУЛГА....................................................................14**
1.1 СОЁЛЫН ӨВ....................................................................15
1.2 СОЁЛЫН ӨВ: БИЕТ БОЛОН БИЕТ БУС ӨВ....................................................................16
1.3 МОНГОЛ ОЛОН УЛСЫН ӨВИЙН БАГ....................................................................17
1.4 ТӨСЛИЙН ТҮҮХ....................................................................18
1.5 ТАЙЛАНГИЙН БҮТЭЦ....................................................................21
**2. БИЕТ ӨВ-АРХЕОЛОГИ....................................................................22**
2.1 СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ....................................................................22
2.1.1 Монгол Улсын соёлын өвийн талаарх ном зүй ....................................................................22
2.1.2 Баримт бичиг....................................................................24
2.2 НОМ ЗҮЙН СУДАЛГААНД ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ АРХЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ ТОЙМ ....................................................................24
2.3 ОЮУ ТОЛГОЙ ТӨСЛИЙН ШУУД НӨЛӨӨЛЛИЙН БҮС ДЭХ АРХЕОЛОГИЙН МЭДЭЭЛЭЛ....................................................................30
2.3.1 Ном зүйн судалгаа....................................................................30
2.3.2 Оюу Толгой төслийн шууд бус нөлөөллийн бүсэд хийгдсэн археологийн малтлага, судалгааны тойм ....................................................................32
2.4 ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ СОЁЛЫН ӨВТ ДУРСГАЛУУДЫГ ГАЗРЫН ЗУРАГТ БАРИМТЖУУЛАХ....................................................................39
2.5 ГАЗАРЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН САН ДАХЬ СОЁЛЫН ӨВҮҮД....................................................................40
2.5.1 Мэдээллийн сан дахь мэдээлэлүүд....................................................................40
2.5.2 Мэдээллийн сангийн бүтэц....................................................................40
2.5.3 Өгөдлүүдийг газарзүйн мэдээллийн системд хөрвүүлсэн нь ....................................................................42
2.5.4 Газарзүйн мэдээллийн систем дэх файлуудын тайлбар....................................................................43
2.5.5 Газарзүйн мэдээллийн систем дэх файлууд ба тэдгээрийн хүснэгтэн мэдээлэл, эх үүсвэр....................................................................45
2.6 АРХЕОЛОГИЙН ДУРСГАЛТ ГАЗРЫН БАЙРШЛЫГ УРЬДЧИЛАН ТОДОРХОЙЛОХ ЗАГВАР ....................................................................51
2.7 АРХЕОЛОГИЙН СУУРЬ СУДАЛГАА....................................................................60
2.7.1 2010 оны 8-р сарын 18-27-ны үед хийгдсэн хээрийн судалгааны ажлын хураангуй ....................................................................61
2.7.2 2010 оны 11-р сарын 11-20-ны өдрүүдэд хийгдсэн хээрийн судалгааны ажлын хураангуй ....................................................................63
2.8 МОНГОЛЫН АРХЕОЛОГИЙН ОРОН НУТГИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ХЭВ МАЯГ: ӨМНӨГОВЬ АЙМАГ....................................................................66
2.8.1 Монголын Археологийн үечлэл....................................................................67

2.8.2 Чулуун зэвсгийн үе ..... 68
2.8.3 Төмөр зэвсгийн үе ..... 70
2.8.4 Эртний улсуудын үе ..... 72
2.8.5 Түрэгийн үе ..... 75
2.8.6 Уйгурын үе ..... 76
2.8.7 Кидан ..... 76
2.8.8 Дундад зууны үе ..... 77
2.8.9 Өмнөговь аймагт явуулах археологийн судалгаанд ашиглах асуултууд ..... 79
2.8.10 Судалгааны зорилгод хүрэхэд шаардлагатай өгөгдлүүдийн категориуд ..... 80
2.8.11 Оюу толгой төслийн археологийн дурсгалууд ..... 81

2.9 СОЁЛЫН ӨВТЭЙ ХОЛБОГДОХ АСУУДЛААР ОЮУ ТОЛГОЙ КОМПАНИЙ ХИЙЖ БАЙГАА АЖЛУУД ..... 82
2.9.1 Эдгээр дурсгалууд ямар ач холбогдолтой вэ? ..... 85
2.9.2 Боломж ..... 87

**3. БИЕТ ӨВ —ПАЛЕОНТОЛОГИ ..... 88**

3.1 ЭРТНИЙ АМЬТАН, УРГАМЛЫН ҮЛДЭГДЛИЙН ТАЛААР ТА ЮУ МЭДВЭЛ ЗОХИЛТОЙ ВЭ? ..... 88
3.2 МОНГОЛ УЛСЫН ЭРТНИЙ АМЬТАН, УРГАМЛЫН ҮЛДЭГДЭЛ ЯАГААД ХАДГАЛАГДАХ ЁСТОЙ ВЭ? ..... 89
3.3 ОЮУ ТОЛГОЙ ТӨСЛИЙН БҮСЭД ХЭДЭН ТӨРЛИЙН, ЯМАР ПАЛЕОНТОЛОГИЙН ДУРСГАЛУУД ХАДГАЛАГДАЖ БАЙНА ВЭ? ..... 89
3.3.1 Байшин цав ..... 90
3.3.2 Хуурай цав ..... 92
3.3.3 Үрэлбэ Худаг ..... 92
3.3.4 Шар цав ..... 92
3.3.5 Амтгай ..... 93
3.3.6 Өмнөговь аймаг дахь палеонтологийн дурсгалт газруудын байршил ..... 94
3.4 МОНГОЛЫН ЭРТНИЙ АМЬТАН, УРГАМЛЫН ҮЛДЭЦИЙН БАЙДАЛ БА ТҮҮНД УЧИРЧ БУЙ АЮУЛ, ЗАНАЛ ..... 96
3.5 МОНГОЛ УЛСЫН ЭРТНИЙ АМЬТАН, УРГАМЛЫН ҮЛДЭЦИЙГ ХАМГААЛАХ ЗАГВАР ..... 97

**4. БИЕТ БУС ӨВ ..... 101**

4.1 ГОВИЙН СОЁЛ ..... 101
4.2 ГАЗАР НУТАГ БА ХҮМҮҮС ..... 102
4.3 СОЁЛ ..... 102
4.3.1 Аж үйлдвэржилт болон Гадныхны их түрлэг ..... 103
4.4 ӨМНӨГОВЬ АЙМГИЙН БИЕТ БУС ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА, ЧИГ ХАНДЛАГА ..... 104

4.5 МАТЕРИАЛЛАГ СОЁЛ ..... 106
4.5.1 Төмрийн Болон Мөнгөний Дарханы Урлал ..... 106
4.5.2 Ноён Сэврэйн хийцийн онцлог ..... 110
4.5.3 Мөнгөн дарханы хөөрөг ..... 111
4.5.4 Ноён Сэврэй хийцийн гөлөм, хазаар, дөрөө ..... 111
4.5.5 Үйсэн иштэй хутга хийх технологи ..... 113
4.5.6 Дарханы цавуу хийх технологи ..... 113
4.5.7 Мөнгөн гоёл чимэглэл, бугуйвчны урлал ..... 114
4.5.8 Дархан хүний гурван цээр ..... 114
4.5.9 Төмрийн болон мөнгөний дарханы талаарх дүгнэлт ..... 115
4.6 СОЁЛЫН ӨВИЙН БУСАД МАТЕРИАЛУУД ..... 116
4.6.1 Үе дамжсан тамхины хөөрөг ..... 116
4.6.2 Малын тамганы соёл ..... 117
4.6.3 Уламжлалт гэр ахуйн сав, эд зүйлсийн хэрэглээ ..... 117
4.6.4 Дуглуур тойрог хийх арга ухаан ..... 117
4.7 МОНГОЛ ГЭРИЙГ УРЛАХ, МОНГОЛ ГЭРТ АМЬДРАХ ..... 119
4.7.1 Гэрийн тавилга, засал ..... 120
4.8 ХҮНС, ХООЛ ..... 123
4.8.1 Хийцтэй цай ..... 123
4.8.2 Цулхир, бажууны гурил хийх арга ухаан ..... 123
4.9 НИЙГЭМ, ШАШИН, ХЭЛ ..... 125
4.9.1 Өмнөговь аймгийн оршин суугчдын шашин шүтлэг ..... 125
4.9.2 Бурхан тахил, шүтээн ..... 126
4.10 ХРИСТИЙН СҮМҮҮД ..... 128
4.10.1 Итгэгчид болон шүтэн бишрэгчид ..... 128
4.11 ОВГИЙН НЭР, УРАГ ТӨРЛИЙН ХЭЛХЭЭ ХОЛБОО ..... 130
4.12 ДУУ ХӨГЖИМ, ДУУЛААЧИД ..... 132
4.12.1 Уртын дуу, ерөөл магтаал ..... 132
4.13 АРДЫН ТОГЛООМ ..... 136
4.13.1 Чулуун гэр болон бусад тоглоом ..... 136
4.13.2 Шагайн харваа ..... 138
4.14 ГОВЬЧУУДЫН ХОРИО ЦЭЭРИЙН ЁС ..... 138
4.15 ӨВТ ГАЗРУУД: ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ТАХИЛГАТ ГАЗРУУД ..... 139
4.16 ОЮУ ТОЛГОЙ ТӨСЛИЙН ШУУД НӨЛӨӨЛЛИЙН БҮС ДЭХ ТАХИЛГАТ ГАЗРУУД ..... 143
4.17 ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ СОЁЛЫН ӨӨРЧЛӨЛТ БОЛОН УЛАМЖЛАЛЫГ ҮНЭЛЭХ НЬ ..... 144
4.17.1 Биет бус өвийн аль хэсэг нь өнөөг хүртэл оршин тогтнож байна вэ? ..... 144
4.17.2 Биет бус өвийн аль хэсэг эрсдэлд өртөөд байна вэ? ..... 187

4.18 ДҮГНЭЛТ ........................................................................................ 188

**5. ОЛОН НИЙТИЙН ХӨТӨЛБӨР .................................................. 189**

5.1 НОМ ЗҮЙН СУДАЛГАА ........................................................................ 189

5.1.1 Түшээт хан аймгийн Түшээт засгийн хошууны баримтын товч тойм ..................................................................... 191

5.1.2 Түшээт хан аймгийн Мэргэн засгийн хошууны баримтын товч тойм ..................................................................... 192

5.1.3 Сайн ноён хан аймгийн Ёст засгийн хошууны баримтын товч тойм ..................................................................... 192

5.2 МУЗЕЙ ........................................................................................ 195

5.2.1 ШУУД НӨЛӨӨЛЛИЙН БҮС ДЭХ МУЗЕЙ БОЛОН ТЭДГЭЭРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ........................................................................ 195

5.3 "ОЮУ ТОЛГОЙ" ТӨСЛИЙН ШУУД НӨЛӨӨЛЛИЙН БҮС ДЭХ СОЁЛЫН ТӨВҮҮД ........................................................................ 198

5.3.1 Сумын соёлын төвүүдэд шаардлагатай нөөц ба санхүүгийн дэмжлэг ..................................................................... 200

5.3.2 Өмнөговь аймгийн музейн үзмэрүүд ........................................ 202

5.3.3 Өмнөговь аймгийн шинэ музейд тавигдах шаардлага ................. 203

5.4 БОЛОВСРОЛ ........................................................................ 205

5.4.1 Соёлын өвийг боловсролтой уялдуулах нь ................................ 205

5.4.2 Насанд хүрэгсэд ба соёлын өвийн мэдлэг, боловсрол ................. 207

5.4.3 Иргэдийг чадавхижуулах ...................................................... 208

5.5 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ ........................................................................ 210

5.5.1 Шууд нөлөөллийн бүс дэх жуулчдыг татах үзмэрүүд.................... 210

5.5.2 Өмнөговь аймгийн аялал жуулчлалын цэгүүд ............................ 211

5.5.3 "Оюу Толгой" төслийн орчим соёлын өвийн аялал жуулчлалыг хөгжүүлэх нь ..................................................... 213

5.5.4 Өмнөговь аймагт соёлын өвийн аялал жуулчлалыг хөгжүүлэх ..................................................................... 217

5.5.5 Өмнөговь аймагт аялал жуулчлал хөгжүүлэхийн дутагдалтай талууд..................................................................... 221

5.6 СОЁЛЫН ӨВИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ АЖИЛД НУТГИЙН ИРГЭДИЙН ОРОЛЦОО ЗАЙЛШГҮЙ БОЛОХ НЬ........................................ 224

5.6.1 Одоо хэрэгжиж байгаа олон нийтийн хөтөлбөрүүд ...................... 225

5.6.2 Цаашид авч хэрэгжүүлэх хөтөлбөрүүд ........................................ 226

5.7 ОЛОН НИЙТИЙН ХӨТӨЛБӨРИЙН ТАЛААРХ ДҮГНЭЛТ.............................. 226

**6. НУТГИЙН ИРГЭД БОЛОН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЗӨВЛӨГӨӨН .......................................................................... 227**

6.1 ОРОЛЦОГЧ ТАЛУУДТАЙ ХИЙСЭН УУЛЗАЛТУУД...................................... 227

6.1.1 Ханбогд суманд хийсэн танилцуулах уулзалт.............................. 228

6.1.2 Түүх соёлын талаар сонирхдог иргэдтэй хийсэн уулзалт............. 228

6.1.3 Орон нутгийн байгууллагуудтай хийсэн уулзалтууд ..................... 229
6.1.4 Монгол Олон Улсын Өвийн Багийн Мэргэжилтнүүдийн Уулзалт ..................... 230
6.1.5 Зөвлөх Хорооны Уулзалт ..................... 232

**7. СОЁЛЫН ӨВИЙН ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН ..................... 236**

7.1 СОЁЛЫН ӨВТЭЙ ХОЛБООТОЙ МОНГОЛ УЛСЫН ХУУЛИЙН ТОЙМ ..................... 236
7.2 МОНГОЛ УЛСЫН НЭГДЭН ОРСОН СОЁЛЫН ӨВИЙН ТУХАЙ ЮНЕСКОГИЙН КОНВЕНЦИУД ..................... 237
7.3 СОЁЛЫН ӨВИЙН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ӨНӨӨГИЙН ОРЧИН ..................... 238
7.4 СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТАЛААР МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРААС АВЧ БУЙ АРГА ХЭМЖЭЭ ..................... 244
7.5 МОУӨБ-ЫН САНАЛ БОЛГОЖ БУЙ СОЁЛЫН ӨВИЙН ШИНЭ БҮТЭЦ ..................... 247

**8. СОЁЛЫН ӨВИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ЗӨВШӨӨРӨГДӨХ ХЭМ ХЭМЖЭЭ, ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭ ..................... 250**

8.1 СОЁЛЫН ӨВИЙН ЗӨВШӨӨРӨГДӨХ ӨӨРЧЛӨЛТИЙН ХЭМЖЭЭ ..................... 251
8.2 ЗӨВШӨӨРӨГДӨХ ӨӨРЧЛӨЛТИЙН ХЯЗГААРААС СОЁЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЗӨВШӨӨРӨГДӨХ ХЭМЖЭЭ РҮҮ ШИЛЖИХ ..................... 261
8.3 СОЁЛЫН ӨВИЙН ЗӨВЛӨХ ХОРОО ..................... 262
8.4 ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭ ..................... 262

**9. ДҮГНЭЛТ ..................... 275**

**10. ХАВСРАЛТ 1: ДУТАГДАЛТАЙ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ ..................... 277**

**11. ХАВСРАЛТ 2: НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ ..................... 288**

**12. ХАВСРАЛТ 3. ӨМНӨГОВЬ АЙМАГТ БУЛШЛАГДСАН ДУРСГАЛТ ГАЗАР ОЛДОХ МАГАДЛАЛЫГ ТОДОРХОЙЛОХ ГЕОАРХЕОЛОГИ ЗАГВАР ..................... 320**

**13. ХАВСРАЛТ 4. БИЕТ ӨВИЙН СУДАЛГААНЫ БАГИЙН 2010 ОНЫ 11-Р САРЫН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН ..................... 330**

**14. ХАВСРАЛТ 5. СОЁЛЫН ӨВИЙН ДУРСГАЛ ОЛДОХ ҮЕД БАРИМТЛАХ ЖУРАМ ..................... 368**

**15. ХАВСРАЛТ 6: ПАЛЕОНТОЛОГИЙН ХЭЭРИЙН АЯЛЛЫН ТАЙЛАН ..................... 374**

**16. ХАВСРАЛТ 7. БИЕТ БУС ӨВИЙН БАГИЙН БАРИМТЖУУЛАЛТ ..................... 378**

**17. ХАВСРАЛТ 8. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМАНД СОЁЛЫН ӨВИЙН ХӨТӨЛБӨРИЙН СУДАЛГААГААР АЖИЛЛАСАН ТАЙЛАН ..................... 382**

18. ХАВСРАЛТ 9. БИЕТ БУС ӨВИЙН 2010 ОНЫ 10-Р САРЫН ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН ....................................390
19. ХАВСРАЛТ 10. ОЛОН НИЙТИЙН ХЭСГИЙН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО..........................................446
20. ХАВСРАЛТ 11. НААДМЫН СУДАЛГААНЫ ЯВЦЫН ТАЙЛАН............449
21. ХАВСРАЛТ 12. НААДМЫН СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН ..................................................................452
22. ХАВСРАЛТ 13. ОЛОН НИЙТИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН..............................................475
23. ХАВСРАЛТ 14. СӨХ БОЛОВСРУУЛАХ ТӨСЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС.....................................................493
24. ХАВСРАЛТ 15. СӨХ-ИЙН ЗӨВЛӨХ ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ..........................................495
25. ХАВСРАЛТ 16. СОЁЛЫН ӨВИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ ЗӨЛДӨХ ХОРООНЫ УУЛЗЛАТЫН ТЭМДЭГЛЭЛ ..................................................................498

## Хүснэгтийн тайлбар

Хүснэгт 1. СӨХ боловсруулах төслийн ном зүйн судалгаа .......... 24
Хүснэгт 2. ОТ уурхайн талбай орчим хийсэн археологийн хээрийн судалгааны ажлын жагсаалт .......... 30
Хүснэгт 3 Оюу толгой төслийн орчимд байгаа археологи, палеонтологийн дурсгалт газрын талаарх мэдээлэл .......... 35
Хүснэгт 4 Оюу толгой орчимд буй археологийн дурсгалын төрөл зүйл .......... 38
Хүснэгт 5 Газарзүйн холболт хийхэд ашиглагдсан газрын зургууд .......... 44
Хүснэгт 6. Хээрийн судалгаагаар авсан мэдээлэл .......... 45
Хүснэгт 7: Өмнөговь аймгийн нутагт буй палеонтологийн дурсгалт газрын мэдээлэл .......... 94
Хүснэгт 8 Өмнөговийн нутаг дахь Христийн сүмүүд .......... 128
Хүснэгт 9 Шашин шүтдэг хүмүүс (сум, шашнаар) .......... 129
Хүснэгт 10 Багшид итгэдэг буддын шашин шүтдэг хүмүүс .......... 129
Хүснэгт 11 Баян-Овоо болон Манлай сумдын шашны зан үйлийн онцлогууд .......... 129
Хүснэгт 12 Өмнөговь аймгийн тахилгат газрууд .......... 140
Хүснэгт 13 Шууд нөлөөллийн бүс дэх хорио цээртэй газрын мэдээлэл .......... 145
Хүснэгт 14 Оюун толгойн зам, онгоцны буудал, цахилгаан станц, усны хоолойн дагуух тахилгат газар нутаг .......... 151
Хүснэгт 15: Оюу Толгой-Гашуун Сухайтын чиглэлийн зам болон Цахилгааны шон дагуух 15 км-ийн доторх уламжлалт ба тахилгат газрууд .......... 160
Хүснэгт 16 Өмнөговь аймгийн биет бус өв .......... 181
Хүснэгт 17 Түшээт хан аймгийн Түшээт засаг болон Мэргэн засаг, Сайн ноён хан аймгийн Ёст Засгийн хошууны түүхэн баримтын тоо .......... 191
Хүснэгт 18 Бурхны шашны хурал номын газрууд .......... 194
Хүснэгт 19 Өмнөговь аймаг дахь жуулчны баазууд .......... 218
Хүснэгт 20 Зөвлөх Хорооны гишүүд .......... 233
Хүснэгт 21 Соёлын өөрчлөлтийн зөвшөөрөгдөх хэм хэмжээ .......... 253
Хүснэгт 22 Эрсдлийн үнэлгээний матрицын жишээ .......... 265
Хүснэгт 23 Эерэг нөлөөллийн үнэлгээ .......... 270

## Зургийн тайлбар


Зураг 1. (а) Өмнөговь аймгийн газрын зураг (б) Оюу Толгой төслийн талбай, түүний шууд бус/Дам нөлөөллийн бүсүүд ............ 15
Зураг 2. Монголын Соёлын Өв Хөтөлбөрийн Олон Улсын Багийн бүтэц, зохион байгуулалт ............ 18
Зураг 3. Өмнөговь аймаг дахь уул уурхайн төслүүдийн хүрээнд хийгдсэн археологийн судалгаанууд ............ 29
Зураг 4. Оюу толгой төслийн орчимд одоогоор мэдэгдээд байгаа археологи, палеонтологийн дурсгалт газрын бүдүүвч зураг ............ 35
Зураг 5. Оюу Толгой орчмын талбайн 10 км-ын тойрог бүрээс олдсон дурсгалт зүйлсийн тоо ............ 38
Зураг 6. Өмнөговь аймгийн зүүн хэсэгт явуулсан археологийн судалгааны эхний хэсэгт хамрагдсан талбай, хэмжсэн цэгүүд болон уул уурхайн ашиглалтын талбайн байршил ............ 46
Зураг 7. Археологийн судалгаа явуулсан газар нутаг болон хэмжсэн цэгүүдийн байршлыг хэсэгчилсэн байдлаар үзүүлсэн зураг, Өмнөговь аймгийн зүүн хэсэг ............ 47
Зураг 8. Өмнөговь аймгийн баруун хэсэгт явуулсан археологийн судалгааны хоёрдугаар хэсэгт хамрагдсан талбай болон хэмжсэн цэгүүдийн байршил, Өмнөговь аймгийн баруун хэсэг ............ 48
Зураг 9. Археологийн судалгаа явуулсан газар нутаг болон хэмжсэн цэгүүдийн байршлийг хэсэгчилсэн байдлаар үзүүлсэн зураг, Өмнөговь аймгийн баруун хэсэг ............ 49
Зураг 10. Өмнөговь аймагт явуулсан археологийн судалгаанд хамрагдсан талбай болон хэмжсэн цэгүүдийн байршил ............ 50
Зураг 11. Газарзүйн мэдээллийн систем ашиглан урьдчилан таамаглах загвар боловсруулах алхамууд ............ 53
Зураг 12. Эцсийн байдлаар бэлэн болсон таамаглах загвар ............ 54
Зураг 13. Загварын байгаль орчны үзүүлэлтүүдийг харуулсан статистик график ............ 56
Зураг 14. Давхаргын бус болон гаралтын (гадаад) давхаргын зангилааг загварчилсан арга зүй ............ 58
Зураг 15 Оюут товгорын зэсийн ухмалын малтлага судалгааны явц болон зарим олдвор хэрэглэгдэхүүн ............ 81
Зураг 16 Оюу Толгойн зэсийн ухмалын ерөнхий байдал болон малтлагын зүсэлтийн зураг ............ 82
Зураг 17 Оюут товгорын ерөнхий байдал болон тухайн үеийн “Айвенхоу Майнз Монголия инк” компанийн зарим удирдлагууд ирж ажилтай танилцаж байгаа байдал ............ 83
Зураг 18 Мангасын хүрээний сансрын зураг ба дурсгалыг хууль бусаар ухаж сүйтгэснийг харуулсан зургууд ............ 84

Зураг 19 Монголын өмнөд хэсэг дэх палеонтологийн дурсгалууд ..................... 91
Зураг 20 а). Төмрийн дархан: Баян-Овоо сумын Хар заг багийн малчин Рашням бол Сунтагийн ач хүү бөгөөд түүний төмрийн дарханы хэрэглэж байсан гэрийн хана, гутлын шөвөг, төмрийн хасуур, хуурай зэрэг багаж хэрэгслийг (в) хадгалж байна; с). Баян-Овоо сумын Налих багийн өндөр настан Цэдэн-Иш Сунтаг дарханы хийсэн цоожийг 40 гаруй жил хэрэглэж байна. ................................................ 108
Зураг 21 Мөнгөний дархан ба мөнгөн эдлэл: а) Их дархан Ү.Батням, в) Ноён-Сэврэй хийцийн эмээл; с) хазаар, гөлөм; d) мөнгөн аяга; е) эмээлийн гөлөм; f) Дархан Борхүү гуай урласан мөнгөн аягын хамт .................................... 109
Зураг 22 а). Мөнгөний дархан: Ханбогд сумын Жавхлант багийн Хулгарын усанд нутагладаг Сайхансамбуугийн Батсүх в). Уран Базарын 1960-аад оны хийцийн мөнгөн аяга с). С. Батсүх гуайн хадгалж буй Монгол үндэстний төмөр тулга ........... 111
Зураг 23 Ханбогд сумын Жавхлан багийн Улаан толгойн усанд амьдардаг залуу малчин Ц. Алтангэрэл (а) өндөр Лувсангийн хийцийн бугуйвчийг долоон настайгаасаа хойш ээжээсээ өвлөн авч одоог хүртэл эдэлж хэрэглэж байна (b-e). ........................................................................ 112
Зураг 24 Үндэсний хөөрөг: а). Манлай сумын иргэн Шагдарсүрэн гуайд уг сумын сүүлчийн хошууны засаг ноён төрийн сайд дээдсийн хөөрөг бий. в). Ханбогд сумын Жавхлан багийн дархан Борхүүгийн хөөрөг, с). Баян-Овоо сумын Налих багийн дархан Л. Батаагийн хөөрөг................................. 116
Зуарг 25 Малын тамга: а). Ханбогд сумын Жавхлант багийн малчин С. Батсүхийн нүдтэй, амтай загасан тамга, b). Баян-Овоо сумын малчин Рашнямын П үсэг хэлбэрийн тамга ........................................................................................ 118
Зураг 26 Манлай сумын иргэн өндөр настан Сугир гуайн модон хөхүүр, хувингийн зүйлс ......................................................... 118
Зураг 27 Манлай сумын иргэн Жуулхүү гуай эхнэрийн хамт ширмэл ширдэг ширж байгаа нь ............................................... 119
Зураг 28 а) Баян-Овоо сумын Гүн хар уус хэмээх газар амьдардаг малчин Мөнхбат гуайн гэрийн "Хуруу тооно" b). Өвөрхангай аймгийн Уянгын хийцийн шинэ гэр, Ханбогд сумын малчин Лэнтэнгийнх.................................................... 120
Зураг 29 Баян-овоо сумын Хар Ус багийн Гүн хар уус хэмээх газар амьдардаг залуу малчин Мөнхбатын гэрийн тавилга, заслын ерөнхий байдал .......................................................... 121
Зураг 30 Хоол унд бэлтгэж буй байдал ................................................ 124
Зураг 31 Цулхирын гурил хийх: а). Баян-Овоо сумын Налих багийн өндөр настан Цэдэн-Иш гуай цулхир түүж, цулхирын будаа, гурил хийж байна, b). Түүж, хатаасан цулхир, с). Цулхирын будаа.............................................................. 124

Зураг 32 Ханбогд сумын төв дэх гандан ..... 126
Зураг 33 Бурхан тахил: a). Ханбогд сумын Хулгарын ус хэмээх газар өвөлжиж буй малчин С. Батсүхын бурхан тахил, b). Баян-Овоо сумын малчин, уртын дууч Цээнзэн гуайн бурхан тахил, c). Бурханы тахилын хайрцаг, d). Цөгц ба бурханы өргөл ..... 127
Зураг 34 Ургийн хэлхээ, холбоо: a). Баян-Овоо сумын ургийн хэлхээ холбоог Сүхбаатар гуай судалж үндсэн 3 овгоос гаралтай хэмээн үзэж байна, b). Ханбогд сумын тэмээчин Отгоолой Удайд овгийн хүн бөгөөд Удайд овгийнхон тахьдаг өөрийн овоотой ажээ. ..... 131
Зураг 35 Өмнөговь аймгийн уртын дуучид: a). Баян-Овоо сумын Хар заг багийн Хөх хадны бууцанд суудаг иргэн Цээнзэн, b). Баян-Овоо сумын Халих багийн иргэн Л. Батаа, c). Даланзадгад сумын иргэн Д. Бямбаа ..... 134
Зураг 36 Баян-Овоо сумын Налих багийн иргэн Ц.Төмөртогтохын багадаа тоглож байсан чулуун тоглоомын бууры ..... 137
Зураг 37 Цээнзэн гуайн хөвгүүд модон болон төмөр утсан тоглоом өөрсдөө хийж тоглодог байсан ба өнөөдөр үр хүүхдүүд нь ч бас тоглож байгаа юм байна. ..... 137
Зураг 38. Шагайн харваач: a). Ханбогд сумын Жавхлан багийн малчин Бандиа гуай, б). Бандиа гуай Ханбогд сумын шагайн харвааны багийн гишүүн ажээ. ..... 138
Зураг 39 Өмнөговь аймгийн биет бус өвт газрууд: a) Манлай сум, Ширнэн Хөөвөний морь уналгын газар, Зааны овоо, b). Мааньты Овоо, c). Нэр тодорхойгүй, d). Ханбогд сум, Жавхлант баг дахь 3 дуулга тахилгат уул, e). Баян-Овоо сумын Хар Заг баг, Шувуун Нумт Овоо, f). Нэр тодорхойгүй, g). Баян-Овоо сумын Налих баг, Үнэгэн хайрхан ..... 143
Зураг 40 Ханбогд Сумын Галба музей ..... 198
Зураг 41 Ханбогд сумын Соёлын Төв ..... 199
Зураг 42 Өмнөговь аймгийн музей (зүүн); Тэмээний үзэсгэлэн (баруун) ..... 203
Зураг 43 Аймгийн музейн шинээр барихаар төлөвлөөд байгаа барилгын бүдүүвч зураг ..... 204
Зураг 44 Өмнөговь аймгийн сургуулиуд ..... 205
Зураг 45 Соёлын өвийн аялал жуулчлалын нэг хэсэг болох говийн айлын ерөнхий байдал ..... 211
Зураг 46 Дэмчигийн хийд дэх дэлхийн энергийн төв ..... 214
Зураг 47 Дэмчигийн хийд ..... 215
Зураг 48 Өмнөговь аймаг дахь жуулчны баазын ерөнхий байдал ..... 222
Зураг 49 Соёлын өвийн асуудал хариуцсан болон дагнан гүйцэтгэх байгууллагын томьёолол ..... 242
Зураг 50 Археологийн дурсгалын тонон сүйтгэж байгаа шалтгаан ..... 247

Зураг 51 Бидний санал болгож буй Соёлын өвийг хамгаалах хууль эрх зүйн бүтэц ........ 248

## 1. ТАНИЛЦУУЛГА

**Жеффрей Х. Алтшул, Б. Гүнчинсүрэн, Жон В. Олсен**

Оюу Толгой компани 2010 оны 6 дугаар сарын 17-ны өдөр "Састэйнабилити Ийст Азиа" компаниар "Соёлын өвийн хөтөлбөр" боловсруулах ажил гүйцэтгүүлэхээр гэрээ байгуулсан билээ. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь "Оюу Толгой төслийн нөлөөгөөр соёлын өвд учирч буй аюул заналыг багасгах, зохицуулах, соёлын өөрчлөлтийг хянах, ойлгох, соёлын өвийг хадгалж хамгаалах болон энэ чиглэлээр ажилладаг ашгийн болон ашгийн бус олон нийтийн байгууллагуудад дэмжлэг үзүүлэх"-д оршино (ОТ 2009). Хэдийгээр Оюу Толгойн төслийн хамрах газар нутаг болох Ханбогд, Баян-Овоо, Манлай сумдын соёлын өвд гол анхаарал хандуулах боловч, Соёлын өвийн хөтөлбөр нь Өмнөговь аймгийг бүхэлд нь хамарч, улмаар Үндэсний хэмжээнд загвар хөтөлбөр болно гэдэгт итгэлтэй байна (Зураг 1).

Соёлын өвийн хөтөлбөр боловсруулах ажил нь хоёр үе шатад хуваагдана. Эхний үе шат нь соёлын өвийн суурь болон бодит байдлын үнэлгээ хийх, хоёрдугаар үе шат нь эхний үе шатанд цуглуулсан мэдээ, мэдээллээ соёлын өвийн хөтөлбөр болон түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулахад ашиглах. Энэхүү тайланд төслийн эхний үе шатанд хийгдсэн ажлууд, тэдгээрийн үр дүнг нэгтгэн оруулла.

(a)



(б)




**Зураг 1.** **(а) Өмнөговь аймгийн газрын зураг (б) Оюу Толгой төслийн талбай, түүний шууд бус/Дам нөлөөллийн бүсүүд**

## 1.1 Соёлын Өв

Соёл нь хүн төрөлхтөн оршин тогтнох үндэс суурь нь болдог. Угсаатан зүйн судлаачид энэ тодорхойлолттой төдийлөн санал нийлдэггүй боловч [Кроебер ба Клукхон 1952], ихэнх судлаачид соёлыг хүмүүс бие биенээсээ харилцан хамааралтай байдаг гэсэн хүрээгээр ойлгодог. Соёл нь итгэл үнэмшил, үнэт зүйлс, хэл, үзэл бодол, улс төр, нийгмийн байгуулал болон эдийн засгийн загваруудаас бүрдэнэ. Эдгээр ухагдахуунууд нь тус бүр чухал үзүүлэлтүүд боловч соёл гэдэгт эдгээрийг амьдралын хэв маягт нэгтгэсэн байдлаар авч үздэгт оршино.

Өв нь соёлын чухал хэсэг юм. Хүний бусад амьтдаас ялгарах онцлог нь бодож сэтгэж, зан үйлийг суралцаж чаддагт оршино. Нэг хүн Бантуд, нөгөө нь Хопид, бүр нөгөө нь Монголд хийсэн зүйлс тэдний соёл бөгөөд түүнээсээ суралцаж, мөн өнгөрснөөсөө сургамж авч байдаг. Заримдаа эдгээр нь илүү бодитой байдаг. Гэр бүлийнхний нь үлдээсэн жаахан ч гэсэн зүйл тухайн гэр бүлийн нандин өв болдог.

Соёлын өв нь энэхүү бодит байдлын жишээ бөгөөд түүнд олон зүйлс агуулагддаг. Тухайлбал, домгийн шинжтэй түүхэн үйл явдлууд нь ихэвчлэн уул, ус, бусад байгалийн бүрэлдхүүн хэсэгтэй холбогддог бөгөөд түүгээр дамжуулан түүний ач холбогдол, үнэ цэнийг залуу үедээ зааж сургадаг [Бассо, 1996]. Эдгээр үнэт зүйлс нь нийгмийн зан үйлээр дамжин уламжлагддаг. Шашны зан үйл, хурим найр, оршуулга, бүжиг, концерт болон хоол унд нь нийгмийн харилцааг бэхжүүлэх, давтах гэсэн жижигхэн хэсгүүд юм.

Монголчууд уламжлалт өв соёлоо өөрчлөлгүйгээр эдийн засгаа хөгжүүлэхийг зорьж байна. Өмнөговь аймгийн хөгжил дэвшил, соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын ажиллагаа төдийлөн тэнцвэртэй биш байна. Өмнөговь аймаг нь ашигт малтмалын нөөц арвинтай бөгөөд эдгээр нөөц дээрээ тулгуурлан эдийн засгаа хөгжүүлэх найдлага тавьж байна. Говь нутаг бол газар нутаг болон оюун санааны хувьд Монголын соёлын чухал нэгэн хэсэг юм. Нүүдэлчин амьдралын хэв маяг ч уг нутгийн хатуу ширүүн уур амьсгалтай холбоотой.

Соёлын өвийн хөтөлбөрийн зорилго нь уламжлалт соёлыг алдагдуулахгүйгээр эдийн засгийг хөгжүүлэх боломжийг судлахад оршино. Соёлын өвийн хөтөлбөр нь соёлийн өвт зүйлс, газар нутгаа хамгаалахаас илүү Монголчууд гэж хэн бэ, тэд хэн байсан бэ гэдгийг мэдсэнээр цаашид хэрхэн уламжлалаа хадгалан үлдэх үйл явцыг тодорхойлох чухал ач холбогдолтой юм.

## 1.2 Соёлын Өв: Биет болон Биет Бус Өв

ЮНЕСКО-ийн тодорхойлолтоор бол соёлын өвийг биет болон биет бус гэж хоёр ангилдаг [2007:97].

Биет болон биет бус соёлын өв нь дараах байдлаар ялгагдана. Биет өв гэдэгт ихэнх соёлын дурсгалт газрууд (яг бүгд ч биш) ордог ба эдгээр нь өнгөрсөн үеийн хүн төрөлхтний түүхийн хувьд үнэ цэнэтэй зүйл бөгөөд үзвэр үзэгчид, жуулчдад тухайн өнгөрсөн зуунд очсон мэт мэдрэмж төрүүлдэг. Биет бус соёлын өв нь нөгөө талаараа амьд өв юм. Бүжиг, хөгжим, театр, гар урлал нь тухайн ард түмний соёлын хувирал өөрчлөлтийг илэрхийлдэг ба соёлын олон янз байдлыг бий болгох гол хүч болдог. Эдгээр нь байгаль, түүхтэйгээ зохицон аливаа нэг үндэстэн, хамт олноос байнга үйлдэгдэж байдаг бөгөөд залгамж чанараа хадгалан үлддэг. Мөн байнга хувьсан өөрчлөгдөж байдаг бөгөөд хойч үедээ өвлүүлэн өгөх нь тухайн ард иргэдээс хамаарна.

Олон жилийн туршид, ихэвчлэн биет өвийг хадгалж хамгаалахад анхаарч байсан. Барилга байгууламж, археологийн дурсгалт газар, хөшөө дурсгал зэрэг нь үндэстний болон олон улсын хамгаалалтын жагсаалтад орон хамгаалагдаж ирсэн. Харин сүүлийн жилүүдэд биет бус өвд анхаарлаа хандуулах болсноор 2003 онд ЮНЕСКО-гоос "Биет бус соёлын өвийг хамгаалах тухай конвенци" баталсан билээ. Уг баримт бичигт, биет болон биет бус өв нь хоорондоо салшгүй холбоотой бөгөөд түүнийг цогцоор нь хадгалж хамгаалахын чухлыг ЮНЕСКО-гоос онцгойлон тэмдэглэсэн байна.

Биет болон биет бус соёлын өв нь бүхэлдээ дэлхийн уламжлалт соёлын баялаг, дэлхийн соёлын уламжлалын олон янз байдлыг илтгэн харуулдаг. Тиймээс 2004 онд биет болон биет бус соёлын өвийг хамгаалах цогц арга хэмжээ хэмээх "Яматогийн тунхаглал" гаргасан бөгөөд биет ба биет бус өвийг хамгаалах цогц арга хандлага шаардлагатай байгааг дахин нотолсон. Үнэхээр биет болон биет бус соёлын өвийг хамгаалах арга зам нь ижил төстэй юм [ЮНЕСКО 2007:97].

## 1.3 Монгол Олон Улсын Өвийн Баг

Бид соёлын өвийн хөтөлбөр боловсруулахдаа Монголын соёлын өвийн талаарх үндэсний туршлагыг өвийн менежментийн чиглэлийн олон улсын туршлагатай хослуулахыг зорьж Монгол олон улсын өвийн багийг байгуулсан билээ (Зураг 2). Доктор Б. Гүнчинсүрэн (ШУА-ийн Археологийн хүрээлэн), доктор Жон Олсен (Аризонагийн их сургууль), Жэфф Алтчул (Статистикийн судалгаа) нараар удирдуулсан МОУӨБ нь гурван дэд-багаас бүрдэнэ. Доктор Ч. Амартүвшин  (ШУА-ийн Археологийн хүрээлэн) биет өвийн багийг, доктор С. Чулуун (ШУА-ийн Түүхийн хүрээлэн) биет бус өвийн багийг, Доктор Ж. Гэрэлбадрах (МУБИС) олон нийтэд зориулсан хөтөлбөрийг удирдан ажилласан.

Төслийн 1-р үе шатны явцад багууд хамтдаа болон бие даасан байдлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн:

1. ном зүйн судалгаа;
2. олон нийт болон оролцогч талуудын зөвлөгөөн;
3. соёлын өвийг хамгаалах хууль эрхзүйн орчныг үнэлэх судалгаа;
4. дутагдалтай байдлыг илрүүлэх судалгаа;
5. хээрийн суурь судалгааны ажлууд юм.

Эдгээрийн дунд цуглуулсан мэдээллүүд нь эрсдлийн үнэлгээ хийж, байж болох өөрчлөлтийн хэмжээг тодруулахад ашиглагдах ба ингэснээр Соёлын Өвийн Хөтөлбөрийг боловсруулах нөхцөл, боломж бүрдэнэ.




**Зураг 2. Монголын Соёлын Өв Хөтөлбөрийн Олон Улсын Багийн бүтэц, зохион байгуулалт**

## 1.4 Төслийн Түүх

Төслийн 1-р шатны үйл ажиллагаа 2010 оны 6-р сард эхлэн 2011 оны 1-р сард дуусгавар болсон. Төслийн 1-р шатанд хийгдсэн үндсэн 8 ажлуудыг дурьдвал:

- Ном зүйн судалгаа
- Дутагдалтай байдлыг илрүүлэх судалгаа
- Хээрийн суурь судалгаа
- Олон нийт болон оролцогч талуудын уулзалт, зөвлөгөөн
- Соёлын өвд сөргөөр нөлөөлж буй хууль эрхзүйн орчинд хийх үнэлгээ
- Соёлын өвийн бүртгэл, зурагжуулалт
- Эрсдлийн үнэлгээ
- Соёлын өвийн бүтэц, тогтолцоонд гарч болох өөрчлөлтийн хэмжээг тодорхойлох

Төслийн 1-р үе шатны ажлууд амжилттай хэрэгжсэн хэдий ч зарим нэг судалгаанууд давхцаж хийгдэх тал ажиглагдсан ба эдгээрийг хамтад нь гүйцэтгэсэн бол илүү үр дүнтэй байх байсан. Хээрийн судалгааны ажлын үед төлөвлөхөд хүндрэлтэй асуудлууд гарч байсан тул судлаачид суурь судалгаа хийхийн зэрэгцээ орон нутгийн ард иргэдтэй уулзаж, мэдээлэл өгч, орон нутгийн номын сангууд дахь соёлын өвтэй холбоотой мэдээллүүдтэй танилцсан. Зөвлөх хорооны гишүүд нэгдүгээр үе шатны тайланг уншиж танилцсаны дараа Өмнөговь аймгийн соёлын өвийн талаар тодорхой ойлголттой болох тул эрсдлийн үнэлгээ хийх семинар болон соёлын өвийн байж болох өөрчлөлтийн хэмжээг төслийн 2-р үе шатны үед гүйцэтгэх нь хамгийн тохиромжтой юм.

Төслийн баг тус бүр соёлын өвтэй холбоотой хэвлэгдсэн болон хараахан хэвлэгдээгүй байгаа ном зохиолуудтай танилцах, тэднийг судлах ажлаар төслийн ажлаа эхлүүлсэн ба нилээдгүй хугацааг уг ажилд зарцуулсан. Ном зүйн судалгааны эхэнд бид олон тооны ном, зохиолууд цуглуулсан төдийгүй сумдаар явж тэнд буй соёлын өвтэй холбоотой материалуудын бүртгэлийг хийсэн.

Хээрийн ажлыг ном зүйн болон дутагдалтай байдлыг илрүүлэх судалгаануудын дараа хийхээр төлөвлөж байсан боловч Өмнөговь аймгийн "Наадам"-ын судалгааг цаг алдалгүй хийх үүднээс биет бус өвийн баг төслийн ажил эхэлсэн даруйд хээрийн судалгааны ажлыг эхлүүлсэн. Хээрийн судалгааны ажлуудын үеэр нутгийн иргэдтэй уулзаж, тэдэнд соёлын өвийн хадгалалт, хамгаалалт болон уг төслийн талаар тодорхой ойлголт өгөх боломж, нөхцөл бүрдсэн. Мөн уг хугацаанд судлаач Ч. Амартүвшин болон Б. Гүнчинсүрэн нар соёлын өвийн хадгалалт, хамгаалалттай холбогдох хууль, эрх зүйн орчинд анализ хийж, одоо байгаа эрхзүйн орчин болон үүнийг цаашид хэрхэн өөрчилж, сайжруулах талаар сум, аймаг, орон нутгийн болон үндэсний хэмжээнд хүмүүстэй уулзаж, санал солилцсон.

2010 оны 9-р сард болсон төслийн багийн нийт гишүүдийн уулзалтын үед Монголын талын судлаачид өөрсдийн судалгааны анхан шатны үр дүнгээ танилцуулсан ба багийн гишүүд Улаанбаатар хот болон Өмнөговь аймагт нийт 10 өдрийн турш ажилласан. Багийн гишүүд Оюу Толгой (ОТ) болон бусад уурхайн талбайнуудаар зочилж, шууд нөлөөллийн бүсэд буй нутгийн иргэдтэй уулзалт зохион байгуулж, аймаг сумын удирдлагуудад ажлаа танилцуулж, Даланзадгад хотын Музей, Соёлын төв, Номын сан болон бусад өвт газруудтай танилцсан. Аяллын туршид Монголын багийн гишүүн бүр холбогдох олон улсын судлаачидтай нягт ажиллаж байсан бөгөөд соёлын өвийн одоогийн байдал, СӨХ боловсруулахын тулд цаашид юу хийх хэрэгтэй талаар төлөвлөж, бүгд нэгдсэн ойлголтод хүрсэн. Хээрийн ажлын үр дүнг "ОТ" ХХК-д танилцуулсан илтгэлийг хэлэлцүүлсэн. Мөн оныхоо 10-р сард дутагдалтай байдлыг илрүүлэх судалгааны дүгнэлтийг бэлэн болгосон (Хавсралт 1).

Багийн нийт гишүүдийн уулзалтын дараа баг тус бүр хээрийн суурь судалгааны ажлуудыг гүйцэтгэсэн. Өмнөговь аймаг дахь археологийн дурсгалуудын талаарх мэдээллийг мэдээллийн санд нэгтгэж оруулсан. Ингэснээр газарзүйн мэдээллийн системийг ашиглан одоо мэдэгдэж буй дурсгалт газруудыг зураг дээр тэмдэглэн, археологийн дурсгал байх магадлалтай газруудыг урьдчилан таамаглах загвар боловсруулсан төдийгүй загварыг шалгах хээрийн судалгаа хийсэн. Биет бус судалгааны багийнхан нутгийн иргэдийн амьдралын хэв маяг, ёс заншил, онцлогийг судлаж байх явцад олон нийтийн хөтөлбөрийн судлаачид сум болон аймгийн соёлын аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж, соёлын төвүүдийн үйл ажиллагааг судласан. Өвлийн улирал, цаг агаарын улмаас палеонтологийн хээрийн ажил хойшлогдсон ба 2-р үе шатны үед уг судалгааг хийхээр төлөвлөж байна.

Соёлын Өвийн Хөтөлбөр (СӨХ) боловсруулах ажлын чухал хэсгүүдийн нэг нь эрсдлийн үнэлгээний семинар болон соёлын өвд гарч болох өөрчлөлтийн хэмжээг тодорхойлох ажлууд юм. Эдгээр 2 ажлууд нь олон талаараа хоорондоо нягт уялдаатай тул бид хамтатган зохион байгуулахаар шийдсэн. Соёлын өвийн зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хэмжээний бүтэц, тогтолцоо нь СӨХ-ийн туршид үргэлжилнэ. Уг процессууд бие даасан, үл хамаарах байдлаар явагдах ба Монгол Олон Улсын Өвийн Баг болон “ОТ” ХХК хамтран Өмнөговь аймгийн соёлын өвтэй холбоотой ажилладаг 15 хүний бүрэлдэхүүнтэй “Зөвлөх хороо”-ны гишүүдийг сонгосон. “Зөвлөх Хороон”-ы гол бүтэц, үүрэг нь СӨХ боловсруулахтай холбоотой ажлаар иргэдийн санаа бодлыг төлөөлөх, хяналт тавих юм. Мөн, “Зөвлөх хороо”-ны гишүүд эрсдлийн үнэлгээний семинарт оролцоно. Уул уурхай болон бусад салбарын төлөөлөл болсон 5 хүн соёлын өвийн эрсдлийн үнэлгээний семинарт оролцох ба уг уулзалтаас өмнө гишүүдэд СӨХ боловсруулах хөтөлбөртэй холбоотой мэдээллүүдийг урьдчилан хүргүүлэх тул тэд урьдчилан тодорхой ойлголттой болох боломжтой. Зөвлөх хорооны гишүүдэд хамгийн сайн мэдээлэл өгч чадах баримт бичиг нь төслийн 1-р үе шатны тайлан юм. Бид энэ тайланг Зөвлөх хорооны гишүүдэд хүргүүлэхэд хангалтгүй байсан тул семинарыг 2 дах үе шатны дараа хийхээр хойшуулсан.

## 1.5 Тайлангийн бүтэц

Төслийн 1-р үе шатны тайлан 9 бүлэгтэй. Энэхүү танилцуулгын дараа баг тус бүрийн тайлан орсон. Мөн биет өвийн багийн тайлан археологи (Бүлэг 2) ба палеонтологийн (Бүлэг 3) гэсэн 2 хэсгээс бүрдэнэ. Тайлангийн 4, 5 дугаар бүлгүүдэд биет бус өвийн судалгааны ажил, олон нийтийн хөтөлбөрийн үр дүнгийн талаар тус тус тусгасан. Төслийн судалгааны 1-р үе шатны гол ажлуудын нэг нь оролцогч талууд болон нутгийн иргэдтэй хийх уулзалт байсан ба эдгээр уулзалтуудын талаар 6-р бүлэгт өгүүлсэн. Соёлын өвтэй холбоотой одоо мөрдөгдөж буй үндэсний болон олон улсын хууль тогтоомж, эрх зүйн актуудын талаар 7-р бүлэгт дэлгэрэнгүй авч үзсэн ба цаашид ямар байдлаар өөрчилж, сайжруулах талаарх саналууд тусгагдсан. Тайлангийн 8-р бүлэгт нэгдүгээр үе шатны тайланд үндэслэн Өмнөговь аймгийн эрсдлийн үнэлгээ болон байж болох өөрчлөлтийн хэмжээг хэрхэн тодорхойлох талаар бичсэн ба төслийн эхний үе шатны дүгнэлтийг 9-р бүлэгт харуулсан болно.

Тайлан нийт 16 хавсралттай. Хавсралт 1-д дутагдалтай байдлыг илрүүлэх судалгаатай холбоотой "ОТ" ХХК-д бэлтгэж өгсөн баримт бичгийг оруулсан. Хавсралт 2-т ашигласан ном зүй, бусад материалуудын жагсаалтыг үзүүлэв. Хавсралт 3-т Өмнөговь аймаг дахь археологийн дурсгал газруудын олдох магадлалыг харуулсан гео-археологийн загварын үр дүн, Хавсралт 4-т 2010 оны 11-р сард хийсэн хээрийн судалгааны ажлын тайлан, Хавсралт 5-т Монгол Олон Улсын Өвийн Багийн бэлтгэсэн төслийн ажлын үед олдох магадлалтай дурсгалтай хэрхэн харьцах журам зэргийг тус тус хавсаргав. Биет бус өвийн судалгааны ажил нь нийт 3 хавсралттай ба эдгээр нь судалгааны ажлын хүрээнд багийн цуглуулсан материалуудын жагсаалт (Хавсралт 6) ба хээрийн судалгааны ажлуудын тайлан (Хавсралт 7, 8) болно. Олон нийтийн судалгааны хөтөлбөртэй холбоотой 4 хавсралт тайланд багтсан ба эдгээр нь багийн гүйцэтгэсэн 3 хээрийн судалгааны ажлуудын товч тайлан (Хавсралт 9), Өмнөговь аймгийн Наадмын судалгааны товч ба дэлгэрэнгүй тайлан (Хавсралт 11, 12), олон нийтийн хөтөлбөрийн хээрийн судалгааны ажлын тайлан (Хавсралт 13) болно. Хавсралт 14-д МОУӨБ-ын бэлтгэсэн СӨХ боловсруулах төслийн талаарх мэдээллийн хуудсыг оруулсан бол Хавсралт 15 нь "Зөвлөх хороо"-ны багийн ажиллах чиг үүргийг харуулсан баримт юм. Хавсралт 16 нь Оюу Толгой дах СӨХ-ийн "Зөвлөх Хороо"-ны хурлын протоклуудаас бүрдэл болсон.

## 2. БИЕТ ӨВ-АРХЕОЛОГИ

**Ч. Амартүвшин, Б. Гүнчинсүрэн**

Соёлын өвийн хөтөлбөр боловсруулахад хийх ёстой нэн тэргүүний алхам нь Өмнөговь аймаг дахь соёлын өвийн талаар одоогоор мэдэгдээд буй антропологи, археологи, түүх, палеонтологийн баримтуудыг цуглуулах судлах явдал юм. Эдгээр баримт, ном зохиолуудыг цуглуулсны дараа СӨХ боловсруулахад шаардлагатай ямар мэдээлэл, судалгаанууд дутагдаж байгааг тодорхойлно.

Ном зүйн судалгаанд баримталсан арга зүй, цуглуулсан материалуудыг хэрхэн электрон хэлбэрт оруулж баримтжуулсан талаар болон урьдчилан таамаглах загварыг хэрхэн боловсруулсныг энэ бүлэгт өгүүлнэ. Мөн түүнчлэн баг тус бүрийн биет ба биет бус өв, олон нийтэд зориулсан олдворын талаарх тайлан, ном зүйн судалгааны үр дүн багтсан.

### 2.1 Судалгааны Арга Зүй

### 2.1.1 Монгол Улсын соёлын өвийн талаарх ном зүй

Ном зүйн судалгааны үр дүнг ойлгохын тулд бид Монгол Улсын шинжлэх ухааны ном зохиолуудын хэвлэгдсэн байдлын талаар тодорхой ойлголттой байх ёстой. Соёлын өвийн талаарх бүтээлүүд гэдэгт биет, биет бус өвтэй холбоотой эрдэм шинжилгээний нэг сэдэвт болон хамтын бүтээлүүд, эрдэм шинжилгээний болон сурталчилгааны өгүүллүүд багтана. Харин Өмнөговь аймгийн хувьд ийм төрлийн тусгайлсан бүтээл хараахан гараагүй боловч энэ хүрээнд хамааруулан авч үзэх зүйлс нэлээд тоотойгоор байдаг.

Орчин үеийн шинжлэх ухааны үндэстэй судалгааг монгол хүн эх орондоо явуулах боломж нөхцөл Монгол оронд үндэсний ардчилсан хувьсгал ялан мандаж, улс үндэстнийхээ сэргэн мандлыг зарлан тунхагласан XX зууны эхэн үеэс бүй болсон юм. 1921 оны 11 дүгээр сарын 9-нд Ардын Засгийн газрын шийдвэрээр эрдэм номын ажлыг эрхлэх Судар бичгийн хүрээлэнг байгуулсан нь эдүгээгийн Монгол улсад шинжлэх ухаан, тэргүүний технологийг хөгжүүлэх эрхэм зорилго бүхий шинжлэх ухааны төв байгууллага болох Шинжлэх Ухааны Академийн эх үүсвэр болжээ.

Судар бичгийн хүрээлэнгээс 1924 оны 8 сарын 7-нд батлан гаргасан "Хуучны зүйлийг сахин хамгаалах дүрэм" бол манай улсад эртний түүх, соёлын үнэт зүйлсийг үнэлж үзэх, судлан шинжлэх, хадгалж хамгаалах талаар гаргасан анхны чухал баримт бичиг байв. Монгол улсын хэмжээнд дагаж баримталж байснаас гадна гадаад оронтой байгуулсан эрдэм шинжилгээний гэрээ, хэлэлцээрт тусган мөрдөж байжээ.

Монголын эртний судлал нь анх үүссэн цагаасаа олон улсын хамтын ажиллагааны шинжтэйгээр хөгжиж ирсэн түүхтэй билээ. Шинэ тулгар байгуулагдсан Судар бичгийн хүрээлэнгээс гадаадын шинжлэх ухааны байгууллага, эрдэмтэн судлаачидтай холбоо тогтоож, хамтран ажиллахад онцгой анхаарч тодорхой үр дүнд хүрч байсны нэгээхэн хэсэг нь Монгол орныг археологийн талаар шинжлэн судлах зорилготой холбоотой байсныг олон жишээ баримтаар батлаж болох юм. Тэр үеийн Судар бичгийн хүрээлэнд уригдан ажиллаж байсан В.И. Лисовский, В.А. Казакевич, Г.И. Боровка, С.А. Кондратьев, П.К. Козлов, С.А. Теплоухов, А.Д. Симуков, Б.Я. Владимирцов, Б. Барадин, Л.А. Амстердамская, Б.Б. Бамбаев, С.И. Руденко, Д.Д. Букинич нарын зэрэг Орос-Зөвлөлтийн судлаачдын эртний судлалын чиглэлээр гүйцэтгэсэн томоохон судалгааны ажлын зэрэгцээ хөрөнгөтөн орон (тухайн үеийн нэршлээр)-ы зарим эрдэмтэд ч Монголд ихээхэн амжилттай ажиллаж чухал үр дүнд хүрч байсныг тэмдэглэх нь зүйтэй. Үүнд, 1922-1923, 1925 онд Монголын өмнөд бүс нутагт анх удаа палеонтологи-археологийн дорвитой шинжилгээ хийсэн Америкийн Нэгдсэн Улсын Байгалийн Түүхийн Музейн судлаач Р.Ч. Эндрюсийн удирдсан Төв Азийг судлах гуравдугаар экспедицийг дурдаж болно.

Үүний зэрэгцээ Монголын хөдөө орон нутагт археологийн судалгааны анхны алхам болох хайгуулын ажлыг Монголын сэхээтнүүд бие даан явуулж, түүвэр хэрэглэгдэхүүн цуглуулж байсан баримт бий. Тухайлбал, 1920-иод оны дунд үед Судар бичгийн хүрээлэнд Өмнөговиос Даш, Дорнодоос Буддарь нарын хүмүүс чулуун зэвсгийн олдвор цуглуулан илгээж байсныг 1933-1934 онд Монголд ажилласан Зөвлөлтийн эрдэмтэн Д.Д. Букинич нэр заан тайландаа тэмдэглэсэн байдаг.

Шинжлэх ухааны хүрээлэнгээс ийнхүү хөдөө орон нутгийг судлахад анхаарал тавьж, хуучны соёл түүхийн дурсгалт зүйл, хөшөө, бичигт чулуу, чухал булш хиргисүүр зэргийг олж илрүүлэх, тэдгээрийг тэмдэглэн авахын тулд орон нутгийг судлах төлөөлөгчидтэй болох, шинжлэх ухааны мэдлэгийг ард түмэнд түгээх, өөрийн хүрээлэнгийн зорилт, үйл ажиллагааг сурталчлах, хүрээлэнг олон түмэнтэй холбож, тэдний туслалцаа дэмжлэгийг авч байхын тул төлөөлөгч, сурвалжлагч нарыг томилох асуудлыг 1934 онд хүрээлэнгийн тэргүүлэгчдийн хурлаар хэлэлцэж хөдөө орон нутагт үүрүүд байгуулахыг Засгийн газарт мэдэгдэж зөвшөөрүүлсэн байна. Эхлээд Улаанбаатар, Төв, Дорнод, Увс аймагт орон тооны сурвалжлагч ажиллуулж, тэдгээрийг төвөөс удирдан чиглүүлж байхын тулд хүрээлэнгийн дэргэд хөдөө орон нутгийг судлах товчоо байгуулан ажиллуулж 1940-өөд оны үед хэлтэс болон өргөтгөжээ.

Шинжлэх ухааны хүрээлэнгийн ажил өргөжин, бичиж туурвих нь нэмэгдэхийн хэрээр бүтээлүүдээ нийтлүүлж олны хүртээл болгох сэтгүүлтэй болох шаардлага гарч ирсэн. Ийнхүү хүрээлэн өөрийн сэтгүүлтэй болох санааг сэдэж "Шинжилгээний мэдээ" нэрээр гаргахаар төлөвлөсөн боловч гарч амжилгүй байсаар 1935 онд "Шинэ толь" нэртэйгээр анхны дугаар нь нийтлэгдсэн байна. Энэ сэтгүүлийн 1936 оны эхний дугаарт Ж. Цэвээний бичсэн "Монголын хуучин судлалын тухай асуудал" хэмээх өгүүлэл бол археологийн судалгааны талаар монгол эрдэмтдийн туурвисан анхны бүтээл байв.

### 2.1.2 Баримт бичиг

Хөтөлбөр боловсруулах ажлын эхний шат буюу номзүйн судалгааны хүрээнд биет, биет бус, олон нийттэй харилцах гэсэн гурван баг тус тусдаа олон тооны ном бүтээлийн жагсаалт гаргасан байна (Дэлгэрэнгүй жагсаалтыг Хавсралт 2-оос үзнэ үү).

**Хүснэгт 1. СӨХ боловсруулах төслийн ном зүйн судалгаа**

| № | | | Цуглуулсан бүтээлийн тоо |
|---|---|---|---|
| 1 | Биет өв | Археологи | 170 |
| | | Палеонтологи | 80 |
| 2 | Биет бус өв | | 8 |
| 3 | Олон нийтийн хөтөлбөр | | 36 |
| | Нийт | | 294 |

Тайлангийн дараагийн бүлгүүдэд баг тус бүрийн ном зүйн судалгааны үр дүнгүүдээс танилцуулна. Бүх багуудын ном зүйн судалгаанд ашиглагдсан ерөнхий баримт бичгүүд нь "ОТ" ХХК-ий өгсөн "Өмнөговь аймгийн суурь судалгаа-2008" [Улаанбаатар, 2008] болон "Оюу Толгой төслийн нийгэм эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ (эцсийн тайлан)" [Улаанбаатар, 2009] болно. ОТ төслийн нийгэм эдийн засгийн суурь үнэлгээ нь төслийн эерэг болон сөрөг нөлөөллийн талаарх иргэдийн санал бодлыг тусгасан тайлан юм. Уг тайланд өгүүлснээр нутгийн иргэдийн хамгийн ихээр санаа зовниж буй асуудал нь "соёлын өв" болж байна. "Өмнөговь аймгийн суурь судалгаа-2008" судалгаа нь нэлээд дэлгэрэнгүй, соёлын өвтэй холбоотой нарийвчилсан судалгаа шинжилгээний ажилд түлхүү анхаарсан байна.

## 2.2 Ном зүйн судалгаанд Өмнөговь аймаг дахь археологийн судалгааны тойм

XIX зууны эцэс XX зууны эхэн гэхэд Монгол орны байгаль, газарзүй, түүх соёлын дурсгалыг судлах ажилд Орос, Америк, Швед, Японы эрдэмтэд оролцож байжээ. Анх 1878-1879 онуудад М.В. Певцов Алтай хангайн нуруу, их нууруудын хотгороор аялахдаа Өмнөговь аймгийн газарзүйн онцлог, уур амьсгалаараа хангайн бүсээс

ялгагдах онцлогыг тогтоосноороо судалгааны эх сурвалж тавигдсан гэж үзэж болно. Энэ ч утгаараа Өмнөговь аймгийн нутагт газарзүйн эрдэмтэн судлаачид анхаарлаа хандуулж байсан байна. XX зууны эхэн хагас буюу 1921 оны хувьсгал ялснаас хойш үеэс Монгол орны байгаль газарзүй түүх соёлыг судлах ажил өрнөж тухайн үед байгуулагдсан Монголын шинжлэх ухааны байгуулага болох Шинжлэх ухааны хүрээлэн, улсын музей байгуулагдан хуучны дурсгал судлан цуглуулах ажил эхэлснээр уг бүс нутагт эртний түүх судлал хөгжсөн болно.

Үүний дараа 1922-1925 онд Америкийн эрдэмтэн Р.Ч. Эндрюсийн удирдсан экспедиц нь 1922 онд Хаалганаас Өргөө, Мишиг гүн, Сайн ноён ханы өргөө, Таацын Цагаан нуур Бага Богд, Говийн Алтайн нурууны Гурван Сайхан, Баянзаг, Сайр-Ус хаалган, 1923 онд Хаалган, Баянзаг, Таацын цагаан нуур, Бага Богд, Хаалган, 1925 онд Хаалган, Баянзаг, Орог нуур, Их Богд, Баянзаг, Хялга, Хөх хотын замаар, Борзон гэсэн замаар тус тус аялсан байна.

1940-өөд оноос, Монголын анхны үндэсний археологичид гадаадын судлаачидтай хамтарсан болон бие даасан судалгаануудыг хийж эхэлсэн юм. 1957 онд Х. Пэрлээ Өмнөговь аймгийн Долоон, Цогтцэций, Аргалант, Номгон, Ханхонгор, Мандал-Овоо сумдад хайгуул судалгааны ажил хийж гүйцэтгэсэн байна. Хийгдсэн ажлын үр дүнд тус хайгуул шинжилгээний анги нь Өмнөговь аймгийн Аргалант сумын нутаг дахь Годил балгас, Номгон сумын нутагт буй Шар толгойн хэрэм, Баянбулагийн туурь зэрэг эртний хот суурингийн үлдэгдлийг үзэж судлан ерөнхий дэвсгэр зургийг үйлдсэн байна.

1960 онд МЗТСХЭ–ийн чулуун зэвсгийг судлах ангид Монголын талаас археологич Н. Сэр-Оджав Д. Дорж, Ц. Доржсүрэн, Зөвлөлтийн талаас профессор А.П. Окладников, эрдэм шинжилгээний ажилтан В.В. Волков хамтарсан хайгуул судалгааны ажил хийсэн. Уг ажлын хүрээнд тус анги нь Өмнөговь аймгийн Манлай сумын нутаг Хар аргалант хэмээх ууланд Монголын үеийн булш малтан шинжилсэн бөгөөд уг булшнаас ширэн хавтага, төмөр хутга, ширэн хоромсогтой нимгэн арьсаар бүрж хийсэн наамал модон нум, эмээлийн мод, сумны төмөр зэв зэрэг зүйлс илрүүлэн олсон байна[1]. Мөн тус ангийнхан Гурван Сайханы нурууны хойд болон өмнөд талаас олон арван чулуун зэвсгийн дурсгал илрүүлэн олсон байна[2].

[1] Н.Сэр-Оджав, Д.Дорж нар. МЗТСХЭ-ийн тайлан. ТХГБСХ. УБ.,1960

[2] А.П. Деревянко, Д. Дорж, Р.С. Васильевский, В.Е. Ларичев, В.Т. Петрин, Е.В. Девяткина, Е.М. Малаева. Палеолит и неолит Монгольского Алтая. Новосибирск, 1990, тал 53

1970 онд Өмнөговь аймгийн ихэнх сумдаар “Говийн бүсийн экспедици” Д. Наваанаар ахлуулан ажиллажээ. Үүнд, Манлай сумын Говийн төхөмд малтлага хийж хүрэл, төмөр боловсруулж байсныг илрүүлсэн бол 1976 онд Номгон сумын нутаг дахь Баянбулагийн турьт сорилт малтлага хийж 200 гаруй төмөр шилбэт хүрэл зэв төмөр зэрэг эд өлгийн зүйлс олжээ. Баян-Овоо сумны нутаг дахь Хан хадны булшийг малтан судлаж Хүннүгийн үед холбогдох дурсгал хэмээжээ. Мөн, Номгон сумын Алтан үнэгтээс 54 ширхэг Ү-шү зоос олсон байна[3].

1971 онд МЗТСХЭ-ийн хуучин чулуун зэвсгийн дурсгал судлах анги Өмнөговь аймгийн Булган сумын нутаг Баянзаг хэмээх газраас зэсийн хайлш, хүрэл хутганы хугархай, нимгэн бөөрөнцөг бүхий шавар савны хагархай мөн Гурвантэс, Сэврэй зэрэг сумдын нутгаас чулуун зэвсгийн үеийн үлдэц, хусуур, ялтас, залтас зэрэг олдворууд олж судалгааны ажлын талаар эрдэм шинжилгээний тайлан бичсэн байна. Уг экспедицийн бүрэлдэхүүнд, Монголын талаас археологич Д. Дорж, Зөвлөлтийн талаас А.П. Окладников, А.П. Деревянко, А.П. Алексеев, Р.С. Василевский, В.Е. Ларичев нар ажилласан байна[4].

1985 онд МЗТСХЭ-ийн хуучин чулуун зэвсгийн дурсгал судлах анги Өмнөговь аймгийн нутгийн зарим хэсэгт ажилласан байна. Монголын талаас, археологич Д. Дорж, Д. Цэвээндорж, Зөвлөлтийн талаас А.П. Деревянко, А.П. Алексеев, Р.С. Василевский, В.Е. Ларичев, В.Т. Петрин нарын судлаачид чулуун зэвсгийн болон хүрлийн эрт үед холбогдох дурсгалт газруудыг шинээр нээн олж эрдэм шинжилгээний тайлан бичсэн байна[5].

---

[3] Д. Наваан. 1976 оны хээрийн экспедицийн тайлан. ТХГБСХ, УБ.,1976
[4] Д.Дорж, А.П.Окладников. МЗТСХЭ-ийн хуучин чулуун зэвсгийн үе судлах анги. ТХГБСХ. УБ.,1971
[5] Д.Дорж, Д.Цэвээндорж. МЗТСХЭ-ийн хуучин чулуун зэвсэг судлах ангийн тайлан. ТХГБСХ. УБ.,1985

1988 онд Өмнөговь аймгийн нутагт ажилласан хээрийн шинжилгээний анги тус аймгийн Цогт-Овоо, Номгон, Цогтцэций, Баяндалай, Гурвантэс, Сэврэй, Булган, Хүрмэн сумдын нутгаар 10 сарын 25-аас 11 сарын 17-ныг хүртэл ажилласан байна. Уг экспедицийн бүрэлдэхүүнд Н. Сэр-Оджав, Т. Санжмятав нар оролцсон бөгөөд Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын нутаг Их Баяны агуйгаас алдагдсан эмээл нум сумыг сурвалжлан олж агуйд үлдэж хоцорсон зүйлсийг нь тэмдэглэн авч зарим зүйлсийг нь Улаанбаатар хотноо авчирсан байна. Гурвантэс, Сэврэй, Булган, Цогт-Овоо, Хүрмэн сумдын Орон нутаг судлах кабинетэд байгаа археологийн дурсгалт зүйлүүдийг үзэж танилцан уг сумдын нутгаас шинээр хадны зураг, хүн чулуун хөшөө олж илрүүлэн судалгааны эргэлтэнд оруулжээ. Хүрмэн сумын нутагт 4 булангаа өндөр шон чулуутай (зүүн урд булангийн шон чулуунд наран зүг хандуулан нэгэн буга зурсан) дөрвөлжин булш нэгийг малтан судалжээ[6].

1990 онд Монгол-Зөвлөлтийн хамтарсан хээрийн шинжилгээний анги Өмнөговь аймгийн Номгон сумын нутагт ажилласан байна. Экспедицийн бүрэлдэхүүнд, Монголын талаас Д. Цэвээндорж, З. Батсайхан, Зөвлөлтийн талаас П.Б. Коновалов нар оролцсон. Тус ангийнхан Номгон сумын Баянбулагийн сууринд туршилтын хоёр малтлага хийж улмаар уг сумын нутагт орших чулуун зэвсгийн үеийн Бяруухайн сууринд гүймэг ажиглалт хийгээд цахиур чулуугаар хийсэн ялтас, хусуур, үлдэц зэрэг шинэ чулуун зэвсгийн үеийн дурсгалыг шинээр илрүүлэн олсон байна[7].

1995, 1996 онд Монгол-Орос-Америкийн хамтарсан "Монголын чулуун зэвсгийн үе" төслийн археологийн шинжилгээний анги нь Өмнөговь аймгийн Булган, Гурван тэс, Сэврэй сумдын нутгаар хайгуул, малтлаг судалгаа хийсэн. Монголын талаас, Д. Цэвээндорж, Б. Гүнчинсүрэн, Оросын талаас, А.П. Деревянко, В.Т. Петрин, А.Н. Зенин, Америкийн талаас Ж. Олсен, Р. Ривс, эрдэм шинжилгээний ажилтан Ж. Брантингхэм нар оролцсон хээрийн шинжилгээний ангийнхан Булган сумын нутаг Цахиуртын хөндийд нийт 5 хэсэг газарт малтлага судалгаа хийж хуучин чулуун зэвсгийн бүх үеүдэд холбогдох 3.000 орчим чулуун зэвсгийг олж цуглуулжээ[8].

---

[6] Н.Сэр-Оджав, Д.Наваан. Өмнөговь аймгийн нутагт ажилласан хээрийн шинжилгээний анги. ТХГБСХ. УБ.,1988

[7] Д.Цэвээндорж, З.Батсайхан, П.Б.Коновалов. Монгол-Зөвлөлтийн хамтарсан хээрийн шинжилгээний анги. ТХГБСХ, УБ.,1990

[8] А.П. Деревянко, Д. Олсен, Д. Цэвендорж, В.Т. Петрин, А.Н. Зенин, А.И. Кривошапкин, Р.У. Ривс, Е.В. Девяткин, В.П. Мыльников. Археологические исследования Российско-Монгольско-Американской экспедиции в Монголии в 1995 г. Новосибирск, 1996; А.П. Деревянко, Д. Олсен, Д. Цэвэндорж, В.Т. Петрин, А.Н. Зенин, А.И. Кривошапкин, Р.У. Ривс, С.В. Николаев, В.П. Мыльников, Б. Гунчинсурэн, Я. Цэрэндагва. Археологические исследования Российско-Монгольско-Американской экспедиции в Монголии в 1996 г. Новосибирск, 1998; А.П. Деревянко, А.Н. Зенин, Д. Олсен, В.Т. Петрин, Д. Цэвээндорж. Палеолитические комплексы Кремневой долины (Гобийский Алтай). Новосибирск, 2002

2000 онд тус аймгийн Даланзадгад хот, Ноён суманд археологич У. Эрдэнэбат, Ч. Амартүвшин нар ажиллажээ. Тэд, Даланзадгад хотноо Өмнөд говийн улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргаанаас эрхлэн зохион байгуулсан "Өмнөд говийн улсын тусгай хамгаалалттай газрууд болон ойр орчмын нутгийн байгалийн нөөц түүнийг зохистой ашиглан хамгаалах үндэслэл" сэдэвт эрдэм шинжилгээний хуралд оролцож Өмнөговь аймгийн нутаг дахь түүх соёлын дурсгал болон түүнийг хадгалан хамгаалах сэдвээр илтгэл тавьж хэлэлцүүлжээ. Улмаар Өмнөговь аймгийн Ноён сумын нутаг дахь Цагаан Ханангийн агуйгаас эртний нэгэн шарил олдсоныг ухвар мөчид хүн тонон сүйтгэсэн гэсэн мэдээллийн дагуу газар дээр нь очиж шалгалт малтлага хийж цэнхэр торгоны болон улаан даавууны тасархайнууд, цагаан эсгийний тасархай, шарил дор дэвсэж байсан бололтой зэгс дэрс, сийрсэн зүйлүүд бог малын 3 ширхэг нурууны яс, хүрэл гархи, самрын яс болон элдэв шүр, шилэн сувсыг хооронд нь хэлхсэн зүүсгэл нэг ширхэг, даавуун хавтага, даавуун уут, хугархай модон сам зэрэг эд өлгийн зүйлс эргүүлэн олсон ба агуй дотор буцааж тавьсан болон сумын төвд айлын хашаанд хадгалж байсан шаталгүй үлдсэн авсны модыг цуглуулан авчирчээ[9].

Өмнөговь аймгийн нутагт дээрх судалгааны ажлуудын үргэлжлэл болгон авран хамгаалах судалгааны цоо шинэ ажлууд эхэлсэн билээ. Өмнө нь дурдсан "Айвенхоу Майнз Монголия Инк", "Оюу толгой" компаний ашиглалтын талбайд хийсэн судалгаанаас гадна 2008-2010 онуудад Цогтцэций сумын нутагт үйл ажиллагаагаа явуулж байгаа "Энержи Ресурс" компанийн Ухаа Худаг нүүрсний уурхайн ашиглалтын талбайд, 2009 онд Ханхонгор сумын нутаг дахь "Хангад Эксплорейшн" ХХК-ны "Баруунназран" ашиглалтын талбайд, 2010 онд Мандал-Овоо сумын нутаг дахь "Жаст" ХХК-ны "Олон овоот гоулд" алтны уурхайн ашиглалтын талбай, Гурвантэс сумын нутаг "АГМ Майнинг" ХХК-ны "Торомхон" ашиглалтын талбай, Хүрмэн сумын нутаг "Тасархай дэл" ашиглалтын талбай, мөн сумын нутаг дахь "Алтан Эрдэнэ Газар" ХХК-ны ашиглалтын талбай зэрэг олон тооны уул уурхайн компанийн ашиглалтын талбайд хайгуул судалгааны ажлыг зохион байгуулсан билээ (Зураг 3).

[9] У.Эрдэнэбат, Ч.Амартүвшин. Өмнөговь аймгийн нутагт ажилласан хээрийн шинжилгээний ангийн тайлан. ТХГБСХ. УБ.,1999




**Зураг 3.** **Өмнөговь аймаг дахь уул уурхайн төслүүдийн хүрээнд хийгдсэн археологийн судалгаанууд**

Өмнөговь аймгийн нутагт буй археологийн дурсгалын тоог нарийвчлан гаргах боломж одоогоор бүрдээгүй байгаа хэдий ч өөрсдийн мэдэлд байгаа хэрэглэгдэхүүнд тулгуурлан 606 дурсгал бий гэсэн тоог гарган ажиллаж байна. Энэхүү дурсгалуудын тархалтыг ажиглахад аймгийн нийт газар нутгийг бүхэлд нь хамаарч чадахгүй байгаа нь доорхи хэдэн шалтгаантай хэмээн үзэж байна. Үүнд, хайгуул судалгааны ажил нь тодорхой хүрээнд сонгогдсон талбай (уул уурхайн компаний ашиглалтын талбай), сонгогдсон судалгааг (чулуун зэвсгийн, хот суурины гэсэн судалгааны чиглэл заасан төсөл хөтөлбөр) хамаарч байгаатай холбоотой юм. Мөн бүс нутгийн алслагдсан байдал, цаг агаар, уур амьсгалын эрс тэс байдал зэргээс гадна Монголын археологийн судалгааны цаашдын бодлого, чиглэлд тухайн бүс нутагт хийх судалгаа нилээн хэтийн хугацаатай тавигдсан зэргээс хамааралтай хэмээн үзэж болох юм.

## 2.3 Оюу толгой төслийн шууд нөлөөллийн бүс дэх археологийн мэдээлэл

### 2.3.1 Ном зүйн судалгаа

Археологи, палентологийн холбогдох хууль дүрмийн дагуу "Оюу Толгой" ХХК нь Соёлын өвийн хөтөлбөр боловсруулах төслийн шууд нөлөөллийн газарт олон тооны төслүүдийг санхүүжүүлж хэрэгжүүлсэн байна. Эдгээр шууд нөлөөллийн бүсэд уурхайн талбай, Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад зэрэг сумд орно. 2001 оноос хойш ШУА-ийн Археологийн хүрээлэнгээс холбогдох хууль, журмын биелэлт ямар түвшинд хэрэгжиж байгаа талаар судалгаа хийж, малтлага хайгуулаас илрүүлсэн олдворууд дээр бүрэн хэмжээний судалгаа шинжилгээний ном тайлан гаргажээ. Эдгээр тайлангуудын жагсаалтыг Хүснэгт 2-т үзүүлэв.

**Хүснэгт 2. ОТ уурхайн талбай орчим хийсэн археологийн хээрийн судалгааны ажлын жагсаалт**

| No | Судлагдсан газар | Бүрэлдэхүүн | Он | Ажлын зорилго | Судалгааны үр дүн |
|---|---|---|---|---|---|
| 1 | Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Оюу толгой дахь "Айвенхоу Майнз Монголия Инк" ХХК-ны ашиглалтын талбай | Д.Цэвээндорж Б.Гүнчинсүрэн Я.Цэрэндагва | 2001 | Хайгуул | Эртний зэсийн ухмал олж илрүүлсэн байна. |
| 2 | Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Оюу толгой дахь "Айвенхоу Майнз Монголия Инк" ХХК-ны ашиглалтын талбай | Д.Цэвээндорж Б.Гүнчинсүрэн Я.Цэрэндагва | 2002 | Хайгуул, малтлага судалгаа | Эртний зэсийн 4 ухмалын малтлага судалгаа, Жавхлант хайрханы хадны зургийн судалгаа |
| 4 | Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Оюу толгой дахь "Айвенхоу Майнз Монголия Инк" ХХК-ны ашиглалтын талбай | Д.Цэвээндорж Б.Гүнчинсүрэн Я.Цэрэндагва Н.Батболд Д.Базаргүр Ц.Болорбат Ж.Гантулга | 2003 | Хайгуул | чулуун зэвсгийн бууц суурин, хүрэл төмөр зэвсгийн үеийн 51 дурсгал илрүүлэн олжээ. |
| 5 | Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Оюу толгой дахь "Айвенхоу Майнз Монголия Инк" ХХК-ны ашиглалтын талбай | Ч.Ерөөл-Эрдэнэ Ж.Гантулга | 2005 | Хайгуул судалгаа | Хүрэл төмрийн үеийн 23 дурсгал илрүүлэн олжээ. |
| 6 | Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Оюу толгой дахь "Айвенхоу Майнз Монголия Инк" ХХК-ны ашиглалтын талбай | Д.Цэвээндорж Б.Гүнчинсүрэн Ч.Амартүвшин Н.Батболд Д.Базаргүр Ц.Болорбат Ж.Гантулга Ч.Ерөөл-Эрдэнэ | 2005 | Малтлага судалгаа | Хүрэл төмрийн үеийн 13 булшийг малтан судалсан байна. |
| 7 | Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Оюу толгой | Б.Гүнчинсүрэн Ч.Амартүвшин | 2005 | Хайгуул судалгаа | Хүрэл төмрийн үеийн 10 дурсгал илрүүлэн |

| No | Судлагдсан газар | Бүрэлдэхүүн | Он | Ажлын зорилго | Судалгааны үр дүн |
|---|---|---|---|---|---|
| | дахь "Айвенхоу Майнз Монголия Инк" ХХК-ны ашиглалтын талбай | Ж.Гантулга Ч.Ерөөл-Эрдэнэ | | | олжээ. |
| 8 | Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Оюу толгой дахь "Айвенхоу Майнз Монголия Инк" ХХК-ны ашиглалтын талбай | С.Хүрэлсүх Р.Мөнхтулга | 2005 | Малтлага судалгаа | XIX зууны Дэмчигийн хийдийн туурийн малтлага судалгааг гүйцэтгэжээ. |
| 9 | Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Оюу толгой дахь "Айвенхоу Майнз Монголия Инк" ХХК-ны ашиглалтын талбай | Ч. Амартүвшин | 2006 | Хайгуул судалгаа | Хүрэл төмөр, хүннү, түрэгийн үеийн 10 дурсгал илрүүлэн олжээ. |
| 10 | Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Оюу толгой дахь "Айвенхоу Майнз Монголия Инк" ХХК-ны "Heruga" ашиглалтын талбай | Ж.Гантулга П.Алдармөнх | 2008 | Хайгуул судалгаа | 21 дурсгал илрүүлэн олжээ. |
| 11 | Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг "Оюу толгой" компанийн талбай орчимд тавигдах хатуу хучилттай замын трассын дагуу | Г.Галдан | 2010 | Хайгуул судалгаа | 3 дурсгалт газар илрүүлэн олжээ |
| 12 | Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг "Оюу толгой" орчимд шинээр байгуулагдах нисэх онгоцны буудлын зурвас газар | Б.Гүнчинсүрэн Ч.Амартүвшин | 2010 | Хайгуул судалгаа | Дурсгалт газар олдоогүй |

2001 онд анх Д. Цэвээндорж, Б. Гүнчинсүрэн нарын бүрэлдэхүүнтэй баг Оюу Толгой орчимд бэсрэг хайгуулын ажлыг гүйцэтгэснээр тухайн бүс нутгийн судалгааны ажил эхэлсэн байна. Үүнээс хойш 2004, 2007 оноос бусад жилүүдэд хайгуул, малтлага судалгааны ажлыг нийтдээ 12 удаа зохион байгуулсан байна. Эдгээр хээрийн судалгааны тайланд тусгагдсан дурсгалын байршил, төрөл зүйл, он цагийн асуудалд тулгуурлан цаашид хийх ажлын төлөвлөгөө, хөтөлбөрийг боловсруулж байгаа билээ.

Дээр дурдсан хайгуул, малтлагын явцад гарсан зарим үр дүнг нэгтгэн Д. Цэвээндорж, Я. Цэрэндагва, Б. Гүнчинсүрэн, Д.Гарамжав нар "Жавхлант хайрханы хадны зураг" (2004), Д. Цэвээндорж, Д. Гарамжав, Б. Гүнчинсүрэн, Я. Цэрэндагва, Ж. Гантулга, Ч. Амартүвшин, Т. Мөнхбат нар "Ханбогдын хадны зураг" (2010) гэсэн нэгэн сэдэвт бүтээлийг уншигчдын гарт хүргэсэн билээ. Энэхүү бүтээлүүд нь биет өвийн судалгааны багийн ном зүйн судалгаанд голлох үүргийг гүйцэтгэнэ.

Мөн 2005 онд Жавхлант багийн нутагт хийсэн авран хамгаалах малтлага судалгааны үр дүнд илэрсэн оршуулгын зан үйлийн өвөрмөц хэлбэр нь эрдэм шинжилгээний өгүүлэл, ОХУ, Япон, БНХАУ-д болсон олон улсын эрдэм шинжилгээний хурал, МУИС-ын магистрын дипломын ажилд дурдагдан хэлэлцэгдсээр байгаа билээ. Үүнийг дурдах болсон шалтгаан нь нөлөөллийн бүсэд байгаа дурсгалын шинжлэх ухааны болон эрдэм шинжилгээний үнэ цэнэ, түүний эрсдэлийн үнэлгээг тогтооход чухал нөлөө үзүүлэх болов уу хэмээн үзэж байна.

2005 онд Ханбогд сумаас урагш 70 гаруй км зайд буюу Галбын говьд нэгэн шороон хэрэм байгааг мэдээллийн дагуу үзэж танилцан түүнийг эрдэм шинжилгээний тайландаа тэмдэглэсэн билээ. Энэхүү шороон хэрмийг нутгийнхан Мангасын хүрээ хэмээн нэрийддэг бөгөөд тэндээс олдож буй олдвор хэрэглэгдэхүүнд тулгуурлан одоогоос 2000 гаруй жилийн тэртээ Хүннү гүрний үед байгуулж байсан хот болохыг тогтоогоод байна [Амартүвшин нар, 2009]. Уг шороон хэрмийн үлдэгдэл нь Монгол улсын биет өвийн чухал дурсгалын нэг хэмээн үзэж судлаачдын саналаар 2008 онд аймгийн тусгай хамгаалалттай түүх соёлын дурсгалын бүртгэлд оруулсан юм.

Ийнхүү тухайн бүс нутагт хийсэн археологийн хайгуул, малтлага судалгааны үр дүнг нэгтгэн гаргасан эрдэм шинжилгээний бүтээлүүд нь Монголын археологийн судлагдахуунд тодорхой байр суурийг эзлэж, эрдэм шинжилгээний эргэлтэнд орж байна.

### 2.3.2 Оюу Толгой төслийн шууд бус нөлөөллийн бүсэд хийгдсэн археологийн малтлага, судалгааны тойм

Монгол улсын уул уурхайн салбарт 2000 оноос гадны томоохон хөрөнгө оруулагчид орж ирсний нэг бол "Айвенхоу Майнз Монголия инк" компани бөгөөд тэд Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Оюу толгойд геологийн эрэл хайгуулын ажлаа эхлүүлсэн байна. Үүнтэй зэрэгцэн тус компанийн ашиглалтын талбайд Монгол улсын Соёлын өвийн тухай болон бусад хууль тогтоомжийн дагуу археологийн авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажил хийгдсэн билээ. Энэхүү авран хамгаалах судалгааны ажлыг Монгол улсын ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний баг дагнан гүйцэтгэв.

2001 онд анх тус хүрээлэнгийн захирал, доктор, профессор Д. Цэвээндорж, доктор Б. Гүнчинсүрэн нарын бүрэлдэхүүнтэй баг Оюу толгой орчимд бэсрэг хайгуулын ажлыг гүйцэтгэсэн байна. Энэхүү хайгуулын явцад хүрэл зэвсгийн үед хамаарагдах зэс олзворлож байсан ухмал болон бутлуур чулуу, чулуун зэвсгийн зүйлс зэргийг илрүүлэн олжээ.

Дараа жил нь буюу 2002 онд өмнөх жилийн хайгуулын үр дүнд илэрсэн дурсгалуудын заримыг малтан судалсан байна. Судалгааны багийн бүрэлдэхүүнд доктор, профессор Д. Цэвээндорж, Б. Гүнчинсүрэн, Я. Цэрэндагва нар оролцон ажиллажээ. Энэхүү хээрийн шинжилгээний явцад Оюу толгойгоос баруун урагш 17 км зайд орших Жавхлант хайрхан уулын хадны зургийг хуулбарлан авч хожим 2004 онд "Айвенхоу Майнз Монголия Инк" компанитай хамтран "Жавхлант Хайрханы хадны зураг" хэмээн нэгэн сэдэвт бүтээлийг хэвлүүлсэн [Цэвээндорж нар, 2004].

2003 онд Оюу толгойгоос Гашуун Сухайт буюу Монгол улсын хил хүртэл шинээр тавих замын дагуу археологийн авран хамгаалах хайгуулын ажлыг гүйцэтгэсэн байна. Хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд доктор, профессор Д. Цэвээндорж, Б. Гүнчинсүрэн, Я. Цэрэндагва нар оролцон ажилласан байна. Хайгуулын явцад 61 дурсгал шинээр илрүүлэн олжээ [Цэвээндорж нар, 2003].

2005 онд Оюу толгой орчимд усны суваг татах трассын дагуу хайгуулын ажлыг доктор Б. Гүнчинсүрэн, Ч. Амартүвшин, Ч. Ерөөл-Эрдэнэ, Ж. Гантулга нарын бүрэлдэхүүнтэй нэмж гүйцэтгэв. Хайгуулын явцад 5 дурсгал шинээр илрүүлэн олсноос [Гүнчинсүрэн нар, 2005] гадна Далайн дуулга, Шийр уул, Цагаан толгой, Зүүн хацавч зэрэг газруудаас хадны зургийн шинэ дурсгал, Галбын говьд Мангасын хүрээ хэмээх МЭӨ I- МЭ I зуунд хамаарагдах эртний хотын турийг тэмдэглэсэн байна.

Мөн онд, 2003 онд илрүүлэн олсон дурсгалуудын заримаас сонгон малтлагын ажлыг гүйцэтгэв. Уг хээрийн шинжилгээний ангийн бүрэлдэхүүнд доктор, профессор Д. Цэвээндорж, Ч. Амартүвшин, Б. Гүнчинсүрэн, Б. Цогтбаатар нар оролцон ажилласан болно. Судалгааны хүрээнд 13 дурсгал хамрагдсан бөгөөд үүнээс хүрэл зэвсгийн үед холбогдох дөрвөлжин булш, шоргоолжин булш, хиргисүүр зэргээс онц сонирхолтой олдвор хэрэглэгдэхүүн гарсан байна [Цэвээндорж нар, 2005]. Энэхүү малтлагын үеэр зарим хайгуулын ажлыг гүйцэтгэж эртний нүүдэлчдийн зэс хайлуулж байсан зуухны үлдэгдэл шинээр илрүүлэн олсон билээ.

2006 онд Оюу толгойд шинээр баригдах нисэх онгоцны буудлын талбай, шинээр тавих автозам болон усны сувгийн дагуух археологийг авран хамгаалах хайгуулын ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд, доктор Ч. Амартүвшин, Б. Гүнчинсүрэн нарын судлаачид оролцон ажилласан бөгөөд нийт 19 орчим дурсгал илрүүлэн олсон байна [Амартүвшин нар, 2006].

Хоёр жилийн дараа буюу 2008 онд "Айвенхоу майнз Монголия Инк" компани, "Онтре гоулд" ХХК-уудын хамтын өмчлөлийн "Heruga" ашиглалтын талбайд судлаач Ж. Гантулга, П. Алдармөнх нарын бүрэлдэхүүнтэй баг ажиллаж нийт 21 дурсгал илрүүлэн олсон байна [Гантулга нар, 2008].

2010 онд Оюу толгойгоос урагш шинээр тавьж буй хатуу хучилттай авто замын трассын дагуу судлаач Г. Галдан хайгуулын ажлыг гүйцэтгэж нийт 3 дурсгал шинээр илрүүлэн олсон байна. Үүний дараагаар Б. Гүнчинсүрэн, Ч. Амартүвшин нар Оюу толгойд шинээр баригдаж буй нисэх онгоцны буудлын зурваст хийсэн хайгуулын явцад дээрх трассын дагуух хайгуулыг дахин шалгажээ [Гүнчинсүрэн нар, 2010]. Мөн онд, Ч. Ерөөл-Эрдэнэ, Ж. Гантулга нар эрчим хүчний шугам, автозамын трасс, нөөцийн талбайд хайгуул хийж шинээр 12 дурсгал илрүүлэн олсон байна [Ерөөл-Эрдэнэ нар, 2010].

Ийнхүү 2001-2010 онуудад Өмнөговь аймгийн Ханбогд сумын Оюу толгой компаний захиалгаар Оюу толгой орчимд болон түүний үйл ажиллагааны нөлөөллийн бүсэд нийт 12 удаагийн хээрийн шинжилгээний анги зохион байгуулж 145 дурсгал шинээр илрүүлэн олсноос 13 дурсгалыг малтан судалсан байна. Мөн авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны үр дүнгийн талаар "Жавхлант хайрханы хадны зураг" [2004], "Ханбогдын хадны зураг" [2010] сэдэвт 2 зохиол, 5 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэл нийтлэгдээд байна.

Дээрх 2001 оноос эхэлсэн судалгааны ажлаас өмнө энд археологийн хайгуул, малтлагын ажил хийж байсан мэдээ бидний мэдэлд байхгүй байгаа тул судалгааны ажлын эхлэлийг 2001 оноос авч үзнэ.

Дээр дурдсан 149 дурсгал нь 2001-2008 онд "Айвенхоу Майнз Монголия инк", 2010 онд "Оюу толгой" компанийн хүсэлтийн дагуу хийсэн авран хамгаалах судалгааны үр дүн юм. Эдгээр дурсгалын зарим нь яг Оюу толгойн уурхайн бүсэд байх бол зарим нь бүтээн байгуулалт, эрэл хайгуул, урьдчилсан судалгаа (үүнд, авто зам, усны хоолой, нөөцийн талбай, онгоцны буудал гэх мэт) хийх талбайд буюу уурхайн талбайгаас тодорхой хэмжээний зайтай оршино. Мөн 2001-2008 онд "Айвенхоу Майнз Монголия инк" компаний төлөвлөж байсан ажлын төлөвлөгөө бидний хайгуулын ажилтай уялдаж байсан бол өнөөдөр энэ төлөвлөгөө хэвээрээ байгаа эсэх нь дурсгалын хадгалалт хамгаалалт, нөлөөллийн бүсийг тодорхойлоход шууд хамааралтай болно.

Бид "Оюу толгой орчимд" гэсэн бүсийг Оюу толгойн уурхайгаар төвийн цэгийг аван 80 км-ийн радиусаар тодорхойлов (Зураг 4). Энэхүү радиусыг 10 км тутамд хуваахад 8 тойрог болж байгаа юм. Тойргийг төвөөс эхлэн дугаарласан бөгөөд энэ нь зайнаас хамааралтай эрсдэлийн үнэлгээтэй холбоотой. Дээрх 80 км тойрогт багтаж байгаа дурсгалууд нь "Айвенхоу Майнз Монголия Инк" болон Оюу толгой компанийн захиалгаар хийсэн хайгуул, малтлага судалгааны ажлын үр дүнгээс гадна Онтре Гоулд (Entrée Gold), Энержи Ресурс (Energy Resources) компанийн захиалгаар хийсэн хайгуул судалгааны үр дүн хамт багтсан гэдгийг дурьдах нь зүйтэй.




**Зураг 4.** **Оюу толгой төслийн орчимд одоогоор мэдэгдээд байгаа археологи, палеонтологийн дурсгалт газрын бүдүүвч зураг**

**Хүснэгт 3** **Оюу толгой төслийн орчимд байгаа археологи, палеонтологийн дурсгалт газрын талаарх мэдээлэл**

| Тойргийн дугаар | Хамаарагдах дурсгал | Тайлан |
|---|---|---|
| Heruga 001, 002, 003, 004, 005, 006, 007, 008, 009, 010, 011, 012, 013, 014, 015, 016, 017, 018, 019, 020, 021 | Ж.Гантулга, П.Алдармөнх. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь "Айвенхоу Майнз Монголия инк" болон "Онтро голд" компаниудын хамтран эзэшдэг "Javaland 3136X" тоот лицензийн "Heruga" ордын талбайд хийсэн археологийн хайгуул судалгааны тайлан. Улаанбаатар, 2006 | 24 |
| OTS-05 | B.Gunchinsuren at all. A report of the archaeological survey conducted in the Ivanhoe Mines' license area named "Oyu tolgoi" in Khanbogd soum, Omnogobi aimag. Ulaanbaatar, 2005. | |
| Airport site 1, 2 | D.Tseveendorj at all., Report for archaeological survey works made at the Oyu tolgoi airstrip to be built newly in the exploitation site of "Ivanhoe Mines Mongolia inc." company in the territory of Khanbogd soum, Umnugobi aimak. Ulaanbaatar, 2006. | |
| UKR-031, 034, 035, 036, 040 | Б.Гүнчинсүрэн нар. Өмнөговь аймгийн Цогтцэций сумын "Ухаа худаг" нүүрсний уурхайгаас Ханбогд сумын "Гашуун сухайт" хилийн боомт чиглэлд тавигдах төмөр замын дагууд хийсэн археологийн хайгуул судалгааны тайлан. Улаанбаатар, 2009. Б.Гүнчинсүрэн нар. "Энержи Ресурс Рэйл" ХХК-ны Өмнөговь аймгийн нутагт шинээр тавьж буй төмөр замын трассын дагуух археологийн дурсгалыг малтан судлах хээрийн шинжилгээний ангийн тайлан. Улаанбаатар, 2009. | |

| Тойргийн дугаар | Хамаарагдах дурсгал | Тайлан |
|---|---|---|
| Zuun khatsavch | Д.Цэвээндорж нар. Ханбогдын хадны зураг. Улаанбаатар, 2010. | 20 |
| Dalain duulga | Д.Цэвээндорж нар. Ханбогдын хадны зураг. Улаанбаатар, 2010. | |
| Road -1, 2, 3, 4, 5, 6 | Ч.Ерөөл-Эрдэнэ, Ж.Гантулга. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг "Оюу толгой" ХХК-ийн ашиглалтын талбайд хийсэн археологийн хайгуул судалгааны тайлан. Улаанбаатар, 2010 | |
| Erchim-1, 2, 3 | Ч.Ерөөл-Эрдэнэ, Ж.Гантулга. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг "Оюу толгой" ХХК-ийн ашиглалтын талбайд хийсэн археологийн хайгуул судалгааны тайлан. Улаанбаатар, 2010 | |
| OTR-28 | Д.Цэвээндорж нар., Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт гүйцэтгэсэн хайгуул судалгааны тайлан. Улаанбаатар, 2003 | |
| Resource area-1, 2, 3 | Ч.Ерөөл-Эрдэнэ, Ж.Гантулга. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг "Оюу толгой" ХХК-ийн ашиглалтын талбайд хийсэн археологийн хайгуул судалгааны тайлан. Улаанбаатар, 2010 | |
| Shiveet rock art-44, 45, 46 | Б.Гүнчинсүрэн, Ч.Амартүвшин. Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын нутаг дахь "Онтре Гоулд инк" компанийн ашиглалтын талбайд хийсэн хайгуул судалгааны ажлын тайлан. Улаанбаатар, 2004 | 42 |
| Shiveet site-07 | Б.Гүнчинсүрэн, Ч.Амартүвшин. Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын нутаг дахь "Онтре Гоулд инк" компанийн ашиглалтын талбайд хийсэн хайгуул судалгааны ажлын тайлан. Улаанбаатар, 2004 | |
| OTR-08, 09, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 39, 40, 41, 42, 43, 44, 45, 46, 47, 48, 49, 52, 53, OTR lithic 1, 2 | Д.Цэвээндорж нар., Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт гүйцэтгэсэн хайгуул судалгааны тайлан. Улаанбаатар, 2003. Д.Цэвээндорж нар, Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь "Айвенхоу Майнз Монголия инк" компанийн ашиглалтын талбайд хийсэн малтлага судалгааны тайлан. Улаанбаатар, 2005. | |
| UKR-041, 042, 043, 044 | Б.Гүнчинсүрэн нар. Өмнөговь аймгийн Цогтцэций сумын "Ухаа худаг" нүүрсний уурхайгаас Ханбогд сумын "Гашуун сухайт" хилийн боомт чиглэлд тавигдах төмөр замын дагууд хийсэн археологийн хайгуул судалгааны тайлан. Улаанбаатар, 2009. Б.Гүнчинсүрэн нар. "Энержи Ресурс Рэйл" ХХК-ны Өмнөговь аймгийн нутагт шинээр тавьж буй төмөр замын трассын дагуух археологийн дурсгалыг малтан судлах хээрийн шинжилгээний ангийн тайлан. Улаанбаатар, 2009. | |
| OTS-04 | B.Gunchinsuren at all. A report of the archaeological survey conducted in the Ivanhoe Mines' license area named "Oyu tolgoi" in Khanbogd soum, Omnogobi aimag. Ulaanbaatar, 2005. | |
| OTW-02, 03 | Д.Цэвээндорж нар. "Айвенхоу Майнз Монголия Инк" компанийн Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь Оюу толгойд шинээр тавигдах ус татах шугамын дагууд хийсэн археологийн хайгуул судалгааны тайлан. Улаанбаатар, 2006. | 4 |
| Цагаан Толгой | Д.Цэвээндорж нар. Ханбогдын хадны зураг. Улаанбаатар, 2010. | |
| Shiveet rock art-37, 38, 39, 40, 41, 42 | Б.Гүнчинсүрэн, Ч.Амартүвшин. Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын нутаг дахь "Онтре Гоулд инк" компанийн ашиглалтын талбайд хийсэн хайгуул судалгааны ажлын тайлан. Улаанбаатар, 2004 | |

| Тойргийн дугаар | Хамаарагдах дурсгал | Тайлан |
|---|---|---|
| Shiveet site-05, 06 | Б.Гүнчинсүрэн, Ч.Амартүвшин. Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын нутаг дахь "Онтре Гоулд инк" компанийн ашиглалтын талбайд хийсэн хайгуул судалгааны ажлын тайлан. Улаанбаатар, 2004 | 12 |
| UHGZ-01, 02, 03, 04 | Ч.Амартүвшин нар. Өмнөговь аймгийн Цогтцэций, Баян-Овоо Ханбогд сумын нутгаар дайран өнгөрөх "Нүүрсний зам" ХХК-ны хатуу хучилттай замын трассад хийсэн археологийн авран хамгаалах малтлага судалгааны тайлан. Улаанбаатар, 2010 | |
| Shiveet rock art-03, 04, 05, 06, 07, 08, 09, 10, 11, 12, 13, 14, 15, 16, 17, 18, 19, 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29, 30, 31, 32, 33, 34, 35, 36 | Б.Гүнчинсүрэн, Ч.Амартүвшин. Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын нутаг дахь "Онтре Гоулд инк" компанийн ашиглалтын талбайд хийсэн хайгуул судалгааны ажлын тайлан. Улаанбаатар, 2004 | 36 |
| Shiveet site-01, 02, 03 | Б.Гүнчинсүрэн, Ч.Амартүвшин. Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын нутаг дахь "Онтре Гоулд инк" компанийн ашиглалтын талбайд хийсэн хайгуул судалгааны ажлын тайлан. Улаанбаатар, 2004 | |
| Shiveet rock art-01 | Б.Гүнчинсүрэн, Ч.Амартүвшин. Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын нутаг дахь "Онтре Гоулд инк" компанийн ашиглалтын талбайд хийсэн хайгуул судалгааны ажлын тайлан. Улаанбаатар, 2004 | 4 |
| OTS-01, 02, 03 | B.Gunchinsuren at all. A report of the archaeological survey conducted in the Ivanhoe Mines' license area named "Oyu tolgoi" in Khanbogd soum, Omnogobi aimag. Ulaanbaatar, 2005. | |
| OTR-01, 02, 03, 04, 06, 38 | Д.Цэвээндорж нар., Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт гүйцэтгэсэн хайгуул судалгааны тайлан. Улаанбаатар, 2003 | 7 |
| Mangas | Ч.Амартүвшин нар. Мангасын хүрээ хэмээх нэгэн шороон хэрмийн тухай ACTA Historica Mongolici. Tomus X, Fasc.5, тал 36-41.<br>Ч.Амартувшин, Ж.Гантулга, Д.Гарамжав. О крепости с защитным земляным валом, именуемым Мангасын Хурээ. //Древние культуры Монголии и Байкальской Сибири. Материалы Международной научной конференции 20-23 сентября 2010 г. Сборник научных трудов. Выпуск 4. Улан-Удэ, 2010. | |
| Нийт | | 149 |

Хүснэгт 3-т, багтсан 149 дурсгалыг төрөл зүйлээр нь: 1. Хадны зураг, 2. Булш оршуулга, 3. Хот суурин / нээлттэй суурин, 4. Хөшөө дурсгал, 5. Сүм хийд гэсэн тав хуваан авч үзэж болно. Эдгээрийг тоон үзүүлэлтээр доорх хүснэгтээр үзүүлэв (Хүснэгт 4). Эдгээр дурсгалууд нь харилцан адилгүй тоотой байгаа бөгөөд хамгийн олон тоотой нь чулуун дарааст байгууламжууд юм.

**Хүснэгт 4 Оюу толгой орчимд буй археологийн дурсгалын төрөл зүйл**

| Дурсгалт газрын төрөл | Хадны сүг зураг | Булш оршуулга /чулуун дараастай булш/ | Хот суурин/Нэлттэй суурин | Хөшөө дурсгал | Сүм хийд |
|---|---|---|---|---|---|
| Тоо | 47 | 99 | 2 | 1 | |
| *Дурсгалт газрын тодорхойлолт* | *Томоохон чулуун дээрх зураг, дүрслэл Ойролцоох нутаг усны нэрээр дурсгалт газрыг нэрлэсэн байна.* | *Энэ хэсэгт бүх он цагт хамааргдах чулуун дараастай булш, байгууламж багтана.* | *Энэ хэсэгт чулуун зэвсгийн олдоцтой газраас эртний хот суурингийн үлдэгдэл хүртлэх бүх дурсгал багтана.* | *Энэ хэсэгт чулууг ямар нэгэн зориулалтаар босгон тавьсан байгууламжууд багтана* | *Буддизмын зан үйлийн явуулдаг дуган хийдийн балгас туурь* |




**Зураг 5. Оюу Толгой орчмын талбайн 10 км-ын тойрог бүрээс олдсон дурсгалт зүйлсийн тоо**

Хүснэгт болон диаграммаас харахад хамгийн эрсдэлтэй Оюу Толгойн 1-3-р тойрогт буюу 30 км радиуст 86 дурсгал байгаа нь түүнийг хамгаалах, хадгалах талаар нилээдгүй ажил хийхийг бидэнд анхааруулж байгаа юм.

Ийнхүү 80 км-ийн тойрогт нийт 149 дурсгал хамрагдсан байгаагаас Хадны зургийн дурсгал цогцолбор байдлаар Жавхлант хайрхан (Ханбогд), Далайн дуулга (Ханбогд), Цагаан толгой (Ханбогд), Зүүн Хацавч (Ханбогд), Шивээт (Баян-Овоо) гэсэн нийт 6 тоотой байна. Эдгээрийн Ханбогд сумын нутагт хэмээн дурдагдсан дурсгалаар нэгэн сэдэвт зохиолууд [Цэвээндорж нар, 2004; Цэвээндорж нар, 2010] гарсан бол Баян-Овоо сумын Шивээт хэмээх газрын хадны зургийн дурсгалын [Гүнчинсүрэн нар, 2004] талаар одоогоор хэвлэгдээгүй байна.

## 2.4 Өмнөговь аймаг дахь соёлын өвт дурсгалуудыг газрын зурагт баримтжуулах

Ном зүйн судалгаанаас гарсан чухал үр дүнгүүдийн нэг нь Өмнөговь аймаг дахь биет соёлын өвүүдийн мэдээллийг газарзүйн мэдээллийн системд оруулсан явдал юм.

Дан ганц шууд нөлөөллийн бүсэд бус нийт аймгийн хувьд хийгдсэн хэвлэмэл болон хэвлэгдэж хараахан амжаагүй материалуудыг ашиглан уг мэдээллийн санг үүсгэсэн. Мэдээллийн санг үүсгэхдээ газарзүйн мэдээллийн систем ашиглан Өмнөговь аймаг дахь биет өвийн дурсгалуудын тархалтыг зураг дээр байршуулсан. Эндээс бид дурсгалуудын бүртгэлтэй холбоотой алдаа болон сул талуудыг харах боломжтой. Жишээ нь Өмнөговь аймгийн зүүн талын сумдаар дурсгалын тархалт нягт байгаа нь энэ хэсгээр дийлэнх судалгаа хийгдсэнтэй холбоотой. Нутгийн иргэдтэй хийсэн уулзалтын дунд илүү олон дурсгалууд аймгийн баруун хэсгээр оршиж байх магадлалтайг бид тодорхойлсон. Бидний туршлага дээр үндэслэн Говь Алтайн уулсын зүүн хэсгийн ойролцоо маш олон археологийн дурсгал байж болно хэмээн таамагласан. Мөн бид статистик анализ ашиглан өөрсдийн аргазүйг сайжруулсан. Мөн уг таамаглах загварыг турших хээрийн судалгааг 2010 оны 11-р сард хийсэн.

## 2.5 Газарзүйн мэдээллийн сан дахь соёлын өвүүд

### 2.5.1 Мэдээллийн сан дахь мэдээлэлүүд

Хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд номзүйн судалгааны дараагийн үе шат бол соёлын өвийг газрын зурагжуулах ажил байсан юм. Энэхүү ажлыг гүйцэтгэхийн өмнө дурсгалын талаар хэрхэн мэдээллийн сан үүсгэж, түүнийг ямар байдлаар ойлгомжтой болгох вэ гэсэн асуудал тулгарсан. Монгол улсын хэмжээнд биет өвийн дурсгалын хувьд ийм төрлийн мэдээллийн санг боловсруулах туршлага сүүлийн жилүүдэд нилээдгүй хуримтлуулсан гэж хэлж болох юм. Жишээлбэл, 1997-2001 онуудад ШУА-ийн Археологийн хүрээлэн АНУ-ын Мичиганы Их сургуулийн Антропологийн тэнхимтэй хамтран Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Эгийн голын сав нутагт археологийн нарийвчилсан хайгуул судалгаа хийж олон тооны дурсгал илрүүлэн олж тэдгээрийг мэдээллийн сан бүхий газрын зурагт буулгах ажлыг гүйцэтгэжээ [Амартүвшин, 2004]. Үүний дараагаар 2003-2008 онуудад тус хүрээлэн АНУ-ын Ийелийн Их сургуулийн Антропологийн тэнхимтэй хамтран Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын нутаг Бага газрын чулуунд мөн ийм төрлийн судалгааны ажлыг гүйцэтгэсэн байна [Амартүвшин нар, 2010]. 2007 оноос ШУА-ийн Археологийн хүрээлэн, Алтай судлалын хүрээлэнтэй хамтран Баян-Өлгий, Ховд аймгийг бүхэлд нь хамарсан археологийн хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэж эхний үр дүнгээ нэгтгэсэн нэгэн сэдэвт бүтээлийг хэвлүүлсэн байна [Төрбат нар, 2009]. 2008 оноос БСШУЯ-ны дэргэдэх Соёлын өвийн төв Хэнтий, Дорнод, Сүхбаатар, Дорноговь зэрэг зүүн бүсийн аймгуудын биет өвийн дурсгалын мэдээллийн санг бүрдүүлэхээр ажиллаж өөрсдийн хэмжээнд үр дүнг нэгтгэн хэвлүүлсээр байна [Энхбат нар, 2008].

Дээрх археологийн хээрийн судалгааны ажлын үр дүнд илэрсэн дурсгалыг нэг арга зүйгээр биш боловч тус бүртээ өөрсдийн боловсруулсан аргачлалын дагуу мэдээллийн санг бүрдүүлсэн байдаг. Эдгээр судалгааны ажлын арга зүйгээс хамгийн ололттой, хамгийн зөв бүтэцтэй гэсэн зүйлүүдийг нэгтгэн Хөтөлбөрийн биет өвийн мэдээллийн санг бүрдүүлэхэд ашиглав.

### 2.5.2 Мэдээллийн сангийн бүтэц

Мета өгөгдөл гэж нэрлэгддэг СӨХ-н мэдээллийн бүтцэд маш олон тайлбар элементүүд ордогийг дор харууллаа.

**Сумын нэр.** Хөтөлбөр нь Өмнөговь аймгийн нутгийг хамаарах тул аймгийн нэрийг олонтаа давтахгүйн үүднээс шууд сумын нэрээс эхлэв. Сумын нэрээр эрэмблэх нь сумын нутагт илэрсэн дурсгалын тооноос дутагдалтай тал болон цаашид авах арга хэмжээний талаар дүгнэлт гаргах боломжтой болох юм.

**Газрын нэр**. Монголын археологийн судалгаанд бүх цаг үеийн туршид дурсгалыг тухайн газар усны нэрээр нэрлэж тэмдэглэсээр ирсэн билээ. Харин энэ мэдээллийн санд нэгэн онцлог зүйл ажиглагдана. Учир нь сүүлийн жилүүдэд уул уурхайн компаниуд лицензийн талбайг тухайн газар усны нэрнээс нэгийг сонгон том талбайг бүхэлд нь нэрлэх нь элбэг болсон юм. Үүнтэй уялдан авран хамгаалах хайгуул судалгаа хийсэн лицензийн талбайн нэрүүд газрын нэр гэсэн заалтанд хамт багтаж байгаа юм. Үнэндээ нэг лицензийн талбайд тус бүрдээ нэртэй уул, хөндий, ам байгаа нь ойлгомжтой боловч зарим талаар тухайн газар усны нэр мартагдах, сунжирах тал гарч болзошгүйг анхаарах хэрэгтэй юм.

**Дурсгалын дугаар**. Энэхүү заалтанд хайгуулын ажлын дугааруud багтаж байна. Дугаарыг өгөхдөө ихэнхдээ ашигт малтмалын лицензийн талбайн нэрийг латин үсгээр товчлон ард нь дугаарласан байдалтай байна.

**Солбилцол**. Монголын археологийн шинжлэх ухаанд хиймэл дагуулын тусламжтайгаар солбилцол тогтоох багажийг хэрэглээд 20 орчим жил болж байгаа билээ. Энэ хугацаанаас өмнө олдсон дурсгалууд нь тодорхой солбицолгүй байгаа боловч бид номзүйн судалгааны явцад судлаачдын тодорхойлолтоос үндэслэн барагцаалсан солбицолуудыг нэмж оруулсан болно. Сүүлийн жилүүдийн судалгааны ажлын үр дүнд олдсон дурсгалууд нь бүгд солбилцолтой байгаа ч солбицолын алдаа дунджаар ±3-7 м байгааг анхаарах нь зүйтэй. Монголын археологичид Garmin 12, Garmin 12xp, Garmin Etrex зэрэг GPS төрлийн багажийг хэрэглэдэг.

**Хэлбэр**. Энэ нь дурсгалын хэлбэрийг тодорхойлохоос гадна төрлийг хамт тодорхойлж байгаа болно. Он цаг тодорхойгүй дурсгалуудыг хамгийн энгийнээр дугуй, дөрвөлжин, зууван дугуй хэлбэртэй хэмээн харагдах байдлаар тодорхойлсон бол хадны зураг, эртний хот, сүм хийдийн турь зэрэг овор хэмжээтэй он цаг нь тодорхой дурсгалыг оноосон нэрээр нь тэмдэглэв. Гэвч зарим тохиолдолд дурсгалыг булш, чулуун байгууламж, тахилын байгууламж хэмээн шууд онооход тун адармаатай байгаа болно. Үүнийг шийдэх ганц арга зам бол малтлагын ажил билээ. Гэхдээ өөрсдийн туршлаганд тулгуурлан дээрх ангилалд хуваарилахыг оролдсон болно.

**Хэмжээ**. Дурсгалын овор хэмжээнд тулгуурлан статистик харьцуулалт болон үнэлгээ хийх боломжтой юм. Хэмжээ авахдаа дугуй хэлбэртэй дурсгалыг хойноос урагш чигт голчоор, харин дөрвөлжин хэлбэртэй дурсгалыг хоёр талын уртаар тус тус хэмжсэн байна. Хэмжээг метр, сантиметрийн хэмжигдэхүүнээр тэмдэглэв.

**Он цаг**. Археологийн судалгаанд гадаад зохион байгуулалтаар нь он цагийг тодорхойлох боломж байдаг хэдий ч зарим тохиолдолд ялангуяа говийн бүсэд энэ нь тун хязгаарлагдмал байдаг. Энэ нь а. Говийн бүс нутагт өнөөг хүртэл археологийн малтлага судалгаа тун бага явагдсан, б. Малтлага судалгаа хийгдсэн ч тухайн дурсгалаас, дурсгалын он цагийг харьцуулах замаар тогтоох эд өлгийн зүйлс гарахгүй, зөвхөн хүн малын яс гарсан тохиолдолд мухардалд орох нь бий, в. Дурсгалаас илэрсэн органик хэрэглэгдэхүүнийг $C_{14}$ лабораторийн шинжилгээнд илгээх шаардлагатай байдаг боловч хөрөнгө мөнгөний бололцооноос хамааран тэр болгон хамруулж чадахгүй гэсэн хэд хэдэн шалтгаантай байна. Хэдий ийм боловч, Монголын археологийн шинжлэх ухаанд он цаг нь нарийвчлан тогтоогдсон, гадаад дотоод хэлбэрийн ангилал хийгдсэн олон дурсгалууд байдаг нь бидний мэдээллийн санд тодорхой нэр, он цагийн хамт тусгагдсан.

**Судалгааны ивээн тэтгэгч**. Энэ нь сүүлийн үеийн судалгааны ажлын үр дүнтэй холбоотой юм. Учир нь археологийн авран хамгаалах судалгааны ажлыг захиалан хийлгэж байгаа аж ахуйн нэгжийг тодорхой дурдах нь зүйтэй бөгөөд энэ нь харьцуулалт, задлан шинжилгээ хийхэд хэрэг болно хэмээн үзэж байна.

**Огноо**. Дурсгалыг илрүүлсэн он, дурсгалын тухай хэвлэн нийтлүүлсэн оныг хүснэгтэнд байршуулав.

**Судалгааны эх хэрэглэгдэхүүн**. Энэ хэсэгт тухайн дурсгалыг олж илрүүлсэн судлаачид, хайгуул судалгааны тайлан, эрдэм шинжилгээний өгүүлэл, нэгэн сэдэвт бүтээлүүдийг бичсэн этгээдийн нэрийг оруулсан болно. Тухайн дурсгалын талаар эрдэм шинжилгээний олон өгүүлэл, тайланд дурдагдсан тохиолдолд хамгийн эхний судалгааны хэрэглэгдэхүүнийг хүснэгтэнд тэмдэглэсэн.

### 2.5.3 Өгөдлүүдийг газарзүйн мэдээллийн системд хөрвүүлсэн нь

Газарзүйн мэдээллийн систем нь газар, байр зүйтэй холбоотой мэдээллийн менежмент, анализ болон зураг боловсруулалтын компьютержсэн систем юм.

1960–иад оны үеэс газарзүйн мэдээлэлтэй харьцдаг мэргэжилтнүүд компьютерт байр зүйн хэмжигдэхүүн бүхий мэдээллийг хэрхэн хадгалах, зохион байгуулах талаар санал боловсруулж эхэлсэн нь Газарзүйн мэдээллийн систем (ГМС, GIS)-ийн эхлэл болсон.

1980-аад оноос эхлэн компьютерийн техникт эргэлт гарч үйлдэл гүйцэтгэх хурд, өгөгдөл хадгалах чадвар багтаамж сайжирснаар орон зайн хэмжигдэхүүн бүхий өгөгдлүүдтэй харьцах чадвартай программууд хөгжиж ирсэн. Үүнд сайн чанарын задаргаа бүхий график дэлгэц гарч ирсэн нь түлхэц болсон.

ГМС нь байгалийн нөөцийн менежмент, газар ашиглалт төлөвлөлт, зам харилцаа, зах зээл болон бусад газар зүйн мэдээллийг ашигладаг олон тооны салбаруудад өргөн тархсан технологи юм.

Геологийн судалгааны ажил нь газар, байр зүйтэй нягт холбоотой байдаг учир ГМС-ийг олон геологийн байгууллагуудад янз бүрийн компьютер дээр орон зайн хэмжигдэхүүн бүхий өгөгдлийг хадгалах, боловсруулах чиглэлээр өргөн хүрээтэй ашиглаж байна.

ГМС нь орон зайнаас хамаарсан хэмжигдэхүүн бүхий өгөгдлүүдтэй ажиллахад зориулагдсан мэдээллийн систем юм. Өөрөөр хэлбэл ГМС нь database system (өгөгдлийн систем) ба орон зайн хэмжигдэхүүний өгөгдөлд боловсруулалт хийх өвөрмөц боломжийг хоёуланг нь агуулсан байна. Мөн түүнчлэн өнгөт карт, статистик тооцоо, график хүснэгтүүд зэрэг олон талт мэдээллүүдийг агуулж байдаг.

"Дэлхий дээр орших байгаа бүх объектуудад (geo-reference) газарзүйн холболт хийх" нь аливаа мэдээллийг ГМС руу нэгтгэх үндэс суурь болно. Мэдээллийн сан гэсэн нэр томъёо нь ямар нэг биетийн (объект) талаарх болон тэдгээр нь бусад объекттэй харилцан үйлчлэх хамаарлын талаарх мэдээллийн цуглуулга юм.

## 2.5.4 Газарзүйн мэдээллийн систем дэх файлуудын тайлбар

Өмнөговь аймагт явуулсан археологийн судалгааны ажлын үр дүнг зураг зүйн аргаар боловсруулан хэрэглэгчдийн хэрэгцээнд тохируулан ГМС-д нэгтгэн орууллаа. ГМС нь мэдээллийг орон зайн хувьд цэгэн (point), шугаман (polyline), битүү талбайн (polygon) хэлбэрээр хадгалдаг бөгөөд тус тусдаа өөрийн гэсэн хүснэгтэн мэдээллийг агуулдаг. ГМС-д оруулахдаа дээрх 3 төрлийн нэг нь болох цэгэн (point) хэлбэрээр оруулсан бөгөөд тухайн файлын агуулга, эх сурвалжийн тухай товч бичлээ.

- Судалгааны талбай: Өмнөговь  аймаг
- Координатын систем:  UTM Zone 48N
- Датум: WGS 1984
- Ашигласан программ хангамж: ArcGIS v9.3
- Ашигласан материал: 30 x 30 метрийн нарийвчлалтай ASTER GDEM, газрын гадаргын хотгор гүдгэрийн байдлыг тодруулж өгсөн зураг (hillshade), M1:100000 масштабтай байрзүйн зураг, Ашигт малтмалын хэрэг эрхлэх газраас гаргасан лицензтэй талбайн shape файл.

*Газрын зурагт буулгах (газарзүйн холболт хийх).* Аливаа зургийн мэдээг тоон хэлбэрт оруулахын өмнө заавал газарзүйн холболт хийх ёстой. Учир нь өөрийн мэдээ мэдээллийг давхцуулж боловсруулалт хийхийн тулд нэг ижил газар зүйн өгөгдөлд оруулах шаардлагатай байдаг. Тухайн судалгааны талбайн байршил, хамарч буй газар нутгийн хэмжээ, судалж буй сэдвээс хамаарч газарзүйн өгөгдлөө:

- WGS_1984_UTM_Zone_48N
- Projection: Transverse_Mercator
- False_Easting: 500000.000000
- False_Northing: 0.000000
- Central_Meridian: 99.000000
- Scale_Factor: 0.999600
- Latitude_Of_Origin: 0.000000
- Linear Unit: Meter байдлаар сонгосон юм.

Газарзүйн холболтын алдаа бага байх тусам мэдээ боловсруулалтын үр дүн бодитой байх болно.

*Топографи зурагт буулгах (байрзүйн зургийн холболт хийх).* Өмнөговь аймгийн бүх нутаг дэвсгэрийг хамарсан 1:100 000 масштабтай байрзүйн зургийг ArcGIS программын Georeferencing командаар газарзүйн өгөгдөлд оруулах холболтыг хийлээ. Холболтын алдааг багасгах зорилгоор байрзүйн зургийн трапец бүрийн 4 өнцгийн газарзүйн солбицлыг түүж хатуу цэгүүдийн сүлжээ байгуулж суурь зургаа хөрвүүлсэн болно.

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрийг хамарсан М 1:100000 масштабтай байрзүйн зургийг ArcGIS v9.3 программын тусламжтайгаар ГМС-д оруулаа. Газарзүйн холболт хийгдсэн зураг нийт 129 ширхэг бөгөөд нийтдээ 25 gb хэмжээтэй (Хүснэгт 5). Үүнд:

**Хүснэгт 5 Газарзүйн холболт хийхэд ашиглагдсан газрын зургууд**

| Д/д | Планшет | Ширхэг |
|---|---|---|
| 1 | K-48 | 77 |
| 2 | K-47 | 29 |
| 3 | L-47 | 3 |
| 4 | L-48 | 30 |

### 2.5.5 Газарзүйн мэдээллийн систем дэх файлууд ба тэдгээрийн хүснэгтэн мэдээлэл, эх үүсвэр

Хээрийн хэмжилтийн цэгэн мэдээлэл нь археологийн судалгааны олдворуудын байршлийг тодорхойлох бөгөөд хүснэгтэн мэдээлэл дараах хэлбэртэйгээр хадгалагдсан (Хүснэгт 6).

**Хүснэгт 6. Хээрийн судалгаагаар авсан мэдээлэл**

| ID | Aimag_mgl | Soum_mgl | Land_mgl | Type_mgl | Dursgal_mgl | X | Y | Size | Date | Sud_hereg | Tailan_name |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | |
| | | | | | | | | | | | |

Points_umnugobi

- ID — Дэс дугаар
- Aimag_mgl — Аймгийн нэр (монгол хэл)
- Soum_mgl — Сумын нэр (монгол хэл)
- Land_mgl — Газрын нэр
- Type_mgl — Дурсгалын хэлбэр
- Dursgal_du — Дурсгалын дугаар
- X — Уртраг
- Y — Өргөрөг
- Size — Хэмжээ
- Date — Илрүүлсэн огноо
- Sud_hereg — Судалгаа хийлгэсэн компани
- Tailan_name — Тайлангийн нэр

Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт явуулсан археологийн судалгааны нийт 650 гаруй цэгүүдийг тоон хэлбэрт шилжүүлсэн бөгөөд тус судалгаа нь 2 үе шаттайгаар хийгдсэн. Эхний ээлжийн судалгаа нь Өмнөговь аймгийн Цогт-Цэций, Манлай, Ханбогд, Баян-Овоо, Мандал-Овоо, Номгон сумдын нутгийг хамарсан ба нийт 500 гаруй цэг хэмжигдсэн. Хэмжигдсэн цэгүүдийн байршлыг хэрэглэгчийн хэрэгцээнд нийлүүлэн дараах байдалтайгаар хэвлэлийн эхийг бэлтгэлээ (Зураг 6). Зураг 6-д эхний удаагийн хээрийн хэмжилтийн цэгэн мэдээллүүдийг ерөнхийд нь харууллаа. Уг зурагт урьд нь хэмжигдсэн болон шинээр хэмжигдсэн цэгүүд, мөн ашигт малтмалын хайгуул явуулах зөвшөөрөл хүссэн, хайгуул явуулж буй болон олборлолт явуулж талбайн хилийн цэсийг оруулсан болно.




**Зураг 6.** **Өмнөговь аймгийн зүүн хэсэгт явуулсан археологийн судалгааны эхний хэсэгт хамрагдсан талбай, хэмжсэн цэгүүд болон уул уурхайн ашиглалтын талбайн байршил**

Археологийн дурсгалт газрууд хоорондоо ойрхон учир цэгэн мэдээллүүдийг байршилийг илүү тод харуулах үүднээс судалгаанд хамрагдсан газар нутгийг хэсэгчилсэн байдлаар хэвлэлийн эхийг бэлтгэлээ. Зураг 7-д хэмжигдсэн цэгүүдийг төрөл зүйлээр ялган, цэгүүдийн өөр өөрийн гэсэн таних тэмдгээр харуулсан болно.







**Зураг 7.** **Археологийн судалгаа явуулсан газар нутаг болон хэмжсэн цэгүүдийн байршлыг хэсэгчилсэн байдлаар үзүүлсэн зураг, Өмнөговь аймгийн зүүн хэсэг**

Археологийн хоёрдугаар ээлжийн хээрийн судалгаа нь Өмнөговь аймгийн Сэврэй, Гурвантэс, Баяндалай, Ханхонгор, Хүрмэн сумдын нутаг дэвсгэрт явагдсан бөгөөд нийт 150 орчим цэгүүдийг илрүүлэн хэмжсэн. Эдгээр хээрийн хэмжилтийн цэгүүдийг тоон хэлбэрт шилжүүлж дараах байдлаар зургийн хэвлэлийн эхийг бэлтгэсэн. Зураг 8-д хоёрдугаар ээлжийн хээрийн хэмжилтийн цэгэн мэдээллүүдийг ерөнхийд нь харууллаа. Уг зурагт урьд нь хэмжигдсэн болон шинээр хэмжигдсэн цэгүүд, ашигт малтмалын хайгуул явуулах зөвшөөрөл хүссэн, хайгуул явуулж буй болон олборлолт явуулж талбайн хилийн цэсийг оруулсан болно.




**Зураг 8.** **Өмнөговь аймгийн баруун хэсэгт явуулсан археологийн судалгааны хоёрдугаар хэсэгт хамрагдсан талбай болон хэмжсэн цэгүүдийн байршил, Өмнөговь аймгийн баруун хэсэг**

Хоёрдугаар ээлжийн судалгааны археологийн дурсгалт газрууд нь хоорондоо ойрхон учир цэгэн мэдээллүүдийг байршилийг илүү тод харуулах үүднээс судалгаанд хамрагдсан газар нутгийг хэсэгчилсэн байдлаар хэвлэлийн эхийг бэлтгэлээ. Зураг 9-д эсрэгээр нь хэмжигдсэн цэгүүдийг төрөл зүйлээр ялган, цэгүүдийн өөр өөрийн гэсэн таних тэмдгээр харуулсан болно.




**Зураг 9.** **Археологийн судалгаа явуулсан газар нутаг болон хэмжсэн цэгүүдийн байршлийг хэсэгчилсэн байдлаар үзүүлсэн зураг, Өмнөговь аймгийн баруун хэсэг**

Дээрх 2 хэсэг явагдсан археологийн судалгаа нь Өмнөговь аймгийн Цогт-Цэций, Манлай, Ханбогд, Баян-Овоо, Мандал-Овоо, Номгон, Сэврэй, Гурвантэс, Баяндалай, Ханхонгор, Хүрмэн сумдын нутгийг хамарсан бөгөөд 9-12-р сарын хооронд үргэлжилсэн. Энэ судалгааны явцад хэмжигдсэн бүх цэгэн мэдээллийн байршлийг Зураг 10-д харууллаа.




**Зураг 10. Өмнөговь аймагт явуулсан археологийн судалгаанд хамрагдсан талбай болон хэмжсэн цэгүүдийн байршил**

Энэхүү ажлын үр дүнд Өмнөговь аймагт явуулсан археологийн судалгаагаар хэмжигдсэн бүх цэгэн мэдээллүүд тоон хэлбэрт орон ГМС-д нэгтгэгдсэн ба энэхүү мэдээллээр хэрэглэгчийн хэрэгцээнд тохируулсан төрөл бүрийн зураг хийх боломжтойгоос гадна цаашид жил жилийн хэмжилтийн мэдээллээр баяжуулж, шинэчлэх боломжтой Газар зүйн мэдээллийн сангийн суурь мэдээлэл бүрдсэн.

Эцэст нь дүгнэн хэлэхэд судалгааны ажлаас бид гурван гол үр дүнг олж авсан. Нэгдүгээрт бид тухайн газарт өмнө нь явуулсан археологийн судалгааны ажлын нэгдсэн санг бий болгож чадсан. Хоёрдугаарт, төслийн баг Өмнөговь аймагт явагдсан археологийн судалгааны талаарх ном зохиолыг судлан давуу болон сул талуудыг олж мэдэж чадсан. Гуравдугаарт, орон нутгийн өгөгдлийн сан нь археологийн олдворын байрлал, тэдгээрийн судалгааны үнэ цэнэ, хадгалалт хамгаалалтын байдлын талаар мэдээлэл өгөх гол эх сурвалж болж чадсан.

## 2.6 Археологийн Дурсгалт Газрын Байршлыг Урьдчилан Тодорхойлох Загвар

**Жеффрей Х. Алтшул, Виллиам И. Хэйден**

Археологийн дурсгалт газрын менежмент нь гурван үндсэн асуултын хариулттай салшгүй холбоотой: Үүнд: Археологийн дурсгалууд хаана байрлаж байна вэ?, Ямар төрлийн археологийн дурсгал байна вэ? Аль дурсгалуудыг хадгалж хамгаалах шаардлагатай бэ? гэсэн асуултууд байдаг.

Аливаа бүс нутгийн соёлын үнэт зүйлсийн менежмент хийж эхлэхдээ бид ихэвчлэн эдгээр асуултуудад сайн хариулж чаддаггүй. Тухайлбал, Өмнөговь аймаг байна. Соёлын Өвийн Хөтөлбөр боловсруулах эхний шатны ажил дууссаны дараа бид тухайн аймагт илэрсэн байгаа 500 гаруй археологийн дурсгалуудыг баримтжууллаа. Хэдийгээр энэ нь их мэт боловч, үнэн чанартаа бол тухайн аймаг дахь нийт дурсгалуудын 1 орчим хувийг л баримтжуулсан болов уу. Үүний нэгэн адил жишээ бол АНУ-ын Вашингтон мужид жил тутам шинээр илрүүлсэн болон үргэлжлүүлэн хайж байгаа бөгөөд одоогоор 50.000 археологийн дурсгалыг баримтжуулаад байгаа билээ.

Өмнөговь аймгийн археологийн дурсгалуудын мэдээлэл хомс байгаагаас шалтгаалан зарим хүмүүс соёлын өвийг хамгаалах ажлын эхний алхам нь тухайн аймаг болон тэнд оршиж буй археологийн дурсгалт газрууд хаана байрлаж болох талаар загвар судалгаа байх ёстой хэмээн маргаж болох юм. Гэсэн хэдий ч тиймэрхүү судалгаа нь хэт их өртөгөөр, удаан хугацааны туршид хийгдэх шаардлагатай. Мөн, тухайн хугацаанд илрүүлээгүй археологийн дурсгалууд нь эрсдэлд орсоор байх болно.

Энэ тохиолдолд, боломжит хувилбар нь Өмнөговь аймаг дахь археологийн дурсгалуудын талаарх өөрсдийн мэдэлд байгаа мэдээлэлдээ тулгуурласан судалгааг хийвэл бидний боломж илүү сайжрах болно. Анх 1970 оны сүүл, 1980 оны эхээр АНУ-д археологийн дурсгалын менежментийг GIS технологийн тусламжтайгаар урьдчилсан загвар гаргах арга дэлгэрсэн юм. Ихэнх менежментэд чиглэсэн урьдчилсан загвар нь уснаас хол, ашигт малтмалын нөөц ихтэй, амьтан тэжээх, салхинаас хамгаалах зэрэг байгалийн баялагтай холбоотой газар нутагт хүн оршин сууж байсан таамаглал дээр тулгуурладаг. Археологийн дурсгалуудыг байгуулахдаа тухайн хүмүүс чухам юу бодож байсныг хэзээ ч мэдэж чадахгүй ч гэсэн эртний хүмүүс өндөрлөг газар, уулын бэл, гол горхи зэргээр нутаглаж байсан нь дурсгалын байршилтай холбоотойг төвөггүй мэдэж болно. Ингэснээрээ бид археологийн дурсгал байх боломжтой болон боломжгүй гэсэн тэмдэг – дохиог бий болгож болно.

Археологийн дурсгалт газруудын байршлын урьдчилсан загвар хийх эхний алхам нь Загварын хамрах талбайг GIS хэлбэрт оруулах явдал байсан (Зураг 11). SRTM-ээс өгсөн тоон өгөгдлүүдийг ашиглан бид Өмнөговь аймгийг бүхэлд нь болон талбайг дүүргэх хангалттай талбайг багтаасан тэгш өнцөгт талбайг тодорхойлсон (Зураг 11. Газарзүйн мэдээллийн систем ашиглан урьдчилан таамаглах загвар боловсруулах алхамууд

). Дараа нь Урьдчилсан загварын хамрах талбайг нь пикселээр хэмжигдсэн хоёр тэнцүү хэсэг (cell)-т хуваасан. SRTM-ийн өгөгдлийн сангийн хуваагдсан хэсгүүдийн тусгал нь нэг арк секунд боловч Монголд гурван арк секунд буюу ойролцоогоор 90 метр байлгах боломжтой. Тиймээс судалгааны талбайг ойролцоогоор 90 x 90 метрээр 45.616.892 хэсэгт хуваасан.




1. Физик мэдээллүүдэд дүн шинжилгээ хийх (хадгалагдсан өгөгдлүүдээс)
2. Файлын сан өгөгдөл тус бүрт
   Өндөршил
   Налуу
   Геологи
   Геологийн томоохон хагарлуудын зай
   Үерийн усны урсацын зай
   Рашаан усны зай
   Тухайн цэг хүртэлх зай
   Экологийн бүс (WWF)
3. Эсрэг түүвэр (өмнөх судалгааны явцад илэрсэн байрлал)
4. Эсрэг түүвэр (ёудалгааны явцын мэдээ баримт)
5. Эсрэг болон зерэг түүврийн хэмжээг тохируулах
6. Олдвортой болон олдворгүй талбайг тодорхойлхын тулд layerүүдийг харьцуулах
7. Олдворын тодорхрой хязгаартай геометрийн дүрслэлийн магадлалын layer
8. Олдворгүй тодорхрой хязгаартай геометрийн дүрслэлийн магадлалын layer
9. Олдвортой/олдворгүй талбайн хил хязгаарыг тодорхойлхын тулд засвар хийх
10. Магадлалын түвшинд дүгнэлт хйиж мэдрэг ангилалуудыг тодорхойлж өгөх (олон дахин)

**Зураг 11.** **Газарзүйн мэдээллийн систем ашиглан урьдчилан таамаглах загвар боловсруулах алхамууд**




**Зураг 12. Эцсийн байдлаар бэлэн болсон таамаглах загвар**

Хэсэг тус бүрийн хувьд бид дараах орчны хувьсагч хэмжигдэхүүнүүдийг /environmental variable/ тодорхойлсон.

- Ховор амьтан, ургамлууд байрлах эко бүсүүд
- Дэлхийн газрын гадаргуугийн тогтоц
- Газар нутгийн оноосон нэрнүүдээс онцгой анхаарал татаж буй нэрсийн жагсаалтыг Ж. Олсен тодорхойлсон.
- Хур тунадас их ордог бүс нутгууд
- Хэвгий
- Өндөршил
- Гол хагарал хүртлэх зай
- Булгууд хүртлэх зай

Хүрээлэн буй орчны өөрчлөлтөд дүн шинжилгээ хийсэн, харин энэ загварт оруулаагүй.

- Төрх, тал (градусаар хэмжсэн)
- Төрх, тал (үндсэн чиглэлүүд)
- Тэмдэгт газар, овоо хүртлэх зай (тухайн газраас)
- "Нэрлэсэн булгууд" хүртэлх зай (тухайн газраас)
- Ус хүртлэх зай

- Газрын байдал
- "Нэрлэсэн булгууд" хүртэлх зай
- Гол хагарлууд хүртэлх зай

Бидэнд мөн соёлын хоёр төрлийн өөрчлөлт буюу нэгдүгээрт, археологийн дурсгалуудын хэлбэр, хоёрдугаарт, археологийн судалгаа хийсэн газар нутаг гэсэн хүчин зүйлс байгааг тодорхойлж байна.

Харин байгаль орчны хувьсал өөрчлөлтийн хувьд өндөрлөг газар, уулын бэл, ойролцоох гол горхийг тогтмол давтамжтай хэмжигдэхүүн (interval-scale)-ээр хэмжинэ. Өндөрлөг газарт нэг болон хоёр метрийн хоорондох зөрүү нь 1.000 болон 999 метр хоорондын зөрүүтэй адил байна. Экологийн бүс, геологийн цэгүүд нь эсрэгээрээ nominal-scale–аар хэмжигдэнэ. Эдгээрийг бүхэлд нь хамарсан мэдээлэл байхгүйгээс гадна дараалал нь тийм ч чухал биш. Хэрвээ "овооны нэр"-н дээр байвал 1 пиксел, "шар" дээр байвал 2 пиксел, "эрдэнэ" дээр байвал  3 пиксел, алин дээр нь ч биш бол 4 пикселээр дүгнэж болно. Эдгээр оноонууд нь байрлал хоорондын ялгааг тусгах бөгөөд оноогоор илэрхийлсэн мэдээллүүд бүгдийг нь хамраагүй юм.

Соёлын өөрчлөлтийн хувьд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн судлаачид эхлээд археологийн дурсгалууд нь судлагдсан бүх газруудыг тэмдэглэсэн. Үүний үр дүнд 3.013.654 ширхэг хэсэг нь судлагдсан, харин бусад нь судлагдаагүй хэмээн тэмдэглэгдсэн. Судлагдсан газруудад 526 дурсгалуудын байршлын мэдээлэл оржээ. Учир нь эдгээр дурсгалт газрууд жижиг хэмжээтэй бөгөөд хоорондоо ойролцоо зайтай байрладаг, зарим нь хоёр ба түүнээс дээш газраас бүрдсэн байна. Иймээс 387 дурсгалт газар кодлогдон 3.013.267 нь дурсгалт газар биш хэмээн тэмдэглэгдсэн.

Дараагийн алхам нь судлагдсан газруудын байгаль орчны өөрчлөлтөд өгсөн оноо нь загварт хамрагдаж байгаа газар нутагт бүхэлд нь өгсөн оноотой уялдуулах явдал юм. Хамгийн чухал нь бидний үнэлгээ хийхэд ашиглаж буй пикселүүд нь хүрээлэн буй орчныг бүхэлд нь төлөөлсөн байхыг хүсч байгаа билээ. Бид мэдээлэлд тулгуурласан статистик судалгаа хийж байгаа ч энэ удаад хистограмын судалгаа хангалттай хэмээн үзсэн.

Зураг 13-д уулархаг газруудын хистограмыг харуулсан. Хамгийн эхний хоёр хистограм нь төстэй бөгөөд загварт хамрагдаж буй газрын бүх пиксел оноонуудыг харуулна. Доод мөрний зүүн талд археологийн дурсгалуудыг хамарсан бүх пиксел оноонууд, баруун талд нь судлагдсан боловч дурсгалт газруудад багтаагүй бүх пикселүүд байна. Дээд эгнээнд мөн энэ байдлаар байрлуулна.



**Зураг 13. Загварын байгаль орчны үзүүлэлтүүдийг харуулсан статистик график**

Ингэснээр энэ нь байгаль орчны өөрчлөлтөд өгсөн оноонуудын загвар юм. Дурсгалт газруудын пикселүүд нь энэ загвартай нийцэхгүй байгаа нь эрт үед хүмүүс дурсгалт газрын байршлыг сонгохдоо байгаль орчны өөрчлөлтийг харгалзан үздэг байсныг харуулж байна. Иймээс урьдчилсан загвар (predictive model)-т хүрээлэн буй орны хувьсал өөрчлөлтийг оруулах нь чухал.

Үүнийг харгалзан үзэж бид загварт оруулах есөн өөрчлөлтийн жагсаалтыг сонгосон. Энэ удаад, гол горхи, томоохон уул хүртэлх зай гэсэн хоёр нөхцлийг авч үзээгүй боловч нэгдсэн үр дүн нь маш ойролцоо гарсан. Бид дээрх найман өөрчлөлтийг дараах байдлаар авч үзсэн.

Загварыг боловсруулахдаа MLP мэдрэлийн системийг ашигласан. Зохиомол мэдрэлийн систем (ANN) нь биологийн мэдрэлийн системүүдийн математикийн төлөөллийг бий болгох оролдлогоос анх үүсчээ. Нервологиос хэт төсөөрсөн боловч, ANN нь археологийн дурсгалт газруудын байршил зэрэг хялбаршуулсан системийг загварчлахад ашиглагдаж байна[10]. Ерөнхийдөө ANN нь биологийн мэдрэлийн эс шиг үйлдэл хийдэг бөгөөд энэ мэдээлэл хүлээн авч, дамжуулж, хариу үйлдэл гүйцэтгэхийг хэлнэ. ANN нь ялангуяа өгөгдлийн цогцод байгаа асуудалтай загварууд, нуугдмал бүтцэд чухал юм. Учир нь өгөгдлүүд дээр ажиллаж сурсан мэдрэлийн эсүүдийн сүлжээ нь байнга эдгээр бүтцийг задалж, тайлж чаддаг. Мэдрэлийн эсэд нэг бүрчлэн дүн шинжилгээ хийх арга нь дангаараа үүнийг хийж чаддаггүй (уналтад суурилсан дүн шинжилгээ гэх мэт) билээ. Бидний судалгаанд ANN нь маш чухал үүргийг гүйцэтгэх юм. Учир нь энэ арга нь өөр өөр хэмжигдэхүүнүүдээр хэмжсэн хувьсал өөрчлөлтүүдийг багтааж чаддаг бөгөөд эцэст нь ANN нь өгөгдлийг бүхэлд нь хянаж чадсанаар сүлжээнд байгаа хэв загваруудыг олж тогтоох чадвартай байдаг[11].

Харин, DRISI, MLP алгоритмийг ашиглахад эхлээд судлаач дурсгалт газар болон дурсгалт газар биш нь тогтоогдсон хэсэг бүхий дадлагын растер (цэгэн) зургийг сонгоно. Ингэснээр энэхүү дадлагын растер (цэгэн) зураг нь гадаад давхаргат мэдрэгчийн үүрэг гүйцэтгэнэ (Зураг 14). Манай туршилтын хувьд дурсгалт газар болон дурсгалт газар биш гэсэн хоёр боломжит эс байгаа бөгөөд оруулах хувьсагч растерууд нь хувьсагч (нийт 8 орчны хувьсагчтай) нэг бүрт мэдрэгч хуваарилагдсан дотоод давхаргаар төсөөлөгдөнө.

[10] Rust, Craig. *Neighbourhood-based Site Locational Modelling*. Dissertation Status Report and Draft Prospectus, Simon Fraser University, Vancouver, British Columbia, 2007

[11] Huang, Fi-Jie and Mann Lectern. Large-Scale Learning with SVM and Convolutional Nets for Generic Object Categorization, *Proceedings of the Computer Vision and Pattern Recognition Conference (CVPR'06),* IEEE Press, Los Alamitos, California, 2006
Lecun, Y., and Y. Bengio. *Convolutional Networks for Images, Speech, and Time-Series. In The Handbook of Brain Theory and Neural Networks*, edited by M.A. Arbib. MIT Press, Cambridge, Massachusetts, 2004
LuCun, Y., L. Bottou, Y. Bengio, and P. Haffner. Gradient-based learning applied to document\line recognition. *Proceedings of the IEEE* 86 (November):2278-2324. Los Alamitos, California, 1988




**Зураг 14.** **Давхаргын бус болон гаралтын (гадаад) давхаргын зангилааг загварчилсан арга зүй**

Үүний дараа далд давхарга болон Оролт давхаргын мэдрэгч эсүүдийн хоорондын холбоон дээр тулгуурлан Multi-Layer Perceptron(MLP) буюу Олон давхаргат мэдрэгчийг бэлдэнэ. Хэдий далд давхаргын мэдрэгч эсийн тоо тодорхой биш байсан ч IDRISI болон бусад Олон давхаргат мэдрэгч программ үүнийг багцаалах чадвартай байдаг. Далд давхаргын эсүүд хийсвэр, дундын чанартай бөгөөд Гадаад давхаргын эсүүдтэй цогц математикийн хэлхээ үүсгэхэд зориулагдсан байдаг. Үүнээс гадна процессын загвараас хамаарч нэгээс илүү Далд давхарга байж болдог (манай загвар 4 эсээс бүрдсэн нэг Далд давхаргатай). Далд ба Дотоод давхарга хоорондын холбоо давхаргуудын эсийн  тохиолдлын математик жингээс хамаарч бий болдог ба үүнтэй адил үйл явц өрнөж Далд ба Гадаад давхаргын холбоог үүсгэдэг. Олон давхаргат мэдрэгч  эдгээр харилцааг даддлагын растерийн хэсэг тус бүрийн хувьд Гадаад давхаргын эсийн төлвийг бүртгэгдсэн утгатай харьцуулж, боловсруулдаг.

Тохиолдлын чанартай өгөгдсөн жингээс үүдээд эдгээр утга өөр хоорондоо дүйцдэггүй. Холболтын жин дахин боловсруулагддаг. Алгоритм Гадаад ба Дотоод эсийн жинг харьцуулан тогтоосны дараа дахин шинэчлэгдсэн Далд давхарын эс болон Дотоод давхаргын эсийн жинг харьцуулна. Ингэснээр өмнөхөөсөө бага зэрэг өөрчлөлттэй үр дүн гардаг.

Энэхүү үйлдэл шаардлагатай нарийвчлалд хүрэх эсвэл давталтын тоо тодорхой хэмжээнд хүртэл дахин хийгдэнэ. IDRISI-ын хувьд давталтын стандарт хэмжээ 10.000 бөгөөд бидний үүнээс илүү давталттай хийсэн процесс нарийвчлалыг хангалттай хэмжээнд ихэсгээгүй нь харагдсан.  Эцэст нь Гадаад давхаргын эсийн хамгийн их утга бүхий дурсгалтай болон дурсгалгүй растер бэлэн болно.

Загварт ашиглагдсан мэдээллийн дутмаг байдлаас шалтгаалан дурсгалтай болон дурсгалгүй растерийн дүн тийм ч чухал зүйл биш болов уу. Урьдчилсан таамаг дэвшүүлсэн загварыг дурсгалтай болон дурсгалгүйг тогтоосон хэмээх мэдэгдэл хийхээс илүүтэйгээр боломжит бүсийн хэлбэрээр харвал илүү үр дүнтэй. Жишээ нь 15 км кв. талбайд нэг ч дурсгал илрэхгүй хэмээн таамаглал дэвшүүлэхэд хүндрэлтэй бол дурсгал илрэх боломж таван хувиас хэтрэхгүй хэмээн үзэж болно. Энэ төрлийн логикийг “бүрхэг магадлал” гэж томъёолдог.

IDRISI нь хэрэглэгчдэд Олон давхаргат мэдрэгч процессийн растер бэлдэх боломж олгодог. Үүнд бүх Гадаад давхаргын эс хэсгийн харьяалагдах хэмжээг үзүүлсэн растер гарна. Өмнөговийн урьдчилсан таамаглалтай загварыг хийхэд бүрхэг магадлалын нэг дурсгалтай, нэг ч дурсгалгүй Гадаад идэвхжүүлэлттэй давхаргын растер ашигласан. Энэхүү хоёр төрлийн растер археологийн дурсгалуудтай хэсгийг заах эцсийн газрын зургийг гаргахад хувьсагч болон ашиглагдсан юм.

Загварыг бүтээх хамгийн сүүлийн шат бол мэдрэмжийн бүсийг тогтоох юм. Ерөнхийдөө археологийн дурсгал агуулах магадлалаар нь бага, дунд, өндөр гэсэн гурван төрлийн бүс байдаг. Загварын зорилго нь бага мэдрэмжит бүсийн хэмжээг ихэсгэж, өндөр мэдрэмжит бүсийн хэмжээг багасгахад оршино. Үүний тулд дараах дүрмийг мөрдөнө:

- Бага мэдрэмжит бүс нийт талбайн 70 хувийг хамарч, тогтоогдсон дурсгалын 20 хувиас хэтрэхгүй байх
- Дунд мэдрэмжит бүс нийт талбайн 15 хувийг хамарч, тогтоогдсон дурсгалын 18 хувиас хэтрэхгүй байх
- Өндөр мэдрэмжит бүс нийт талбайн 15 хувийг хамарч, тогтоогдсон дурсгалын 20 хувиас хэтрэхгүй байх.

Юуны өмнө орчны анхан шатны мэдээлэл, бага хэмжээний системтэй археологийн мэдээлэл дээр тулгуурласны хувьд энэхүү газрын зургийн нарийвчлалд эргэлзээтэй зүйл байгааг анхаарах хэрэгтэй. Бидний зорилго үнэнд ойрхон загвар бүтээх, түүнийг хэрхэн бүтээсэн талаар мэдээллийг хүргэхэд оршиж байсан билээ. Цаашид, Өмнөговь аймгийн нутагт ажиллах явцад энэхүү газрын зураг улам сайжирна гэдэгт итгэлтэй байна. Үүнийг сайжруулахад говийн археологийн дурсгалуудын тархалт, бүтцийн тухай бидний мэдлэг чухлаар нөлөөлөх нь дамжиггүй. Газрын зурагт орох өөрчлөлт нь эхэндээ идэвхитэй байж, цаашид бага зэргийн засвараас бүрдэх болов уу хэмээн урьдчилан таамаглаж байна.

Загварыг шалгахын тулд бид бага хэмжээний талбайд хээрийн судалгааны ажил хийсэн бөгөөд зургаадугаар бүлэгт дэлгэрэнгүй өгүүлэгдэх дурсгалын тоо нь өндөр мэдрэмжит бүсэд дунд мэдрэмжит бүсээс илүү байгааг батлаж чадсан юм. Хэдийгээр энэ төлөв байдал бага мэдрэмжит бүсэд дахин батлах хангалттай туршилт хийгдээгүй боловч энэ тал дээр эерэг байр суурьтай байна.

## 2.7 Археологийн Суурь Судалгаа

Төслийн 1-р шатны ажлын хамгийн чухал хэсгүүдийн нэг нь хээрийн судалгааны ажлууд байсан ба түүний дунд урьдчилан таамаглах загварыг турших судалгаа орно. Биет өвийн багийн хээрийн судалгааны ажлуудын талаар дор оруулав.

### 2.7.1 2010 оны 8-р сарын 18-27-ны үед хийгдсэн хээрийн судалгааны ажлын хураангуй

Тус төслийн хүрээнд зохион байгуулагдаж буй гурав дахь удаагийн хээрийн судалгаа боловч биет өвийн судалгааны хэсгийнхний хувьд эхний удаагийнх болно. Судалгааны багийн бүрэлдэхүүнд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Эрдэмтэн нарийн бичгийн дарга, доктор, профессор Б.Гүнчинсүрэн, эрдэм шинжилгээний ажилтан доктор, дэд профессор Ч. Амартүвшин, докторант Ц. Болорбат, жолоочоор (Мерседес Бенз) Н. Довчинхорол нар багтан ажиллав.

Энэхүү хээрийн шинжилгээний багийн гол зорилго бол дээр дурдсан газруудад нутгийн удирдлага, олон нийтийн саналыг сонсох, өөрсдийн төслийн талаар танилцуулга хийх явдал байв.

Хээрийн судалгааны ажил нь үндсэн дөрвөн хэсгээс бүрдэж байсан болно.

Нэгдүгээрт, Орон нутгийн удирдлага болон өөрийн нутгийн түүх-соёлын дурсгалын талаар санаа тавьдаг, түүний судалдаг зарим хүмүүстэй уулзаж, санал бодлоо хуваалцах гэсэн ярилцлага, уулзалт;

Хоёрдугаарт, Тухайн орон нутгийн биет өвийн хадгалах хамгаалах асуудлыг хариуцсан байгууллагуудтай (музей, номын сан) танилцах, мэдээлэл авах, санал бодлыг нь сонсох;

Гуравдугаарт, Ном зүйн судалгааны хүрээнд орон нутагт хэвлэгдсэн судалгаа, сурталчилгааны ном бүтээлийг худалдан авах, хувилах;

Дөрөвдүгээрт, Тухайн сумдын нутагт буй археологийн дурсгалтай танилцах, шаардлагатай хайгуул, малтлагын ажлыг гүйцэтгэх гэсэн зүйлс багтаж байна.

Хээрийн шинжилгээний ажлын явцад дараахь ажлыг хийж гүйцэтгэсэн. *Шинээр тавигдах замын трассын дагуух хайгуулын ажил*. 2006 онд ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн хайгуул судалгааны анги "Айвенхоу майнз Монголия Инк" компаниас тавьсан саналын дагуу Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй Оюутолгой төслийн 6709А тоот ашиглалтын тусгай зөвшөөрлийн талбайн хойд хаалганаас Гашуун Сухайт хилийн боомт хүртэл шинээр тавигдах машин замын дагууд археологийн авран хамгаалах хайгуул судалгааг Монгол улсын "Соёлын өвийн тухай" хуулийн зохих заалтын дагуу хийж гүйцэтгэж байжээ.

Энэхүү төлөвлөж буй замын трассанд өөрчлөлт орж замыг Оюу толгой төслийн талбайн урд хаалганаас эхлэн дээрхи үндсэн трасстай нийлүүлэхээр болсон ба энэ 20 орчим км замын дагуу 2010 оны 7 дугаар сард танай компаниас гаргасан хүсэлтийн дагуу археологийн хайгуул судалгааны ажлыг 7 дугаар сарын 24-өөс 26-ныг хүртэл эрдэм шинжилгээний Г.Галдан хийж гүйцэтгэжээ. Энэхүү судалгааны дүнд 3 дурсгал илрүүлэн олсон бөгөөд эдгээр дахин нягтлан үзэхээр 2010 оны 08 дугаар сарын 22-ны өдөр ажиллав (Хавсралт зураг 13-15). Энэхүү ажлын хүрээнд нэмж хоёр дурсгал илрүүлэн олсон бөгөөд үүнийг Оюу толгой компаний Байгаль орчны хэлтсийн ажилтан нарт үзүүлэн заавар зөвлөмж өгөв.

*Нисэх онгоцны буудлын орчимд хийсэн хайгуул судалгаа*. Тус хүрээлэнгийн хайгуул судалгааны анги тус компаниас тавьсан саналын дагуу Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт үйл ажиллагаа явуулж буй Оюутолгой төслийн Оюут нисэх буудлын зурваст 2010 оны 08 дугаар сарын 21-ны өдөр хайгуул судалгааны ажлыг хийж гүйцэтгэв (Хавсралт зураг 16). Хайгуулын ажил гүйцэтгэх талбай

P1 N43 07 40.9, E106 51 15.7,

P6 43 09 32.4, E106 49 52.2,

P7 N43 09 32.4, E106 50 04.8,

P8 N43 07 45.9, E106 51 28.3 солбилцлуудын төвд байсан болно.

Уг талбай нь говийн талархаг тэгш газар байсан тул эртний нүүдэлчдийн үлдээсэн булш оршуулга, хөшөө дурсгал зэрэг овор хэмжээтэй дурсгал байхгүй болохыг тодорхойлов.

*Булан тойромын булшны судалгаа*. 2010 оны 8 дугаар сарын 23-ны өдөр Улаанбаатар Их сургуулийн Археологийн ангийг төгсөгч, Ханбогд сумын Баян багийн иргэн О. Батзориг бидэнтэй ирж уулзан 2010 оны 7 дугаар сарын дундуур өөрийн багийн нутагт нэгэн эртний оршуулга ил гарсан байгааг олж үзээд, үүнийг яаралтай малтан судлахгүй бол малын хөлд гишгэгдэх, шунахай хүмүүсийн гарч өртөж болзошгүй болсон талаар мэдээлэл өгсөн билээ. О. Батзориг Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 9-т заасны дагуу сумын удирдлага, соёлын төвийн эрхлэгч нарт мэдээлсэн боловч тэд малтлагын ажил хийхгүйгээр ил гарсан олдворуудыг авах санал тавьсан байна. Иймээс бид уг булшийг цаг алдалгүй малтан судлаж, олдвор хэрэглэгдэхүүнийг бүрэн бүтэн авах шаардлагатай хэмээн үзээд 2010 оны 08 дугаар сарын 24-ны өдөр Булан тойром хэмээх газарт очиж малтлагын ажлыг гүйцэтгэлээ.

Энэ булш нь тогтоол ус тогтох хотгор газар бөгөөд загийн шинэхэн ой ургажээ. Тойромын зүүн захад гадна талаараа ямар нэгэн чулуун дараастай байсан гэх ором мэдэгдэхгүй нэгэн оршуулга ил гарсан байв. Хүний гавлын духны хэсэг бүрэн эвдэрсэн, гарын хоёр савруу болон зарим хавирганы яс ил байхаас гадна гавлын ясны хоёр талд шавар сав суулга тавьсан байсан боловч эвдэрч энд тэнд ундуй сундуй хэвтэнэ.

Бид оршуулгын нүхний хэмжээнд малтлагыг зохион байгуулав. Хүнээ хойд зүгт хандуулан бор эсгийнд ороогоод толгойн хоёр талд шавар сав тавин оршуулсан байжээ. Хүний хүзүүнд ногоолин чулуун зүүлт, баруун гартаа хутга, төмөр товруутай бүс бүсэлсэн өсвөр насны хүүхдийн оршуулга хэмээн урьдчилсан байдлаар таамаглаж байна.

Булшнаас гарсан олдвор хэрэглэгдэхүүнийг ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн лабораторид сэргээн засварлаж байгаа бол харин О.Батзориг зарим олдворын тодорхойлолт, зураглалын ажлыг хийж байна. Тэрээр энэхүү булшны үр дүнгийн талаар өөрийн аймаг, сумын сонин хэвлэлд мэдээлэх, эрдэм шинжилгээний өгүүлэл бичих ажлыг зохион байгуулах болно.

Цаашид эдгээр олдворуудыг Ханбогд сумын “Галба” музейд хүлээлгэн өгөхөөр төлөвлөж байгаа боловч музейн үзмэрийн аюулгүй байдал, хадгалалтын горим зэрэгтэй дахин танилцах шаардлагатай байгаа болно.

### 2.7.2 2010 оны 11-р сарын 11-20-ны өдрүүдэд хийгдсэн хээрийн судалгааны ажлын хураангуй

Уг судалгаагаар Өмнөговь аймгийн зүүн хэсгийн сумдаар голчлон ажиллав (Хавсралт 4).

Соёлын өвийн хөтөлбөр боловсруулах төслийн хүрээнд нөлөөллийн бүс нутгуудыг дотор нь гурван ангилалд хуваан авч үзсэн билээ. Энэ удаад нөлөөллийн гуравдугаар бүс буюу тус аймгийн баруун талын сумдуудад ажиллав. Энэхүү ажлын зорилгыг доорх байдлаар тодорхойлов.

- Тус компани хөтөлбөр боловсруулах уралдааны гүйцэтгэх ажлын тодорхойлолтонд (2009 оны 11-р сарын 16-ний өдөр) Ханбогд, Баян-Овоо, Манлай, Даланзадгад сумд болон Өмнөговь аймаг багтаж болно хэмээн санал болгож байсантай уялдуулан манай багийн бүрэлдэхүүн өөрсдийн төлөвлөгөөндөө Өмнөговь аймгийн үлдсэн 11 сумын эрсдэлийг ямар нэгэн хэмжээгээр тодорхойлох талаар тусгасан билээ.

- Монгол улсад түүх-соёлын дурсгалын хадгалалт хамгаалалт, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг үе шаттайгаар хийж байсан боловч харамсалтай нь Өмнөговь аймгийн нутагт ийм төрлийн ажил тун хангалтгүй байсаар байна. Энэ байдлыг бид төслийн нэгдүгээр шатны эхний ажил болох Номзүйн судалгаа болон мэдээллийн сан бүхий газрын зургийн урьдчилсан судалгааны хүрээнд тодорхой харуулсан юм.
- Шат дараалсан судалгааны дараагийн хэсэг бол өөрсдийн боловсруулсан загвар дээр тулгуурлан тухайн бүс нутагт түүх-соёлын дурсгалын байршлыг урьдчилсан байдлаар таамаглаж, түүнийг газар дээр нь шалгах хээрийн судалгааг хийх шаардлагатай байна. Энэ нь Оюу толгой компаниас үл хамааралтай ч бусад уул уурхай, барилга байгууламжийн ажлын явцад гарч болзошгүй эрсдэлийг бууруулахад чухал нөлөөтэй юм.
- Биет өвийн судалгааны багийн гишүүд говийн бүсэд хийсэн судалгааны туршлага дээр үндэслэн 10 хүчин зүйлд тулгуурлан загварыг гаргасан болно. Эдгээр загварт жишээлбэл, ширгэсэн гол, горхи, нуурын хөндий болон ширгээгүй гол, нуурын сав, үнэт чулуу олзворлож байсан газар, ойр орчмын өндөрлөг уул, газар усны оноосон нэр зэрэг зүйлс багтаж байна.
- Урьдчилсан байдлаар гарсан соёлын өвийн бүртгэл - зураглал дээрээс харахад Өмнөговь аймгийн зүүн хэсэгт дурсгалууд шигүү тархсан мэт харагдаж байгаа боловч энэ нь үнэн хэрэг дээрээ ийм биш байгаа нь ойлгомжтой билээ. Говийн бүс нутагт эртнээс нааш хүн жигд тархан суурьшиж байсан нь гарцаагүй бөгөөд Өмнөговийн баруун нутгууд ч гэсэн түүх соёлын дурсгал олон байгаа нь тодорхой юм.
- Энэхүү хээрийн судалгааны хугацаа давчуу тул олон дурсгал бүртгэх бололцоогүй хэдий ч өөрсдийн хийсэн загварыг шалгах, томоохон дурсгалыг баримтжуулах талаар анхааран ажиллах болно.
- Бид бас орон нутгийн удирдлага болон сонирхсон хүмүүстэй уулзан соёлын өвийн талаар мэдээлэл цуглуулах хүсэлтэй.

Энэхүү хээрийн судалгааны ажилд 8 хүн хоёр хэсэг болон ажиллав. Үүнд, Нэгдүгээр баг – *Б. Гүнчинсүрэн, Ц. Болорбат, Б. Эрдэнэ*, *Жолооч*, Хоёрдугаар баг – *Ч. Амартүвшин, Г. Галдан, Ц. Амгалантөгс*, *Жолооч* гэсэн бүрэлдэхүүнтэйгээр ажилласан. Дараах 3 шалтгаанаар хоёр баг болон ажиллахаар төлөвлөсөн: a) энэ хээрийн судалгааны ажил нь Өмнөговь аймгийн баруун бүсийн 11 сумын нутгуудаар буюу нөлөөллийн нэгдүгээр бүсээс гаднах сумдуудаар ажиллах учир олон км замыг туулж, үзэж танилцах дурсгал олон байгаатай холбоотой; b) Мөн хөтөлбөр боловсруулах багийн нэгэн тулмагдаад байгаа асуудал бол орон нутагт байгаа "Зөвлөх хороо"-ны гишүүдтэй биечлэн уулзаж, тэднээс албан ёсны зөвшөөрөл авах ажил юм. Үүнийг нэгдүгээр багийн бүрэлдэхүүн өөр маршрутаар явж гүйцэтгэнэ; c) Өмнөговь аймгийн нутаг өргөн уудам, сум хоорондын болон шалгах газруудын зай хол байгаагаас нэг машинтай, цөөн хүнтэй ажиллавал хугацаа бага алдана, мөн цөөн км замыг туулах болно.

Хээрийн ажлын явцад бид Цогт-Овоо, Даланзадгад, Ханхонгор, Хүрмэн, Баяндалай, Булган, Сэврэй, Ноён, Гурвантэс гэсэн 9 сумын нутагт 146 дурсгалыг баримтжуулав. Эдгээр дурсгалууд нь Говийн Алтайн уул нуруудын зүүн хэсэгт Гурвансайханы нурууг оруулан Булган, Баяндалай, Даланзадгад, Хүрмэн сумдын нутаг, Сэврэй, Баяндалай сумуудын нутагт байрлах Зөөлөн даваа, Ноён, Гурван тэс сумдын нутаг дэвсгэр дэх Тосон бумба, Эрдэнийн нуруу, Гурван тэс сумын нутаг дах Нэмэлтийн нуруунд тус тус байрлана. Дурсгалууд нь харьцангуй тогтвортой байрлалтай ижил загвартай байна. Жишээ нь бид Тахилга, Тахилгат гэсэн нэртэй уулсыг 9 сумын 5 газар харсан. Бид таван уулыг нь бүгдийг нь шалган тэдгээрийн 4-д нь их хэмжээний археологийн дурсгалыг илрүүлсэн ч цаг агаарын байдлаас болоод Ханхонгор суманд байрлах тав дах Тахилга ууланд очиж чадаагүй.

Бид тухайн жилийн эцэст судалгаагаа эхэлсэн учраас уулаараа маш их цас орсон байснаас шалтгаалан судалгаанд авсан газруудаа бүгдийг нь богино хугацаанд шалгах боломжгүй байсан. Тиймээс бид маш олон газрыг машинаасаа шалган "хийсвэр" судалгааг хийсэн.

Бидний загварчлан бодож байсанчлан эдгээр дурсгалууд нь маш тархай байрласан. Эдгээр дурсгалуудын ихэнх нь өндөр уулын оргил, толгод, одоо урсаж байгаа гол, нуур, горхины орчим байрлаж байсан. Зарим дурсгалуудыг сум орны хамгаалалтад үлдээх болно. Ийм дурсгалуудад Даланзадгад сумын нутагт орших Хан уулын ойролцоох Хүрэл зэвсгийн үеийн дурсгалууд, Гурвансайхан уулын зүүн урд хэсэг дэх  Хүрэл зэвсгийн үеийн хиргисүүр, Сэврэй сумын Тахилт, Үйзэнгийн хадны дурсгал, Ноён сум дах Тахилтын хадны дурсгал зэрэг багтана. Говийн нутгаар их хэмжээний хадны бичиг олдсон. Үүнтэй ижил хадны бичиг Баруун Алтайн мужаас бас олдож байсан.

Бидний олсон нэгэн чухал дурсгал бол Гурвансайхан уулаас олдсон хиргисүүрүүд юм. Энэхүү хөшөө дурсгал нь 2000-3000 жилийн өмнө зүүн Сибирь, Алтайн уулс, Төв Монголын нутаг дэвсгэрт тархсан соёлын хэсэг юм. Говийн нутгийн оршин суудаг хүмүүс хиргисүүртэй холбоотой зан үйлд оролцдоггүй  гэж археологичид үздэг. Тийм  болохоор энэ газар нутгийг тухайн үед өөр хүмүүс эзэлж байжээ гэж үзэж болно. Ийм төрлийн дурсгалуудыг Говиос олсноор энэхүү соёлын тархсан газар өргөжиж байна.

## 2.8 Монголын археологийн орон нутгийн судалгааны ажлын хэв маяг: Өмнөговь аймаг

Археологи гэдэг нь аливаа баримтыг хуримтлуулан цуглуулдаг шинжлэх ухаан юм. Бид too баримт цуглуулан, тэдгээр too баримтыг тайлбарлан, энэ тайлбараа шинэ too баримтаар туршин, сайжруулан шинэчилсэн тайлбарын дагуу шинэ процесс эхлэх замаар хөгждөг. Археологийн шинжлэх ухаан дахь бүх too баримт нь чухал байдаг болохоор археологичид бусад салбарын эрдэмтэн судлаачдын адилаар ажиглалт дундаас аль аль ажиглалтыг сонгон авах талаар шийдвэр гаргах ёстой болдог. Энэ утгаараа тухайн шийдвэр гаргах асуудлаар ямар ямар төрлийн боломжит дурсгал оршин байгаа талаар археологич, менежерүүд болон зохицуулагчид нь мэдэж байх шаардлагатай. Дараа нь эдгээрээс алиныг нь судлах талаар шийдвэр гаргана. Энэ шийдвэрийг гаргахад 2 үндсэн шалгуурыг ашиглана. Нэгдүгээрт, нөлөөллийн шинж чанарыг үнэлнэ. Тухайн дурсгал нь бүхлээрээ сүйрэх үү? Эсвэл зөвхөн нэг хэсэг нь л гэмтэх үү? Энэхүү дурсгалыг бүхлээр нь хамгаалж чадах уу? гэх мэт. Хоёрдугаарт, тухайн дурсгалын ач холбогдлыг тодорхойлно. Археологийн дурсгалуудын ач холбогдлыг тогтоохдоо шинжлэх ухааны мэдээлэл, түүний уламжлал, шашны ач холбогдол болон олон түмэнд нандин дурсгал болж чадах уу гэдгийг харгалзана. Энэ асуудлын талаар 4-р бүлэгт өгүүлэх болно.

Археологийн дурсгалын шинжлэх ухааны ач холбогдол нь эрт үеийн түүх болон бидний мэддэггүй түүхийн талаар мэдээлэл өгөх чадвар юм. Нэг утгаараа бүх дурсгал хүний үйл ажиллагааны дахин давташгүй үр дүн байдаг болохоор ямар нэгэн шинэ зүйлийг хэлж өгч байдаг. Гэвч ийм шалгуурыг ашиглах нь тэдэнд бүх дурсгалуудыг бүтнээр нь судлах шаардлагыг бий болгодог. Энэ нь санхүүгийн хувьд боломжгүй төдийгүй шинжлэх ухааны хувьд ч утгагүй зүйл юм. Тайлбарлан ярих боломжгүй их хэмжээний мэдээлэл цугларахын зэрэгцээ ач холбогдол нь өнгөрсөн үед ямар байхыг тогтооход хэцүү болно. Үүний оронд шинжлэх ухааны ач холбогдлыг нь бид юу мэддэг болон юу мэдэхийг хүсч байгаагаар тогтооно. Өмнөговь аймгийн нутагт өмнө нь хийгдсэн археологийн судалгааны хүрээг түүх соёлын үндсэн хүрээнд тодорхойлсон. Хамгийн чухал нь бид хүн төрөлхтөний түүхэн дэх үйл явдлуудын үндсэн дараалыг мэддэг байх ёстой. Бид юу мэддэг болон юу мэддэггүй вэ гэдэг нь говийн соёлын хөгжлийн тодорхойлогч гол зүйл болохоор яагаад соёл үүсэн хөгжиж, унаж, дийлж явсныг тодорхойлно. Өөрсдийн ойлголтоо гүнзгийрүүлэхийн тулд бид дээрх асуудлуудыг нарийвчлан сургахад шаардлагатай мэдээллүүдийг агуулсан дурсгалуудыг олох хэрэгтэй.

Эдгээр дурсгалуудыг тодорхойлохын тулд бид өмнийн говийн соёлыг судлан түүхэнд хэн, юу, хэзээ, хаана гэдгийг тогтоох хэрэгтэй. Энэхүү түүхэн үечлэлд үндэслэн бид маш өргөн хүрээнд Өмнөговийн археологийн судалгааны дараагийн алхам болсон судалгааны асуулт бэлдэн боловсруулна. Төслийн явцад ч, судалгааны ажлын явцад ч олдсон дурсгалт газруудыг бид дээрхи асуултын дагуу үнэлнэ. Хэрэв эдгээр асуултад хариулт өгч чадвал бид эдгээрийг ач холбогдолтой нарийвчилсан судалгаанд хэрэгтэй гэж үзнэ. Энд дурьдагдсан асуултууд маш өргөн хүрээтэй болохоор бид зөвхөн ач холбогдол тогтоох шалгуур болгон ашиглана. Цаашдын ажилдаа орохоос өмнө бидний чухал гэж үзсэн дурсгалууд нь дээрх асуултуудад нарийвчилсан дүгнэлт хийнэ.

### 2.8.1 Монголын Археологийн үечлэл

Өмнөговь аймаг дахь археологийн дурсгалыг хадгалж хамгаалах иж бүрэн, өргөн хүрээг хамарсан төлөвлөгөө боловсруулахын тулд бид эхлээд юу мэддэг вэ гэдгээ үнэлж, тухайн мэдлэгээ Монголын археологийн үечилсэн хүрээтэй холбох нь чухал. Энэ зорилгоор бид бидний мэдлэгийн цаг хугацааны хязгаарын зураглалыг гаргах Монголын археологийн үечлэлийг хийх бөгөөд дараа нь энэ бүс нутгийн түүх, соёлын талаар бүрэн дүүрэн, үнэн зөв ойлголт өгч чадах археологийн болон түүхийн өгөгдлүүдийн матриц гаргана.

### 2.8.2 Чулуун зэвсгийн үе

Чулуун зэвсгийн үе нь хүн төрөлхтний түүхийн хамгийн эртний бөгөөд хамгийн удаан үргэлжилсэн үе юм. Чулуун зэвсгийн үеийг палеолит буюу хуучин чулуун зэвсгийн үе, мезолит буюу дунд чулуун зэвсгийн үе, неолит буюу шинэ чулуун зэвсгийн үе хэмээх гурван үед хуваан судалдаг.

Түүхэн хөгжлийн урт удаан хугацааны туршид эртний хүмүүс чулуун зэвсэг үйлдвэрлэх арга барил, хүрээлэн буй орчин, амьд байгальтай харьцах харьцаа, байгалийн хатуу ширүүнд дасан зохицох, шинэ газар нутгийг эзэмших зэрэгт томоохон өөрчлөлт дэвшилт гаргасаар иржээ.

Чулуун зэвсгийн эрт үед орчин үеийн хүн төрөлхтний анхдагч байсан хүний төрөлхтний өвөг дээдсийн чулуужсан үлдэгдэл нь дэлхийн бөмбөрцөгийн өнцөг булан бүрийн байгал цаг уурын таатай нөхцөл бүхий газар нутгийг эзэмших зорилгоор Африкаас гадна хүн амаа тэлж эхэлсэн.

Чулуун зэвсгийн хожуу үед бид материаллаг байдлаар илэрхийлэгддэг соёлын урсгалууд зэрэгцэн оршиж байсны илэрхийлэл байж болох олон янзын эд өлгийн зүйлс олж эхэлсэн. Мэдээж Монголын болон бусад улс орнуудын археологичдын тулгардаг гол сорилт нь материаллаг болон материаллаг бус, эсвэл өөр арга механизм илрэх болсон эдгээр олон төрлийн эд өлгийн зүйлсийг хэрхэн зөв тайлах вэ гэдэг асуудал юм.

**Хуучин чулуун зэвсгийн доод үе** (800000-100000 жил). Палеолитын үеийг доод, дунд, дээд гэсэн гурван том үед хуваан авч үздэг. Монгол орны палеолитын үеийн хамгийн эртний үед холбогдох олдворууд бүхий бууц суурин Баянхонгор аймгийн Өлзийт сумын Нарийн гол, Баянлиг сумын Цагаан агуй, Жаргалант сумын Байдрагийн гол, Шинэжинст сумын Босго, Өмнөговь аймгийн Булган сумын Цахиуртын хөндий, Ханбогд сумын Оцон Мааньт, Ховд аймгийн Манхан сум Хойт Цэнхэрийн гол, Баян-Өлгий аймгийн Алтанцөгц зэрэг олон газраас олджээ.

Доод палеолитын үед Монгол нутагт оршин амьдарч байсан хүний хөдөлмөрийн гол зэвсэг нь хугадас, гилбэр ба мэсэн зэвсэг байсан бөгөөд тэдгээр нь цохих, цавчих, хэрчих, хусах зэрэг олон үйлд хэрэглэгдэж байжээ. Тэр үеийн хүн эдгээр үндсэн зэвсгээс гадна бүхэл чулуунаас хэлтэлж авсан хурц ирмэгтэй зузаан нимгэн залтас, ялтас, мөн арслан заан, савгат хирс зэрэг аварга том амьтны яс, модон бороохой, шийдэм зэргийг ашиглаж байжээ.

**Хуучин чулуун зэвсгийн дунд үе (100,000-40,000 жил)**. Дунд палеолитын үндсэн зэвсэг нь таргил үлдэцнээс өргөн ялтас цуулан авч түүний ирмэгийг нь дахин засаж хийсэн гурвалжин мэс юм. Хурц ирмэгтэй гурвалжин мэсийг хутганы зориулалтаар, нимгэн мэсийг мод, ясанд суулгаж жад маягаар хэрэглэж байснаас гадна арьс шир янзлах, мод, ясан эдлэл хийхэд ашигладаг байсан.

Монгол нутагт оршиж буй дунд палеолитын үеийн бууц суурин, дархны газрууд, тэр дундаа Өвөрхангай аймгийн Хархорин сумын нутагт орших Орхон I, Орхон VII, (9, 10-р давхрага), Богд сумын нутаг Арц Богд, Баянхонгор аймгийн Богд сумын Аргалант I, Орог нуур I, II, Өмнөговь аймгийн Ханбогд сумын Оцон Мааньт зэрэг дурсгалуудаас Дунд палеолитийн үеийн хомосафиансийн төрөлтэй холбоотой Мустьен соёл олддог.

Дунд палеолитийн үеийн хүмүүс чулуун зэвсгээс гадна өдөр тутмын үйл ажиллагаандаа том амьтдын ясыг бага зэрэг засаж зэвсэг хийх, модон савааны үзүүрийг галд түлж хатууруулан жадны оронд хэрэглэх, том бөөрөнхий чулууг дүүгүүр болгон ашиглаж байсан нь мөн мэдэгдээд байна.

**<u>Хуучин чулуун зэвсгийн дээд үе (40,000-12,000 жил).</u>** Палеолитийн дунд үеэс дээд үе руу шилжих явцад бие бялдрын болон зан суртахууны хувьд орчин үеийн хүний шинж бүрэлдсэн (Homo sapiens sapiens). Энэ нь чулуун зэвсгийг шинэ арга барилаар хийдэг болсноос тодорхой харагдаж байна. Энэ үед хүмүүс гонзгой үлдэцнээс урт, хутга шиг ирмэг цуулан авч, түүнийгээ цэвэрхэн засч янзлан хоёр талтай зэвсэг хийж эхэлсэн. Чулуун зэвсгээр дахин дахин ирлэж, засч янзалж хэрэглэсээр байгаад эртний хүмүүсийн чулуун зэвсэг хийх арга барил нь эрс сайжирчээ.

Энэ үеийн хүний үйл ажиллагааны ул мөр (голдуу чулуун зэвсэг) Өвөрхангай аймгийн Хархорин сумын Мойлтын ам, Хэнтийн аймгийн Рашаан хад, Батширээт сум, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын Төлбөрийн голын суурин зэрэг газруудаас олон тоогоор олддог.

**<u>Дундад чулуун зэвсгийн үе (12000-8000 жил)</u>.** Мезолитын үед газар тариалан, мал аж ахуй үүсэх эхлэл тавигдаж, эртний хүмүүс нум сумыг зохион бүтээжээ. Энэ үед Умард Ази, Өрнөд ба Дорнод Европод түрж орсон их мөстлөгийн үе нэгэнт дуусч цаг агаар эрс зөөлөрч Умард Ази (Сибирь) их ойт бүс, Төв Азийн байгал газар зүйн байдал, амьтан ургамлын аймаг орчин үеийн төрхийг олсон байна.

Манай орны Баянхонгор аймгийн Баян-Өндөр сумын Чихэн агуй, Дорнод аймгийн Халх гол сумын Хэрээ уул, Чойбалсан хотын орчим Хэрлэн голын баруун эрэг, Өвөрхангай аймгийн Мойлтын ам (I үе), Хэнтий аймгийн Рашаан хад (II-III үе), Дорноговь аймгийн Дулааны говь, Өмнөговь аймгийн Булган сумын Баруун, Зүүн хайрхан уул болон Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Дундговь, Дорноговь, Сүхбаатар аймгийн зарим газраас мезолитын үеийн дурсгалыг илрүүлэн судалжээ.

**<u>Шинэ чулуун зэвсгийн үе (8000-3000 жил).</u>** Неолитийн үеийн хүний аж ахуйн гол шинж нь ан гөрөө хийх, ургамлын үр үндэс түүх зэрэг байгалийн бэлэн бүтээгдэхүүнийг шууд хэрэглэх нь хязгаарлагдаж мезолитын үед эхлэлийн төдий байсан үйлдвэрлэхүй аж ахуй ба өөрөөр хэлбэл газар тариалан, мал аж ахуй эрхлэх ажилд шилжсэн явдал юм.

Неолитын үед чулуугаар зэвсэг хийх дадлага туршлага, арга ухаан өмнөх үеэс улам илүү хөгжиж ахуй амьдралын аливаа хэрэгцээнд олон төрөл эдлэлийг маш нарийн хийцтэй үйлдэх болжээ. Ялтасыг шовгор үлдэцний бүх талаас уртааш нь цуулах болсон тул тэр нь зөв талт урт хутган хэлбэртэй болсон байна.

Чулуун эдлэл хийгээд гарсан энэ үеийн нэг гол онцлог нь чулууг сайтар зүлгэж билүүдэх, өнгөлөх, хөрөөдөж ховил гаргах, өрөмдөж цоолох аргыг сэдэж олсонд оршино.

Неолитын үед Монгол оронд оршин суугчид чулуун зэвсгээс гадна ясаар хийсэн эдлэл өргөн хэрэглэж байжээ.

Неолитын үеийн хүний үйлдвэрлэлийн бүтээгдэхүүний бас нэг чухал шинэ ололт нь шавар ваар, сав бүтээн хийж хэрэглэх болсон явдал юм.

Дээр дурдсан төрөл бүрийн зэвсэг, ваар сав бүхий тэр үеийн хүний бууц суурин Баянхонгор, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Дундговь, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Төв, Увс, Хэнтий зэрэг тус орны ихэнх аймгийн нутгаас олджээ.

### 2.8.3 Төмөр зэвсгийн үе

**Хүрэл зэвсгийн үе**. МЭӨ II мянган жилийн тэртээгээс Евразийн хээр тал нутагт хүрлээр хийсэн эдлэл өргөн тархаж эхэлжээ. Ойролцоогоор МЭӨ II мянган жилийн тэртээ зэсийг цагаан тугалга, хар тугалгатай хольж хайлуулан хүрэл гэдэг шинэ холимог төмөрлөгийг гарган авч үйлдвэрлэлд нэвтрүүлснээр хүрэл зэвсгийн үе эхэлсэн гэж үздэг. Хүрэл зэвсэгт шилжсэн үе нь эдийн соёлд гарсан хувьсгал байгаад зогсоогүй аж ахуй, нийгмийн харилцаанд ч үндсэн өөрчлөлт гаргасан юм. Хүрэл зэвсгийн үед амьдарч байсан хүмүүс, эртний хүрэл зэвсгийн үйлдвэрлэл явуулж байсан дурсгалууд, түүвэр олдвор, дөрвөлжин булш, хиригсүүр, буган хөшөө, хадны зосон зураг, хадны сийлмэл зураг зэрэг олон төрлийн дурсгалыг үлдээсэн байна.

**Төмөр зэвсгийн түрүү үе.** Төмөр зэвсгийн түрүү үе нь хүй нэгдлийн нийгмийн төгсгөлийн шат бөгөөд тэр үед эртний овог аймгууд төмрийн хүдрийг хайлуулах аргыг эзэмшиж, төмрөөр хөдөлмөрийн багаж, байлдааны зэр зэвсэг үйлдвэрлэх болжээ.

Хүн төрөлхтөний урьд өмнө туулж ирсэн чулуун зэвсэг, хүрэл зэвсгийн үеийг бодоход төмөр зэвсгийн үе богино юм. Үнэн хэрэгтээ төмөр одоо хүртэл үйлдвэрлэлийн чухал үндсэн түүхий эд хэвээрээ байна. Гэвч энеолит /зэс чулуу/ ба хүрэл зэвсгийн үед эртний боолын нийгмийн соёл иргэншил үүссэн /Месопотами, Египет, Грек, Энэтхэг зэрэг/ орнуудаас бусад нутагт амьдарч байсан хүй нэгдлийн үеийн овог аймгуудын түүхийг ангилан судлахад "төмөр зэвсгийн түрүү үе" гэдэг нэр томъёо хэрэглэдэг. Төмөр зэвсгийн үйлдвэрлэл дэлхийн орон бүрт харилцан адилгүй өөр өөр үед тархсан байна.

**Дөрвөлжин булш.** Дөрвөлжин булш нь Монголын хүрэл зэвсгийн үеийн археологийн томоохон дурсгалын нэг юм. Дөрвөлжин булш жижиг толгодын орой шил, даваа хөтөл дээр ганц нэг, хоёр гурваараа тохиолдохоос гадна тэднийг гол төлөв уулын энгэр, бэл, аманд мөн тэгш талын дунд нэг дор арваас хэдэн арав хүртэл тоотой хэсэг бүлгээр нь барьж байгуулсан байдаг. Дөрвөлжин булш дорнод Монголын талаас Алтайн уулс, Байгал нуураас Говь хүртэл өргөн тархсан археологийн томоохон дурсгал юм.

Дөрвөлжин булшны зохион байгуулалтыг авч үзвэл, хайрцаглан хийсэн нимгэн хавтгай чулуун авсанд хүнээ оршуулж, том зузаан хавтгай чуулуунуудаар дарж таглан шороогоор булаад дээр нь хавтгай чулууг босгон эгнүүлэн дөрвөлжлөн зоож, дотор гадна хаяаг нь арай багавтар чулуугаар дарж бэхэлсэн байдаг.

**Хиргисүүр.** Хиргисүүр нь хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн өвөрмөц дурсгал юм. Хиргисүүрийг үйлдэгчид нь хүрэл ба төмөр зэвсгийн түрүү үеийн нүүдэлчид байсан гэдэг нь түүний дөрвөлжин булш, буган хөшөөтэй нэг дор нэгэн цогцолбор болон оршин байдгаас илэрхий. Манай орны нутаг дэвсгэр дээр байгаа хиргисүүрүүд нь гаднах хэлбэр төрх зохион байгуулалтын хувьд гуч орчим төрөлд хуваагдана Хиргисүүр нь том хэмжээний дугуй овгор чулуун дараас, түүнийг тойруулан чулуу эгнүүлэн зоож дугуй, дөрвөлжин хүрээ татсан байдаг. Судлаачид хиргисүүрийг МЭӨ II мянган жилийн төгсгөл МЭӨ I мянган жилийн эхэн үед холбогдуулан авч үздэг.

**Буган хөшөө.** Гонзгой урт чулууг засч, гурав зааглан, оройн хэсэгт нар сар, доогуур нь олон эгнээ хонхор, эх биеийг ороолгон төв хэсэгт сүрэг бугыг загварчилсан байдалтайгаар ихэд сүрлэг сийлж, бас доогуур нь бүс татан зэр зэвсгийг зүүсэн байдалтай дүрсэлсэн хөшөө чулууг буган хөшөө хэмээн нэрлэдэг. Хөшөөнөө дайчин эрийн зэвсэг болох чинжал хутга, билүү, байлдааны алх, нум, хоромсого, жад, бамбай, толь дүрслэхээс гадна хөшөөний бүсийг олон төрлийн хээгээр чимсэн байдаг. Буган хөшөөг эрдэмтэд 100 орчим жилийн тэртээгээс судлаж энэ завсар 700 орчим буган чулуун хөшөөг олж илрүүлжээ. Эдгээрээс хамгийн их буюу 550 орчим нь Монгол улсын нутгаас олджээ.

**Хадны зураг.** Монгол орны нутаг дэвсгэр дээр оршин амьдарч байсан хүрэл зэвсгийн үеийн хүмүүсийн үлдээсэн өөр нэгэн хосгүй дурсгал бол хадны зураг юм. Энэ үед холбогдох хадны зургийг улаан зосон, сийлмэл хэмээн ангилан авч үздэг. Монгол орны хүрэл зэвсгийн үед холбогдох улаан зосон зургийн гол төлөөлөгч нь "Сэлэнгэ"-ийн төрлийн зосон зураг юм. Монгол нутагт амьдарч байсан хүрлийн үеийн овог аймгийн гишүүдийн оюун санааны хөгжилтийг харуулах өөр нэгэн томоохон дурсгал бол хадны сийлмэл дурсгал юм. Энэ төрлийн дурсгал монгол нутгийн хад чулуунд харьцангүй олон тоотой байдаг төдийгүй нэгэн хаднаа өөр өөр үеийн дурсгалууд ч давхарлагдан зурагдаж холилдсон байдаг.

**Чандманий соёл**. Монгол оронд төмөр зэвсгийн эхэн үед амьдарч байсан хүмүүсийн  аж ахуй, соёлын олон талт асуудлыг улируулан тодруулан судлахад Увс аймгийн Улаангом хотын ойролцоох Чандмань уулнаа малтан шинжилсэн өвөрмөц хэлбэрийн булшууд онцгой ач холбогдолтой юм. Эдгээр булш нь тодорхой нэгэн овог аймгийн дурсгал болох тул Монголын археологийн судалгаанд тусгай соёл болгон авч үздэг. Чандмань уулын булш гадаад хэлбэр төрх, ухэгсдийг оршуулсан зан үйлээрээ том дөрвөлжин чулуун далантай, чулуун далантай авсгүй, жижиг чулуун австай, дүнзэн бунхантай шороон булш гэсэн үндсэн дөрвөн төрөлд хамаарах ажээ.

**Пазырыкийн соёл**. Монгол Алтайтай хил залгаа Монгол, Орос, Хятад, Казахстаны Алтайд МЭӨ VI-II зуунд холбогдох пазырыкийн соёл хэмээх чухал нэгэн дурсгал байдаг билээ. Энэхүү соёлд хамаарах булш оршуулгыг XIX зууны үеэс судлаж эхэлсэн бөгөөд харин анхны өргөн хүрээтэй малтлагыг 1920-иод оноос С.И. Руденко, М.П. Грязнов нар хийжээ. Пазырыкчууд бол хагас нүүдлийн мал аж ахуйг эрхэлдэг байсан бөгөөд мөн гар урлал өндөр хөгжсөн байсныг булшнаас гарах эд өлгийн зүйлс гэрчилнэ. Одоогийн байдлаар 120 гаруй газар 600 гаруй том жижиг булшийг малтан шинжлээд байгаа бөгөөд Алтайн өндөр уулын бүсэд байх мөнх цэвдэгтэй эдгээр булш өдгөө нийт хүн төрөлхтний соёлын чухал өвд тооцогдож байдаг билээ.

### 2.8.4 Эртний улсуудын үе

**Хүннү гүрний үе.** МЭӨ III зууны үед хүннүчүүд бусад нүүдэлч аймгуудаасаа хүчирхэгжин аймгийн байгууллын хувьд шинэ шатанд орох эхлэлээ тавьжээ. Хүннүгийн аймгийн холбоог шанью нэртэй хаан захирдаг байсан бөгөөд МЭӨ III зууны үе хүртэл аймаг буюу зонхилогчийн зөвлөлөөр сонгодог байсан боловч дараагаар нь үе залгамжлуулах хэлбэрт шилжсэн байна. Хүннүчүүд Модунг хаан болсны дараагаар хөрш зэргэлдээ аймаг улсуудыг цэрэглэн эзлэж газар нутгаа тэлэн өргөсгөх бодлого баримталсан байна.

Хүннү нарын дотоодын зөрчил болон овог аймгуудын хоорондын тэмцлээс шалтгаалан Хүннү гүрэн нь МЭӨ 57-55 оны хооронд умард, өмнөд гэсэн хоёр хэсэг болон хуваагдаж Хуханье шаньюйгаар толгойлуулсан өмнөд хүннүчүүд Хан улсын харьяанд орж, Хуханьейн ах Чжичжи умард Хүннүг захирах болжээ.

МЭӨ III - МЭ II зуун хүртэлх хугацаанд Төв Азийн өргөн уудам нутагт Хүннү нар нүүдэллэн амьдарч, төр улсаа цогцлон байгуулж, мандан бадарч байсны бодит нотолгоо болох археологийн дурсгалууд Монгол орны нутаг дэвсгэрээс олон тоотойгоор олддог.

Хүннүгийн археологийн дурсгалыг дотор нь булш бунхан, хот суурин, хадны зураг гэж ерөнхийлөн ангилан авч үзнэ.

**Хүннүгийн булш бунхан.** Хүннүгийн үед холбогдох булш бунханыг оршуулгын зан үйл, гаднах хэлбэр төрх, дагалдуулсан эд зүйл зэргээр нь язгууртны болон жирийн иргэдийн гэж хуваан авч үздэг. Энэ хоёр булш нь гаднах төрх байдал, зохион байгуулалтаараа эрс ялгаатай байдаг төдийгүй булшнаас гарч байгаа эд өлгийн зүйлсийн хувьд ч ялгагдана.

Язгууртны булш нь хэмжээний хувьд харьцангуй том, дөрвөлжин чулуун өрлөг далантай, үүдэвчтэй байдаг. Хүннүгийн язгууртны ийм булш манай орны Төв аймгийн Борнуур сумын нутаг Ноён уулын Сүжигт, Зурамт, Хужиртын ам, Ховд аймгийн Манхан сумын Тахилтын хотгор, Архангай аймгийн Хайрхан сумын Хүнүй голын Гол мод, Хэнтий аймгийн Баян-Адарга сумын Борбулаг, Дуурлиг нарс зэрэг газруудад олон тоогоор байна. Мөн Буриадын нутаг Ильмовын ам, Дерестуй зэрэг газруудад ч хүннүгийн язгууртны бүлэг булшууд байдаг.

Хүннүгийн жирийн иргэдийн булшийг Өвөрхангай аймгийн Богд сумын Тэвш уул, Булган аймгийн Бүрэгхангай сумын Өвгөнт, Үүдэнт, Хөвсгөл аймгийн Галт сумын Нүхтийн ам, Архангай аймгийн Эрдэнэмандал сумын Наймаа толгой, Батцэнгэл сумын Худгийн ам, Солби уул, Хөвсгөл аймгийн их-Уул сумын нутаг Сул толгой, Булган аймгийн Хутаг-Өндөр сумын нутаг Бурхан толгой, Төв аймгийн Алтанбулаг сумын нутаг Морин толгой, Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Дуулга уул зэрэг олон газруудад малтан шинжилжээ.

Хүннүгийн жирийн иргэдийн булш нь 5-13 м дугуй чулуун далантай байх ба далангаас доор 1.7 м гүнд нүх ухаж дотор нь банзан авс болон мод чулуугаар хийсэн хашлаганд хүнээ толгойгоор нь хойд зүг хандуулан тэнэгэр байдлаар хэвтүүлэн оршуулсан байдаг. Хүннүгийн жирийн иргэдийн булшийг малтан судалсан хэрэглэгдэхүүнээс үзэхэд сонгосон газар зүйн байршилт, булшны гадаад байдал, бүтэц зохион байгуулалт, булшинд үхэгсдийг оршуулах зан үйл, дагалдуулан тавьсан эд өлгийн зүйл зэрэг бүхий л талаараа дундад зууны төдийгүй өнөөгийн монголчуудын үхэгсдээ оршуулдаг заншилтай ижил төстэй байгаа нь хүнну монголчууд хоёр нэгэн угсаатан болохыг археологийн талаас нь харуулж буй чухал үндсэн баримт гэж үзэж болно.

**Хот суурин**. Хүннүгийн археологийн судалгааны чухал хэрэглэгдэхүүний нэг бол тэр үеийн хот суурин юм. Хүнну нар нүүдлийн мал аж ахуй эрхлэхийн зэрэгцээ тодорхой хэмжээгээр газар тариалан эрхлэн хот суурин байгуулан сууж байсан байна.

Төв аймгийн Борнуур сумын Бороогийн суурин, Мөнгөнморьт сумын Хүрээн дов, Тэрэлжийн дөрвөлжин, Бүрхийн дөрвөлжин, Эрдэнэ сумын Өндөр дов, Баянжаргалан сумын нутаг Хэрлэн голын Цагаан арлын Гуа дов, Дорнот аймгийн Цагаан-Овоо сумын Баруун Дөрөөгийн хэрэм, Барс хот II, Хэнтий аймгийн Жаргалтхаан, Дэлгэрхаан сумын зааг нутагт орших Цэнхэрийн голын хэрэм, Булган аймгийн Бүрэгхангай сумын нутаг Шувуутайн голын хэрэм, Өмнөговь аймгийн Номгон сумын нутаг Баянбулагийн турь зэрэг Хүннүгийн үед холбогдох хот суурины үлдэцийг археологийн хайгуул шинжилгээний ажлын явцад олж илрүүлэн заримыг малтан судалжээ.

**Хадны зураг**. Хүнну нарын үлдээсэн археологийн дурсгалын өөр нэг төрөл бол хадны зураг юм. Манай орны нутаг дэвсгэрээс олдсон хэдэн мянган хадны зургаас судлаачид Ховд аймгийн Үенч, Алтай сумын зааг нутаг Ямаан усны хавцлын Ханан хаданд дүрслэгдсэн гурвалсан морь хөллөсөн сүйх тэрэг, тамган дүрс, Баян-Өлгий аймгийн Улаан хус сумын нутаг Цагаан салаагийн хаднаа буй нохойд хөөгдсөн аргалийг угтан харваж буй анчныг дүрсэлсэн зургуудыг хүннүгийн үед холбогдуулан авч үздэг. Гэвч Хүннүгийн үед холбогдох зурагнууд нэлээд байх боловч тэдгээрийг одоо хир нарийвчлан судлаагүй байгаа билээ.

### 2.8.5 Түрэгийн үе

Түрэгүүд нь Төв Азид эрт цагаас оршин нутагласаар ирсэн, түүх соёл, угсаа гарлаараа монголчууд, тэдний өвөг дээдэстэй туйлын ойрын холбоотой нүүдэлчин ард түмэн юм. Монгол болон зөрчид угсаатны нэгэн адил алтай язгуурын хэлний бүлэгт хамаарах түрэгүүд VI-VIII зууны үед нийт Төв Ази түүний дотор одоогийн Монгол нутгийг харьяандаа багтаасан хүчирхэг хаант улсыг байгуулж энэ бүс нутаг дахь түрэг угсаатны 400 орчим жилийн ноёрхлын эх үндсийг тавьжээ.

Түрэг угсаатанд холбогдох археологийн эд өлгийн дурсгалт зүйлийн дотор хаад ноёд, жирийн иргэдэд зориулсан тахил тайлгын онгон, тэдгээрийн бүрэлдэхүүнд багтах хүн чулуу, адгуус амьтны дүрс, руни бичээст пайлуур хөшөө, уран барилгын холбогдолт дурсгал, хад чулуу болон бусад эд зүйлд сийлбэрлэн гаргасан элдэв зураг, их бага бичээсийн зүйлс, нас барагсдийг оршуулсан булш хиргисүүр зэрэг зүйлс орж байна.

**Тахил тайлгын онгон**. Түрэгийн тухайт эд өлгийн дурсгал, нэн ялангуяа тэдний хамгийн их нийтлэг бөгөөд өргөн тархсан дурсгал болох тахил тайлгын онгоны цогцолборууд нь түрэг угсаатан оршин суусан Евразийн уудам нутгаар өргөн тархсан бөгөөд манай орны Хэнтийн уулсаас Алтайн их уулсыг хүртлэх нутагт элбэг олддог. Эдгээр нь уг нас барсан хүний язгуур угсаа, зэрэг дэвээс шалтгаалан их бага, янз бүрийн хэмжээтэйгээс гадна бүтэц зохион байгуулалтаараа ч эрс ялгаатай байв.

Жирийн иргэдийн онгон нь хавтан чулууг газарт хайрцаглан суулгаж хийсэн дөрвөлжин хашлага, түүний өмнө (зүүн талд) байрлуулсан хүн дүрст чулуун хөшөө, уг хөшөөний өмнөөс наран ургах зүгийг чиглүүлж цувруулан зоож тавьсан балбал хэмээх зэл чулуун эгнээ зэрэг үндсэн хэсгээс бүрдэнэ.

Язгууртны онгоныг үйлдэхдээ, өнгөлж засаад хээ угалз гарган чимэглэсэн дөрвөн хавтангаар хашлага босгож өмнө нь нэлээд бодитой уран хийцтэй хүн чулуу тавьж олон тооны зэл чулуу цувуулсан байна.

**Хүн чулуу.** Түрэгийн тайлгын онгоны нэг бүрэлдэхүүн хэсэг болох хүн чулуун хөшөө нь тухайн үеийн хүмүүсийн төрх байдал, хувцас өмсгөл, эд хэрэглэл, гоёл чимэг, зэр зэвсгийн төрөл зүйл, тэдгээрийн онцлог зэргийг сэргээн тодруулж судлахад онцгой ач холбогдолтой эх сурвалж баримт төдийгүй тэр үеийн дүрслэх урлагийн хөгжил, гоо сайхны үзлийн хэмжээ төвшинг илтгэн харуулдаг байна. Монгол нутагт эдүгээ нийт 500 гаруй хүн чулуу илрүүлэн олж бүртгээд байгаагийн 400 гаруй нь түрэгийн үед холбогдох ба цаашид ч шинээр нэмэн олдох боломжтой юм. Хүн чулуу хэмээх нь боржин, гантиг, хүрмэн чулуу, элсэн чулуу занар зэрэг чулуугаар хүний дүрс оруулан хийж тахил тайлгын онгоны бүрэлдэхүүнд оруулан босгодог хөшөө юм.

### 2.8.6 Уйгурын үе

Түрэгийн хаант улс мөхсөний дараа түүний ор суурийг Уйгур улс эзэлж VIII-IX зууны үед Монгол нутагт ноёрхлоо тогтоожээ. Уйгур нь мөн алтайн хэлний бүлэгт багтах түрэг угсаатан байв.

Уйгурчууд хот балгад барьж суурьшин суух талаар бусад нүүдэлчдээс нэлээд онцлогтой байлаа. Тэд манихейн шашныг дэлгэрүүлж согдын гар урчуудын туслалцаатайгаар энэхүү шашны сүм дугана барьдаг байжээ. Уйгурууд дөрвөлжин шавар хэрэмт бэхлэлт хотуудыг их барьдаг ба хил хязгаарыг сэргийлэн хамгаалах бэхлэлт хотын бүхэл бүтэн сүлжээ бүрэлдэн тогтсон байжээ. Манай улсын нутагт уйгур улсын сүр жавхлант нийслэл Ордубалык буюу Хар балгас, мөн шашин номын томхон төв болж байсан Сэлэнгэ мөрний хөвөөн дэх Бийбулагийн балгас зэрэг хотууд байдгийг археологийн талаар бага сага шинжин судалж байжээ. Уйгурууд, Монгол нутагт оршин тогтнож байсан олон аймаг, улсын дотор нэлээд дээгүүр соёлтой байжээ. Тэр үеийн дурсгалын тоонд, "Сэлэнгийн бичээс" хэмээн алдаршсан Могойн шинэ усны гэрэлт хөшөө, Архангай аймгийн Тариат сумын нутаг дахь Тэрхийн бичээс зэрэг бичиг үсгийн томхон дурсгалууд орно.

### 2.8.7 Кидан

Монгол нутагт оршиж байсан эртний улсуудын нэг нь Кидан улс юм. 901 онд Киданы хаанаар Елюй овгийн Амбагянь тодрон гарч эрх мэдлээ бэхжүүлэн хуучин найман аймгийг үндэс болгон Кидан улсыг байгуулжээ. Кидан гүрэнд 55 аймаг улс багтсан ба тэдгээрийг өмнөд замын 16 аймаг, умарт замын 28 аймаг, гадаад 8 аймаг гэж хуваадаг. 5 нийслэлтэй, газар нутаг нь дорнод далайгаас Алтайн уулс, Хэрлэн голоос Хятадын цагаан суваг хүртэл өргөжсөн байна.

Монгол нутгаас Киданы үед холбогдох археологийн дурсгалууд бусад үеийнхийг бодвол харьцангуй цөөн тоогоор олддог. Монгол нутагт буй Кидан нарын холбогдолт археологийн дурсгалаас хамгийн олон тоотой хийгээд харьцангуй сайн судлагдсан нь хот балгадын үлдэц юм. Монголд олддог Киданы холбогдолт археологийн дурсгалын дотор хот суурины дурсгал зонхилж байдаг. Түүхийн сурвалж бичиг, археологийн мэдээгээр манай улсын нутагт киданы үеийн арваад хот мэдэгдэж байна. Киданы булш оршуулгын дурсгалыг малтан шинжилсэн байдлаас үзэхэд эл төрлийн дурсгал, тэдний уугуул нутаг Шар мөрөн, Урчи мөрөн зэрэг нутгаас их олддог байна. Киданы булшийг зохион байгуулалтынх нь хувьд нүх ухаж оршуулсан булш, газар дор хонгил хийж оршуулсан хаад ноёдын булш гэсэн үндсэн хоёр хэсэгт хуваaж үздэг.

### 2.8.8 Дундад зууны үе

**<u>Монгол гүрний үе</u>**. Төв Азид ноёрхон байсан Кидан гүрэн XII зууны үед мөхсөний дараа монгол угсааны овог аймгууд Хятадын цагаан хэрмээс Сэлэнгийн эх хүртлэх нутгийг эзлэн оршиж байв.

XIII зууны эхээр эдгээрийн дотроос Хамаг Монголын ханлиг нэн хүчирхэгжин нийт монгол угсаатныг нэгтгэн 1206 онд Онон мөрний эхэнд их хуралдай хийж Тэмүжинг Чингис хаан цолоор өргөмжлөн Их Монгол улсыг байгуулжээ. Ингээд Чингис хаан засаг захиргаа шинэчлэн тогтоож цэргээ зохион байгуулж, хил хязгаараа өргөтгөн тохинуулжээ. Чингис хааны зарлигаар Хар Хорумд улсын нийслэлийг байгуулж, дараах хаадын үед өргөтгөн барих ажлыг гүйцэтгэсээр иржээ. Харин 1260 онд Хубилай хаан улсын нийслэлийг өмнө зүг шилжүүлж Хятад газар төвлөрөн сууж улсын нэрийг Их Юан болгон өөрчилжээ. 1368 онд Монголчуудын байгуулсан Их Юан улс Хятадын босогчдод цохигдон мөхсөнөөр монголчууд уугуул нутагтаа төвлөрөх болсон ч өмнөх сүр хүч нь доройтон суларч өөр хоорондоо тэмцэн хямарсан бутралын үе эхэлжээ. Энэ байдал удтал үргэлжилсээр 17-18-р зууны үед монголчууд бүхэлдээ Манж Чин гүрний мэдэлд орж улс төрийн тусгаар тогтнолоо алдахад хүргэсэн юм.

**<u>Хот суурин</u>**. Монголчуудын байгуулсан хот суурингаас хамгийн их хэмжээтэй судлагдсан нь XIII зууны Монголын нэгдсэн улсын нийслэл Хар Хорум хот юм. Хот нь эргэн тойрон хүрээлсэн шавар хэрэмтэй, дөрвөн талдаа хаалгатай, төв хэсэгтээ огтлолцсон хоёр их гудамжаар гар урлал, худалдаа арилжаа, орд харш, сүм хийдийн гэх хэдэн үндсэн хэсэгт хуваагдаж байв. Хар Хорум хотын барилга байгууламжийн зохион байгуулалт, гоёл чимэглэлийн хэрэглэгдэхүүнээс IX-XII зууны үеэс уламжлан ирсэн орон нутгийн уран барилгын арга барил харагддаг. Тэр үед монгол оронд Хар Хорумаас гадна хэд хэдэн хот байсныг сурвалж бичгийн мэдээ гэрчлэх бөгөөд, тухайлбал, Саорин, Тосху болон хааны дөрвөн их орд гэж байжээ. Одоо мэдэгдэж байгаагаар монголчуудын барьж байгуулсан хот суурины хамгийн эртнийх нь XII зууны үед холбогдох Аврагын балгас юм. Энэ нь Хэрлэн голын баруун гарын цутгал Аваргын голын хойд эрэгт Рашаан дэрсний ухаа хэмээх уулын өмнө бэлд орших ба 4,5 ам дөрвөлжин км талбайтай.

Археологийн судалгааны явцад Монголын их гүрний үед холбогдох өөр бусад хотуудыг ч илрүүлэн олж ямар нэгэн хэмжээгээр малтан судалж байсны тоонд Хэрлэн Барс, Хар хул хааны балгас, Шаазан хот, Халтарын балгас зэргийг дурдаж болно.

**<u>Монголчуудын булш оршуулга</u>**. Дундад зууны монголчуудын нийгмийн харилцаа, үйлдвэрлэх хүчний хөгжил, зан суртахуун, шашин шүтлэг, ахуй байдлыг бодитойгоор судлан шинжихэд чухал ач холбогдолтой дурсгалын нэг нь тэр үеийн булш оршуулга юм.

Түүхийн сурвалжид тэмдэглэн үлдээснийг үзвээс эртний монголчууд нас барсан хүнээ газрын хөрсөн нүх малтаж булшлан оршуулах ба тэр хүний амьд ахуйдаа хэрэглэж асан эд юмсын зүйлсээс даглдуулан хийдэг байсныг тодорхой өгүүлжээ. Эртний энэ заншил шарын шашин монголд дэлгэснээр орхигдож нас барсан хүнээ ил задгай нутаглуулах болжээ.

Эдүгээ манай улс болоод ОХУ-ын нутагт монгол булш малтан шинжилсэн байдлыг үзэхэд эгэл жирийн иргэдийн булш оршуулгэа голлож байна. Эдгээрийг газар зүйн байрлалыг ажиглахад ямар нэгэнуул, өндөрлөг газрыг сонгон авч уулын өмнөд энгэр, хормой бэл, тэгш дэвсэг газар оршуулдаг нь хаа ч нийтлэг үзэгддэг юм. Дундад зууны монгол булш ихэвчлэн газрын хөрсөн дээр чулуу өрж хийсэн, чулуун дараасны өрлөг нь урт талаараа умар зүг чиглэсэн, цөөвтөр чулуутай, нуугдмал байдалтай байна. Дараасыг хуулж авахад голдуу дан шороогоор булж төдий л гүн биш, австай, авсгүй хоёр янзаар оршуулсан байдаг.

**Хүн чулуу**. Монгол оронд байгаа хүн чулуу нь VI-IX зууны Түрэг овог аймгуудын, XIII-XIV зууны Монгол гүрний үеийн хүн чулуу хэмээх үндсэн хоёр төрөлд хамаарна. Монгол гүрний үеийн хүн чулуу Монгол улсын зүүн өмнөд хэсгээр байрлажээ. Монголын үеийн хүн чулууг баруун гартаа хундага барьж, зүүн гараа сандлын түшлэгт, эсвэл өвдөг дээрээ тавин түшлэгтэй сандалд суугаа байдлаар урладаг. Мөн энэ үеийн хүн чулууг зөв тийш дарсан ташуу энгэртэй, урт хормой, нарийн ханцуйтай дээлтэй, мухар буюу шөвгөрдүү, заримдаа яльгүй ээтийж эргэсэн хоншоортой гутал өмссөнөөр дүрсэлсэн нь түрэг болоод бусад төрлийн хүн чулуунаас их ялгаатай байна.

Монголчуудын хүн чулуун хөрөг нь тухайн үеийн хүмүүсийн бодит дүр төрх, хувцас өмсгөл, гоёл чимэглэл, эдлэл хэрэгслэлийн онцлогийг тусган харуулах түүхэн чухал сурвалж болохын зэрэгцээ тэр үеийн монголчуудын гоо сайхны мэдрэмж, урлаг уран сайхны түвшин, урчууд дархчуудын ур чадварыг илтгэн харуулах дүрслэх урлагийн үнэт дурсгал болох юм.

### 2.8.9 Өмнөговь аймагт явуулах археологийн судалгаанд ашиглах асуултууд

Монголын түүхийн үндэс суурийг 750,000 жилийн өмнөх хүртэл авч үзэн, цаашид Өмнөговь аймагт хийх археологийн судалгаанд удирдамж болгох үүднээс төсөөлөлд-суурилсан багц асуултуудыг санал болгох боломжтой. Эдгээр асуултыг Монголын эртний түүхтэй холбоотой асуудлуудад хариулт олох, дэлхийн бусад улс оронтой харьцуулах боломжит мэдээлэл цуглуулах зорилгод тулгуурлан боловсруулав. Үүний дүнд дэлхийн бусад орнуудтай харьцуулах замаар Монголын түүхийг тодорхой тайлбарлан өгүүлэх боломж бүрдэнэ.

Дараах үндсэн зургаан асуудалд тодорхой хариулт өгөхүйц археологийн мэдээлэл олж тогтоох, тайлбарлахыг бид онцгойлон зөвлөж байна.

- Тухайн археологийн дурсгал нь Монгол язгуур угсааг тодорхойлоход туслах түүхийн баримтад ямар түвшинд хувь нэмэр оруулж чадах вэ? (өөрөөр хэлбэл, "монгол соёл" гэж юу болох, энэ нь хэзээнээс онцгой өвөрмөц дүр төрхөө олж ялгарахуйц болсон бэ?) Үүнтэй адилаар тухайн археологийн мэдээллүүд нь Монголын түүхийн маргаантай элементүүд болох Түрэг, Уйгар, Кидан болон бусад үндэстэн ястны соёлыг тодорхойлоход хэрэглэгдэж болно.
- Байгаль, цаг уурын өөрчлөлт нь Монголын соёлын хөгжилд хэрхэн нөлөөлсөн бэ?
- Түүхий эд боловсруулж ашиглахад гарсан өөрчлөлтүүд нь эртний археологийн олдворуудад илрэх боломжтой эсэх? Энэхүү түүхий эд ашиглалтын өөрчлөлтийг хэрхэн тайлбарлаж болох вэ?
- Хүн байгалийн харилцан шүтэлцээний хувьсал өөрчлөлтийг археологийн дурсгалт газруудын орон зайн тархалтад тулгуурлан сэргээн босгож тогтоож, тайлбарлаж болох уу?
- Археологийн нотолгоонд үндэслэн хүн төрөлхтний өнгөрсөн үеийн түүх болон "бодит бус" орчинг илрүүлэн тогтоож, хөрвүүлэн тайлбарлах боломжтой юу? Өөрөөх хэлбэл, "онгон дагшин газрууд" нь археологийн баримтуудад ямар түвшинд/чухам хэзээ өөрийн дүр төрхийг илтгэн харуулах вэ?
- Өмнөговь аймаг дахь археологийн олдворууд нь түүхэн газар, хүмүүстэй хэрхэн/ямар түвшинд холбогдох боломжтой вэ? Өөрөөр хэлбэл, Монголын соёлын гарал үүсэл, хөгжил цэцэглэлтийг сайтар ойлгож мэдэхэд Монголын түүх, археологийн баримтууд нь харилцан бие биетэйгээ хэрхэн уялдаж, баяжигдаж чадах вэ?

### 2.8.10 Судалгааны зорилгод хүрэхэд шаардлагатай өгөгдлүүдийн категориуд

Хоорондоо харилцан хамаарал бүхий эдгээр зургаан асуултыг боловсруулахдаа эд өлгийн соёлын баримт нотолгоо /соёлын биет өв/-г дэс дараалаар нь авч үзсэн бөгөөд тэдгээрийн заримыг нь цаг тооллын үргэлжлэлийн хожуу үеийн түүхийн баримтуудтай холбогдуулан боловсруулсан.

Юуны өмнө, газарзүйн байршлын мэдээллүүдийг цуглуулж, хөрвүүлэн тайлах замаар том талбайтай газар нутгийн ашиглалтыг олж мэдэх ёстой. Түүхийн бүх үеийн археологийн дурсгалт газруудад статистикт үндэслэсэн хайгуул судалгаа явуулах талаар системтэй арга хэмжээ авах хэрэгтэй. Тэгснээр тэдгээр мэдээллүүд нь газарзүйн мэдээллийн систем /GIS/-тэй уялдаж чадах бөгөөд цаг хугацаа өнгөрөх явцад газар ашиглалтад гарсан өөрчлөлтүүдийн талаар илүү  тодорхой мэдээлэл өгч чадна.

Хоёрдугаарт, иймэрхүү хайгуул судалгаа нь гадаргын хайгуул, малтлагаар дамжуулан, тэр ч бүү хэл  геологийн үе давхрагын түвшинд хүртэл нарийвчлан судлагдах  боломжтой археологийн дурсгалт газруудыг олж тогтооно.

Гуравдугаарт, эд өлгийн хэрэглэгдэхүүнүүдийг, ялангуяа Монголын соёлын онцлог шинжийг илтгэн харуулах олдворуудыг хөрвүүлэн тайлах боломжийг бүрдүүлэх үүднээс археологийн мэдээллүүдийг түүхэн болон аман уламжлалтай харьцуулж авч үзэх ёстой.

Дөрөвт, археологийн мэдээллүүд нь тухайн үеийн цаг уурын өөрчлөлтийн талаарх баримтыг агуулсан байдаг учраас ширгээгүй гол, нуурын доторх ялзмагуудад бичигдэн үлдсэн эрт дээр үеийн цаг уурын тухай мэдээллийг олж авах нь чухал. Дээрээс нь археологийн олдворуудаас ургамлын тоос, амьтны ясны үлдэгдлүүдэд дүн шинжилгээ хийснээр Монголын эртний соёлын өөрчлөлтөд уур амьсгал, хүрээлэн буй орчин хэрхэн нөлөөлснийг олж мэдэх боломжтой.

Эцэст нь, эдгээр өргөн хүрээтэй мэдээллийн эх сурвалжийг ашиглан мэдээлэл олж авах боломжийг нэмэгдүүлэхийн тулд өргөн хүрээтэй салбар хоорондын арга замыг ашиглах шаардлагатай. Ингэхдээ археологийн мэдээллүүдийг устаж үгүй болох эрсдлээс хамгаалах, Монголын өөр өөр бүс нутгаас олдсон археологийн олдворуудын ач холбогдлыг харьцуулах үр дүнтэй арга боловсруулах болон Монголын соёлыг гарал үүсэл, хөгжил цэцэглэлтийнх нь хувьд хосгүй өвөрмөц шинжийг тодорхойлох цогц аргачлалыг боловсруулах зэрэг олон зорилтыг нэг дор гүйцэтгэх боломжтой болох юм.

### 2.8.11 Оюу толгой төслийн археологийн дурсгалууд

2002 онд Цогтцэций, Манлай сумын заагт буй Хармагтайн хайгуулын лицензийн талбайд авран хамгаалах хайгуул судалгааны ажлыг гүйцэтгэж нийт 61 дурсгалыг бүртгэсэн байна [Цэвээндорж нар, 2002]. Харин 2003 онд Оюу товгорт буй эртний зэсийн ухмал геологийн сувагт өртөгдөн сүйтгэгдсэн болохыг судлаачид мэдээлэн түүний дагуу тус компанид шаардлага тавин цаг алдалгүй KHR Ex.03.01, KHR Ex.03.02, KHR Ex.03.03, KHR Ex.03.04 гэсэн дугаартай малтлагуудыг гүйцэтгэж тухайн дурсгалыг бүтэц зохион байгуулалтыг тодорхойлж чадсан юм [Цэвээндорж нар, 2003].

Энэхүү дурсгалууд нь хүрэл зэвсгийн үе буюу одоогоос 3000-4000 жилийн тэртээ хүмүүс байгалийн зэс олзворлож байсан ил уурхайн үлдэгдэл бөгөөд үүнийг гэрчлэх баримтууд цөөнгүй гарсан билээ (Зураг 17, Зураг 15). Мөн 2008 онд Засгийн газрын 175-р тогтоолын хавсралтаар Аймгийн хамгаалтанд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтанд орсон байна [Түүх, соёлын., 2008; 281].



**Зураг 15 Оюут товгорын зэсийн ухмалын малтлага судалгааны явц болон зарим олдвор хэрэглэгдэхүүн**





**Зураг 16** **Оюу Толгойн зэсийн ухмалын ерөнхий байдал болон малтлагын зүсэлтийн зураг**

Мөн Оюу толгойн уурхайн бүсэд буй өөр нэгэн зэсийн ухмал бүрэн устаж үгүй болно (Зураг 16). 2002 онд энэхүү ухмалыг малтан судлаж [Цэвээндорж нар, 2002] зохих эрдэм шинжилгээний эх хэрэглэгдэхүүнийг цуглуулжээ. Мөн цаашид уг дурсгалыг хэрхэн баримтжуулан хойч үедээ өвлүүлэн үлдээх талаар тус компани мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллаж байгаа билээ. Гэсэн хэдий ч Оюу толгой хэмээх дэлхийд томоохонд тооцогдох нөөц бүхий уурхайг биднээс өмнө ойролцоогоор 3000 жилийн тэртээ нээж, олзворлож, ашиглаж байсан баримт бүрэн устаж үгүй болж байна.

## 2.9 Соёлын өвтэй холбогдох асуудлаар Оюу толгой компаний хийж байгаа ажлууд

Оюу толгой компани нь Монгол улсад хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх түүний дотроос түүх-соёлын дурсгалын хадгалалт хамгаалалтын талаар байгуулагдсан цагаасаа эхлэн анхаарч ирсэн билээ. Гэхдээ уул уурхайн үйл ажиллагааны явцад шууд болон дам нөлөөллөөр биет өвийн дурсгал ямар нэгэн хэмжээгээр сүйтгэгдэж байгааг энд дурдах нь зүйтэй.

Мөн уул уурхайн барилга байгууламж, ашиглалтын явцаас гадна дам нөлөөллөөс хамааран зарим дурсгал сүйтгэгдэх тохиолдол гарч байгаа юм. Үүний нэг жишээ бол Оюу толгой компаниас зүүн урагш 70 орчим км зайтай Галбын говид орших Мангасын хүрээ юм (Зураг 18). Энэхүү дурсгалыг урьдчилсан байдлаар МЭӨ I-МЭ I зууны үед буюу Хүннү гүрний үед хамаарагдах цэргийн бэхлэлт хот болохыг тогтоогоод байгаа [Амартүвшин нар, 2010] бөгөөд уг хэрмийг Монголын түүхийн чухал дурсгал хэмээн үзэж Монгол улсын Засгийн газрын 2008 оны 175-р тогтоолын хавсралтаар Аймгийн хамгаалалтанд байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтанд оржээ [Түүх, соёлын., 2008; 281].

2005 онд уг дурсгалыг судлаачид мэдээллийн дагуу очиж танилцах үед дурсгал нь хэвийн хадгалалттай байсан бол 2009 онд дахин очиход энд тэнд цооноглон малтаж тонон сүйтгэсэн байв. Энэхүү хотын турийг тонон сүйтгэх болсон шалтгаан нь нэгдүгээрт, хувиараа алт олборлогч болон эртний эдлэл цуглуулагч нар уг хотын туриас хүрэл эдлэл олон тоотой гардаг гэсэн мэдээллийг авсан. Хоёдугаарт, Гашуун сухайтын боомтоор нэвтрэх зорилготой иргэд зам зуураа үзэж танилцах, өмнөхтэй ижил мэдээллийн дагуу шалгаж, олз ашиг хайн тонон сүйтгэсэн байж болох талтай. Гэхдээ, дурсгалын талаарх мэдээллийг хаанаас олсон бэ гэдэг нь чухал асуулт юм. Мангасын хүрээ нь Гашуун сухайтын боомт хүрэх автозамаас даруй 20-30 км зайтай, зөвхөн хойноос болон зүүн талаас орох бүдэг замтай, Хилийн заставаас хойш 10 гаруй км зайд оршдог гээд олон талын хамгаалалт байдаг юм.

Гэвч энэ дурсгалын талаарх мэдээллийг маш дэлгэрэнгүй олж авч чадсан тонуулчид урт, хэцүү замыг туулан нилээд сүрхий багаж техниктэй ирж сүйтгэсэн нь харагддаг. Энэ нь магадгүй Оюу толгойд олон газраас ирэн ажиллаж байгаа ажилчдын бусдад өгсөн мэдээлэл, эсвэл нутгийн иргэдийн өөрсдийн хийсэн шунахайн сэдэлттэй зүйл болох талтай.





**Зураг 17** **Оюут товгорын ерөнхий байдал болон тухайн үеийн "Айвенхоу Майнз Монголия инк" компанийн зарим удирдлагууд ирж ажилтай танилцаж байгаа байдал**





**Зураг 18** **Мангасын хүрээний сансрын зураг ба дурсгалыг хууль бусаар ухаж сүйтгэснийг харуулсан зургууд**

Соёлын өвийг хууль бусаар тонохын эсрэг Оюу Толгой компани ямагт ажилласаар ирсэн бөгөөд СӨХ боловсруулах ажлын хүрээнд барилгын болон уурхайн ажлын үед археологийн юмуу палеонтологийн дурсгал олдсон тохиолдолд ямар арга хэмжээ авах талаар дотоод журмыг МОУӨБ боловсруулсан (Хавсралт 5). Уг дотоод журам нь барилгын менежерүүд болон хүнд машин механизмын операторуудын өдөр тутам мөрдөх баримт бичиг юм.

### 2.9.1 Эдгээр дурсгалууд ямар ач холбогдолтой вэ?

Хүн төрөлхтний хөгжлийн түүхэнд төмөрлөг боловруулалтын үе ихээхэн чухал байр эзэлдэг. Аливаа ард түмний эртний түүхэнд зэсийн хүдрийг олборлож улмаар түүнийг хайлуулж, боловсруулах арга эзэмшиж хөдөлмөрийн багаж, зэвсэг хийх болсон явдал нь үйлдвэрлэлийн салбарт гарсан онцгой чухал ач холбогдол бүхий дэвшил болсон юм. Монголын төмөрлөг боловсруулалтын асуудлыг манай ууган археологч Х. Пэрлээ ихэд анхаарч Дорнод аймгийн Халх гол сум, Дорноговь аймгийн Эрдэнэ, Мандах, Даланжаргалан сумд, Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Онгон, Хонгор, Дарьганга сумд, Өвөрхангай аймгийн Гучин ус, Говь-Алтай аймгийн Бигэр зэрэг сумдын нутгаас зэсийн хүдэр хайлуулж байсан нутаг, зарим газраас нь зуухны улбаа олдсоныг бүртгэж тэмдэглэсэн байна. Мөн Өмнөговь аймгийн Булган сумын Баянзаг, Гурван Тэс сумын төв орчимд неолитын суурингаас чулуун зэвсэг, шавар сав суулганы хагархайн хамт зэсийн хайлш, түүнчлэн Баянхонгор аймгийн Баянлиг сумын нутаг Зоог-Зуухаас зэс хайлуулж байсан хоёр зуух олдсон юм. Сүүлийн жилүүдэд явуулсан археологи, геологийн судалгаагаар эрт үед зэс олборлож байсан ором, зэсийн хүдрийг хайлуулж байсан зуух, дутуу хайлсан хүдэр, зэсийн хайлш шинээр олдохоос гадна эдгээр ажилд хэрэглэж байсан багаж зэвсгийн зүйлс олдсоор байна. Тухайлбал, Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Ханбогд уулын ноён оргилоос чанх баруун тийш Умдайн гол хэмээх хуурай сайрын зүүн талын дэвсэг дээр орших ухмалууд, Оюу толгойн зэсийн ухмалуудыг геологчид эртнээс мэддэг байсан байна. Эндхийн зэсийн ухмалын ойролцоогоос олон тооны чулуун зэвсэг, шавар ваарны хагархай олддог.

2002 онд ШУА-ийн Археологийн хүрээлэн "Айвенхоу Майнз Монголиа Инк" компанийн ашиглалтын лиценз бүхий "Оюу толгой" төслийн бүсэд археологийн малтлага судалгаа явуулж эрт цагт зэсийн хүдэр олзворлож байсан зэсийн дөрвөн ухмалыг малтан судалсан.

Манай орны археологийн судалгааны түүхэнд урьд өмнө зэсийн хүдэр олзворлож байсан эртний ухмалуудыг тусгайлан малтан шинжилж байгаагүй бөгөөд энэ утгаараа бидний судалгааны ажил Монголын археологийн судалгаанд нэгэн шинэ хуудас нээсэн судалгаа болсон юм.

Судалгааны ажлын явцад олдсон хүдэр бүхий хадыг бутлаж байсан бутлуур болох чулуун лантуу, чулуун сүх хийгээд мал амьтны яс зэрэг нь энэхүү эртний зэсийн ухмалууд ойролцоогоор хэдий үед холбогдож болохыг тогтоох боломжийг бидэнд олгож байна. Чулуун бутлуурын хийцийн бүдүүлэгдүү байдал, хэмжээ зэрэг нь эртний энэ ухмалууд нь одоогоос 4.000-5.000 мянган жилийн тэртээд ашиглагдаж байсныг илэрхийлж байна. Өөрөөр хэлбэл шинэ чулуун зэвсгийн үеэс хүрэл зэвсгийн үед шилжсэн шилжилтийн үед буюу зэс чулуун (энеолит) зэвсгийн үед холбогдоно. Үүнийг батлах өөр нэгэн баримт бол ухмалуудаас чанх баруун зүгт 18 км зайтай орших Жавхлант уулын хадны зургийн дурсгал юм. Жавхлант уулын хаднаа зэс чулуун зэвсгийн үеийн хэмээн нэрлэгддэг гурван хуруутай хүнийг олон тоогоор дүрсэлсэн байдаг. Энэ нь тухайн үед оршин амьдарч байсан хүмүүс энэхүү зэсийн ухмалуудыг ашиглаж байсан болохыг болон уг ухмалууд нь зэс чулуун зэвсгийн үед холбогдох болохыг давхар батлан харуулж байна.

Монгол нутаг дээр амьдарч байсан эртний хүмүүс нь дэлхийн бусад хэсэгт байсан хүмүүсийн нэгэн адил нэгэн цаг үед метал зэвсгийг амьдрал ахуйдаа хэрэглэж байсан бөгөөд ингэхдээ тэд өөр газраас металыг авч ашиглалгүй өөрсдийн амьдарч байгаа газар орондоо зэсийн агуулга бүхий чулуун хүдрийг уурхайн маягаар авч ашиглаж байжээ. Уурхай маягаар малтахдаа зэсийн хүдрийн судлыг дагуулсан нь тэдний ашигт малтмал ашиглах мэдлэг, туршлага тодорхой түвшинд хүрсэн байсныг харуулж байна.

Ийм учраас Оюу толгойгоос хэрэгжүүлж буй “Соёлын өвийн хөтөлбөр”-ийн хэрэгжилтийн явцад Монгол нутагт оршин амьдрагсадын чулуун зэвсгийн үеэс төмөрлөг зэвсэгт шилжсэн шилжилт, төмөрлөг олборлолт, боловсруулалтын үүсэл, хөгжлийн түвшинг илтгэж буй чухал баримт болох энэхүү зэсийн ухмалын жижигрүүлсэн загварыг хийж үлдээн ирээдүйд байгуулагдах музейн чухал нэгэн үзмэр болгох хэрэгтэй юм. Энэ нь шинжлэх ухаан, танин мэдэхүйн хувьд чухал ач холбогдолтойгоос гадна бусад уул уурхайн компаниудын үйл ажиллагаанд өртөж болзошгүй Монголын түүх, соёлын дурсгалуудын хадгалалт, хамгаалалтад хэрхэн анхаарах тал дээр жишиг болох юм.

### 2.9.2 Боломж

СӨХ-ийн анхаарч ажиллах ёстой элементүүдийн нэг нь Монгол нутагт уул уурхай эрхэлж байсны ул мөр болон “Оюу Толгой” үүнтэй хэрхэн уялдаж буйг судлах юм. Оюу Толгой дахь эртний зэсийн ухмал болон тэр үед хүмүүс хэрхэн зэс хайлуулдаг байсныг харуулсан жижиг хэмжээний үзмэр хийхийг бид санал болгож байгаа. Ингэснээр соёлын өвийг хадгалж, хамгаалахын чухлыг болон уул уурхай эрчимтэй хөгжиж буй энэ үед өв соёлоо хэрхэн авч үлдэх хэрэгтэй талаар хүмүүст ойлгуулахад тустай.

Нөхцөл байдлын дүрслэл нь соёлын өв болон археологийн үнэт зүйлсээ хадгалж хамгаалахын ач тусыг хүмүүст таниулна. Оюу Толгой төдийгүй Монголын бусад уул уурхайн компаниуд археологийн дурсгалын хадгалж, хамгаалах ажилд цаг, хөрөнгө зарцуулснаар үр шимийг нь бүх хүн хүртэх боломжтой болно.

## 3. БИЕТ ӨВ —ПАЛЕОНТОЛОГИ

**Х. Цогтбаатар, Б. Гүнчинсүрэн**

Хэдий дэлхийн олон оронд динозаврын үлдэц зэрэг нь шинжлэх ухааны судлагдахуун талаасаа авч хэлэлцэгддэг бол Монгол улсын хувьд хүн бүр үүнийг үндэсний соёлын өвийн нэг хэмээн үздэг. Ийнхүү чухлаар тавигдах болсны үндсэн шалтгаан нь судлаачид гэхээсээ илүүтэй ард иргэд үүнийг өөрсдийн өв, соёлын нэг хэсэг гэж үздэг байсанд оршино. Харамсалтай боловч үнэндээ динозаврын өндөг гэх мэт палеонтологийн дурсгалууд нь аялал жуулчлал болон хууль бус тонолтын улмаас орлогын нэг эх үүсвэр хэмээн тооцогдсоор байна.

Уг бүлэгт бид палеонтологийн дурсгал гэж юу болох, яагаад чухалд тооцогддог талаар болон "Оюу Толгой" төслийн шууд нөлөөллийн бүс болон Өмнөговь аймгийн нутаг дэвсгэрт буй гол палеонтологийн дурсгалт газруудын талаар өгүүлэх болно. Мөн үүний дараа СӨХ боловсруулах ажилд загвар болгон ашиглах боломжтой Америк улсад хэрэгжсэн жишээнүүдээс оруулсан болно. Өмнөговь аймгийн палеонтологийн судалгаатай холбоотой номзүйн материалуудыг (Хавсралт 2) хавсралтаас үзэж болно.

### 3.1 Эртний амьтан, ургамлын үлдэгдлийн талаар та юу мэдвэл зохилтой вэ?

Эртний амьтан, ургамлын үлдэгдэл нь ховор, нөхөн сэргээгдэхгүй бөгөөд Монголын байгалийн баялгийн чухал хэсэгт тооцогддог. Мөн шинжлэх ухааны судлагдахууныхаа хувьд маш олон чухал мэдээллийг өөртөө агуулж байдаг. 1920-д оны үеэс эхлэн Монгол улс эртний амьтан, ургамлын үлдэгдэл ихтэй, бараг 150 сая жилийн тэртээх эртний ертөнцийн талаар шаардлагатай ойлголтыг өгдөг дэлхийд чухалд тооцогдох газруудын нэг болж ирсэн.

Хэд хэдэн шалтгааны улмаас эртний амьтан, ургамлын үлдэц, тэр дундаа сээр нуруугүйтэн амьтдын үлдэц ховор байдаг. Ихэнх организмууд бүрэн утгаараа хадгалагдаж чадаагүй байдгийн учир нь тэнд яс, шүд гэх мэт хатуу хэсгүүд байдаггүй. Тэр бүр тааралдаад байдаггүй хурдасууд нь зөөлөн хэсгүүдийг фоссил болтол нь хадгалж чаддаг байна. Механик болон биологийн процесс нь организмын том хэсгүүдээс илүүтэй жижиг хэсгүүдийг хурдан сүйтгэдэг. Монголын говьтой адил эртний амьтан, ургамлын үлдэцийг хадгалж үлдсэн газар дэлхий дээр тун цөөхөн байдаг.

Хаанаас олдсон нь тодорхойгүй амьтан, ургамлын үлдэц төдийлөн үнэ цэнэтэй байдаггүй. Харин хаанаас, хэрхэн олдсон нь тодорхой үед илүү судалгааны үр өгөөжтэй байж, тухайн амьтан хэрхэн амьдарч байсан талаарх мэдээллийг бидэнд өгдөг. Тухайн үлдэцийг ашиглан тэр үеийн экологи, байгаль орчны талаарх мэдээллийг авч чадахын хирээр үлдэц үнэ цэнтэй байдаг.

Эволюц хувьслын явц болон харилцан хамаарлыг ойлгон мэдэхийн тулд өөр өөр амьтны араг ясыг хооронд нь харьцуулах шаардлагатай. Үүний тулд судлаачид шинэ төрөл зүйлийг өмнөхөөс нь ялгах чадвартай байх хэрэгтэй.

## 3.2 Монгол улсын эртний амьтан, ургамлын үлдэгдэл яагаад хадгалагдах ёстой вэ?

Эртний амьтан, ургамлын үлдэц нь хүүхэд, насанд хүрэгчид, судлаачид зэрэг хүн бүрийн хувьд чухал өв. Эртний амьтан, ургамлын үлдэцийг ашиглан бид амьдралын тухай, түүн дээр бичигдсэн түүхүүдийн тухай олж мэддэг. Шинжлэх ухааны олон чухал ач холбогдолтой үнэт олдворууд Монгол улсын нутагт дэвсгэрт хадгалагддаг. Иймд бид эдгээр үнэт дурсгалуудаа сайтар хадгалж, хамгаалан үлдэх учиртай.

## 3.3 Оюу толгой төслийн бүсэд хэдэн төрлийн, ямар палеонтологийн дурсгалууд хадгалагдаж байна вэ?

Оюу толгой төслийн шууд нөлөөллийн бүсэд хамрагдах Өмнөговь аймгийн Ханбогд, Манлай, Баян-Овоо сумын нутагт дэлхийд данстай палеонтологи (эртний амьтан ургамал судлал – эртний шим ертөнц судлал)-ийн олдворт газар олон байдаг. Эдгээр сумдын нутагт байдаг Байшин цав, Хуурай цав, Амтгай, Үрэлбэ худаг, Шар цав хэмээх олдворт газрууд Монгол орны Мезозойн эриний Хожуу цэрдийн галавын эхэн үеийн (145 сая жилийн өмнөх) амьтан ургамлын хувьсал, хөгжлийн үндсэн баталгаа болдог үлэг гүрвэлийн зарим бүлгийн эх нутаг болох нь тогтоогдож, улмаар баталгаажсаар байна.

Эдгээр олдворт газруудад 1970-1980-аад онд ажиллаж байсан Монгол-Зөвлөлт (Орос)-ийн палеонтологийн хамтарсан экспедици, 1990-ээд оноос ажиллаж байгаа Монгол-Японы хамтарсан палеонтологийн экспедицийн эрдэмтэн судлаачид олон сонин олдворыг нээн олж, судлан шинжилж, шинэ төрөл зүйлийг тогтоосон байна. Тухайлбал: Segnosaurus galbinensis (Сегнозавр), Erlikosaurus andrewsi (Эрликозавр), Enigmosaurus mongoliensis (Энигмозавр) зэрэг холимог идэшт үлэг гүрвэл, Garudimimus brevipes (Гарудимимус), Alectrosaurus olsoni (Алектрозавр) зэрэг махан идэшт үлэг гүрвэл, Quaesitosaurus orientaslis (Куаситозавр), Hadrosauroid gen et sp.nov (Гадрозаврын эртний өвөг төлөөлөгч), Pachycephalosaurid gen et sp nov (пахицефалозаврын шинэ төрөл) зэрэг өвсөн идэшт үлэг гүрвэлүүдийг нэрлэж болно.

Мөн, Шар цав хэмээх үлэг гүрвэлийн мөр бүхий олдворт газрыг Ханбогд сумын нутагт орших Байшин цавын олдворт газраас зүүн хойш 10 орчим км-т 1995 оны 7 сарын 31-ны өдөр Монгол-Японы палеонтологийн хамтарсан экспедици анх нээсэн бөгөөд 1996, 2001 онуудад тус экспедици нарийвчилсан судалгааг явуулжээ. Шар цавын үлэг гүрвэлийн мөр, зам, хөлийн дардас нь байгальд бүтээгдсэн хэв маягаараа хатуу элсжингийн үе давхаргадас дээр хадгалагдсан бөгөөд уг элсжингийн үе нь том ширхэгтэй элсэн чулуунаас бүрдсэн байдаг. Үлэг гүрвэлийн мөр, жим нь хэлбэр хэмжээний хувьд олон янз болох нь тогтоогдсон ба багаар тооцоход 4-5 өөр үлэг гүрвэлийнх гэдэг нь батлагдсан юм.

Үлэг гүрвэлийн сайн хадгалагдсан зам, мөр, жим нь эрт галавын амьтны аймгийн экологи (тухайн амьтдын сүргийн бүтэц, тоо хэмжээ), зан араншин, хөдөлгөөн зэргийг тогтооход маш чухал мэдээ баримт болдог.

Энэ бүс нутагт тархсан олдворт газруудаас үлэг гүрвэлийн хөгжлийн хамгийн сонирхол татахуйц, ээдрээтэй, өвөг удмын холбооны хувьд эртний шинж байдлыг хадгалсан амьтдын олдвор олддог учраас сээр нуруутны хувьсал, хөгжлийн зүй тогтлыг танин мэдэх судалгаанд цаашид ихээхэн ач холбогдолтой байх болно. Дээр дурдсан олдворт газруудыг тусгайлсан бодлоготойгоор хамгаалах явдал Монголын төдийгүй олон улсын анхаарлын төвд зайлшгүй байх ёстой. Энэ бүс нутгаас олдож байгаа үлэг гүрвэлийн олдворууд нь Умард Америк (АНУ ба Канад)-д хамгийн өргөн дэлгэр тархан хөгжиж байсан гадрозавридын овгийн амьтдын үүслийн төв хөгжлийн голомт нь Төв Ази байсан гэдгийг баталж байдаг.

Соёлын өвийг хадгалах хамгаалах хөтөлбөрийн суурь судалгааны эхний үед шууд болон шууд бус нөлөөллийн бүст хамрагдах газрууд, Өмнөговь аймгийн гол газар нутгаар судалгаа хийсэн (Хавсралт 6). Оюу Толгойн төслийн улмаас хамгийн их эрсдэлд орох палентеологийн гол газруудыг доор тайлбарлав.

### 3.3.1 Байшин цав

**Геологийн нас:** Хожуу Цэрд (Баян ширээгийн настай; Кампаниас өмнөх цаг үе)

**Газарзүй:** Энэ олдворт газар өргөн уудам тэгш талбайд эрэг болон багавтар илэрцүүдийг үүсгэсэн олон тооны жижиг цавуудаас тогтдог. Энэ олдворт газрыг 5 дэд хэсэгт хуваадаг (BTs-I, II, III, IV ба V). Байшин цав-I нь зүүнээсээ баруун тийш сунаж тогтсон, өмнө зүгт харсан үргэлжилсэн эргээс тогтдог. Байшин цав II ба V нь Байшин цав-I-ийн зүүн үзүүрээс урагш үргэлжлэх хэд хэдэн илэрцүүд юм. Харин Байшин цав III ба IV нь дээрх дэд хэсгүүдээс баруун урагш орших намхан эрэг, жижиг толгойн тусгаарлагдсан жижиг илэрцүүдийг хэлнэ.




**Зураг 19 Монголын өмнөд хэсэг дэх палеонтологийн дурсгалууд**

**Геологи:** Олдвор агуулсан давхаргадас нь элсжин ба шавранцарын үе ээлжлэн тогтсон хурдас хуримтлалтай. Зүсэлтийн ихэнх хэсгүүдэд элсжингийн үе давамгайлсан байдаг ба эртний хөрс (paleosol)-ний хөгжилт энд ажиглагддаггүй. Байшин цав-V дэд хэсэг дэх элсжингийн үе давхаргад аварга хэмжээтэй (10-30 см-ийн диаметртэй) мөрт малтмал (trace fossil)-ын олдвор тохиолддог. Уг олдворт газрын дэд хэсгүүд дэх элсжингийн хатуу үеийн гадаргуу дээрх урсгалын бидрээгээр эртний голын урсгалын ерөнхий чиглэл нь урд зүгээс баруун зүгт чиглэсэн нь тогтоогдсон байна.

Эдгээр үе давхаргадас нь сээр нуруутны чулуужсан олдвороор баян. Сүүлийн жилүүдэд гадрозавройд (Ornithopoda, Dinosauria)-ын олон бүрэн бүтэн хэлхээ яс, бөөгнөрөн хуримтлагдсан яснууд болон салангад яснуудыг нээн олж, судалсан байна [Tsogtbaatar, 2007]. Дромаеозаврид, орнитомимид болон сегнозавридын нилээд олдвор эндээс олдсон байна. Байшин цав-I олдворт газрын баруун хэсгээс үлэг гүрвэлийн өндөгний хальс (Elongatoolithid хэлбэр) олдсон байна.

Энэ олдворт газрын BTs-I дэд хэсгийн баруун үзүүр хавийн шавранцарын давхаргаас далд үрт ургамлын навчны ор мөрийг 2004 онд анх удаа олсон байна [Suzuki et al., 2004].

### 3.3.2 Хуурай цав

**Геологийн нас:** Хожуу Цэрд (Баян ширээгийн настай: Кампаниас өмнө)

**Газарзүй:** Энэ олдворт газар нь Байшин цав олдворт газраас холгүй, баруун урагшаа 2.9 орчим км-т оршино. Чулуужсан олдвор агуулсан үе давхарга нь ерөнхийдөө урд зүг рүү харсан эрэг үүсгэн тогтсон. Энэ олдворт газрын давхаргадас нь Байшин цав олдворт газартай ижил формац.

**Геологи:** Чулуужсан олдвор агуулагч үе давхаргын литологи нь Байшин цавынхтай төстэй. Эртний голын урсгалын чиглэл нь баруун хойд зүгт чиглэсэн (301.8 degree, std = 8.15, N = 26)

Энэ олдворт газраас хүзүүний хэлхээтэй үе бүхий толгойн яс, хэлхээтэй сүүлний үеүд зэрэг гадрозавройдын хадгалалт сайтай олдвор олдож байсан.

### 3.3.3 Үрэлбэ Худаг

**Геологийн нас:** Хожуу Цэрд (Баян ширээгийн цаг үе; Камнаниас өмнөх цаг үе)

**Газарзүй:** Энэ олдворт газар нь энэ нутагт байдаг худгийн нэрээр нэрлэгдсэн боловч олдвор агуулсан үе давхаргадас намхан толгод болон тасархай толгойг үүсгэн энэ бүс нутагт өргөнөөр тархсан байдаг.

**Сээр нуруутан амьтдын олдвор:** Энэ олдворт газраас гадрозавройд орнитопод динозавр, аварга теропод динозавр, Эртний яст мэлхий, Эртний матар.

**Геологи:** Олдвор агуулагч давхаргадсын литологи нь голын үүсэлтэй, элсжин ба шавранцарын  үе ээлжлэн тогтсон, Байшин цав, Хуурай цавын давхаргадастай ойролцоо, голын эртний урсгалын чиглэл нь ихэвчлэн баруун зүг руу хандсан (252.2 degree, std = 4.17, N = 12)

### 3.3.4 Шар цав

**Геологийн нас:** Хожуу Цэрд (Нэмэгтийн цаг үе; Маастрихтийн цаг үе)

**Газарзүй:** Энэ олдворт газрыг зүүн талбай (үлэг гүрвэлийн мөртэй) ба баруун (Avimimus-ийн) талбай гэж хоёр хэсэгт хуваадаг. Энэхүү олдворт газрын баруун ба зүүн талбай нь өөр хоорондоо 2 км-ийн зайтай.

**Геологи:** Энэ олдворт газрын геологийг анх түрүүн Ивахненко ба Курзанов [1982] нар бичсэн байна. Сүүлийн 10 гаруй жил МЯПХЭ энэ олдворт газарт нарийвчилсан геологийн болон палеонтологийн судалгааг хийсэн. Энэ олдворт газрын олдвор агуулсан үе давхаргын литологи нь шавранцар болон нарийн ширхэгт элсжингийн үе ээлж дараалан үеэлсэн ба шавранцарын үе нь давамгай тархсан байна.

Зүүн талбай (үлэг гүрвэлийн мөртэй талбай)-н давхаргадсын зузаан нь 16 м хүрнэ. Энэ талбайн элсжингийн үеийн дээд гадаргууд бэдрээ (ripple mark) хадгалагдсан байдаг ба уг бэдрээний чиглэл нь зүүн хойш- зүүн урагшаас зүүн хойшебаруун урагш (31.2 +180 degree, N = 18), эртний голын урсгалын чиглэл нь хойд - баруун хойд зүг (338.5 градус, стандарт хэлбэлзэл = 5.42, N = 9)-т чиглэсэн байна.

Баруун талбайн илэрц нь урд зүг рүү харсан, зүүнээсээ баруун тийш үргэлжлэн сунасан, эрэглэж тогтсон байдаг. Уг талбайн давхаргадсын литологи нь ихэвчлэн ташуу болон зэрэгцээ үелэл бүхий зузаан элсжингийн үетэй бөгөөд зүсэлтийн литологи нь суналын дагуу олон янз байдаг. Энэ талбайн зүсэлтийн зузаалаг нь 14 м.

**Үлэг гүрвэлийн мөр, сээр нуруутан амьтдын олдвор:** Шар цавын олдворт газрыг анх 1995 оны 7 дугаар сарын 31-нд монгол-Японы хамтарсан Палеонтологийн экспедици Ханбогд сумын Эрээнцаваас зүүн хойш 10 км орчимд олж илрүүлсэн. Тухайн экспедици 1996 болон 2001 онуудад дахин ажиллаж нарийвчилсан судалгааг хийсэн. Шар цав дах динозаврын ул мөр нь элсэн чулуутай холилдсон элсэрхэг стратум дээр хадгалагдсан. Энэхүү мөр нь хөлийн хэлбэр хэмжээний хувьд өөр өөр байсан ба ойролцоогоор 4-5 төрөл зүйлийн үлэг гүрвэл байсан. Энэхүү маш сайн хадгалагдсан үлэг гүрвэлийн мөр нь эртний амьтдын экологи, зан авир, хөдөлгөөн, насыг тогтооход маш чухал ач холбогдолтой.

Энэ олдворт газраас орнитомимид үлэг гүрвэл олдож байсан баримт бий [Ивахненко и др., 1982]. Завропод үлэг гүрвэлийн шинэ төрөл зүйл Quesiatosaurus-ыг толгойн ясны олдворт үндэслэн эндээс олдсон хэмээн бичсэн байдаг [Курзанов и др., 1983]. Жижиг махан идэшт үлэг гүрвэл Avimimus-ын 5-аас доошгүй олдвор энэ газрын доод хэсгийн шавранцарын үеэс олдсон ба үлэг гүрвэлийн мөр маш элбэг, үлэг гүрвэлийн өндөгний хальс: elongatoolithid ба spheroolithid төрөл мөн олдож байсан, эртний шувууны мөчний яс болон яст мэлхий, матар эндээс олдсон байна [Watabe et al., 2010].

### 3.3.5 Амтгай

**Геологийн нас:** Хожуу Цэрд (Баянширээгийн цаг үе; Кампаниас өмнөх цаг үе)

**Газарзүй:** Энэ олдворт газар нь зүүн зүг рүү харсан намхан толгод, эргийг үүсгэсэн олон жижиг илэрцүүдээс тогтдог.

**Геологи:** Энэ олдворт газрын чулуужсан олдвор агуулсан үе давхаргын литологи нь Байшин цавын литологитой маш төстэй, саарал, цагаан цайвар цэнхэр өнгө бүхий элсжин болон шавранцарын үеийн хосолсон ээлж дараалалаас тогтоно. Илэрсэн үе давхаргадсын нийт зузаалаг маш бага (20 метрээс бага), Эртний голын урсгалын чиглэл нь нарийн ширхэгтэй элсжингийн үеийн ташуу үелэл дээрх хэмжилтээр 239 градус буюу баруун урагш чиглэсэн байв.

**Сээр нуруутан амьтны чулуужсан олдворууд:** Энэ олдворт газраас үлэг гүрвэлийн олон олдвор олдож байсан. Тухайлбал: холимог идэшт үлэг гүрвэл – сегнозаврын хэд хэдэн олдвор, орнитоподын сээр нуруунууд, мөчдийн яснууд, пахицефалозаврын толгойн яс, эртний яст мэлхийн маш том, зузаан хуяг зэрэг болно.

## 3.3.6 Өмнөговь аймаг дахь палеонтологийн дурсгалт газруудын байршил

Монголын говийн бүс нутагт одоогоор нийт 60 дурсгалт газар байгааг судлаачид тэмдэглээд байна. Эдгээрээс 31 дурсгалт газар буюу 53.3 хувь Өмнөговь аймгийн нутагт бий (Хүснэгт 7).

**Хүснэгт 7: Өмнөговь аймгийн нутагт буй палеонтологийн дурсгалт газрын мэдээлэл**

| № | Аймаг, сумын нэр | Олдворт газрын нэр | Геологийн нас | Талбайн хэмжээ (км-ээр) | Эх сурвалжууд |
|---|---|---|---|---|---|
| 1 | Гурвантэс | Бүгийн цав | хожуу цэрд, нэмэгтийн цаг үе | 12/5 | Watabe,Tsogtbaatar, Suzuki and Saneyoshi, 2010 |
| 2 | Гурвантэс | Хэрмэн цав | хожуу цэрд, баруун гоёот ба нэмэгтийн цаг үе | 4/8 | Сочава, 1975; Курзанов, 1990; Gradzinski, 1970; |
| 3 | Гурвантэс | Хэрмэн цав-ii | хожуу цэрд, нэмэгтийн цаг үе | 0.5/1.5 | Watabe,Tsogtbaatar, Suzuki and Saneyoshi, 2010 |
| 4 | Гурвантэс | Цагаан хушуу | хожуу цэрд, нэмэгтийн цаг үе | 1.2/1 | Барсболд, 1970; |
| 5 | Гурвантэс | Наранбулаг | хожуу цэрд, нэмэгтийн цаг үе ба палеоген | 1/1.3 | Мартинсон и др., 1969; Watabe,Tsogtbaatar, Suzuki and Saneyoshi, 2010 |
| 6 | Гурвантэс | Улаан хушуу | хожуу цэрд, нэмэгтийн цаг үе | 1.1/1 | Шувалов, 1970 |
| 7 | Гурвантэс | Алтан уул-ii | хожуу цэрд, нэмэгтийн цаг үе | 2/1.4 | Gradzinskii et al., 1974; 1977; |
| 8 | Гурвантэс | Алтан уул-iii | хожуу цэрд, нэмэгтийн цаг үе | 4.3/2 | Osmolska et al., 1970; |
| 9 | Гурвантэс | Алтан уул-iv | хожуу цэрд, нэмэгтийн цаг үе | 1.6/4.7 | Gradzinskii et al., 1974; 1977; |

| № | Аймаг, сумын нэр | Олдворт газрын нэр | Геологийн нас | Талбайн хэмжээ (км-ээр) | Эх сурвалжууд |
|---|---|---|---|---|---|
| 10 | Гурвантэс | Нэмэгт | хожуу цэрд, нэмэгтийн цаг үе | 2.5/2.5 | Watabe, Tsogtbaatar, Suzuki and Saneyoshi, 2010 |
| 11 | Номгон | Шилүүт уул | хожуу цэрд, баруун гоёотын цаг үе | 4.3/8 | Watabe et al.,2000; watabe, Tsogtbaatar, Suzuki and Saneyoshi, 2010 |
| 12 | Номгон | Өндөр богд | хожуу цэрд | 0.3/0.6 | Watabe et al.,2000; Watabe, Tsogtbaatar, Suzuki and Saneyoshi, 2010 |
| 13 | Манлай | Их шунхт | хожуу цэрд, баруун гоёотын цаг үе | 2/1.9 | Михайлов, 1991; Ивахненко и др., 1988 |
| 14 | Манлай | Шар цав | хожуу цэрд, нэмэгтийн цаг үе | 0.5/1.4 | Ивахненко и др., 1988; Курзанов и др., 1983 |
| 15 | Манлай | Шар цав (баруун хэсэг) | хожуу цэрд, нэмэгтийн цаг үе | 0.7/0.6 | Ивахненко и др., 1988; Курзанов и др., 1983 |
| 16 | Манлай | Амтгай | хожуу цэрд, баян ширээгийн цаг үе | 0.3/0.5 | Мартинсон, 1982; Watabe, Tsogtbaatar, Suzuki and Saneyoshi, 2010 |
| 17 | Манлай | Амтгай (хойд мөргөцөг) | хожуу цэрд, баян ширээгийн цаг үе | 0.9/0.6 | Watabe, Tsogtbaatar, Suzuki and Saneyoshi, 2010 |
| 19 | Ханбогд | Байшин цав | хожуу цэрд, баян ширээгийн цаг үе | 1.8/2.1 | Цыбин и др.,1979; Барсболд, 1988; Tsogtbaatar, 2004; 2006; 2008. |
| 20 | Ханбогд | Хуурай цав | хожуу цэрд, баян ширээгийн цаг үе | 0.8/1.2 | Цыбин и др.,1979; Барсболд, 1988; Tsogtbaatar, 2004; 2006; 2008. |
| 21 | Ханбогд | Үрэлбэ худаг | хожуу цэрд, баян ширээгийн цаг үе | 7.4/6 | Watabe,Tsogtbaatar, Suzuki and Saneyoshi, 2010 |
| 22 | Булган | Төгрөгийн ширээ | хожуу цэрд, жодохтын цаг үе | 1.8/5 | Твердохлебов и др., 1974; Fastovsky et al., 1997; Suzuki et al., 2002; Watabe, Tsogtbaatar, Suzuki and Saneyoshi, 2010 |
| 23 | Булган | Алаг тээг | хожуу цэрд, жодохтын цаг үе | 0.5/1.6 | Твердохлебов и др., 1974 |
| 24 | Булган | Баян заг | хожуу цэрд, жодохтын цаг үе | 1.3/3.4 | Dashzeveg et al., 2005; Jerzykewicz et al., 1991; Watabe, Tsogtbaatar, Suzuki and Saneyoshi, 2010 |
| 25 | Булган | Авдрант нуруу | хожуу цэрд, жодохтын цаг үе | 1.2/1 | Watabe, Tsogtbaatar, Suzuki and Saneyoshi, 2010 |
| 26 | Сэврэй | Үүдэн сайр | хожуу цэрд, жодохтын цаг үе | 1.2/2.2 | Ивахненко и др., 1988; Watabe, Tsogtbaatar, Suzuki and Saneyoshi, 2010 |
| 27 | Сэврэй | Замын хонд | хожуу цэрд, жодохтын цаг үе | 0.5/0.4 | Watabe, Tsogtbaatar, Suzuki and Saneyoshi, 2010 |
| 28 | Сэврэй | Бор толгой | хожуу цэрд, жодохтын цаг үе | | Watabe, Tsogtbaatar, Suzuki and Saneyoshi, 2010 |
| 29 | Сэврэй | Ягаан ховил | хожуу цэрд, нэмэгтийн цаг үе | 0.6/0.8 | Курзанов,1983; 1987; Watabe, Tsogtbaatar, Suzuki |

| № | Аймаг, сумын нэр | Олдворт газрын нэр | Геологийн нас | Талбайн хэмжээ (км-ээр) | Эх сурвалжууд |
|---|---|---|---|---|---|
| | | | | | and Saneyoshi, 2010 |
| 30 | Сэврэй | Алтан тээг | | 0.5/0.4 | |
| 31 | Цогт-овоо | Алгуй улаан цав | түрүү цэрд | | Сочава, 1975 |
| 32 | Манлай | Ар шар хад | түрүү цэрд | 1.5/4 | Калугина, 1980; Watabe, Tsogtbaatar, Suzuki and Saneyoshi, 2010 |

Эдгээр дурсгалууд нь Гурвантэс суманд 10, Номгон сум 2, Манлай суманд 6, Ханбогд суманд 3, Булган суманд 4, Сэврэй суманд 5, Цогт-Овоо суманд 1 гэсэн байдалтайгаар байрлана. Үүнээс харахад хамгийн их дурсгалын нягтралтай газар нь тус аймгийн баруун бүс нутаг болох нь харагдаж байна.

## 3.4 Монголын эртний амьтан, ургамлын үлдэцийн байдал ба түүнд учирч буй аюул, занал

Монголд эртний ургамал, амьтны үлдэгдэл, палеонтологийн олдворын газрыг хадгалж хамгаалах өнөөгийн үйл ажиллагаа нь ерөнхийдөө хангалтгүй байна. Монголд хууль бус судалгаа, дэлхийд цуутай палеонтологийн олдворт газруудыг ухах болон олдворыг олон улсад дамжуулан гаргах ажиллагаа ихсэх хандлагатай байна. Түүхийн янз бүрийн үнэт зүйлсийг хулгайлдаг мэргэшсэн хулгайн сүлжээнүүд газар авч байгаа ба энэ сүлжээнд хотын төвийн оршин суугчид ба гадаадын иргэд түүхийн олдвор бүхий газрын орчим амьдардаг орон нутгийн малчин, аймаг сумын дунд шатны албатнуудыг хамруулан оруулж байна.  Өмнөговь болон Баянхонгор аймагт хууль бусаар түүхийн олдворуудын ухсан, эвдэж сүйтгэсэн, хагас ухаж үлдээсэн ул мөр бүхий газрууд нилээд байна. Орон нутгийн хүмүүсийн мэдээлж байгаагаар эдгээр газрыг олон жилийн турш ухаж, эд хөрөнгөтэй болж бэлждэг хэд хэдэн бүлэг хүмүүс байдаг гэнэ. Эдгээр нь ШУА-ийн хүрээлэнгүүдийн хээрийн судалгааны ажил эхлэхээс өмнө 3, 4 дүгээр сарын үед хууль бус үйл ажиллагаагаа эхлэдэг ба тэд олсон олдворуудаа чанар болон ач холбогдлыг хэр үнэ хүрэх байдлаар нь үнэлдэг ба эдгээр олдвор, эд зүйлсэд учрах хор хөнөөл, гэмтлийг үл хайхран аль болох амар хялбар аргаар ухаж гарган авдаг байна. Тэдгээрийн олдвор, эд зүйлсийг ухан гаргаж байгаа арга технологи нь шинжлэх ухааны үнэ, ач холбогдлыг бууруулж, байгаль экологи болон түүхийн үнэт зүйлийн онгон байдлыг бууруулж байна.

Эдгээр гэмт хэрэгтнүүд жил бүр хилээр хууль бусаар олсон олдвор, эд зүйлийг зөөж байгаа талаар хэвлэл мэдээллээр мэдээлж байна. Тусгай зориулалттай багийн хичээнгүй ажиллагааны үр дүнд хурааж авсан эд зүйлс Улаанбаатар хотод байдаг Монгол улсын ШУА-ийн Палеонтологийн төвд шилжүүлэгдэн хадгалагдаж байна. Эдгээр хурааж авсан олдворуудын дунд ховор, шинжлэх ухааны чухал ач холбогдол бүхий олдворуудын хэсэг байгаа боловч ямар эх биетийн хэсэг болох олдсон газрыг тодорхойлоход хүндрэлтэй байна.

Монголын хууль эрх зүй, бодлого боловсруулагчид энэ асуудалд сүүлийн хэдэн жил нилээд анхаарал хандуулж ажиллаж байгаа (Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хууль батлагдан хэрэгжиж байна) боловч хууль бус үйл ажиллагааг хориглох, зөрчилд хариуцлага хүлээлгэх, хохирлын нөхөн төлбөр нь маш бага байгаа нь хууль бус үйл ажиллагааг бүрэн зогсоож чадахгүй байна.

Одоогийн байдлаар, эдгээр хууль эрх зүйн хэрэгжилт шинжлэх ухааны ач холбогдлын талаар мэдлэг, мэдээлэлгүй, мэргэжлийн зааварчилгаагүйгээр ухан гаргаж байгаа эртний олдвор эрэгчидийн үйлдэлээр зөрчигдөж, хэрэгжилтэнд муугаар нөлөөлж байна. Эдгээр хууль бус үйл ажиллагаанд зарим аймаг, сумын төр захиргааны албан хаагчид, геологийн хайгуул, уул уурхай болон аялал жуулчлалын байгууллагын албан хаагч, мэргэжилтэнүүд тэр байтугай зарим их дээд сургуулиуд оролцож байгаа баримтууд байгаа нь тун харамсалтай юм.

## 3.5 Монгол улсын эртний амьтан, ургамлын үлдэцийг хамгаалах загвар

Эртний амьтан, ургамлын үлдэцийг хамгаалах талаар АНУ-д хамгийн идэвхитэй ажиллаж ирсэн байгууллага бол Сээр нуруугүйтэн амьтдын палеонтологийн холбоо юм (http://www.vertpaleo.org/). Эртний амьтан, ургамалын үлдэцтэй холбоотой АНУ-ын хуулийн дагуу шинжлэх ухааны ач холбогдол бүхий газруудыг хамгаалалтад авдаг ба түүнчлэн судлаачид судалгаа хийх, материал цуглуулах боломжийг олгодог. Мөн зарим газруудад ашгийн бус зорилгоор дээж цуглуулахыг зөвшөөрдөг бөгөөд ийм ижил төстэй систем Монголд хэрэгжих боломжтой.

Энэ талаарх материалыг бүрэн эхээр нь доорх хаягаар орж уншина уу. http://www.vertpaleo.org/education/documents/PublicLaw111-011-PRPA.pdf.

# I. Нийтлэг асуултууд

**АНУ дахь үлдэгдлийг уг хууль хэрхэн хадгалж, хамгаалж үлддэг вэ?** АНУ-ын хуулийн дагуу зөвхөн зөвшөөрөгдсөн, өөрийн ур чадварыг харуулсан судлаач шинжлэх ухааны ач холбогдолтой ургамал, амьтдын үлдэгдлийн дээжийг тодорхой зөвшөөрлийн дагуу цуглуулах эрхтэй.

**Улсын нутаг дэвсгэр дээр мэргэжлийн бус хүмүүс дээж цуглуулахад ямар зохицуулалт байдаг вэ?** Үүнд тодорхой өөр зохицуулалт байхгүй. Ашгийн бус зорилгоор дээж авч буй хүмүүст АНУ-ын газрын менежмент юмуу ойн үйлчилгээний албанаас зөвшөөрөл олгодог. Эдгээр дээжнүүдийг зөвхөн боловсролын зорилгоор ашиглаж болно.

**Хувийн газруудын хувьд уг хууль яаж үйлчилдэг вэ?** Тусгайлан нөлөөлдөггүй. Зөвхөн улсын мэдлийн газрыг гэж заасан байдаг.

**Улсын мэдлийн газар дээр байгаа амьтан, ургамлын үлдэгдэл үндэсний хууль тогтоомжоор зохицуулагдан, аль хэдийн хамгаалагдсан байдаггүй гэж үү?** Тийм, гэсэн хэдий ч өмнөх хууль тогтоомжууд үүнийг нарийвчлан,тодорхой заалж өгөөгүй байсан.

**Амьтан, ургамлын үлдэгдэлийг яаралтай хамгаалах шаардлагатай гэж үү?** Тийм. Учир нь АНУ-ын  Ойн үйлчилгээний газраас хийсэн судалгааны дагуу Төв Америкийн Оглалад хийгдсэн палеонтологийн нийт судалгааны гуравны нэг нь албан ёсны зөвшөөрөл аваагүй байсан гэж гарсан. Хэдий Монголд энэ талаар тоо баримт ховор хэдий ч бид АНУ-тай ойролцоо байгаа болов уу гэж таамаглаж байна.

**Уг хуулийн гол чиглүүлэгч зарчим нь юу болох?**

1. **Нийтийн эзэмшил газар байгаа үлдэгдэл нь АНУ-ын өв соёлын нэг хэсэг юм.**
   *Зөвлөмж:* Дараа дараагийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

2. **Сээр нуруугүйтэн амьтдын үлдэгдэл маш ховор байдаг.**
   *Зөвлөмж:* Дараа дараагийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

3. **Зарим нэг ховор амьтан, ургамлын үлдэгдэл.**
   *Зөвлөмж:* Дараа дараагийн арга хэмжээг авч хэрэгжүүлэх.

4. **Эртний амьтан, ургамлын үлдэцийг хулгайлсан тохиолдолд шийтгэх**
   *Зөвлөмж:* Нийтийн эзэмшлийн газар үйлдэгдсэн ийм хэргүүдийг илрүүлэх арга зам, түүнд тавих хяналтыг чангатгах.

5. **Сайтар хамгаалахын тулд нарийвчилсан мэдээ шаардлагатай.**
   *Зөвлөмж:* Эртний амьтан, ургамлын үлдэцийн нөөцийг тодорхойлохын тулд эдгээр зүйлс аль хэсгээр олдсон талаарх мэдээллийн бүртгэлийг сайтар хийж байх хэрэгтэй. Боломжтой тохиолдолд GPS ашиглан координатуудыг тэмдэглэж авах шаардлагатай.

6. **Улсын хэмжээний амьтан, ургамлын үлдэгдэлийн мэдээллийг олон нийтийг гэгээрүүлэх чиглэлээр ашиглахад бэлэн байх, мэдээллийн сан үүссэн байх.**

   *Зөвлөмж:* Төрийн бус, ашгийн бус байгууллагатай хамтран улсын өмч болох үлдэгдэлийг харуулсан загвар бэлтгэж,нэмж сайжруулах үүднээс орчин үеийн техник, технологи ашиглах. Мэдээллийг олон нийтэд түгээх.

7. **Үлдэгдэлийн хадгалалт, хамгаалалтын менежментийг хийхдээ олон нийтийг оролцоог хангах.**

   *Зөвлөмж:* Үлдэгдэлийн нөөцийг хадгалах, хамгаалах тал дээр олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх, энэ талаарх тэдний ойлголтыг дээшлүүлэх.

**Монголын палеонтологийн дурсгалыг хадгалж, хамгаалахад АНУ-ын Палеонтологийн Нөөцийг Хамгаалах Акт (2009) хэрхэн туслах вэ?**

Монгол улсын соёлын өвийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу палеонтологийн олдвор болон тэдний эх үүсвэр нь түүхийн болон соёлын хууль тогтоомжоор тодорхойлогдоно.

АНУ-ын 2009 оны палеонтологийн олдворыг хамгаалах тухай хуулинд үндэсний хэмжээнд олдворыг хамгаалан улс орны бүх иргэдийн боловсролд эртний олдворуудыг ашиглахын ач холбогдлыг хуульчлан зааж өгсөн. Энэхүү хуулийн зорилго нь хүмүүсийг палеонтологийн дурсгалд хүрэхийг хориглох бус харин ч зөвшөөрнө гэсэн үг юм. Үндэсний хэмжээний хууль журмыг баталж өгснөөр ховор олдворуудтай зүй зохистой харьцах боломжийг бий болгоно.

Палеонтологийн дурсгалын хадгалалт хамгаалалттай холбогдох хууль эрхзүйн орчин Монгол улсад төдийлөн сайн хөгжөөгүй нөхцөл байдлыг харгалзан үзэж АНУ-ын Палеонтологийн Нөөцийг Хамгаалах Актыг Монголын нөхцөлд тохируулан, өөрчлөн ашиглах боломжтой.

АНУ-ын энэхүү акт нь дурсгалыг хамгаалангаа хөгжих боломжтой гэдгийг харуулахыг зорьсон акт юм. Иймд "Оюу Толгой" ХХК-ийг уг ажилд манлайлан оролцож, зөв эрхзүйн орчныг Монгол улсад бий болгох үйлсэд хувь нэмрээ оруулахыг хүсч байна.

# 4. БИЕТ БУС ӨВ

**С. Чулуун**

Археологи болон палеонтологийн судалгаануудтай харьцуулахад Өмнөговь аймгийн биет бус соёлын өв харьцангуй бага судлагдсан. МОУӨБ-ийн биет бус өвийн судалгааны багийнхан төслийн 1-р үе шатанд ном зүйн судалгаа гэхээсээ илүүтэй угсаатны зүйн судалгаан дээр төвлөрч ажилласан (Хавсралт 6-8). Тайлангийн энэ хэсэгт бид төслийн 1-р шатны судалгааны явцад Өмнөговь аймгийн соёлын талаар юу олж мэдсэнээ нэгтгэх ба аймгийн биет бус өвийн талаарх судалгааны үр дүнгүүд мөн багтсан. Энэ хэсэгт мөн тухайн аймгийн хамгийн чухал биет бус өвүүдийн нэг болох төмрийн болон мөнгөний дарханы урлал, ёс заншил, модон эдлэл болон малын тамганы соёл, эсгий хийх талаар өгүүлсэн. Үүний дараа, Монгол гэрийн талаар өгүүлсэн болно. Мөн, Өмнөговь аймгийн шашин шүтлэгийн тэр дундаа Буддизм болон бөөгийн ёс заншилын талаар ч давхар өгүүлсэн байгаа. Өмнөговь аймгийн иргэдийн хоол хүнс, цулхир болон бажууны гурил хэрхэн бэлтгэх талаар дараагийн хэсгүүдэд дурдсан. Аймгийн уламжлалт тоглоом наадгай, дуу хуурын талаар тайлангийн энэ хэсэгт оруулсан.

Өмнөговь аймгийн биет бус өв соёл, соёлын өвд гарч буй өөрчлөлтийн тухай өгүүлэхэд бүлгийн 2 дахь хэсэг зориулагдсан. Бүлгийн эхэн хэсэгт аймгийн нутгаар тархсан 12 гол биет бус өвийн талаар бичсэн бол “Оюу Толгой" төслийн шууд нөлөөллийн бүс болон Өмнөговь аймаг дахь тахилгат газруудын нэр, жагсаалтыг мөн үйлдсэн. Хэдийгээр энэ нь анх удаа хийгдэж буй ерөнхий жагсаалт боловч уншигчдад эдгээр газруудын талаар тодорхой ойлголт өгнө (Биет бус өвийн багийн судалгааны материалуудыг Хавсралт 7-9 үзнэ үү).

## 4.1 Говийн соёл

Биет бус өвийг тодорхойлохын тулд бид соёлын талаарх ойлголттой байх хэрэгтэй болно. Өмнөговь аймгийн соёлыг ойлгохын тулд тухайн газар нутгийн байгаль орчин, газар зүйн байрлал болон байгалийн хүчин зүйлүүд хүмүүст хэрхэн нөлөөлснийг ойлгох хэрэгтэй юм. Түүнчлэн гадны хүчин зүйлүүд тэр дундаа эдийн засгийн хөгжил нь Өмнөговь аймгийн уламжлалт соёлд хэрхэн нөлөөлснийг судлах шаардлагатай.

## 4.2 Газар нутаг ба Хүмүүс

Монголын говь нь олон зууны турш хүн, амьтан оршин сууж байсан газар нутаг юм. Энэхүү газар нутаг нь өвс ногоо багатай боловч байгаа цөөхөн хэдэн төрөл зүйлийн ургамал нь тухайн улс орныхоо эх газрын хатуу ширүүн, хур тунадас багатай уур амьсгалд зохицсон байдаг. Монголчууд говьд мал аж ахуй эрхлэн усны ховор, эрс тэс уур амьсгалд дасан зохицсон өвөрмөц соёл иргэншилтэй энэ хүмүүсийг "Их говийн зоригтууд" хэмээн нэрлэдэг. Энэ хатуу ширүүн уур амьсгалд говийн иргэд дасан зохицох төдийгүй цэцэглэн хөгжиж байна.

Говь нутаг нь хэт халуун, хур тундас багатай уур амьсгалтай. Зундаа хур тундас маш бага ордог, 30-35 хэм халуун байдаг. Зуны улиралд удаан хугацаагаар халуун байдаг учраас говийнхон тохиромжтой бэлчээрийг олох зорилгоор 50-70 км газар нүүх хэрэгтэй болдог. Есдүгээр сард бороо орсноор таана, хүмүүл ургаж малчид өвлийн бэлтгэл болгон малдаа тарга хүч авахуулах зорилгоор намрын улиралд отор хийн олон дахин нүүх хэрэгтэй болдог.

Говийн өвөл нь Монгол дахь хамгийн дулаан өвөл бөгөөд -15-20 хэм хүйтэн байдаг. Малчид өвөлдөө малтайгаа өвлийг өнгөрөөн эмэгтэйчүүд нь хүүхдүүдтэйгээ сумын төв дээр өвөлждөг. Хэрэв өвөл нь их хүйтэн бол малчид малтайгаа илүү дулаан нөмөртэй газар өвөлждөг. Хамгийн хэцүү улирал бол байнга шуурч байдаг хаврын улирал. Монголын говийн элсэн шуурга мал малчдыг хамгийн их зовоодог зүйл.

## 4.3 Соёл

Саяхныг хүртэл Өмнөговь аймгийнхны ахуй амьдрал тэмээ, цөөн тооны хонь ямаанд л суурилж байсан. Сумын төвийн оршин суугчдын тоо нэмэгдэж байсан ч гэсэн ХАА-н үйлдвэрлэл харьцангүй хязгаарлагдмал байжээ.

Говийн малчид жилийн дөрвөн улиралд хүнд хэцүүг даван туулах уламжлалт мэдлэг туршлагатай. Олон зууны турш хуримтлагдсан мэдлэг, чадвар, туршлага бүхий соёлын өвтэй. Соёл гэдгийг **Мал** (тэмээ, хонь, адуу, ямаа, үхэр) – **Малчин** (уламжлалт болон шинэ) – **Бэлчээр** (нүүдэл, өвөлжөө, хаваржаа, зуншлага, намаржаа) гэсэн холбоо харилцаанд ойлгодог.

**Тэмээ** болон **Худаг** гэсэн хоёр зүйл бол соёлын гол элементүүд юм. Монголын говийг тэмээгүйгээр төсөөлөхийн аргагүй бол сайн худаггүйгээр говьд амьдрал байхгүй. Малын тоног хэрэгсэл, хоол унд, дуу магтаал, ер нь орон нутгийн мэдлэг боловсролтой холбоотой бүхий л зүйл нь тэмээтэй салшгүй холбоотой. Тэмээ маллахад ус хамгийн чухал. Усны хангамж хязгаарлагдмал байдаг болохоор малчид жилийн туршид гэр орноосоо хол газар оторлон явах хэрэгтэй болдог.

Говийн малчид үеэс үед уламжлагдан ирсэн мал аж ахуйгаа эрхлэн явуулах өөрийн гэсэн арга барилтай. Говьд бэлчээрийн мал аж ахуй эрхлэнэ гэдэг хангайгаас өөр. Говийн мал хангайнхыг бодвол бэлчээр ойртой. Хойд зүгийн малчдыг бодвол говийн малчдын өвөл хаврын улиралд мал аж ахуй эрхлэх арга барил нь бараг өөрчлөгддөггүй. Гол ялгаа нь ердөө ургамлын тархалт, малын төрөл л байдаг.

Мал аж ахуйд гол нөлөөлөх зүйл бол байгаль орчин бөгөөд отрын бэлчээр байхгүй, баталгаат мал эмнэлгийн үйлчилгээ байхгүй, мал маллах хэв маяг хязгаарлагдмал, сумын төв, орон нутаг болон зах зээлээс алслагдмал зэрэг олон сул талтай. Хэдий ийм эрсдэлтэй ч гэсэн орон нутгийн иргэд, шинэ айл өрхөд амьдралын хамгийн тохиромжтой хэв маяг бол мал аж ахуй эрхлэх гэж үздэг. Мал аж ахуй эрхлэх амьдралын хэв маягт амархан дасдаг. Мал маллах дадлага, арга туршлагын талаар бичсэн ном зохиол ч олон бий.

Хүн болгон мал маллаж болох ч малчны гэр бүлээс гаралтай хүмүүс нь мал маллахыг ажил гэж боддог хүмүүсээс тодорхой давуу талтай. Малчин айлууд өвөлжөө болон хаваржаатай байх давуу эрхтэй. Хамгийн чухал нь уламжлалт мэдлэг нь үеэс үед дамжин өв уламжлагдаж байдаг.

Социализмын үед бэлчээрийн ургамлын төрөл зүйлээс болоод нэг хэсэг бэлчээрийг нэг төрлийн малд л зориулдаг байв. Энэ байдал одоо харьцангуй багассан ч зарим газруудад байсаар байна. Жишээ нь: Баян-Овоо сумын өмнөд болон зүүн өмнөд хэсгээээр заг нилээд ургадаг болохоор тэмээ бэлчээхэд хамгийн тохиромжтой бол Манлай сумын зүүн өмнөд хэсэг нь адуу иддэг ургамал ихтэй болохоор адууны бэлчээрт тохиромжтой нутаг болно.

### 4.3.1 Аж үйлдвэржилт болон Гадныхны их түрлэг

Орчин үеийн уул уурхай Өмнөговь аймагт, ялангуяа Ханбогд, Баян Овоо сумдад эрчимтэй хөгжиж байна. Уул уурхайн салбараас байгаль орчин болон нийгэмд үзүүлж байгаа үр нөлөө нь мэдэгдэхүйц болж нутгийн уугуул иргэдийн нийгмийн болон амьдрах хэв маягт сөргөөр нөлөөлсөөр байна. Уул уурхайн салбарын нөлөөлөл малчидад бүр ч мэдэгдэхүйцээр буюу малын бэлчээрт сөргөөр нөлөөлж байна. Нутгийн иргэдийн ярьж байгаагаар уурхай руу чиглэсэн том том замууд нь их хэмжээний малын бэлчээрийг хааж бэлчээрийн нөхцөлийг муутгахад хүргэж байна. Усны нөөц болон хэмжээ багасч агаарын бохирдол ихсэж байгааг малчид ярьж байна.

Уул уурхайн салбарт ажиллагсадын тоо үлэмж нэмэгдэн эдгээрийн олонхи нь гадаадынхан болон говийн амьдралыг мэдэхгүй өөр аймгийнхан байна. Ажлын байр бий болж байгаа нь сайшаалтай ч гэсэн гадныхны түрлэг орж ирж байгаа нь орон нутгийн соёл хэл заншилд сөргөөр нөлөөлж байна. Уул уурхайн салбар нь бас тухайн орон нутгийнхаа дэд бүтцийг хөгжүүлэх ёстой болохоор орон нутгийн хөгжлийн боломжийг нэмэгдүүлэх гадаад ертөнцтэй холбогдох холбоо харилцааг сайжруулдаг давуу талтай.

Ханбогд, Манлай, Баян-Овоо сумдын иргэдэд уул уурхайн салбарын үзүүлж байгаа нөлөө нь сумын төвүүдэд тодорхой харагдаж байна. Хүмүүс сумын төв дээр оршин суудаг байсан ч гэсэн сүүлийн үед хөгшчүүд, сургуулийн насны хүүхдүүд тухайн хүүхдүүдийн эцэг эхчүүдийн аль нэг нь сумын төв дээр өвөлжих хандлага ажиглагдаж байна. Түүгээр ч барахгүй сүүлийн хэдэн жил өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан малаа барсан өрхүүд сумын төв рүү ихээр нүүн ирж байна. Энэ өөрчлөлт нь хүмүүс төв газар луу нүүх нөхцөл нь болж орчин үеийн нийгмийн давуу талыг олж авах нэг арга хэрэгсэл болж байна.

Эдийн засгийн хөгжил хурдасахын хэрээр говийн соёлд байгалийн төдийгүй соёлын өвийн өөрчлөлт ч сөргөөр нөлөөлж байна. Энэ бүс нутгийн өвөрмөц соёлыг хамгаалж холбогдох бүртгэл, судалгааг хийсний үндсэн дээр соёлын өвийг баримтжуулж эдийн засгийн хөгжлөөс шалтгаалан үүсч болох эрсдлийг үнэлэн соёлын өвийг хамгаалах хөтөлбөр төлөвлөгөөг боловсруулах цаг нь болжээ.

## 4.4 Өмнөговь аймгийн биет бус өвийг хамгаалах арга, чиг хандлага

ШУА-ийн Түүхийн хүрээлэнгээс энэхүү хөтөлбөрийн нэгдүгээр үе шатанд Өмнөговь аймгийн хэд хэдэн суманд угсаатан зүйн судалгааг явуулсан. Биет бус өвийн судалгааг угсаатан зүйн судлагааны арга зүйг ашиглав. Бид хэд хэдэн сум, тосгодод уулзалт зохион байгуулж дараа нь хүмүүстэй хэсэг бүлгээр уулзсаны эцэст Өмнөговь аймгийн соёлын тодорхой асуудлуудыг мэддэг хувь хүмүүс, айл өрхүүдийг тусгайлан сонгон авч нарийвчилсан судалгааг хийсэн. Судлаачид болон орон нутгийн малчдын хооронд тодорхой хэмжээний итгэлцэл бий болгох зорилгоор бүтэн жилийн туршид энэ үйл ажиллагааг явуулсан. Судалгааны ажлын явцад судлаачид тусгайлсан тэмдэглэл хөтөлж тодорхой тооны гэрэл зургаар баримтжуулсан болно.

Энэ үйл ажиллагааны явцад судлаачид биет бус өвийн хамгийн чухал хэсэг нь юу болох, олон нийт хэрхэн оролцвол зохистой талаар орон нутгийн хүмүүстэй ярилцсан. Ихэнх тохиолдолд судлаачид тодорхой хэмжээний тайлбарыг "Оюу Толгой" төсөлд хамгийн ашигтай ойлгомжтой соёлын өвийн асуудалтай холбон хэрэглэсэн. Тиймээс биет бус өвийг сонгохдоо малчид, сумын төвийн иргэдийн ойлголт санал хүсэлт дээр тулгуурласан. Судалгааны ажилд төмрийн болон алт мөнгөний дарханы урлалыг илүү ач холбогдол өгөн багтаасан бөгөөд энэ талаар дараагийн хэсэгт тодорхой өгүүлнэ.

Энд уншигчид соёлын элемент болон мөнгөн эдлэлийн талаар нилээд дурьдсан болохыг анзаарах байх. Мөнгөн эдлэлийн эдийн засгийн ач холбогдлын талаар маш олон газар дурьдах тул бид энэхүү хэсэгтээ эдгээр мөнгөн эдлэлийн нийгэм болон соёлын хэрэглээ, тэдгээрийг урласан дархчуудын нийгэмд гүйцэтгэж байсан үүргийн талаар түлхүү ярих болно.

Өмнөговь аймгийн биет бус соёлын өвийн үндсэн элементүүдийг өөрсдийн судалгааны ажилд үндэслэн дараах байдлаар тодорхойлж байна.

1. Материаллаг соёл
    a. Төмрийн болон мөнгөний дарханы урлал
    b. Өвлөгдөж ирсэн эд зүйлс: Биет материаллаг соёлын өв уламжлал
        i. Олон үе удам дамжсан хөөрөг
        ii. Малын тамга хийх ёсон
        iii. Уламжлалт гэр ахуйн сав
        iv. Эсгий хийх, дүглүүр ба тойрог
    c. Монгол гэр урлах болон аж төрөх
    d. Хоол хүнс
        i. Унд – борцтой хийцтэй цай
        ii. Цулхир болон бажуун гурил
2. Нийгэм, шашин, хэл
    a. Өмнөговь аймгийн шашин
    b. Өмчлөл болон хууль, эрх зүй
    c. Удам угсаа болон угсаа залгамжлах харилцаа
    d. Хэл
    e. Дуу, дуучид

i. Уртын дуу, ерөөл магтаал

ii. Дуу, хуур

iii. Хөгжмийн зэмсэг

f. Тоглоом наадам

i. Чулуун гэр барих болон бусад тоглоомууд

ii. Шагай

g. Өмнөговьчуудын цээрлэх ёсон

3. Өвт газрууд: Өмнөговь аймаг дах уламжлалт өвт газрууд

## 4.5 МАТЕРИАЛЛАГ СОЁЛ

### 4.5.1 Төмрийн Болон Мөнгөний Дарханы Урлал

Өмнөговь аймаг нь Ноён-Сэврэйн хийц хэмээгдэх онцлог дарханы урлалтай бөгөөд судалгааны 4 сумын нутагт энэхүү дэг сургуулийн салаа салбар болон мөн дарханыхаа нэрээр нэрлэгдсэн олон хийц тархжээ.

Өнөөдөр энэ бүс нутагт төмөр, мөнгөний дарханы 3 үеийн ур хийц уламжлал, бүтээл урлал хадгалагдаж байна.

I-II үе нь 19 дүгээр зууны сүүлээс-1970-аад оныг хамрах бөгөөд төмрийн дархан Сунтаг, мөнгөний дархан өндөр Лувсан, модны дархан Дорж, Уран Ням, Санж, Базар нар 1930-90-ээд оны үед амьдарч байжээ. Уран Ням Монгол улсын сайн малчинд дурсгадаг байсан мөнгөн хувин, мөнгөн хуц, эцэг малын баримлыг цутгаж хийж байсан. Х.Чойбалсангийн үед Дарханы зэрэг гэж байсан ба энэ бүс нутгаас Уран Санж Монгол улсын гавъяат дархан цол хүртэж байжээ. Дархан Тарган Даржаа, мөнгийг маш нимгэн болгож аяга урладаг байсан бол Дархан Жамяандорж мөнгөн аяганд утас ороож хээ тавьдаг байжээ. Үүнээс гадна Сунтаг дархан, Уран Базар, Пэрэнлэй, Мөнгөн Чимид, Уран-Бөгтөр-Ганган Осор, зургаан хуруу Банзрагч, Гунжаа Ням, Угалзын Хэцийн уран Төмөр зэрэг дархчуудын хийц гэж яригдаж байна.

Баян-Овоо сумын өндөр настан Цэдэн-Иш гуай Сунтаг дарханы урласан 40 гаруй жил болж буй цоожийг хадгалж буй бол түүний ач хүү Раш түүний төмрийн дарх хийдэг багажнуудыг хадгалж байна (Зураг 20).

*"Сунтаг дархан Номгон, Хүрмэний заагийн хүн, авдар хөөрөгтэй байсан, төмрийн хатыг маш гайхамшигтай тааруулдаг төмрийн ширээлт, цуултыг маш сайн хийдэг дархан байсан. Нэг хүн Сунтаг дарханаас тэмээ хяргах хайч хийлгээд ирлэх билүү гэж асуухад 2 жил ирлэлтгүй тэмээ хяргана гэсэн байна. Гэтэл үнэхээр гурав дахь жилдээ хугараад унасан гэдэг. Энэ нь махан төмрийн дунд ирэнд нь сахлын хутга шиг нарийн иртэй ган суулгасан байсан, махан төмөр нь шамрахаар ир нь гараад байсан байна. Мөн мах, мод, төмрийн хутга хийдэг. Төмрийн хутга нь галын хайчийг хуйлруулаад зордог хутга хийдэг хүн байсан. Эмнэлгийн барилга барихад хэдэн дархан хүнийг авчруулж, Сунтаг дарханд хуучин байшингийн хадаастай хар моднуудыг өгөхөд шуудайтай багаж авчраад хадаасыг нь гялтайтал харуулдаж, урт хадаасыг нь цавчиж хаяад гөлиийтөл нь харуулдсан. Бусад дарханууд нь очиж үзэхэд сүхний ир нь маш хурц хэвээрээ байжээ"*[12].



A



B

[12] Даланзадгад сумын дархан Ү. Батнямын ярианаас. 2010 оны 10 дугаар сарын 28-ний өдөр, Даланзадгад хот.




c

**Зураг 20** **а). Төмрийн дархан: Баян-Овоо сумын Хар заг багийн малчин Рашням бол Сунтагийн ач хүү бөгөөд түүний төмрийн дарханы хэрэглэж байсан гэрийн хана, гутлын шөвөг, төмрийн хасуур, хуурай зэрэг багаж хэрэгслийг (в) хадгалж байна; с). Баян-Овоо сумын Налих багийн өндөр настан Цэдэн-Иш Сунтаг дарханы хийсэн цоожийг 40 гаруй жил хэрэглэж байна.**

Мөн Ханбогд сумын Хулгарын усанд нутагладаг Батсүх гуай Уран Базарын мөнгөн аяга, Сунтаг дарханы цоож, тулга зэргийг өвлөн хадгалж байна (Зураг 21).

III үе нь мөнгө, төмрийн дарханы өмнөх үеийн ур хийц, чадварыг өвлөн авч дарх хийж буй Ханбогд сумын Жавхлант багийн Жаргалсайхан, Борхүү, Даланзадгад сумын Батням, Баян-Овоо сумын Шархүү дарханы шавь нар болох Алтангэрэл, Баттөр, Батбуян нар байна.


A


B


C


D


E


F

**Зураг 21** **Мөнгөний дархан ба мөнгөн эдлэл: a) Их дархан Ү.Батням, в) Ноён-Сэврэй хийцийн эмээл; c) хазаар, гөлөм; d) мөнгөн аяга; e) эмээлийн гөлөм; f) Дархан Борхүү гуай урласан мөнгөн аягын хамт**

### 4.5.2 Ноён Сэврэйн хийцийн онцлог

Даланзадгад сумын иргэн Батням Ноён-Сэврэйн хийцийн дархны урлалыг эзэмшин хөгжүүлж улмаар олон арван шавь төрүүлэн гаргасан байна. Батням гуай Ноён-Сэврэйн хийц гэдгийг тодорхойлохдоо (Зураг 21):

> *"Ноён-Сэврэйн хийц нь мөнгөний орц өндөртэй, тиймээс хэдэн үе дамжин хэрэглэх боломжтой байдаг. Мөнгөн аяга хийхэд залгалгүй, мөнгөө бүрж давуулж нугалан хийдэг онцлогтой. Яагаад Ноён-Сэврэйн хийц хэмээгдэх энэхүү дарханы урлал энэ бүс нутагт хөгжсөнтэй холбоотой нэгэн хууч яриа байдаг. Урьд энэ нутгийнхан Шинжаан Уйгур руу жин тээдэг байжээ. Эзэн гол Шивээ хүрэнгийн боомт гараад баруун тийш хилийн дагуу 500-600 км явж Харлаг тагийн нуруу Тэнгэр уулын ар ёроолд Бар хөл хот, Баруун-Зуу гэдэг мөргөлийн газарт том мөнгөний уурхай байсан байна. Тэндэхийн хүмүүс маш ядуу арьс шир, идэж уух, өмсөх юм байхгүй. Тийшээ жинд явах замд Үзмэн уул гэдэг маш их зэрлэг үзэмтэй газраар явна. Тэндэхийн хүмүүс үзмийг шороотой хольж хаягаа манадаг. Морины таханд үзэм шавчихаад явуулдаггүй байсан гэж байгаа. Миний авга намайг багад ярьдаг байсан. Тэр үед нууцаар жин тээж худалдаа хийдэг байсан, одоогийнхоор бол контрабанд хийж байсан байна. Ах маань жин тээж ирээд бидэнд үзэм авчирч өгөөд хүнд үзүүлэлгүй газар унагалгүй идээрэй гэж их захьдаг байсан. Уурхайн ажилчдад цалин гэж гулууз мөнгө өгдөг, түүгээрээ жинчдээс хямд үнээр ноос, нэхий зэргийг сольж авдаг. Дээрх мөнгөөрөө юм хийж зардаг болсноор мөнгөний дархчуул олон болсон. Тэгээд мөнгөний орц өндөртэй Ноён-Сэврэйн хийц гэж хөгжсөн бололтой байдаг. Энэ нь 1800-аад оны үеэс эхэлсэн. Ноён-Сэврэй одоогийн Гурван-Тэсэд маш олон дархан урчууд байсан. Ноён нутгийн баруун талын хүн ардын зураач Долгорын Маньбадар. Түүнийг уран зурагт сургасан Долгорын Гэндэнсамба гэдэг хүн, Уранманьбадар гэдэг удмын дархчуул байсан. Мөн Дархан Санж, Дархан Түвдэн, Дархан Базар г.м. Миний мэдэхээр Халхад төмөр эдлэлийн Далай Чойнхор вангийн, Боржигин, Хэнтийн Батноровын, Дарьгангын гэсэн 4 хийц байдаг. Түүн дээр манай Ноён-Сэврэйн хийц алдартай ба мөн Засагт ханы хийц гэж Ховд, Завхан чиглэлийн хийц байж болох юм."*





B



C

A

**Зураг 22** **а). Мөнгөний дархан: Ханбогд сумын Жавхлант багийн Хулгарын усанд нутагладаг Сайхансамбуугийн Батсүх в). Уран Базарын 1960-аад оны хийцийн мөнгөн аяга с). С. Батсүх гуайн хадгалж буй Монгол үндэстний төмөр тулга**

## 4.5.3 Мөнгөн дарханы хөөрөг

Ү. Батням гуай Өмнөговийн дархчуулын хэрэглэж байсан багаж, тухайлан дарханы хөөргийн тухай

*"Тулман хөөрөг, ямааны арьсан, амыг нь онгойлгож хийгээг дүүргээд буцаж амыг нь хавчдаг. Авдран-Зөвхөн модон дөрвөлжин хайрцагаар хийдэг, дөрвөлжин хажуугийн колопыг татаж хийгээр дүүргэдэг. Салхин-Ярьдаг цагаан хоолой, хөөрөгний хярсан дээр галаа түлж, төмрөө хийчихээд салхины аясыг дагаж байрлуулдаг. Хүчтэй салхи бүгдийг нь хайлуулдаг учир салхи ширүүн байвал зөрүүлж тавина. Сэвэлзүүр салхинд маш сайн болдог. Нөгөө хоёроосоо хамаагүй хүчтэй."* хэмээн өгүүлсэн.

## 4.5.4 Ноён Сэврэй хийцийн гөлөм, хазаар, дөрөө

**Гөлөм**: Нэг тал нь элэгдэхээр сольж тавьж болдог, учир нь доголыг дээр доор нь тааруулж хийдэг (Зураг 21е). Мөн нэвт оёдолтой, булигаарыг нь нэвт шивж оёод цаад талд нь мөн булигаар тавьдаг. Угалзны хамар нь элэгдсэн ч хээ нь хэвээрээ байдаг, өндөр булигааран хамар нь хээгээ хамгаалдаг.

**Хазаар**: цутгуу товруутай, бөгжтэй, сурвалж, арлыг цутгуураар хийдэг (Зураг 21с).

**Жийжүү дөрөө** гэдэг нь төмөр дөрөөнд гуулиар хээ суулгасан хээтэй байдаг.

**Аяга**: Дэшингний ирмэг дээгүүр утас тавьж хажлаад цаана нь бад тавина. Бад гэдэг нь бадам гэсэн утгатай бурханы доор байдаг бадамаас арай өөр (Зураг 21d ба f). Их гарын мөнгөн аяга 18 лан. Ач холбогдол нь насан туршдаа болон үе залгамжилан хэдэн үе дамждаг.





a) b) c)




**d)** **e)**

**Зураг 23** **Ханбогд сумын Жавхлан багийн Улаан толгойн усанд амьдардаг залуу малчин Ц. Алтангэрэл (а) өндөр Лувсангийн хийцийн бугуйвчийг долоон настайгаасаа хойш ээжээсээ өвлөн авч одоог хүртэл эдэлж хэрэглэж байна (b-e).**

### 4.5.5 Үйсэн иштэй хутга хийх технологи

Даланзадгад сумын дархан Ү. Батням өгүүлэхдээ,

*"Үйсэн иштэй хутга нь маш бат бөх байдаг онцлогтой. Манайхны дархчууд хийдэг байсан. Хусны үйсийг норгож нарийхан зүсээд хутганы ишийг ороодог. Норгосон үйсийг шахаж, дахин ороож хатаах гэх мэтээр хийсээр маш сайн чанарын иш хийдэг арга байдаг. Одоо үйсэн иштэй хутга ховордсон байна. Хусны нимгэн хальсыг дэвтээж хутганы ишний нарийн гозгор төмөрлүү шахаж усыг нь дүүргээд нүдэж давтаад хэд хоног байлгаад дахин хийж давтаж өөг нь засаж зүлгэн хийдэг. Энэ нь хэзээ ч хугарч, шамрана гэж байхгүй. Энэ мэт Ноён-Сэврэй хийцийн үндсэн чанар нь үе дамжин хэрэглэгдэх юм"* хэмээжээ.

Ханбогд сумын малчин Борхүү:

*"Нэг мөнгөн аяга бол 3 үе болдог. Харин миний аяга бол 4 омойлох (үе) хүрэх байх. Учир нь хүүхдүүд аяганы амсрыг хазаж, хонхойлгон, өнгө алдуулдаг. Харин миний аяга бол амсар зузаан болохоор хонхойж, халтар болохгүй."* хэмээгээд мөнгөн аяганы амсарыг жигд углуургадаж, мөнгө,

мод 2-ыг ямарч завсар орохгүй суулгаад, аяганыхаа ёроолыг нь бадмалсан хээ гаргаж цохидог. Ингэж 2 давхар мөнгийг уулзуулж, бадам цэцгийн хэлбэр гарган цохисон байна. Аяганы ёроолд зузаан мөнгө хийх хэрэгтэй. Харин сүүлийн үед хүмүүс мод, мөнгө хоёрын дунд туглага, элс, зэс зэргийг дэвсэн мөнгөн дээрээ цутгаж хийдэг болсон бололтой. Үүнийг шалгаж үзэхийн тулд модон дээр зөөлөн юм тавиад доош харуулан цохиж үзэхэд, хөндийрч сонсогддог.

### 4.5.6 Дарханы цавуу хийх технологи

"Баян-Овоогийнхон 5 янзын ширээр 5 өөр цавуу хийдэг байсан. Шар, хар, хүрэн цавуу. Хүний биен дээр наалддаг, наалддаггүй. Арьс, малын ясыг өөх тосгүй болгоод 3-7 хоног хаврын урь идүүлээд, жижиглээд овооны хөтөл газар дээр том тогоо тавиад, хөрөөр чанана. 24-36 цагийн турш түлэхгүй, ямар нэгэн хольц хийхгүй чанадаг ба өнгө тогтон хар, шар болж ирэх үед нь үе үе юм нааж үзнэ. Одоо боллоо гэж үзэх үедээ гаргаж, хөргөн аваад модон хэвэнд хийж хатааж авна. Хэвгүй байх юм бол бутлаад уутанд хийчихнэ. Хэрэглэх үедээ давс, хужиргүй хамгийн сайн усыг хэрэглэх ёстой ба уулын ус илүү тохиромжтой. Тэдгээр сайн устай газрууд нь: Хачигийн уулын ус, Налихын Хачигт, Дэлгэр сууж, Хөхтолгой, баруун зүүн Дэрс гэх мэт"[13].

---

[13] Баян-Овоо сумын иргэн Сүхбаатарын ярианаас. 2010 оны 10 дугаар сарын 27.

### 4.5.7 Мөнгөн гоёл чимэглэл, бугуйвчны урлал

Өндөр Лувсангийн давтагдашгүй онцлог хийцтэй мөнгөн бугуйвчийг өнөөдөр Ханбогд, Баян-Овоо сумынхан үе дамжуулан эдэлж хэрэглэж байна (Зураг 23). Хээрийн шинжилгээний ажлын явцад Ханбогд сумын өндөр настан Бандиа гуайн гэргий, залуу малчин Алтангэрэл, Баян-Овоод мөн хэд хэдэн хүмүүс энэхүү бугуйвчийг зүүсэн байсантай таарав. Өндөр Лувсангийн хийцийн энэ бугуйвчийг эдгээр хүмүүс багадаа аав ээж болон дээдсээсээ өвлөн авчээ. Тухайлбал Алтангэрэлийг 7 нас хүрэхэд нь ээж нь энэхүү шүрэн шигтгээтэй мөнгөн бугуйвчийг анх зүүж өгсөн байна. Мөн нилээд хэмжээний мөнгөөр цутгаж хийсэн хоёр бөгжийг тэрээр 20-оод наснаасаа зүүсэн бөгөөд одоо мөнгө нь барагдаж нимгэн болоод байна гэж ярьж байв. Иймд энэ давтагдашгүй мөнгөний дарханы хийцүүд нь говь нутаг даяар алдаршиж энэ нутгийн мөнгөний урлал нь үе дамжуулан хэрэглэхэд эдэлгээ дааж хадгалагддаг тэр хэрээрээ өвөг дээдэс, өв соёлын тухай мэдээ, уламжлалыг тээж чаддаг байна.

### 4.5.8 Дархан хүний гурван цээр

Борхүү гуайн хэлснээр дархан хүний хийхийг цээрлэдэг гурван эд зүйлс байдаг ба эдгээр нь хутга, цоож, тамга юм.

*"Дархан хүн хутга, цоож, тамгыг олноор хийдэггүй, учир нь хутга амьтан, хүнд хор хүргэж болох эд зүйл ба цоож нь мөн бусдаас эд зүйлсээ харамлан хамгаалж буй, мөн малын тамга малыг бусдаас харамлаж буй сэтгэлийн илрэл гэж үзэх тал байдаг. Тиймээс нэг тамга бодын үнэ хүрдэг, хутга хийлгэсэн хүнд хуурай дагуулдаг байсан цээр байдаг."*[14]

Баян-Овоо сумын Сүхбаатар гуай дархан хүний гурван цээр үеэс үед яаж дамжин ирсэн талаар дараахи түүхийг ярьсан юм.

*"1970-аад оны үед Өмнөговьд банк ухсан маш том хэрэг гарсан юм. Хулгайчийг тодруулж чадалгүй арав гаруй жил болсон бөгөөд тухайн үеийн төмрийн сайн дархан уран Санжийг сэрдэж байсан юм. Банкны том, төмөр цоожийг гагцхүү уран Санж л хайлуулж эвдэж чадна гэж үзэж байжээ. Гэвч хожим нь Ангараг гэдэг тагнуулын албанд ажиллаж байсан Цогт-Овоогийн хүн авсан болох нь тогтоогдсон юм."*[15]

[14] Ханбогд сумын иргэн дархан Борхүүгийн ярианаас, 2010 оны 10 дугаар сарын 26-ны өдөр.
[15] Баян-Овоо сумын иргэн Сүхбаатарын ярианаас, 2010 оны 10 дугаар сарын 27-ны өдөр

### 4.5.9 Төмрийн болон мөнгөний дарханы талаарх дүгнэлт

Ү. Батням гуайн дарханы дамжаа хичээллүүлэн 70 гаруй шавь бэлтгэж буй болон өмнөх үеийн дархчуудын ур, эд үе дамжин хэрэглэгдсээр байгаагаас үзэхэд Өмнөговийн уламжлалт дарханы ур ухаан мэдлэг хадгалагдан улам бүр хөгжиж байгаа нь харагдаж байна. Дарханы урлал хөгжиж буй нь энэхүү урлал ба бүтээгдэхүүний зах зээл байна. Дархан ур ухаан, технологи дамжин залгамжлагддаг гол арга нь үе дамжсан дархчуулын бүтэц юм. Гэвч өнөөдөр энэхүү бүтэц эвдэрсэн ба үе дамжсан бус шинээр сурч эзэмшсэн дархчууд бий болсон байна. Үе дамжсан дархчуудын тогтолцооны нэг сул тал нь хэн нэгэн үе залгамжлан дархан болохгүй бол тэрхүү мэдлэг, ухаан бүхэлдээ мартагдан орхигддог явдал юм. Тухайлбал бид Сунтаг дарханы төмрийн хөөргийг нь дарж тусалж байсан ач хүү нь хэмээн нутгийнхандаа алдаршсан Рашням гуайтай уулзахад Сунтаг дарханы хэрэглэж байсан хэдэн багажнаас өөр зүйл үзүүлж, ярьж чадахгүй байлаа. Учир нь тэр дархан болоогүй тул түүний арга технологийг өвлөн аваагүй, тиймээс Сунтаг дарханы төмрийн ширээлт, зуултыг гайхалтай тааруулдаг арга ухаан бүрмөсөн мартагдсан гэж хэлж болохоор байв. Ахмад үеийнхэн зөвхөн үе дамжсан дархчуудыг жинхэнэ дархан хүн хэмээн үзэх хандлага байна. Л. Батаа гуай үе дамжсан бус, шинээр сурч эзэмшсэн Борхүү гуай зэрэг дархчуудыг үл хүлээн зөвшөөрөх байдалтай байв. Л. Батаа гуай "би тийм дархан мэдэхгүй юм байна, хүнээс жаахан юм сурсан юм гэнэ лээ" гэж байв.

Мөнгөн дарханы урлал хэдийгээр өөрчлөгдөж ирсэн боловч мөнгөний дархан цаашид хөгжих зах зээл байгаа эсэх нь эргэлзээтэй тул гар урлалын асуудлыг "Соёлын өвийн хөтөлбөр"-т тусгах нь зүйтэй юм.

## 4.6 СОЁЛЫН ӨВИЙН БУСАД МАТЕРИАЛУУД

### 4.6.1 Үе дамжсан тамхины хөөрөг

Үе дамжсан түүхтэй эд зүйлсийг хадгалж, эдэлж хэрэглэж явах нь Монголчуудын соёлын нэгэн чухал хэсэг байдаг. Ялангуяа нэр хүндтэй төр нийгмийн зүтгэлтэн, эсвэл өвөг дээдсээсээ уламжлан ирсэн хөөрөг барих нь Монгол эрчүүдийн бахархлын нэгэн хэсэг билээ. Бид үүнийг онцлон дурдаж байгаа нь чухам ийм өвийн зүйлсээр биет бус өвийн мэдлэг, түүх дамжин тээгдэж байдаг хэмээн үзэж буйтай холбоотой. Ирсэн зочин гийчинтэй хөөргөө барьж тамхилах зуураа хөөрөгнийхөө гарал үүсэл, түүх, домог, залгамжлалыг ярьдаг. Тэрхүү яриа тухайн хөөрөгний эзний талаарх ойлголт төсөөллийг бий болгодог. Өвөг дээдэс, хэрхэн залгамжлан хадгалж яваа нь тухайн хүний нийгмийн байр суурь, ухаан, нурууг илтгэн харуулна. Тухайлбал, Манлай суманд аж төрж буй Шагдарсүрэн гуай нь алтан ургийн хүн бөгөөд түүнд сүүлчийн хошууны засаг ноён төрийн сайд дээдсийнх нь хөөрөг хадгалагдаж байна (Зураг 24). Социализмын үед тэрээр алтан ургийн хүн гэдгээ нууж, дарж явах цаг байсан тул өвөг дээдсийнхээ ч түүхийг сайн мэдэхгүй, түүхийн номноос үүвэр түүвэр ойлголт авчээ. Гэвч түүнд өвөг эцгээс нь ээжээр нь дамжин ирсэн хөөрөг хадгалагдаж байна.



A



B



C

**Зураг 24** **Үндэсний хөөрөг: а). Манлай сумын иргэн Шагдарсүрэн гуайд уг сумын сүүлчийн хошууны засаг ноён төрийн сайд дээдсийн хөөрөг бий. в). Ханбогд сумын Жавхлан багийн дархан Борхүүгийн хөөрөг, с). Баян-Овоо сумын Налих багийн дархан Л. Батаагийн хөөрөг**

Л. Батаа "Миний барьж байгаа хөөрөг нь Дандар эмч гэдэг хүний хөөрөг. Хүмүүс ярихдаа, далайн ёроолд 1000 жил болсон мөс гэж ярьдаг. Энэхүү хөөргийг "Хэсүүжин" гэж нэрлэдэг. Шүрэн толгойтой хүрэн хөөргө. Гартаамаар голцуу хөөрөг хийдэг. Бөгж, бугуйвч, ээмэгний шигтгээг мөн хийдэг. Манай нутагт энэхүү чулуугаар Лувсан гэдэг хүн юм хийдэг байсан. Хавчийн зүүн урд талаас их олддог."

### 4.6.2 Малын тамганы соёл

Монголчуудын бэлчээрийн мал аж ахуйн нэгэн томоохон соёл бол малын тамга юм. Судалгааны бүс дэх малчин өрх айлууд малын тамга хэрэглэсээр байна (Зуарг 25). Тухайлбал Манлай сумын малчин Батсух гуай нүдтэй, амтай загасан тамга, Баян-Овоо сумын малчин Рашням "П" үсгийн хэлбэртэй тамга хэрэглэдэг бол эхнэрийн тал нь дан саран тамгатай айл байжээ. Саран товруутай товхтой буйл, туухай, уйлан тамга, дан саран, чандмань зэрэг тамга энэ бүс нутагт өргөн тархжээ.

### 4.6.3 Уламжлалт гэр ахуйн сав, эд зүйлсийн хэрэглээ

Ингэний айраг буюу хоормог исгэх модон хөхүүрийг малчин айл өрхүүд хэрэглэж байна. Манлай сумын иргэн өндөр настан Сугир гуай модон хөхүүр, хувин хийж байна. Модон хувин, хөхүүрийн хэрэгцээ, мөн түүнийг үйлдвэрлэгчид байна (Зураг 26).

### 4.6.4 Дуглуур тойрог хийх арга ухаан

Манлай сумын Жуулхүү гуай эхнэрийн хамт уламжлалт эсгий ширдэгийг ширж борлуулж байна. Өмнөговийнхон гэрт дэвсэж хэрэглэдэг энэхүү ширдэгийг дуглуур, тойрог хэмээн нэрлэдэг байна (Зураг 27). Гар аргаар хийдэг учир их хэмжээгээр хийж борлуулах явдал байхгүй шинэ гэр барьж буй хүмүүсийн хүсэлт, захиалгын дагуу цөөн тоогоор хийдэг ажээ.

Даланзадгад сумын Д. Бямбаа гуай "урьд дуглуур, тойруулгыг түмэннаст, зоос, угалз, ханан сүлжээ зэрэг хээтэй хийдэг байсан. Хүрэн одончуугаар захладаг их бөх байдаг. Ахарын эсгий буюу сайн эсгийгээр хийдэг байсан" хэмээн ярив.



A



b

**Зуарг 25** **Малын тамга: a). Ханбогд сумын Жавхлант багийн малчин С. Батсүхийн нүдтэй, амтай загасан тамга, b). Баян-Овоо сумын малчин Рашнямын П үсэг хэлбэрийн тамга**







**Зураг 26** **Манлай сумын иргэн өндөр настан Сугир гуайн модон хөхүүр, хувингийн зүйлс**





**Зураг 27** **Манлай сумын иргэн Жуулхүү гуай эхнэрийн хамт ширмэл ширдэг ширж байгаа нь**

## 4.7 Монгол гэрийг урлах, монгол гэрт амьдрах

Шинэ гэр барьсан айл өрхүүд гол төлөв Улаанбаатар, Өвөрхангайн Уянгын гэрийг худалдан авч хэрэглэж байна (Зураг 28). Энэ бүс нутаг мод ховортойгоос гэр урлах нь бага, модны дархчууд зөвхөн захиалгаар хааяа нэг маш цөөнийг урладаг байна. Уянгын гэр барьж буй Ханбогд сумын Жавхлант багийн малчин Лэнтэнгийн хэлж буйгаар, бөх, үзэмж хээ сайтай, том гэрүүд байдаг онцлогтой ажээ.

Монголчуудын уламжлалт "хуруу тооно"-ыг хийж урлах арга ухаан өнөөдөр тасраад байгаа бөгөөд Баян-Овоо сумын залуу малчин Мөнхбат дээдсээсээ уламжилсан хуруу тоонотой гэрт амьдарч байна. Хуруу тоононы онцлог нь удаан эдэлгээтэйд орших бөгөөд Мөнхбат энэхүү гэрээ эмээ, өвөөгөөсөө өвлөн авч амьдарч буй ажээ.





B

A

**Зураг 28** **a) Баян-Овоо сумын Гүн хар уус хэмээх газар амьдардаг малчин Мөнхбат гуайн гэрийн "Хуруу тооно" b). Өвөрхангай аймгийн Уянгын хийцийн шинэ гэр, Ханбогд сумын малчин Лэнтэнгийнх.**

## 4.7.1 Гэрийн тавилга, засал

Малчин өрх айлууд гол төлөв гэрт амьдарч байна (Зураг 29). Манлай сумын залуу малчин Галаа өнгөрсөн жил өвөлжөөн дээрээ гэр барьжээ. Гэрийн тавилга, дотоод засал чимэглэл нь ерөнхийдөө уламжлалт байдлаа хадгалсан буюу гэрийн баруун, зүүн талаар төмөр болон модон ор, хоймрт хээтэй модон авдар, аяганы эрэгнэг, зуух, цайны явган ширээ зэргээс бүрдэж байна. Хоймрт авдран дээр эсвэл гэрийн хананд тусгай тавиур засаж бурхан тахилаа зассан байх ба гэрийн эзэн хоймрт, зочид баруун талаар, гэрийн ээзгтэй хүүхдүүд зүүнээр байрших байдал хадгалагдаж байна. Бурхны хөрөг, бусад ёслолын зүйлс, гэр бүлийн зураг бүхий модон хайрцаг хоймрт нь байна. Өмнө нь ихэнхи айлууд Хятадын 14 инчийн хар зурагт, нарны зай хураагууртай байлаа. 2010 оны намраас эхлэн айлууд сателлит ТВ антен хэрэглэдэг болсон нь тэдний гол үнэтэй гангараа байлаа. Мотоцикл, Excel машинтай айлууд цөөнгүй байна.



**Зураг 29 Баян-овоо сумын Хар Ус багийн Гүн хар уус хэмээх газар амьдардаг залуу малчин Мөнхбатын гэрийн тавилга, заслын ерөнхий байдал**

**Сархинаган тооно.** Тооно нь гэрийн орой дээр байрлан цонхны үүрэг гүйцэтгэдэг. Сархинаган тооно гэдэг нь уньтай нугас маягийн зүйлээр холбогддог. Унь гэдэг нь гэрийн дээд хэсгийг бүрдүүлдэг урт саваа моднууд юм. Эвхэгддэг ханыг уд модоор хийдэг. Гэрийн хаалга нь урд зүг зүү харсан байна. Нүүх үед тооно унийг хойд зүгт харуулан баглаж гэрийг буулгах үед урд зүг харуулна.

Өрх гэдэг нь тооныг хучдаг дөрвөлжин хэлбэртэй эсгий юм. Хаалгыг эсгийгээр хийнэ. Өрхний татдаг оосрыг нь цагаан адууны дэлээр хийж үлдсэн гурван оосрыг нь хар адууны дэлээр хийнэ. Гэрийн чагатага хэмээх тооны голоос уядаг тэнцвэржүүлэгч олсыг долоон атан тэмээний өнгө өнгийн зогдороор хийнэ. Гэрийг зөв барьж, буулгах ба өрхний оосрыг нар зөв эргүүлдэг. Зөвхөн хүн нас барсан үед л өрхийг бүтээж, гэрийг эсрэг талаас нь барьдаг.

Чагатага нь тухайн айл өрхийн хүч чадлыг харуулдаг болохоор эхнэрийн эмээ нь хийдэг. Чагатагыг унины ард өлзий хээ гарган нугална. Дээд үзүүрийг нь хаалга руу харуулан гурван настай хонь байгаа мэтээр дүрсэлдэг. Гэрийн шалан дээр эсгий хивсэнцэрийг тусгай утсаар хээлэн дэвсдэг. Гэрийн модон хэсгийг энд хийдэггүй бөгөөд зөвхөн хаалга болон хаалганы тотгыг л хийдэг.

Хаалганы босго болон тотгыг очир хээгээр хээлэн дээд доод талд нь нууц уяа бэхэлдэг. Урьд нь зочин орж ирэхдээ хутгаа буулгаж, нусаа нийн баруун хөлөөр босгон дээгүүр алхан орж ирдэг байжээ. Гэрийн хошлон баруун талаас эхлэн татдаг. Ханыг бас баруун талаас эхлэн барьдаг. Та хаалга баганадах буюу босгон дээр гишгэхийг хориглоно.

**Унины сэгэлдрэг**: Хорол тооно болон сархинаган тооно гэсэн хоёр төрлийн тооно байдаг. Зуухыг төмрөөр хийх ба байрлаж байгаа газрыг нь тухайн айлын гал голомт хэмээн хүндэтгэдэг. Шинэ айл болоход эхнэрийн ээж хүргэн хүүгийнхээ хэт цахиураар анхны галыг нь асааж өгдөг. Гэрийн эзэгтэй тулганы зүүн талд суудаг. Харин өрхийн тэргүүн нь гэрийн хойморт сууна. Гэрт байгаа эмэгтэйчүүд ихэвчлэн зүүн талаар суух ба баруун хэсгийг нь эрчүүдэд зориулсан суудал хэмээн хүндэтгэдэг. Орыг ихэвчлэн гэрийн баруун хойд хэсэгт байрлуулан харин эмэгтэйчүүдийн орыг гэрийн зүүн хэсэгт байрлуулна. Зүүн талд тогооны тавиур болон хүүхдэд зориулсан үхэг хэмээх ор байна. Үхэг нь эсгий хучлагатай байх бөгөөд зарим газар үжин хэмээн нэрлэдэг.

Үхэгийн хажууд байгаа авдар нь гэрийн эзэгтэйд, хоолны савны хажууд байгаа авдар нь гэрийн эзэнд тус тус хамаарна. Гэрийн эзний ор нь энэ авдарны хажууд байрлана. Цахан дээр айргийн хөхүүрийг байрлуулна. Хөхүүр гэдэг нь үхрийн болон тэмээний ширээр хийгдсэн байна. Гэрийн зүүн талд лам суухыг хориглодог бөгөөд гэрийн хоймор суух ёстой.

Ихэнх малчин айлууд гэрт амьдардаг. Галаа хэмээх залуу малчных энэ жил өвөлжөөн дээрээ шинэ гэр барьжээ. Гэрийн дотор тавилга нь уламжлалт маягаар тавигдсан байна. Гэрийн зүүн болон баруун талаар хээтэй ор тавигдсан бөгөөд аяга савны шүүгээ, жижиг модон ширээ, зуух тавигдсан байхыг та харж болно. Гэрийн хойморт бурхан шүтээнийг тусгай тавиур дээр байрлуулсан байх бөгөөд гэрийн эзэн хоймороо сууж, зочид баруун талаар, эхнэр хүүхдүүд нь зүүн талаар суусан байхыг харж болно.

## 4.8 Хүнс, хоол

### 4.8.1 Хийцтэй цай

*Унд* нь Өмнөговийн энэ бүс нутаг дахь өдрийн үндсэн хоол, хүнсний нэг бөгөөд будаатай цайнд түүхий мах эсвэл борц хийн буцалгаж бэлтгэдэг. Манлай сумын малчин Энхбаясгалангийн гэргий Бямбасүрэн "унд идэхгүй бол өдөр ч өнгөрөхгүй шүү дээ" хэмээн инээж байв. Ундыг хэрхэн бэлтгэдэг вэ? (Зураг 30),

*"Эхлээд цайгаа өтгөн чанаж бэлэн болгоно. Цай шингэн байвал амтгүй хярам болно. Цайгаа гаргаж саванд хийж тавьсны дараа тогоондоо өөх, будаа хийж хуурна. Будаагаа маш сайн хайрвал амттай сайхан болдог. Будаагаа хуураад тусгайлан бэлдсэн цайгаа, шар болтол хуурсан будаан дээрээ хийж сүлнэ. Цайгаа эхлээд сүлэх юм бол улаан өнгө сууна, тиймээс сүүлд нь хийдэг. Эцэст нь жижиглэж бэлдсэн махаа дээрээс нь хийж жигд галаар 20-25 минут буцалгаж болгоно".*

Монголд сүүлийн үед зөв хооллох, цагаан хоол идэхийн ач холбогдлын талаарх мэдээлэл, сурталчилгаа бий болсонтой холбоотой сүү, махыг холих нь зохистой бус гэсэн санаа тархаж байгаа нь Өмнөговийнхны гол хоолны төрлийн хэрэглээнд сөрөг нөлөөтэй байж болзошгүй хэмээн Манлай сумын засаг даргын тамгын газрын нэгэн ажилтан бидэнд ярьж байв. Гэвч бидний хээрийн шинжилгээгээр малчид энэхүү үзэл санаанаас ангид урьдын адил ундыг гол хоол, цай болгон хэрэглэсээр байна. Өглөө гол төлөв цай боорцог идэж, өдөр ундаа хийдэг. Зуны цагт өдөр унд хийж идсэн бол орой заавал махан хоол хийдэггүй. Хоол хүнсэнд мах, гурил, цагаан будаа зэргээр унд, шөлтэй хоол, цуйван, бууз, хуушуур гол төлөв хийж хэрэглэж байна.

### 4.8.2 Цулхир, бажууны гурил хийх арга ухаан

Цулхир нь говьд ургадаг ургамал ба говьчууд хүнс, эмчилгээний зориулалтаар түүж хэрэглэдэг (Зураг 31). Дэлхийн II дайны үеийн гурил, будаа хомс байсан цагт говийнхон цулхирын будаа, гурил хэрэглэж байсан ба халуун хөөдөг, таван цулыг угаадаг хүйтэн чанарыг нь эмчилгээнд өргөн хэрэглэдэг байна.

Ханбогд сумын Улаан толгойн усанд нутаглаж буй залуу малчин Цэцгээгийн Алтангэрэл, түүний эхнэр Насан-Өлзий нарын ээж Цэдэнхүү гуай, Баян-Овоо сумын Л. Батаа, Раш гуай нар бидэнд цулхирын гурилыг түүх, хатаах, будаа, гурил хийх арга ухааны талаар нарийвчлан ярьж өгсөн юм.



**Зураг 30** **Хоол унд бэлтгэж буй байдал**



C

B

A

**Зураг 31** **Цулхирын гурил хийх: а). Баян-Овоо сумын Налих багийн өндөр настан Цэдэн-Иш гуай цулхир түүж, цулхирын будаа, гурил хийж байна, b). Түүж, хатаасан цулхир, c). Цулхирын будаа**

## 4.9 НИЙГЭМ, ШАШИН, ХЭЛ

### 4.9.1 Өмнөговь аймгийн оршин суугчдын шашин шүтлэг

Буддын шашин говийхны гол шашин байгаагүй хэдий ч Өмнөговь аймаг нь анхны буддын шашинтай газар нутаг юм. Энэ бүс нутагт Монголын бусад нутаг газар оронтой адил 18-20 дугаар зууны эхэн үед бурханы шашин өргөн дэлгэрч олон сүм хийд байгуулагдсан байсан (Зураг 32). Сүм хийдүүд нь өөрсдийн бий болгосон хууль, дэг журмыг дагаж мөрддөг байсан ба түүнийг "Жаяг" гэж нэрлэдэг. Тухайн үед Өмнөговь аймгийн сүм хийдүүдэд мөрдөгдөж байсан ёс жаяг нь Монголын баруун болон төвийн аймгуудын сүм дуганд мөрдөгдөж байсантай адил төсөөтэй байжээ. Хэрвээ лам ёс жаягаа дагахгүй бол шийтгэл хүлээдэг бөгөөд түүнийг "Баа гэж нэрийддэг" бөгөөд энэ шийтгэлд нь дараах шийтгэлийн хэлбэрүүд багтдаг байсан: 100 ширхэг зул өргөх, сүмдээ мөнгө өгөх, 100 удаа залбирах, бусад лам нарынхаа өглөөний цайг бэлтгэх мөн зодуулах гэх мэт.

Социалист нийгмийн үед ихэнх сүм дугануud эзэнгүй болж сүйтгэгдээд 1990 оны Ардчилсан хувьсгалаас хойш шашин шүтэх үзэл баримтлал эрх чөлөөтэй болсоор олон сүм дуганууд нээгдэж үйл ажиллагаагаа сэргээсэн. Тус аймгийн Ханбогд сумын Дэмчигийн хийд, Өлгийн хийд үйл ажиллагаа дахин сэргээсэн. Ханбогд сумын төв дээр Пунцагтэгчилэн хийд мөн үйл ажиллагаа явуулж байна. Баян-Овоо, Манлай сумынхан хувьсгалаас өмнө Цогт-Овоо сумын нутаг дахь Шанхын хийд рүү очиж цам, майдар эргэх зан үйлд оролцдог байсантай холбоотой олон түүх, хууч яриа байна. Баян-Овоо сумынхан Налих, Долоон шар загийн хийдтэй холбоотой олон түүх, уламжлалаа хадгалж байна. Тухайлбал бидний уулзаж ярилцсан Л. Батаа, Цэдэн-Иш нар Долоон Шар заг, Налихийн хийдэд шавилж байсан байна. Баян-Овоо сумын гол тахилгатай байсан овоодын сан судрыг мэддэг хүн үгүй болсон тул одоо дахин тахих боломжгүй болсон гэж Л. Батаа гуай үзэж байв. Мөн гурван багийн гол тахилгатай овоод нь урьд хошууны засаг ноён Долоон шар заг хийдийн номтой ламтай муудалцсанаас тэрээр гурван хараал булсан газар гэсэн тайлбар хэлж байв.

Ханбогд суманд 20 гаруй бөө тодорсноор орой бүр бөө нарын онгод дуудлагын зан үйл болж байна. Гол төлөв залуу, энэ нутгаас тодорсон бөө нар гэнэ. Манлай суманд Ханбогдоос бөө нар ирж шинэ овоог тахилга шүтээн болгосон байв. Цэцгээ, Гүнж гээд 20 гаруй бөө нар дээр нэмэгдэж дахин шинээр 7 бөө тодорч байна. Бид Очир хэмээх бөөтэй уулзах хүсэл тавьсан боловч холын хүнийг хүлээж авахгүй гэснээр уулзаж чадаагүй болно.





**Зураг 32 Ханбогд сумын төв дэх гандан**

## 4.9.2 Бурхан тахил, шүтээн

Шашингүйн үзэл давамгайлсан социалист орчин үежилтийн үед Монголчууд шүтдэг бурхан тахилаа ил тавьж шүтэж тахих эрхгүй байсан бол 1990-ээд оноос шүтэх бишрэх эрх чөлөөтэй болсноор айл бүр бурхан тахилтай болсон гэхэд ташаа болохгүй билээ (Зураг 33). Судалгааны бүс дэх айл өрхүүд Алтангэрэл судар болон Очирваань бурханыг залж тахиж байна. Эдгээр бурхан шүтээнүүд нь гол төлөв өвөг дээдсээсээ уламжлан авсан байх ба шашин хориотой байх үед далд хийж нууж байгаад гаргаж ирсэн байх нь олонтой байна.

Буддын шашин нь говийнхны гол шашин нь байгаагүй. Говийнхны гол шүтээн нь говийн ноён хутагт Данзанравжаа байжээ. Зарим нутгийн оршин суугчид Данзанравжаагийн байгуулсан Гурван сарьдаг дуганд ирж мөргөдөг. Түүнээс гадна айлуудаас хойхон хотны овоо нэртэй нэгэн толгод байдаг. Айлууд одоог хүртэл сар шинээр цай сүүгээ өргөн сайн сайхныг хүсч шүтэн дээдэлдэг байна.

Буддын шашин нь 18-р зуунаас 20-р зууны эхэн хүртэл өргөн дэлгэр тархаж маш олон сүм хийдүүд баригджээ. Ханбогд сумын Өлгий, Пунцагтэгчинлэн болон Дэмчигийн хийдүүд 1990 оноос дахин сэргэж үйл ажиллагаагаа явуулж эхлэсэн. Шанхын хийд дээр болсон цам, майдар эргэх ёслолд Баян-Овоо, Манлай сумуудын иргэд өргөнөөр оролцсон нь энэхүү хийд хоёр сумын шашны гол төв болохыг харуулж байна. Номгон суманд байрлах Уртын, Эхэн, Загийн хийдүүд нь байнга дурьдагдаж байдаг болохоор Номгон сум нь хувьсгалаас өмнөх үед буддын шашны гол төв байсан нь харагдаж байна. Одоогийн Баян-Овоо сумын нэрэнд орсон энэхүү овоо нь бурхан шашны ёслол хийдэг ариун газар байсныг одоо мэдэх хүн ховор болсон. Тийм болохоор энэ овоог дахин тахихаа больсон.



A



B



**C**



**D**

**Зураг 33** **Бурхан тахил: a). Ханбогд сумын Хулгарын ус хэмээх газар өвөлжиж буй малчин С. Батсүхын бурхан тахил, b). Баян-Овоо сумын малчин, уртын дууч Цээнзэн гуайн бурхан тахил, c). Бурханы тахилын хайрцаг, d). Цөгц ба бурханы өргөл**

Гэвч сүүлийн хэдэн жил бөөгийн шашны зарим хүмүүс энэ овоог тахих болсон.

Өнөөг хүртэл тахин шүтэж байгаа өөр нэг зүйл бол тусгай мод юм. Нутгийн оршин суугчид өнөөг хүртэл тоорой модондоо цай хоолныхоо дээжийг өргөсөөр байгаа.

## 4.10 Христийн сүмүүд

2003-2007 онд Ханбогд, Манлай, Даланзадгад сумуудад гурван христийн сүм бий болсон. Эдгээрт 59 шүтэн бишрэгч, нэг пастор, нэг туслах байдаг. Баасан, Бямба гаригуудад хүүхдүүд, шүтэн бишрэгчдэд зориулсан тусгай үйлчилгээ байдаг. Түүнээс гадна сургалт болон халамжийн үйл ажиллагаанууд долоо хоногийн турш явагддаг. Эдгээр сүмүүд нь 10%-ийн гишүүдийн хураамж, Монголын христосийн холбоо, Дэлхийн зөн, Мөнхийн итгэл болон бусад буяны байгууллагуудын хандиваар үйл ажиллагаагаа явуулдаг.

**Хүснэгт 8 Өмнөговийн нутаг дахь Христийн сүмүүд**

| | Христийн шашны үйлчилгээний нэр | Байгуулагдсан он | Ажилчидын тоо | Шүтэн бишрэгчдийн тоо |
|---|---|---|---|---|
| Манлай | Авралын зар гэр сүм | 2007 | 1 пастор | 50-60 |
| Ханбогд | | 2006 | | |
| Даланзадгад | Есүсийн аврал сүм | | | 80 |

Эдгээр сүмүүд нь гадаадын зарим байгууллага Солонгосын холбогдох байгууллага иргэд, мөргөлчид болон оюутнуудтай хамтран ажилладаг бөгөөд Өмнөговь аймагт гурван баг ажиллуулан олон нийтийн хөтөлбөр хэрэгжүүлэх замаар аймгийн хэмжээнд христэд итгэгчдийн тоог нэмэгдүүлэх сонирхолтой байна. Сүмийнхэн сумын удирдлагуудтай нягт хамтран ажиллах хүсэлтэй байгаа ч шашин шүтдэггүй хүмүүсийн эсэргүүцлийг даван туулах хүмүүст бурхны аврал зарыг ойлгуулахад тодорхой хэмжээний хүндрэл учирсаар байна.

### 4.10.1 Итгэгчид болон шүтэн бишрэгчид

Өмнөговь аймагт буддын шашин нилээн өргөн дэлгэр тархсан (Хүснэгт 9). Гэвч лам багшид очдог хүн цөөн байдаг. Өөрсдийгөө буддын шашинтан гэж үздэг хүмүүсийн хагас нь л өөрсдийн жилийн заслаа хийлгэдэг (Хүснэгт 10). Харин маш цөөн тооны хүмүүс өөрсдийн амьдралд гарсан хүндрэлтэй асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор сүм хийдэд ханддаг байна. (Хүснэгт 11)

Христосын болон Бөөгийн шашин нь Буддын шашныг бодвол цөөн итгэгчидтэй. Шашингүй үзэл нь Өмнөговь аймагт, ялангуяа Баян-Овоо суманд нилээд тархсан.

**Хүснэгт 9 Шашин шүтдэг хүмүүс (сум, шашнаар)**

| Сум | Шашин шүтдэггүй | Буддын шашин | Христосын шашин | Бусад |
|---|---|---|---|---|
| Баян-Овоо | 67.4 | 26.1 | 6.5 | |
| Манлай | 26.6 | 73.4 | | |
| Ханбогд | 11.9 | 86.2 | 1.8 | |
| Даланзадгад | 20.5 | 73.3 | 5.4 | 0.8 |

**Хүснэгт 10 Багшид итгэдэг буддын шашин шүтдэг хүмүүс**

| Сум | Тийм | Үгүй |
|---|---|---|
| Баян-Овоо | 7.1 | 92.9 |
| Манлай | 12.5 | 87.5 |
| Ханбогд | 22.9 | 77.1 |
| Даланзадгад | 28.9 | 71.1 |

**Хүснэгт 11 Баян-Овоо болон Манлай сумдын шашны зан үйлийн онцлогууд**

| Сум | Янз бүрийн лам нар итгэгчдийг сонсдог | Зайран удганчуудын хамгаалалтад байх | Сүмийн хонхны дуу сонсох | Зурхайчид очих | Шри Шри бясалгалд явах | Фенг Шүй шүтэх | Асуулгад оролцогсдын тоо |
|---|---|---|---|---|---|---|---|
| Баян-Овоо | 1 | 3 | 1 | | | | 10 |
| Манлай | 1 | | | 1 | 1 | 1 | 8 |

### Өмчийн Эрх ба Холбогдох Хууль Тогтоомж

Өмнөговь аймгийн сум бүр өөрийн засаг захиргааны байгууллага, засаг даргын тамгын газар болон тахих овоотой хүмүүс. Өмнөговийнхон Монголын бусад аймгийнхныг бодвол азтай улс: тэд өөрийн гэсэн өвөлжөөтэй, өөрийн шүтэн бишрэх овоотойн дээр газрын төлөө тэмцдэггүй.

Уламжлал ёсоор өвөлжөө хуваах тодорхой журамгүй. Язгууртнууд, мяндагтнууд болон хошууны туслахууд өөрсдийн хүссэн газраа эзэмшиж өөрсдийн нэрээр нэрлэн тухайн нэрээ банзан дээр бичиж хаддаг байжээ. Хэн ч ийм нэр бичсэн бэлчээр лүү ордоггүй байжээ. Энэ нь эртний уламжлалтай хамаатай.

Өмнөговийн малчид өөрсдийн саравч хашаатай бөгөөд үүнийгээ удам дамжин өвлүүлдэг. Амьдрах газраа үндны усныхаа ойролцоо сонгон Он хэмээх чулуугаар тэмдэг тавьдаг байжээ. Энэхүү онгоор тэмдэглэсэн газар хэн нэгэн гэрээ барих эрхгүй. Тэгээд ч айлууд он чулуу тавихгүйгээр өөрийн гэрийг буулгах ёсгүй.

Өмнөговь аймагт худаг усны нөөцтэй холбоотой уламжлал нилээд тархсан. Ус ховор газар нутагт худаг усыг өмчлөх эрх байдаг нь тийм ч гайхмаар зүйл биш. Гэхдээ хэн нэгэн худгийг дангаараа эзэмшихгүй хэд хэдэн айлууд нэгдэж нэг худгаас үндлана гэсэн үг. Хамгийн гол нь ус нийтийн өмч хэвээр үлдсэн.

Судалгааны ажлын явцад Өмнөговийн хаад ноёдын соёрхсон зарим сонирхолтой журмууд байдгийг олж мэдсэн. Жишээ нь, Дайчин бэйлийн хошууны тамгийн газар нь эзний хуучны өмчлөл гэдэг нэртэй газарт оршдог байжээ. Тамгийн газар нь өөрийн дотоод бүтэц хуультай байсан. Хулгай хийх, мөрийтэй тоглох, дээдэстнийг үл хүндэтгэх зэрэг тодорхой гэмт хэргийн шийтгэлийг тухайн орчны нөхцөл байдалтай холбогдуулан оноодог байжээ. Энэ нь Монголын бусад хэсгүүдтэй ижил байна.

## 4.11 Овгийн нэр, ураг төрлийн хэлхээ холбоо

Ураг төрлийн харилцаа уламжлалт Монголын нийгмийн харилцаанд нэн чухал дэг журам байсан билээ. 1990-ээд онд орхигдсон овог ургийн нэрийг сэргээх үйл ажиллагаа өрнөж, өнөөдөр хүн бүр эцгийн нэрээс гадна овог ургийн нэр хэрэглэж буй. Овог ургийн нэрийн судалгаа нь энэ бүс нутгийн уламжлалт нийгмийн хэлхээ холбооны талаар ойлгож авах чухал эх сурвалж юм.

Баян-Овоо сумын иргэн Ө. Сүхбаатар (Зураг 34) *"Баян-Овоо суманд Улаан даавуу, Өндөр мануул (Боржигин), Ёохчууд (түрэг гарлын овог) гэсэн ердөө л 3 овог бий, гэтэл 120-30-аад овог тэмдэглэгдээд байгаа. Миний бодлоор 1990-ээд оноос хойш овгийг буруу тогтоосон. Энэ нь үндэсний аюулгүй байдалд харшлах аюултай. Ер нь бол овог тогтоосон нь зөв. Өөр нэгэн жишээ бол Дундговийн Эрдэнэдалай 5 овгийнхон байдаг явдал. Гэтэл бас л нийтдээ 100 гаруй овгийн нэр тэмдэглүүлсэн байгаа. Монголчуудын хувьд 3 үе дотроо суух нь тун хорио цээртэй байдаг. Тийм хүмүүсийг алаг мариа хэмээн нэрлэж шинийн 3-ний дотор ордоггүй алаг мариа хүмүүс дээр орж золгодоггүй."*

Бидний судалгаагаар Ханбогд сумын малчин Отгоолой, Бандиа нар нь Удай ургийн Урианхай овгийн хүмүүс болох нь тодорсон бөгөөд энэ ургийнхан нийлж тахьдаг овоо байдаг гэнэ. Мөн энэхүү Удайд овог нь урианхай овог тул энэ бүс нутгийн овгийн бүрэлдэхүүнийг харуулах баримт болж байна.



A



B

**Зураг 34** **Ургийн хэлхээ, холбоо: a). Баян-Овоо сумын ургийн хэлхээ холбоог Сүхбаатар гуай судалж үндсэн 3 овгоос гаралтай хэмээн үзэж байна, b). Ханбогд сумын тэмээчин Отгоолой Удайд овгийн хүн бөгөөд Удайд овгийнхон тахьдаг өөрийн овоотой ажээ.**

**Өмнөговийнхны хэл** бол Монголын нутгийн аялгууны хэлнүүдийн нэг юм. Энэхүү үгсийн сан нь тухайн газар нутгийн гзар, газарзүйн байрлал, хамгийн гол нь энэхүү хүнд хэцүү цаг ууртай газар байгаа нүүдлийн эдийн засагтай холбоотой байжээ. Өмнөговийнхны нутгийн аялгуу нь зарим нэг өвөрмөц аялгатай. Жишээ нь: баруун тийшээ гэхийн оронд бараншаа, барантга гэх мэтчилэн хэлдэг. –саар хэллэгийг хэлэхдээ аа, ээ, оо, гэх мэтчилэн урт эгшгээр дууддаг. Явсаар байгаад гэхийн оронд яава байгаад, өгссөөр байгаад гэхийг өгсөө байгаад гэх мэтчилэн дууддаг. Гэвч шинээр ирсэн хүмүүс энэ ялгааг тийм ч их анзаардаггүй төдийгүй өмнөговийн нутгийн хэл нь их Монгол хэлний аялгатай уусан алга болж байна.

## 4.12 Дуу хөгжим, дуулаачид

Монголын урт богины дуу нь тухайн үндэстний амьдрах хэв маяг, ёс заншил, уламжлалтай холбоотой. Ханбогд, Манлай, Баян овоо сумдад Монгол дууг уламжлал ёс заншилд тулгуурлан олон янзаар дуулдаг. Жишээ нь: Эргэлэнгийн дээгүүр, Гишгэдэл сайт үрээн зээрд, Холч морь гэсэн дуунуудыг зөвхөн Ханбогд суманд дуулдаг ч Наранзул хулыг Манлай суманд, Хурдан Сайханг зөвхөн Манлай суманд дуулдаг байна. Эдгээр дуунуудын ихэнх нь уул ус, говийн хүн амтай холбоотой байдаг. Залуу үедээ дуу шүлэг заах уламжлал ч тасраагүй байна.

### 4.12.1 Уртын дуу, ерөөл магтаал

Энэ бүс нутаг дахь уртын дууны уламжлал, дэгийн талаар Баян-Овоо сумын иргэн Ө. Сүхбаатар, Цээнзэн, Л. Батаа, Даланзадгад сумын Д. Бямбаа нартай ярилцсан (Зураг 35). Сүхбаатар гуай тайж удамтай хүн бөгөөд дээдсээсээ өвлөн авсан уртын дууны түүвэр хадгалж байна. Тэрээр ярихдаа "социализмын үед үзэл сурталд харш хэмээн дуулагдаж байгаагүй, олонд түгж дэлгэрээгүй олон сонирхолтой дуунууд энэ түүвэрт багтсан байдаг. Мөн зарим уртын дууны үгийг зориудаар болон санамсаргүйгээр өөрчлөн гажуудуулж дуулж ирсэн болохыг мэдэж болохоор байна."

Цээнзэн гуайнхан ах дүүгээрээ хуурч, уртын дууч улс бөгөөд түүний дүү нь төрийн хан хуурч Цэрэндорж гуай ажээ. Тэрээр 2010 оны 9 дүгээр сард "Энержи Ресурс" компаниас Цогтцэций суманд зохион байгуулсан "Говь-Шанхын гурван уртын дууны тэмцээн"-нд оролцож гуравдугаар байр эзэлсэн тухайгаа хуучлахын хамт Говь-Шанхын гурван дууны домог, ая дэгийн онцлогийн тодруулав.

*"Говь Шанхын гурван дуу гэдэг нь энэ нутгийн Гэсэр лам хэмээх хүний зохиосон гурван дуу юм. Эдгээр нь "Өндрийн сайхан", "Хулч бор", "Хурдан сайхан". Одоо Өндрийн сайхан-ы аяыг зөв дуулах хүн байхгүй болсон байна. Тус тэмцээн болохын өмнөх өдөр бүх оролцогчид бэлтгэл хийсэн. Би Өндрийн сайхан-ыг дуулахад зарим сэргэлэн залуучууд бичиж аваад давтаж бэлтгэсэн байсан. Гэсэн ч олигтой аяыг нь олж чадахгүй байна. Ер нь говийн уртын дууны уламжлал тасрах гээд байна шүү".*

*"Шанхын Ар ширээ Шавхдай гэдэг газар Гэсэр гэлэн гэдэг баян хүн байсан. Гэсэр гэлэнд нэг хурдан хул морь байжээ. Нэгэн удаа Гэсэр гэлэн Сангийн далайн хажууд хүнтэй муудан, хүн алсан хэрэгт ороод байв. Тэрээр тэр өдөртөө хул морио барьж унаад Богдын хүрээ орсон гэдэг. Тэгээд хүрээнд очиж хятадийн пүүс дээрэмдэж байгаад баригдсан учир тэнд хүн алсан байх учиргүй гээд хулгайн хэргийнхээ мөнгийг төлж гарч ирсэн домогтой. Домогт гарч байгаа хул морины тухай 3 дуу төрсөн нь "Хурдан сайхан, Өндөр өвс, Хулч морь" дуунууд юм хэмээн домгийг нь өгүүлсэн.*

Л. Батаа гуайд түүний өвөө нь уртын дуу зааж өгчээ. Эхлээд уртын дууны үгийг цээжлүүлж эргэн шалгадаг байжээ. Хожим найр, хуриман дээр тэдгээр дуунуудын аяыг сонсохоор үгийг мэддэг тул амархан ая хөг нь орж ирж байсан гэж ярьж байв. Тэрээр энэ нутагт дуулагддаг байсан уртын дууны үгийг өөрийн сонирхлоор цуглуулж нэгэн дэвтэр болгоод байгаа бөгөөд боломж гарвал хэвлүүлмээр байна гэв. Сүүлийн 20 гаруй жил юм харахаа больсон тэрбээр багын дууны үгийг сайн цээжилдэг сургуулиараа дууны үгийг хүнд хэлж бичүүлдэг нэгэн ажээ. Биднийг ярилцаж байх зуур биднийг бич хэмээн "Түмний эх", "Өндрийн өвс", "Хулч морь", "Шавь хурлын магнай", "Шашин төрийн дуу", "Төрийн товчоо", "Ертөнцийн гурван завхай" гэсэн дууны үгийг дуудаж, домог түүхийг хэлж өгөв.

Д. Бямбаа гуай Говь Шанхын гурван дууны тэмцээнд оролцсон ба Даланзадгад сумын 3 дугаар сургууль дээр уртын дууны дугуйлан хичээллүүлж байна. Тэрээр хэлэхдээ энэ бүс нутагт Говь Шанхын агуу дуучин Ханшин, мөн Таванжин, Зургаанжин гэсэн сайн дуучид байсан. Одоо Банзрагч, Ч. Бат-Өлзий зэрэг олон дуучид байна.

Ханбогд сумын төв дээр аж төрөн сууж буй Авираа гуай энэ нутагт 1964 онд Ханхонгор сумаас ирж сувилагчаар ажиллахдаа Ханбогдын уртын дуучдаар заалгаж уртын дуу дуулах ухаанд суралцжээ. Мөн тэрээр хоолойн цуур хэмээх нэн онцгой ур чадварыг эзэмшсэн. Тэрээр "Эрэглэнгийн зоо" зэрэг дуу дуулж, хоолойн цуурын аялгуу бичүүлэв.

*"Би уртын дууг анх Малжиг гуайгаас сурсан. Ер нь энэ нутгийн ардаас сурсан гэж хэлж болноо. Данзанравжаагийн зохиол "Эрэглэнгийн дээгүүр" дууг Малжиг гуайгаар заалгаж байсан бол "Гүйдэл сайт үрээн зээрд" дууг хадам эгч Ийжийхүү гэдэг хүн надад анх зааж өгч байлаа. "Шар талын цэцэг" дууг Улзанаар заалгасан. Энэхүү дуунуудыг манай нутгаас өөр газар дуулж байгаагүй. Миний нэг дуу радиогийн алтан сан хөмрөгт одоо болтол хадгалагдаж байгаа. Би өөрийнхөө дуулсан дууг одоо сонсдог юм. Тэр үед би залуу байждээ"* гэсэн байна. *"Надмид гэдэг уртын дууны түүвэртэй хөгшин байсан. Намайг бичиж аваарай гэдэг байсан ч "чоно үүрэндээ гэгчийн үлгэрээр" бичиж авахгүй байсаар байгаад өөд болгосон* хэмээн хүүрнэсэн.

Ханбогд сумын иргэн Цэдэнгомбо, Идэрцог нар ерөөл хэлдэг ба Хулгарын усны Сайхансамбуугийн Батсүх гуай сум, орон нутгаа магтсан өөрийн зохиосон ерөөлөө хэлэв."





**A** **B** **C**

**Зураг 35** **Өмнөговь аймгийн уртын дуучид: a). Баян-Овоо сумын Хар заг багийн Хөх хадны бууцанд суудаг иргэн Цээнзэн, b). Баян-Овоо сумын Халих багийн иргэн Л. Батаа, c). Даланзадгад сумын иргэн Д. Бямбаа**

**Дуу хуур, баяр цэнгэл**

Аливаа баяр наадам нь өөрийн эхлэл, өрнөл, төгсгөлийн дуутай байсан нь одоог хүртэл хадгалагдан ирсэн. Аливаа баяр цэнгэлийг Түмний Эхээр эхлэн Хуур магнайгаар дуусах гэж байгааг илэрхийлэн Зун цагаар төгсгөдөг байжээ. Түшээт Хан Аймгийн өмнө хэсгээр шөнө дунд 12 жилийг, үүр цайхаас өмнө Үүлэн Борыг, Бор Бялзуухайг үүр цайхад, Найман тахилыг нар мандахад тус тус дуулдаг байсан ба баяр наадмын төгсгөл нь нилээд хатуу дэг журамтай байжээ. "Алтан богд", "Богдон уулын сүндэл", "Хан уул", "Урт сайхан хүрэн", "Богдын өндөр", "Бор бялзуухай", "Наран зул хул", "Түмэн эх" дуунуудаар баяр наадмыг эхэлж "Холч морь", "Хурдан сайхан", "Ялбуулсан эрхтэй", "Уяхан замбатив", "Жаргалтайн дэлгэр", "Эр бор харцага", "Гишгэдэл сайт", "Ар хөвч", "Хурмаст тэнгэр", "Хөндийн өндөр" зэрэг дууг баяр наадмын өрнөл дээр дуулан Хурдан сайхнаар баяр наадмаа төгсгөдөг байжээ.

Заншил ёсоор холч морь дууг дуулж зочин бүрт айраг барих ба айлчин нь тухайн хултай айргийг ууж дуусгах ёстой. Дархан хул дүүргэсэн айл зочиндоо хуланд айраг дүүргэн зочид дархан хулыг зогсоохгүйн тулд нар зөв тойруулан дамжуулан уух ёстой. Хүн бүр энэ хулан дах айргийг хамтдаа ууж дуусган дахин айргаар дүүргэдэг. Зарим айлууд дархан хулыг хүн болгонд өгөх ба үүнийгээ дагнаа гэж нэрлэдэг. Дагнаа гэдэг нь таван дуу дуулж дуусах тутамд нэг хул айраг уух ёстой. Хүүхэд эмэгтэйчүүд болон дуучид хулыг бүрэн ууж дуусгах албагүй. Монгол ардын дуу нь баяр наадам учир утгыг оруулж өгдөг бөгөөд тухайн улс үндэстний амьдралд хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн ерөөж байдаг.

**Хөгжмийн зэмсэг**

Өмнөговь аймагт морин хуур, хуучир, хулс, бишгүүр, аман хуур болон бусад хөгжмийн зэмсгүүд байх бөгөөд аймгийн музейд хувь хүний цуглуулгаас авсан олон янзын хөгжмүүд байдаг. Бид судалгааны ажлын явцдаа байнгын хэрэглэгддлэг хөгжмийн зэмсгүүдээс гадна зэс бүрээ, гандан, цам, сэлмэн дун, дуу, дуран хэнгэрэг, хүрэл хэнгэрэг, харанга гэх мэтийн бусад 10 төрлийн хөгжмийн зэмсгүүдийг ирүүлсэн.

Уламжлалт хөгжмийг дандаа найрал хөгжмөөр тоглодог байсан. Ийм найрал хөгжмийг аман уламжлалд нилээд их тэмдэглэсэн байдаг. Жишээ нь, ноён хутагт Данзанравжаагийн жүжигт дөч гаруй хөгжимчдөөс бүрдсэн найрал хөгжим тоглодог байжээ.

Айл болгонд ногоон толгойтой морин хуур байдаг. Энэ нь Монгол айл өрхийн хамгийн их хүндэтгэн үздэг зүйлсийн нэг бөгөөд тухайн айлд зочилсон хүн бүр өөрсдийн өдрийнхөө үйл хэргийг амжилттай болгохын тулд морин хуурыг тоглож чаддаг эсэхээс үл хамааран заавал дуугаргадаг байжээ. Өмнөговийнхон ч гэсэн энэ уламжлалыг дагаж мөрддөг.

Өмнөговьд Хонь Хурга Нийлүүлэх, Ингэ Буйлуулах, Үнээ Тугал Мөөрүүлэх гэх мэтийн сонин нэртэй аялгуунууд байдаг. Эдгээрээс хамгийн сонирхолтой нь өмнөд халхын Аяга Буйлуулах гэдэг дуу юм. Дуучин нь өөрийн зүүн алган дээр сайтар угаасан шаазан аяга тал устай тавиад ядам хуруугаараа нар зөв усыг нь эргүүлдэг. Ингэснээр аяга буйлуулах гэсэн аялгуу үүсдэг байна. Энэ аялгууг ботгоо голсон ингийг ботгыг нь авахуулах үед ашигладаг байжээ.

## 4.13 Ардын тоглоом

### 4.13.1 Чулуун гэр болон бусад тоглоом

Чулуун гэр барьж тоглох тоглоом нь Монголчуудын нүүдлийн ахуй, ёс заншлыг үеэс үед дамжуулахад чиглэгдсэн шилдэг биет бус өвийн нэг юм (Зураг 36). Тиймээс бид малчин өрхүүдэд ажиллахдаа чулуун гэрийн буйр бий эсэх, хүүхэд, залуучууд тоглож буй эсэхийг тодруулсан. Ханбогд сумын малчин Бандиа, Бүнтэн, Баян-Овоо сумын малчин Цэдэн-Иш нарын үр хүүхдүүд нь багадаа тоглож байсан чулуун тоглоомын газрууд одоо хүртэл хадгалагдаж байна. Тэд ярихдаа "одоогийн хүүхдүүд чулуун гэр барьж тоглох явдал байхгүй болсон, бидний багад болон 1960-70 он хүртэл тоглодог байсан. Тэдгээрийн үлдэц одоо тарж бутарсан буйр байна" гэв.

Баян-Овоо сумын малчин, өндөр настан Цэнзэн гуай болон түүний хөвгүүд эвлүүлдэг модон болон төмөр утсан тоглоом хийж чаддаг, мөн багадаа тоглож өссөн байна (Зураг 36). Мөн малчин айл өрх бүрт шагайн тоглоом байгаа ажээ. Гэвч шагайгаар тоглох нь түгээмэл биш болсон байна. Манлай сумын малчин Энхбаясгалангийн охидууд шагай шүүрэх, морь уралдуулах зэрэг тоглоом тоглодог гэж хэлж байна.



**Зураг 36** **Баян-Овоо сумын Налих багийн иргэн Ц.Төмөртогтохын багадаа тоглож байсан чулуун тоглоомын буурь**



**Зураг 37** **Цээнзэн гуайн хөвгүүд модон болон төмөр утсан тоглоом өөрсдөө хийж тоглодог байсан ба өнөөдөр үр хүүхдүүд нь ч бас тоглож байгаа юм байна.**

### 4.13.2 Шагайн харваа

Монголын уламжлалт шагайн харваан тоглоом нь 1990-ээд оноос хойш тоглоом болон спортын төрөл хэлбэрээр өргөн дэлгэрэн (Зураг 38) төрийн наадмын 4 дэхь төрөл болсонтой холбон тайлбарлах боломжтойгоос гадна өөр бусад ямар шалтгаан, бүтэц байгаа нь сонирхолтой юм (Хавсралт 10, 11 – Наадмын тухай тайлан). Шагайн харваа нь Ханбогд болон бусад суманд өргөн тархаж хөгжсөн байна. Ханбогд сумын малчин Бандиа гуай сумын шагайн харвааны шигшээ багт орж олонтоо тэмцээн уралдаанд орсон бөгөөд олон шавь нартай гэнэ. Шагайн харваа тоглоом нь ахмад настнаа хүндлэх, ёс журмыг баримтлах, тэвчээр гаргах зэрэг олон сайн шинж чанарыг эрчүүдэд суулгадаг хэмээн тоглогчид нь үнэлэн хэлдэг байна.







C

A

B

**Зураг 38. Шагайн харваач: а). Ханбогд сумын Жавхлан багийн малчин Бандиа гуай, б). Бандиа гуай Ханбогд сумын шагайн харвааны багийн гишүүн ажээ.**

## 4.14 Говьчуудын хорио цээрийн ёс

Хорио цээрийн ёс нь тухайн соёлын ёс зүй, утга бэлгэдлийн тогтолцооны илэрхийлэл байдаг тул энэ бүс нутгийн соёлын агуулга, бүтцийг ойлгож түүнд зориулсан соёлын өвийн хөтөлбөр боловсруулахад судлан тодруулах зайлшгүй чухал хэсэг нь юм. Өмнөговьчуудын хорио цээрийн ёсны судалгаа цаашид үргэлжлэх бөгөөд энэ удаад тэмээний махтай холбоотой цээрүүд, бурханы өмнө тэмээний мах гаргадаггүй байсан болон чулуун тоглоомыг нутаг дээрээ хаяж нүүдэггүй, ороонгоны эврийг болгоомжтой хэрэглэх буюу тэмээнд ачиж болдоггүй, хэрэв ачвал тэмээ хээл хаядаг, бүйлс түлдэггүй зэрэг хорио цээрийн зан үйлийг тодруулав.

Бандиа гуай хуучлахдаа, хүүхдийн чулуун тоглоомыг нутаг дээрээ хаядаггүй. Манлайд Долио Мятав гэдэг хүн хүүгийнхээ 2 тэмээн тоглоомыг хаяснаас хүү нь ухаан солиотой болсон гэж ярьцгаадаг юм. Мөн тэмээний махыг ихэд сэжиглэж тэмээ алдаг айлд орохоос цээрлэж, сэжиглэдэг байсан гэв. Тэмээг говийн соёлын цөм гэж үзэх атлаа махыг нь цээрлэдэг байсан нь чухам хэдийд үүссэн ямар нөхцлөөс үүссэн, ямар агуулгатай болох нь сонирхолтой юм.

Хонины толгойг өвдөг дээрээ тавьж байж муулдаг, уул довын орой дээр бие засдаггүй, хэцээс хэцэд явж байгаа аргал, зээр, гөрөөсийг агнадаггүй зэрэг олон янзын хорио цээрийг илрүүлээд байна.

## 4.15 Өвт газрууд: Өмнөговь аймгийн тахилгат газрууд

Төслийн 1 дүгээр үе шатанд хийсэн судалгаа, шинжилгээгээр бүртгэгдсэн Өмнөговь аймагт байгаа соёлын биет бус өвт газруудыг Хүснэгт 12-д үзүүлэв. Эдгээр нь уг аймагт байдаг бүх биет бус өвт газруудыг үзүүлж байгаа хэрэг биш юм. Үүнээс харахад орон нутгийн иргэд бишэрч хүндэлдэг, тахин шүтдэг үнэт зүйлс их байгаа ба ихэнх нь нүүдэлчин ард түмний гол шинж болох уул, нуруу, уст газар, рашаан булагыг дээдлэн шүтэж байгаа нь харагдаж байна. Түүнээс гадна, үүнд археологийн болон тахилга, овоо, оршуулгын газар зэрэг босгосон, байгуулсан газрууд орж байна. Орон нутгийн ард иргэд соелын өвийн талаар ярилцах, мэдээлэл солилцох дуртай болох нь ажиглагдсан тул цаашид олон өвт газрууд илэрч болохыг харуулж байна.

Хүснэгт 12 Өмнөговь аймгийн тахилгат газрууд

| | Өвт газрын нэр | Мэдээллийн эх сурвалж | Холбогдох зан үйл, хорио цээр |
|---|---|---|---|
| 1 | Өндөр Богд уул | Манлай сумын засаг даргын орлогч, Өөлий, малчид Алтангэрэл, Галаа | Шүтэж дээдэлдэг уул |
| 2 | Хонхорын овоо | Малчин Алтангэрэл | Ханбогд сумын бөө нарын шүтэж мөргөдөг овоо |
| 3 | Зааны овоо | Малчин Энхбаясгалан | Шашны зан үйл хийгддэггүй |
| 4 | Жавхлант уул | Малчин Бүнтэн, Бандиа | Жилд 2 удаа шашны зан үйл явуулдаг |
| 5 | Ханбогд уул | Малчин Бүнтэн, Бандиа | Жилд 2 удаа шашны зан үйл явуулдаг |
| 6 | Номгон уул | Малчин Бүнтэн, Бандиа | Жилд нэг удаа тахьдаг, 2010 оны тахилгын зан үйлийг Баясгалан, Сайхандэлгэр ивээн тэтгэсэн |
| 7 | Гялаан тойром | Сумын татварын байцаагч Сухбаатар | Нийтийн хүн тавидаг газар |
| 8 | Их Өлзийт | Малчин Алтангэрэл, Галаа | |
| 9 | Их Овоот | Малчин Алтангэрэл, Галаа | Тахилгат уул |
| 10 | Мааньтын овоо | Малчин Алтангэрэл, Жавхлант баг, Ханбогд сум | Ихэс дээдэсийг оршуулдаг байсан шүтлэгт овоо |
| 11 | Алаг дэлийн овоо | Малчин Алтангэрэл, Жавхлант баг, Ханбогд сум | Шүтлэгтэй овоо, одоогоор тахьдаггүй |
| 12 | Шавгийн дуулга (Догшин гурван дуулгын нэг) | Малчин Алтангэрэл, Жавхлант баг, Ханбогд сум | Шүтлэгтэй овоо, одоогоор тахьдаггүй |
| 13 | Хачивцын дуулга | Малчин Алтангэрэл, Жавхлант баг, Ханбогд сум | Шүтлэгтэй овоо, одоогоор тахьдаггүй |
| 14 | Далайн дуулга | Жавхлант багийн малчин Бүнтэн | Овоо тахьдаггүй |
| 15 | Хүрэн хайрхан овоо | Малчин Отгоолой | Шашны зан үйл хааяа хийдэг |
| 16 | Бор хошууны овоо | Энгэр баг модонд нутаглагч малчин Лэнтэн | Шүтлэгтнй газар, шашны зан үйл хийдэггүй |
| 17 | Толийн ус | Энгэр баг модны Хөөвөр хэмээх газарт нутаглагч малчин Бандиа | Хулан үндаалдаг ус хэзээ ч ширгэдэггүй |
| 18 | Ямаат улааны агуй | Жавхлант баг | Баян-Овоогоос Шаабаа-тар зэрэг хүмүүс ирж тахьдаг. |
| 19 | Тогоо хайрхан | Малчин Рашням | Могой багаас тахьдаг. |
| 20 | Шархадны бууц | Малчин Рашням | Догшин газар |
| 21 | Үнэгэд, Сэрүүн хайрхан | Малчин Л. Батаа | Шүтлэгтэй газар, шашны зан үйл явуулдаггүй |
| 22 | Цагаан-Овоо | Сүхбаатар | Могой багийн хүн тавьдаг газар |
| 23 | Шар Дэл | Сүхбаатар | |
| 24 | Хадан цохионы дэнж | Сүхбаатар | Баян-Овоо сумын хүн тавьдаг газар |

| | Өвт газрын нэр | Мэдээллийн эх сурвалж | Холбогдох зан үйл, хорио цээр |
|---|---|---|---|
| 25 | Зүүн Толь | Сүхбаатар | |
| 26 | Долоон шар загийн хийдийн туурь | Малчин Л. Батаа | |
| 27 | Налихын хийдийн туурь | Малчин Цэдэн-Иш | |
| 28 | Шувуун нумт овоо | Малчин, байгаль хамгаалагч Рашням | Чингис хааны тахьж байсан дайны сүр хүчийн овоо гэдэг. Лам ирээд сэржим тавихад улам шороо тавиад байдаг. Рашням өөрөө Мангуд овгийн хүн |
| 29 | Бух хайрхан | Л. Батаа гуай | Догшин хайрхан тахих хүн таардаггүй догшин газар |
| 30 | Ашиг хайрхан | Малчин Ц. Мөнхбат | Харзаг багаас тахьдаг |
| 31 | Хөх овоо | Малчин Ц. Мөнхбат | Налих багийн тахьдаг овоо |
| 32 | Өлзийт хайрхан | Баян-Овоо сум Малчин Л. Батаа | Ганжирваа хувилгаан тахьдаг байсан, мөн хүүхдийн овоо ч гэж нэрлэгддэг. |



A



B



C



D



E



F



G

**Зураг 39** **Өмнөговь аймгийн биет бус өвт газрууд: a) Манлай сум, Ширнэн Хөөвөний морь уналгын газар, Зааны овоо, b). Мааньты Овоо, c). Нэр тодорхойгүй, d). Ханбогд сум, Жавхлант баг дахь 3 дуулга тахилгат уул, e). Баян-Овоо сумын Хар Заг баг, Шувуун Нумт Овоо, f). Нэр тодорхойгүй, g). Баян-Овоо сумын Налих баг, Үнэгэн хайрхан**

## 4.16 Оюу Толгой төслийн шууд нөлөөллийн бүс дэх тахилгат газрууд

Саяхан "Оюу Толгой" компани Түүхийн Хүрээлэнтэй хамтран угсаатны зүйн судалгаа явуулсан ба уг судалгаанд 85 өрх хамрагдаж, 160 тахилгат газрууд тодорхойлогдсон (О. Цэрэннадмид, аман мэдээлэл, 2011). Эдгээрийн Хүснэгт 14-15-д харууллаа. Уурхай хөгжихийн хирээр эдгээр тахилгат газруудын тоо ч мөн давхар ихсэнэ гэж бид таамаглаж байна.

## 4.17 Өмнөговь аймаг дахь соёлын өөрчлөлт болон уламжлалыг үнэлэх нь

### 4.17.1 Биет бус өвийн аль хэсэг нь өнөөг хүртэл оршин тогтнож байна вэ?

Бид нутгийн оршин суугчидтай хийсэн ярилцлагын явцад биет бус өв гэдэг нь тэдний хувьд юу болох талаар ярилцсан. Энэ ярилцлагын үндсэн дээр бид Өмнөговьчуудад хамгийн чухал гэж тооцогдсон арван гол өвийг тодорхойлон гаргасан (Хүснэгт 16). Өмнөговь аймаг дах биет бус соёлын өвүүдэд мөнгөний дархан, шагай, бөөгийн шашин тус тус орж байна. Учир нь эдгээр уламжлалууд нь одоогийн нийгмийн байдалд тохирч маш олон хүмүүсийн хамруулж чаддаг. Хуучны хэн нэгнийг ялгаварлан гадуурхдаг заншил устаж гар урчууд тэдний үйл ажиллагаа нь улам бүр нээлттэй болсоор байна. Жишээ нь Мөнгөний дархчууд нь төрөл бүрийн гар урлалын бүтээгдэхүүнүүд (мөнгөн аяга, эмээл, хазаар)-ийг хийж тэдгээр нь маш их эрэлт хэрэгцээтэй байна. Урьд нь ердөө хэдхэн дархан л байж тэд өөрсдийн хүрээнд арга технологио нууцалдаг байсан. Гэвч бидний мэдэж байгаагаар залуу дархан Батням Өмнөговь аймгийн дархны бүх арга технологийг сурч мэдэн өөрийн мэдлэг туршлагаа олон нийтэд хүргэнэ. Батням одоогоор 70 гаруй шавьтай бөгөөд Ноён-Сэврэй чиглэлийн дархны өвийг хадгалан үлдэж дараагийн үедээ шилжүүлэх сонирхолтой байна. Дархны мэдлэгээ үе залгамжлуулах байдал уламжлал болсон ч холбогдох арга технологийг нууцлах нь зах зээлээ хадгалах нэгэн арга байсан. Биет бус өвийг үе залгамжлуулснаар олон нийтэд илүү их хандах боломж олгосон. Ингэснээр Өмнөговь аймгийн дархны урлал хадгалагдан цааш хөгжих болно.

Энд авсан жишээнээс үзвэл биет бус өвийн талаарх мэдлэг мэдээлэл нь улам бүр нээлттэй олон нийтэд хүртээмжтэй болж тухайн бүтээгдэхүүний зах зээл сулрах биш хүчирхэгжин үйл ажиллагаа нь сэргэн хөгжиж эхэлсэн. Дархнаас бусад уламжлалт үйл ажиллагааны хувьд олон түмэн илүү ихээр хүлээн авч дэмжих болсон.

Эдийн засгийн хөгжлийн зэрэгцээ социалист нийгмийн үед хаалттай байсан зарим нийгмийн уламжлалт үйл ажиллагаа дахин сэргэж эхэлсэн. Жишээ нь: 1990-ээд оны үеэс шагай няслах тоглоом сэргэж эхэлснээр олон төрлийн хүмүүс хамрагдах болж шинэ шинэ хүмүүстэй уулзан харьцах болсон. Ийнхүү удаан хугацаагаар уналтад орood байсан шагайн уламжлал дахин сэргэж байна.

**Хүснэгт 13 Шууд нөлөөллийн бүс дэх хорио цээртэй газрын мэдээлэл**

| | Тахилга, цээртэй газрын нэр байршил, координат | Тахилга, догшин, цээртэй газрын төрөл, холбогдох зан үйл, хорио цээр | Тахиж шүтдэг хүмүүс, овог, нэр, ургийн нэр, нас | Харьяалал, баг, бууц, усны нэр |
|---|---|---|---|---|
| **1** | Ханбогд Хайрхан  | Жил бүр зуны эхэн сард тахьдаг. Шинийн 1-нд гарч овоонд золгодог. Эмэгтэй хүн гардаггүй. Жавхлант багийн Тойн цохионы малчин Батын Намсрайжавын хэлснээр “элдэв хүмүүс гарч баймааргүй байна. Хужаа хүн гарч байсан гэсэн тийм баймааргүй байна”. Ханбогд хайрханы эзэн ногоон тэрлэгтэй, цагаан тэмээ унасан, тэмээнийхээ бөхнөөс хурганы уут угласан бөгөөд тэрхүү уутнаас нь аргалын хурга цухуйсан эмэгтэй байдаг байна.<br>1970-аад оны үед модон багана босгосон боловч 3 хоноод тэнгэр ниргэж устгасан. Дараа нь төмөр багана босгосон байсан нь саяхныг хүртэл байсан. Цэдэнгомбо гуай очиж авч хаясан байна. | Ногоонууд Цэрэндоржийн Хандсүрэн, 53, уугуул.<br><br>Тайжууд Батын Намсрайжав,<br>уугуул | Хайрцагт аман ус, Тойн цохионы бууц, Жавхлант баг |
| **2** | Халанхай Хайрхан | Ханбогд хайрханы зүүн бэл дэхь цувраа улаан толгой. Догшин, хөндөж, нутаглаж болдоггүй газар хэмээн цээрлэдэг. | Мөнх-Овоо овогтой Долгорын Цэндоо, 69 настай. | Оорцог нэртэй бууцтай, Халив нэрт усаар нутагладаг. |
| **3** | Бага Булагийн амны бүрд | Бага Булагт олон хүүхэдтэй нэгэн айл нутаглаж байгаад хүүхдүүд нь хөлддөггүй усны хүний нүд шиг нүх рүү чулуу шидсэнд эмэгтэй хүн орилох шиг болсон. Түүнээс хойш тэр айлд гай зовлон иржээ. Энэ нь лусын нүдийг сохлосон хэрэг болсон тул догширч айл нутаглахаа больсон байна. | Мөнх-Овоо овогтой Долгорын Цэндоо, 69 настай. | Оорцог нэртэй бууцтай, Халив нэрт усаар нутагладаг. |
| **4** | Тойн Цохионы хөндий, Мааньтын хошуу морь уядаг газар | Ханбогд хайрханыг тахиж наадам хийхдээ Тойн цохионы хөндийгөөс морь тавьж уралдуулан Мааньтын хошуунд барьдаг байна. Мөн морь уралдуулдаг энэ газрыг Алтангэрэлийн дугуй гэж нэрлэдэг байна. Мөн Гурван сайхан овоог тахиж наадам хийн энд морь уралдуулдаг байна. | Батын Намсрайжав, 47, Тайжууд овогтой | Тойн цохионы бууц, ус |
| **5** | Вандан толгой | Хөндөж, явж малаа бэлчээж болдоггүй догшин газар хэмээн үздэг байсан. Гэтэл Оюу-Толгой төслийн лицен- | Цэрэндоржийн Хандсүрэнгийн эхнэр | Хайрцагт аман усны бууц |

| | **Тахилга, цээртэй газрын нэр байршил, координат** | **Тахилга, догшин, цээртэй газрын төрөл, холбогдох зан үйл, хорио цээр** | **Тахиж шүтдэг хүмүүс, овог, нэр, ургийн нэр, нас** | **Харьяалал, баг, бууц, усны нэр** |
|---|---|---|---|---|
| | | зийн талбайд орсноор тэнд ажиллаж байсан харуул гал-зуурсан гэж хүмүүс ярьдаг байна. | Батын Охиндуу, Тайжууд овгийн хүн | |
| **6** | Оюут Толгой  | Балчин унзад хэмээх хүн Оюут овооноос оюу авч хөөрөг хийж байсан, оюу гардаг байна. | Хороот бууцны Дамбаадоржийн Мөнхбаяр, Эхийн Хөөвөр бууцны Сайхан-Гомбын Цэдэнгомбо, Дамбаадоржийн Эрдэнэжаргал нар шүтдэг. | Хороот бууц, ус<br><br>Эхийн Хөөвөр бууц, ус |
| **7** | Хүрэн тээг,Цанхи  | Дээр үед хүн тавьдаг байсан газар. Хүрэн тээг нь туулай хэлбэртэй, хажуу дахь цанхи нь Сар шувуу хэлбэртэй. Сар хярсан туулай гэж хэлдэг. Хүн тавихдаа туулайны суга, цавинд аваачиж тогтвортой тавьж байгаа юм гэж ярьдаг. Ер нь урьд үед хүнийг тавихдаа аль болох баялаг газар тавьдаг ба энэ нь үр хойчид нь тустай хэмээн үздэг байна.<br>Цанхид сүүлийн үед 10-аад хүн тавьсан (Д. Намсрай) | Дамбаадоржийн Мөнхбаяр, эхнэр Батын Оюунэрдэнэ | Хороот бууц, Бор хошууны бууцанд байсан бөгөөд газарт орж энд 5 жилийн өмнө ирсэн. |
| **8** | Өлийн зам | Мөнхбаярын бууцны хойно байрладаг гүйдэлтэй газар гэдэг. | Дамбаадоржийн Мөнхбаяр, эхнэр Батын Оюунэрдэнэ | Хороот бууц, ус |
| **9** | Хөл Хайрхан | Ханбогд хайрханы зүүн урд хөл хэмээн гэгээнтэн хэлсэн гэж тахиж шүтдэг. | Эхийн Хөөвөр бууцны Сайхан-Гомбын Цэдэнгомбо, Дамбаадоржийн | Эхийн Хөөвөр бууц, ус |

| | Тахилга, цээртэй газрын нэр байршил, координат | Тахилга, догшин, цээртэй газрын төрөл, холбогдох зан үйл, хорио цээр | Тахиж шүтдэг хүмүүс, овог, нэр, ургийн нэр, нас | Харьялал, баг, бууц, усны нэр |
|---|---|---|---|---|
| |  | | Эрдэнэжаргал нар тахиж шүтдэг | |
| **10** | Ухаа Овоо  | Ухаа овоо бол эзэнтэй, юмтай, хоосонгүй. Цаг муудсан үед тахихад бороо ороод сайхан болдог. Геологич Д. Гарамжав байнга ирж эргэж байдаг. | Эхийн Хөөвөр бууцны Сайхан-Гомбын Цэдэнгомбо, Дамбаадоржийн Эрдэнэжаргал нар тахиж шүтдэг | Эхийн Хөөвөр бууц, ус |
| **11** | Ноён хар овоо  | Ноён хүний булш байж магадгүй, тийнхүү Ноён овоо хэмээн нэрлэсэн байх хэмээн Цэдэнгомбо үздэг. Мөн Ноён хар овоо, Бүдүүн овоо хоёр нь холбоотой байж магадгүй. Учир нь Бүдүүн овооноос Ноён хар овоо хүртэл гараар босгосон цувраа босоо чулуунууд байдаг | Эхийн Хөөвөр бууцны Сайхан-Гомбын Цэдэнгомбо, Дамбаадоржийн Эрдэнэжаргал нар тахиж шүтдэг | Эхийн Хөөвөр бууц, ус |
| **12** | Бүдүүн овоо  | Ноён овооны урд талд байрладаг. Бурханы шашны үеийн юм байх, Нэг бүдүүн лам байсан байх гэж боддог Бүдүүн овооноос Ноён хар овоо хүртэл хүний гараар босгосон байж болох цувраа босоо чулуу байдаг. | Эхийн Хөөвөр бууцны Сайхан-Гомбын Цэдэнгомбо, Дамбаадоржийн Эрдэнэжаргал нар тахиж шүтдэг. | Эхийн Хөөвөр бууц, ус |
| **13** | Дөрвөлжин овоо | Эхийн Хөөвөр бууцныхан шүтдэг. Энэ овооны хажуугаар тэмээ унасан хүн явбал тэмээ дагаад яваад байдаг гүйдэлтэй газар хэмээн үздэг. | Эхийн Хөөвөр бууцны Сайхан-Гомбын Цэдэнгомбо, | Эхийн Хөөвөр бууц, ус |

| | Тахилга, цээртэй газрын нэр байршил, координат | Тахилга, догшин, цээртэй газрын төрөл, холбогдох зан үйл, хорио цээр | Тахиж шүтдэг хүмүүс, овог, нэр, ургийн нэр, нас | Харьяалал, баг, бууц, усны нэр |
|---|---|---|---|---|
| |  | | Дамбаадоржийн Эрдэнэжаргал нар тахиж шүтдэг | |
| **14** | Хөх овоо  | 3 Дуулга ууланд байдаг догшин цээртэй газар. Энэ бууцныхан тийш харж бие засахыг цээрлэдэг. | Эхийн Хөөвөр бууцны Сайхан-Гомбын Цэдэнгомбо, Дамбаадоржийн Эрдэнэжаргал нар тахиж шүтдэг | Эхийн Хөөвөр бууц, ус |
| **15** | Чавгын агуй | Чавга гэдэг лам энэ агуйд нямба хийж байснаас ийнхүү нэрлэгдэх болсон бөгөөд хожим нэгэн төвд лам ирж нямба хийх гэсэн боловч 3 хоноод буцсан гэдэг. Хожим Садага Балжир хэмээх энэ нутгийн сайн анчин энд ан хийдэг байснаас Балжир хэмээх нэр нь сунжирч Баяжихын агуй болсон байж магадгүй хэмээн үздэг. | Эхийн Хөөвөр бууцны Сайхан-Гомбын Цэдэнгомбо, Дамбаадоржийн Эрдэнэжаргал нар тахиж шүтдэг | Эхийн Хөөвөр бууц, ус |
| **16** | Хороот Хайрхан | Гашуун Сухайтын бууцны Пүрэвийн Цэвэгдоржийн гэр бүл, хотныхонд тахьдаг. Шинийн нэгэнд гарч мал сүргээ даатган залбирч мөргөдөг. | Пүрэв овогтой Цэвэгдорж, эхнэр Цэрмаа, охин Мөнгөнцоож, хүү Түвшинтөгс нар тахиж шүтдэг. | Гашуун Сухай бууц |
| **17** | Цагаан овоо  | Догшин хайрхан, хөндөж болдоггүй. Гэвч Оюу-Толгой төслийнхөн хөндөж ухсан ба эргэн нөхөн сэргээлт хийсэн байна. | Пүрэв овогтой Цэвэгдорж, эхнэр Цэрмаа, охин Мөнгөнцоож, хүү Түвшинтөгс нар тахиж шүтдэг. | Гашуун Сух ай бууц |
| **18** | Мэлхий цохио | Догшин газар, мөн цохионы ар талд Цохиот ам хэмээх газар урьд нь хүн тавьдаг байжээ. 2 залуу гэр бүлийн | Пүрэв овогтой Цэвэгдорж, эхнэр Цэрмаа, | Гашуун Сухай бууц |

| | Тахилга, цээртэй газрын нэр байршил, координат | Тахилга, догшин, цээртэй газрын төрөл, холбогдох зан үйл, хорио цээр | Тахиж шүтдэг хүмүүс, овог, нэр, ургийн нэр, нас | Харьяалал, баг, бууц, усны нэр |
|---|---|---|---|---|
| |  | хоёр чулуу авч хөндсөнд хоттой хонь чоно орж өөрсдийнх нь 30 гаруй хонийг сүйтгэсэн гэж Цэвэгдоржийн эхнэр Цэрмаа ярив. | охин Мөнгөнцоож, хүү Түвшинтөгс нар тахиж шүтдэг. | |
| **19** | Энгэр баг мод | Догшин газар. Малчин Лэнтэн энэ нутагт бууж хэсэг амьдрах үед эхнэр нь маш хүнд өвчин туссан. | Малчин Лэнтэн болон түүний хамаатан садан | Энгэр багийн нутагт орших өвөлжөө |
| **20** | Оюу-Толгой | Хөндөж, явж малаа бэлчээж болдоггүй догшин газар хэмээн үздэг байсан. Гэтэл Оюу-Толгой төслийн лицензийн талбайд орсноор тэнд ажиллаж байсан харуул галзуурсан гэж хүмүүс ярьдаг байна. | Мөнх-Овоо овогтой Долгорын Цэндоо, 69 настай. | Оорцог нэртэй бууцтай, Халив нэрт усаар нутагладаг. |
| **21** | Гурван сайхан | 3 эрэгтэй хүн, эмэгтэй хүн гарч болдоггүй. Ханбогд уулын савдагийн нөхөр хэмээн тахьж шүтдэг. | Цэрэндоржийн Хандсүрэнгийн эхнэр Батын Охиндүү, Тайжууд овгийн хүн | Хайрцагт аман усны бууц |
| **22** | Хөх хадны овоо | Хөх хадны бууцны Долгорсүрэнгийн Дэмбэрэл, Салаа бууцны Намсрай нарын гэр бүлийнхэн шүтдэг, цагаан сарын шинийн 1-нд гарч тэнгэр, ууландаа өргөл өргөдөг. | Зэлмэ овгийн Долгорсүрэнгийн Намсрай, Дэмбэрэл нарын гэр бүлийнхэн | Хөх хадны бууц, Салаа бууц |
| **23** | Хөөрхөн овоо | Догшин овоо, эмэгтэй хүн гарч болдоггүй, мод чулууг нь хөнддөггүй нэрийг нь хэлэхээс цээрлэж Хөөрхөн хэмээдэг. | Зэлмэ овгийн Долгорсүрэнгийн Намсрай, Дэмбэрэл нарын гэр бүлийнхэн | Хөх хадны бууц, Салаа бууц |
| **24** | Улаан толгой дахь төрсөн буурь | Ухаж сэндийлбэл таагүй, сэтгэлд санаанд сэвтэй төрсөн өдрөөрөө очиж хөрвөөдөг. | Зэлмэ овгийн Долгорсүрэнгийн Намсрай | Салаа бууц |
| **25** | Угалзын бууцны овоо | Угалзын бууцны Өөлийн Сэр-Одын хотны 2 овоотой, шинийн 1-нд өргөл өргөж шүтдэг. | Угалзын бууцны Өөлийн Сэр-Одын гэр бүлийнхэн | Угалзын бууц |

| | Тахилга, цээртэй газрын нэр байршил, координат | Тахилга, догшин, цээртэй газрын төрөл, холбогдох зан үйл, хорио цээр | Тахиж шүтдэг хүмүүс, овог, нэр, ургийн нэр, нас | Харьяалал, баг, бууц, усны нэр |
|---|---|---|---|---|
| |  | | тахиж шүтдэг. | |
| **26** | Угалзын бууц  | Аргалын хэвтэр байсан газар бөгөөд өвөлд маш өнтэй, сайхан бууц. | Угалзын бууцны Өөлийн Сэр-Одын гэр бүлийнхэн тахиж шүтдэг. | Угалзын бууц |
| **27** | Баян Бараат Хайрхан | Энэ хавийн хамгийн өндөр уул бөгөөд шүтэж дээдлэн байнга идээ цагааныхаа дээжийг өргөдөг. | Угалзын бууцны Өөлийн Сэр-Од, Эхэн Бурханы бууцны Цэдэнжавын Банди гэр бүлийнхэн тахиж шүтдэг. | Угалзын бууц, |
| **28** | Улаан толгойн энгэр | Угалзын бууцийн Өөлийн Сэр-Одын эхнэр Сүнжидмаагийн нагац ах Хорол овогтой Батсүгирын хүй дарсан чулуу байдаг. | Өөлийн Сэр-Одын гэр бүлийн Угалз өвөлжөө | Угалзын бууц, |
| **29** | Эхэн Бурхантын бууцны ойролцоох булш | Археологичид судалсан ба хүн олдсон.Зарим нэг булшнаас нь юм гараагүй гэж хэлсэн гэвч юмгүй байх боломж байхгүй. | Угалзын бууцны Өөлийн Сэр-Од, Эхэн Бурханы бууцны Цэдэнжавын Банди гэр бүлийнхэн тахиж шүтдэг. | Угалзын бууц, |
| **30** | Цагаан дэл  | Цагаан дэл уул нь Эхэн Бурхантын бууцнаас 1 км-т байрлах бөгөөд энэ бууцныхан түүнийг аварга могойн бие хэмээдэг. Энэхүү аварга могойн сүүл нь Эхэн Бурхантын бууцын зүүн талд 200 м-т орших хадтай уулын хонгио нүх рүү ордог хэмээн үздэг байна. Энэхүү Цагаан дэлийг догшин хэмээн үзэж хөндөхийг цээрлэдэг. | Эхэн Бурханы бууцны Цэдэнжавын Банди гэр бүлийнхэн тахиж шүтдэг. | Эхэн бурхантын бууц |

**Хүснэгт 14 Оюун толгойн зам, онгоцны буудал, цахилгаан станц, усны хоолойн дагуух тахилгат газар нутаг**

| Газрууд | Үнэлгээ-ний шалгуур | Үнэлгээ | | | | | Дүн шинжилгээ | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Байршил болон эрсдэл | Газрын нэр, ангилал | Тухайн байршилд хамааралтай хүмүүс | Холбогдох зан үйл, ёс-лолын ажил-лагааны давтамж | Оршин байсан хугацаа | Дагалдах соёлын хэлбэрүүд | Шинжилгээ хийх | Соёлын үнэ цэнэ |
| **Оюу Толгой-Гашуун Сухайтын зам** | | | | | | | | |
| 1 | Дунд зэргийн эрсдэл<br>Зүүн тийш 5 км | Соёлын дурс-галт газар Морин уралдаа-ны газар – Мааньт, тойн цохиогийн хөндий | Ханбогд сумын иргэд | Жил тутам | Хувьсгалын өмнө | Түүх, домог | Соёлын үнэ цэнэ-сумын морь уралддаг үндсэн гол газруудын нэг | Их |
| 2 | Их эрсдэл<br>Хороо өвөлжөөний баруун хойод зүгт 2км | Хорио цээртэй газар - эртний оршуулгын га-зар, сүүлийн жилүүдэд сэр-гээгдсэн Хүрэн тээг, Цанхи | Мөнхбаяр, Дамбаадоржийн өвөлжөө гэх мэт хэд хэдэн айл, Бор хушуут | Чулуу авч хөндөхийг цээрлэдэг газар | Хувьсгалын өмнө | Хэрхэн оршуулгын газар болсон түүх | Нэлээд хүмүүс мэддэг, хорио тавьдаг | Дунд |
| 3 | Дунд зэргийн эрсдэл<br>Зүүн зүгт 5 км | Тахилгат уул – Хул Хайрхан | Цэдэнгомбо, Сай-хангомбо, Эрдэнэ-жаргал, Дамба-доржийн эхийн хөөвөр өвөлжөөг багтаасан энэ газ-рын ойролцоо та-ваас илүү айлууд | Айл өрхөд тулгуурлаж жил бүр, ёс заншилд тулгуурлан улирлын чанартай | Хувьсгалын өмнө | Данзанравжаа тахиж байсан түүхтэй | Алдартай бүтээлүүдээрэ э дэмжигдсэн Ханбогд тахилгат уулын иргэдийн нэг | Их |
| 4 | Дунд зэргийн эрсдэл<br>Зүүн зүгт 5 км | Ухаа толгой тахилгат толгой | Цэдэнгомбо, Сай-хангомбо, Эрдэнэ-жаргал, Дамба-доржийн эхийн хөөвөр өвөлжөө-1 айл өрх | Айл өрхөд тул-гуурлаж жил бүр, ёс зан-шилд тулгуур-лан улирлын чанартай | Тодорхойгүй | Баримтжуулаагүй | Цэдэнгомбо хөгшин ээнтэй гэж итгэдэг. Геологич Га-рамжав ирдэг. | Дунд |
| 5 | Дунд зэргийн | Дөрвөлжин | Тэр газраар | Зарим сөрөг | Хувьсгалын | Тодорхойгүй | Тахилгат | Дунд |

| Газрууд | Үнэлгээ-ний шалгуур | Үнэлгээ | | | | | Дүн шинжилгээ | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Байршил болон эрсдэл | Газрын нэр, ангилал | Тухайн байршилд хамааралтай хүмүүс | Холбогдох зан үйл, ёс-лолын ажил-лагааны давтамж | Оршин байсан хугацаа | Дагалдах соёлын хэлбэрүүд | Шинжилгээ хийх | Соёлын үнэ цэнэ |
| | эрсдэл Өмнөговийн ГС замаас 7 км хол | овоо тахилгат толгой | нутгаладаг айл өрх | хүчин зүйлтэй Табуу | өмнө | | уулсын нэг | |
| 6 | Дунд зэргийн эрсдэл Зүүн зүгт 6 км | Хан богд хайр-ханы түүхийн тахилгат агуй | Ханбогд сумын иргэд Монгол даяар алдартай болсон | Ёс заншлын бус | Хувьсгалын өмнө | Түүх олонтой | Түүхийн тахил-гат газар нь аялал жуулч-лалын газар болсон | Дунд |
| 7 | Оюу Толгойн баруун зүгт 500 м | Ах дүүсээрээ тахьдаг Цагаан овоо тахилгат толгой | Гашуун сухайт өвөлжөө | Заншлын дагуу жил бүр айл өрх | Өвөлжөөнд өвөлжсөнөөс хойш | Тодорхойгүй | Гэр бүлээрээ тахьдаг уламжлалт тахилгат овоо Оюу Толгойн төслөөс гарсан | Дунд |
| 8 | Эрсдэл ихтэй<br><br>Баруун тийш 1 км | Ах дүүсээрээ тахьдаг Хөх хадны овоо | Дэмбэрэл, Дол-горсүрэн нарын ах дүүсээрээ тахь-даг тахилгат овоо, Хөх хад өвөлжөө, Салаа өвөлжөөний Намсрай тэдний гэр бүл | Ах дүүсээрээ заншлын дагуу жил бүр | Ах дүүсээрээ байрласнаас хойш | Тодорхойгүй | Газар нутгийн байрлал, тахилгат овоонд суурилсан | Дунд |
| 9 | Эрсдэл ихтэй<br><br>Баруун зүгт 1 км | Дөрвөлж Хайрхан тахилгат уул | Уулзвар, Бударга-на, Булан, Дэрс, Шавагийн өвөл-жөө гэх мэт газар нутгийн ах дүү-сээрээ 5 гэр бүл | Заншил ёсоор цагаан сараар ах дүүс, гэр бүлээрээ, нут-гаараа сүсэг-лэж тахьдаг | Тахилгат ууланд ах дүүс нутаг усаараа гэр бүлээрээ нутгаласнаас хойш | | Тахилгат уул тэднийг ивээдэг гэж өвөлжөөний айлууд сүсэглэн тахьдаг | Их |
| 10 | Эрсдэл их | Үнэгэд Хайрхан | Уулзвар, Бударга- | Ёс заншлын | Одоогоос өмнө | Овоог сэвтээсэн ху- | Гүн сүсэглэдэг | Их |

| Газрууд | Үнэлгээ-ний шалгуур | Үнэлгээ | | | | | Дүн шинжилгээ | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Байршил болон эрсдэл | Газрын нэр, ангилал | Тухайн байршилд хамааралтай хүмүүс | Холбогдох зан үйл, ёс-лолын ажил-лагааны давтамж | Оршин байсан хугацаа | Дагалдах соёлын хэлбэрүүд | Шинжилгээ хийх | Соёлын үнэ цэнэ |
| | Аймаг чиглэ-сэн баруун зам дайрч өнгөрдөг | тахилгат уул | на, Булан дэрс, Шавaг өвөлжөө-ний иргэд ах дүүс нутгаараа | бус боловч хурц догшин гэж гүн сүсэг-лэн тахьдаг | | мүүст сөргөөр нө-лөөлсөн олон түүх-тэй | | |
| 11 | Дунд зэргийн эрсдэл | Улаан дэлийн нуруу тахилгат газар | Уулзвар, Бударга-на, Булан дэрс, Шавaг өвөлжөө-ний иргэд ах дүүс нутгаараа | Ёс заншлын бус боловч хурц догшин гэж гүн сүсэг-лэн тахьдаг | Одоогоос өмнө | Овоог сэвтээсэн хү-мүүст сөргөөр нө-лөөлсөн олон түүх-тэй | Өвөлжөөний 5 айл гүн сүсэглэдэг | Дунд |
| 12 | Эрсдэл ихтэй<br><br>Оюу Толгойн замаас зүүн зүгт 1 км | Уулзвар голын тахилгат ус (ойролцоо газ-рын усны гол эх үүсвэрийн нэг) | Чулуунбаатар Хүүдэг удайд овогтой түүний гэр бүл болон нутгийнхан | Энэ нь энэ газрын усны гол эх үүсвэр учраас тодор-хой цээрийг баримтлан хүмүүс тахьдаг | Одоогоос өмнө | Хориог зөрчсөн хүмүүст тохиолдсон эмгэнэлт түүхтэй | Оюу Толгойн замаас 1 км зайд Уулзвар гол, голын эх байрладаг ба энэ нутгийн хүмүүсийн усны эх ундарга | Эрсдэл ихтэй |
| 13 | Эрсдэл ихтэй<br><br>Оюу Толгойн замаас зүүн тийш 1 км | Цахилдагтай гол ба усны эхлэл,тахилгат ус | Хүүдэг удайд овогтой Чулуун-баатар түүний гэр бүл болон нут-гийнхан | Энэ нь энэ газрын усны гол эх үүсвэр учраас тодор-хой цээрийг баримтлан хүмүүс тахьдаг | Одоогоос өмнө | Хориог зөрчсөн хү-мүүст тохиолдсон эмгэнэлт түүхтэй | Оюу Толгойн замаас 1 км зайд Уулзвар гол, голын эх байрладаг ба нутгийн хүмүү-сийн усны эх ундарга | Эрсдэл ихтэй |
| 14 | Дунд зэргийн эрсдэл<br>Оюу Толгойн замаас зүүн зүгт 7-8 км | Тахилгат устай газар<br><br>Улаан булаг | Ногоонууд овог-той Алтангарьд, Дашдолгор ба ойролцоох айл өрхүүд, хөршүүд | Ёс заншил байхгүй ч хо-рио цээр ихтэй | Одоогоос өмнө | Хэрхэн тахигдсан тухай сайхан түүхтэй | Тахилгат газ-рын нэг гэдэг нь малчид, до-мог түүхээс ойлгогддог | Эрсдэл ихтэй |
| 15 | Энгэр баг мод | Цагаан Хайрхан | Алтангарьд, | Ёс заншил | Одоогоос өмнө | Нэгэн түүхтэй | Хүчтэй | Эрсдэл ихтэй |

| Газрууд | Үнэлгээ-ний шалгуур | Үнэлгээ | | | | | Дүн шинжилгээ | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Байршил болон эрсдэл | Газрын нэр, ангилал | Тухайн байршилд хамааралтай хүмүүс | Холбогдох зан үйл, ёс-лолын ажил-лагааны давтамж | Оршин байсан хугацаа | Дагалдах соёлын хэлбэрүүд | Шинжилгээ хийх | Соёлын үнэ цэнэ |
| | өвөлжөөнөөс зүүн зүгт 3 км | тахилгат уул | Болдмаа, Энгэр баг мод өвөлжөөний айлууд тахьдаг | байхгүй ч хорио цээртэй | | | тахилгат догшин газрын нэг | |
| 16 | Цагаан хад - Оюу Толгойн замд | Цагаан Хад та-хилгат газар | Их цагаан Хад өвөлжөө, Цогнэ-мэх хүү болон энэ газрын бусад ай-лууд тахьдаг | Ёс заншил байхгүй ч хорио цээртэй | Одоогоос өмнө | Нэгэн түүхтэй | Хүчтэй тахилгат догшин газрын нэг | Эрсдэл ихтэй |
| 17 | Дунд зэргийн эрсдэлтэй Оюу Толгойн замаас зүүн зүгт 20 км | Номгон Хайрхан уламжлалт тахилгат уул | Номгон баг Хан-богд сумын иргэд | Жил бүр ёс заншлын дагуу тахьдаг наа-дамтай | Одоогоос өмнө | Энэ уулын ноёны тухай олон түүхтэй | Ханбогд сумын тахилгат газрын нэг | Эрсдэл ихтэй |
| 18 | Эрсдэл ихтэй<br><br>Оюу Толгойн замаас зүүн зүгт 500м | Баруун Тогоо Хайрхан тахил-гат уул | Зүүн заг өвөлжөө-ний Хөх Хиа овогтой Отгондуу, Лантуу нар ах дүүс нутгаараа | Ёс заншил байхгүй ч өглөө бүр хү-мүүс дээж өр-гөдөг | Одоогоос өмнө | | Цагаан Хадны тахилгат газ-рын нэг. Зам-тай их ойр байрладаг | Эрсдэл ихтэй |
| 19 | Эрсдэл ихтэй<br><br>Оюу Толгойн замаас баруун зүгт 500 м | Зүүн Тогоо Хайрхан тахилгат уул | Зүүн заг өвөлжөө-ний Хөх Хиа овогтой Отгондуу, Лантуу нар ах дүүс нутгаараа | Ёс заншил байхгүй ч өглөө бүр хү-мүүс дээж өр-гөдөг | Одоогоос өмнө | | Цагаан Хадны тахилгат газ-рын нэг. Зам-тай их ойр байрладаг | Эрсдэл ихтэй |
| 20 | Эрсдэл ихтэй<br><br>Оюу Толгойн замаас баруун зүгт 400 м | Дарвагай тахилгат гол | Зүүн заг өвөлжөө-ний Хөх Хиа овогтой Отгондуу, Лантуу нар ах дүүс нутгаараа | Ёс заншил байхгүй ч өглөө бүр хү-мүүс дээж өр-гөдөг | Одоогоос өмнө | | Манайх болон хөршүүдийн ус-ны гол их ун-дарга учраас бидний хувьд нэн чухал газар гэж Отгондуу | Эрсдэл ихтэй |

| Газрууд | Үнэлгээ-ний шалгуур | Үнэлгээ | | | | | Дүн шинжилгээ | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Байршил болон эрсдэл | Газрын нэр, ангилал | Тухайн байршилд хамааралтай хүмүүс | Холбогдох зан үйл, ёс-лолын ажил-лагааны давтамж | Оршин байсан хугацаа | Дагалдах соёлын хэлбэрүүд | Шинжилгээ хийх | Соёлын үнэ цэнэ |
| | | | | | | | хэлсэн | |
| **Цахилгааны шонгууд** | | | | | | | | |
| 21 | Дунд зэргийн эрсдэлтэй Цахилгаан станцын баруун зүгт 10 км | Хөөрхөн овоо тахилгат овоо | Зэлмэ овогтой Намсрай, Долгор-сүрэн, Дэмбэрэл нарын ах дүү нар | Тогтсон ёс заншил биш ч эмэгтэй хүн оройд нь га-рах, нэрээр нь дуудах хорио-той | Хувьсгалаас өмнө | Тодорхойгүй | Энэ газрын тахилгат овоо бөгөөд хүмүүс үүнд их ач холбогдол өгдөг | Эрсдэл ихтэй |
| 22 | Дунд зэргийн эрсдэл Цахилгаан станцаас баруун зүгт 4км | Угалз өвөлжөөнд ах дүүсээрээ удаан тахигдсан овоо | Өөлий овогтой Сэр-Одын угалз өвөлжөө | Заншлын да-гуу цагаан са-раар гэр бү-лээрээ | Өдөр нь тодор-хойгүй ч Сэр-Од манай өвөг дээдсээс өвлөгдөж ир-сэн гэдэг | Яагаад хамгийн сайн өвөлжөө болсон тухай түүхтэй | Тэдгээр нь тогтвортой, то-хилог, өвлөг-дөж ирсэн өвөлжөө, овоо-нууд байсан | Эрсдэл ихтэй |
| 23 | Дунд зэргийн эрсдэлтэй Утасны модноос баруун зүгт 10 км | Баян Бараат тахилгат уул | Угалз өвөлжөө-ний Өөлий овог-той Сэр-Од, тэд-ний гэр бүл, Эхэн бурхант өвөлжөө-ний Банди, Цэ-рэнжав нарын ах дүүс | Тогтсон зан-шил байхгүй ч өглөө бүр хү-мүүс дээж өр-гөдөг | Энэ газрын дор хаяж 2 дахь удмын хүмүүс | Түүх домог байхгүй | Эхэн Бурхант газрын гол тахигдсан уул | Эрсдэл ихтэй |
| 24 | Эрсдэл ихтэй<br><br>Утасны модноос зүүн тийш 3 км | Цагаан Дэл уулын бэл тахилгат газар | Энэ газрын айл-ууд нь Өөлий овогтой Сэр-Од, Угалз өвөлжөө-нийхөн, Эхэн Бур-хант өвөлжөөний Цэдэнжав, тэдний | Энэ газрын ой-ролцоо чанга дуу чимээ гар-гаж болохгүй, мод чулуунд хүрч болохгүй хатуу цээртэй | Хувьсгалаас өмнө | Сайхан домог түүх-тэй | Энэ газар нь дурсгалт газар бөгөөд энэ нутгийн хүмүүс гүн сүсэглэдэг | Эрсдэл ихтэй |

| Газрууд | Үнэлгээ-ний шалгуур | Үнэлгээ | | | | | Дүн шинжилгээ | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Байршил болон эрсдэл | Газрын нэр, ангилал | Тухайн байршилд хамааралтай хүмүүс | Холбогдох зан үйл, ёс-лолын ажил-лагааны давтамж | Оршин байсан хугацаа | Дагалдах соёлын хэлбэрүүд | Шинжилгээ хийх | Соёлын үнэ цэнэ |
| | | | гэр бүл | | | | | |
| 25 | Дунд зэргийн эрсдэлтэй Цахилгаан станцаас баруун зүгт 9 км | Хүрэн овоо тахилгат уул | Энэ газрынхан нь (Жавхлант багийн төв) Ганц мод өвөлжөөний Но-гоонууд овогтой Ганболд, Хольхүү, | Ёс заншил байхгүй ч то-дорхой хорио цээртэй | Хугацаа нь тодорхой бус | | Энэ газрын дурдагдсан хэсэг гэр бүлүүдээр их хүндлэгдсэн | Эрсдэл ихтэй |
| 26 | Цахилгаан станцын баруун зүгт 9 км | Таван Овоо тахилгат уул | Энэ газрынхан нь (Жавхлант багийн төв) Ганц мод өвөлжөөний Но-гоонууд овогтой Ганболд, Хольхүү, | Ёс заншил байхгүй ч то-дорхой хорио цээртэй | Хугацаа тодорхойгүй | | Жавхлант багийн төвийн иргэд тахьдаг | Эрсдэл ихтэй |
| 27 | Утасны шонгоос баруун зүгт 3 км | Шага овоо тахилгат толгой | Энэ газрынхан нь (Жавхлант багийн төв) Ганц мод өвөлжөөний Но-гоонууд овогтой Ганболд, Хольхүү, | Ёс заншил байхгүй ч то-дорхой хорио цээртэй | | | 2 гэр бүл хүндлэн тахьдаг | Эрсдэл ихтэй |
| 28 | Дунд зэргийн эрсдэлтэй Оюу Толгой талдаа баруун зүгт 10 км | Задгайт Улаан Толгой тахилгат газар | Жавхлант багийн Тамсаг Улаан Толгой өвөлжөө-ний Идэрборгил, Цэдэнбалжир нар | Ёс заншилгүй, хорио цээртэй | | Уснаас ирсэн гөрөөс, тахины сайхан түүхтэй | Хайрлаж хүндлэгдсэн газар | Эрсдэл ихтэй |
| 29 | Эрсдэл ихтэй<br><br>Оюу Толгой талдаа зүүн зүгт 5 км | Ханан Даваагийн Нууц газар овоо түүхийн өвлөгдөн газр | Энэ газрыг мэдэх Ханан Даваа өвөлжөөний хүмүүс | | XX зууны эхэнд | Сайхан түүхтэй | Өнгөрсөн түүхийг агуулсан түүхийн дурсгалт газар | Эрсдэл ихтэй |
| 30 | Эрсдэл ихтэй<br><br>Оюу Толгой | Улаан нууц газар түүхийн, өвлөгдсөн газар | Жавхлант багийн Уст баг модны Хаван овогтой | | XX зууны эхэнд | Холбогдох түүхүүд бий | | Эрсдэл ихтэй |

| Газрууд | Үнэлгээ-ний шалгуур | Үнэлгээ | | | | | Дүн шинжилгээ | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Байршил болон эрсдэл | Газрын нэр, ангилал | Тухайн байршилд хамааралтай хүмүүс | Холбогдох зан үйл, ёс-лолын ажил-лагааны давтамж | Оршин байсан хугацаа | Дагалдах соёлын хэлбэрүүд | Шинжилгээ хийх | Соёлын үнэ цэнэ |
| | талдаа зүүн хойш 1 км | | Шаваг өвөлжөө-ний Цэрэнхүү, Цагаан | | | | | |
| 31 | Эрсдэл ихтэй<br><br>Оюу Толгой талдаа баруун хойш 1.5 км | Цагаан нууц газар түүхт өвлөгдсөн газар | Жавхлант багийн Уст баг модны Хаван овогтой Шаваг өвөлжөөний Цэрэнхүү, Цагаан | | XX зууны эхэнд | Холбогдох түүхүүд бий | Нутгийн түүхийн мэдлэг олгох хамгаалалттай нууц газар | Эрсдэл ихтэй |
| **Өвлөгдсөн тахигдсан газруудын ойролцоох шинэ онгоцны буудал ба усны хоолой** | | | | | | | | |
| 32 | Эрсдэл ихтэй<br><br>Хийн хоолойн урд зүгт 6 км | Хүнхэр догшин тахилгат газар | Ухаа Заг Дунд өвөлжөө, Баян багийн иргэд сүсэглэдэг догшин тахилгат газар | Ёс заншилгүй ч хорио цээртэй | | | Нутгийн иргэд тахьдаг догшин тахилгат газар | Эрсдэл ихтэй |
| 33 | Дунд зэргийн эрсдэлтэй<br><br>Хийн хоолойн зүүн урд 12 км | Өвгөн овоо тахилгат овоо | Багийн иргэд | Ёс заншил байхгүй ч багийн иргэдээр гүн бишрэгдсэн | Одоогоос өмнө | Хэрхэн догширсон түүхтэй | Энэ газрын гол тахилгат овоонуудын нэг | Эрсдэл ихтэй |
| 34 | 0 | Хүрэн овоо тахилгат овоо | Үрэлбэ өвөлжөө-ний Мижиддорж, Аюур нарын гэр бүл шүтдэг | Гэр бүлийн ёслол жил бүр | Уламжлагдсан боловч саяхан шинэчлэгдсэн | | Гэр бүлээр шүтдэг Овоо | Дунд зэргийн эрсдэлтэй |
| 35 | Дунд зэргийн эрсдэл<br><br>Хийн хоолойн хойд зүгт 8 км | Орвог тахигдсан газар | Алаг баян багийн Хүрэн цохионы хоёр мод өвөл-жөөний Банди-маа, Ичинхорлоо, бусад ойролцоо | Тодорхой хорио цээртэй ба хоригдсон ёс заншилтай | Өвөг дээдсээс өвлөгдсөн | | Нутгийн айл өрх, тахин шүтэж онголсон газар | Эрсдэл ихтэй |

| Газрууд | Үнэлгээ-ний шалгуур | Үнэлгээ | | | | | Дүн шинжилгээ | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Байршил болон эрсдэл | Газрын нэр, ангилал | Тухайн байршилд хамааралтай хүмүүс | Холбогдох зан үйл, ёс-лолын ажил-лагааны давтамж | Оршин байсан хугацаа | Дагалдах соёлын хэлбэрүүд | Шинжилгээ хийх | Соёлын үнэ цэнэ |
| | | | өрхүүд | | | | | |
| **Тахигдаж, өвлөгдсөн газруудын ойролцоох шинэ онгоцны буудал ба хийн хоолой** | | | | | | | | |
| 36 | Эрсдэл ихтэй<br><br>Хийн хоолойгоос 3 км | Тахилгат овоо тахигдсан толгой | Энэ овоо нь Дэнэг өвөлжөөний айлуудаар шүтэгдсэн | Тодорхой ёс заншил байх-гүй ч Цагаан сарын үеэр ёслол үйлддэг | Өвөг дээдсээс уламжлагдсан | | Нутгийн айл өрх, тахин шүтэж онголсон газар | Эрсдэл ихтэй |
| 37 | Дунд зэргийн эрсдэлтэй Шинэ онгоц-ны буудлын баруун урд 11 км | Улаан толгой голын тахигдсан газар | Гавилууд багийн Залгайт улаан Толгой өвөлжөө, Мод багийн Ухна буд | Чулуу мод хө-дөлгөж болох-гүй тахигдсан гол. Дээдсээс уламжлагдан ирсэн | Дээдсээс уламжлагдсан | | | Эрсдэл ихтэй |
| 38 | Эрсдэл ихтэй<br><br>Шинэ онгоц-ны буудлын баруун талд 4 км | Дугатын цагаан овоо тахилгат овоо | Гавилууд багийн Хавтгай Улаан өвөлжөөний Но-гоонууд овогтой Э. Сүрэнхорол бо-лон ойролцоох өрхүүд | Гэр бүлээрээ цагаан сараар тахьдаг | Дээдсээс уламжлагдсан | | Гол шүтэгдсэн овоо | Эрсдэл ихтэй |
| 39 | Дунд зэргийн эрсдэлтэй Шинэ онгоц-ны буудлаас урагш 6 км | Цагаан овоо тахилгат овоо | Алаг баян багийн Ухаа Заг өвөл-жөөний Дэндэв, Дамдинсүрэн бо-лон бусад айл өр-хүүд сүсэглэдэг | Ёс заншил байхгүй | XIX зуунаас хойш | Олон янзын түүх байдаг | Олон түүх, уламжлал хадгалсан түүхт ганц газар | Эрсдэл ихтэй |
| 40 | Эрсдэл ихтэй Шинэ онгоц-ны буудлын баруун хойно 5 км | Хойд нууц газар түүхт уламжлалт газар | Энэ нутгийн иргэд | | XX зууны эхэнд | Холбоотой түүх бий | Энэ газрын түүхт газруудын нэг | Эрсдэл ихтэй |
| 41 | Эрсдэл | Таван Толгой | Гавилууд багийн | Заншилд | XX зууны эхэнд | Энэ газрын тухай | Нутгийн | Эрсдэл ихтэй |

| Газрууд | Үнэлгээ-ний шалгуур | Үнэлгээ | | | | | Дүн шинжилгээ | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Байршил болон эрсдэл | Газрын нэр, ангилал | Тухайн байршилд хамааралтай хүмүүс | Холбогдох зан үйл, ёс-лолын ажил-лагааны давтамж | Оршин байсан хугацаа | Дагалдах соёлын хэлбэрүүд | Шинжилгээ хийх | Соёлын үнэ цэнэ |
| | өндөртэй Шинэ онгоц-ны буудлын баруун хойно 800 м | түүхт тахигдсан газар | иргэд | тулгуурлан айл өрхүүд | | олон түүх бий | хүмүүст тахигдсан түүхтэй чухал газруудын нэг | |

**Хүснэгт 15: Оюу Толгой-Гашуун Сухайтын чиглэлийн зам болон Цахилгааны шон дагуух 15 км-ийн доторх уламжлалт ба тахилгат газрууд**

| | Тахилгат болон хориотой газруудын нэр | Төрөл, холбогдох ёс заншил, түүх домог | Шүтдэг ард (нэр, хамаатан садны нэр, нас) | Баг ба өвөлжөө |
|---|---|---|---|---|
| 1 | Ханбогд Хайрхан | Жил бүрийн зуны эхэн сар, Цагаан сарын шинийн нэгэнд тахьдаг заншилтэй. Энэ тахилгат уул руу эмэгтэй хүн гарахыг хориглоно. Бид энд олон хүн уул руу гарахад тааламжтай биш байдаг мөн хятад хүнгарсан гэж сонссон. Битгий тэгээсэй гэж хүсэж байна гэж Жавхлант багийн Тойн Цохио өвөлжөөний малчин Намсрайжав хэлсэн. | Ногоонууд овогтой Ц. Хандсүрэн, Тайжууд овогтой Б. Намсрайжав, Ханбогдын ихэнх иргэд | Жавхлант багийн Хайрцагт Аман Ус өвөлжөө, Тойн Цохио өвөлжөө |
| 2 | Халанхай Хайрхан | Энэ нь Ханбогд Хайрханы зүүн талын бэл дэхь толгойнуудын нэг. Энэ нь тахигдсан газар. Ойролцоо амьдрах, мод чулуунд нь хүрэхийг хориглосон. | Цэндоо, Долгор, Мөнх-Овоо, нас 69 | Оорцог өвөлжөө, Халив ус |
| 3 | Бага булаг уулын баянбүрд | Нэгэн цагт Бага Булагт олон хүүхэдтэй айл амьдардаг байсан. Ус нь хэзээ ч хөлддөггүй ба хүүхдүүд усны цөөрөм рүү шидэхэд эмэгтэй хүн орилжээ. Тэр цагаас хойш тэдний гэр бүлд их зовлон тохиолд-жээ. Энэ нь Лусын нүдийг цохьсон бай-жээ. Мөн тэр цагаас хойш энэ газар харгис догшин газар болж ойролцоо нь айл нутаглахаа больжээ. | Цэндоо, Долгор, Мөнх-Овоо овогтой, нас 69 | Оорцог өвөлжөө, Халив ус |
| 4 | Тойн Цохио хөндий ба Мааньтын Туг морин уралдааны газар | Ханбогдыг тахих ёслолын үеэр Тойн Цо-хионы хөндийд морь уралдуулж, Маань-тын Тугд дуусдаг. Морин уралдааны газ-рыг Алтангэрэлийн тойрог гэж нэрлэдэг. Гурван Сайхны 3 толгойг тахьдаг. | Намсрайжав, Бат Тайжууд овогтой, нас 47 | Өвөлжөө ба Тойн Цохионы ус |
| 5 | Вандан уул | Хүн, мал ойртдоггүй тахилгат газар. Хэ- | Охиндүү Бат Тайжууд | Хайрцагт Аман Ус өвөлжөө |

| | Тахилгат болон хориотой газруудын нэр | Төрөл, холбогдох ёс заншил, түүх домог | Шүтдэг ард (нэр, хамаатан садны нэр, нас) | Баг ба өвөлжөө |
|---|---|---|---|---|
| | | дийгээр Оюу Толгой энэ газрыг ашиглаcан ч түүнээс хойш нэг хамгаалагч галзуурсан гэх мэт олон гамшиг тохиолдож улам ноцтой болж байгаа. | овогтой, Хандсүрэнгийн эхнэр, Цэрэндорж | |
| 6 | Оюут Толгой | Балчин Унзад Оюут Толгойгоос чулуу авч хөөрөг хийсэн түүхтэй. Энэ газар оюу чулуу байдаг. | Хороот өвөлжөөний Мөнхбаяр, Даваадорж, Эхийн хөөвөр өвөлжөөний Даваадорж, Эрдэнэжаргал, Сайхангомбо, Цэдэнгомбо | Хороот, Эхийн хөөвөр өвөлжөө |
| 7 | Хүрэн Тээг ба Цанхи | Хувьсгалын өмнө оршуулгын газар байсан. Хүрэн Тээг туулайн хэлбэртэй, хажуугийн толгой Цанхи сар шувуутай адил харагддаг гэж хүмүүс ярьдаг. Туулай шиг харагддаг ба гар доор нь тавьбал тогтвортой учраас оршуулгын газар болсон. Энэ газрыг тогтвортой, баялаг, үр хойчдоо нөлөөлнө гэж оршуулгын газраар сонгосон гэж Ханбогдын хүмүүс ярьдаг. Сүүлийн үед Цанхид 10аад хүнийг оршуулсан (Д. Намсрай) | Мөнхбаяр, Дамбаадорж, түүний эхнэр Оюун-Эрдэнэ Бат | Бор хошуу, Хороот өвөлжөө |
| 8 | Улын зам | Улын зам нь гүйдэлтэй газар, Мөнхбаярын өвөлжөөний хойно байдаг. | Мөнхбаяр, Дамбаадорж, түүний эхнэр Оюун-Эрдэнэ Бат | Хороот өвөлжөө, ус |
| 9 | Хөл Хайрхан | Энэ уул бол Ханбогд Хайрханы зүүн урд хөл гэж Ноён Хутагт хэлсэн учир шүтэгдсэн. | Эхийн хөөвөр өвөлжөөний Даваадорж, Эрдэнэжаргал, Сайхангомбо, Цэдэнгомбо | Эхийн хөөвөр өвөлжөө, ус |
| 10 | Ухаа уул | Ухаа уул нь өөрийн эзэнтэй, ямар нэг зүйл байдаг. Цаг агаар муудахад бид тахьхад цаг агаар сайжирдаг. Геологич Д. Гарамжав ойролцоо нь байж анхаарал тавьдаг. | | Эхийн хөөвөр өвөлжөө, ус |
| 11 | Ноён Хар Овоо | | Эхийн хөөвөр өвөлжөөний Даваадорж, Эрдэнэжаргал, | Эхийн хөөвөр өвөлжөө, ус |

| | Тахилгат болон хориотой газруудын нэр | Төрөл, холбогдох ёс заншил, түүх домог | Шүтдэг ард (нэр, хамаатан садны нэр, нас) | Баг ба өвөлжөө |
|---|---|---|---|---|
| | | | Сайхангомбо, Цэдэнгомбо | |
| 12 | Будүүн Овоо | Будүүн овоо нь Ноён овооны урд зүгт байрладаг. Монголын Буддын шашинаас үүдэлтэй бүдүүн лам тэнд байрладаг байсан учир Бүдүүн Овоо гэж нэрлэсэн. Уудам Овоо Бүдүүн Овоо 2ын хооронд босгосон чулуун хүрээ бэл байдаг. | Эхийн хөөвөр өвөлжөөний Даваадорж, Эрдэнэжаргал, Сайхангомбо, Цэдэнгомбо | Эхийн хөөвөр өвөлжөө, ус |
| 13 | Дөрвөлжин овоо | Эхийн хөөвөр өвөлжөөний хүмүүсийн гол тахилгат уулсын нэг. Мөн энэ газрын ойролцоо тэмээ унавал тэмээ дагадаг болдог гүйдэлтэй газар. | Эхийн хөөвөр өвөлжөөний Даваадорж, Эрдэнэжаргал, Сайхангомбо, Цэдэнгомбо | Эхийн хөөвөр өвөлжөө, ус |
| 14 | Хөх овоо | 3 Дуулга ууланд байрладаг газар. Эхийн хөөвөр өвөлжөөнийхэн энэ зүгт бие засахаас зайлсхийдэг хориотой. | Эхийн хөөвөр өвөлжөөний Даваадорж, Эрдэнэжаргал, Сайхангомбо, Цэдэнгомбо | Эхийн хөөвөр өвөлжөө, ус |
| 15 | Чавгын агуй | Буддын лам Чавга даянчилсанаас хойш Чавга гэж нэрлэсэн. Дараа нь төвдийн лам даянчлахаар ирсэн ч 3 илүү хоножчадаагүй. Садага Балжир энэ газар их ан хийснээс хойш нэрийг нь Баяжих гэж нэрлэхийг Цэдэнгомбо зорьж байгаа. | Эхийн хөөвөр өвөлжөөний Даваадорж, Эрдэнэжаргал, Сайхангомбо, Цэдэнгомбо | Эхийн хөөвөр өвөлжөө, ус |
| 16 | Хороот Хайрхан | Гашуун Сухайт өвөлжөөний Цэвэгдорж, Пүрэвийн гэр бүлийнхэн шүтдэг. Цагаан сарын шинийн нэгэнд шинэ ондоо мал сүрэг, амьдрал ахуйгаа сайхан байлгахыг даатгаж хоол цайны дээжээ өргөдөг. | Цэвэгдорж Пүрэв, энхнэр Цэцэгмаа, Төвшинтөгс, Цэвэгдорж, Мөнгөнцоож, Цэвэгдорж | Гашуун Сухай өвөлжөө |
| 17 | Цагаан Овоо | Энэ нь мод, чулууг нь хөдөлгөж болохгүй тахилгат газар. Гэвч Оюу Толгойн төслөөр ухагдаж, буцаагдсан. | Цэвэгдорж Пүрэв, энхнэр Цэцэгмаа, Төвшинтөгс, Цэвэгдорж, Мөнгөнцоож, Цэвэгдорж | Гашуун Сухай өвөлжөө |
| 18 | Яст мэлхий хад | Энэ нь бас тахилгат газар бөгөөд хувьсгалаас өмнө Цохиот Ам гэж нэрлэгддэг байсан хадны ар бэл оршуулгын газар байсан. "залуу эхнэрүүд эндээс чулуу | Цэвэгдорж Пүрэв, энхнэр Цэцэгмаа, Төвшинтөгс, Цэвэгдорж, Мөнгөнцоож, Цэвэгдорж | Гашуун Сухай өвөлжөө |

| | Тахилгат болон хориотой газруудын нэр | Төрөл, холбогдох ёс заншил, түүх домог | Шүтдэг ард (нэр, хамаатан садны нэр, нас) | Баг ба өвөлжөө |
|---|---|---|---|---|
| | | авснаар мал руу нь чоно дайрч 30 хонь бэртсэн." гэж Цэрмаа хэлсэн. | | |
| 19 | Энгэр Баг Мод газар | Малчин Лэнтэн Энгэр Баг Модод нутагласнаар эхнэр нь өвдөж нүүсэн. | Малчин Лэнтэнгийн гэр бүл | Энгэр Баг Мод өвөлжөө |
| 20 | Оюу Толгой | Оюу Толгойн ойр орчмын газар мал бэлчээх, мод чулуу хөдөлгөхийг хориглодог тахилгат газар байсан. Гэвч Оюу Толгой төсөлд орж малтлага хийснээр Оюу Толгойн хамгаалагч нарын нэг нь галзуурсан. | Цэндоо Долгор Мөнх-Овоо овогтой 69 настай | Оорцог өвөлжөө, Халив ус |
| 21 | Гурван Сайхан уул | Ханбогд Хайрханы зүүн талд байрладаг Гурван Сайхан Уул нь Ханбогд Хайрханы Хатадын 3 нөхөр эзэмшдэг ба эмэгтэйчүүд гарахыг хориглодог. | Хандсүрэн, Цэрэндорж, эхнэр Охиндуу, Бат Тайжууд овогтой | Хайрцагт Аман Ус өвөлжөө |
| 22 | Хөх Хадны Овоо | Энэ агуй нь Хөх Хад өвөлжөөний Долгорсүрэн, Дэмбэрэл, Салаа өвөлжөөний Намсрай, тэдний гэр бүлээр шүтэгдэг. Цагаан сарын шинийн нэгэнд тахиж, ёслол үйлддэг. | Намсрай, Долгорсүрэн, Зэлмэ овогтой, Дэмбэрэл, тэдний гэр бүлийн гишүүд | Хөх Хад өвөлжөө, Салаа өвөлжөө |
| 23 | Хөөрхөн овоо | Тахигдсан онгон газар, эмэгтэй хүн гарахыг хориглодог. Мөн мод чулуу хөдөлгөж болохгүй. Жинхэнэ нэрийг нь хэлэхийг цээрлэдэг учир хүмүүс Шинэ Толгой гэж нэрлэдэг. | Намсрай, Долгорсүрэн, Зэлмэ овогтой, Дэмбэрэл, тэдний гэр бүлийн гишүүд | Хөх Хад өвөлжөө, Салаа өвөлжөө |
| 24 | Улаан Толгойд Төрсөн газар | Улаан Толгойд миний төрсөн газар байдаг. Миний төрсөн газрыг устгавал надад хэцүү, би жил бүр төрсөн газраа ирж хөрвөөж аз хийморь, аз жаргалаа дууддаг. | Намсрай, Долгорсүрэн, Зэлмэ овогтой | Салаа өвөлжөө |
| 25 | Угалз өвөлжөөний хажуудах овоо | Өөлийн Сэр-Од овогтой. Угалз өвөлжөөнд 2 тахилгат овоо байдаг ба нэгийг нь Цагаан сарын шинийн нэгэнд тахьдаг заншилтай. | Сэр-Од, угалз өвөлжөө | Угалз өвөлжөө |

| | Тахилгат болон хориотой газруудын нэр | Төрөл, холбогдох ёс заншил, түүх домог | Шүтдэг ард (нэр, хамаатан садны нэр, нас) | Баг ба өвөлжөө |
|---|---|---|---|---|
| 26 | Угалз өвөлжөө | Энэ өвөлжөө нь үүслээрээ онцлогтой. Өмнө нь аргаль угалзын өвөлжөө байсан ба маш дулаахан газар юм. Сэр-Одын гэр бүл энэ өвөлжөөг дээдсээсээ өвлөсөн ба гүн сүсэглэдэг. | Сэр-Од, угалз өвөлжөө | Угалз өвөлжөө |
| 27 | Баян Бараат Хайрхан | Баян Бараат нь энэ газрын өндөр уулсын нэг бөгөөд нутгийн иргэд өглөө бүр энэ ууланд дээж өргөдөг. | Сэр-Од, угалз өвөлжөө, Банди, Цэдэнжав, Эхэн Бурхант өвөлжөө, тэдний гэр бүл | Угалз өвөлжөө<br><br>Эхэн Бурхант өвөлжөө |
| 28 | Улаан Толгойн Энгэр | Энэ нь Батсугар, Хорол, нагац Сэр-Одын эхнэр Сүнжидмаа на-рын төрсөн газрыг тэмдэглэсэн чулуу байдаг. | Угалз өвөлжөө, Сэр-Од Өөлий овогтой гэр бүл | Угалз өвөлжөө |
| 29 | Эхэн Бурхант өвөлжөөний булш | Археологичид судласан. | Угалз өвөлжөөний Сэр-Од Өөлий овогтой, Эхэн Бурхант өвөлжөөний Банди Цэдэнжав түүний гэр бүл | Угалз өвөлжөө<br><br>Эхэн бурхант өвөлжөө |
| 30 | Цагаан дэл | Цагаан дэл нь урт хүрээтэй уул бөгөөд хүмүүс аварга могойн бие гэж хэлдэг. Тэр аварга могойн домог нь Эхэн Бурхант өвөлжөөний зүүн хаданд хүрдэг. Хүмүүс Цагаан дэл нь ширүүн уул гэж боддог бөгөөд тэр орчмоор явдаггүй. | Угалз өвөлжөөний Сэр-Од Өөлий овогтой, Эхэн Бурхант өвөлжөөний Банди Цэдэнжав түүний гэр бүл | Угалз өвөлжөө<br><br><br>Эхэн бурхант өвөлжөө |
| 31 | Эхэн Бурхант өвөлжөөний Хадан нүхнүүд (хонгионууд) | Банди Цэдэнжавын хүүхдүүд Эхэн Бурхант өвөлжөөний хадны нүхэнд чулуугаар гэр барьж тоглодог байсан. | Эхэн Бурхант өвөлжөөнийх-нөөр тахигдсан | Эхэн бурхант өвөлжөө |
| 32 | Чулуугаар тэмдэглэсэн төрсөн газар | Ц. Энхтуяа Адгийн бурхант өвөлжөөнд төрсөн ба төрсөн газраа чулуугаар тэмдэглэсэн нь тэнд байдаг. | Б. Шинэбаяр, Ногоонууд овогтой, 45 настай | Адгийн бурхант өвөлжөө |
| 33 | Адгийн бурхант өвөлжөөний хүүхэд тоглодог газар | Адгийн Бурхант өвөлжөөнөөс зүүн зүгт 100 метрт Б. Шинэбаярын хүүхдүүдийн тоглодог газар байдаг. | Б. Шинэбаяр Ногоонууд овогтойнас 45 | Адгийн Бурхант өвөлжөө |
| 34 | Хүрэн Овоо | Хүрэн Овоог шүтдэг. Ганц мод өвөлжөө-ний зүүн талд байрладаг. Ганболд Ца-гаан сарын шинийн нэгэнд тахьдаг зан- | Х. Ганболд, Ногоонууд овогтой, нас 46 | Ганц мод өвөлжөө |

| | Тахилгат болон хориотой газруудын нэр | Төрөл, холбогдох ёс заншил, түүх домог | Шүтдэг ард (нэр, хамаатан садны нэр, нас) | Баг ба өвөлжөө |
|---|---|---|---|---|
| | | шилтай гэж хэлсэн. | | |
| 35 | Таван Овоо | Ганц мод өвөлжөөний хойно байрладаг ба Х. Ганболд тахьдаг. Цагаан сарын шинийн нэгэнд ёслол үйлддэг. | Х. Ганболд, Ногоонууд овогтой, нас 46 | Ганц мод өвөлжөө |
| 36 | Хүрэн энгэрийн булшны газар | Хүрэн энгэрт 5 булш хиргисүүр байдаг ба археологичид судалсан, доош нь харуулж оршуулсан хүний хүүр олдсон гэж сонсогдсон. | Бадамсамбуу Бат Зэлмэ овогтой нас 39 | Хацавч өвөлжөө, ус |
| 37 | Шаргын овоо | Болдбаяр, Данахүү гэр бүлийнхэн Шаргын овоог тахьдаг. Наадам, Цагаан сар шиг ёслолоор тахьдаг заншилтай. | Болдбаяр, Данахүү, Мөнх-Овоо овогтой, нас 44 | Задгай сухай өвөлжөө |
| 38 | Дөрвөлж Хайрхан | "Бид Дөрвөлж Хайрханыг тахиснаас хойш жинхэнэ нэрийг нь хэлэхийг цээрлэж, Хүрэн Хайрхан, Хойд Хайрхан гэж нэрлэдэг" гэж Хангарьд, Бунтун, Хангууд хэлсэн. Бидний өвөг дээдэс энэ уул тэмээ өсөхийг тэтгэдэг гэж хэлсэн. Бид Цагаан сарын шинийн нэгэнд тахих ёслол үйлдэж, өглөө бүр дээж өргөдөг. Мөн энэ уулыг Бударгана, Булан дэрс, Шаваг, Уулзвар өвөлжөөнийхөн тахьдаг. "Хөөвөр голын дагуу Хойд Хайрханы урд газар нь мөн онгон  газар юм. Биднийг хүүхэд байхаас л модны мөчир, чулуу авахыг хориглодог байсан" гэж Отгонхүү, Цэвээнжав, Ширнэн хэлсэн. | Энэ нь Хангарьд бунтун хангууд овогтой, Чулуунбаатар, Отгонхүү нарын гэр бүлээр тахигддаг. | Уулзвар, Бударгана Булан Дэрс, Шаваг өвөлжөөнүүд |
| 39 | "Балгант" нэртэй догшин газар | "Балгант нь хүмүүс ойролцоо нутаглахыг хориглодог догшин газар. Хүрч хөндөхийг зөвшөөрдөггүй." "Балгант их догшин өвөрмөц газар. Би нэг удаа мотоцикл шаварт суугаад газрыг нь жаахан ухсан толгой өвдөж, биеэр тууралт гарсан" гэж Ширнэн, Итгэл, Хаван овогтой хэлсэн. | Хангарьд бунтун хангууд овогтой, Чулуунбаатар, Отгонхүү, Цэвээнжав Удайд нарын гэр бүлийнхэн шүтдэг. | Уулзвар, Бударгана Булан Дэрс, Шаваг өвөлжөөнүүд |

| | Тахилгат болон хориотой газруудын нэр | Төрөл, холбогдох ёс заншил, түүх домог | Шүтдэг ард (нэр, хамаатан садны нэр, нас) | Баг ба өвөлжөө |
|---|---|---|---|---|
| 40 | Их усан дахь төрсөн газар | Бунтан Хангууд Хангарьд, Хангарьдын Гэрэлт-Од нарын төрсөн газар байдаг ба тэд цагаан сараар төрсөн газраа очдог. Хэрэв миний төрсөн газар хөндөгдвөл бидэнд хэцүү гэж хэлсэн. Мөн Б. Наранчимэгийн төрсөн газар Бударгана өвөлжөөний баруун хойно 2 км, Оюу Толгой замын зүүн талд 100 м.т байдаг. | Хангарьд бунтун хангууд овогтой | Бударгана өвөлжөө |
| 41 | Үнэгэд Хайрхан | Үнэгэд Хайрхан нь тахилга ёс заншил байхгүй онгон газар. Гэхдээ тэнд очиж мод чулуу хөдөлгөж болохгүй гэж Ширнэн Итгэл Хаван овогтой хэлсэн. | Ширнэн Итгэл Хаван овогтой, Шаваг өвөлжөөний хүмүүс шүтдэг онгон уул юм. | Шаваг өвөлжөө |
| 42 | Улаан дэл хяр | Улаан Дэлийн Ам нь хяр бөгөөд Дөрвөлж Хайрханаас зүүн тийшээ Шаваг өвөлжөөнөөс зүүн хойш 9 км, Уулзвар өвөлжөөнөөс зүүн тийш 1.5 км үргэлжилдэг. Эндээс мод авч, ан хийж болохгүй хориотой. "Улаан дэлийн хяр нь нийтдээ онгон газар. Нэг удаа Эрдэнэбаяр буйлс мод авсан маргааш нь чононд бариулсан" гэж хэлсэн бол Цэвээнжав нэмж "Улаан хяр нь бидний онгон шүтээний газар хэзээ ч ан хийж буу дуугаргаж, мод сугалж байгаагүй" гэж хэлсэн. | Ширнэн Итгэл Хаван овогтой, Шаваг өвөлжөөний хүмүүс онгон уулыг шүтдэг.<br><br>Булан дэрсний өвөлжөөний Цэвээнжав, Хүүдэг удайд овогтой нар шүтдэг. | Уулзвар, Бударгана Булан Дэрс, Шаваг өвөлжөөнүүд |
| 43 | Шаваг, Булан Дэрс өвөлжөөний ойролцоох Чулуун Гэр тоглоомын газар | Тэнд Шаваг өвөлжөөний Ширнэн, Булан Дэрс өвөлжөөний Цэвээнжав, Отгонхүү нарын багадаа тоглож байсан чулуун гэр тоглоом олон суурь байдаг. | Шаваг өвөлжөөнийхөн, Ширнэн Итгэл Хаван овогтой нар тэдгээр чулуун гэр тоглоомын суурийг шүтдэг. | Уулзвар, Бударгана Булан Дэрс, Шаваг өвөлжөөнүүд |
| 44 | Шар Хөөрөгийн өвөлжөө | Шар Хөөрөг өвөлжөөний 2 айл 1980 онд шатсан түүнээс хойш нутгийн хүмүүс энэ газрыг гүйдэлтэй гэж боддог болсон. "Ялангуяа нялх хүүхэдтэй айлд энэ өвөлжөө ширүүн" гэж Отгонхүү хэлсэн. | Шаваг болон Булан Дэрс өвөлжөөнийхөн гүйдэлтэй гээд очдоггүй. | |

| | Тахилгат болон хориотой газруудын нэр | Төрөл, холбогдох ёс заншил, түүх домог | Шүтдэг ард (нэр, хамаатан садны нэр, нас) | Баг ба өвөлжөө |
|---|---|---|---|---|
| | | Өмнө нь энд тэмээн дээр гарсан мэт холыг харах өндөр өвөлжөө байсан. | | |
| 45 | Шандны Ам | Дөрвөлж Хайрханаас зүүн тийш 1 км зайд байрладаг хувьсгалаас өмнө оршуулгын газар байсан гэж Отгонхүү хэлсэн. | | |
| 46 | Уулзвар гол | Уулзвар гол, Уулзвар усны эхлэл Оюу Толгой замаас 1 км  зайд байдаг. Мод чулуу хөндөж болох-гүй хориотой онгон газар. | Чулуунбаатар Хүүдэг удайд овогтой түүний гэр бүлийнхэн шүтдэг. | Уулзвар өвөлжөө |
| 47 | Цахилдагтай гол | Цахилдагтай гол эх ундарга нь Оюу Толгой замаас зүүн тийш 1 км зайд оршдог. Уулзвар голтой адил зарим хорио цээртэй. | Чулуунбаатар Хүүдэг удайд овогтой түүний гэр бүлийнхэн шүтдэг. | Уулзвар өвөлжөө |
| 48 | Уулзвар, Цахилдагтай голуудын ангийн нууц газар | | Чулуунбаатар Хүүдэг удайд овогтой түүний гэр бүлийнхэн шүтдэг. | Уулзвар өвөлжөө |
| 49 | Хороотын хяр | Энэ газар нь Уулзвар голын баруун зүгт 1.5 км, Оюу Толгой замын баруун зүгт 500 метр зайд байдаг. | Чулуунбаатар Хүүдэг удайд овогтой түүний гэр бүлийнхэн шүтдэг. | Уулзвар өвөлжөө |
| 50 | Хөтөл шандны хяр | Энэ газар нь Уулзвар голын баруун хойд зүгт 1.5 км, Оюу Толгой замын баруун зүгт 2 км зайд байдаг. Орой дээрээ антентай ч онгон газар. | Чулуунбаатар Хүүдэг удайд овогтой түүний гэр бүлийнхэн шүтдэг. | Уулзвар өвөлжөө |
| 51 | Цагаан эрэг | Энэ нь догшин ба гүйдэлтэй гэсэн 2 хэсэгтэй. Энэ нь тэдний хооронд явдаггүй гэсэн үг. | Хоролсүрэн, Осор, Ногоонууд овогтой, нас 34 | Энгэр улаан өвөлжөө |
| 52 | Энгэр Улаан Толгой өвөлжөөний овоо | Энэ овоо нь өвөлжөөний хойшоо 100 метр зайд байдаг. Цагаан сарын шинийн нэгэнд тахигддаг уламжлалтай. | Хоролсүрэн, Осор, Ногоонууд овогтой, нас 34 | Энгэр Улаан өвөлжөө |
| 53 | Энгэр Улаан Толгой өвөлжөөний хүмүүсийн чулуун гэр | Энгэр Улаан Толгой өвөлжөөний хүмүү-сийн ихэнх нь, Хоролсүрэн Хосоогийн хүү чулуугаар гэр барьж тоглодог байсан | Хоролсүрэн, Осор, Ногоонууд овогтой, нас 34 | Энгэр Улаан өвөлжөө |

| | Тахилгат болон хориотой газруудын нэр | Төрөл, холбогдох ёс заншил, түүх домог | Шүтдэг ард (нэр, хамаатан садны нэр, нас) | Баг ба өвөлжөө |
|---|---|---|---|---|
| | тоглоомын суурь | суурь өвөлжөөний хойно 100 метрт байдаг. Одоо тэд тэмээн чулуунуудыг авч гэртээ хадгалсан. Чулуунуудыг гэртээ хадгалснаар манай тэмээн сүрэг өсч байгаа гэж боддог. | | |
| 54 | Битүүхэйн энгэр дэхь булшнууд | Битүүхэй уулын өмнө 2-3 оршуулга байдаг ба энд оршуулгын газар байсан. | Хоролсүрэн, Осор, Ногоонууд овогтой, нас 34 | Энгэр Улаан өвөлжөө |
| 55 | Улаан Булаг | Улаан булагийн 2 талаарх модыг огтолвол сүү цус гардаг. Мод авах, сэвтээхийг хориглодог газар. Амьдралын турш би эндээс ямар ч мод авч сэвтээдэггүй гэж Алтангарьд хэлсэн. | Алтангарьд Дашдолгор Ногоонууд овогтойнас 26 | Талбар өвөлжөө |
| 56 | Буддын лам нарын булшны газар | Ламын шар булш гэж нэрлэгддэг булш Талбар өвөлжөөний баруун талд 300-400 м зайд байдаг. Бүтээн байгуулалтын үед сүйтгэгдсэн. | Алтангарьд Дашдолгор Ногоонууд овогтойнас 26 | Талбар өвөлжөө |
| 57 | Оюут Толгой | Талбар өвөлжөөний зүүн хойно 2 км зайд цагаан саарал уул байдаг ба малтлага хийвэл ногоон чулуу гардаг. Нутгийн иргэн Баатарчулуун 1 м ухаад юу ч олоогүй. | Хоролсүрэн, Осор, Ногоонууд овогтой, нас 34 Алтангарьд Дашдолгор Ногоонууд овогтойнас 26 Энгэр толгой өвөлжөө | Энгэр толгой, Талбар өвөлжөө |
| 58 | Тэмээн Хүрэн Овоо | Энэ овоо нь Харганат өвөлжөөний баруун талд 1 км зайд байрладаг онгон догшин газар. "Нутгийн нэгэн иргэн модны мөчир авснаар унаж явсан тэмээ нь удахгүй үхсэн. Хүмүүс ярихдаа өөрөө гэмтэж, үхээгүй нь болж гэж ярьдаг" гэж Хоролсүрэн хэлсэн. | Энхжаргал, Осор, Ногоонууд овогтой, Харганат өвөлжөө нас 32 | Харганат өвөлжөө |
| 59 | Өндөр Хөх Толгой өвөлжөөний Овоо | Энхбаяр Бунтун Хангууд түүний гэр бүлийнхэн шүтдэг өвөлжөө | Энхбаяр Бунтун Хангууд нас 46 | Өндөр Хөх Толгой өвөлжөө |
| 60 | Бор Хошуу Овоо | Цагаан сарын шинийн нэгэнд тахигддаг. | Болдмаа Данахүү нас 47 | Энгэр Баг Мод өвөлжөө |
| 61 | Цагаан Хайрхан | Цагаан Хайрханы голын ус руу нь юм | Болдмаа Данахүү нас 47 | Энгэр Баг Мод өвөлжөө |

| | Тахилгат болон хориотой газруудын нэр | Төрөл, холбогдох ёс заншил, түүх домог | Шүтдэг ард (нэр, хамаатан садны нэр, нас) | Баг ба өвөлжөө |
|---|---|---|---|---|
| | | шидэж болохгүй, мод хөрсийг нь хөндөж болохгүй. Нэгэн удаа нэг айл хонио угаасан дараа нь мал руу нь чоно дайрсан. Мөн "Цагаан Хайрханд нэг булш байсан нь ухагдсан. Монгол хүн бол тийм зүйл хийхгүй Хятад л байсан байх. Лус хилэгнэсэн гэж би сонссон" гэж Болдмаа ярьсан. | | |
| 62 | Шаваг өвөлжөөний онгон мод | Хувьсгалын өмнө оршуулгын газар байсан. Цэрмаагийн хүүхдүүдийн булш байсан гэж би сонссон. Энэ нь Эрдэнэбаярын өвөлжөөнөөс хойш 4 км зайд байдаг. | Эрдэнэбаяр, Осор, Төмөр нас 46 | Баг Модны Салаа өвөлжөө |
| 63 | Ханан Овоо өвөлжөөний Овоо | Өвөлжөөнөөс хойш 100 м зайд байдаг. Цагаан сарын шинийн нэгэнд тахьдаг заншилтай. | Жаргалсайхан, Цэдэн, Өвөө болон тэдний гэр бүл энэ овоог тахьдаг. | Ханан өвөлжөө, Тохой гол |
| 64 | Таван Овоо онгон газар | "Манай өвөө энэ овоог өвөг дээд-сээсээ шүтэж ирсэн бид ч үргэлж-лүүлэн шүтвэл бидний ирээдүй сайхан байна гэж хэлсэн" гэж Сайхан-Овоо өвөлжөөний Цэнд-Аюуш хэлсэн. | Жаргалсайхан Цэдэн, Өвөө түүний гэр бүлийнхэн, Цэнд_Аюуш, Рэгзэн, Дадо овогтой, нас 59 | Ханан өвөлжөө, Цохио гол<br><br>Сайхан овоо өвөлжөө |
| 65 | Баян Мод онгон газар | Баян Мод онгон газар нь Ханан өвөлжөөний зүүн хойно 200 м зайд байдаг. Мод чулууг нь хөн-дөж болохгүй онгон газар. | Жаргалсайхан Цэдэн, Өвөө түүний гэр бүлийнхэн | Ханан өвөлжөө, Цохио гол |
| 66 | Ханан өвөлжөөний дэргэдэх булшны газар | Ханан өвөлжөөнөөс хойш 500 м зайд булш байдаг. Археологичид судалсан. | Жаргалсайхан Цэдэн, Өвөө түүний гэр бүлийнхэн | Ханан өвөлжөө, Цохио гол |
| 67 | Сайхан Овоо өвөлжөөний овоо | Өвөлжөөний баруун хойно 200 м зайд байдаг бөгөөд биднийг хүү-хэд наснаас эрүүл аз жаргалтай ивээж өсгөсөн гэж талархдаг. | Цэнд_Аюуш, Рэгзэн, Дадо овогтой, нас 59, түүний гэр бүлийнхэн, | Сайхан Овоо өвөлжөө, ус |
| 68 | Ундайн гол | Таван Толгой өвөлжөөний баруун хойно | Отгонжав, Хайдав, Но- | Таван Толгой өвөлжөө, Ундайн ус |

| | Тахилгат болон хориотой газруудын нэр | Төрөл, холбогдох ёс заншил, түүх домог | Шүтдэг ард (нэр, хамаатан садны нэр, нас) | Баг ба өвөлжөө |
|---|---|---|---|---|
| | | 200 м зайд байдаг. Хүмүү-сийн усны гол ундарга учир бо-хирдуулж сэвтээж болохгүй гэж Отгонжав хэлсэн. | гоонууд овогтой нас 39, тэдний гэр бүлийнхэн шүтдэг | |
| 69 | Ацат Хөх Овоо өвөлжөөний Овоо | Зүүн зүгт 800 м зайд Ацат Хөх Овоо өвөлжөө байдаг ба бид өглөө бүр цайны дээжээ өргөдөг. | Цэрэннадмид, Түгэл, Их Өлзийт нас 42, тэдний гэр бүл | Ацат Хөх Овоо өвөлжөө |
| 70 | Бор Тээг Улан дахь төрсөн газр | Бор Тээгийн өмнө Бандиа Самбын төрсөн газар байдаг. | Бандиа Самба,  Удайд овогтой, нас 72 | Энгэр Баг Модны Хөөвөр өвөлжөө, ус |
| 71 | Булан дэрсэн дэх төрсөн газар | Булан Дэрс өвөлжөөнд Лхагвацэ-рэнгийн Буд, Тогтох нарын төрсөн газар байдаг. | Боржигон овогтой, Баатарчулуун, Сүх | Энгэр Баг Модны Булан дэрс өвөлжөө, ус |
| 72 | Шаваг өвөлжөөн дэхь төрсөн газар | Хөөвийн Шаваг өвөлжөөнд Баа-тарчулууны Энх-Очирын бага хүү-гийн төрсөн газар байдаг. | Боржигон овогтой, Баатарчулуун, Сүх | Энгэр Баг Модны Булан дэрс өвөлжөө, ус |
| 73 | Бор Хошуу өвөлжөөний онгон мод, гүйдэлтэй газар | Баруун хошуу өвөлжөөний баруун хойно нэг Буйлс мод байдаг ба мөчир ч авч болохгүй. Мөн хо-лоос шидийн гэрэл гарахыг хү-мүүс харсан гэж хэлсэн. | Боржигон овогтой, Баатарчулуун, Сүх | Энгэр Баг Модны Булан дэрс өвөлжөө, ус |
| 74 | Сэрвэн уулын өмнөх чулуун гэр тоглоомын суурь | Сэрвэн ууланд тоглоомон гэрийн сайхан суурь байдаг. Хэзээ хэн тоглож барьсныг нь бид мэдэхгүй гэж Баатарчулуун хэлсэн. | Боржигон овогтой, Баатарчулуун, Сүх | Энгэр Баг Модны Булан дэрс өвөлжөө, ус |
| 75 | Хар Толгой дахь булш | Булан Дэрс өвөлжөөний зүүн хойно 5 км зайд энэ булш байдаг. 200-300 жилийн өмнөх үеийн булш хүмүүс ярьдаг. | Боржигон овогтой, Баатарчулуун, Сүх | Энгэр Баг Модны Булан дэрс өвөлжөө, ус |
| 76 | Тэмээн Хүрэн овооны бунхан | Тэмээн Хүрэн нь Булан Дэрс өвөлжөөний зүүн хойно 4 км зайд байдаг. Өвдгөөрөө суусан эмэгтэй хүний булш байдаг ба яснууд ил харагддаг. | Боржигон овогтой, Баатарчулуун, Сүх | Энгэр Баг Модны Булан дэрс өвөлжөө, ус |
| 77 | Булан Дэрс өвөлжөөн дэхь ясан сийлбэр | Цагаан Хайрханы ойролцоо Булан Дэрс өвөлжөөний зүүн зүгт энэ ясан сийлбэр байдаг | Боржигон овогтой, Баатарчулуун, Сүх | Энгэр Баг Модны Булан дэрс өвөлжөө, ус |
| 78 | Энгэр Баг модон дахь | Булан Дэрс өвөлжөөний зүүн хойно нэг | Боржигон овогтой, | Энгэр Баг Модны Булан дэрс |

| | Тахилгат болон хориотой газруудын нэр | Төрөл, холбогдох ёс заншил, түүх домог | Шүтдэг ард (нэр, хамаатан садны нэр, нас) | Баг ба өвөлжөө |
|---|---|---|---|---|
| | Гандангийн буурь | байшин хоёр гэрийн суурь байдаг. Энэ нь Энгэр Баг модны гандангийн суурь юм. | Баатарчулуун, Сүх | өвөлжөө, ус |
| 79 | Их Цагаан Хад өвөлжөөн дэхь Овоо | Энэ Овоо нь Их Цагаан Хад өвөлжөөнд байдаг ба Цогнэмэх Хүү, Хунзцагаан овогтой тэдний гэр бүлийнхэн шүтдэг. Гол заншил нь Цагаан сарын шинийн нэгэнд үйлдэгддэг ёслол. | Их Цагаан Хад өвөлжөөний Цогнэмэх Хүү, нас 43, Хунзцагаан овогтой тэдний гэр бүлийнхэн шүтдэг | Их Цагаан Хадны  өвөлжөө |
| 80 | Цагаан Хад онгон газар | “Цагаан Хадны сухайг хөндөж болохгүй гэж биднийг хүүхэд байхаас захидаг байсан ба бид сургаалыг дагаж хэзээ ч ямар ч сухай хөндөж байгаагүй. Одоо хайлаа, тоорой мод тэнд өндөр ургахаа больсон. Бид ч хойч үедээ энэ газрыг хөндөж болохгүй гэж захидаг” гэж Цогнэмэх хүүгийн эхнэр хэлсэн. | Цагаан Хад өвөлжөөнийхөн, Цогнэмэх хүү, нас 43, Хунзцагаан овогтой тэдний гэр бүлийнхэн шүтдэг. | Их Цагаан Хадны  өвөлжөө (өвөл-жөө одоо нүүж, нутгийнхан Далан Заг өвөл-жөөнд өвөлждөг болсон) |
| 81 | Цагаан Хадан дахь чулуун гэр тоглоомын суурь | Цогнэмэхийн эхнэрийн ах дүүсийн хүүхдүүд тоглодог байсан чулуун гэр тоглоомын суурь нь Цагаан хаданд Оюу Толгой замаас баруун тийш 4 км зайд байдаг. | Цагаан Хад өвөлжөөнийхөн, Цогнэмэх хүү | Цагаан Хадны өвөлжөө |
| 82 | Номгон Хайрхан | Номгон Хайрхан уул нь Оюу Толгой замаас зүүн зүгт 20 км зайд оршдог ба Номгон багийн хүмүүсийн хамгийн их шүтдэг, онгон газар юм. Зуны эхэн сард наадам хийдэг. Морь уралдаж, бөх барилдах гэх мэт. Мөн энэ уулын ойр нутгийнхан өглөө бүр дээжээ өргөж залбирдаг. | Цагаан Хад өвөлжөөнийхөн, Цогнэмэх хүү | Цагаан Хадны өвөлжөө |
| 83 | Зургаан Модны хуучин булшны газар | Зургаан мод, Далан загийн шинэ бууц-наас баруун хойш 4-5 км хол хуучин булшны газар байдаг гэж Цогнэмэхийн эхнэр ээжээсээ сонсжээ. Элдэв хорио цээр байхгүй хүмүүс явж болох газар. | Цагаан Хад өвөлжөөнийхөн, Цогнэмэх хүү | Цагаан Хадны бууц Даланзагийн бууц |

| | Тахилгат болон хориотой газруудын нэр | Төрөл, холбогдох ёс заншил, түүх домог | Шүтдэг ард (нэр, хамаатан садны нэр, нас) | Баг ба өвөлжөө |
|---|---|---|---|---|
| 84 | Баруун Тогоо Хайрхан | Дарвагай Шар овогтой Чулуу, Дарвагай хоёр мод нь Отгондүү Лантуу, Зүүн загийн бууцны Хөх Хиа овогтой нарын шүтдэг онгон газар юм. Баруун Тогоо Хайрхан Оюу Толгой, Таван Толгой Трансын 2 замын дунд байрладаг. Энэ уул нь онгон шүтээн уул бөгөөд бид өглөө бүр цайны дээжээ өргөдөг. Мөн Цагаан сарын шинийн нэгэнд нутгийн бүх эрчүүд тэнд гарч хүслээ хэлдэг. Эмэгтэй хүн гарах хориотой. Гадныхан ч очиж хүслээ хэлдэг. | Хөх Хиа овогтой Отгондүү, Лантуу, Дарвагай Шар овогтой Чулуу, Дарвагайн Хоёр мод, Зүүн Заг бууц, нас 32, тэдний гэр бүлийнхэн | Дарвагай Шар овогтой Чулуу, Дарвагайн Хоёр мод, Зүүн Заг бууц |
| 85 | Зүүн Тогоо Хайрхан | Зүүн Тогоо Хайрхан нь онгон, догшин уул бөгөөд эмэгтэй хүн гарч болдоггүй. Ёс заншил байхгүй ч хүмүүс шүтдэг гэж Отгондүү Лантуу хэлсэн. | Хөх Хиа овогтой Отгондүү, Лантуу, Дарвагай Шар овогтой Чулуу, Дарвагайн Хоёр мод, Зүүн Заг бууц, нас 32, тэдний гэр бүлийнхэн | Дарвагай Шар овогтой Чулуу, Дарвагайн Хоёр мод, Зүүн Заг бууц |
| 86 | Дарвагай гол | Дарвагай гол нь онгон, догшин газар бөгөөд мод, сухай хөдөлгөж болохгүй. Тоорой мод ургадаг байсан ч одоо бол өндөр ургадаггүй. | Хөх Хиа овогтой Отгондүү, Лантуу, Дарвагай Шар овогтой Чулуу, Дарвагайн Хоёр мод, Зүүн Заг бууц, нас 32, тэдний гэр бүлийнхэн | Дарвагай Шар овогтой Чулуу, Дарвагайн Хоёр мод, Зүүн Заг бууц |
| 87 | Цагаан Хадны гүйдэлтэй эсвэл догшин газар | Хүрэн Шанаа гэж товчлон нэрлэдэг энэ газар Жаргалсайхан амиа хорлосон. Түүнээс хойш энэ газар догширч, олон янзын бэрхшээл тохиолдох болсон. | Хөх Хиа овогтой Отгондүү, Лантуу, Дарвагай Шар овогтой Чулуу, Дарвагайн Хоёр мод, Зүүн Заг бууц, нас 32, тэдний гэр бүлийнхэн | Дарвагай Шар овогтой Чулуу, Дарвагайн Хоёр мод, Зүүн Заг бууц |
| 88 | Далан Шар Цулхир ургуулдаг газар | Цагаан Хаднаас Баруун зүгт 5 км зайтай Цулхир тарьдаг. | Хөх Хиа овогтой Отгондүү, Лантуу, Дарвагай Шар овогтой Чулуу, Дарвагайн Хоёр мод, Зүүн Заг бууц, нас 32, тэдний гэр бүлийнхэн | Дарвагай Шар овогтой Чулуу, Дарвагайн Хоёр мод, Зүүн Заг бууц |
| 89 | Цагаан Хад – Дарвагай | Цагаан Хад нь Дарвагай голын эхлэл | Хөх Хиа овогтой Отгондүү, | Дарвагай Шар овогтой Чулуу, |

| | Тахилгат болон хориотой газруудын нэр | Төрөл, холбогдох ёс заншил, түүх домог | Шүтдэг ард (нэр, хамаатан садны нэр, нас) | Баг ба өвөлжөө |
|---|---|---|---|---|
| | гол | газар бөгөөд бид энэ газрыг битгий онгичоосой гэж хүсэж байна. Энэ газар нь усны ундарга бөгөөд шүтэгдсэн газар юм. | Лантуу, Дарвагай Шар овогтой, Чулуу, Дарвагайн Хоёр мод, Зүүн Заг бууц, нас 32, тэдний гэр бүлийнхэн | Дарвагайн Хоёр мод, Зүүн Заг бууц |
| 90 | Суул Толгойн хоолой, Нөмгөн багийн морин уралдааны газар | Нөмгөн Хайрханыг тахих үеэр морь уралдаж, бөх барилдсан. Нөмгөн Хайрханы зүүн талд морь уралддаг газрыг Сүүл Толгой гэж нэрлэдэг. | Өлзийбүрэн Буд, Сономчин, Цагаан Хад өвөлжөө, нас 31, Эрдэнэбилэг, Жаргал, Сономчин, нас 51 | Цагаан хад, Гүн Дэрс өвөлжөө |
| 91 | Модот Хошуу | Энэ газрыг Оюу Толгой төсөл санаачлан Тэмээн Поло газар болгосон. Ихэвчлэн өвөл, хавар заримдаа жилийн турш Поло зохиогддог. | Өлзийбүрэн Буд, Сономчин, Цагаан Хад өвөлжөө, нас 31, Эрдэнэбилэг, Жаргал, Сономчин, нас 51 | Цагаан хад, Гүн Дэрс өвөлжөө |
| 92 | Цагаан Хадны онгон газар | Тоорой мод ургадаг байсан Цагаан хадны энэ газар олон янзын хорио тогтоосон догшин газар. Тоорой мод авахыг хориглосон боловч урт ургахаа больсон. | Өлзийбүрэн Буд, Сономчин, Цагаан Хад өвөлжөө, нас 31, Эрдэнэбилэг, Жаргал, Сономчин, нас 51 | Цагаан хад, Гүн Дэрс өвөлжөө |
| 93 | Отолт хийдэг газар | Хувьсгалын өмнө энд нутгийн хүмүүс нуугдаж байгаад энүүгээр өнгөрөх Хятадын худалдаачдыг дээрэмддэг байсан. | Дэмбэрэл (нас 35) Намсрай (нас 49) Долгорсүрэн, Зэлмэ овогтой | Жавхлант баг, Хөх Хад, Салаа өвөлжөө |
| 94 | Хөөрхөн Овоо | Энэ нь манай өвөг дээдсээр шүтэгдэж ирсэн бөгөөд овооны орой дээр тахилга үйлддэг заншилтай. Эмэгтэй хүн гарахыг хориглоно. Зүрхэн овоо гэж нэрлэх болсон. | Дэмбэрэл (нас 35) Намсрай (нас 49) Долгорсүрэн, Зэлмэ овогтой | Жавхлант баг, Хөх Хад, Салаа өвөлжөө |
| 95 | Бор Овоо | Хамгийн их шүтэгдсэн, ариун газруудын нэг юм. Гадныхан ан хийхийг хориглодог. Хэрэв ан хийвэл ширүүн цас, бороо орно. Бүх улирлын турш устай байдаг. Овоо руу буу чиглүүлэхийг хориглодог. Овоон дээр болон ойролцоо нь бие засахыг хориглоно. | Дэмбэрэл (нас 35) Намсрай (нас 49) Долгорсүрэн, Зэлмэ овогтой | Жавхлант баг, Хөх Хад, Салаа өвөлжөө |
| 96 | Задгайт Улаан Толгойн онгон газар | Энэ газрын эргэн тойронд хүүхдүүд газар ухвал, гар дээр тууралт гарч, мал руу нь | Ц. Идэрборгил, Тамсаг, нас 37 | Жавхлант баг, Улаан Толгой өвөлжөө |

| | Тахилгат болон хориотой газруудын нэр | Төрөл, холбогдох ёс заншил, түүх домог | Шүтдэг ард (нэр, хамаатан садны нэр, нас) | Баг ба өвөлжөө |
|---|---|---|---|---|
| | | чоно дайрна. Тахь, гөрөөс эндээс ус уудаг. | | |
| 97 | Гялаан Цохио Хад | Хадны баруун урд могойн үүр байдаг, нутгийн хүмүүс Лусын орон гэж боддог. Могойд хүрч болохгүй. Мэндбаярын нэг хүүхэд нэг могой алснаар дараа нь осолдож, нас барсан. Түүнээс хойш Мэндбаярын гэр бүл шүтэх болсон. | Мэндбаяр, Мөнх-Овоо, нас 43 | Жавхлант баг, Гялааны өвөлжөө |
| 98 | Модон өвөлжөөний ганц хайлаас мод | Хүн, мал хүрч ойртож болохгүй, нутгийн хүмүүс шөнө дунд гэрэл гарч, инээдэг, жил бүр тэнд нэг хэрээ үүрээ засдаг гэж ярьдаг. | Наранцэцэг Амьтан, Цахар овогтой нас 53 | Жавхлант багийн Адаг Халив, Модон өвөлжөө |
| 99 | Хөдөөгийн Эрдэнэ овоо | Овооны зүүн талд хувьсгалын өмнө оршуулга байсан. Одоо Овооны ойролцоо сонин үзэгдэл болдог гэж нутгийнхан ярьдаг. | Пүрэвдорж М, Боржигон овогтой, нас 45 | Гавилууд баг, Эхэн Халив өвөлжөө |
| 100 | Хөх Хад өвөлжөөний Овоо | Малчин Дэмбэрэл 2004 онд өвөлжөөний хойно чулуу овоолж өглөө бүр ёслол үйлддэг байсан. Цагаан сарын шинийн нэгэнд гол ёслол үйлддэг. | Дэмбэрэл.З, Зэлмэ овогтой, нас 35 | Жавхлант баг, Хөх Хад өвөлжөө |
| 101 | Дэл өвөлжөөний овоо | С. Батсүх 1990 оноос хойш өвөлжөөний зүүн талд байдаг энэ овоог тахиж эхэлсэн ба өглөө бүр дээж өргөж, Цагаан сарын шинийн нэгэнд гол тахилга, ёслол үйлддэг. | Батсүх, Сайхангомбо, нас 73 | Жавхлант баг, Хулгарын Усны Дэл өвөлжөө |
| 102 | Улаан Толгой өвөлжөөний овоо | Ц. Идэрборгилын өвөлжөөний зүүн талд энэ овоо байдаг. Тэр 2008 онд Даланзадгадаас лам авчирч энэ овоог босгосон бөгөөд түүнээс хойш ёслол үйлдэж тахьдаг болсон. Цагаан сарын шинийн нэгэнд гал асааж, тахьдаг. | Ц. Идэрборгил, Тамсаг, нас 37 | Жавхлант баг, Улаан Толгой өвөлжөө |
| 103 | Улаан Овоо өвөлжөөний Хойд овоо | Ц. Нэргүйгийн өвөлжөөний хойно байдаг. Хувьсгалын өмнө шүтэгдсэн. Цагаан | Мэндбаяр, МөнхОвоо, нас 43 | Жавхлант баг, Гялааны өвөлжөө |

| | Тахилгат болон хориотой газруудын нэр | Төрөл, холбогдох ёс заншил, түүх домог | Шүтдэг ард (нэр, хамаатан садны нэр, нас) | Баг ба өвөлжөө |
|---|---|---|---|---|
| | | сарын шинийн нэгэнд гал асааж тахьдаг. | | |
| 104 | Гялааны өвөлжөөний овоо | Мэндбаяр хүүхэд байхдаа ээжтэй-гээ дандаа ёслол үйлдэж энэ овоог тахьдаг байсан учраас одоо ч шүтдэг. Тэд өглөө бүр дээж өр-гөж тахьдаг. Онгон газар юм. | Мэндбаяр, МөнхОвоо, нас 43 | Жавхлант баг, Гялааны өвөлжөө |
| 105 | Модон өвөлжөөний овоо | Энэ овоо нь Наранцэцэгийн өвөл-жөөний баруун хойно байдаг. 3 жилийн өмнөөс овоолж тахиж ирсэн ба энэ газрын хамгийн том овоо. | Наранцэцэг, Амьтан, Цахар овогтой нас 53 | Жавхлант багийн Адаг халивын Модон өвөлжөө |
| 106 | Эргэн усан дахь Оройн Зараа Овоо | Д. Чулуунбатын өвөг дээдэс энэ өвөл-жөөнд өвөлждөг байжээ. Энэ өвөлжөө-ний овоог тэд өглөө бүр дээж өргөж, уламжлалт баяруудаар тахьдаг. | Чулуунбат, Даш, Боржигон овогтой, нас 65 | Гавилууд баг, Эргэн усан дахь Оройн Зараа өвөлжөө |
| 107 | Ханан жим дээрх маанийн үсэг | Маанийн 6 үсэг бичигдсэн хад нь Баяр-сайхан болон бусад хүмүүсээр тахигдаж, өглөө бүр цайны дээжээ өргөдөг. | Амартүвшин.Ц, Улаан даавуу овогтой, эмэгтэй, нас 31 | Жавхлант баг, Ханан Даваа өвөлжөө |
| 108 | Ханан даваань нууц газар | Өмнөдөөс ирсэн Гуа Мин Дан цэргүүд чу-луу овоолж босгосон. Нутгийн хүмүүс тэнд нуугдаж байгаад тэдэн рүү дайрдаг байсан. | Амартүвшин.Ц, Улаан даавуу овогтой, эмэгтэй, нас 31 | Жавхлант баг, Ханан Даваа өвөлжөө |
| 109 | Улаан нуувч | Хятадын цэргүүдийг ирж яваг харж тэн-дээс буцаах гэж босгосон хамгаалалтын овоо гэж нутгийнхан ярьдаг. | Ц. Цагаан , Хаван овогтой, эмэгтэй, нас 55 | Жавхлант багийн Уст Баг Модны Шавааг өвөлжөө |
| 110 | Цагаан нуувч | Хятадын цэргүүдийг ирж яваг харж тэн-дээс буцаах гэж босгосон хамгаалалтын овоо гэж нутгийнхан ярьдаг. | Ц. Цагаан , Хаван овогтой, эмэгтэй, нас 55 | Жавхлант багийн Уст Баг Модны Шавааг өвөлжөө |
| 111 | Бүлтгэр Хонгорын Овоо | Нутгийн хүмүүсээр тахиулж ирсэн уламж-лалтай, гал асааж тахьдаг заншилтай бө-гөөд одоо хэвээрээ. Манай гэр бүл тахиж, өглөө бүр цайны дээжээ өргөдөг гэж Сү-хээ хэлсэн. | С. Сүхээ, Хөх Хиа овогтой, нас 68, эмэгтэй | Баян багийн Хулсан голын Хулсан өвөлжөө |
| 112 | Замт Хонгор овоо | Хээээ гэдэг нь тодорхойгүй ч уламжлан | С. Сүхээ, Хөх Хиа овогтой, | Баян багийн Хулсан голын Хулсан |

| | Тахилгат болон хориотой газруудын нэр | Төрөл, холбогдох ёс заншил, түүх домог | Шүтдэг ард (нэр, хамаатан садны нэр, нас) | Баг ба өвөлжөө |
|---|---|---|---|---|
| | | тахиж ирсэн. | нас 68, эмэгтэй | өвөлжөө |
| 113 | Хулсан өвөлжөөний овоо | Өвөлжөөний зүүн талд нэг жижиг овоо байдаг ба тодорхой заншилгүй ч өглөө бүр цайны дээжээ өргөдөг. Тугал малаа харах гэж дээр нь гардаг. | С. Сүхээ, Хөх Хиа овогтой, нас 68, эмэгтэй | Баян багийн Хулсан голын Хулсан өвөлжөө |
| 114 | Алтан Тэвшийн хөндий | Хувьсгалын өмнө булшны газар байсан ба тэнд хоёр хөндий байдаг, хөндийн зүүн талд ивээс чулуу байсан. Шөнө тэр хөндийгөөс гэрэл гардаг гэж хүмүүс ярьдаг. | С. Сүхээ, Хөх Хиа овогтой, эмэгтэй, нас 68 | Баян багийн Хулсаг усны Хулсан өвөлжөө |
| 115 | Ухаа Загийн Эхэн өвөлжөөний Овоо | Энэ овоог зөвхөн манай гэр бүл шүтдэг, бид дээр нь авирч гардаг. Бид өглөө бүр цайны дээжээ өргөж, тахьдаг. Цагаан сарын шинийн нэгэнд тусгайлан тахьдаг заншилтай. | Ө. Нацагдорж, Булцуу овогтой, нас 52 | Баян багийн Ухаа Загийн Эхэн өвөлжөө |
| 116 | Хүнхэр Онгон газар | Энэ газар онгон, догшин газар. Мод авахыг хориглодог. Мод авсан хүн өвдсөн түүхтэй. Эмэгтэй хүн гарах хориотой. Нэгэн эмэгтэй гараад нөхөр нь нас барсан. | Ж. Бямбадорж, Мөнхжин, нас 40 | Баян багийн Ухаа Загийн Эхэн өвөлжөө |
| 117 | Өвгөн Овоо | Алаг баян багийн гол ариун газар. Өвөг дээдсээсээ хүндлэн тахиж ирсэн овоо. Онгон, догшин газар. Ардаа цөөн модтой, мод авч болохгүй. Зуны эхэн сард тахиж наадам хийдэг. | Ц. Цоггэрэл, Худган, нас 35 | Баян багийн Ухаа Загийн Эхэн өвөлжөө |
| 118 | Хүрэн Овоо | Мижиддоржийн гэр бүл тахьдаг овоо, түүний өвөлжөөний хойд зүгт байдаг. Ариун толгодын ноён явчихсан байж байгаад буцаж ирснээр тахигдах болсон. Хүн, машин тэрэг ойртож болохгүй онгон, догшин газар. | А. Мижиддорж, нас 74 | Алаг Баян багийн Өрөлбө өвөлжөө |
| 119 | Орвог онгон газар | Энэ газрын хамгийн онгон, догшин газрын нэг. Хэсэг сухай мод байдаг ба хүмүүс энэ зүг рүү харж малын гол тасла- | И. Бандимаа, Хөх Хиа овогтой, нас 56 | Алаг Баяг багийн Хүрэн Цохионы Хоёр Мод өвөлжөө |

| | Тахилгат болон хориотой газруудын нэр | Төрөл, холбогдох ёс заншил, түүх домог | Шүтдэг ард (нэр, хамаатан садны нэр, нас) | Баг ба өвөлжөө |
|---|---|---|---|---|
| | | даггүй. Саяхан тэмээ хөнгөлсөн боловч үхсэн. Бадамдорж жаахан газар ухаад хөлөө гэмтээсэн. | | |
| 120 | Их Ширээт Уул - Хий үзэгдэлтэй газар | Энэ газар нь хий үзэгдэлтэй уул, шөнө гэрэл харагддаг. Бид гэрлийг харсан ма-най хойд өвөлжөөтэй ойр байдаг учир. | Бадамдорж. Р, Зэлмэ овогтой, нас 46 | Алаг баян багийн Их Ширээт өвөлжөө |
| 121 | Шар Довын Баруун Хөндийн хий үзэг-дэлтэй газар | Энэ газрын ойролцоо гүйдэлтэй, өдөр нүцгэн хүн явдаг гэж хүмүүс ярьсан. | Баярцогт. Б, Шар овогтой, нас 50 | Галивууд баг, Хөөвөр өвөлжөө |
| 122 | Хурдан морины овоо, суварга | Сумын наадмын үеэр энэ овоо, суваргыг бүх уралдааны морьд тойрдог. Морьдоо даатгадаг. | Баярцогт. Б, Шар овогтой, нас 50 | Галивууд баг, Хөөвөр өвөлжөө |
| 123 | Хутагтын аравнайлсан мөнх ногоон ургамал | Энд ургасан ургамал нь эмчилгээний ча-нартай, мөнх ногоон ургамлыг Говийн Догшин Хутагт аравнайлсан. Нутгийнхан хутагтаар аравнайлуулсан гэж энэ газ-рын ойролцоо хог хаядаггүй. | Хад, Равдандорж, Арлаан, нас 57 | Гавилууд баг, Шаваг өвөлжөө |
| 124 | Хутагтын аравнайлсан гоёо | Энд ургасан ургамал нь эмчилгээний ча-нартай, мөнх ногоон ургамлыг Говийн Догшин Хутагт аравнайлсан. Нутгийнхан хутагтаар аравнайлуулсан гэж энэ газ-рын ойролцоо хог хаядаггүй. | Хад, Равдандорж, Арлаан овогтой, нас 57 | Гавилууд баг, Шаваг өвөлжөө |
| 125 | Морь Овоо | Адуучид өвөлжөөний хойд талд байдаг энэ овоог ихээр шүтдэг ба уралдаанд явахдаа морьдоо энэ овоог тойруулдаг. | Түмэндэлгэр, Хад, Арлаан овогтой , эмэгтэй, нас 28 | Гавилууд баг, өвдөг өвөлжөө |
| 126 | Хий үзэгдэлтэй газар – Цагаан Хошуу | Өвөлжөөний зүүн талд байдаг Цагаан Хошуу нь янз бүрийн дуу чимээ гардаг хий үзэгдэлтэй бөгөөд хүн амьтан айлга-даг газар. | Оюунбатын хүү | Гавилууд баг, Хөндлөн өвөлжөө |
| 127 | Улаан эрэг дэхь Ганц Хайлаас | Ганц хайлаас нь догшин, ариун мод юм. Ганц мөчир ч эндээс авч болохгүй. | Баярцогт. Б, Шар овогтой, нас 50 | Гавилууд баг, Хөндлөн өвөлжөө |
| 128 | Улаан Эрэг дэхь Ганц Тоорой Мод | Ганц Тоорой мод нь энэ газрын онгон, догшин мод юм. Мөчир ч авч болохгүй. | Баярцогт. Б, Шар овогтой, нас 50 | Гавилууд баг, Хөндлөн өвөлжөө |

| | Тахилгат болон хориотой газруудын нэр | Төрөл, холбогдох ёс заншил, түүх домог | Шүтдэг ард (нэр, хамаатан садны нэр, нас) | Баг ба өвөлжөө |
|---|---|---|---|---|
| | | Дээдсээс тахигдаж ирсэн бөгөөд одоо маш хөгширч удахгүй унах гэж байгаа. | | |
| 129 | Хүрдэтийн Яшил мод | Удаан хугацааны турш тахигдаж ирсэн, хөндөж болохгүй. Онгон моддын нэг. | Баярцогт. Б, Шар овогтой, нас 50 | Гавилууд баг, Хөндлөн өвөлжөө |
| 130 | Тахилгат овоо | Энэ овоог нутгийн Дэнг өвөлжөөнийхөн тахьдаг ч наадам шиг онцгой ёс заншил байхгүй | Гарам овогтой Цогзолмаа, эмэгтэй, нас 27 | Алаг баян багийн Дэнг өвөлжөө |
| 131 | Гуны өвөлжөө – хий үзэгдэлтэй | Энэ газрын эргэн тойронд гүйдэлтэй, эсвэл хий үзэгдэлтэй. Саяхан Маамын гэр бүл тэндээс чимээгүй нүүсэн. Жилийн дараа өөр нэг айл буусан ч хүүхэд нь усан дээр тоглож байхдаа нүцгэн хүн харсан гэжээ. | Гарам овогтой Цогзолмаа, эмэгтэй, нас 27 | Алаг баян багийн Дэнг өвөлжөө |
| 132 | Зараан дахь Ганц Онгон  Хайлаас мод | Зараа өвөлжөөний хойно байдаг Ганц Хайлаас мод нь догшин, онгон мод юм. Нэг удаа Лхамжав тэндээс мөчир авчихсан чинь тэмээ явахаа байчихжээ. Бас нэг айл тэнд буусан нөхөр нь нас баржээ. Майнбаярын гэр бүл бас тэнд бууснаар гай барцад тохиолдож, эхнэр нь нас баржээ. Тиймээс нутгийнхан тэнд буухаас цээрлэдэг. | Тайж овогтой Батын Эрдэнэбаяр 49 настай эрэгтэй | Гавилууд баг, Зараагийн Бурхантын бууц |
| 133 | Улаан Толгойн гол | Манай өвөлжөөний зүүн талд 1-2 км зайтай байдаг ба мод чулуу хөдөлгөж болохгүй ариун догшин газар. Манай өвөлжөөний баруун талд 1 км зайд байдаг Ганц Хайлаас нь өвөг дээдсээс шүтэгдэж ирсэн. Ойролцоо олноор бужигнахыг хориглодог, Өнчин Мод гэж нэрлэдэг. | Баг Модны Буд овогтой Ухна, нас 74 | Гавилууд баг, Задгайт Улаан Толгой  өвөлжөө |
| 134 | Дугатын Цагаан Овоо | Манай шүтдэг чухал овоо. Өвөг дээдсээс уламжлан шүтэж ирсэн Цагаан сараар ёслол үйлдэн тахидаг. Энэ нь манай зуслангаас зүүн хойш 4 км зайтай. Шинэ | Ногоонууд овогтой Э. Сүрэнхорол, нас 42 | Гавилууд баг, Хавтгай Улаан өвөлжөө |

| | Тахилгат болон хориотой газруудын нэр | Төрөл, холбогдох ёс заншил, түүх домог | Шүтдэг ард (нэр, хамаатан садны нэр, нас) | Баг ба өвөлжөө |
|---|---|---|---|---|
| | | онгоцны буудлаас зүүн урагш 4 км. | | |
| 135 | Бумбатын Онгон Хайлаас Мод | Ганц Хайлаас мод Задгай Улаан Толгой өвөлжөөний зүүн талд 6 км зайтай бай-даг ба онгон догшин газар юм. Чулуу хө-дөлгөж, өвс ногоо зулгааж болохгүй. | Боржигон овогтой Л. Сайнхүү, нас 56, эмэгтэй | Гавилууд баг, Задгай Улаан Толгой өвөлжөө |
| 136 | Хавцлын Ам дархан газар | Дөрвөлж уулын зүүн хойно, сумын төвөөс 8 км зайд энэ толгой байдаг. Онгон даг-шин газар юм. Тэнд нутагласан айлын нөхөр нь удаан хугацаанд өвдөж, нас барсан. | Мөнхжин овогтой Д. Дамдинсүрэн, нас 65 | Алаг Баян баг Ухаа Заг өвөлжөө |
| 137 | Цагаан Овоо | Цагаан Овоо нэртэй энэ газар нь Дөр-вөлж ууланд Ухаа Заг өвөлжөөний ба-руун талд байдаг. Гэрийн хаалгаа тэр зүг рүү харуулж барих хориотой, хэрэв тэг-вэл мал сүрэгт муу нөлөөтэй. Би хүүхэд байхад манайх тэнд нутагладаг байсан ба олон ботго үхсэн. Равжаа Хутагт тэнд гэ-рээ барьсан ч гэр нь босоогүй. Тэгээд л энийг дийлэх хүч надад алга гэж бууж өгсөн. | Мөнхжин овогтой Д. Дамдинсүрэн, нас 65 | Алаг Баян баг Ухаа Заг өвөлжөө |
| 138 | Хойд нуувч | Хятадын худалдаачид, цэргүүдийг отож нууцаар хардаг газар. Тэнд хамгаалах нууц газар олон бөгөөд Ундайн голыг хя-тад цэргүүд бохирдуулахаас хамгаалдаг байсан гэж тэд хэлдэг. | Биндэръяа Ц, нас 32 | Үйлсэн хөөвөр өвөлжөө |
| 139 | Элэгний Уулын хяр | Хайлаас, бүйлс мод ургадаг, хөндөж болохгүй онгон догшин газар. Чийгтэй үед нь өвс ногоо зулгааж, мал бэлчээж болохгүй, дүн өвөл бол болно. | Боржигон овогтой овогт Доржийн Туяа, 52 настай, эмэгтэй | Гавилууд баг, элэгний усны ханангийн бууц |
| 140 | Хараат Хайрхан онгон уул | Бор цай, архи өргөдөг Хар овоо нь онгон догшин газар юм. Энэ газрын ойролцоо мал алж болохгүй. 10 жилийн өмнө Ган-бат шулаа хийж цээрлэл хүртсэн. Туяа- | Ханхэнтий овогт Б. Баатарчулуун, нас 28 | Гавилууд баг, Хайрханы өвөлжөө |

| | Тахилгат болон хориотой газруудын нэр | Төрөл, холбогдох ёс заншил, түүх домог | Шүтдэг ард (нэр, хамаатан садны нэр, нас) | Баг ба өвөлжөө |
|---|---|---|---|---|
| | | гийн нөхөр Хараат Хайрханд ирвэс агнаад нас барсан. Цэмпэлмаагийн нөхөр газар ухаад нас барсан. Нутгийн хүмүүс нэрийг нь дурдахыг цээрлэдэг. | | |
| 141 | Замын Улааны Буу газар | Олон жилийн өмнөөс хий үзэгдэлтэй гэж яригдаж ирсэн онгон догшин газар. 2009 онд Цогцолмаагийн ах шөнө дунд тэнд явж байгаад нохой хөтөлсөн ногоон дээлтэй хүн явахыг харжээ. | Булцэн овогт Ц. Төмөртогоо, нас 30 | Гавилууд баг, Эхэн Халив голын Төмөрт өвөлжөө |
| 142 | Төмөрт өвөлжөөний булш | Булшинд хүрэх, ухахыг хориглодог. Хоёр булш байдаг ба нутгийн нэг залуу нэгийг нь ухаад 2-3 жилийн турш өвджээ. | Булцэн овогт Ц. Төмөртогоо, нас 30 | Гавилууд баг, Эхэн Халив голын Төмөрт өвөлжөө |
| 143 | Төмөрт өвөлжөөний овоо | Цагаан сарын шинийн нэгэн, гурванд дээдсээсээ уламжлан тахиж ирсэн. Урд зүг рүү буун дуу гаргаж аян замын барцдаа гаргадаг заншилтай. | Булцэн овогт Ц. Төмөртогоо, нас 30 | Гавилууд баг, Эхэн Халив голын Төмөрт өвөлжөө |
| 144 | Таван Толгой | Дээдсээс шүтэж ирсэн ба мал сүргээ эндээс харж хамгаалдаг. Сүүлийн жилүүдэд эндээс гадагш явахдаа тахьдаг заншилтай болсон. | Булцэн овогт Ц. Төмөртогоо, нас 30 | Гавилууд баг, Эхэн Халив голын Төмөрт өвөлжөө |

**Хүснэгт 16 Өмнөговь аймгийн биет бус өв**

| | Биет бус өвийг өвлүүлэн уламжлуулах арга зам | | | Биет бус өвийн үнэ цэнэ, ач холбогдол | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Биет бус өвийн төрөл | Биет бус өв тээгч | Мэдлэг, чадвараа өвлүүлэн уламжлуулах арга зам | Тархалт (газар нутаг) | Хамрах хүрээ (хүмүүс) | Өнөөгийн байдал, ирээдүйн хандлага | Хэнд ач холбогдолтой вэ | Аюулд ороод байна уу? |
| 1 | Төмрийн дархан | Ханбогд сумын Жавхлант багийн иргэн Борхүү шиг тухайн мэдлэг, чадварыг ахмад гар урлаачдаас эсвэл сургалтаар дамжуулан сурч авсан хүмүүс, | Тухайн мэдлэг, чадвар нь удам дамжин өвлөгдөөгүй. Бие даан суралцсан. | Өв уламжлагдан ирсэн мөнгөн аяга, бугуйвч нь газар сайгүй тархсан байдаг. | Тухайн эд зүйлсийг өвлөн авсан хүнийг тодорхойлоход хэцүү. | Төмрийн дархны урлал нь энэ бүс нутагт сайн хөгжсөн бөгөөд мөнгөн аяга, эмээл, эмээлийн тоноглолын эрэлт ихтэй байдаг. | Айл өрх болгонд мөнгөн аяга байх бөгөөд тэр нь утга учиртай байдаг. Эртний хийц нь мартагдаж байгаа бөгөөд шинэ хийц загвар хөгжиж байна. | Ноцтой аюулд ороогүй байна. Төмрийн дархан ялангуяа алт мөнгөний дархан олширч байна. |
| 2 | Бусад материаллаг соёл: Хөөрөг, модон торх, эсгий хийх, мал амьтны гаралтай бусад зүйлс | Малчин айл өрх бүрт өвлөгдөн ирсэн хөөрөг байдаг бөгөөд модон торх, эсгий ширдэг, мал амьтны гаралтай эд зүйлс хэрэглэдэг. | Өвөг дээдсээс өвлөгдөн үлдсэн | 4 суманд бүгдэд нь | Малчин айл өрх | Их хэрэглэдэг | Өвлөгдөн үлдсэн эдгээр эд зүйлс нь өвөг дээдсийн талаар чухал мэдээлэл агуулсан байдаг. | Ноцтой аюулд учраагүй. Социалист дэглэм нуран унасны дараа энэ нь эргэж сэргэсэн бөгөөд анхаарал хандуулах болсон. |

| | Биет бус өвийг өвлүүлэн уламжлуулах арга зам | | | Биет бус өвийн үнэ цэнэ, ач холбогдол | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Биет бус өвийн төрөл | Биет бус өв тээгч | Мэдлэг, чадвараа өвлүүлэн уламжлуулах арга зам | Тархалт (газар нутаг) | Хамрах хүрээ (хүмүүс) | Өнөөгийн байдал, ирээдүйн хандлага | Хэнд ач холбогдолтой вэ | Аюулд ороод байна уу? |
| 3 | Монгол гэр хийх болон гэрт амьдрах | Ихэнх малчин айлууд гэрт амьдардаг бөгөөд гэрийн талаар мэдлэгтэй байдаг. | Хэдийгээр Өмнөговь аймагт уламжлалт гэрийн урлал өөрчлөгдөж гэр хийх нь багасч байна. | 4 суманд бүгдэд нь | Бүх малчин айл | Цөөхөн хэдэн тохиолдлыг эс тооцвол их хэрэглэж байна. | Малчдын нүүдэлчин амьдралын хэв маягт гэрт амьдрах нь илүү тохиромжтой. Гэхдээ уламжлалт тавилга хэрэглэх нь багасч байна. | Одоогоор ноцтой нөлөө илрээгүй. Гэсэн хэдий ч мал маллахаас зайлсхийж сумын төв рүү шилжиж байгаа нь урт хугацааны сөрөг нөлөөтэй. |
| 4 | Шашин шүтлэг: Бурхны шашин болон бөө мөргөл | Сүсэгтэн олон, лам хуврага, бөө | Өвөг дээдсээс өвлөгдөн үлдсэн бурхан шүтээн, ном судар | 4 суманд бүгдэд нь | Ард иргэд | Их хэрэглэдэг. | Ард иргэдэд ач холбогдолтой | Бурхны шашин хөгжин цэцэглэж байна. Хэдийгээр христийн шашин дэлгэрч байгаа нь аюул болovч, хүмүүсийн сүсэг бишрэл алдагдах нь илүү аюултай. |

| | Биет бус өвийг өвлүүлэн уламжлуулах арга зам | | | Биет бус өвийн үнэ цэнэ, ач холбогдол | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Биет бус өвийн төрөл | Биет бус өв тээгч | Мэдлэг, чадвараа өвлүүлэн уламжлуулах арга зам | Тархалт (газар нутаг) | Хамрах хүрээ (хүмүүс) | Өнөөгийн байдал, ирээдүйн хандлага | Хэнд ач холбогдолтой вэ | Аюулд ороод байна уу? |
| 5 | Бурхан шүтээн, зан үйлийн объект | Ихэнх айл өрх, томчууд, ахмадууд үүнийг мэднэ. | Өвөг дээдсээс өвлөгдсөн ирсэн эсвэл шинээр шүтэж биширч байгаа | 4 суманд бүгдэд нь | Айл өрх бүр | Өргөнөөр хэрэглэдэг | Сүсэгтнүүдэд ач холбогдолтой | Дээр дурдсанчлан |
| 6 | Хийцтэй цай – будаа, махтай сүүтэй цай | Малчин айл өрхүүд нь уламжлалт хоол ундаа хэрэглэдэг бөгөөд малчид хийцтэй цай болон үндэсний бусад хоолоо мэднэ. | Малчин айлуудын дунд дэлгэрч байна | 4 суманд бүгдэд нь | Бүх малчин айл өрх | Нүүдэлчин амьдралын хэв маягт өргөнөөр хэрэглэгддэг бөгөөд сум руу нүүвэл өөрчлөгдөнө. | Бүх малчин айлд ач холбогдолтой. Хүнсэнд хэрэглэдэг ургамлууд бараг мартагдсан. | Аюулд орсон. Хоол хүнсний талаарх уламжлалт мэдлэг, арга нь сумын төвд худалдаалагддаг бэлэн хүнсний улмаас мартагдаж байна. |
| 7 | Цулхирын гурил | Батаа, Раашням, Бүнтэн, Цэндээхүү гэсэн ахмадууд | Хүүхэд насандаа хийж байсан | 4 суманд бүгдэд нь | Ахмадууд болон тодорхой хүмүүсийн бүлэг | Үүнийг хүнсэндээ хэрэглэх нь багассан. Эмчилгээний журмаар түгээмэл хэрэглэгддэг. | Хүмүүс үүнийг бага зэрэг мэддэг. Энэ нь Өмнөговийн ургамал, түүнтэй холбоотой соёлын талаарх хүмүүсийн мэдлэгийн чухал хэсэг юм. | Аюулд учирсан. |

| | Биет бус өвийг өвлүүлэн уламжлуулах арга зам | | | Биет бус өвийн үнэ цэнэ, ач холбогдол | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Биет бус өвийн төрөл | Биет бус өв тээгч | Мэдлэг, чадвараа өвлүүлэн уламжлуулах арга зам | Тархалт (газар нутаг) | Хамрах хүрээ (хүмүүс) | Өнөөгийн байдал, ирээдүйн хандлага | Хэнд ач холбогдолтой вэ | Аюулд ороод байна уу? |
| 8 | Ураг төрөл Ургийн нэр болон ураг төрлийн холбоогоо сэргээх | Баян-Овоо сумандамьдардаг иргэн Сүхбаатар гэх мэт цөөхөн хэдэн хүмүүс л сайн мэддэг. Түүний гэр бүлийн гишүүд бүх хамаатнуудаа мэднэ. | Гэр бүл болон ургийн хүрээнд | 4 суманд бүгдэд нь | Засгийн газраас гаргасан ургийн овгийг сэргээх шийдвэртэй холбоотойгоор бүх айл өрхийг хамруулах | Иргэний үнэмлэх дээр бичигдэх ёстой. Бусад үүрэг нь тодорхойгүй | Зарим овгууд цуглаарч, баяр наадам зохионо. | Эргэн сэргэж байна. |
| 9 | Уртын дуу, магтаал | Цэнзэн, Батаа, Авираа, Бямбаа зэрэг ахмадуудаас суралцсан уртын дуучид | Бие даан суралцсан болон гэр бүлийнхээ хүрээнд уламжлан авсан. | 4 сумдад бүгдэд нь | Сум бүрт 2–3 хүн | Хэдийгээр сонирхож байгаа боловч, ая, шүлэг нь мартагдсан. Нэр нь үл мэдэгдэх тууль хайлах сонирхолтой. | Тууль хайлаачид нь удахгүй устаж үгүй болох эрсдэлтэй байгааг ойлгож, анхааралдаа авах. | Социализмын үеийн үл ойшоох, дарах явдал сөргөөр нөлөөлсөн. Тодорхой хэмжээгээр аюулд учирсан. |

| | Биет бус өвийг өвлүүлэн уламжлуулах арга зам | | | Биет бус өвийн үнэ цэнэ, ач холбогдол | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Биет бус өвийн төрөл | Биет бус өв тээгч | Мэдлэг, чадвараа өвлүүлэн уламжлуулах арга зам | Тархалт (газар нутаг) | Хамрах хүрээ (хүмүүс) | Өнөөгийн байдал, ирээдүйн хандлага | Хэнд ач холбогдолтой вэ | Аюулд ороод байна уу? |
| 10 | Тоглоом: чулуугаар гэр барих, шагай нэслах | 40-өөс дээш насны малчид чулуугаар гэр барьж тоглодог байсан. Гэвч одоо шагай тоглохоо бараг больсон. | Нүүдэлчин амьдралын хэв маягаасаа сурсан. Ахмадуудаасаа болон бие даан, эсвэл багийн гишүүн болон тоглох маягаар суралцсан. | 4 суманд бүгдэд нь | Тоглоомчдын дунд 40-өөс дээш насны ахмадууд хамрагдсан. | 1990 оноос хойш мартагдаж эхэлсэн | 40-өөс дээш насныханд чухал үнэ цэнэтэй. Нүүдэлчин амьдралын хэв маягтай холбоотой өвийн чухал төрөл. Уламжлалт зан заншлаа суралцах ач холбогдолтой | Шагай тоглох нь эргэж сэргэсэн боловч бусад нь мартагдсаар байна.<br>- Аюулд учирсан. |
| 11 | Говийнхны цээрлэх ёс | Малчин айлууд уламжлалт зан заншил, хорио цээрийн ёсоо дагаж мөрддөг. | Нүүдэлчин амьдралын хэв маягаасаа суралцсан. | 4 суманд бүгдэд нь | Малчин айл өрхийн хүрээнд уламжлагдсан | Хорио цээрийн ёсыг дагаж мөрдөх нь багасч байна. Үүнийг маш олон төрлөөр тайлбарлаж байна. | Хорио цээр нь зохион байгуулалт, ёс заншил, соёлын утгыг агуулдаг. | Социализмын үед үүнийг нухчин дарж байсан учраас энэ талын мэдлэгийг үлэмж хэмжээгээр мартагнуулсан. Аюулд учирсан |

| | Биет бус өвийг өвлүүлэн уламжлуулах арга зам | | | Биет бус өвийн үнэ цэнэ, ач холбогдол | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Биет бус өвийн төрөл | Биет бус өв тээгч | Мэдлэг, чадвараа өвлүүлэн уламжлуулах арга зам | Тархалт (газар нутаг) | Хамрах хүрээ (хүмүүс) | Өнөөгийн байдал, ирээдүйн хандлага | Хэнд ач холбогдолтой вэ | Аюулд ороод байна уу? |
| 12 | Өвт газар, тахилгат газар | Сум болгоны иргэн бүр тахилгат газартай ямар нэгэн холбоотой байх болно. Эргээд тэдний гэр бүл, ураг төрөл, сумтайгаа холбогдоно. | Гэр бүл, хамаатан садан, сумын түвшинд суралцсан | 4 сумдад бүгдэд нь | Хүн бүр | Зарим тахилгат газар нутгийг заримдаа тахьдаг бөгөөд бусад нь бараг мартагдсан. Ерөнхийдөө газар нутгийг тахин шүтэх нь эргэн сэргэж байна. | Монголын алслагдсан газраас ирсэн хүмүүсээс бусад бүх хүнд чухал үнэ цэнэтэй (залуучуудад ач холбогдол багатай байж магадгүй) Гадаадынханд чухал биш. | Аюулд учирсан Уул уурхай, дэд бүтэц болон газар ашиглалтаас шууд шалтгаалсан |

### 4.17.2 Биет бус өвийн аль хэсэг эрсдэлд өртөөд байна вэ?

Биет бус өвийн хамгийн их эрсдэлтэй хэсэг нь одоо хэрэглэгдэх нь багасч байгаа уламжлал ёс заншлын талаарх мэдлэг юм. Түүнчлэн хойч үедээ уламжлалт мэдлэг дамжуулдаг арга зам бас өөрчлөгджээ.

Үүний жишээ болгон бид Уртын дууг авч үзэж болох юм. Уртын дууч Цээнзэн гуайн үзэж байгаагаар говийн уртын дууны уламжлал бараг тасарч байна. Бидний хээрийн судалгааны ажлын явцад олж мэдсэнчлэн уламжлалт дуу хөгжмийн уламжлал тасарч байна гэсэн Цээнзэн гуайн таамаглал үнэн байна. Уламжлалыг өвлөн үлдээдэг заншил тасарч цөөхөн хэдэн хүмүүс л ур чадвартай дуучдаас суралцахыг хүсдэг болжээ. Говийн уртын дууны уламжлалд уртын дууны үгийг шинээр зохиох буюу өөрчлөх чиг хандлага үүсчээ. Ингэснээр дууны үгийг буруу алдаатай дуулж сурахад хүргэж байна. Дууны үгийг дараа үеийнхэндээ зөв сургах шаардлагатай байгаа ч одоохондоо энэ арга хэмжээг зохион байгуулалттай хийхгүй байна. Тодорхой мэдлэг мэдээлэлгүйн улмаас Өмнөговь аймгийн биет бус өвийн уламжлал бараг тасрах гэж байна.

Бидний хээрийн судалгааны ажлаас үзвэл уламжлалт хорио цээрийн заншил бас орчин үед уусан алга болж байна. Хүмүүс энэхүү уламжлал хорио цээрийг даган мөрдөхөө больж, зарим нь хуучин хорио цээрийг шинээр тайлбарлах болжээ. Тиймээс энэ нь шинэ хорио цээр үү, хуучин уламжлал уу гэдгийг ялгахад маш түвэгтэй болсон байна. Уламжлалт зан үйлийг шинээр тайлбарлах боломжтой. Жишээ нь, Батаагийн бидэнд тайлбарласнаар Баян-Овоо суман дах 4 овоог хүмүүс одоо тахихаа больсон гэнэ. Учир нь эдгээр овоог тахиж шүтдэг байсан хүмүүс байхгүй болсноос энэ овоог тахихаа байсан гэнэ. Өөрөөр хэлбэл, овоо нь ариун нандин хэвээрээ ч дахин тахихаа больжээ. Батаагийн дүгнэн хэлснээр хэрэв тодорхой тахин шүтдэг хүмүүс байхгүй бол тухайн овоог тахихаа болино гэсэн үг ажээ. Гэхдээ л энэ овоо ариун нандин газар хэвээрээ үлдэнэ. Хэрэв тухайн дурсгалтай холбоотой ёс заншил мартагдвал уг овоо илүү түгээмэл хорио цээрийн заншилтай хамааралтай болдог гэнэ.

## 4.18 Дүгнэлт

Өмнөговь аймаг нь түүх дурсгалын олон газартай байдгийн ихэнхи нь нүүдлийн аж амьдрал дээр үндэслэсэн байдаг. Эдийн засгийн хөгжил нь соёлд урьдчилан таамаглах боломжгүйгээр нөлөөлдөг. Соёлын Өвийн Хөтөлбөрийн зорилго нь соёлын харилцааг зогсоох бус харин орон нутгийн иргэдийн энэхүү өөрчлөлт, тэдний хамгийн их хүндлэн дээдэлдэг, тэдний өдөр тутмын амьдралд шууд нөлөөлдөг соёлын асуудлуудын талаар өөрсдийн дуу хоолойг илэрхийлсэн илэрхийллийг тусгасан байх ёстой.

# 5. ОЛОН НИЙТИЙН ХӨТӨЛБӨР

**Ж.Гэрэлбадрах**

СӨХ боловсруулах төслийн олон нийтийн хөтөлбөрийн гол анхаарч ажиллаж буй чиглэлүүд нь нутгийн иргэд болон тухайн газар түр хугацаагаар зочилж буй иргэдэд соёлын өвийг хэрхэн зөв тайлбарлан таниулах вэ? гэдэг асуудал юм. Олон нийтийн хөтөлбөрийн дэвшүүлж буй гол чиглэлүүд нь: боловсрол, музей, аялал жуулчлал юм.

Уг бүлгийн агуулга ном зүйн судалгааны үр дүнгээр эхлэж байгаа бөгөөд бусад багуудын нэгэн адил тухайн орон нутгийн түүхэн дурсгалт газрууд, аялал жуулчлал болон боловсролын зорилгоор хөгжүүлж болох газруудыг урьд өмнө хэвлэгдсэн ном зохиол ашиглан тодорхойлохоор судалгаагаа эхлүүлсэн юм. Хамгийн эхэнд авч үзсэн асуудал нь ирээдүйд аялал жуулчлалын зорилгоор ашиглаж болох газруудыг тодорхойлох явдал байв. Үүний тулд боломжит ном, хэвлэмэл баримтуудыг судлахаас гадна музей, боловсрол, аялал жуулчлал хөгжүүлэх боломжийн талаар нутгийн иргэд, албаны хүмүүс, бусад холбогдох газруудтай уулзалтууд хийж, хээрийн судалгаа хийж мөн гүйцэтгэлээ. Аймаг, сум орон нутгийн боловсролын газрууд, музей, соёлын төвүүд болон аялал жуулчлалын одоогийн нөхцөл байдал, тэднийг хэрхэн сайжруулж СӨХ-ийг боловсруулах нь зүйтэй талаар мөн уг бүлэгт дурьдав.

Олон нийтийн хөтөлбөрийн баг нийт 3 удаагийн хээрийн судалгаа хийсэн ба тайлангуудыг Хавсралт 10-13-д харуулав.

## 5.1 НОМ ЗҮЙН СУДАЛГАА

Өмнөговь аймгийн соёлын өвтэй холбоотой мэдээллийг (a) түүхэн эх сурвалж; (b) архивын баримтууд; (c) ном зүйн судалгаа гэж 3 ангилж болно. Монгол нутагт хүн амьдарч байсан хуучин болон дунд шинэ чулуун зэвсгийн үед холбогдох олон дурсгалт газрууд бий. Эдгээрийг судалсан олон судалгааны зохиол бүтээлүүд биет өвийн тайланд тодорхой тусгагдсан тул энд үл өгүүлэв.

Монголын дунд үеийн түүхийн судалгааны гол хэрэглэдэхүүн болдог "Монголын нууц товчоо", Рашид ад-дины "Судрын чуулган", нэр үл мэдэгдэх зохиогчийн "Шар тууж", Саган Сэцний "Эрдэнийн товч" зэрэг түүхийн сурвалж бичгүүдэд нэр нь гардаг түүхт газар ус Өмнөговь аймгийн нутагт цөөнгүй байдаг. Тухайлбал, "Монголын нууц товчоон"-д Хэрэйд улсын хаан Тоорилын нэг суурин Дидиг сахалын Нэгүн ус гэдэг газар байсан хэмээн гардаг нь одоогийн Өмнөговийн нутаг юм. Өмнөговь аймгийн нутаг бол тэр үеийн Хэрэйд улсын өмнөд нутагт багтаж байсан билээ.

1487-1517 онуудад тархай салангид монголчуудыг нэгтгэн захирч байсан Батмөнх даян хааны амьдрал, үйл ажиллагааны зарим хэсэг Өмнөговь аймгийн нутагт өрнөж байсан ба түүний нас барсан газар мөн тус аймгийн нутагт байгаа хэмээн үзэж байгаа билээ. Тэр талаарх мэдээ сэлт Саган сэцний "Эрдэний товч", "Шар тууж" зэрэг сурвалжид тэмдэглэгдсэн байдаг.

XVII-XX зууны эхэн үед монголчууд төрийн тусгаар тогтнолоо алдаж, Манжийн эрхшээлд орсон үед өнөөгийн Өмнөговь аймгийн нутаг дээр Халх Монголын гурван хошуу оршиж байсан байна. Тэдгээр нь Түшээт хан аймгийн Түшээт засаг, Мэргэн засаг, Сайн ноён хан аймгийн Ёст засгийн хошуу юм.

Халхын Түшээт хан аймгийн Түшээт засгийн хошуу нь одоогийн Өмнөговь аймгийн Мандал-Овоо, Цогт-Овоо, Цогтцэций, Номгон, Даланзадгад, Ханхонгор, Баян-Овоо сумдын нутаг болно. Түшээт хан аймгийн Мэргэн засгийн хошуунд Өмнөговь аймгийн Ханбогд сум багтаж байв. Халхын Сайн ноён хан аймгийн Ёст засгийн хошуунд одоогийн Өмнөговь аймгийн Хүрмэн, Баяндалай, Ноён, Сэврэй, Гурвантэс сумдын нутаг орж байсан байна.

Халхын энэ гурван хошууны түүхэнд холбогдох архивын баримт сэлт Монгол улсын Үндэсний Төв Архивт хадгалагдаж байна. "Соёлын өвийн хөтөлбөр"-ийн Олон нийтийн хөтөлбөрийн судалгааны ажлын хүрээнд Өмнөговь аймгийн түүхэнд холбогдох одоогоор эртний хэмээн үзэх архивын баримтын судалгааг хийж, тэр үед холбогдох баримт бүрийг хошуу тус бүрээр нь нарийн тодорхойлон гаргасан юм.

Хүснэгт 17 Түшээт хан аймгийн Түшээт засаг болон Мэргэн засаг, Сайн ноён хан аймгийн Ёст Засгийн хошууны түүхэн баримтын тоо

| | Хошууны Нэр | Хөмрөгийн дугаар | Хамрах цаг хугацаа | Тоо | Одоогийн засаг захиргааны нэгж | Түүхэн нэршил |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Халхын умар замын зүүн гарын умард хошуу | М-17 | 1731-1911 | 391 | Мандал-Овоо, Цогт-Овоо, Цогтцэций, Номгон, Даланзадгад, Ханхонгор, Баян-Овоо сумд | Түшээт хан аймгийн Говь Түшээт засгийн хошуу |
| 2 | Халхын умар замын зүүн гарын дундад хошуу | М-16 | 1741-1911 | 236 | Ханбогд сум | Түшээт Хан аймгийн Мэргэн засгийн хошуу, |
| 3 | Халхын умар замын зүүн гарын баруун этгээдийн хошуу | М-66 | 1815-1911 | 815 | Хүрмэн, Баяндалай, Ноён, Сэврэй, Гурван Тэс | Сайн ноён хан аймгийн Ёст засгийн хошуу, |

### 5.1.1 Түшээт хан аймгийн Түшээт засгийн хошууны баримтын товч тойм

Түшээт засгийн хошууны баримт цэрэг дайчлан мордуулсан тухай жанжинд өргөсөн айлтгал, тус хошууны эр хэмжээлсэн данс (цэргийн насны эрчүүдийн бүртгэл), хошууны дотор алба хуваасан данс, ноёд тайж нар зэрэг залгамжилсан, турж үхсэн хүмүүсийн бүртгэл, тайж нарын бүртгэл, тамгын жасаанаас олон газарт явуулсан баримтын хуулга данс, газар нутаг булаацалдсан, хүний морь мал хулгайлсан, сүмд нэр шагнах, хошуу нутгийн захыг тогтоох, лам нарыг бүртгэсэн, худалдааны хятад иргэдэд тэмдэгт бичиг олгох зэрэг бичгүүдээс бүрдэж байна.

### 5.1.2 Түшээт хан аймгийн Мэргэн засгийн хошууны баримтын товч тойм

Мэргэн засгийн хошууны баримт газар нутаг булаалдсан, хошууны өрх ам, малыг тоолж бүртгэсэн, цэрэг эрсийн бүртгэл, алба оногдуулсныг тэмдэглэсэн, шавь болгон өргөсөн, хамжлага олгосон, анги хороонд суугаа цэргийн уналга агт, им, тэмдэг, шүд зүс зэргийг тэмдэглэсэн данс, мөн хошуудад явуулсан бичиг, хошуудын нутаг булаалдсан хэргийг шийдсэн, өв хөрөнгөө батлан өргөсөн, залгамжлуулсан, хүний эд хөрөнгийг дээрэмдсэн, үржил сүргийн дутууг төлүүлэх, жасаа болон бусад албанд суугчдын хэрэглэлийг гаргуулах, тамгын жасаанд суух түшмэл, бичээч нарыг томилсон, халсан, улааны зар бичиг хүргүүлсэн зэрэг нугалбар бичгээс бүрдэж байна.

### 5.1.3 Сайн ноён хан аймгийн Ёст засгийн хошууны баримтын товч тойм

Ёст засгийн хошууны баримт тус хошууны тамгын газраас олон газартай харилцсан болон хошууны тамгын жасааны түшмэд, бичээч нарын захиж хүлээлцсэн хэргийн тэмдэглэл, алба хуваасан данс, хошууны хүн ам, малын тооллого, цэрэг эрийн бүртгэл, Манжийн хааны үржил сүргийн тухай, хэргэм зэрэг олгох, алтны уурхай нээх тухай, ноёд, түшмэдэд олгосон цалингийн бүртгэл, хошууны ардын амьдрал ядуурсан тухай, Улиастай дахь Хятадын пүүсэнд төлсөн өрийн данс, хулгай дээрэм, өр авлага нэхэмжилсэн тухай, сүм хийд, хурал номын холбогдолтой баримтуудаас бүрдэж байна.

XIX зууны Халх Монголын том түүхчдийн нэг дөтгөөр зэргийн тайж Галдан Халхын Түшээт хан аймгийн Түшээт засгийн хошууны засаг ноёны туслагчийн албыг хашиж байх үедээ "Эрдэнийн эрих хэмээх түүх болой" хэмээх алдарт зохиолоо бичиж туурвисан ажээ. Түүний зохиосон "Эрдэнийн эрих хэмээх түүх болой" бол Халх Монголын түүхийн талаар бичигдсэн хамгийн том сурвалж зохиолд тооцогдоно. Галдан туслагчийн амьдарч байсан газар нь Өмнөговь аймаг юм.

Өмнөговь аймгийн нутагт байсан эрт ба дунд үеийн хот суурингууд, цэргийн хот бэхлэлтийн талаарх суурь судалгааг Т. Майдар хийж, "Монголын архитектур ба хот байгуулалт" гэсэн ном бичиж нийтлүүлжээ. Академич Б. Ринчингийн удирдлагаар туурвисан "Монгол ард улсын угсаатны судлал, хэлний шинжлэлийн атлас"-т Өмнөговь аймгийн түүх-соёлд холбогдох арвин хэрэглэгдэхүүн бий.

Сүүлийн үед Монголд улсад идэвхитэй хөгжиж буй орон нутгийн түүх судлалын ажлын үр дүнд Өмнөговь аймгийн өв соёл, сум орны түүх, тус аймгаас төрөн гарсан урлаг, соёл, боловсролын сайчуулын тухай олон ном зохиол гарсан байна. Ном зүйн судалгааны явцад цуглуулсан баримтад түшиглэн тэдгээрээс Олон нийтийн хөтөлбөрийн судалгааны ажилд хэрэглэх хэрэгтэй мэдээллүүдийг олж авах боломжтой болж байгаа юм.

"Соёлын өвийн хөтөлбөр"-ийн Олон нийтийн хөтөлбөрийн ном зүйн судалгааны явцад Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр дээр оршиж байсан бурхны шашны сүм хийд, хурал номын газруудыг олж тодорхойлов. Үүнийг Олон нийтийн хөтөлбөрийн нэг үндсэн хэсэг болох Соёлын өвийн аялал жуулчлалын шашны аялал жуулчлалд хэрэглэж болно. Эдгээрийг харьяалах сум, нэр, оршин байсан газрын нэрээр нь дурдав (Хүснэгт 78):

Хүснэгт 18 Бурхны шашны хурал номын газрууд

| | | |
|---|---|---|
| Гурвантэс сум | Гоёотын хурал | Сүмбэр ууланд буй |
| Гурвантэс сум | Уужимын хурал | Тост ууланд буй |
| Сэврэй сум | Цагаан суврагийн хурал | Сумын төв дээр буй |
| Сэврэй сум | Дуган голын хурал | Дуган голд буй |
| Ноён сум | Овоотын хийд | Овоот гэдэг газарт буй |
| Ноён сум | Цагаан суварга хурал | Тогоо хараат ууланд буй |
| Ноён сум | Ганзагтын хурал | Ганзагат гэдэг газар буй |
| Баяндалай сум | Байшинтын хийд | Байшинт гэдэг газар буй |
| Баяндалай сум | Ламын хүрээ | Хайрхан ууланд буй |
| Баяндалай сум | Уул жаргалантын хүрээ | Зүүн сайхан ууланд буй |
| Баяндалай сум | Цагаан дэрсийн хурал | Цагаан дэрс гэдэг газар буй |
| Мандал Овоо сум | Ханын цагаан суваргын хийд | Ханан гэдэг газар буй |
| Мандал Овоо сум | Шар хулсны хурал | Шар хулс гэдэг газар буй |
| Ханхонгор сум | Арцатын шилийн хийд | Таван ховоот гэдэг газарт |
| Ханхонгор сум | Шар довын хийд | Шар дов гэдэг газар буй |
| Ханхонгор сум | Маанийн хурал | Маанийн худаг гэдэг газарт |
| Даланзадгад сум | Балгасын хийд | Годил балгас гэдэг газарт |
| Хүрмэн сум | Шүлүүтийн хурал | Хүрмэн ууланд буй |
| Хүрмэн сум | Уртын хийд | Уртын булаг гэдэг газар буй |
| Хүрмэн сум | Цагаан уулын хурал | Энгэр шанд худаг гэдэгт |
| Номгон сум | Сангийн далай хийд | Сумын төв дээр буй |
| Номгон сум | Эхэн загийн хийд | Эхэн заг гэдэг газар буй |
| Номгон сум | Рашаантын хийд | Рашаант овоо гэдэг газарт |
| Номгон сум | Улаан эргийн хурал | Шандын улаан ууланд буй |
| Номгон сум | Булганы хурал | Цолгойн өндөр ууланд буй |
| Баян-Овоо сум | Налихын хурал | Налих гэдэг газар буй |
| Баян-Овоо сум | Долоон сүмийн хийд | Сумын төв дээр буй |
| Цогтцэций сум | Сайн бичгийн хийд | Балганы хоёр овоо гэдэгт |
| Цогтцэций сум | Лүнгийн хурал | Цагаан Овоо гэдэг газарт |
| Цогтцэций сум | Дашлин хурал | Эрдэнэ овоо гэдэг газарт |
| Манлай сум | Шүтээн хийд | Шүтээн хан богд ууланд |
| Манлай сум | Дөчийн хийд | Их Өлзийт ууланд буй |
| Манлай сум | Сэргэлэн тойн хийд | Гурван хараат ууланд буй |
| Манлай сум | Цохиотын хийд | Гурван хараат ууланд буй |
| Манлай сум | Цогт сүмийн хийд | Өгөөмөр овоо гэдэг газарт |
| Манлай сум | Цавчирын хийд | Цавчир гэдэг газарт буй |
| Манлай сум | Сүмбэр хийд | Сүмбэр овоо гэдэгт буй |
| Манлай сум | Баянбулагийн хурал | Баянбулаг гэдэг газарт буй |
| Ханбогд сум | Алаг баяны хийд | Алаг баян овоо гэдэгт буй |
| Ханбогд сум | Дэмчигийн хийд | Галбын ууланд буй |
| Ханбогд сум | Цагаан толгойн хийд | Галбын ууланд буй |
| Ханбогд сум | Улаан сахиусын хийд | Галбын уулны Бургас голд |
| Ханбогд сум | Цогцолын хурал | Түмэн Өлзийт овоо гэдэгт |
| Ханбогд сум | Бага модны хурал | Бага мод гэдэг газарт |
| Ханбогд сум | Агуйтын хурал | Баян ус худаг гэдэг газарт |

Эдгээр 46 хийд, хурал номын газраас Ханбогд сумын нутагт орших Галбын гурван хийд Дэмчиг, Улаан сахиусны буюу Рийтэрийн хийд, Цагаан толгойн, Алаг баяны хийд, Цогцолын хийд гэсэн таван газарзүйн байрлалыг нарийвчлан тогтоож, Соёлын өвийн газрын зурагт тусгуулсан билээ. Үлдсэн хийд, хурал номын газруудын туурь, үлдлийн нарийвчилсан байрлалыг сумдын Соёлын төвөөс эрхлэн "Соёлын өвийн хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хийж гүйцэтгэх бололцоотой хэмээн үзэж байна.

## 5.2 МУЗЕЙ

### 5.2.1 Шууд нөлөөллийн бүс дэх музей болон тэдгээрийн үйл ажиллагаа

**"Оюу Толгой"-н гууд нөлөөллийн бүсэд хэдэн музей, ямар нөхцөлд байна вэ?**

"Оюу толгой" төслийн шууд нөлөөллийн бүсэд орших Даланзадгад, Баян-Овоо, Ханбогд, Манлай гэсэн дөрвөн сумын музей, орон нутаг судлах кабинетийн нөхцөл байдал харилцан адилгүй байна. Өмнөговь аймгийн төв Даланзадгад суманд буй Аймгийн музейн төлөв байдлыг доор тодорхой өгүүлэх тул энд орхив.

Манлай сумын орон нутаг судлах музей нь тусдаа багавтар байшинд Номын сантай хамт байрладаг. Тус музей үзмэрийн хоёр том өрөөтэй ба үзмэрийн төрөл зүйл олноос гадна бусдын сонирхлыг татахуйц ажээ. Тэнд дэлгэн тавьсан үзмэрийн дэглэлт сайн, бүгд тайлбартай. Уг музей тохижолт, ая тух сайтай. Музейг номын санч давхар хариуцан ажилладаг. Манлай сумын музей зэргэлдээ орших Ханбогд, Баян-Овоо сумдын музей, орон нутаг судлах кабинетээс илүү сайн үйл ажиллагаатай байгаа нь Сумын засаг дарга Х. Сугирын тавьж буй анхаарал, Соёлын төвийн эрхлэгч Д. Отгонбатын ажилтай шууд холбоотой ажээ.

"Оюу толгой" төслийн шууд нөлөөллийн бүсийн гол нутаг Ханбогд сумын "Галба" музей нь тус суманд соёлын өвийг хадгалах, хамгаалах, сурталчлах, олон нийтэд зориулсан сургалт явуулах гол газар болох ёстой билээ (зураг 40). Уг музей анх 1994 онд музей, хийд хоёрыг хамтатган барьсан модонд байшинд байрлаж байсан ажээ. 2008 онд ХААН банкны тус сумын салбараас 10 сая төгрөг гаргаж, Соёлын төвийн баруун бөөрөнд залгаж тусгай байр барьж өгсөн байна. Тус музей 600 гаруй үзмэртэй нь сумын хэмжээнд баялаг үзмэртэйд тооцогдоно.

“Галба” музей хэмжээгээр жижиг боловч тусгай байртай, үзмэр ихтэй тул бусдаас илүү сайн, үлгэр жишээ музей байх боломжтой. Харин үзмэрийг зөв дэглэн байрлуулаагүй, хэсэг бусгаар нь бөөнд нь тавьсан байдал судалгааны ажил эхэлсэн 6 сарын турш яг хэвээр байна.

“Галба” музейн өнөөгийн төлөв байдал гэхүл,

- байр нь зориулалтын бус
- хэмжээгээр арай жижиг,
- үзмэр хадгалах тусгай сан хөмрөгийн өрөөгүй,
- музейн ажилтан суух тусгай өрөөгүй тул үзмэрийн танхимд удирдлагын үйл ажиллагаа явуулдаг,
- үзмэр худалдан авах хөрөнгө мөнгөгүй
- музейн ажилтан нь мэргэжлийн бус хүн зэрэг юм.

Музей хариуцсан ажилтан нь ажилдаа хойрго, идэвхигүй ханддаг нь багахан зүйлээр харагдаж байсныг дурдвал, бидний хэсэг судлаачид музейн үзмэрүүдэд тайлбар байхгүй байгааг сануулж тэдгээрийг монголоор бичээд орой зочид буудалд ирвэл дор нь англи болгоод өгье, хэвлээд тавиарай гэж гуйгаад хоёр орой хүлээгээд ирээгүйг хэлэх байна.

Ямар боловч, “Галба” музейд зориулалтын шинэ байр барих шаардлагатай гэсэн дүгнэлтэд хүрч байна. Шинэ байрны асуудлаас өмнө “Галба” музейд хийвэл зохих ажил нийлээд байгаа билээ.

“Галба” музейд цаашид хийх ажлууд гэвэл,

- үзмэрийг дахин бүлэглэж, 3-4 танхимд хуваан дэглэх,
- бүх үзмэрийн нэрийг монгол ба англи хэлээр бичиж тавих,
- үзмэрийн тоо бүртгэлийг хөтлөх,
- цонхонд хамгаалалтын сараалж төмөр хийх,
- олон нийтэд зориулсан сургалтын ажлын төлөвлөгөөтэй болох,
- музейн ажилтны мэдлэг боловсролыг дээшлүүлэх зэрэг юм.

“Галба” музей болон түүнийг шууд харьяалдаг сумын Соёлын төвөөс орчин цагийн музейд тавигддаг бүх шаардлагыг хангахын төлөө ажиллах хэрэгтэй болсныг цаг үе шаардаж байгааг зөвөөр ойлгож, зөв дүгнэлт хийх болжээ. Ингэхдээ хамгийн түрүүнд зэргэлдээ орших Манлай сумын музейн үйл ажиллагаатай танилцаж, түүний түвшинд хүрэх хэрэгтэй юм. Түүний дараагийн алхам нь музейн стандартад тавигдах бусад ажлуудыг хийх гүйцэтгэх явдал билээ. Мөн олон нийтэд зориулсан ажил, тэр дотроо сургуулийн сурагчдад зориулсан сургалтын ажлыг хийж эхлэх явдал зэрэг байгаа юм.

Энэ бүхэнтэй зэрэгцэн “Галба” музейд шинэ барилга барих асуудлыг одооноос эхлэн сумын ба аймгийн удирдлагад үе шаттайгаар тавьж шийдвэрлүүлэх нь зүйтэй байна. Бас тус суманд үйл ажиллагаа явуулдаг уул уурхайн компаниудаас авах нэмэр хандивын асуудлыг ч зохих түвшинд ярьж хөөцөлдөх хэрэгтэй юм.

Баян-Овоо сумын “Орон нутаг судлах музей” дүнзэн байшинд байрлаж байсан нь 2002 он галд өртөж шатсанаар ихэнхи үзмэр нь үгүй болжээ. Одоо нэгэнт байргүй болсон тул Соёлын төвийн хувцас солих өрөөнд ”Орон нутаг судлах кабинет” гэсэн нэрээр түр оршиж байна. Тусдаа музейн байртай болбол дотор нь тавих үзмэрүүдийг нутгийн иргэдээс олж цуглуулж болно хэмээн Соёлын төвийн эрхлэгч Б.Жүрмэддорж төлөвлөж байгаа ажээ. Тус сумын ”Орон нутаг судлах кабинет”-ийг Соёлын төвийн тасалбар түгээгч давхар хариуцан ажиллаж байна.

“Оюу толгой” төслийн шууд нөлөөллийн бүсийн сумдын музей, орон нутаг судлах кабинетийн нөхцөл байдал Өмнөговь аймгийн бусад сумдын адил төвшинд байна. Өөрийн тусгай зардал төсөвгүй учраас ямар нэгэн сургалт, үзэсгэлэн, соёлын арга хэмжээ зохион байгуулж чаддаггүй. Бас шинээр үзмэр худалдан авах хөрөнгө мөнгөгүй ажээ. Музей хариуцсан хүмүүс нь мэргэжлийн бус бөгөөд бүгд өөр ажилтай тул давхар хариуцан ажилладаг.

Энэ бүхнээс үзэхэд Өмнөговь аймгийн сумдын музей, орон нутаг судлах кабинетээр дамжуулан Соёлын өвийг хөтөлбөрийн гол арга хэмжээг явуулна хэмээн хөгжингүй орнуудын орон нутгийн музейн үйл ажиллагаатай адилтган үзэж, төлөвлөх нь өнөөгийн нөхцөлд бараг боломжгүй байна.

“Оюу толгой” төслөөс шууд нөлөөллийн бүсийн сумдад музейн зориулалтын байр барьж өгнө гэвэл эхний ээлжинд огт байргүй Баян-Овоо, Манлай суманд, дараа нь Ханбогд суманд гэсэн дараалллаар явах нь зүйтэй болов уу. Шинэ байр барихаас өмнө байгаа үзмэрээ сайтар дэглэх, бусдад үзүүлэн сурталчлах, олон улсын музейн стандартыг нэвтрүүлэх, олон нийтийн ажил зохиож эхлэх, ажилтны мэдлэг боловсролыг дээшлүүлэх, мэргэжлийн боловсон хүчнээр хангах зэрэг аймаг, сумын хэмжээнд шийдэх асуудлууд багагүй байна.

Мөн музейн зориулалтын техник хэрэглэл, дохиолол хамгаалал, үзмэрийн хорго зэргийг худалдан авахад зохих санхүүгийн дэмжлэг хэрэгтэй байгаа билээ. Аймгийн Боловсрол, Соёлын газраас эрхлэн зохион байгуулж сумдын музей, орон нутаг судлах кабинетүүдийг Монголын Үндэсний музейтэй нягт хамтран ажиллаж, сургалт хийж, мэргэжил–арга зүйн зөвлөгөө байнга авч өдөр тутмын ажилдаа тусгаж байх нь чухал юм.



**Зураг 40 Ханбогд Сумын Галба музей**

## 5.3 "Оюу толгой" төслийн шууд нөлөөллийн бүс дэх соёлын төвүүд

"Оюу толгой" төслийн шууд нөлөөллийн бүсийн сумдын Соёлын төвүүд бол уламжлалт Соёлын өвийг хадгалах, хамгаалах, сурталчлах тал дээр яг өнөөгийн нөхцөлд музейгээс илүү чухал үүрэгтэй байгааг онцлон тэмдэглэж байна. Соёлын төвүүдийн үйл ажиллагааг дэмжих замаар уламжлалт Соёлын өвийн хөтөлбөрийг зөв зохистой хэрэгжүүлэх бүрэн үндэстэй хэмээн үзэж байна. Энэ нь зөвхөн Олон нийтийн хөтөлбөртэй холбоотой ажил бус бөгөөд биет болон биет бусын өвийн судалгааны ажил ч үүнд багтаж байгаа юм.

*Баян-Овоо сумын Соёлын төв:* "Оюу толгой" төслийн шууд нөлөөллийн бүсийн Баян-Овоо сумын Соёлын төв (эрхлэгч Б. Жүрмэддорж) 1960-аад оны үед барьсан чулуун барилгад байрладаг. Халаалт байхгүй тул хүйтний улиралд Соёлын арга хэмжээ явуулахад хүндрэлтэй байдаг. Тус Соёлын төв эрхлэгч, бүжгийн багш, хөгжмийн багш, номын санч, тасалбар түгээгч (орон нутаг судлах кабинетээ давхар хариуцдаг) гэсэн 5 орон тоотой ажилладаг.

Нийтдээ 250 хүн суух үзвэрийн танхимтай. Тэнд морин хуур, даралтат хөгжим, бүжиг, ерөөл магтаал, уртын дуу гэсэн 5 дугуйлан хичээллүүлдэг бөгөөд тэдгээрт одоогоор 36 хүүхэд  суралцаж байна. Соёлын төвд сумын хамгаалалтад авсан биет соёлын өвт 8 газар, биет бус соёлын өвийг тээгч 6 хүнийг тус тус бүртгээд байна. Тэдгээр хүмүүсийн дуулсан уртын дуу, хуурдсан ая аялгуу,  хэлсэн ерөөл магтаалыг видео бичлэг хийх авах, биет бус өвийн гэрэл зураг, видео бичлэгийг үйлдэж, хувилан хадгалах ажил хийх шаардлагатай байгаа ажээ. Энэ ажлыг хийвэл тэдгээрийг Соёлын төвд хадгалж, сургалт дугуйланд хэрэглэх төдийгүй сумын сургуулийн сургалтад өргөн ашиглах бололцоо бүрдэх юм.

*Ханбогд сумын Соёлын төв:* (эрхлэгч Нарангэрэл) эрхлэгч, хөгжмийн багш, бүжгийн багш, номын санч, музейн ажилтан (тасалбар шалгагчийн хамт) гэсэн 5 ажилтантай. Соёлын төвд хөгжим, бүжиг, морин хуурын дугуйлан ажиллуулдаг бөгөөд түүнд 40 гаруй хүүхэд суралцдаг байна. Соёлын төв нь 200 гаруй хүний суудалтай. 2008 онд гадаадын хөрөнгө оруулалтаар 500 хүний суудалтай соёлын төв баригдсан боловч гүйцэтгэгч байгууллага муу хийснээс болоод ашиглалтанд ороогүй ажээ.

Сумын Засаг даргын захирамжаар сумын хамгаалалтанд авсан 34 газар байдгийг (Зураг 41) соёлын төв ерөнхийлөн хамгаалах, тордох ажлыг хийдэг байна. Тус Соёлын төвийн эрхлэгч Нарангэрэл санаачлан "Оюу толгой" төслөөс 2,8 сая төгрөгийн санхүүжилт авч, сумын биет соёлын өвт газруудын 33-т машины зогсоол, 24-т самбар, 12-т чулуун гортиг хийснийг сайшаан тэмдэглэж байна.




**Зураг 41 Ханбогд сумын Соёлын Төв**

*Манлай сумын Соёлын төв*: (эрхлэгч Д. Отгонбат) бусад сумдын адил дээрээс тогтоож өгсөн 5 орон тоотой. Тус сумын соёлын төв хоёр байртай. Эхнийх нь 152 хүн орох үзвэрийн танхим бүхий Соёлын төв юм. Хоёрдахь нь номын сан, орон нутаг судлах музей байрладаг байшин ажээ. Соёлын төвд морин хуур, ардын хөгжим, даралтат хөгжим, бүжгийн дугуйлан явуулдаг. Тэдгээрт 20 гаруй хүүхэд явж байна. Тус сумын хамгаалалтад биет соёлын 17 өв байдаг. Харин биет бус соёлын өв тээгч 23 хүний бүртгэлтэй.

Биет соёлын өвийн эвдэрч устахын зэрэгцээ соёлын биет бус өвүүд мартагдах аюул ирж байгаа ажээ. Тухайлбал, ингэ хөөсөлдөг, хонь тойглодог хүмүүс цөөрч байгаа тул тэдгээр үйл явц, дууг дүрсжүүлэн хадгалах хэрэгтэй байна. Соёлын биет болон биет бус өвийг баримтжуулж авах дуу хураагуур, видео бичлэг, гэрэл зургийн аппарат, GPS, ноутбуук, проектор зэрэг техник хэрэгслээр Соёлын төвүүдийг хангах нь зайлшгүй чухал болсон байна.

"Оюу толгой" төслийн шууд нөлөөллийн бүсийн Соёлын төвүүд Засгийн газраас тогтоож өгсөн эрхлэгч, бүжгийн багш, хөгжмийн багш, номын санч, тасалбар түгээгч (орон нутаг судлах кабинетээ давхар хариуцдаг) гэсэн 5 орон тоотой ажилладаг. Суман дахь соёлын үйл ажиллагааг хариуцан ажилладаг гол газар юм. Мэргэжлийн хувьд аймгийн Боловсрол, соёлын газарт, захиргаа санхүүгийн талаар сумын засаг даргын тамгын газарт тус тус харьяалагддаг.

Соёлын төвүүд сумын хамгаалалтад буй биет соёлын өвт газрууд болон биет бус соёлын өвийг тээгч хүмүүсийг бүртгэн өөрт буй боломжийн хүрээнд ажил зохион байгуулж байна. Тэдгээр хүмүүсийн дуулсан уртын дуу, хуурдсан ая аялгуу, хэлсэн ерөөл магтаалыг видео бичлэг хийх авах, биет бус өвийн гэрэл зураг, видео бичлэгийг үйлдэж, хувилан хадгалах ажил хийх шаардлагатай байгаа ажээ. Энэ ажлыг хийвэл тэдгээрийг Соёлын төвд хадгалж, сургалт дугуйланд хэрэглэх төдийгүй сумын сургуулийн сургалтад өргөн ашиглах бололцоо бүрдэх юм. Энэ талаар "Оюу толгой" төсөл тодорхой бичил хөтөлбөр зохиож, эдгээр хэрэгцээтэй зүйлсээр дээрх сумдыг хангах ажлыг хийх шаардлагатай хэмээн үзэж байна.

Сумын соёлын төв нь соёлын өвийн сургалт, сурталчилгааны гол газрын нэг болох тул соёлын өвийн талаарх ном хэвлэл, дүрс бичлэг, үзүүлэн, сургалтын ном, гарын авлага, гэрэл зураг зэргийг мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор хийж, хэвлүүлэн хувилж тараадаг байвал Соёлын өвийг хамгаалахад их тустай ажил болно. Энэ ажлыг Соёлын төвүүд өөрсдөө хийх санхүүгийн болон мэргэжлийн чадвар дутагддаг тул "Оюу толгой" төслөөс тодорхой дэмжлэг үзүүлж ажиллавал зохилтой байна.

### 5.3.1 Сумын соёлын төвүүдэд шаардлагатай нөөц ба санхүүгийн дэмжлэг

"Оюу толгой" төслийн шууд нөлөөллийн бүсийн сум болон сумдын Соёлын төвд шаардлагатай дэмжлэг туслалцааг а. Эд материалын дэмжлэг, б. Санхүүгийн дэмжлэг хэмээн хоёр хуваан авч үзвэл зохилтой.

"Оюу толгой" төслийн шууд нөлөөллийн бүсийн Ханбогд, Манлай, Баян-Овоо сумдын хамгаалалт ба бүртгэлд буй биет өв болон биет бус өвийг тээгч хүмүүсийн талаарх мэдээллийн иж бүрэн мэдээлийн сан байгуулах хэрэгтэй байгаа. Түүнд видео бичлэг, гэрэл зураг, газрын зураг, газарзүйн нарийвчилсан цэг тогтоох зэрэг ажлууд багтана. Энэ ажлыг хийхэд шаардагдах дуу хураагуур, гэрэл зургийн аппарат, видео бичлэгийн аппарат, байрлал тогтоох GPS, проектор, компьютер, зурагт зэрэг техник хэрэгслээр хангах ажлыг "Оюу толгой" төслөөс зохион байгуулж хангавал их үр дүнтэй ажил болно.

"Оюу толгой" төслийн дам нөлөөллийн бүсийн сумдад Өмнөговь аймгийн хамгаалалтад байдаг түүх, соёлын дурсгалт газруудад, харин "Оюу толгой" төслийн шууд нөлөөллийн бүсийн Ханбогд, Баян-Овоо, Манлай сумдын нутагт буй бүх биет соёлын өвийн хамгаалалтын бүс гортигийг нарийвчлан тогтоож, хашаа хайс, машины зогсоол, тайлбарын самбар, дурсгал руу орохыг ба салаа зам гаргахыг хориглосон тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу хийж байрлуулах ажил хийхийг "Оюу толгой" төсөлд албан ёсоор санал болгож байна.

Өмнөх хэсэгт дурдсан ёсоор "Оюу толгой" төслөөс шууд нөлөөллийн бүсийн сумдад музейн зориулалтын байр барьж өгнө гэвэл эхний ээлжинд огт байргүй Баян-Овоо, Манлай суманд, дараа нь Ханбогд суманд гэсэн дараалаар явах нь зүйтэй. "Оюу толгой" төслийн олзворлолтын явцад гарах ашигт малтмалын зарим олдворын дээжийг аймгийн болон шууд нөлөөллийн бүсийн сумдын музейд үзмэр болгон өгч байх нь зүйтэй.

Мөн шууд нөлөөллийн бүсийн сумдын Соёлын төвүүдэд тоног төхөөрөмж, үндэсний хөгжим, номын сангийн техник хэрэглэлийн судалгаа хийж, дутагдаж буй зүйлүүдийг шинээр худалдан нийлүүлбэл энэ нь эд материалын сайн дэмжлэг болно.

Санхүүгийн дэмжлэгийн тухайд гэвэл энэ нь ихэвчлэн сумдад зохион явуулах Соёлын өвийн арга хэмжээ, уралдаан тэмцээнийг ивээн тэтгэж зохион байгуулах явдал юм. Эдгээрийн заримыг хэлбэл,

- Говь нутагт тэмээний соёлыг улам бүр хадгалахын тулд, тэмээг уналга эдэлгээнд сургахад түлхэц үзүүлэх зорилгоор өндөр бай шагналтай тэмээний уралдааныг нас бүрээр (тором, тайлаг, ат, буур) жил бүр зохиож байгуулж байх нь зүйтэй. Ингэвэл тэмээ сургах, эдлэх ашиглах явдал их сайжрах юм.
- Үндэсний хувцасны асуудал их санаа зовоож байгаа тул үндэсний хувцас-малгай, дээл, хантааз, хүрэм, гуталны уралдааныг жил бүр явуулж, шагналыг нь өгдөг бол сайн байна.

- Монголын уламжлалт соёлын өвийг хадгалж, хамгаалах, сурталчлахад төрөл бүрийн уралдаан их тустай, түлхэц болохуйц арга хэмжээ болдог. Сумын морин хуурчдын, уртын дуучдын, бие биелгээний, суран хазаар-чөдөр-ногтны, морин хуур урлаачдын уралдааныг зохиож, бай шагнал олгодог бол хүмүүс их идэвхждэг. Учир нь Сумын засаг даргын тамгын газар болон болон Соёлын төвүүдэд тийм уралдаан зохиох ямар ч төсөв санхүү байдаггүй зовлонд оршино.

### 5.3.2 Өмнөговь аймгийн музейн үзмэрүүд

**Өмнөговь аймагт ямар үзмэртэй, нийт хэдэн музей байна вэ?**

Өмнөговь аймаг 15 сумтай бөгөөд сум бүрд музей эсхүл орон нутаг судлах кабинет бий. Аймгийн төв, Даланзадгад суманд Аймгийн музей оршдог. Тус музей нь үндсэн музей, Тэмээний үзэсгэлэн, Зүүн сайхан уулын Ёлын аманд байрлах Байгалийн музей гэсэн гурван хэсгээс бүрддэг. Үндсэн музей нь палеонтологи, түүх, угсаатны зүй, шашин гэсэн үндсэн 4 танхим, 2500 орчим үзмэртэй. Музейн одоо байрлаж байгаа байр хуучирч муудсан тул 3 тэрбум төгрөгийн өртөгтэй шинэ байр бариулахаар зураг төслийг нь хийлгэж, газрын асуудлыг шийдсэн нь сайшаалтай. Одоо барилга бариулах хөрөнгө санхүүг хөөцөлдөж байна.

Зүүн Сайхан уулын Ёлын аман дахь Байгалийн музей нь амьтан, ургамлын төрөл зүйлийн үзмэртэй, жуулчид ихээр сонирхон үздэг газар юм. Аймгийн музей хөдөө сумдаар явж, явуулын үзэсгэлэн зохион байгуулах боломжтой боловч төсөв зардал их гардагаас тэр болгон явж чаддаггүй байна. Жилд 4,5 сая төгрөгийн үзмэр худалдан авах төсөвтэй.

Өмнөговь аймгийн музейн өнөөгийн нөхцөл байдлыг Монгол улсын бусад аймгуудын музейн адил төвшинд байна хэмээн үзэж байна (Зураг 42). Харин уул уурхай эрчимтэй  хөгжиж буй, соёлын өвийн асуудал чухлаар тавигдаж буй бүс нутгийн музей хэмээн авч үзвэл хийх ажил их байгаа нь мэдээж хэрэг юм. Тус музей, аймгийн удирдлага болон өөрийн нөөц бололцоо, мөн бусад компаниудын дэмжлэгтэйгээр 2010 оны 10 сарын 22-нд "Тэмээний үзэсгэлэн" байгуулсан нь их чухал ач тустай ажил болсныг онцлон тэмдэглэж байна.




**Зураг 42 Өмнөговь аймгийн музей (зүүн); Тэмээний үзэсгэлэн (баруун)**

Музейн үзмэрийн баяжилт хийхдээ тэмээ, ашигт малтмал, палеонтологи гэсэн гурван чиглэлийг гол болгосон нь зөв байж болович хэт ингэж явцууран бусад зүйлийг орхигдуулах нь яваандаа сөрөг үр дагавартай байж болохыг анхаарах хэрэгтэй.

Өмнөговь аймгийн ихэнхи сум бие даасан музейгүй. Сумын соёлын төвийн 1-2 өрөөг тохижуулан Орон нутаг судлах кабинет байгуулан ажиллуулж байгаа. Аймаг болон сумын төсөвт музейн ажилтны орон тоо байхгүй тул Соёлын төвийн тасалбар түгээгч-шалгагч, эсвэл номын санч музейгээ давхар хариуцан ажилладаг ажээ. Энэ нь сумын музей, орон нутаг судлах кабинетийн ажилд муугаар нөлөөлдөг нь илэрхий. Мөн сумдын музей, орон нутаг судлах кабинетэд үзмэр худалдан авах хөрөнгө мөнгө байдаггүй тул үзмэрийн баяжилт хийх ямар ч боломжгүй гэсэн үг юм.

Өмнөговь аймгийн сумдын музей, орон нутаг судлах кабинетэд тусгайлсан төсөв байхгүй тул ямар нэгэн сургалт, үзэсгэлэн, соёлын бусад арга хэмжээ зохион байгуулах бололцоогүй болж байгаа юм. Ийм хүндрэлтэй байдал зөвхөн Өмнөговь аймгийн төдийгүй нийт Монгол улсын сумдын музей, орон нутаг судлах кабинетэд нийтлэг оршиж байна.

Зүй нь музей бол дан ганц үзмэр хадгалдаг, дэлгэн үзүүлдэг газар төдийгүй олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгаа явуулдаг, орон нутгийнхаа хэмжээнд тодорхой сэдвээр судалгаа хийдэг мэргэшсэн газар байх ёстой билээ.

### 5.3.3 Өмнөговь аймгийн шинэ музейд тавигдах шаардлага

"Оюу толгой" төсөл Өмнөговь аймгийн Даланзадгад суманд шинээр баригдах шинэ музейн барилгын санхүүжилтэд "Таван толгой", Энержи ресурс" зэрэг бусад уул уурхайн компаниудтай хамтран оролцвол сайн юм (Зураг 43). Мөн уул уурхайн олзворлолтын явцад гарах ашигт малтмалын эд зүйл болон гарч болзошгүй палеонтологийн олдвор (үлэг гүрвэлийн өндөг, яс гэх мэт)-уудыг аймгийн болон шууд нөлөөллийн сумдын музей, орон нутаг судлах кабинетэд шилжүүлэн өгдөг байж болно.





**Зураг 43** **Аймгийн музейн шинээр барихаар төлөвлөөд байгаа барилгын бүдүүвч зураг**

# 5.4 БОЛОВСРОЛ

## 5.4.1 Соёлын өвийг боловсролтой уялдуулах нь

**Боловсролын системд соёлын өвийн асуудлыг хэрхэн тусгасан вэ?**

“Оюу толгой” төслийн “Соёлын өвийн хөтөлбөр”-ийн нэг үндсэн хэсэг нь бүх нийтийн сургалт тэр дундаа бүрэн дунд боловсролын сургууль руу чиглэж байгаа юм (Зураг 44). Олон нийтийн сургалтын талаар гол анхаарч буй зүйл бол бүх нийтийн боловсролын тогтолцоогоор дамжуулан олон нийтэд уламжлалт соёлын өвийн талаар үнэн, оновчтой мэдлэгийг хэрхэн олгох арга замыг зөв тодорхойлоход оршиж байна. Энэхүү сургалтыг сургуулийн насны хүүхдийг бүрэн хамрах боловсролын тогтолцоо болох бүрэн дунд сургууль ба бусад хүн ам буюу насанд хүрэгчдийг хамруулах албан бус сургалт гэсэн хоёр хэсгээр нь явагдах зүйтэй гэсэн дүгнэлт хийж байна.

Бүрэн дунд сургуульд ордог “Иргэний боловсрол” хичээлийн хөтөлбөрт биет соёлын өвийн талаар буюу сум орны байгаль орчин, түүх соёлын дурсгалт газрууд болон уламжлалт биет бус соёлын өвийн талаар тусгаж хэрэгтэй байна. Уг хичээлийг заах багш нарт гарын авлага, үзүүлэн таниулах материал дутмаг байдгаас заахад хүндрэлтэй байдаг нь ажиглагдсан юм. Мөн анги удирдсан багш нарт байдаг “Төсөлт ажил” хичээлийн сэдэв сонголтод Соёлын өвийн зарим нэг зүйлийг оруулж болно.




**Зураг 44 Өмнөговь аймгийн сургуулиуд**

Сумын сургуулиудад сургалтанд ашиглах техник тоног төхөөрөмж дутагдалтай байдаг тул дан ганц аман яриагаар Соёлын өвийн талаар хичээл заах нь учир дутагдалтай. Сургалтын хэрэглэгдэхүүнийг гэрэл зураг, видео бичлэгээр хийж үзүүлвэл хүүхдүүдийн сонирхлыг илүү татна. Тэдгээр техник хэрэглэл худалдан авах хөрөнгө санхүүг “Оюу толгой” төсөл гарган өгч болох талтай.

Өмнөговь аймгийн сумын сургууль бүрд газарзүй ба түүхийн кабинетийг сайтар тохижуулах ажлыг "Соёлын өвийн хөтөлбөр"-т багтаах нь зөв хэмээн үзэж байна. Учир нь газарзүйн кабинетэд тухайн сумын байгаль орчин, эрдэс баялаг, өвс, ургамал, ан амьтан зэрэг зүйлсийг бүрэн багтаах бол түүхийн кабинетэд сумын нутагт буй биет соёлын өв–палеонтологийн, түүхийн, соёлын, шашны дурсгалт газрууд, биет бус өв болох ардын ёс заншил, мал аж ахуйн эд зүйл, тоног төхөөрөмж, дуу хөгжим, тоглоом наадгай зэргийг тусгана. Энэ хоёр кабинетээр дамжуулан сурагчид говь нутгийнхаа Соёлын өвийн талаар тодорхой мэдлэгтэй болж, түүнийг хайрлан хамгаалах сэтгэлгээ суулгахад чухал ач тустай хэмээн үзэж байна.

Иймд "Оюу толгой" төслөөс шууд нөлөөллийн бүсийн сургуулиудад

- Түүхийн
- Газарзүйн гэсэн хоёр кабинетийг бүрэн тохижуулж, сум орон нутгийн түүх соёлын дурсгалууд болон байгаль орчин, хөрс, өвс ургамлын талаар бүрэн мэдлэг ойлголт өгөх, сургалт явуулахад орчныг бүрдүүлж өгөх хэрэгтэй юм байна.

Бүрэн дунд сургуулийн 1-11 ангид бүтэн жилийн турш ордог "Иргэний боловсрол" хичээлд юу заах ерөнхий зөвлөмж ирдэг, агуулга нь тодорхой бус байдаг ажээ. Тиймээс уг хичээлээр ямар сэдэв орох талаар бага, дунд, ахлах анги гэсэн 3 шатлалтай хөтөлбөрийг сургууль бүр өөрсдөө боловсруулаад ордог. БСШУЯ-аас "Иргэний боловсрол" хичээлийн агуулгыг тодорхой болгосон шийдвэр гаргахгүй бол сургууль бүрт өөр өөрөөр ордог тул Соёлын өвийн талаар хичээл орох нь газар бүр алдаг оног байдаг ажээ. Энэ байдлыг удаалгүйгээр даруй жигдлэх хэрэгтэй байна.

Учир иймийн тулд БСШУЯ-д "Иргэний боловсрол" хичээлийн хөтөлбөрт бага, дунд, ахлах ангийн хүүхдийн насны онцлогт тохируулан Монгол орны болон тухайн сум нутаг орны байгаль орчин, түүх соёлын дурсгал, уламжлалт ёс заншил, хоол унд, хувцас хунар, нүүдлийн мал аж ахуйн соёл зэргийг танин мэдүүлэх, хайрлан хамгаалах талаар тусгай хичээл (хэдэн жил, хэдэн цаг орохыг тодорхой заасан) оруулдаг болгон тогтоож улс орон даяар мөрдүүлэхийг СӨХ-ийн Олон нийтийн хөтөлбөрийн хүрээнд албан ёсоор тавихыг санал болгож байна.

"Оюу толгой" төслөөс шууд нөлөөллийн бүсийн сумдын цэцэрлэг, сургуулиудад "Ёс заншлын өргөө", "Соёлын өвийн танхим" байгуулан тохижуулж, хүүхдэд бага наснаас нь эхлэн уламжлалт соёлын өвийг мэдүүлэх, зааж сурталчлах, соёлын өвийн төрөл бүрийн сургалт, сурталчилгаа явуулдаг уурхай болгох хэрэгтэй юм байна.

Мөн Өмнөговь аймгийн сумдын цэцэрлэгүүдийг монгол тоглоомоор, сургуулиудыг үндэсний хөгжмийн зэмсгээр сайтар хангах ажлыг хийхэд "Оюу толгой" төслөөс дэмжлэг үзүүлбэл сайн байна.

Соёлын өвийн тухай боловсролыг дан ганц сургууль дээр танхимын сургалтаар олгох нь учир дутагдалтай байдаг. Тиймээс Өмнөговь аймгийн болон сумын орон нутаг судлах музей, орон нутаг судлах кабинетэд сургуулийн сурагчдын түүхийн ба газарзүйн зарим нэгэн хичээлийг зааж байх тусгай хөтөлбөрийг сургууль, музей хоёр хамтран боловсруулах нь чухал юм байна.

## 5.4.2 Насанд хүрэгсэд ба соёлын өвийн мэдлэг, боловсрол

**Соёлын өвийн боловсролыг насанд хүрэгчдэд хэрхэн олгох вэ?**

Соёлын өвийн сургалтын хоёрдахь хэсэг нь сургуулийн насны бус хүмүүс буюу насанд хүрэгчдийг хамруулах албан бус сургалт юм.

Уламжлалт соёлын өвийн дунд байгаа хүмүүс болох хөдөө мал маллаж байгаа насанд хүрэгчид, тэр дотроо залуучуудад Соёлын өвийн тухай мэдээлэл, боловсрол олгох нь нэн чухал ач тустай. Малчид хөдөө нутагтаа таруу амьдардаг тул тэдэнд зориулан тэнхмийн сургалт явуулах бололцоо байхгүй билээ.

Иймээс улиралд нэг удаа болдог багийн хурал, жил бүр болдог "Авто техникийн улсын үзлэг"-ээр малчид, залуучууд хөдөөнөөс олноор цуглардаг тул тэр үед Соёлын өвийн сургалт тогтмол явуулдаг байх хэрэгтэй. Ингэхдээ тэдэнд сумын сургууль бүрд байдаг "Албан бус боловсролын" багш нараар биет ба биет бус соёлын өвийн тухай, тэдгээрийг хайрлан хамгаалах талаар сургалт зохион байгуулах бололцоо байгаа нь судалгааны явцад тодорхой болсон билээ.

Учир иймийн тулд сумдын сургуулиудын албан бус боловсролын багш нарыг түшиглэсэн "Соёлын өвийн албан бус сургалт" гэсэн хөтөлбөр боловсруулан насанд хүрэгчид болон бүх насны иргэдэд соёлын өвийн тухай боловсрол тогтмол олгож байх нь зүйтэй гэсэн саналыг тавьж байна. Уг хөтөлбөрийг "Оюу толгой" төслийн нөлөөллийн бүсэд буй сумдын сургуулиуд аймгийн Боловсрол, Соёлын газартай хамтран боловсруулж, тодорхой төлөвлөгөөтэй ажиллах хэрэгтэй юм байна.

Мөн үүний зэрэгцээ сумдын багийн дарга, байгаль хамгаалагч нарт зориулсан Соёлын өвийн сургалтыг аймгийн төв дээр зохион байгуулах хэрэгтэй. Тэдгээр хүмүүсээр дамжуулан хөдөө мал маллан амьдарч буй болон сумын төв дээр буй насанд хүрэгчдэд Соёлын өвийн боловсрол олгох зайны сургалтыг зохион байгуулах ажлыг Өмнөговь аймгийн Боловсрол, Соёлын газарт хариуцуулан хийлгэж байх нь зүйтэй гэсэн саналыг дэвшүүлж байна.

Энэхүү албан бус сургалт болон зайны сургалт хоёр үндсэн аргаар насанд хүрэгчдэд Соёлын өвийн байнгын бөгөөд цэгцтэй боловсрол олгож байх нь өнөөгийн нөхцөл байдалд илүү үр өгөөжтэй хэмээн үзэж байна. Эдгээр сургалтыг зохион байгуулах, техник хэрэглэл болон сургалтын гарын авлага, үзүүлэн тараах материалыг бэлтгэх, хэвлэх зэрэгт "Оюу толгой" төслөөс санхүүгийн дэмжлэг үзүүлэн хамтран ажиллах байх хэмээн найдаж байна.

### 5.4.3 Иргэдийг чадавхижуулах

**Музей болон боловсролын ажилтнуудыг сургах хэрэгцээ**

Өмнөговь аймгийн сумдын музей, орон нутаг судлах кабинет хариуцсан ажилтнуудын дийлэнхи нь мэргэжлийн бус хүмүүс байгаа тул эхний ээлжинд тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэх явдал чухлаар тавигдаж байна. Жил бүр Улаанбаатар хотод болдог музейн ажилтны сургалт – семинарт тэднийг явуулж оролцуулах хэрэгтэй. Мөн аймгийн төв Даланзадгадад музейн ажилтны 7 хоногийн тусгай сургалт зохион байгуулж, мэргэжлийн багш нараар тэднийг цаашид хэрхэн яаж ажиллах талаар нарийн зааварчилсан хичээл заалгаж байх хэрэгтэй байна.

Энэхүү сургалт нь нэг удаагийн бус, тогтмол (хоёр жил тутамд нэг байж болно) байвал илүү үр өгөөжтэй болно хэмээн үзэж байна. Уг сургалтуудыг аймгийн Боловсрол, соёлын газраас зохион байгуулж явуулах бөгөөд дараа нь заасан хичээлийн дагуу сумдын музей, орон нутаг судлах кабинет ямар ажил хийснийг дүгнэж тооцож явбал илүү ажил хэрэгч, бүтээлч ажил болно гэсэн саналыг дэвшүүлж байна.

Яваандаа аль болох мэргэжлийн хүмүүсээр сумдын музей, орон нутаг судлах кабинетийг хариуцан ажиллуулах бодлогыг аймгийн Боловсрол, соёлын газар ба сумдын Соёлын төв барьж ажиллах нь зүйтэй. Мөн Соёлын төвийн өөр ажилтан музей, орон нутаг судлах кабинетийг хавсарга байдлаар хариуцдаг байдлыг өөрчлөн дангаараа ажиллах орон тооны төсөв зардлыг Засгийн газарт тавих хэрэгтэй байна.

Үүнээс өмнө музей, орон нутаг судлах кабинетийг Соёлын төвийн тасалбар түгээгч-шалгагчид бус, харин дээш нь нэг шат ахиулж, Манлай сумын адилаар номын санчид хариуцуулан ажиллуулбал ажил нь эрхбиш дээрдэх нь гарцаагүй.

Бүрэн дунд сургуулийн "Иргэний боловсрол" хичээлийн хөтөлбөрт бага, дунд, ахлах ангийн хүүхдийн насны онцлогт тохируулан гурван өөр байдлаар "Соёлын өвийн боловсрол" олгох бичил хөтөлбөрийг боловсруулах саналтай байгаагаа дээр өгүүлсэн билээ. Иймд уг хичээлийг түлхүү заадаг түүх, газарзүйн ба албан бус боловсролын багш нарт Соёлын өвийн талаар сургалт зохион байгуулж тэднийг "сургагч багш" маягаар бэлтгэх хэрэгтэй байна. Тэдгээр сургагч багш нар өөрсдийн сургуулийн бусад багш нартаа Соёлын өвийн талаарх сургалт явуулдаг, заавар зөвлөгөө өгдөг байхаар бодож төлөвлөх нь зүйтэй гэсэн дүгнэлтэд хүрээд байна.

Албан бус боловсролын багш нарыг багийн хурал болон бусад арга хэмжээний үеэр насанд хүрэгчдэд зориулсан Соёлын өвийн сургалтыг хариуцан ажиллуулдаг байх саналыг дээр дурдсан билээ.

Мөн Өмнөговь аймгийн сумдын Соёлын төвийн бүх ажилтнууд, дээр нь нэмээд сумын байгаль хамгаалагч нарыг хамарсан Соёлын өвийн сургалт, семинарыг жил бүр аймгийн Боловсрол, соёлын газраас зохион байгуулж байх хэрэгтэй байна. Дээрх бүх сургалтыг зохион байгуулах үүрэг хүлээж буй Боловсрол, соёлын газрын дэргэд Соёлын өвийн сургалт сурталчилгаа явуулдаг, тэр талаарх хурал зөвлөлгөөн, хэлэлцүүлэг хийдэг "Соёлын өвийн сургалт, сурталчилгааны танхим" байгуулах нь тун чухал болоод байна. Тэр танхим нь Өмнөговь аймгийн соёлын өвийг бодлогын хэрэгжилтийг хангах, зохион байгуулах түшиц бааз газар болох ёстой хэмээн үзэж байна. Уг танхимыг "Оюу толгой" төслөөс санхүүжүүлэн байгуулбал зүйтэй гэсэн санал байна.

"Оюу толгой" төслөөс Өмнөговь аймгийн Соёлын өвийн бодлогыг сайтар дэмжиж ажиллахгүй бол Монголын төрөөс Соёлд хандах бодлого өрөөсгөл буйг нэгэн жишээгээр хэлье. Монгол улсын Боловсрол, соёлын талаарх бодлогыг Өмнөговь аймагт хэрэгжүүлэгч төрийн гол байгууллага болох Боловсрол, соёлын газар 15 ажилтантай. Тэдгээрийн 13 нь боловсролын, 1 нь соёлын мэргэжилтэн байгаа нь Засгийн газраас боловсрол ба соёлд тавих анхаарал ялгаатай байгаагийн нэг илрэл юм.

Аймгийн Боловсрол, соёлын газар ихэнхи анхаарлаа боловсрол, хичээл сургалтад төвлөрүүлдэг ажээ. Нэг сурагч математик, нийгмийн тухай мэдлэг хичээлийн анги дэвших шалгалтанд унавал тэр нь байж боломгүй асуудал болж хүндэрдэг байна. Түүний адилаар түүх-соёлын дурсгал, соёлын өвийг хадгалах, хамгаалах, сурталчлах ажилд анхаарал тавьдаг байвал сайн юм. Бүх зүйл боловсрол руу чиглээд соёл, соёлын өвийн бодлого орхигдох сөрөг тал харагдаж байна.

Дараа нь Өмнөговь аймгийн орон нутгийн удирдлагын түвшинд соёлын өвийн бодлогод хэрхэн хайхрамжгүй ханддагийн нэг жишээг дурдвал, БСШУЯамны дэргэдэх "Соёлын өвийн төв"-өөс ирүүлсэн зааврын дагуу аймгийн Засаг даргын дэргэд "Соёлын өвийг хамгаалах салбар зөвлөл" байгуулж, тэргүүнээр нь Боловсрол, соёлын газрын дарга ажиллах ёстой ажээ. Гэтэл Өмнөговь аймагт энэ зөвлөлийг дээрээс ирүүлсэн ёс журмын дагуу бус, харин Боловсрол, соёлын газрын дэргэд 9 хүнтэй байгуулж, тэргүүнээр нь тус газрын соёл хариуцсан мэргэжилтэн ажиллаж байна. Өмнөговь аймагт Соёлын өвийн талаарх бодлого ямар төвшинд байгааг энэ баримт харуулна.

Энэ байдлаа нэн даруй засаж, салбар зөвлөлийг ном журмынх нь дагуу дахин байгуулж, идэвхитэй ажиллуулвал Соёлын өвийн талаар авч хэрэгжүүлэх ажил илүү үр дүнтэй, аймгийн засгийн дарга, бусад дарга нараас шийдвэр гаргах болон санхүү, эд материалын дэмжлэг авахад хэрэгтэй юм.

Учир иймийн тулд Соёлын өвийн талаарх бодлогод "Оюу толгой" төслөөс гойд анхаарал тавьж ажиллах ёстой гэсэн албан ёсны саналыг дахин хэлэх байна.

## 5.5 АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ

### 5.5.1 Шууд нөлөөллийн бүс дэх жуулчдыг татах үзмэрүүд

**Оюу Толгой төслийн шууд нөлөөллийн бүсэд байрлах аялал жуулчлалын гол дурсгалт газрууд**

Аялал жуулчлал бол Соёлын өвийг бүтээгдэхүүн болгон бусдад үзүүлдэг тусгай өвөрмөц үйлдвэрлэл бөгөөд нэг талаар соёлын өвийг хэрэглэгч байдаг билээ. "Оюу толгой" төслийн шууд нөлөөллийн бүсийн дөрвөн сумын нэг Ханбогд сумын жишээн дээр тэнд ямар дурсгалт газрууд байгаа, тэдгээрт түшиглэн ямар аялал хийж болохыг өгүүлье.

Монголын алдарт 33 говийн нэг болох үзэсгэлэнт Галбын говь Ханбогд сумын нутагт оршдог. Энэхүү байгалийн үзэсгэлэнт газраар тусгай аялал хийх бүрэн боломж байна. Тэнд говийн жимс болох-хармагийг амтлан үзэж, говийн цөөн модны нэг болсон загийн ой, дэлхийд ховордсон хулан зэргийг харж болно.

Ханбогд суманд шашны аялал жуулчлал хийх дурсгалт газрууд хангалттай байна. "Дэлхийн энергийн төв" гэгдэх Дэмчигийн хийдийг үзээд явахгүйгээр Галбын 3 хийд – Дэмчигийн хийд, Цагаан толгойн хийд, Рийтэрийн хийдийн туурийг цогцоор нь үзэх, бас улааны шашны Баян ба Цогзолын хийдийн туурийг үзүүлж тайлбарладаг шашны бүрэн гүйцэд аялал жуулчлалын хөтөлбөр зохиож болох юм байна.



**Зураг 45 Соёлын өвийн аялал жуулчлалын нэг хэсэг болох говийн айлын ерөнхий байдал**

Мөн тус сумын нутагт буй түүх соёл–шүтлэг бишрэлийн дурсгалт газрууд болох Чингис хааны ууртаны нүх, Чулуун дээрх хүний мөр, орсон хүнийг баяжуулдаг Баяжихын агуй, хүнийг дахин төрсөн мэт ариусгадаг Эхийн умай хад, Данзанравжаа хутагтын "Саран хөхөө" жүжгээ тоглуулдаг байсан задгай театрын бууръ, Эр хүний бэлгэ хад, Эмэгтэй хүний бэлгэ чулуу зэрэг газруудыг үзүүлэх тусгай аялал зохион байгуулж болно.

Мөн нүүдлийн мал ахуйтай танилцуулах аяллыг Ханбогд суманд зохион байгуулах боломжтоот нь харагдсан билээ (Зураг 45). Тус сумын Гавилууд багт адуу, Номгон багт үхэр, Жавхлан багт бог мал, Баян багт тэмээний аж ахуй зонхилж байгаа тул жуулчид энэ үндсэн дөрвөн чиглэлээс сонгон очиж үзэж болно. Малчин айлын ахуй амьдралтай танилцах, тэмээ, адуу унаж үзэх, гэрэл зургаа авахуулах, сүү цагаан идээг амсах зэрэг мал аж ахуйтай танилцах аялал жуулчлалын нэг хэлбэрийг бий болгох малчин айлууд нь бүрэн байна.

Энэ мэтээр хөрш зэргэлдээ Баян-Овоо, Манлай сумдын нутагт буй биет соёлын өвт газрууд буюу аялал жуулчлалын дурсгалт газрууд элбэг бий. Энд онцгойлон Манлай сумын нутагт буй эртний 75 сая жилийн настай үлэг гүрвэлийн мөрийг хадгалсан Шар цавын дурсгалт газрыг дурдаж болно.

## 5.5.2 Өмнөговь аймгийн аялал жуулчлалын цэгүүд

**Өмнөговь аймагт аялал жуулчлал хөгжүүлэх боломж**

Монгол улсын Засгийн газрын "Аялал жуулчлалыг хөгжүүлэх үзэл баримтлал"-ын дагуу Өмнөговь аймагт аялал жуулчлал идэвхитэй хөгжиж байна.

Өмнөговь аймгийн аялал жуулчлалын үндсэн бүтээгдэхүүн нь 1963 оноос эхэлсэн говь нутгийн байгалийн үзэсгэлэнт газрууд ба палеонтологийн дурсгалт газруудын хосолмол байдал юм.

Өмнөговь аймгийн аялал жуулчлалын гол сэтгэл татах үзмэр нь байгалийн үзэсгэлэнт газрууд бөгөөд аялагч жуулчид Монголын их говь нутгийн сайхныг үзэж, хоёр бөхт тэмээ сонирхдог бөгөөд жуулчдын гол төвлөрөл Говь Алтайн нурууны Гурван сайхны нурууны Зүүн сайхны уул, "Ёлын ам", "Дүнгэнээ ам", "Хонгорын элс", "Баянзаг", "Хэрмэн цав" зэрэг газруудад байна.

Өмнөговь аймгийн аялал жуулчлалын хоёрдахь чухал сэтгэл татах үзмэр нь палеонтологийн дурсгалууд юм. Дэлхийд алдартай "Баянзаг"-ийн дурсгалт газрыг энд онцгойлон дурдаж байна. Тус аймагт ирсэн жуулчдын 90 орчим хувь нь үүнийг үзэж сонирхож байгаа нь дэлхий дахинд өндөр ач холбогдолтой газар мөн болохыг харуулж байна. Нутгийн иргэд Баянзагийг "Улаан эрэг" гэж бас нэрлэдэг.

Аймгийн ИТХ-аас санаачлан Булган сумын нутагт буй Баянзагийн хажууд "Үлэг гүрвэлийн парк", "Палентологийн эрдэм шинжилгээний хүрээлэн" байгуулах ажил хийх гэж буй ажээ. "Говь тур" аялал жуулчны баазын захирал Д. Эрдэнэбаттай уулзаж "Үлэг гүрвэлийн парк"-ийн талаар саналыг нь сонсоход Баянзагийг үзэхээр ирсэн гадаадын жуулчдаас авсан санал асуулгаас харахад үүнийг сонирхох хүн гараагүй бөгөөд жуулчид арай өөр юм үзэх хүсэлтэй байгаа ажээ. Түүний оронд олдвор олдсон газруудыг ил музей болгох байдлаар жуулчдад үзүүлэх, тэнд хүн явж үзмэр үзэх зам болон явж болохгүй газрыг нарийн зааж тэмдэглэвэл зөв хэмээж байв.

Өмнөговь аймаг байгаль, түүх, соёлын дурсгалт 9 гайхамшигаа тодруулсан байна. Эдгээр нь

1. Гурван тэс сумын нутагт орших Хэрмэн цав, Зуун мод, Зулганай
2. Сэврэй сумын нутагт орших Хонгорын элс, Сэврэй хайрхан, Чоно шургуул
3. Ноён сумын нутагт орших Ноён богд хайрхан, Толь хад, Саран хөндий
4. Булган сумын нутагт орших Баянзаг, Төгрөгийн ширээ, Торгоны зам
5. Ханхонгор сумын нутагт орших Ёлын ам, Мухар шивэрт, Дүнгэнээгийн ам, Тосонгийн ам, Шатын ам
6. Мандал-Овоо сумын нутагт орших Алгуй улаан цав
7. Номгон сумын нутагт орших Сангийн далайн хийд
8. Манлай, Ханбогд сумдын нутагт орших Үлэг гүрвэлийн мөр, Дэмчигийн хийд, Галбын говь
9. Ноён, Сэврэйн хийцийн мөнгөн эдлэл зэрэг юм.

Дээрх нэр бүхий дурсгалт газруудад жуулчид хамгийн ихээр очдог байна. Хэдийгээр дээрх жагсаалтад нэр ороогүй боловч аялал жуулчлалын эргэлтэд орох бололцоотой байгалийн болон биет соёлын өвийн дурсгалт газрууд Өмнөговь аймгийн сум бүрд байгаа. Тэдгээрийг тодорхойлон гаргаж, сурталчлан аялал жуулчлалын шинэ чиглэл гаргах эдийн засгийн тооцоог мэргэжлийн байгууллагаар хийлгэх нь зөв хэмээн үзэж байна.

### 5.5.3 "Оюу Толгой" төслийн орчим соёлын өвийн аялал жуулчлалыг хөгжүүлэх нь

**"Оюу Толгой" төслийн орчим соёлын өвийн аялал жуулчлалыг хөгжүүлэхийн давуу болон сул талууд**

"Оюу Толгой" төслийн шууд нөлөөллийн бүсэд Соёлын өвийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд давуу болон сул талын аль аль нь байна. Баян-Овоо, Ханбогд, Манлай гурван сумын хувьд Соёлын өвийн аялал жуулчлал хөгжүүлэхэд нөлөөлөх давуу талууд гэвэл,

- байгалийн аялал жуулчлал хийх үзэсгэлэнт газрууд нь байна.
- шашны аялал жуулчлал хийх сүм хийдийн туурь дурсгалууд байна
- түүх-соёлын аялал жуулчлал хийх дурсгалт газрууд бэлэн байна.
- мал аж ахуйтай танилцах аялал хийх бүрэн боломж байна.
- уул уурхайн аялал жуулчлал хийх нөхцөл боломж бүрдэж эхэлж байна.

Ханбогд сумын хувьд бол сүүлийн үед жуулчлал хөгжих хандлага бий болсон нь дэлхийн энергийн төв гэгдэх Дэмчигийн хийдийн нэг хэсгийг "Оюу толгой" төслөөс санхүүжүүлэн сэргээсэнтэй холбоотой ажээ (Зураг 46, Зураг 47).

Баян-Овоо, Ханбогд, Манлай гурван суманд Соёлын өвийн аялал жуулчлал хөгжүүлэхэд саад болохуйц сул талуудыг дурдвал,

- төвөөс алслагдсан тул тээврийн үнэ өндөр байгаа явдал
- засмал замгүй байгаа нь жуулчдыг аян замд залхаах нэг хүчин зүйл болдог
- зочид буудлын багтаамж, хүрэлцээ, үйлчилгээ тааруу байгаа явдал
- жуулчдын сонирхол татахуйц аялалын тусгай чиглэл, хөтөлбөр байхгүй зэрэг юм.



**Зураг 46 Дэмчигийн хийд дэх дэлхийн энергийн төв**

Оюу толгой" төслийн шууд нөлөөллийн гурван сумын нутагт ганц жуулчны бааз байгаа нь хангалтгүй үзүүлэлт билээ. Тэр бол Ханбогд сумын нутаг орших "Дэлхийн энергийн төв" жуулчны бааз юм. Тус жуулчны бааз сумын төвөөс баруун урагш 6 км-т оршдог тул суманд ирсэн гадаад, дотоодын жуулчид очиж байрлах боломжтой юм. Бааз 10 гэртэй, 40 орны хүчин чадалтай. Хоолны газар, бие засах газартай. Үнийн хувьд нэг хүн 30 ам долларын үнэ төлөх ажээ. Гэхдээ уг жуулчны бааз зөвхөн дулааны улиралд ажилладаг билээ.

"Оюу толгой" төслийн шууд нөлөөллийн бүсэд аялал жуулчлал хөгжүүлэх боломж бололцоог тодорхой болгож, цаашдын зорилтоо тодорхойлохын тулд эдгээр сумдад өнөөгийн байдлаар жуулчин авах хүчин чадал ямар байгаа мэдэх хэрэгтэй байгаа юм. "Оюу толгой" төслийн шууд нөлөөллийн бүсийн гол нутаг Ханбогд сумын төв дээр буй зочид буудлын урьдчилсан судалгааг хийв.

Ханбогд сумын төвд гурван буудал буй нь "Уужим-Од" ХХК-ний "Эрхэс" зочид буудал, "ДТМ" ХХК-ний "Баян-Эрдэнэ" зочид буудал, "Хан дизель" ХХК-ний мэдэлд буй Ханбогд сумын зочид буудал юм.

"Эрхэс" зочид буудал Гавилууд багт харьяалагдах бөгөөд 2 давхар барилгатай. Люкс өрөө-2, хагас люкс өрөө-2, нийтийн өрөө-2 нийт 16 ортой. Өрөө тус бүр бие засах болон угаалгын өрөөтэй. Нам даралтат зуухын халаалттай. Хажуу талдаа хоолны газартай. Машин тавих хашаатай. Үнийн хувьд гэвэл,

- Люкс (хоёр ор, зурагт, халуун ус, ариун цэврийн өрөө, шүршүүр) 45000 төгрөг
- Хагас люкс (хоёр ор, зурагт, халуун ус, ариун цэврийн өрөө, шүршүүр) 30000 төгрөг
- Хагас люкс (хоёр ор, зурагт, халуун ус, ариун цэврийн өрөө, шүршүүр) 30000 төгрөг

- Нийтийн өрөө (4 ор, зурагт, халуун ус, ариун цэврийн өрөө, шүршүүр) 40000 төгрөг ажээ. Уг буудалд гадаадын зочид, жуулчид их төлөв буудаг. Дутагдалтай тал нь цэвэрлэгээ, үйлчилгээ муу байгаа явдал юм.

"Баян-Эрдэнэ" зочид буудал Баян багт харьяалагддаг. Хоёр давхар улаан тоосгон барилгад оршдог. Люкс 1 өрөө, энгийн өрөө 5-тай. Дундаа нийтийн ариун цэврийн өрөөтэй ажээ. Машин тавих хашаатай. Үнэ нь, энгийн өрөө зундаа 8000 төгрөг, өвөлд 10000 төгрөг, люкс өрөө мөн зундаа 8000 төгрөг, өвөлд 10000 төгрөг байдаг ажээ. Энэ буудалд голдуу монголчууд бууж байрладаг ажээ.



**Зураг 47 Дэмчигийн хийд**

Ханбогд сумын Засаг даргын тамгын газрын харьяанд зочид буудал байсныг сумын эрчим хүчний "Хан дизель" ХХК-д шилжүүлсэн байна. Уг зочид буудал мөн 2 давхар байшинд байрладаг. Байшин дотроо гал тогоотой ганц зочид буудал юм. Нийт 6 өрөө, 25 ортой. Нийтийн ариун цэврийн өрөө нь нь дундаа байдаг. Нам даралтат уурын зуухаар халаадаг. Үнийн хувьд 10000-15000 төгрөг ажээ. Тус буудалд ихэвчлэн монголчууд буудаг.

Ханбогд суманд хоёр гэр буудал байдгийн эхнийх нь "Баян-Эрдэнэ" зочид буудлын харьяа гэр буудал юм. Одоогоор түүнийг сарын 150000 төгрөгөөр түрээслээд байгаа ажээ. Хоёрдахь нь хувь хүний 5 ор бүхий гэр буудал бөгөөд нэг хүнийг хоногийн 8000 төгрөгөөр буулгадаг байна.

Ханбогд сумын хэмжээнд жуулчин болон албаны ажлаар яваа хүмүүсийн бууж байрлах зочид буудлын орны тоо бага байгаа нь уг судалгаанаас харагдаж байна. Цаашдаа Ханбогд суманд алба болон амины ажлаар ирэх хүмүүс, мөн жуулчдын тоо ихсэх төлөв илт мэдэгдэж байгаа тул өнөөгийн буудлын хүчин чадал хүрэлцэхгүй нь тодорхой юм.

Мөн зочид буудлын үйлчилгээ, ариун цэврийн асуудалд онцгойлон анхаарах хэрэгтэй байна. Зочид буудал гэдэг нь хүн оруулаад байрлуулаад орхино гэсэн үг биш бүхэл бүтэн үйлчилгээний цогц гэдгийг сайн ойлгож орчин цагийн зочид буудалд тавигдах үйлчилгээг байгаа нөхцөл боломжийн хэмжээнд үзүүлж байх хэрэгтэй.

Энэ судалгаа Ханбогд суманд аялал жуулчлал хөгжүүлэх сул талын нэг болсон зочид буудлын багтаамж бага, үйлчилгээ тааруу байгааг хэлж өгч байна.

Өмнөговь аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газраас боловсруулсан аялал жуулчлалыг хөгжүүлэх "Мастер төлөвлөгөө" ёсоор Өмнөговь аймгийг төв, зүүн, баруун гэсэн аялал жуулчлалын гурван дэд бүсэд хуваажээ. Зүүн бүсэд Манлай, Ханбогд, Цогтцэций сум орох ба уг бүсэд уул уурхайг хөгжүүлэх ажээ. Төвийн бүсэд Булган, Хүрмэн, Ханхонгор, Баяндалай, Номгон, Мандал-Овоо, Цогтцэций, Цогт-Овоо сумдыг оруулсан бөгөөд аялал жуулчлалыг дангаар нь хөгжүүлнэ. (Төвийн бүсээ дотор нь 1, 2-р бүс гэж давхар хуваасан байна.) Баруун бүсэд Ноён, Сэврэй, Гурвантэс сум оржээ. Эл бүсэд аялал жуулчлал, уул уурхайг хөгжүүлнэ гэж "Мастер төлөвлөгөө"-нд тусгаад байгаа ажээ.

Аялал жуулчлалын төвийн ба баруун бүсэд Говь гурван сайхан, Хонгорын элс, Баянзаг, Хэрмэн цав зэрэг газрыг түшиглэн аялал жуулчлал, жуулчны баазын үйл ажиллагаа арай түлхүү хөгжиж байгаа бол зүүн бүсэд харьцангүй сул байна.

Аялал жуулчлалын зүүн бүсийн Манлай, Ханбогд, Цогтцэций сумдыг уул уурхайн ашиглалт болон хязгаарлалтын бүсэд бүрэн хамруулж, аялал жуулчлалыг хөгжүүлэх боломж нөхцөл, авч хэрэгжүүлэх арга хэмжээ зэргийг тусгаагүй дутагдлаа даруй засах хэрэгтэй юм.

Сүүлийн жилүүдэд Өмнөд Америк, Австрали зэрэг уул уурхай өндөр хөгжсөн бүс нутаг орнуудад уул уурхай, түүний бүтээн байгуулалт зэрэгт түшиглэсэн уул уурхайн аялал жуулчлал (Mining tourism) хөгжүүлж байна. Үүний адилаар "Оюу толгой" төслийн шууд нөлөөллийн бүсэд хариуцлагатай уул уурхайн аялал жуулчлалыг шинээр эхлүүлэх хэрэгтэй байна. Энэ талаар "Оюу толгой" төсөл өөрөө тусгай хөтөлбөр гарган хэрэгжүүлж эхлэх нь зүйтэй юм. Мөн шууд нөлөөлллийн бүсийн гурван суманд хариуцлагатай уул уурхайн аялал жуулчлалын зэрэгцээ байгалийн болон түүх–соёлын аялал жуулчлал хөгжүүлэх бүрэн боломж байгаа нь эхний зургаан сарын судалгаагаар нэгэнт тогтоогдсон билээ.

### 5.5.4 Өмнөговь аймагт соёлын өвийн аялал жуулчлалыг хөгжүүлэх

**Өмнөгов аймагт соёлын өвийн аялал жуулчлалыг хөгжүүлэхийн давуу болон сул талууд**

Өмнөговь аймагт аялал жуулчлал хөгжүүлэх давуу тал бол юуны өмнө олон жилийн туршлага юм. Өмнөговь аймгийн аялал жуулчлал нь Монгол улсын хэмжээнд бараг анхдагч бөгөөд 1963 оноос Гурван сайхан уулын Ёлын ам, Хонгорын элс чиглэлд аялал жуулчлал, жуулчны баазын үйл ажиллагааг явуулж эхэлжээ. Өмнөговь аймаг аялал жуулчлал харьцангуй сайн хөгжсөн аймгуудын тоонд орно. Одоо тус аймагт 20-22 жуулчны бааз ажиллаж байгаа нь улсын хэмжээнд дээгүүр орох үзүүлэлт юм.

Олон нийтийн хөтөлбөрийн хээрийн судалгааны явцад хийсэн Өмнөговь аймгийн жуулчны баазуудын бүртгэлээс (Зураг 48) жуулчид хэрэгтэй мэдээллээ олж авах, тус аймгийн аялал жуулчлалын даац хэмжээ, үнэ ханш зэрэг олон зүйлийг мэдэх боломжтой.

**Хүснэгт 19 Өмнөговь аймаг дахь жуулчны баазууд**

| № | Харъяалал | Жуулчны баазын нэр | Аж ахуйн нэгжийн нэр | Байршил | Утас, факс | Гэрийн тоо | Нийт орны тоо | Үнэ | Зэрэглэл /цэцэг/ | Вэб сайт, цахим хаяг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **1.** | Өмнөговь, Ханхонгор сум | Жуулчин говь-1 | "Жуулчин говь"ХК | УБ хотоос 600 км Даланзадгадаас баруун хойш 35 км, | УБ345959 50535355 95144470 | 50 | 150 | 40$ | | www.juulchin-gobi.mn s_sanaa84@yahoo.com |
| **2.** | Өмнөговь, Ханхонгор | Нью төвшин | "Нью төвшин"ХХК | УБ хотоос 600 км ДЗ хотоосбаруун хойш 37км | 99097824 99088924 99007824 | 36 | 110 | 30$ | | www.welcometomongolia.mn oko_0419@yahoo.com |
| **3.** | Өмнөговь, Булган сум | Говийн гурван тэмээ | "Говийн гурван тэмээ"ХХК | ДЗ хотоос 70 км Булган сумаас баруун урагш 23 км | УБ327837 98880930 99089514 | 48 | 84 | 80$ | 2 | www.THREECAMELLODGE.COM naraa@threecamellodge.com |
| **4.** | Өмнөговь, Ханхонгор сум | Говь сайхан | "Монгол байгаль "ХХК | ДЗ-аас баруун зүгт 25 км | Өм.22475 99538098 | 10 | 20 | 30$ | | monbaigali@gmail.com |
| **5.** | Өмнөговь, Ханхонгор сум | Говь мираж | "Өнөр говь ХХК" | ДЗ-с баруун хойш 50 км | 99033988 99084988 Өм.23904 | 28 | 80 | 30$ | 1 | www.gobimirage.mn , info@gobimirage.mn |
| **6.** | Өмнөговь, Сэврэй сум | Жуулчин говь-2 | "Жуулчин говь"ХК | ДЗ-аас 230 км "ЖГ-1"ЖБ-аас195 км Хонгорын голоос хойш 1,5 км | УБ345959 88091377 | 30 | 80 | 40$ | | www.juulchin-gobi.mn s_sanaa84@yahoo.com |
| **7.** | Өмнөговь, ………… | Говийн анар | "Говийн анар"ХХК | Хонгорын голоос зүүн тийш 12 км Нью төвшин ЖБ-аас 160 км | 99114811 УБ310455 99118276 88129222 | 15 | 40 | 30$ | | Uran_anar@yahoo.com |
| **8.** | Өмнөговь, Булган сум | Баян заг | "Дал хуудас"ХХК | ДЗ-аас 100 км, Булган сумаас зүүн тийш 12 км | 50532555 99539988 99048099 | 30 | 60 | 30$ | | baynzag@yahoo.com |
| **9.** | Өмнөговь, Ханхонгор сум | Гүег хаан | "Тал нутгийн хаад"ХХК | ДЗ-аас баруун тийш 35 км, Жуулчин ханбогд ЖБ-аас зүүг тйиш 3 км | 99538370 99280729 | 16 | 32 | 30$ | | www.khans-of-mongolia.de khansofm@mobinet.mn |

| № | Харъяалал | Жуулчны баазын нэр | Аж ахуйн нэгжийн нэр | Байршил | Утас, факс | Гэрийн тоо | Нийт орны тоо | Үнэ | Зэрэглэл /цэцэг/ | Вэб сайт, цахим хаяг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **10.** | Өмнөговь, Ханхонгор сум | Сайжрах тур | "Дархан говь "ХХК | ДЗ-аас баруун хойш 16 км | 95294139 95189237 | 20 | 60 | 30$ | | www.saijrakhgobi.mn saijrakhgobi_juulchin@yahoo.com |
| **11.** | Өмнөговь, Ханбогд сум | Дэлхийн энергийн төв | "Дэлхийн энергийн төв"ХХК | Ханбогд сумын төвөөс баруун урагш 6 км | 99253040 99085738 99117069 | 10 | 40 | 30$ | | www.wec.mn wec_camp@yahoo.com |
| **12.** | Өмнөговь, Ханхонгор сум | Говийн баян бүрд-1 | " Төвшин шанхат"ХХК | ДЗ-аас баруун зүг 12 км | 99532020 99819779 | 40 | 120 | 30$ | | www.welcometourgobi.com goodfriend245@yahoo.com |
| **13.** | Өмнөговь, Булган сум | Говийн баян бүрд-2 | " Төвшин шанхат"ХХК | ДЗ-аас 996 км Булган сумаас баруун зүг14 км | 99532020 99109889 99819779 | 30 | 80 | 30$ | | www.welcometourgobi.com goodfriend245@yahoo.com |
| **14.** | Өмнөговь, Даланзадгад сум | Мазаалай | "Өмнийн говь "ХХК | ДЗ сумын төвийн зүүн хэсэгт | 88850966 99080765 95274787 | 10 | 40 | 30$ | | Nara_0708@yahoo.com |
| **15.** | Өмнөговь, Ханхонгор сум | Дунгэнээ | "Вержелэнт "ХХК | ДЗ-аас 20 км, Жуулчин ханбогд ЖБ-аас зүүн урагш 10 км | 99076482 99116482 | 14 | 28 | 30$ | | |
| **16.** | Өмнөговь, Булган сум | Монгол говь | "Говийн өгөөж"ХХК | Булган сумаас 12 км ДЗ-аас96 км | 99118102 99092302 99193249 | 40 | 100 | 35$ | 2 | www.mongolgobi.com info@mongolgobi.com |
| **17.** | Өмнөговь, Булган сум | Говь тур | "Шонхор говь "ХХК | ДЗ-аас 88 км, Булган сумаас 17 км | 99091285 99539488 | 25 | 75 | 38$ | | www.gobitourcamp.com gobitour_bayanzag@yahoo.com |
| **18.** | Өмнөговь, Ханхонгор сум | Говь дисковери | "Говь дисковери"ХХК | ДЗ-аас баруун хойно 40 км | 91917299 99822008 | 30 | 80 | 38$ | | www.gobidiscovery.mn gobidiscovery@magicnet.mn |
| **19.** | Өмнөговь, Сэврэй сум | Говь дисковери 2 | "Говь дисковери"ХХК | ДЗ-аас 230 км Сэврэй сумаас 48 км | 99157546 96655835 | 40 | 100 | 38$ | | www.gobidiscovery.mn gobidiscovery@yahoo.com |
| **20.** | Өмнөговь, Баяндалай сум | Жуулчин ханбогд | "Жуулчин ханбогд"ХХК | ДЗ-аас баруун тийш 36 км Ёлын амнаас зүүн тийш 18 км | 99038808 88101955 | 25 | 80 | 30$ | | chbjargal@yahoo.com dursamj_uni@yahoo.com |

| № | Харъяалал | Жуулчны баазын нэр | Аж ахуйн нэгжийн нэр | Байршил | Утас, факс | Гэрийн тоо | Нийт орны тоо | Үнэ | Зэрэглэл /цэцэг/ | Вэб сайт, цахим хаяг |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| **21.** | Өмнөговь, Ханхонгор сум | Дизерт говь | "Зосын хороот"ХХК | ДЗ-аас баруун хойно 23 км | 91999414<br>99159109 | 20 | 60 | 40$ | | desertgobi@mongolnet |
| **22.** | Өмнөговь, Булган сум | Dream gobi | "Жамо трейвэл"ХХК | Булганаас 50 км | 99116574<br>99054550<br>УБ315379 | 20 | 38 | 80$ | | www.jamo.mn<br>bolortat@yahoo.com |

Дээрх 22 жуулчны бааз нэг удаад 1557 жуулчин хүлээн авах хүчин чадалтай байна. Өмнөговь аймгийн төв Даланзадгад суманд 11 зочид буудал байгаа нь нийтдээ 154 хүн хүлээх чадалтай юм. Мөн дээрх зочид буудлуудаас гадна байгалийн үзэсгэлэнт газар ихтэй тус аймгийн Булган, Сэврэй, Ханхонгор сумдын нутагт буй 212 ор бүхий 18 дэн буудал байгаа нь үнийн хувьд арай хямд (1 ор нь 5000 төгрөг) бөгөөд дотоодын аялагчид түүнд голлон буудаг ажээ.

Хоёрдахь давуу тал нь Өмнөговь аймгийн аялал жуулчлалын үндсэн бүтээгдэхүүн болох 1963 оноос эхэлсэн говь нутгийн байгалийн үзэсгэлэнт газрууд ба палеонтологийн дурсгалт газруудын хосолмол байдал юм. "Говь ба Үлэг гүрвэл" гэсэн энэхүү бүтээгдэхүүн-үйлчилгээний хослол их үр өгөөжтэй, үзүүштэй аялал жуулчлал мөн бөгөөд энэ бол Өмнөговь аймагт аялал жуулчлал хөгжүүлэх давуу тал билээ.

Аялал жуулчлалыг хөгжүүлэхэд зайлшгүй анхаарах, авч хэрэгжүүлэх зүйл бол аялагч жуулчдын ая тухтай байдлыг хангах, сайн үйлчилгээг бий болгох, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах явдал юм. 2010 онд Монгол улсын хэмжээгээр зочид буудал, жуулчны баазын зэрэглэл тогтооход тус аймгийн жуулчны баазууд хоол, ариун цэврийн өрөө, халуун усны үйлчилгээгээр бусад аймгийн жуулчны баазуудаас сайн гэсэн үнэлгээ авсан. Мөн жуулчны баазууд 1, 2 цэцгийн зэрэглэл авчээ. Өмнөговь аймагт үйл ажиллагаа явуулж байгаа аялал жуулчлалын баазуудын үйлчилгээ, стандарт нь сайн байгаа нь Өмнөговь аймагт аялал жуулчлал хөгжүүлэх давуу талын нэг юм.

### 5.5.5 Өмнөговь аймагт аялал жуулчлал хөгжүүлэхийн дутагдалтай талууд

Өмнөговь аймагт аялал жуулчлал хөгжүүлэхийн сул талуудыг дурьдвал,

- "Говь ба Үлэг гүрвэл" гэсэн энэхүү бүтээгдэхүүн – үйлчилгээний хослол их үр өгөөжтэй, үзүүштэй аялал жуулчлал мөн боловч дан ганц энэ хослолоор аялал жуулчлалыг эрчимтэй хөгжүүлнэ гэвэл зарим талаар учир дутагдалтай. Орчин цагийн аялал жуулчлалын эрэлт хэрэгцээнд нийцүүлэн уламжлал болсон "Говь – үлэг гүрвэл" гэсэн бүтээгдэхүүн-үйлчилгээний зэрэгцээ олон улсын аялал жуулчлалын зах зээлд эрэлттэй байгаа аяллын шинэ төрлүүдийг бий болгох хэрэгтэй юм. Тэдгээр нь уламжлалт ахуй амьдралын, соёлын өвийн, баяр наадам, томхон үйл явдал арга хэмжээнд (event tourism) суурилсан аялал зэрэг төрлүүд байх нь зүйтэй.

- Өмнөговь аймагт биет соёлын өв болох түүх-соёлын дурсгалуудыг аялал жуулчлалд хэрэглэх явдал хангалтгүй байгааг онцгойлон анхаарах хэрэгтэй юм байна. Дэлхийд хосгүй чулуун зэвсгийн ил суурин, Чингисийн далан, хадны зураг, сүм хийдийн туурь зэргийг аяллын хөтөлбөрт тусгайлан оруулах замаар аяллын шинэ чиглэлийг төлөвлөх хэрэгтэй байгааг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газарт зөвлөж байна.
- Өмнөговь аймгийн аялал жуулчлалд дотоодын аялал жуулчлалд хандсан бодлого, үйл ажиллагаа, нэгдсэн төлөвлөгөө бараг байхгүйтэй адил байна. Аялал жуулчлалын ихэнхи бодлого, төлөвлөлт гадаадын жуулчлалд хандсан байгаа тул үүнтэй зэрэгцүүлэн дотоодын аялал жуулчлалд зориулсан үнийн уян хатан бодлого, аяллын тусгай хөтөлбөрүүдийг авч хэрэгжүүлэх хэрэгтэй юм байна. Энэ бол зөвхөн Өмнөговь аймгийн төдийгүй нийт Монгол улсын аялал жуулчлалд буй том дутагдал юм.



**Зураг 48 Өмнөговь аймаг дахь жуулчны баазын ерөнхий байдал**

Өмнөговь аймагт дахь аялал жуулчлалын үйл ажиллагаа ерөнхийдөө сайн, боломжийн хэмжээнд байгаа боловч манай хөтөлбөрийн хүрээнд яригдаж буй Соёлын өвийн аялал жуулчлал зохих төвшинд хүрээгүй байна. Тус аймагт байгалийн аялал жуулчлал зонхилж байгаа бөгөөд тэрхүү тодорхой хэмжээгээр орхигдоод байгаа Соёлын өвийн аялал жуулчлалыг хөгжүүлэхийн тулд юу юу шаардлагатай гэвэл:

- Өмнөговь аймагт ирэх жуулчдын сонирхлыг татах, аялах сэдлийг нэмэгдүүлэх зорилгоор аялал жуулчлалын бүтээгдэхүүн-үйлчилгээний нэр төрлийг олшруулах нь нэн чухал байна. Түүний нэг нь шашны аялал жуулчлал юм. Тус аймгийн нутагт урьд өмнө байсан, одоо сэргээсэн бурхны шашны зарим сүм хийдийн үлдэл туурийг харуулах, шашны хурал номын үйл ажиллагаа үзүүлэх, Сангийн далай хийдийн дэгийн цамын бүжиг үзүүлэх, Дэлхийн энергийн төвд аялуулах зэрэг үйл явдлууд байж болно. Эдгээр нь нэг талаар биет соёлын өв, нөгөө талаар биет бус бус соёлын өв болдог. Энэ дагуу аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн-үйлчилгээг боловсруулж, аялал жуулчлалын зах зээлд сурталчлах, таниулах нь зүйтэй юм.
- Өмнөговь аймгийн арвин баялаг түүхийн биет соёлын өвүүдийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн-үйлчилгээ болгон эргэлтэд оруулах ажил их чамлалттай байна. Булган сумын нутагт орших дэлхийд алдартай хуучин чулуун зэвсгийн "Цахиуртын хөндий" задгай суурин, Булган сумаас баруун урагш 20-д км-т орших "Хавцгайтын хад"-ны зураг, Ноён, Баяндалай, Хүрмэн сумдын нутгийн өмнөд хэсгээр орших "Чингисийн далан-А", Номгон сумын нутаг Борзонгийн говийн өмнөд биеэр орших "Чингисийн далан-Б" гэсэн түүхийн чухал дурсгалыг түүх соёлын аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгож аяллын хөтөлбөрт тусгайлан оруулах шаардлагатай хэмээн үзэж байна. Энэ мэтээр сурвалжлан явбал олон дурсгалт газрын нэр гарна.
- Говийн малчин монголчуудын аж амьдрал, гэр орон, нүүдлийн аж ахуйтай танилцах, тэмээ морь унуулах зэрэг бичил аялал, биет бус соёлын өвийн бэсрэг наадам зэргийг тогтмол үйл явдал болгон хөтөлбөрт оруулж байх. Энэ нь жуулчдын сонирхлыг хамгийн их татдаг соёлын өвөрмөц байдал болохыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгох хэрэгтэй байна.
- Биет ба биет бус соёлын өвийн (Cultural heritage tourism) аялал жуулчлалыг бие даасан бүтээгдэхүүн-үйлчилгээ болгох, аяллын бүх төрлийн хөтөлбөрт ямар нэгэн байдлаар тусгаж байх нь нүүдэлчийн монголчуудын уламжлалт аж төрөх ёс, өвөрмөц соёлыг дэлхий нийтэд таниулах, сурталчлах өндөр ач холбогдолтойг анхаарах нь зүйтэй. Үүнийг дагасан аялал жуулчлалын том урсгал бий болох боломж бий.

- Аялал жуулчлал хурдацтай хөгжихийн хэрээр сөрөг нөлөөлөл нилээдгүй бий болдог. Үүнд жуулчны баазыг дагасан төвлөрөл, хог, бохир усны асуудал, дурсгалт газар болон жуулчны баазуудын зүг үүсэх олон салаа зам, байгалийн болон биет соёлын өвийн хадгалалтын нөхцөл муудах зэрийг нэрлэж болох байна. Энэ нь Монгол орны өмнөд говь нутгийн экологийн эмзэг бүтэц, хөрс, бэлчээрийг муутгах, байгалийн сөрөг нөлөөллийг ихэсгэх муу талтай юм. Байгаль экологид үзүүлэх сөрөг нөлөөлөл, ачааллыг бууруулах зорилгоор аялал жуулчлалын үзмэр бүхий бүх дурсгалт газруудад хүрэх замын чиглэл, зайг заасан тэмдэглэгээг бий болгох, үзмэрийн тайлбар, танилцуулга бүхий мэдээллийн самбар хийх зайлшгүй хэрэгтэй юм байна. Энэ нь нэг талаасаа байгаль орчин, хөрс ургамлыг хамгаалах, нөгөө талаас түүх-соёлын дурсгалууд гэмтэх, устахаас сэргийлэх сайн талтай.
- Өмнөговь аймгийн нутагт буй биет соёлын өв буюу түүх-соёлын дурсгалуудыг аялал жуулчлалын эргэлтэд оруулахын өмнө сайтар хамгаалалтад авах явдал чухал байгаа юм. Энэ нь нэн ялангуяа үлэг гүрвэлийн болон түүх-археологийн дурсгалт газруудад хамгийн их хамаатай. Хэрэв ингэхгүйгээр шууд аялал жуулчлалын үзмэр болгож эхэлбэл үлэг гүрвэлийн мөр зэрэг хосгүй дурсгалууд устах аюул тун ойрхон байна. Иймд эхлээд эмзэг үзмэрүүдийг хэрхэн яаж хамгаалах талаар тусгай хөтөлбөр гаргаж хэрэгжүүлэх хэрэгтэй байна.

Үүний дараа аялал жуулчлалын гол үзмэр болж буй байгалийн болон биет соёлын өвт газруудад хамгаалалтын бүс, хязгаарлалтын хилийг нарийвчлан тогтоон зааглаж, хашаа хайс, машины зогсоол, мэдээлэх самбар, замын чиглэл, зай, хориглосон тэмдэг, тэмдэглэгээг стандартын дагуу хийж байрлуулахыг санал болгож байна.

## 5.6 Соёлын өвийн хөтөлбөр боловсруулах ажилд нутгийн иргэдийн оролцоо зайлшгүй болох нь

"Оюу толгой" төслийн "Соёлын өвийн хөтөлбөр"-ийг боловсруулах, хэрэгжүүлэхэд нутгийн иргэдийн оролцоо амин чухал ач тустай билээ. Уг хөтөлбөрийг боловсруулах хээрийн судалгааны ажлын явцад орон нутгийн захиргаа болон сургууль, соёлын байгууллагын багш, ажилтнууд, нутгийн иргэдийн санаа бодлыг аль болох бүрэн тусгахыг зорьсон юм.

### 5.6.1 Одоо хэрэгжиж байгаа олон нийтийн хөтөлбөрүүд

Монгол улсад хэрэгжиж буй Соёлын өвийн талаарх хөтөлбөрүүдийг дурдвал, “Морин хуур, уртын дуу” үндэсний хөтөлбөр, “Бие биелгээ” үндэсний хөтөлбөр, “Монгол хөөмий” үндэсний хөтөлбөр, “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулах, хадгалах хөтөлбөр”, “Түүх, соёл, үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах үндэсний  үндэсний хөтөлбөр” зэрэг юм.

Эдгээр хөтөлбөрүүдийн Өмнөговь аймаг дахь хэрэгжилтэд нь уул уурхайн компаниудын дэмжлэг их хэрэгцээтэй байна. Учир дээрх үндэсний хөтөлбөрүүдэд хөрөнгө санхүү тусгагдаагүй байдаг тул аймаг, сумын төсвийн хөрөнгөнөөс илүүчлэн арга хэмжээ зохион явуулах боломж хомс байдагт оршдог юм. Тухайлбал, “Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулах, хадгалах хөтөлбөр”-ийн соёлын өвийн мэдээллийн сан бүрдүүлэхэд шаардагдах компьютер болон бусад хэрэгсэл худалдан авах зардал гэж огт байхгүй байна.

Аймгийн Боловсрол, соёлын газраас явуулж буй Соёлын талаарх бодлого, үйл ажиллагааг а) биет соёлын өвийн б) биет бус соёлын өвийн хэмээн нарийвчлан ялган зааглаж, тус тусад нь тодорхой арга хэмжээ төлөвлөж байх хэрэгтэй юм байна. Соёл хэмээн ерөнхийлөн үзэх нь өнөө цагийн шаардлагад тэр бүр нийцэхгүй болж байна. Энэ нь зөвхөн Өмнөговь аймгийн төдийгүй, нийт Монгол улсын хэмжээнд хамаатай юм.

Нүдэнд харагдаж, гарт баригддаг биет соёлын өвд арай илүү анхаарал тавиад улам бүр устаж алга болж буй биет бус соёлын өв болох уламжлалт ёс заншил, хувцас хунар, үг яриа, найр наадмын дэг ёс, ардын язгуур урлаг, үндэсний дуу хөгжим зэрэгт тавих арай бага анхаарч байгаа байдал харагдаж байна.

Өмнөговь аймагт чадвал жил бүр, ядвал хоёр жилд нэг удаа аймгийн уртын дууны, хөөмийн, морин хуурын, язгуур урлагийн, үндэсний бүжгийн, үндэсний хувцасны, ардын гар урлалын зэрэг олон уралдааныг дээрх хөтөлбөрүүдийн хүрээнд зохион байгуулахад уул уурхайн том төслүүдийг шууд татан оролцуулж, төрөл тус бүрийн зардлыг хариуцуулан өгөх ажлыг Боловсрол, соёлын газраас зохион байгуулж, Засаг даргын тамгын газрын зүгээс дэмжин ажил хэрэг болгох хэрэгтэй байна.

Ингэхдээ эдгээр уралдаанд зөвхөн Өмнөговь аймгийн нутаг дэвсгэр дээр амьдран сууж буй хүмүүсийг хамруулах юм. Ингэж ялгаж зааглахгүй бол Улаанбаатар болон бусад аймгийн мэргэжлийн урлагийн байгууллагын хүмүүс ирж шагналыг нь хамаад буцдаг зохисгүй явдал энэ оны 8 сард болсон Говь шанхын уртын дууны уралдааны үеэр болсон билээ. Эдгээр уралдаан тэмцээний гол зорилго нь Өмнөговь аймгийн олон нийтийн дунд уламжлалт биет бус соёлын өвийг хадгалах, хамгаалах, сурталчлахад чиглэх ёстой.

### 5.6.2 Цаашид авч хэрэгжүүлэх хөтөлбөрүүд

"Монгол хувцасны үндэсний хөтөлбөр" боловсруулж улс орон даяар мөрдүүлэх нь чухал болохыг Өмнөговь аймагт уул уурхай хөгжиж, үндэсний хувцас өмсөх явдал ихэд багасч байгаагаас харагдаж байна. Үндэсний хувцас гэдэг бол бүхэл бүтэн Соёлын өв юм. Хэдийгээр Өмнөговь аймгийн зарим сумдад жилд 1 удаа албан газар, сургуульд "Монгол хувцасны өдөр" болдог ч энэ нь санасан хэмжээнд хүрэхгүй байна.

Ханбогд сумын төвийн хүмүүс байтугай хөдөө нутагтаа мал маллаж буй малчдын дунд хүртэл үндэсний хувцсаа бус уурхайн хувцас өмсөж байгаа нь үндэсний хувцас мартагдах аюул ойрхон ирснийг илтгэж байна. "Оюу толгой" төслийн шууд нөлөөллийн Манлай суманд уламжлал болсон долоо хоногийн 1 дэх өдөр бүр үндэсний хувцас өмсдөг сайхан уламжлалыг бүх сумдад нэвтрүүлэх нь зүйтэй юм.

"Оюу толгой" төслөөс эрхлэн шууд нөлөөллийн бүсийн 3 сум тус бүрд загвар-гоёлын бус үндэсний хувцас–малгай, дээл, хантааз, хүрэм, гуталны уралдааныг жил бүр зохион байгуулж байх саналыг албан ёсоор тавьж байна.

Мөн Өмнөговь аймгийн хэмжээгээр үндэсний хувцасны наадам, үндэсний хувцасны өдөр жил бүр зохиож, үүндээ уул уурхайн компаниудаас зохих дэмжлэг авах талаар аймгийн Боловсрол, соёлын газар тодорхой ажил хийх хэрэгтэй байна.

## 5.7 Олон нийтийн хөтөлбөрийн талаарх дүгнэлт

"Соёлын өвийн хөтөлбөр"-ийн хэрэгжилт нь нутгийн иргэдийн оролцооноос шууд хамааралтай. Уламжлалт соёлын өвийг хадгалах, хамгаалах үндсэн үүрэг нутгийн иргэдэд өөрсдөд нь байгааг 2010 оны 8-р сард болсон Ханбогд сумын 4 багийн хурлын үеэр ярьж таниулсан билээ. Баян-Овоо, Манлай сумдад энэхүү сургалтын ажлыг бас хийх ёстой бөгөөд үүнийг багийн дарга нар болон албан бус боловсролын багш нараар дамжуулан хийх бололцоотой юм.

Жил бүрийн төгсгөлөөр Өмнөговь аймгийн нутгийн удирдлагын байгууллага, соёлын мэргэжилтнүүд, сумдын иргэдийн төлөөлөл, уул уурхайн компаниуд гэсэн 4 талын яриа хэлэлцүүлэг хийж Соёлын өвийн хадгалалт, хамгаалалт, сурталчилгааны талаарх тухайн жилийн ажил байдлаа хэлэлцэн дүгнэж, дараа жилийн ажлын зорилтоо нарийвчлан тодорхойлдог ажлыг тогтмолжуулах хэрэгтэй юм байна. Энэ бол Соёлын өвийн талаарх тогтвортой бодлого, үйл ажиллагааны нэг чухал хэсэг болох юм. Нөгөө талаар Соёлын өвийн талаарх бодлогыг тодорхойлох, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд нутгийн иргэдийн оролцоог дээшлүүлэх нэгэн чухал хөшүүрэг болно хэмээн үзэж байна.

# 6. НУТГИЙН ИРГЭД БОЛОН ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН ЗӨВЛӨГӨӨН

**Б. Гүнчинсүрэн ба Ч. Амартүвшин**

Энэхүү төслийн үндсэн гол ажил бол Соёлын өвийн хөтөлбөр боловсруулах ажилд Орон нутгийн иргэдийн санал, хүсэлтийг түлхүү оруулах, тэдний оролцоог дэмжих явдал билээ. Иймээс манай багийн бүрэлдэхүүн төслийн эхний өдрөөс эхлэн орон нутагт ажиллаж нутгийн иргэдтэй уулзаж Оюу толгой төсөл, түүний нөлөө биет болон биет бус өвд хэрхэн тусах талаар тэдний санал бодлыг тусгаж байв (Хавсралт 13. "Соёлийн өвийн хөтөлбөр" төслийн баримт бичиг). Энэхүү зургаан сарын хугацаанд гурван багийн гишүүд нэгдсэн болон тусгайлсан байдлаар Ханбогд, Манлай, Баян-Овоо, Даланзадгад сумын иргэдтэй уулзалтыг гурван удаа хийлээ. Энэ нь зөвхөн энэ гурван удаагийн уулзалтаар орон нутгийн иргэдтэй холбоотой ажилласан гэсэн хэрэг биш бөгөөд хээрийн судалгаагаар ажиллах, хөтөлбөр боловсруулах суурь судалгааны бүхий л хугацаанд тэдэнтэй холбоотой байсан болно.

Нутгийн иргэд болон оролцогч талуудтай хийсэн уулзалт зөвлөгөөнүүдээс хамгийн чухал нь 2010 оны 9 дүгээр сард зохион байгуулсан "Монгол олон улсын өв"-ийн багийн судлаачидтай хийсэн уулзалт байлаа. Эдгээр цуврал уулзалт хуралдаан зохион байгуулсны дараа Өмнөговь аймгийн соёлын өвийн хамгаалалтын талаар гол гол оролцогч талуудаас бүрдсэн "Соёлын өвийн хөтөлбөр"-ийн Зөвлөх хороог байгуулах боломжтой болсон ба уг зөвлөх хорооны анхдугаар хуралдааныг 2010 оны 12 дугээр сард зохион байгуулсан. Энэхүү хуралдаан болон бусад бүх хуралдааны талаар дор товч өгүүлэв.

## 6.1 Оролцогч талуудтай хийсэн уулзалтууд

Орон нутгийн иргэдтэй хийсэн уулзалтын тухай дор сийрүүлэв.

| № | Уулзалтын сэдэв | Багийн нэр / судлаач | Хамрах хүрээ | Огноо |
|---|---|---|---|---|
| 1 | "Соёлын өв гэж юу болох", "Түүнийг хамгаалан хойч үестээ үлдээхэд юу хийх" уулзалт | Ж.Гэрэлбадрах С.Чулуун | Баян, Номгон, Жавхлант, Гавилууд багийн засаг дарга нар болон нутгийн иргэд | 2010-*08-01-08-04* |
| 2 | Түүх-соёлын талаар судалгааны ажил сонирхон хийдэг иргэдтэй хийсэн уулзалт | Б.Гүнчинсүрэн Ч.Амартүвшин | Ханбогд, Даланзадгад, Баян-Овоо, Манлай сум | 2010-*08-18-08-27* |
| 3 | Монголын соёлын өвийн багийн уулзалт | Б.Гүнчинсүрэн Ж.Гэрэлбадрах С.Чулуун Х.Цогтбаатар | Даланзадгад, Ханбогд, Баян-Овоо, Манлай | 2010-*09-20-09-27* |

### 6.1.1 Ханбогд суманд хийсэн танилцуулах уулзалт

**Уулзалтын сэдэв: "Соёлын өв гэж юу болох", "Түүнийг хамгаалан хойч үедээ үлдээхэд юу хийх"**

Соёлын биет бус өвийн судалгааны болон олон нийттэй харилцах хэсгийн судлаачид болох доктор, дэд профессор Ж. Гэрэлбадрах, доктор, дэд профессор С. Чулуун нар 2010 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс 08 дугаар сарын 04-ний өдрүүдэд "Оюу толгой" ХХК-ний зүгээс зохион байгуулсан Ханбогд сумын дөрвөн багийн хурлуудад оролцож "Соёлын өв гэж юу болох", "Түүнийг хамгаалан үр хойчисдоо үлдээхэд юу хийх" тухай бичил танилцуулгыг хийсэн. Мөн "Оюу толгой" Соёлын өвийн хөтөлбөр боловсруулахын тулд нутгийн иргэдийн зүгээс ямар санал сэтгэгдэлтэй байгаа талаар урьдчилсан судалгааг гүйцэтгэсэн. Тус багийнхан 08 дугаар сарын 05-наас 08-ны өдрүүдэд Ханбогд сумын удирдлага болон "Оюу толгой" төслийн удирдлагуудтай уулзаж өөрсдийн судалгааны ажлын тухай дэлгэрэнгүй танилцуулгыг хийсэн болно.

### 6.1.2 Түүх соёлын талаар сонирхдог иргэдтэй хийсэн уулзалт

Манай судлаачид "Оюу толгой" төслийн шууд нөлөөллийн бүсүүдэд орж байгаа Ханбогд, Даланзадгад, Баян-Овоо, Манлай сумдын удирдлага, Соёлын өвийн төвийн эрхлэгч, Соёлын асуудал хариуцсан байцаагч, сум орныхоо түүх-соёлын талаар судалгаа хийдэг хүмүүстэй уулзах ажлыг 2010 оны 08 дугаар сарын 18-ны өдрөөс 08 дугаар сарын 27-ны өдрүүдэд хийж гүйцэтгэлээ.

Өмнөговь аймгийн Даланзадгад хотын иргэн Бат-Өлзийтэй хийсэн уулзалт 2010 оны 08 дугаар сарын 19-ны 14:00 цагт болсон. Энэ хүн өмнө нь улсад хариуцлагатай алба хашиж байсан бөгөөд одоо Өмнөговь аймгийн Ахмадын зөвлөлийн даргаар ажиллаж байгаа юм байна. Тэрээр өөрийн аймгийн түүх, соёлыг хамгаалах, хойч үедээ өвлүүлэн үлдээх чин хүсэлтэй бөгөөд түүнийгээ биелүүлэхийн тулд нилээдгүй ажлыг хийжээ. Үүний нэг жишээ бол аймгийн хэмжээнд буй түүх-соёлын дурсгалын бүртгэлийг хийхийн тулд аймгийн засаг даргын тамгын газраас хөрөнгийн асуудлыг шийдүүлэн 2009 онд "Чингис хаан" дээд сургуулийн захирал, доктор Х. Лхагвасүрэн, судлаач н.Балжинням нартай хамтран бүртгэл хийх хээрийн шинжилгээний анги зохион байгуулсан байна. Энэхүү хээрийн шинжилгээний ангийг зохион байгуулахад түүний толгойлж байгаа Ахмадын хороо чухал үүрэг гүйцэтгэжээ.

Өмнөговь аймгийн иргэн А. Цоожтой 2010 оны 8 дугаар сарын 19-ны 16:10 цагт тус аймаг дахь Оюу толгой компанийн төлөөлөгчийн газрын хурлын танхимд уулзалт зохион байгуулав. А.Цоож нь Өмнөговь аймгийн Сэврэй сумын уугуул иргэн мөн л аймагтаа хариуцлагатай алба хашиж байсан байна. Тэрээр түүх-соёлын өвийг хадгалалт хамгаалалт, аймгийнхаа түүх, байгаль орчны талаар олон ном бүтээлийг хэвлүүлсэн бүтээлч хүн болно.

Ханбогд сумын Гавилууд багийн дарга н.Улам-Ундрахтай 2010 оны 8 дугаар сарын 23-ны өдөр өөрийн гэрт нь очиж уулзав. Уулзалтын хүрээнд тухайн бүс нутагт тулгамдаад байгаа асуудлууд болон түүх, соёлын дурсгалын талаарх зарим мэдээллийг авав.

Ханбогд сумын засаг даргын орлогч н.Цогтгэрэлтэй 2010 оны 8 дугаар сарын 23-ны өдөр уулзаж өөрсдийн ажлын талаар танилцуулав. Тэрээр энэхүү төслийг өөрийн зүгээс бүх талаар дэмжин ажиллахаа илэрхийлж, цаашид холбоотой ажиллахыг хүсэв.

Баян-Овоо сумын Засаг дарга Х. Батболдтой уулзаж өөрсдийн төслийн талаар танилцуулж, санал сэтгэлдлийг сонсов. Тэрээр мөн уг төслийг дэмжин ажиллахаа илэрхийлээд татварын байцаагч Ө. Сүхбаатар, соёлын төвийн эрхлэгч н.Жүрмэддорж нарыг танилцуулав. Тэд өөрийн суманд тулмагдаад байгаа асуудал болон түүх соёлын дурсгалын хадгалалт хамгаалалтын талаар авах арга хэмжээний талаар өөрсдийн саналаа хэлэв.

Манлай сумын Засаг дарга Х. Сугиртай уулзаж мөн өөрсдийн төслийн талаар танилцуулахад төслийн талаар ойлголттой байснаас гадна зарим мэдээллийг өгөв. Манлай сумын нутагт үлэг гүрвэлийн чулуужсан яс, далайн амьтны хэв дардас зэрэг палеонтологийн чухал олдворууд байдаг бөгөөд эдгээрийн хадгалалт хамгаалалтанд цаг алдалгүй анхаарахгүй бол сүйдэж дуусаж байгааг дамжуулав. Мөн энэ чухал палеонтологийн дурсгалыг дайруулан төмөр зам тавихаар яригдаж байгааг сануулаад үүнийг хэрхэн авран хамгаалах талаар арга хэмжээ авч өгөхийг хүссэн.

### 6.1.3 Орон нутгийн байгууллагуудтай хийсэн уулзалтууд

Даланзадгад хотын музейтэй 2010 оны 08 дугаар сарын 20-ны өдөр танилцаж музейн бүртгэл мэдээллийн сангийн ажилтан Д. Баярмаа, сан хөмрөгч Б. Жаргал нар өөрсдийн байгууллагын талаар танилцуулга хийсэн.

Уг музейн үйл ажиллагаа ерөнхийдөө сайн явагдаж байгаа хэдий ч төрийн байгууллагуудын уялдаа холбоо муу байгаагаас тэдэнд түүх соёлын үл хөдлөх дурсгалын мэдээллийн сан хомс, үзмэрийн баяжуулалт зогссон зэргээс харж болно. Музей үйл ажиллагаагаа идэвхитэй хийж байгаа нэг зүйл бол Даланзадгад хотод шинээр барихаар төлөвлөж буй шинэ музейн байрны асуудал юм. Энэ байрыг бариулахаар олон талаар хөөцөлдөж байгаа боловч одоо хир тодорхой ахиц гараагүй байна.

Аймгийн Төв номын сантай 2010 оны 08 дугаар сарын 20, 21-ний өдөр очиж танилцав. Номын сан өөрийн гэсэн байртай хэдий ч багтаамж муу, уншлагын танхим жижиг, ховор хуучин номын фонд хадгалалтын горим алдагдсан байна. Ховор хуучин номын фондод Монгол улсын хэмжээнд цорын ганц байдаг “Хөх судар” хэмээх муутуу цаасан дээр хар бэхээр бичсэн гар бичмэл (Хавсралт зураг 12) болон бусад ховор нандин номууд хадгалагдаж байгаа хэдий ч бүгд хадгалалтын буруугаас нилээд муудаж, зарим хуудас устаж үгүй болоход хүрсэн байна.

Ханбогд сумын “Галба” музейтэй 2010 оны 08 дугаар сарын 22-ны өдөр танилцав. Уг музейг Хаан банкны тусламжтайгаар сумын Соёлын төвийн дэргэд өргөтгөл маягтай шинээр барьсан байна. Саяхан шинээр байгуулагдсан тул үзмэрийн дэглэлт зохион байгуулалт бүрэн дуусаагүй ажээ.

Манлай сумын соёлын төв, номын сан, музейтэй 2010 оны 08 дугаар сарын 26-нд танилцав. Энэ сумын музей, номын сан нь хангалттай сайн ажиллаж байгаа бөгөөд үзмэрийн баяжуулалт ч гэсэн давгүй сайн байгааг энд дурдах хэрэгтэй. Мөн үл хөдлөх дурсгалын тархалтын талаарх мэдээллийг газрын зургаар үзүүлсэн нь чухал зүйл болжээ.

### 6.1.4 Монгол Олон Улсын Өвийн Багийн Мэргэжилтнүүдийн Уулзалт

Монголын Олон Улсын Өвийн багийн гишүүдийн анхны бүрэн уулзалт 2010 оны 09 дүгээр сарын 19-ны 10 цагт болсон. Уулзалтаар Монголын судлаачид, гадаадын нөхдөдөө Монголын түүх, археологи, угсаатны зүй, палеонтологийн судалгааны өнөөгийн хүрсэн түвшин, хийж буй судалгааны ажлуудынхаа талаар товч танилцуулсан. Мөн, “Оюу толгой” орчимд өмнө нь хийсэн судалгааны ажлынхаа тухай мэдээлсэн.

Хээрийн аялал дууссаны дараа судлаачид, судалгааны чиглэл бүрээрээ цаашид хийх ажлаа нарийвчлан тогтоох, зөрүүтэй байгаа ойлголтуудаа нэг болгох уулзалтуудыг хийсэн. 2010 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр Монголын Олон Улсын Өвийн Багийн судлаачид анхны үр дүнгээ "Оюу толгой", "Рио Тинто" компанийн мэргэжилтнүүдэд дэлгэрэнгүй танилцуулсан уулзалтыг хийсэн.

Монголын олон улсын өвийн багийнхан 2010 оны 09 дүгээр сарын 20-ны өдөр Улаанбаатар – Даланзадгадын чиглэлийн нислэгээр хүрэлцэн очсон. Уулзалтуудыг тус бүрээр нь жагсаавал:

2010 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 09.00 цагаас олон улсын багийн гадаадын судлаачид маань "Оюу толгой" төслийн дэд ерөнхийлөгч С. Санждоржтой уулзан, ордын тухай үндсэн мэдээллийг авч, өөрсдийн сонирхсон асуултандаа хариулт авсан. Мөн уурхайн бүтэц зохион байгуулалттай танилцах бичил аяллыг хийсэн.

2010 оны 09 дүгээр сарын 21-ний өдрийн 13.30 цагаас Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг дарга Л. Дэндэвсамба, Баян, Номгон, Жавхлант, Гавилууд багуудын засаг дарга нар болох М. Мягмаржав, А. Мягмар, Н. Ширнэн, Улам-Ундрах, Ханбогдын Соёлын төвийн эрхлэгч Нарангэрэл, "Шинэ Ханбогд" ТББ-ын тэргүүлэгч гишүүн Сандагсүрэн нартай уулзалт хийж өөрсдийн хийх ажлынхаа талаар танилцуулсан. Сумын Соёлын төвийн эрхлэгч Нарангэрэл, "Шинэ Ханбогд" ТББ-ын Сандагсүрэн нар хамтран ажиллахаа илэрхийлсэн. Зөвлөх багийн бүрэлдэхүүнд тодорхой тооны хүн оруулах саналтай байгаагаа танилцуулахад багийн Засаг дарга нар ямар ажил эхлэн хийх гэдгээ бус ямар хөлс авахаа сонирхсон нь судлаачдын сэтгэлд нийцээгүй болно. Дараа нь судлаачид, Ханбогд сумын "Галба" музей, сүмийн хийдийн үйл ажиллагаатай танилцсан.

2010 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн 11.00 цагаас Өмнөговь аймгийн Манлай сумын засаг дарга Х. Сугир, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын дарга, Засаг даргын орлогч, Байгаль орчны улсын байцаагч, Соёлын төвийн эрхлэгч, сургуулийн захирал нартай уулзаж өөрсдийн хийх ажлынхаа талаар танилцуулж харилцан ярилцсан. Сумын Засаг дарга Х. Сугир судлаачдад өөрийн биеэр сумынхаа музейг танилцуулсан. Бусад сумдаа бодвол харьцангуй зохион байгуулалт сайтай музей болохыг судлаачид хүлээн зөвшөөрсөн. "Оюу толгой" соёлын өвийн хөтөлбөр боловсруулах багийн зөвлөх хэсгийн бүрэлдэхүүнд оролцон ажиллахыг хүсэхэд Х. Сугир нь хүсэлтийг зөвшөөрч байгаагаа мэдэгдсэн.

2010 оны 09 дүгээр сарын 23-ны өдрийн 11.00 цагаас Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын засаг дарга Х. Батболд, татварын байцаагч, ахмад настан н. Сүхбаатар, Соёлын төвийн эрхлэгч Д. Жүрмэддорж болон байгал орчны улсын байцаагч нартай уулзаж өөрсдийн хийх ажлынхаа талаар танилцуулж харилцан ярилцсан. "Оюу толгой" соёлын өвийн хөтөлбөр боловсруулах багийн зөвлөх хэсгийн бүрэлдэхүүнд оролцон ажиллахыг хүсэхэд Х. Батболдод санал болгосон.

2010 оны 09 дүгээр сарын 24-ний өдрийн 10 цагаас Өмнөговь аймгийн төв Даланзадгад хотноо, Нутгийн удирдлагын ордонд судлаачдын урьдчилан төлөвлөсөн уулзалтуудын сүүлчийн уулзалт болсон. Уулзалтанд, Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга Б. Түвшинбаяр, Засаг даргын тамгын газрын соёлын асуудал эрхэлсэн түшмэл н. Уламцэцэг, Аймгийн мэргэжлийн хяналтын газрын соёлын асуудал эрхэлсэн улсын байцаагч Бурмаасүрэн, Аймгийн Орон нутгийг судлах музейн захирал Ц. Отгонтуяа, Номын сангийн ажилтан н. Түвшинжаргал, Аймгийн ахмадын зөвлөлийн дарга н. Бат-Өлзий, Өмнөговь аймгийн Байгаль хамгаалах нийгэмлэгүүдийн тэргүүн н. Даргахүү нар оролцсон. Энд судалгааны хэсэг бүр өөрсдийн судалгааны судлагдахуун, түүнийг хэрхэн судлаж, хэрхэн хамгаалах талаар дэлгэрэнгүй танилцуулгыг үзүүлж, уулзалтанд ирсэн хүмүүсийн санал сэтгэгдэлтэй танилцсан. Уулзалтын дараа багийн гишүүд аймгийн Орон нутгийг судлах музей, Номын сангийн үйл ажиллагаатай тусгайлан танилцсан болно.

2010 оны 09 дүгээр сарын 26-ны өдөр 15.00 цагаас Аймгийн Ахмадын зөвлөлийн дарга Н. Бат-Өлзийн хүсэлт болгосны дагуу аймгийн ахмад настан, түүхийн багш Лувсанцэрэн, Батням нартай уулзаж Өмнөговь аймгийн нутгийн соёлтой холбоотой хоёр чухал баримтыг шинээр тэмдэглэж авсан.

### 6.1.5 Зөвлөх Хорооны Уулзалт

"Оюу толгой" ХХК-тай байгуулсан гэрээний дагуу Соёлын өвийн хөтөлбөр боловсруулах явцад үнэлгээ хийх, СӨХ-ийн зөвлөх баг (Монголын Олон Улсын Өвийн Баг (МОУӨБ))-т зөвлөгөө өгөх, олон нийттэй харилцах, мэдээллээр хангах гэсэн үндсэн гурван үүрэг бүхий Зөвлөх хороог байгуулах болсон юм.

Зөвлөх хорооны бүрэлдэхүүнд тухайн салбараар судалгаа хийж байгаа Монголын тэргүүлэх эрдэмтдийг оролцуулахаас гадна нутгийн иргэдийн оролцоо, хүйсийн байдлыг харгалзан үзэж 15 нэр бүхий хүмүүсийг (Хүснэгт 20). сонгон оролцуулсан болно. Зөлөх хороо нь аймгийн болон орон нутгийн засаг захиргаа, ард иргэд, шинжлэх ухаан болон судлаачидаас гадна олон улс болон бүс нутгийн засгийн газрын бус байууллагын төлөөлөгчид зэрэг Өмнөговь аймгийн соелын өв хамгаалалын гол гол оролцогч талуудын төлөөллөөс бүрдсэн. Зөвлөх хорооны гишүүд Соёлийн

өвийн хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэх ба гишүүдийн үүрэг оролцоог Хавсралт 14-д үзүүлэв.

**Хүснэгт 20 Зөвлөх Хорооны гишүүд**

| № | Овог, нэр | Албан тушаал | Үүрэг, оролцоо |
|---|---|---|---|
| 1 | Артаг Б. | Улаанбаатар хот дахь Өмнөговь аймгийн нутгийн зөвлөлийн гишүүн, Улаанбаатар хотын Нийгмийн даатгалын газрын дэд дарга | - Улаанбаатар хотод буй Өмнө-говь аймгийн уугуул иргэдийн санал бодлыг төсөлд тусгах<br>- Аймгийн удирдлагатай төслийн багийн гишүүдийг холбох |
| 2 | Барсболд Р. | ШУА-ийн Палеонтологийн төвийн захирал, академич | - Биет өвийн багийн Палеонтологийн судалгаанд онол, арга зүйн асуудлаар дэмжлэг үзүүлэх |
| 3 | Бат-Өлзий Ц. | Өмнөговь аймгийн Ахмадын зөвлөлийн дарга | - Биет бус өвийн багийн гишүүдэд дэмжлэг үзүүлэн ажиллана. Учир нь энэ хүнд олон жилийн туршид цуглуулсан биет бус өвийн чухал эх хэрэглэгдэхүү-нүүд байгаа болно.<br>- Аймгийн ахмадын байгууллагыг тэргүүлж буй учир газар орон түүх, соёлоо мэдэх ахмадуудтай Зөвлөх багийнхныг холбож өгнө. |
| 4 | Батболд Х. | Өмнөговь аймгийн Баян-Овоо сумын Засаг дарга | - Төслийн бүх багуудыг дэмжин ажиллах. Баян-Овоо сумand хэрэгжүүлэх хээрийн судалгаа-ны ажил, мэдээллийн сан бүрдүүлэлт зэрэгт зөвлөгөө өгөх |
| 5 | Галбаатар Т. | ШУА-ийн Ерөнхий Эрдэмтэн нарийн бичгийн дарга, академич | - Төслийн үр дүнд гарах хууль, эрх зүйн шинэтгэл, бодлогын шинжтэй асуудлыг дэмжин ажиллах |
| 6 | Дэндэвсамба Б. | Өмнөговь аймгийн Ханбогд сумын Засаг дарга | - Төслийн бүх багуудыг дэмжин ажиллана<br>- Ханбогд суманд хэрэгжүүлэх хээрийн судалгааны ажил, мэдээллийн сан бүрдүүлэлт зэрэгт зөвлөгөө өгөх |
| 7 | Куланда Ч. | Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны дэд сайд | - Төслийн үр дүнд гарах хууль, эрх зүйн шинэтгэл, бодлогын шинжтэй асуудлыг дэмжин ажиллана. |

| № | Овог, нэр | Албан тушаал | Үүрэг, оролцоо |
|---|---|---|---|
| 8 | Отгонтуяа Ц. | Өмнөговь аймгийн Орон нутгийг судлах музейн захирал | - Музей, соёлийн өвийн төвүүдтэй холбоотой ажилд дэмжлэг үзүү-лэх<br>- Төслийн олон нийтийн хөтөлбө-рийн хэсгийг дэмжин ажиллана. |
| 9 | Сандагсүрэн. | Өмнөговь аймгийн Ханбогд сумын "Шинэ Ханбогд" төрийн бус бай-гууллагын тэргүү-лэгч гишүүн | - Ханбогд сумын иргэдийн орол-цоог хангах<br>- Төслийн бусад хэсгүүдэд дэмжлэг үзүүлэх |
| 10 | Саруулбуян Ж. | Монголын Үндэс-ний музейн захи-рал, доктор | - Үндэсний музей<br>- Биет өвийн болон олон нийтийн хөтөлбөрийн хэсгийг дэмжин ажиллах |
| 11 | Сугир Х. | Өмнөговь аймгийн Манлай сумын Засаг дарга | - Төслийн бүх багуудыг дэмжин ажиллах<br>- Манлай суманд хэрэгжүүлэх хээ-рийн судалгааны ажил, мэдээл-лийн сан бүрдүүлэлт зэрэгт зөвлөгөө өгөх |
| 12 | Уртнасан Н. | ICOMOS-ын Олон улсын зөвлөлийн тэргүүлэгч гишүүн, ICOMOS-ын Монгол улсын Үндэсний хо-рооны дарга | - Олон улсад хэрэгжүүлж буй соё-лын өвийн хөтөлбөрийн талаарх өргөн туршлагатай тул энэ та-лын асуудлаар зөвлөгөө өгөх |
| 13 | Цоож А. | Өмнөговь аймгийн Түүх, соёлын "Баян түүх" төрийн бус байгууллагын тэргүүн | - Төслийн соёлын биет өвийн су-далгааны багийг дэмжин ажил-лана. Тэрээр өмнө нь тус айм-гийн биет өвийн бүртгэлийг хийж байсан туршлагатай. |
| 14 | Цэвээндорж Д. | ШУА-ийн Археоло-гийн хүрээлэнгийн захирал | - Төслийн биет өвийн археоло-гийн хэсгийг дэмжин, зөвлөгөө өгөх |
| 15 | Түвшинбаяр Б. | Өмнөговь аймгийн Засгийн даргын Тамгын газрын дарга | - Аймгийн удирдлагатай төслийн багийн гишүүдийг холбох<br>- Сумдын удирдлагуудыг аливаа үйл ажиллагаанд татан оролцуу-лах |

Зөвлөх хорооны бүрэлдэхүүний асуудлаар "Оюу толгой" ХХК-нийхантай олон удаа санал солилцсоны эцэст дээр өгүүлсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулахаар болж 2010 оны 11 дүгээр сарын хээрийн шинжилгээний ажлын үеэр орон нутгаас сонгогдсон Зөвлөх хорооны гишүүдтэй уулзаж үйл ажиллагааны хөтөлбөрийг танилцуулж хамтран ажиллах зөвшөөрлийг авсан. "Оюу толгой" Соёлын өвийн хөтөлбөр боловсруулах Зөвлөх багийн үйл ажиллагаанд Зөвлөх үүрэгтэй "Зөвлөх хороо"-ны анхдугаар хурлыг 2010 оны 12 дугаар сарын 16-ны өдөр "Оюу толгой" ХХК-ны Улаанбаатар хот дахь байрны хурлын танхимд зохион байгуулав.

Мөн Зөвлөх хорооны анхдугаар хурлаар Хорооны дарга, Нарийн бичгийн даргаа сонгосон. Хорооны даргаар Түвшинбаяр Б. (Өмнөговь аймгийн Засгийн даргын Тамгын газрын дарга), Нарийн бичгийн даргаар Отгонтуяа Ц. (Өмнөговь аймгийн Орон нутгийг судлах музейн захирал) нарыг сонгосон болно. Зөвлөх хорооны дараагийн хурал 2011 оны 3-р сарын 22нд Ханбогд суманд болсон. Энэхүү хуралдааны гол зорилго нь Нэг дэх шатны тайлангийн загварын талаар Зөвлөх Хорооны тайлбарыг хүлээн авч СӨХ-ийн элементүүдийн талаар хэлэлцэх байсан юм. Зөвлөх Хороо нь нэгдүгээр шатны тайланг дэмжлээ. Уулзалтанд оролцогчид СӨХ-ийн бүрэлдэхүүн хэсэг бүр дээр санал бодлоо солилцлоо. (Хавсралт 16-г үзнэ үү).

# 7. СОЁЛЫН ӨВИЙН ТАЛААРХ МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН

**Ч. Амартүвшин, Б.Гүнчинсүрэн, Жеффрей Х. Алтшул**

Бид энэ төслийн хүрээнд Монгол Улсын хууль эрхзүйн орчинд нийцсэн Соёлын Өвийн Хөтөлбөрийг боловсруулахыг зорьсон тул Монгол Улсын соёлын өвтэй холбоотой хууль эрхзүйн орчныг сайтар судлаж мэдэх нь чухал байлаа. Бид ямар үндэслэлээр өнөөгийн хууль, эрх зүйн орчин бүрдсэн, хэрэгжилтийн хувьд сайн болон саар яваа ямар, ямар хэсгүүд байна, хэрхэн сайжруулах боломжууд байгаа талаар нилээд нухацтай судлах шаардлагатай байсан.

Уг бүлэгт бид Монгол Улсын соёлын өвийн хууль эрхзүйн орчин болон соёлын өвийн талаар Монгол Улсын нэгдэн орсон конвенциудын тухай бичив. Мөн түүнчлэн соёлын өвтэй холбоотой хууль хэрэгжихгүй байгаа үндсэн шалтгаан, түүнийг нэмж сайжруулахаар санал болгож буй шинэ эрхзүйн орчны тухай багтаав.

## 7.1 Соёлын өвтэй холбоотой Монгол улсын хуулийн тойм

Монгол улсын Үндсэн хуулийн нэгдүгээр бүлгийн 7 дугаар зүйлд "Монголын ард түмний түүх, соёлын дурсгалт зүйл, шинжлэх ухаан, оюуны өв төрийн хамгаалалтад байна", Монгол улсын Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 6 дугаар бүлгийн 17 дугаар зүйлийн 10-т "Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгоход түүх, археологийн мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул судалгаа хийлгэж зөвшөөрөл авна. Урьдчилан хайгуул хийлгэх, илэрсэн түүх соёлын дурсгалт зүйлийг авран хамгаалах ажилд шаардагдах зардлыг барилга байгууламжийн захиалагч тал хариуцна", "газрын хэвлийг ашиглах явцад түүх соёлын дурсгалт зүйл илэрвэл ашиглагч нь ажлаа зогсоож энэ тухай сум, дүүргийн засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ" Хэрэв энэхүү заалтыг зөрчсөн тохиолдолд 200.000-250.000 төгрөгөөр торгож, үйл ажиллагаа, судалгаа шинжилгээ хийх, хувилан олшруулах, хуулбар хийх, хадгалалтыг зогсоох, хууль бусаар олсон орлогыг хураах арга хэмжээ авахаар заасан байна.

Мөн БСШУЯ-наас гаргасан *"Монгол улсын нутагт археологийн хайгуул, малтлага судалгаа хийх журам"-ын 2.3 болон 2.4 дэхь заалтанд "Хот суурин, барилга байгууламж, уул уурхайн үйлдвэр барьж байгуулах, зам тавих, усан цахилгаан станц барих зэрэг үйл ажиллагаа явуулах байгууллага, аж ахуйн нэгж нь урьдчилан уг асуудлаа Мэргэжлийн зөвлөлд тавих бөгөөд, Мэргэжлийн зөвлөл нь тухайн газар нутагт мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллагаар археологийн урьдчилсан хайгуул, судалгаа хийлгэн дүгнэлт гаргуулж, зөвшөөрөл өгсний дараа уг газар шорооны ажлыг эхлүүлнэ. "Хот суурин, барилга байгууламж, уул уурхайн үйлдвэр барьж байгуулах, зам тавих, усан цахилгаан станц барих газарт археологийн урьдчилсан хайгуул, судалгаа хийлгэх, илэрсэн түүх, соёлын дурсгалыг авран хамгаалах ажилд шаардагдах зардлыг барилга байгууламжийн захиалагч хариуцна"* хэмээн тус тус заасан байна.

## 7.2 Монгол улсын нэгдэн орсон соёлын өвийн тухай юнескогийн конвенциуд

Олон улсын хамтын нийгэмлэг – ЮНЕСКО 1972 онд Дэлхийн байгалийн болон соёлын өвийг хамгаалах тухай Конвенци, 2003 онд Соёлын биет бус өвийг хамгаалах тухай конвенцийг тус тус батлан гаргасан нь дэлхий нийтэд түгээмэл ач холбогдолтой, хосгүй гайхамшигт байгалийн болон соёлын өвүүд, улс үндэстэн бүрийн амьдралын хэв шинж, өвөрмөц онцлогийг тусгасан, түүний нэрийн хуудас, таних тэмдэг болсон соёлын биет бус өвүүдийг хадгалж хамгаалах, өвлүүлэх үйл явцад томоохон алхам болсон юм.

Монгол Улс 1964 онд, "Зэвсэгт мөргөлдөөний үед соёлын үнэт зүйлийг хамгаалах тухай Гаагийн конвенци"-д нэгдэн орж түүний үзэл санаа, зорилтыг хүлээн зөвшөөрч, тууштай дэмжиж ирлээ. Монгол Улс 1990 оноос хойш хүн төрөлхтний нийтлэг замд нэгдэж, дэлхий дахинд нээлттэй болж эхэлсэн нь олон улсын чанартай гэрээ, конвенцид нэгдэн орж ажиллах нөхцлийг бүрдүүлсэн юм. Тухайлбал, 1990 онд ЮНЕСКО-гийн "Дэлхийн соёлын болон байгалийн өвийг хамгаалах тухай конвенци"-д, 1991 онд "Соёлын үнэт зүйлсийг хууль бусаар хилээр гаргах, оруулах, түүнчлэн өмчлөх эрхийг шилжүүлэхийг хориглох, урьдчилан сэргийлэх арга хэмжээний тухай конвенци"-д, 2005 онд "Биет бус соёлын өвийн конвенци"-д, 2007 онд "Соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах болон хөхүүлэн дэмжих тухай конвенци"-д тус тус нэгдэж орсноор тэдгээрийн үзэл санаа, үндсэн зарчмууд болон шаардлагыг соёлын өвийг хамгаалах хууль тогтоомж, бусад баримт бичигт тусган хэрэгжүүлж эхэлсэн байна.

Эдгээр конвенцийн хүрээнд ЮНЕСКО өвүүдийг Дэлхийн өвийн жагсаалт, Соёлын биет бус өвийн Төлөөллийн Дэлхийн жагсаалт, Аюулд учирч буй Дэлхийн Өвийн Жагсаалт болон Яаралтай хамгаалах шаардлагатай Соёлын биет бус өвийн Дэлхийн жагсаалтанд бүртгэж, хамгаалах арга хэмжээ авч байна. Түүнчлэн 1990-ээд оноос байгаль, соёлын өвөө ирээдүй хойч үедээ өвлөн үлдээх, залуучуудад өв соёлоо дээдлэн хүндэтгэх хүмүүжил олгох, түүнийг хадгалж хамгаалах талаар мэдлэг, ур чадвар эзэмшүүлэх зорилгоор Дэлхийн Өвийн боловсролын асуудлыг дэвшүүлэн тавьж хэрэгжүүлж байна.

Монгол улс Дэлхийн Өвийн жагсаалтанд “Увс нуурын ай сав”, “Орхоны хөндийн соёлын дурсгалт газар”-ыг, Соёлын биет бус өвийн Дэлхийн жагсаалтанд “Морин хуур хөгжмийн уламжлалт урлаг”, “Монгол ардын уртын дуу”, “Монгол тууль”, “Бий биелгээ”, “Цуур хөгжмийн уламжлалт урлаг”, “Монгол наадам”, “Монгол хөөмий”, “Шувуугаар ан агнах урлаг”-ийг бүртгүүлсэн байна.

## 7.3 Соёлын өвийн хууль эрх зүйн өнөөгийн орчин

Соёлын өвийг хадгалах хамгаалах талаар эртний уламжлалтай, өөрийн гэсэн дэг жаягтай ард түмэн бол монголчууд бид билээ. Энэхүү уламжлалаа өнөөг хүртэл ямар нэгэн хэмжээгээр хадгалсаар ирсэн боловч зарим тал дээр мартан умартаж байгааг бэлхнээ харж байна.

Монгол улсад 1924 оны 8 сарын 7-нд батлан гаргасан “Хуучны зүйлийг сахин хамгаалах дүрэм” хэмээн эртний түүх, соёлын үнэт зүйлсийг үнэлж үзэх, судлан шинжлэх, хадгалж хамгаалах талаар маш чухал баримт бичгийг гаргажээ.

Монгол улсын хэмжээнд дагаж баримталж байснаас гадна гадаад оронтой байгуулсан эрдэм шинжилгээний гэрээ, хэлэлцээрт тусган мөрдөж байсан уг дүрмийн дотор, Монгол улсын хязгаар дотор буй бүхий хуучны дурсгал болох зүйл цөм Монгол Улсын өөрийн хөрөнгө болох, хуучны дурсгал гэдэгт эх түүхэнд холбогдох бичиг зураг бүхий ба бичиг зураггүй булшны чулуу, хөрөг, жич зураг бичигтэй ба зураг бичиггүй хад, пайз, чулуун пайлуур, багана зэргийн зүйл, жич хуучин цагийн зоосны аймаг, чулуу шороо овоолох зэргээр үйлдсэн булшууд бүх хэрэгслийн хамт, эрт цагийн эвдэрхий хот балгас зэрэг зүйл, орон сав зэрэг эртний түүх ба онгон тахилга, холбогдох урлан үйлдсэн зэрэг зүйлийг ойлгох ба газрын дээр буюу доороос археологийн дурсгалт зүйлийг ухаж авах, судлан шинжлэх явдлыг Судар бичгийн хүрээлэнгээс удирдаж, харгалзан хянах, зөвшөөрөл олгох, энэ дүрмийг зөрчигчид буй аваас шүүх цаазын зохих зүйлийн ёсоор яллан шийтгэж байх зэрэг шинэ цагийн соёлт олон улсын археологийн ухааны хууль ба ёс зүйн шинжтэй зарчмын заалтууд оржээ. Энэхүү дүрмийн гол үзэл санаа мөн онд баталсан "Судар бичгийн хүрээлэнгийн эрхлэх үйлдвэрийн товчоо"-нд улам гүнзгий тусгагдаж, Монгол Улсад шинжлэх ухааныг хөгжүүлэх, түүний бааз суурийг өргөтгөх агуулгатай олон томоохон зорилт дэвшүүлсний дотор "...эрхбиш Судар бичгийн хүрээлэнд археологи хэмээгч хуучин булш, хөшөөний зүйл ба түүхийн аймаг зүйлийг шинжлэх тасалгаа буюу кабинет... байх хэрэгтэй болно" хэмээн онцлон заасан байна.

Үүний дараа 1970 онд, "БНМАУ-ын Соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль" батлагдсан нь түүх, соёлын дурсгалт зүйлийг нэр төрлөөр нь ангилах, тэдгээрийг хамгаалах, ашиглах, судлан жинжлэх, сурталчилах, өвлөн эзэмших, хууль зөрчигчдөд хариуцлага хүлээлгэх зэрэг тодорхой харилцааг зохицуулсан анхны бие даасан баримт бичиг байв. 1971 онд Түүх, соёлын дурсгалыг сэргээн засварлах газар, Түүх соёлын дурсгалт зүйлийн зураг төсөл, эрдэм шинжилгээний товчоо байгуулагдаж түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, судалж шинжилж, сурталчилахаар зогсохгүй, тэдгээрийг засаж сэлбэх, сэргээн засварлах ажил төрийн бодлогын түвшинд тавигдах болсон нь энэ талаар гарсан чухал ололт байлаа.

1980-аад оны сүүлч, 1990 оны эхээр улс орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжих үед хүмүүсийн амьжиргаа дордож үе дамжуулан хадгалж ирсэн түүх, соёлын дурсгалт зүйлээ худалдах, ашиг хонжооны эх сурвалж болгох, хууль бусаар хил гаргах, ховор ном судар, түүх, соёлын дурсгалыг зөвшөөрөлгүй хувилан олшруулах, кино дүрс бичлэг хийх, булш хиргисүүрийг дур мэдэн ухах зэрэг зөрчлүүд гарч эхэлсэн билээ. Иймээс түүх, соёлын дурсгалыг хамгаалах, эрэн сурвалжлах, сэргээн засварлах ажлыг эрчимжүүлэх, түүний эрх зүйн үндсийг боловсронгуй болгох талаар дараахь эрх зүйн баримт бичигт тусгасан юм. Тухайлбал, "Монгол улсын Үндсэн хууль" (1992), "Монгол улсын Үндэсний аюулгүй байдлын үзүэл баримтлал" (1994), "Монгол улсын гадаад бодлогын үзэл баримтлал" (1994)-д тулгуурлан 1996 онд "Монгол улсын төрөөс баримтлах соёлын бодлого"-ыг боловсруулан гаргасан. Уг баримт бичигт:

‵'Монголын эрт эдүгээгийн түүх, соёлын дурсгалт зүйл, сан хөмрөгийг үндэсний эрхэм баялаг гэж үзэж төрийн хамгаалалтанд байлгах" гэсэн зарчимыг тодорхойлон түүнийг хэрэгжүүлэх арга замыг "байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс соёлын үнэт зүйлсийг бүтээх, түүх, соёлын үнэт зүйлсийг судалж шинжлэх, хадгалж хамгаалах үйл ажиллагааг бүх талаар дэмжих", "хууль бусаар гадаадад гарсан Монголын түүх, соёлын үнэт зүйлсийг эргүүлэн авчирах ажлыг зохион байгуулах" гэж зааснаар түүх, соёлын дургалт зүйлсийг хамгаалах, түүх, соёлын дурсгалт болон байгалын өвөрмөц тогтоц, онцлог, үнэт зүйлийг нөхөн сэргээх, олон нийтийн хүртээл болгох зорилгоор ЮНЕСКО зэрэг олон улсын байгууллага, сонирхогч орнуудтай хамтран ажиллах зэрэг төрийн соёлын бодлогын үндсэн чиглэлүүд тодорхойлогдсон байна.

Түүнчлэн 1994 онд ‵'Монгол улсын түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль"-ийг шинээр батлав.  Энэ хууль түүх, соёлын дурсгалт зүйл гэдэг ухагдхууныг шинжлэх ухаан, урлаг, эрх зүйн үүднээс нарийвчлан тодорхойлж, түүх, соёлын дурсгалыг сурвалжлан олох, бүртгэх, зэрэглэл тогтоох, археологийн малтлага хийх, судлах, сурталчилах, хадгалж хамгаалах,  сэргээн засварлах, өмчлөх, эзэмших, ашиглах, хил гаргахтай холбогдсон бүхий л харилцааг шинээр зохицуулсан байна.

Энэхүү хуулийг хэрэгжүүлэх ажил үр дүнтэй байсан боловч соёлийн биет бус өвийн эрх зүйн зохицуулалт хангалтгүй байсан учраас 2001 онд дээрх хуульд соёлын бодит бус өв буюуутга соёлын өвийг өвлүүлэн уламжлуулах, хөгжүүлэх, судлах, сурталчилах харилцааг зохицуулах асуудлыг шинээр нэмж "Соёлын өвийг хамгаалах тухай хууль" нэртэй цогц хуультай болсон юм. "Соёлын өвийг хамгаалах тухай хууль" хэрэгжсэнээр соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан бий болж түүх, соёлын дурсгалт зүйлд зэрэглэл тогтоож, арх ологийн хайгуул, малтлага судалгааг шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр гүйцэтгэдэг болж, бүх шатны Засаг дарга нар соёлын өвийн хадгалалт, хамгаалалтанд хяналт тавьдаг болоод байна. Мөн, Монгол улсад нийтлэг хэрэглэгддэг хуулиуд Иргэний ба Эрүүгийн хууль, Гаалийн хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн хууль, Эрдэнэсийн сангийн хууль, Соёлын тухай хууль, Төрийн албан ёсны хэлний тухай хууль зэрэгт түүх, соёлын дурсгалт зүйлийг зохицуулах нэмэлт өөрчлөлтийг тухай бүр тусгаж байснаараа эрх зүйн суурь тогтолцоо бий болсон юм.

Монгол улсын төрийн бүх институтийн хэмжээнд түүх-соёлын асуудал хариуцсан байгууллага, албан тушаалтан байгааг доорх бүдүүвчээс харж болно (Зураг 49). Тухайн асуудлаар гаргасан холбогдох хууль, тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх байгууллагын бүтэц зэргээс харахад нилээд тогтсон хэв маягтай мэт харагдана. Гэвч амьдрал дээр энэ байдал тийм ч сайнгүй байгаа билээ.




**Зураг 49 Соёлын өвийн асуудал хариуцсан болон дагнан гүйцэтгэх байгууллагын томьёолол**

**Соёлын өвийн төв** – Монгол улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Соёл урлагийн газрын бүтцэд багтан ажилладаг. Ажилагсадын дийлэнх нь сэргээн засварлагч, зураач, баримал мэргэжлийн хүмүүс байдаг. Археологич мэргэжилтэй нэг ажилтантай.

**Үндэсний Түүхийн Музей** – Монгол улсын Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Соёл урлагийн газарт харьяалагдан ажилладаг. Эрдэм шинжилгээний статустай, гадаад орнуудтай хамтарсан археологийн төсөл хэрэгжүүлдэг. Мэргэжлийн боловсон хүчний хувьд түүхч, угсаатан зүйн мэргэжлийн судлаачид байдаг. Эдгээр судлаачид нь археологийн хайгуул, малтлага судалгааны ажлын туршлага хуримтлуулсан. Тус байгууллагад ажиллагсадын дотроос Соёлын өвийн хадгалалт хамгаалалтын талаар үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага байгуулсан мэдээ байдаг боловч үйл ажиллагаа идэвхитэй бус.

**Монгол улсын Их сургуулийн Археологи-антропологийн тэнхим** – Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Дээд боловсролын газарт харьяалагдан ажилладаг. Уг тэнхимд ШУА-ийн Археологийн хүрээлэнд ажиллаж байсан туршлагатай археологичид багшилдгаас гадна антропологийн чиглэлийн судлаачид багшилдаг. Материаллаг бааз, боловсон хүчний хувьд хангалттай хэдий ч сургалт дагнасан учир хадгалалт хамгаалалтын асуудлаар байнгын ажиллагаатай байж чаддаггүй. Мөн тус байгууллагад ажиллагсадын дотроос Соёлын өвийн хадгалалт хамгаалалтын талаар үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага байгуулсан мэдээ байдаг боловч үйл ажиллагаа нь идэвхитэй бус.

**ШУА-ийн Археологийн хүрээлэн** - 2002 оны 8 сарын 9-ний өдрийн Засгийн газрын 159 дүгээр тогтоолоор ШУА-ийн Археологийн судалгааны төвийг өргөтгөн Археологийн хүрээлэн байгуулахаар шийдвэрлэсэн юм. Хүрээлэнгийн захирлаар профессор Д. Цэвээндорж, эрдэмтэн нарийн бичгийн даргаар доктор Я. Цэрэндагва нар ажиллаж байна. Тус хүрээлэн нь чулуун зэвсэг судлалын сектор, хүрэл ба төмрийн түрүү үе, хүннү судлалын сектор, дундад зууны археологийн сектор, хүн судлалын сектор, авран хамгаалах судалгааны сектор, археологи-антропологийн лаборатори, музей, номын сан, гар бичмэлийн хөмрөг гэсэн нэгжтэй. Хүрээлэнгийн дэргэд "Монголын археологичдын холбоо" гэсэн төрийн бус байгууллага байгуулан ажилладаг. Энэ төрийн бусын байгууллага нилээд идэвхитэй үйл ажиллагаатай бөгөөд Монгол улсын авто замын трассын дагуух авран хамгаалах судалгааны ажлыг ерөнхийд нь дагнан гүйцэтгэдэг болно.

## 7.4 Соёлын өвийг хамгаалах талаар Монгол улсын засгийн газраас авч буй арга хэмжээ

Энэ талаар янз бүрийн арга хэмжээ авч байгаа мэт харагдавч энэ дорвитой урт хугацааны үргэлжилсэн ажил болж чаддаггүй. Жишээлбэл, үнэтэй хосгүй олдвор алдагдах, хүмүүсийн мэддэг чухал дурсгал сүйтгэгдсэн зэрэг мэдээлэл олон нийтэд тарвал үүнийг намжаах үүднээс зарим хурал, мэдээллүүдийг хийнэ. Мөн дөрвөн жилд нэг удаа зохион байгуулдаг парламентын сонгуулийн үед нэр дэвшигч нар соёлын өв, түүх-уламжлалын талаар олон зүйл амлаж, ярьж сонгогчдын саналыг татдаг. Сонгогдсоны дараа зарим гишүүд сонгогчидод үнэлгээ авах үүднээс мэргэжлийн байгууллага, эрдэм шинжилгээний ажилтнуудаас мэдээлэл, санаачлагуудыг авч өөрийн санаа мэт олон нийтэд танилцуулна. Сонгуулийн өмнөх жилүүдэд ийм арга барил парламентын гишүүдийн дунд илүү өрнөдөг.

Засгийн газраас 2007 онд Монгол улсын хэмжээнд соёлын биет өвийг бүртгэх ажлыг зохион байгуулахаар төсөв мөнгөний асуудлыг шийдсэн боловч өргөн уудам нутагтай уулын жалга, ам бүхэндээ дурсгалтай Монгол улсын хувьд төсөв нь чамлалттай байсан. Мөн энэхүү бүртгэлийн ажлыг дагнан гүйцэтгэх байгууллагаар мэргэжлийн байгууллага сонгогдоогүй учраас өнөөдөр мухардмал байдалд ороод байгаа болно. Учир нь Боловсрол Соёл, Шинжлэх Ухааны яамны дэргэдэх “Соёлын өвийн төв” гэсэн нэртэй энэ байгууллагын нэр яг энэ ажлыг гүйцэтгэх ёстой мэт харагдах боловч боловсон хүчин, туршлагын хувьд бага байсантай холбоотой. Соёлын өвийн төв нь сүм хийд, урлагийн бүтээл сэргээн засварлах үйл ажиллагаа дагнан гүйцэтгэдэг байгууллага бөгөөд одоо зөвхөн мэргэжлийн нэг археологич ажиллаж байна.

Монгол улсын үе үеийн Ерөнхийлөгч нар Соёлын өв, түүх-соёлын дурсгалын талаар маш их анхаарал тавьж байгаа мэт харагддаг. Гэвч Монгол улсын Ерөнхийлөгч ямар нэгэн хөрөнгө санхүү, шийдвэр гаргах хэмжээний асуудлыг шууд шийдэх эрх мэдэл байхгүй байдаг. Тэд зарлиг, заавар зөвлөмж өгөх байдлаар Парламент, Засгийн газарт ханддаг.

Монголын соёлын өвийн хадгалалт хамгаалалтын асуудлыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам шууд хариуцдаг. Яамны дотор Соёлын урлагийн газар гэсэн хэлтэс энэ асуудлыг дагнан гүйцэтгэдэг. Гэвч энэ хэлтэст соёлын өвийн хадгалалт хамгаалалтыг хариуцсан мэргэжилтэн цорын ганц байхаас гадна тэрээр энэ ажлын зэрэгцээ музейн үйл ажиллагааг давхар хариуцан ажилладаг.

Соёлын биет өвийн хадгалалт хамгаалалтын асуудлыг Шинжлэх Ухааны Академийн Археологийн хүрээлэн, Монгол улсын Их сургуулийн Археологи-Антропологийн тэнхим, Монголын үндэсний түүхийн музей гэсэн гурван байгууллага хариуцан ажиллаж байна. Эдгээрээс ШУА-ийн Археологийн хүрээлэн хамгийн идэвхитэй үйл ажиллагаа явуулдаг. Монгол улсын археологийн мэргэжлийн боловсон хүчний 80 орчим хувь нь энэ байгууллагат байгаа бөгөөд бусад байгууллагат ажиллаж байгаа археологичид тус хүрээлэнд ажиллаж байсан, эсвэл хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан нарын шавь нар байх зэргээр ямар нэгэн хэмжээгээр холбоотой байдаг байна. Тус хүрээлэн 2010 оноос эхлэн өөрийн бүтэцэд "Авран хамгаалах археологийн сектор"-ийг шинээр нэмж ажиллаж эхэллээ. Манай улсад сүүлийн жилүүдэд уул уурхай эрчимтэй хөгжиж байгаатай холбоотой авран хамгаалах хайгуул, малтлага судалгааны ажил олон гарч байгаа тул бие даасан секторын хүрээнд ажиллах шаардлагатай болсон юм.

**<u>Соёлын өвийн талаарх иргэдийн ойлголт</u>.** Монголчууд соёлын өвийн талаарх ойлголт маш өргөн, түүнийг хадгалах хамгаалах талаар ч гэсэн маш эртний уламжлалтай билээ. Үүний нэг жишээ бол нүүдэлчид аман зохиолын маягаар түүхээ бичиж үеийн үед үр хүүхддээ уламжлуулан үлдээсээр ирсэн бөгөөд энэхүү аман түүх он цагийн уртад улам баяжигдсаар байдаг билээ. Харин археологийн дурсгал буюу биет өвийн хамгаалалтын талаар өөрсдийн уламжлалт арга зүйтэй байжээ. Энэ бол тухайн дурсгал байгаа уул, усыг тахин шүтэж, тэр орчмын дурсгалыг сүйтгэж гэмтээсэн хүний ажил үйлс бүтэхгүй, гэр бүлээрээ өвчин зовлонд баригдана гэсэн айдас хүйдсээр айлган жигшээх арга зам юм. Энэ нь олон зууны турш үргэлжилж ирсэн нь дамжиггүй бөгөөд саяхныг хүртэл энэ байдал хэвээр хадгалагдаж байсан. Гэвч сүүлийн жилүүдэд Монгол улсын хэмжээнд ажилгүйдэл, ядуурал газар авснаас хүмүүсийн амь зуух, мөнгө олох арга нь булш бунхан тонон сүйтгэж, ашиг хонжоо хайх нь элбэгшиж байна. Өөр нэгэн арга бол булш бунхан, агуй хонгил нь эртний хүмүүсийн хийсэн оньсоор тоноглогдсон тул аюултай гэсэн цуу яриаг олны дунд тархаасан явдал юм. Ийм маягийн хүний санаанд шууд нөлөөлөх хамгаалах аргууд байгаль орчин хамгаалах тал дээр ч олонтаа байдаг.

Ийм маягийн хамгаалалт зарим газарт үргэлжилж байгаа хэдий ч ихэнх хүмүүсийн дунд түүнийг үл тоомсорлосон, ашиг хонжооны төлөө улайрсан байдалтай байдаг. Түүх соёлын дурсгалыг тонон сүйтгэх үндсэн хэд хэдэн шалтгаан байна (Зураг 50). Эдгээр шалтгаанууд нь бүгд л Монгол улсын нийт нутгийг хамран зэрэгцэн оршиж байна. Уул уурхай, зам, барилгын ажилд өртөх магадлал хэдий өндөр боловч Соёлын өвийг хамгаалах тухай хуульд тодорхой заалт буй тул аж ахуйн нэгжүүд үүнийг мөрдлөг болгон ажиллах хандлага сүүлийн жилүүдэд ажиглагдаж байна. Харин шунхайн сэдэлттэй тонон сүйтгэх асуудал хяналтаас бүрэн гарсан. Дурсгалыг тонон сүйтгэсэн тохиолдолд дээрх хуулинд маш бага мөнгөн торгууль ноогдуулах заалтаас өөр шийтгэлийн тухай заалт байхгүйгээс гадна орон нутагт байгаа байгаль орчны байцаагч, аймаг, сумын удирдлагууд энэ байдалд бүрэн дасан зохицоод хууль бус зүйл биш гэсэн ойлголттой болсон байдаг.

Учир нь, орон нутагт малын болон модны хулгай гэсэн хоёр том гэмт хэрэг үйлдэгдэж түүнд бүх анхаарлаа тавин ажилладагтай холбоотой юм. Мал бол ойлгомжтой хувийн өмч учраас түүнийг хуулиар хамгаалдаг, харин модны хулгай бол өмнөх жилүүдэд яг дурсгалын тонон сүйтгэхтэй ижил хэн ч үл доох гэмт хэрэг байснаа саяхнаас байгаль орчныг хамгаалах байгууллагуудын хүчтэй бодлогын үр дүнд төрийн зүгээс хуулийн заалтыг чангатгахад энэ төрлийн гэмт хэрэг эрс буурсан дүнтэй байдаг.

Монгол улсын Эрүүгийн хуулинд эртний булш бунхан тонон сүйтгэсэн тохиолдолд ийм шийтгэл оногдуулна гэсэн заалт байхгүй, харин шинэ үеийн булш оршуулга тоновол Монгол Улсын Эрүүгийн хуулийн дагуу шийтгэл хүлээхээр тусгагдсан байдаг болно.

Түүх соёлын дурсгалыг хадгалах хамгаалах талаар гарсан Монгол улсын хууль тогтоомж, журмыгягштал баримтлах, түүнийг олон түмэнд сурталчлан танилцуулах асуудлыг төр засгийн зүгээс дэмжлэг туслалцаа үзүүлэх нь тулмагдсан асуудал болоод байна. Энэхүү ажлыг мэргэжлийн судалгааны байгууллага, олон нийтийн байгууллага, телевиз, радио гээд олон байгууллагууд хамтран гүйцэтгэх зүйтэй юм.

**Археологийн дурсгалын тонон сүйтгэх шалтгаан**

| Уул уурхай, зам, барилгын ажлын явцад | Шунахайн сэдэлттэй буюу захиалгын шинжтэй тонолт. Эртний эдлэл цуглуулагч нар хүмүүст захиалга өгөн тонуулж байна. | Гар аргаар алт олзворлож байгаа хүмүүсийн тонолт. Эдгээр бүлэг хүмүүст ямар нэгэн хараа хяналт, зөвшөөрөл гэж байхгүй хууль бусаар алт олзворлодог. Тэд энэ ажлынхаа далимаар дурсгалыг тонон сүйтгэдэг | Хөдөөд байгаа зарим малчид өөрийн өвөлжөө, хаваржаа, зуслангийн дэргэд байгаа дурсгалыг ухан тонох. Тэд ерөнхийдөө сонирхсон байдалтай хийх боловч үндсэн гол зорилго нь илүү нэмэлт орлого олох. |
|---|---|---|---|

**Зураг 50 Археологийн дурсгалын тонон сүйтгэж байгаа шалтгаан**

## 7.5 МОУӨБ-ын санал болгож буй СОЁЛЫН ӨВИЙН ШИНЭ БҮТЭЦ

Бид Монголын соёлын өвийг хамгаалах шинэ бүтцийг санал болгож байна (Зураг 51). Эхний шатанд соёлын өвийн хууль тогтоомжийг түүний хэрэгжилтээс тусад нь авч үзэхийг зөвлөж байна. Судалгаа явуулах, үр дүнг тооцох ажлыг дан ганц нэг байгууллага шийдвэрлэх боломжгүй. Бидний төлөвлөгөө нь БСШУЯ-ны Соёл урлагийн газар соёлын өвийн хууль тогтоомжийг хариуцаж байгаа одоогийн бүтцийг ашиглана. Бид яамны соёлын өвийн бодлогыг боловсруулах, зөвшөөрөл, лиценз олгох асуудлыг зохицуулах үүрэг бүхий соёлын өвийн хэлтсийг Соёлын урлагийн газрын дотор байгуулахыг зөвлөж байна.




**Зураг 51 Бидний санал болгож буй Соёлын өвийг хамгаалах хууль эрх зүйн бүтэц**

Ашигт малтмалын хайгуул хийх, ашиглалтад оруулах зөвшөөрөл авахын тулд Ашигт малтмалын асуудал хариуцсан эрх бүхий байгууллага Соёл урлагийн хороонд анкетыг нь хүргүүлж, улмаар Соёл урлагийн хороо нь түүнийг шалгаж, зөвшөөрөл олгон зохих ёсны хураамж тогтооно. Соёлын өвийн хураамжийг Засгийн газарт жил бүр төлөх бөгөөд тэр нь Шинжлэх ухаан, технологийн газраар дамжин Шинжлэх ухааны академид очно. Түүгээр Шинжлэх ухааны академи нь гурван хэлтэс бүхий Говь судлалын төвийг байгуулна (Даланзадгадад байж болох юм). Түүхийн хэлтэс нь ам дамжиж ирсэн түүхийн чиглэлээр хэрэгжиж буй төслүүдийг хариуцах бөгөөд хамгаалалтад орсон Өвт газруудын жагсаалтыг гаргах болно. Археологи, палеонтологийн хэлтэс нь Өмнөговь аймагт соёлын өвийн судалгаа хийх ажлыг хариуцах болно. Гуравдахь нь Улаанбаатарт аваачих шаардлагагүй Өмнөговь аймгаас олдсон шинжлэх ухааны олдворуудыг хадгалах газар байх болно. Эдгээр хэлтсүүдийг томоохон орд газруудын дэргэд байгуулахыг ШУА-иас шаардах болно. Эдгээр хэлтэст тухайн өвийн үнэ цэнийг тогтоох, зохих хадгалалт хамгаалалтын арга хэмжээ авах эрх бүхий, мэргэшлийн түвшинд бэлтгэгдсэн, нэг болон түүнээс дээш тооны археологич, палеонтологич мөн курст сууж сертификат авсан мэргэжлийн бус ажилчидтай байна. ШУА нь аймгийн төв болон сумдад олон нийтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Даланзадгад дахь Өмнөговийн музейг соёлын өвийн сангаас санхүүжүүлэх болно (музейн үзмэр, сургалтын материал, наадам зэрэг).

Оюу Толгойн соёлын өвийн хөтөлбөр нь уул уурхайн аж үйлдвэрт чиглэгдэж байгаа учраас бид Эрдэс баялаг, эрчим хүчний яамтай хамтран ажиллах ёстой. Мөн бусад яамдууд ч энэ үйл хэрэгт оролцож, Монголын бусад аймгуудад энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх зүйтэй.

Дээрх тогтолцоог бий болгохыг тулд Монголын хуульд өөрчлөлт оруулах шаардлагатай. Бид соёлын өвийн хуульд соёлын өвийн асуудлаар зөвшөөрөл авах зарчмыг тусгах шаардлагатай бөгөөд зөвшөөрөл, лиценз олгодог бусад хууль тогтоомжуудад ч гэсэн үүнийг тусгах нь зүйтэй. Соёлын өвийн сан нь зөвхөн соёлын өвд зориулагдах ёстой. Мөн Монголын соёлын өвийг хамгаалах хуульд хамаарагдаж байгаа дурсгалуудад археологийн дурсгалт газруудыг багтаах, эртний эдлэл, үлэг гүрвэлийн чулуужсан ясыг хууль бусаар малтаж, худалдаалах явдалд олон улсын хэм хэмжээний дагуу шийтгэл оногдуулж байх асуудлыг оруулах хэрэгтэй. Эцэст нь Монголыг Хууль бусаар хил гаргасан Соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРАУТ-ын Конвенцид (1995) нэгдэн орохыг уриалж байна.

## 8. СОЁЛЫН ӨВИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ЗӨВШӨӨРӨГДӨХ ХЭМ ХЭМЖЭЭ, ЭРСДЛИЙН ҮНЭЛГЭЭ

**Жеффрей Х. Алтшул**

Соёлын өвийн хөтөлбөрийн эхний үе шатны гол зорилго нь Өмнөговь аймгийн соёлын өвийн дурсгалуудад үнэлгээ хийх явдал байсан.

- Соёлын өв гэж юу вэ?
- Соёлын өв ямар хүрээг хамрах вэ?
- Соёлын өвийн талаар бид юу мэдэх вэ?
- Соёлын өвийн нөхцөл юу вэ?
- Соёлын өвийн талаар оролцогчид юу бодож байна вэ?
- Соёлын өвтэй холбоотой оролцогчдын анхаарах ямар асуудал байна вэ?
- Соёлын өвийг хамгаалах ямар хуулиуд байна вэ?
- Соёлын өвийг хамгаалах хуулийн хэрэгжилт ямархуу байна вэ?

Өмнө нь тайландаа бид эдгээр асуудлуудтай холбогдуулан ажлынхаа үр дүнг нэгтгэн бичсэн билээ. Эдгээр мэдээлэл дээр тулгуурлан одоо бид уул уурхайн үйл ажиллагаанаас болж Өмнөговь аймгийн соёлын өвд учирч буй аюул занал болон бүс нутгийн соёлын өвийг хөгжүүлэх боломжийг олж тогтоохоор ажиллаж байна. Энэ үнэлгээ нь Өмнөговь аймгийн соёлын өвд учирч буй хор нөлөөг багасгаж, түүнийг цаашид хөгжүүлэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн менежментийн төлөвлөгөөг боловсруулах үндэс болно. Үүний тулд бид Соёлын өвийн хөтөлбөр боловсруулах хоёрдугаар үе шатанд хоёр тусдаа боловч холбоотой арга хэрэглэнэ. Нэгд, Зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хязгаарт загварчлагдсан Соёлын өвийн өөрчлөлтийн зөвшөөрөгдөх хэм хэмжээ юм.[16] Соёлын өвийн өөрчлөлтийн зөвшөөрөгдөх хэм хэмжээ нь СӨХ-ийг урт удаан хугацаанд тогтвортой байлгах менежментийн цогц хандлага юм. Хоёрдугаар арга нь хөтөлбөрийг зөв чиглэлээр эхлүүлэхэд гол анхаарлаа хандуулах

---

[16] Stankey, George H., David N. Cole, Robert C. Lucas, Margaret E. Petersen, and Sidney S. Frissell. *The Limits of Acceptable Change (LAC) System for Wilderness Planning*. General Report INT-176. USDA Forest Service, Intermountain Forest and Range Experimental Station, Ogden, Utah, 1985
- Stankey, George H., Stephen F. McCool, and Gerald L. Stokes Limits of Acceptable Change: A New Framework for Managing the Bob Marshall Wilderness Area. *Western Wetlands*, 2008 10(3):33-37.
- McCool, Stephen F.Limits of Acceptable Change: A Framework for Managing National Protected Areas: Experiences from the United States. Paper presented at the Workshop on Impact Management in Marine Parks, sponsored by the Maritime Institute of Malaysia, Kuala Lumpur, Malyasia, 1996

юм. Энэ нь Эрсдлийн үнэлгээ-Оюу толгой төсөл[17]-д орсон Рио Тинтогийн эрсдлийн үнэлгээ болон Оюу толгой: Эрсдлийн үнэлгээ[18]-нд орсон эрдслийн үнэлгээний нэг хэлбэр юм. Тайлангийн энэ бүлэгт арга тус бүрийг СӨХ боловсруулахад хэрхэн уялдуулах вэ гэдгийг тодорхойлоход чиглэнэ. Энэ бүлгийн төгсгөлд 2011 оны 3-р сарын 23-нд Ханбогд суманд болсон эрсдлийн үнэлгээний уулзалтын үр дүнг мэдээлэх болно.

## 8.1 Соёлын өвийн зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хэмжээ

1964 онд АНУ-ын Конгресс Ургамал, ан амьтныг хамгаалах зорилгоор Онгон байгалийн тухай хууль баталсан. 1970-аад оны үед менежерүүд, хүмүүсийн аялал жуулчлал, амралт сувиллыг байгаль орчинг сүйтгэхгүй байх хэмжээнд хязгаарлаж "чадавхийг хадгалах" гэсэн ойлголтыг хэрэглэж зэрлэг онгон байгалийг хадгалж үлдэх оролдлогуудыг хийж эхлэсэн.

1980-аад оны эхэн үед чадавхийг хадгалах зарчимд суурилсан бодлого тохирохгүй байгаа нь тодорхой болсон. Учир нь тэд буруу асуулт асууж байсан. Хир олон нь хэтэрхий олонд тооцогдох вэ? Чадавхийг хадгалах зарчим нь тоон шийдлийг гаргаж өгдөг (Байгаль орчныг доройтуулахгүй байхын тулд жуулчдын тоо хэд байх ёстой вэ гэх мэт). Үнэндээ асуудал нь жуулчдын тоонд биш тэднийг зан байдалд байдаг билээ. Энэ нь Зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хязгаарыг томъёолсон шинэ менежмент бий болгох шаардлагатайг харуулсан. Энэ нь огт өөр асуултад хариулт авах зорилготой: "Ямар нөөц, нийгмийн нөхцөл байдал тохиромжтой болон эдгээр нөхцөл байдалд бид хэрхэн хандах вэ?"[19] гэдгийг бий болгосон.

---

[17] Serena, David B. *Rio Tinto Copper Projects: Risk Analysis Update — Oyu Tolgoi Project*. Report prepared by Technology and Innovation for Rio Tinto Copper Projects. Vancouver, Canada, 2009

[18] Barclay & Associates *Oyu Tolgoi: Influx Risk Assessment*. Report prepared by Barclay & Associates for Ivanhoe Mines Mongolia Inc. Ulaanbaatar, Mongolia, 2007

[19] McCool, Stephen F. Limits of Acceptable Change: A Framework for Managing National Protected Areas: Experiences from the United States. Paper presented at the Workshop on Impact Management in Marine Parks, sponsored by the Maritime Institute of Malaysia, Kuala Lumpur, Malyasia, 1996

Зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хязгаар нь 1980-аад онд олон баримт бичигт тусгагдсан байдаг[20] бөгөөд үндсэн 4 хэсгээс бүрдэнэ. *Нэгдүгээрт,* Зөвшөөрөгдөх болон хүрч болох нөөц боломж, нийгмийн нөхцөл; *Хоёрдугаарт,* суурь нөхцөлийг бий болгон тэдгээрийн зөвшөөрөгдөх нөөцийн хэмжээ хоорондын холбоог тодорхойлох; *Гуравдугаарт,* хүсч буй нөхцөл байдлыг бий болгоход шаардлагатай менежментийн үйл ажиллагаа, чиглэлийг тогтоох; *Дөрөвдүгээрт,* авч хэрэгжүүлж буй менежментийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэх хяналтын хөтөлбөрийг бий болгох. Энэ дөрвөн хэсэг нь дотроо есөн шатны хөтөлбөрт хуваагдана.

Сүүлийн арван жилд Зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хязгаарыг, соёлын өвийн хөтөлбөрийг удирдан зохицуулах үүднээс ЮНЕСКО болон ИКОМОС баталсан.[21] Ази тивд, ЮНЕСКО-гийн Орон нутгийн хичээл зүтгэл болон хадгалалт хамгаалалт хөтөлбөр нь 12 өвийг жишээ болгон сонгож, Зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хязгаараар дамжуулан соёлын өвийн хадгалалт хамгаалалт болон аялал жуулчлалыг зохицуулах үйл ажиллагааг хийсэн.[22] Байгаль орчныг хадгалж хамгаалах зорилгоор байгуулагдсан Зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хязгаар нь одоо соёлын өвийг хадгалж хамгаалахад бүхий л шинжээрээ ашиглагдаж байна. Хэдийгээр зорилго нь хэвээрээ ч гэсэн үүнийг Соёлын зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хэм хэмжээ гэж нэрлэсэн нь илүү тохиромжтой болох юм. Соёлын өөрчлөлтийн зөвшөөрөгдөх хэм хэмжээг бид хүснэгтээр үзүүллээ. 9 үе шатыг нэг бүрчлэн тодорхойлсон.

---

[20] Stankey, George H., David N. Cole, Robert C. Lucas, Margaret E. Petersen, and Sidney S. Frissell *The Limits of Acceptable Change (LAC) System for Wilderness Planning*. General Report INT-176. USDA Forest Service, Intermountain Forest and Range Experimental Station, Ogden, Utah, 1985 Stankey, George H., Stephen F. McCool, and Gerald L. Stokes Limits of Acceptable Change: A New Framework for Managing the Bob Marshall Wilderness Area. *Western Wetlands*, 2008 10(3):33-37.

[21] Pedersen, Arthur *Managing Tourism at World Heritage Sites: A Practical Manual for World Heritage Site Managers*. UNESCO World Heritage Centre, Paris, 2002

- UNESCO-EIIHCAP. *Safeguarding Intangible Heritage and Sustainable Tourism: Opportunities and Challenges*. UNESCO, Bangkok, Thailand and the Establishment Initiative for the Intangible Heritage Centre for Asia-Pacific (EIIHCAP), Seoul, Korea, 2007

[22] Schipani, Steven. *IMPACT: The Effects of Tourism on Culture and the Environment in Asia and the Pacific: Alleviating Poverty and Protecting Cultural and Natural Heritage through Community-Based Ecotourism in Luang Namtha, Lao PDR.* UNESCO, Bangkok, Thailand, 2008

- UNESCO *Indigenous People and Parks: The Surin Islands Project*. Coastal Region and Small Island Papers 8. UNESCO, Paris, 2001
- UNESCO *IMPACT: The Effects of Tourism on Culture and the Environment in Asia and the Pacific:Tourism and Heritage Site Management in Luang Prabang, Lao PDR.* Office of the Regional Advisor for Culture in Asia and the Pacific, UNESCO Bangkok and School of Travel Industry Management University of Hawai'i, USA, 2004
- UNESCO Asia *Conserved: Lesson Learned from the UNESCO Asia-Pacific Heritage Awards for Cultural Heritage Conservation (2000-2004)*. UNESCO, Bangkok, Thailand, 2008
- Hoi An Centre for Monuments Managements and Preservation. *IMPACT: The Effects of Tourism on Culture and the Environment in Asia and the Pacific: Cultural Tourism and*

**Хүснэгт 21 Соёлын өөрчлөлтийн зөвшөөрөгдөх хэм хэмжээ**

| Үе шат | Тодорхойлолт | Үйл ажиллагаа |
|---|---|---|
| 1. Өмнөговь аймаг дахь үнэт зүйлс, тулгамд-сан асуудлыг тогтоох | Өмнөговь аймаг дахь биет болон биет бус өвтэй холбоотой үнэт зүйлс, тулгамдсан асуудлыг олж тогтоох | Өмнөговь аймаг дахь биет болон биет бус өвтэй холбоотой үнэт зүйлс, тул-гамдсан асуудлыг олж тогтоохтой хол-богдуулан холбогдох хүмүүстэй уулзах |
| 2. Газрын төрлийг тодорхойлох | Өмнөговь аймаг дахь ялгаатай га-зар нутагт тохиромжтой үйл ажиллагааны хэлбэр, хүрээлэн буй орчны шинж төрхийг тодор-хойлох (Өвийн аялал жуучлал, энгийн амралт сувилал, барилга байгууламж барих, дэд бүтэц хөгжүүлэх гэх мэт). Шаардлага-тай менежментийн үйл ажиллагааны төрлийг тодорхойлох | Өмнөговь аймаг дахь соёлын өвийн хүрээлэн буй орчин, хэрэглээ, төлөвлөгдсөн хөгжил, байршилд дүн шинжилгээ хийх. Аймгийг газрын төрлөөр ангилах |
| 3. Өв болон нийгмийн нөхцөл байдлын үзүүлэлтийг сонгох | Оюу толгой болон түүний орчинд байгаа өвийн нөхцөл байдлыг илэрхийлэх тусгай үзүүлэлтүү-дийг олж тогтоох (хөрсний элэг-дэл, ан агнах, уламжлалт зан заншил алдагдах болон түүнийг уламжлалт бус зан заншлаар со-лих гэх мэт) | Хүрээлэн буй орчин болон нийгмийн үйл ажиллагааг бүхэлд нь хамарсан тодор-хой бөгөөд хэмжигдэхүйц хувьсал өөрч-лөлтийг тодорхойлох. Үнэт зүйлсийг менежментийн үйл ажиллагаатай холбох |
| 4. Өвийн бүртгэл болон нийгмийн нөхцөл байдал | Өмнөговь аймаг дахь биет болон биет бус соёлын өвийн одоогийн нөхцөл байдлын бүртгэл. Бо-ломжтой бол цогц суурь судал-гаанаас гол үзүүлэлтийн судал-гаанд шилжих | Биет болон биет бус өвүүдийг газар дээр нь очиж үнэлгээ хийх, тэдний нөхцөл байдал, бүрэн бүтэн байдлыг үнэлэх, үр дүнг GIS мэдээллийн сангаар баримт-жуулах, газар тус бүрт уламжлалт соё-лын зан үйлийн нөхцөл байдлыг тойм-лон оруулах. |
| 5. Өв болон нийгмийн үзүүлэлтүүдийн хэм хэмжээг тодорхойлох | Үзүүлэлт тус бүр дээр стандарт тогтоох (3-р үе шатанд тогтоо-сон); Эдгээр стандарт нь одоо-гийн нөхцөл байдал нь зөвшөө-рөгдөх, үгүйг тогтоох арга замыг бий болгоход ашиглагдана. | Биет болон биет бус өвийн нөхцөл байдлыг үнэлэх стандартуудыг тогтоох зорилгоор холбогдох хүмүүс болон мэр-гэжилтнүүдтэй уулзах. Эдгээр стандар-тыг тодорхойлсон баримт бичиг гаргах |
| 6. Боломжит газ-рын ангилал болон үг ангиллын тар-халтыг тогтоох | Өмнөговь аймаг дахь өвүүдийг хадгалж хамгаалах боломжит ху-вилбаруудыг тогтоох (өвийн ая-лал жуулчлал хөгжүүлэх, өвийг хадгалж хамгаалах, эдийн зас- | Өмнөговь аймаг дахь өвүүдийг хадгалж хамгаалах боломжит хувилбаруудыг тогтоох зорилгоор холбогдох хүмүүстэй уулзах. Өмнөговь аймаг дахь газрын ангиллыг нэмэх болон түүний тархалтыг |

*Heritage Management in the World Heritage Site of the Ancient Town of Hoi An, Viet Nam.* UNESCO, Bangkok, Thailand, 2007

- Save the Ifugao Terraces Movement. *IMPACT: The Effects of Tourism on Culture and the Environment in Asia and the Pacific: Sustainable Tourism and the Preservation of the World Heritage Site of the Ifugao Rice Terraces, Philippines*. UNESCO, Bangkok, Thailand, 2008

| Үе шат | Тодорхойлолт | Үйл ажиллагаа |
|---|---|---|
| | гийн хөгжлийг зохицуулах г.м) | дахин үнэлэх |
| 7. боломжит газрын ангиллын тархалтад зориулсан менежментийн үйл ажиллагаар тогтоох | Боломж тус бүрт шаардлагатай нөхцөл байдлыг бий болгоход шаардлагатай менежментийн үйл ажиллагаар тогтоох (6 дугаар үе шатанд тогтоосон). Тухайн газар нутгийн одоогийн байдал болон зөвшөөрөгдөх байдлын хоорондын ялгааг олж тогтоох | 6 дугаар үе шатыг гүйцэтгэхэд шаардлагатай менежментийн үйл ажиллагаар тогтоох зорилгоор холбогдох хүмүүс болон мэргэжилтнүүдтэй уулзах. 4 дүгээр үе шатанд тогтоосон өвүүдийг 5 дугаар үе шатанд тогтоосон стандарттай харьцуулан үнэлэх; Өвүүдийн хувь стандартын нөхцөл байдлыг зөвшөөрөгдөх стандартад нийцүүлэн өөрчлөх шаардлагатай менежментийн үйл ажиллагаар тодорхойлдог. |
| 8. Хамгийн боломжит хувилбарыг үнэлэх, сонгох | Хувилбар болгонд дүн шинжилгээ хийж, хамгийн боломжит хувилбарыг сонгох | Хувилбаруудад дүн шинжилгээ хийх зорилгоор холбогдох оролцогчид болон мэргэжилтнүүдтэй уулзах |
| 9. Менежментийн үйл ажиллагаар хэрэгжүүлэх болон нөхцөл байдалд хяналт тавих | Тавьсан зорилгод хүрэх үүднээс менежментийн төлөвлөгөөний үр ашгийг үнэлэх үүднээс байгуулагдсан хяналтын хөтөлбөрийн зэрэгцээ боломжит хувилбарыг хэрэгжүүлэх | СӨХ болон M&E төлөвлөгөөг хэрэгжүүлэх |

***Нэгдүгээр үе шат: Бүс нутаг дахь үнэт зүйлс, тулгамдсан асуудлуудыг олж тогтоох***

Эхний алхам нь Өмнөговьд СӨХ боловсруулахтай холбогдуулан асуулт тавих. Ингэхдээ, соёлын өвтэй холбоотой менежерүүд болон холбогдох хүмүүсийг цуглуулан "Юугаараа Өмнөговь аймаг онцлог бөгөөд үнэ цэнэтэй вэ? Аймгийн ялгаатай хэсгүүд хэрхэн бие биетэйгээ холбогдож байна вэ?" хэмээсэн хоёр асуулт тавьж хариултыг нь авах хэрэгтэй юм. Хариултын дунд тус аймгийн шинжлэх ухааны, экологийн, амралтын, боловсролын, түүхийн хосгүй шинжийг болон соёлын өвийн хамгаалалт, эдийн засгийн хөгжлийн боломжуудыг тодорхойлно.

Нэгдүгээр үе шат нь тус бүс нутаг дахь соёлын өвүүдийг болон нийгмийн нөхцлүүдийн төрөл зүйлийг олж тогтооход чиглэнэ. Энэ хүрээнд хоорондоо харилцан адилгүй үнэт зүйлсийг тодорхойлно. Тухайлбал, динозаврын хөлийн мөртэй газар нь аялал жуулчлалын ангилалтай газар. Тэнд очиход хязгаар байхгүй байгаа нь тэднийг устаж үгүй болоход хүргэх учраас эдгээр газар нь маш эмзэг юм гэх мэт.

***Хоёрдугаар үе шат: Газрын ангиллыг тогтоох, тодорхойлох***

Анх дурдсанаар Зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хязгаарын хоёрдугаар үе шат нь онгон байгальтай газар нутагт боломжит ангиллын тодорхойлолтод хамрагдсан. Боломжит ангилал нь АНУ-ын Зэвсэгт хүчний тусгай нэр томъёо юм. Энэ нь онгон байгалийн тусгай хэсэг болон зохих менежментийн төлөвлөгөөний төрөлд зөвшөөрөгдөх өв болон нийгмийн нөхцөлийн төрөл юм. Тухайлбал, АНУ-ын Зэвсэгт хүчин хөндөгдөөгүй, хүмүүсийн оролцоо маш бага, хүн ашиглаж байсан нотолгоо маш бага харьцангүй томоохон газар нутгийг нэрлэхдээ "балар эртний" гэсэн нэр томъёо ашигладаг. Тиймэрхүү газар нутгийн менежмент нь "хөндлөнгөөс оролцохгүй байх" бөгөөд тэнд хүний үйл ажиллагаа маш бага байдаг. Тухайлбал, тухайн газар нутагт моторт хэрэглээг хориглосон байдаг. Бусад боломжит ангилал нь хагас балар эртний моторжуулаагүй, хагас балар эртний моторжсон, байгалийн зам, хөдөө болон хот гэх мэт.

Хэдийгээр, "Боломжит ангилал" хэмээх нэр томъёог АНУ-ын Зэвсэгт хүчний удирдлаганд байдаг онгон байгальд ашиглагддаг ч, энэхүү ангилал нь Өмнөговь аймаг дахь газрын нөхцөл болон ашиглалтыг тодорхойлох боломжгүй юм. Үүний оронд, ЮНЕСКО-гийн дэвшүүлснээр Монголын талын оролцогчид хүлээн зөвшөөрөх нэр томъёоны нэрийг Хоёрдугаар шатанд гаргахыг бид зөвлөж байна. Юуны түрүүнд бид "боломжит ангилал" гэдгийг "газрын ангилал" гэж солихыг зөвлөж байна: хамгаалалттай газар нутаг, үндэсний хүрээлэн, бэлчээрийн газар нутаг, уул уурхайн талбай, хот, тосгон. Эдгээр газрын ангилал нь харьцангүй онгон, хүний нөлөөлөл бага хамгаалалттай газар нутгаас эхэлнэ.

Газар тус бүрийн ангиллын хувьд оролцогчид нь нийгмийн нөхцөл болон соёлын өвд зөвшөөрөгдөх үйл ажиллагааны төрлийг тогтоох шаардлагатай. Жишээлбэл, Үндэсний хүрээлэн нь онгон дагшин, хүний нөлөөнд бага өртсөн, малчдад нээлттэй газар нутгийг хэлж болно. Энэ газар нь сайжруулаагүй замтай бөгөөд аялал жуулчлалыг хөгжүүлэх байгалийн болон соёлын хосгүй үзэсгэлэнтэй дурсгалтай байх ёстой. Энэхүү үнэлгээн дээр тулгуурлан Өмнөговь аймаг дахь газрын ангилал тус бүрийн хувьд нийгмийн харилцаа, зан үйл (биет бус өв) болон соёлын өвийн байрлал, дурсгал (биет бус өв)-ыг хамтад нь хадгалж хамгаалахад шаардлагатай менежментийн үйл ажиллагааны төрлийг тодорхойлно. Эргээд хүрээлэнг жишээ болгон авбал, ихэнх хүрээлэнгийн газар нутаг нь бага бөгөөд жуулчлалыг хөгжүүлэх боломжтой, зам, дэд бүтцийг сайжруулах ёстой. Жуулчлал нэмэгдэхийн хирээр идэвхтэй менежмент тухайлбал соёлын өвийн чиглэлээр боловсон хүчин бэлтгэх шаардлага зүй ёсоор гарч ирнэ.

### *Гуравдугаар үе шат. Өв ба нийгмийн нөхцөлийн үзүүлэлтүүдийг сонгох*

Соёлын өвийн тусгай арга хэмжээг бий болгох ерөнхий нөхцөлийг хэлэлцэнэ. Эдгээр арга хэмжээ нь соёлын нөхцөлийн ерөнхий хүрээний төлөөлөл байхаас гадна нийгмийн үйл явцуудыг өргөн хүрээнд тусгасан тодорхой байх ёстой. Тухайлбал, Монголын бусад газар нутгаас Өмнөговь аймгийг тодосгож байгаа гол шинжүүдийн нэг нь арвин баялаг палеонтологийн дурсгал гэдгийг оролцогчид тогтоох ёстой. Тогтоосон өвийн бүрэн бүтэн байдлыг хангах чухал нэгэн оролцогчид бол нутгийн иргэд юм. Мөн нутгийн иргэд эдгээр өвийг жуулчдыг татах боломж болгон хувиргахыг хүсч байгаа нь тодорхой.

Энэхүү хоёр эрс тэрс зорилтыг тэнцвэржүүлэхийн тулд менежерүүд палеонтологийн дурсгалдуудад очих жуучдын тоо болон дурсгалын бүрэн бүтэн байдал хоорондын холбоог бий болгох ёстой. Өмнөговь аймгийн палеонтологийн дурсгалт газруудын алслагдмал байдлаас шалтгаалан мэргэжлийн палеонтологичдын хамт эдгээр дурсгалуудад очиж хяналт тавих нь өртөг өндөртэй байх болно. Үүний оронд нутгийн малчдаар хяналт тавиулах нь илүү үр дүнтэй арга юм. Палеонтологийн дурсгалыг илрүүлэн олоход малчдыг сургахын оронд энгийн ажиглалт хийж байхыг хүсэх нь зүйтэй. Эдгээр арга хэмжээний өөрчлөлт дээр суурилан, менежерүүд менежментийн үр ашгийг дүгнэх боломжтой болно (5 дугаар алхамыг үзнэ үү).

Янз бүрийн үзүүлэлтүүд биет бус өвд шаардлагатай. Нийгмийн нөхцөл дэх өөрчлөлтийн тодорхой бус үзүүлэлтүүд нь маш хэцүү төдийгүй үр дүн нь ямар байх тал дээр оролцогч тус бүр өөр өөрийн бодолтой гэдгийг анхаарах шаардлагатай. Тухайлбал, зарим оролцогчид наадмыг үзэгчдийн тоогоор соёлын өвийн үнэ цэнэ өсч байгааг хэмжиж болох юм. Зарим нь жуулчдын тоог нэмэгдүүлэхэд анхаарах нь тухайн зан үйлийн соёлын ач холбогдол буурах дохио гэж үзэж болох юм. Тоон үзүүлэлт нь дангаараа зөвхөн нийгмийн нөхцөл байдлыг тодорхой үзүүлэх боломж юм. Үндэсний хувцас, эх хэл, хоол унд зэрэг нь соёлын өөрчлөлтийг хэмжих гол үзүүлэлтүүд байж болох юм. Мөн уламжлалт соёлыг хадгалж хамгаалахад авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг бий болгоход тодорхой удирдамжаар хангана.

### *4 дүгээр үе шат. Өвийн бүртгэл болон нийгмийн нөхцөл байдлыг тодорхойлох*

Зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хязгаарын дөрөв дэх шат бол өмнөх шатнуудын үед тодорхойлогдсон шалгуур үзүүлэлтүүдийг ашиглан тухайн үеийн нөхцөл байдлыг бүртгэх юм. Явцын/хэрэгжилтийн судалгаан дээр үндэслэн суурь нөхцөл нь хангалттай бүртгэгдсэн газарт энэ ажил ихээхэн амжилттай хэрэгждэг. Харин Өмнөговь аймгийн хувьд бүртгэл байдаггүй учраас тухайн аймгийн нутагт орших археологийн дурсгалууд, тэдний нягтаршил, илрэх магадлал тодорхой бус байна. Үүнтэй адилаар аймгийн ихэнх нутагт палеонтологийн судалгаа хийгдээгүй, чулуужсан үлдэгдлийн нягтаршилын тухай хязгаарлагдмал мэдээлэлтэй байна. Энэ байдал бүртгэлгүйгээс гадна хорьдугаар зууны ихэнх хугацаанд нуун дарж байсан биет бус өвийн хувьд байдал илүү дор байна.

Соёлын өвийн хөтөлбөрийн хүрээнд эхний үед үндсэн мэдээллийн судалгаа хийгдсэн. Археологийн дурсгалуудыг аймаг болон сумын эх сурвалж дээр тулгуурлан нэгтгэсэн дэлгэрэнгүй хүснэгт бэлдэж, байршлыг урьдчилан тогтоох загвар гаргав. Археологичдын хийсэн байсан үндсэн бүртгэл тус загварыг туршихад ашигласан. Бусад соёлын өвөөс илүү судлагдсаны хувьд палеонтологийн өвийн бүртгэл 2011 оны эхний хагаст одоо мэдэгдэж буй дурсгалуудын хэмжээ, онцлог байдлыг тусгасанаар хийгдэх болно.

Биет бус өвийн хувьд бүртгэл явуулахад төвөгтэй байдаг. Биет бус өвийн тухай ЮНЕСКО-гийн конвенц 2003 онд батлагдсан боловч бүртгэлийн талаарх зөвлөмж гаргаагүй юм. Энэ талаар, ЮНЕСКО-гийн биет бус соёлын өвийн хөтөлбөрийн мэргэжилтэн Просканы мэдэгдсэнээр "ЮНЕСКО-гийн биет бус өвийг бүртгэх тухай зөвлөмж, зааврыг хаанаас авах вэ гэсэн асуултыг гишүүн орнуудын зүгээс байнга тавьдаг. Заавал мөрдөх заавар, бүртгэлийн хэлбэрийн тухай гарын авлага байхгүй бөгөөд ирээдүйд ч бий болохгүй. Ялангуяа улс бүр нэг болон түүнээс дээш бүртгэлийг өөрсдийн нөхцөл байдалд тохируулан хийх учиртай тул ЮНЕСКО энэ талаар заавар өгөх боломжгүй юм" гэжээ.

Өмнөговь аймгийн нийгэм, соёлын тухай хэвлэлд гарсан материал хомс учир Соёлын өвийн хөтөлбөрийн хүрээнд анхан шатны угсаатны зүйн шинжилгээ, бүртгэлийн ажлыг хийхээр шийдсэн. Энэ нь өвийн хэр хэмжээг мэдэхгүйгээр биет бус соёлын өвийн хөтөлбөрийг гаргана гэсэн үг юм.  Соёлын өвийн зөвшөөрөгдөх хэм хэмжээ нь Соёлын өвийн хөтөлбөрийн үргэлжлэх хугацаанд дахин дахин ашиглагдсаар байх үйл явц гэдгийн санах нь зүйтэй. Бид үйл явцыг хянах хөтөлбөрийг үүсгэснээр (9 дүгээр шат) төгсгөл болгож байгаа биш бөгөөд энэхүү хяналтын хөтөлбөрийн гаргасан үр дүнд тулгуурлан өөрсдийн үндсэн зорилго, асуудлыг цэгнэхэд (1 дүгээр шат) хэрэглэх зэргээр үйл явцын турш нийгэм, соёлын өвийн шалгуурыг дахин тодорхойлж, үүнийг тусгасан бүртгэлийн шинэчлэлийг хийдэг.

### *5 дугаар үе шат. Газрын ангилал тус бүрт нийгэм, соёлын өвийн шалгуурын стандартыг тодорхойлох*

Зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хязгаарын уламжлалт орчинд шийдвэр гаргагч, зохицуулагч нар өвийн нөхцөл байдлын хянахад зориулсан шалгуурыг тогтоож, анхан шатны бүртгэлийн хангалттай нөөцтэй болсон үедээ хянах хөтөлбөрийн стандартыг тогтоож эхлэдэг. Зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хязгаарын явцад гарах шаталсан үйлдлүүдийн нэгэн  адил тавдугаар шат, алдаан дээрээ суралцах зарчмаар олон давталттай явагдана.

Биет өвд голчлон устгал, гутаалт, сүйтгэлийг аль ч хэмжээнд байсан хүлээн зөвшөөрөхгүй байх зарчмаар ханддаг. Жишээ нь хамгаалалтын хангалттай хэмжээний стандартыг соёлын өвийг сүйтгэх үйлдэлд таваас бага хувь нь өртсөн тохиолдол гэж үзэхэд соёлын өвийг сүйтгэх үйлдлийг хуулиар хориглосон зарим улсад хангалтгүй хэмээн үздэг.  Нөгөө талаас соёлын өвийг сүйтгэх үйлдэл байнга гардаг басүүнийг огт тусгаагүй стандарт нь өрөөсгөл болж, хөтөлбөрийн амжилтад нөлөөлөх нь бий.

Мөн стандарт тогтоох явцдаа зохицуулагчид гол зорилгоо гэмт үйлдлийг өөгшүүлэх, хүлээн зөвшөөрөх биш, зохицуулалтын арга хэмжээнд дүгнэлт өгөх гэдгийг анхаарах нь чухал. Олон ажилтантай, сүйтгэл ихээхэн гаргадаг уул уурхайн идэвхитэй бүсэд соёлын өвийг сүйтгэх үйлдлийн 5 хувийн стандартад энэ тохиолдолд хяналт зохицуулалтын өндөр шаардлага тавьж байж хүрэх тохиолдол болно. Эсрэгээрээ тусгай хамгаалалттай бүс, үндэсний хүрээлэнд энэ асуудал дээр тусгайлан анхаарал тавилгүйгээр соёлын өвийг сүйтгэх үйлдэл огт гаргахгүй байх боломж бий. Бидэнд археологи, палеонтологийн объектийг сүйтгэж, тонож байгаа талаар зөвхөн аман баримт байдаг учир зохицуулагчид эхэндээ зорилтод стандартыг тогтоож, явцдаа гарсан дүнд дээр үндэслэн илүү баталгаатай стандарт тогтоох нь зүйтэй.

Харин биет бус өвийн хувьд энэ асуудал илүү ярвигтай. Хэдий хүн бүр археологийн болон палеонтологийн өвийг сүйтгэх үйлдлийг зогсоох нь зөв гэж үздэг боловч Ханбогд сумын наадмыг уламжлалд нийцсэн, багахан хэмжээнд явуулахтай санал нийлэхгүй. Хэдий гадны зочид наадамд оролцсоноор наадмын онцлогийг үгүй хийж, наадмыг өөрчилж байсан ч аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгчид, хоолны газар, рестораны эзэд, орон нутгийн иргэд гадны зочдыг хүлээн авахыг дэмжих тодорхой юм. Үндсэн соёлын өөрчлөлтийн асуудлыг зохицуулах нь бүү хэл энэ асуудлаар зөвшилцөхөд бэрхшээлтэй байдаг. Ихэнх хүн Монголын нүүдлийн соёлыг хадгалахыг дэмждэг боловч  Өмнөговийн иргэдэд уул уурхайн салбарт болон түүний туслах салбарт ажиллаж, амьдралаа дээшлүүлэх сонирхол  бий. Иймд, амьдралын хэв маягийг хадгалж үргэлжлүүлэхийн тулд хэдэн иргэн нүүдлийн мал ахуйгаа эрхлэх вэ гэдгийг тогтоон нүүдлийн хэв маягийг зохицуулах шалгуур, стандартыг тогтоох нь Өмнөговь аймгийн соёлын өвийг хадгалахад нэн чухал юм.

***Зургадугаар үе шат: Боломжит газрын ангилал болон хуваарилалтыг тогтоох***

Нэгдүгээр шатанд тодорхойлсон зорилго нь дөрөвдүгээр шатанд бий болсон өвийн болон нийгмийн нөхцөл байдалтай нийцэхгүй байгааг Зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хязгаар харуулж байна. Зургадугаар алхам нь одоогийн нөхцөл байдлыг нийцүүлэхэд оршино. Зарим хүмүүс хучилттэй замыг барьж, улмаар уул уурхайн хүнд оврын машинууд Хятадын хилээр нэвтрэх нь ихсэнэ гэж үзэж байна. Зарим нь эсрэгээрээ замыг чөлөөтэй байлгаж малчдад бэлчээрээ чөлөөтэй ашиглах боломж олгох ёстой гэж үзэж байна.

Менежерүүд энэ асуудлыг олон талаас нь авч үзэх шаардлагатай. Тэд бодит байдлыг харгалзан газрын ангиллыг өөрчилж болно. Тухайлбал, уул уурхайн хүрээг хязгаарлалтгүй уул уурхайн хүрээ болон тодорхой хэмжээний хязгаарлалттай хүрээ гэсэн хоёр хэсэгт хувааж үзэж болох юм. Хуучин малчид чөлөөтэй нүүдэллэх боломжтой байсан бол энэхүү менежмент нь зарим хязгаарлалтыг тогтоох юм. Эсрэгээрээ газрын ангилал нь хөгжлөө дагаад зарим хязгаарлалтыг хүлээн зөвшөөрөх ёстой.

Өөр нэг арга зам нь ангилсан газруудын тархалтыг өөрчлөх. Уул уурхайн зориулалттай газруудын хэмжээг нь ихэсгэж, багасгаж болно. Хуучин бэлчээрийн газар гэж ангилагдсан Өмнөговь аймгийн хэсэг газар нь хүрээлэн болж тэнд өвийн аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой болж болно.

Зургадугаар алхамын төгсгөлд бид ангилсан газар тус бүрийн тархалтыг харуулсан Өмнөговь аймгийн хэд хэдэн газрын зураг хийх болно.

### *Долдугаар алхам: Боломжит газрын ангиллын менежментийн төлөвлөгөөг боловсруулах*

Оролцогчид болон менежерүүд Тавдугаар алхамд тогтоосон стандартын дагуу бүртгэлд орсон өнөөгийн нийгмийн болон өвийн нөхцөл байдлын хоорондын ялгааг тогтооно. Газрын ангилал нь тогтоосон стандартаас доогуур болон дээгүүр байгаа нөхцөл байдалд менежментийн төлөвлөгөө зайлшгүй шаардлагатай. Тухайлбал, хэрэв жуулчдын тоо хэтэрвэл, менежерүүд дараах алхамыг авч хэрэгжүүлнэ:

Жуулчны баазын тоог цөөрүүлэх

Дурсгалыг  тойруулан хашаа барьж, төлбөртэй болгох

Зөвхөн хөтөчтэй жуулчдыг нэвтрүүлэх

Дурсгалын эмзэг хэсгийг хаах

Стандартаас дээгүүр байгаа тохиолдолд менежментийн арга хэмжээ авах шаардлагагүй.

Менежментийн арга хэмжээ болгон зардалтай байдаг. Энэ шатны хэсэг нь бүх өртөг зардлыг тооцох юм. Төсөвт тохируулан менежментийн арга хэмжээг төлөвлөх шаардлагатай.

### *Наймдугаар алхам: Боломжит хувилбарыг үнэлэх болон сонгох*

Оролцогчид болон менежерүүд зарим асуудал дээр тусгай менежментийн ажилд чиглэсэн үр дагаврыг тооцох шаардлагатай. Энэ алхам нь оролцогч бүрийн ялгаатай байр суурь, ойлголтоос болж хамгийн маргаантай байдаг. Энд ялагч, ялагдагч байхгүй гэдгийг ойлгуулах шаарлагатай. Тухайлбал, эдийн засгийн хөгжил нь уламжлалт мал аж ахуй дээр түшиглэсэн. Менежментийн төлөвлөгөө нь түүнийг хэрэгжүүлэх арга замаас хэтрэхгүй байх ёстой. Тухайлбал Өмнөговь аймагт төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд хяналт тавих археологич, палеонтологичиод байхгүй. Тиймээс хяналт үнэлгээ хийх нэг арга бол Улаанбаатраас мэргэжилтэн очиж бүс нутагт байгаа газрууд дээр очих. Энэ нь өртөг ихтэй байх учраас бүс нутаг хамгийн чухал гэсэн газруудад анхаарлаа хандуулна. Өөр нэг арга бол нутгийн иргэдийг сургаж, тэднээр дамжуулан хяналт тавиулах юм.

***Есдүгээр алхам: Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх болон нөхцөл байдалд хяналт тавих***

Зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хязгаарын сүүлчийн алхам нь менежментийн төлөвлөгөөний үр дүнг үнэлэх хяналт үнэлгээний хөтөлбөрөөр дамжуулан Наймдугаар алхамд сонгосон менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх юм. Оролцогчид болон менежерүүд нь тогтмол уулзаж, үр дүнг үнэлэх шаардлагатай. Тэдгээр үр дүнд тулгуурлан дараагийн ажлаа эхлүүлэх болно. Ингэхдээ хөрөнгө оруулагчдын хүссэн зорилго хэрэгцээнд нийцүүлэхээс ажлаа эхэлнэ. Үнэндээ Зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хязгаар нь орон нутгийн менежментийн асуудал дуустал бас дуусахгүй.

## 8.2 Зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хязгаараас соёлын өөрчлөлтийн зөвшөөрөгдөх хэмжээ рүү шилжих

Зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хязгаарыг АНУ-ын зэвсэгт хүчин төрийн эзэмшлийн газар нутгийн тодорхой хэсгийг зохицуулах зорилгоор гаргасан. Боловсруулагчид нь Зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хязгаарын хязгаарлалт болон боломжийг аль алинийг нь авч үзжээ. Ялангуяа тэд үйл явцыг дуусгах зөв зам гэж байхгүй бөгөөд хүрээ нь тусгай нөхцөлд зохицсон байх шаардлагатайг онцолсон.

Өмнө нь байснаас Зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хязгаарын ялгаатай тал нь олон нийтийн оролцоо юм. Зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хязгаарыг анх гарч ирэхэд Стэнкигийн тодорхойлсноор, "…Зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хязгаарыг боловсруулахад олон нийтийн оролцооны гол үүрэг өмнөх төлөвлөгөөнүүдэд байнга шүүмжлэгдэж байсан хариуцлагыг бий болгоход туслах юм".

Ерөнхийдөө Зөвшөөрөгдөх өөрчлөлтийн хязгаар нь холбогдох оролцогчид болон өвийг хадгалж хамгаалах арга хэрэгсэлтэй байлгах зорилготой. Эдгээр бүх алхамуудыг яг тогтоосон арга замаар авч хэрэгжүүлснээр гаргасан шийдвэр ил тод, үнэн бодитой гэдэгт ард иргэд итгэлтэй байх болно.

## 8.3 Соёлын өвийн зөвлөх хороо

Соёлын өвийн хөтөлбөрийн хүрээнд Соёлын өөрчлөлтийн зөвшөөрөгдөх хэм хэмжээг бий болгох эхний алхам нь Өмнөговь аймаг дахь соёлын өвд оролцогч бүх талуудын төлөөллийг оролцуулсан багийг сонгох юм. Энэ үүднээс Соёлын өвийн хөтөлбөрийн Зөвлөх хороо байгуулагдсан бөгөөд 15 гишүүнтэй. Зөвлөх хорооны гишүүдийг Хүснэгт 20-д жагсаасан байгаа. Хүснэгт 21-д гишүүн тус бүрийн тусгай үүргийг гаргасан боловч, бүх гишүүд Соёлын өөрчлөлтийн зөвшөөрөгдөх хэм хэмжээг боловсруулах бүх үе шатны ажилд оролцоно.

Зөвлөх хорооны эхний хуралдаан 2010 оны 12 сарын 16-нд болж МОУӨБ-н гишүүд маш ихээр оролцон гишүүд нэг нэгээ мэдэх боломжтой болсон. Энэхүү төслийн зорилго чиглэлийн талаар хэд хэдэн илтгэл тавьж дараа нь холбогдох асуулт хариултын хэсгээр үргэлжилсэн (6-р бүлгийг үзнэ үү). Зөвлөх Хорооны хоёр дахь уулзалт Ханбогд суманд 2011 оны 3 сарын 22-нд болсон. Энэхүү хуралдааны үеэр Оюу Толгой уурхайтай танилцсан ба 1-р шатны тайлангийн талаар ярилцсан. Маргааш өдөр нь СӨХ-н эрсдлийн үнэлгээний семинар болсон.

## 8.4 Эрсдлийн үнэлгээ

Соёлын өвийн хөтөлбөрийн эрсдлийн үнэлгээний уулзалт нь соёлын өвд гарч болох бодит нөлөө, эрсдэл болон нөлөөллийг арилгах, багасгах, эрсдлийг бууруулахад чиглэгдсэн Засгийн газрын болон "Оюу толгой" ХХК-ны удирдлагаас хэрэгжүүлэх арга хэмжээ болон механизмийг тогтооход чиглэгдсэн юм. "Рио Тинто" ХХК нь оролцогч талуудын төлөөллийг уулзалтанд оролцуулах замаар зөвлөлдөх арга хэмжээг санаачлан хэрэгжүүлсэн ба тэрхүү уулзалтанд дараах асуудлуудыг дэс дараатайгаар хэлэлцжээ.

- соёлын өвд учирч болох төслийн нөлөө, эрсдлийг олж тогтоох;
- тэдгээр нөлөөлөл үүсэх шалтгааныг тодорхойлох;
- тэдгээр нь шууд нөлөө юу, эсвэл шууд бус нөлөө юу, соёлын өвд эерэг нөлөө үзүүлж байна уу, сөрөг нөлөө үзүүлж байна уу гэдгийг үнэлэх;
- тэдний газарзүйн хэм хэмжээг тодорхойлох,
- үргэлжлэх хугацаа
- гарч болох эрсдэлийн магадлал;
- нөлөөллийн хор уршгийг үнэлэх;
- нөлөөллийг Рио Тинтогийн эрсдлийн ангиллын системээр тодорхойлох;
- хариуцлага хүлээх талуудыг тогтоох;

- нөлөөлөл, эрсдлийг бууруулахад удирдлагын үйл ажиллагаагаар хангах.

Эрсдлийн үнэлгээ нь оролцогч талуудын янз бүрийн санаа зовоосон асуудлуудыг тогтоож, янз бүрийн оролцогч талуудын үзэл санааг солилцоход чухал арга хэрэглүүр юм. Үр дүн нь тухайн бүлэгт сайнаар нөлөөлөх ба соёлын нөөц, баялгийн менежментийн талаар зөвшилцөлд хүргэхүйц сайн харилцааг тогтоож болох юм. Тиймд эрсдлийн үнэлгээ нь дуусалгүйгээр, харин оролцогч талууд өвийн мэргэжлийн менежерүүдэд зөвлөх болон туслах албан ёсны үүрэг гүйцэтгэх тийм томоохон үйл ажиллагааны нэг хэсэг болох ёстой. Иймээс Соёлын өөрчлөлтийн зөвшөөрөгдөх хэм хэмжээгээр ажиллах нь оновчтой зөв механизм болох юм.

Эрсдлийн үнэлгээний талаар семинар 2011 оны 3 сарын 23-нд болсон. Энэхүү семинарт Зөвлөх Хорооны гишүүд болон уул уурхай, аялал жуулчлалын компаний төлөөллүүд оролцсон.

Энэхүү хуралдааныг Ч. Амартүвшин, Ж. Гэрэлбадрах нар даргалан МОУӨ Багийн гишүүд болох Б. Гүнчинсүрэн, Ж, Алтшул, А. Секстон, П. Лхагвасүрэн нар оролцов. Энэхүү хуралдаанаар эрсдлийн үнэлгээний явцыг ерөнхийд нь дүгнэн зөвшөөрөгдөх хэм хэмжээнд эзлэх байрыг тогтоов.

Рио Тинтогийн эрсдлийг үнэлэх зааварчилгааны дагуу эрсдлийг “Нэг буюу хэд хэдэн зорилгод сөргөөр нөлөөлж болзошгүй тодорхойгүй үйл явдал буюу нөхцөл байдал” хэмээн тодорхойлсон. Сөрөг нөлөөтэй эрсдлүүдийг бид занал хэмээн нэрлэж эерэг үр нөлөөтэйг чиг хандлага хэмээн тодорхойлсон. Энэхүү семинар нь хөгжилтэй холбоотойгоор соёлын өвд үүсэх занал болон эерэг чиг хандлага гэсэн хоёр хоёр хэсгээс бүрдэнэ гэдгийг бид оролцогчдод мэдэгдсэн (хүснэгт 23, 24). Эдгээр хөгжил нь уул уурхайн салбартай нилээд холбоо хамааралтай.

Оролцогчид нь эрсдлийн матрикс дээр эхлэн ажилласан. Оролцогч бүрт цаас харандаа өгч Өмнөговь аймгийн соёлын өвд тулгарч байгаа аюул заналыг бичихийг хүссэн. Оролцогсод тухайн хүснэгтийг бөглөн жагсаалт гаргаж бүлэг бүр өөрсдөө 10 чухал гэж үзсэн сэдвийг сонгон авч ярилцсан. Яг ийм дасгалыг бас чиг хандлагын сэдэв дээр хийсэн. Цаг хугацаа давчуу байснаас оролцогчид сэдэв бүр дээр нарийвчилж амжаагүй. Ярилцлагын тэмдэглэлийг нарийвчлан хөтөлсний үндсэн дээр оролцогчид матриксаа Улаанбаатарт ирсний дараа бөглөсөн. Дараа нь энэхүү бөглөсөн матриксаа оролцогч бүрт илгээн семинарын үйл ажиллагааны үр дүнг хүн бүхэнд тодорхой болгосон. Үүний дараа долоон оролцогч өөрсдийн тайлбарыг ирүүлсний 3 нь боломжийн гэж үзсэн. Харин З. Сугармаа (Энержи Ресурс ХХК), Ц. Бат-Өлзий (Өмнөговийн ахмадын хороо), А. Цоог (Баян Түүх ТББ), Х. Сугир (Манлай сумын засаг дарга) гэсэн 4 оролцогч ярилцаж байгаа асуудлаар тайлбар өглөө. Үүний дараа Б. Гүнчинсүрэнгийн тавьсан асуултын хариу болгож Зөвлөх Хорооны гишүүн ШУА-ийн Палеонтологийн Хүрээлэнгийн захирал П. Басболд эрсдлийн үнэлгээний талаар ерөнхий тайлбарыг өглөө.

**Хүснэгт 22 Эрсдлийн үнэлгээний матрицын жишээ**

| А. | Эрсдэл | Нөлөөллийн үйлдлүүд | Төрөл | Хамрах хүрээ | Үргэлжлэх хугацаа | Магадлал | Үр дагавар | Үр дагаврын түвшин | Эрсдлийн ангилал | Эрсдэл хариуцагч | Хийгдэх ажлууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Нүүдлийн соёл, уламжлалт ёс заншил алдагдана. | Нүүдэл багасна. Ханбогдод хотжилт бий болно; Нүүдэлчин ахуйгаас суурьшмал амьдралд шилжинэ; үйлдвэрлэлжилт хүчтэй явагдана, | Шууд/шууд бус | Шууд нөлөөллийн сумд | ОТ уурхай ажиллах туршид | Өндөр эрсдэлтэй | Нүүдлийн аж амьдрал үгүй болох; Үндэсний сууц-гэргүй болох; Уламжлалт тээврийн хэрэгсэлгүй болох | Өндөр | IV | -Засгийн газар<br>-Парламент<br>-Нутгийн удирдлага<br>-Уурхай<br>-Олон нийт | -малаас гарах сүү, махыг уурхайд нийлүүлж, МАА-г дэмжих бодлого явуулах,<br>-МАА-н уламжлалт уралдаан тэмцээнийг жил бүр хийж хэвшүүлэх,<br>-Нүүдлийн соёлын талаарх сургалт, боловсролыг дээшлүүлэх,<br>-Мал маллах уламжлалыг өвлүүлэх, |
| 2 | Түүхийн, палентологийн, археологийн болон соёлын дурсгалууд устах аюул ихэснэ. | Уурхайн бүтээн байгуулалт; Дэд бүтэц барих; Хууль бус Арх/Палеонтологийн малтлага; Тонуул нэмэгдэх, | Шууд/шууд бус | 1. уурхай<br>2.Шууд нөлөөллийн сумд | Зөвхөн уурхайн бүтээн байгуулалтаас үл хамааран үргэлжилнэ. | Өндөр эрсдэлтэй | Эцэг өвгөдийнхөө тухай мэдээлэлгүй болох, Байгаль болон түүхийн дурсгалт газрууд, тэдгээрийн талаар бүртгэлгүй болох, Үндэсний бахархах зүйлгүй болох, | Өндөр | IV | -Засгийн газар<br>-Парламент<br>- Нутгийн удирдлага<br>– Уурхай<br>- Иргэн | -СӨ-ийг бүртгэж, баримтжуулан мэдээллийн сан байгуулах,<br>-СӨ-ийн хамгаалах санхүүгийн эх үүсвэрийг шийдэх,<br>-СӨ-ийн мэргэжилтэн, хүний нөөцийг сайжруулах ,<br>-СӨ-ийн зөрчил,гэмт хэрэгт оногдуулах торгууль, ялыг чангатгах,<br>-СӨ-ийн сургалт, сурталчилгааг сайжруулах,<br>-Албан болон албан бус сургалтын хэлбэрийг ашиглан соёлын өв, түүнийг хадгалах хамгаалах чиглэлийн сургалт явуулж байх<br>- Төрийн байгууллагууд СӨ-ийг хамгаалах |

| А. | Эрсдэл | Нөлөөллийн үйлдлүүд | Төрөл | Хамрах хүрээ | Үргэлжлэх хугацаа | Магадлал | Үр дагавар | Үр дагаврын түвшин | Эрсдлийн ангилал | Эрсдэл хариуцагч | Хийгдэх ажлууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэх,<br>-СӨ-ийг хамгаалахад Олон нийт, ТББ-уудын оролцоог нэмэгдүүлэх,<br>-Палеонтологийн музей байгуулах асуудлыг мэргэжлийн байгууллагатай тохирох, |
| 3 | Говийнхны онцлог ёс, зан үйл алдагдана. | Гадныхан нэмэгдснээр нутгийн аялга үгүй болно, Говийнхны өвөрмөц соёл, тусч зочломтгой зан чанар үгүй болох; | Шууд | Шууд нөлөөллийн сумд | ОТ уурхай ажиллах туршид | эрсдэлтэй | Гэр бүлийн нандин уламжлал үгүй болох; Амьдралын хэв маяг өөрчлөгдөх; Уламжлалт зан үйл үгүй болох, Хувцаслалт өөрчлөгдөх | Дунд зэрэг | III | -Олон нийт<br>-ТББ | -Уламжлалт онцлог ёс, зан үйлийн талаарх судалгаа хийх,<br>-Уламжлалт хоол ундны технологийг сэргээх, хадгалах, сурталчлах<br>-Уламжлалт тоног төхөөрөмжийг сэргээх, хэрэглэх, сурталчлах |
| 4 | Гэр бүлийн харилцаанд сөрөг зүйлүүд бий болно. | Уламжлалт гэр бүлийн ёс эвдэрнэ, Хамтран амьдрах ёс нэмэгдэнэ.<br>Гэр бүл салах явдал нэмэгдэнэ. | Шууд/шууд бус | Шууд нөлөөллийн сумд | ОТ уурхай ажиллах туршид | эрсдэлтэй | Олон хүүхэд өнчин болно. Нийгмийн өвчин ихэснэ. Хүүхдийн хүмүүжил муудна. | Дунд зэрэг | III | -Засгийн газар<br>-Парламент<br>- Нутгийн удирдлага<br>– Уурхай<br>- ТББ<br>- Иргэн | -Гэр бүлээр нь уурхайд ажиллуулах нөхцлийг бүрдүүлэх,<br>-Шууд нөлөөллийн сумдад ажил эрхлэлтийн байдлыг сайжруулах,<br>-Сумдад ажиллах хүчнээ байрлуулж, нийгмийн үйлчилгээг хүртээмжийг сайжруулах,<br>-Уламжлалт гэр бүлийн ёс, хүмүүжлийг сайжруулах,<br>- Гэр бүлийн талаарх а.төрөөс, б. уул уурхайн компаниас баримтлах бодлого шинээр боловсруулан |

| А. | Эрсдэл | Нөлөөллийн үйлдлүүд | Төрөл | Хамрах хүрээ | Үргэлжлэх хугацаа | Магадлал | Үр дагавар | Үр дагаврын түвшин | Эрсдлийн ангилал | Эрсдэл хариуцагч | Хийгдэх ажлууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | | | | | хэрэгжүүлэх санал тавих, |
| 5 | Уламжлалт МАА эрхлэх нь эрс багасна. | Мал маллахаа больж илүү цалинтай уурхай руу тэмүүлнэ, Малчин айл өрхийн цөөрнө. | Шууд/шууд бус | Шууд нөлөөллийн сумд | ОТ уурхай ажиллах туршид | эрсдэлтэй | Малын тоо толгой цөөрнө, Зэрлэгшсэн мал ихсэж, уналгааны мал багасна. | Дунд зэрэг | III | -Засгийн газар<br>-Парламент<br>- Нутгийн удирдлага<br>– Уурхай<br>-ТББ<br>- Иргэн | - Тэмээний соёлыг зүйл бүрээр дэмжих,<br>-Шууд нөлөөллийн сумдад мах, сүү боловсруулах үйлдвэр байгуулан МАА-г дэмжих,<br>-МАА-н бүтээгдэхүүн боловсруулах жижиг үйлдвэр, цех байгуулах,<br>-Залуу малчдыг дэмжин урамшуулах, сонирхол бий болгох,<br>-Малын бэлчээрийг усжуулах ажлыг дэмжих, |
| 6 | Соёлын биет бус өвийн залгамж холбоо үгүй болно. | Соёлын өв тээгч хүмүүс жамаараа ховордохын зэрэгцээ хотжилтын улмаас тэдний тоо эрс цөөрнө. | Шууд бус | Шууд нөлөөллийн сумд | ОТ уурхай ажиллах туршид | эрсдэлтэй | Уламжлалт дарханы урлал үгүй болох; Дуу хөгжимгүй болох; Үндэсний хоол унд үгүй болох; Үндэсний хувцасгүй болох; Гэр бүлийн хүмүүжил ба хориг цээргүй болох; Уламжлалт мэдлэг ухаан, соёл өвлөгдөх нь багасна | Дунд зэрэг | II | -Олон нийт<br>-ТББ<br>-Иргэн | -Биет бус соёлын өвийн судалгааг нарийвчлан хийж тогтоох,<br>-Биет бус соёлын өв тээгчдийн мэдээллийн сан бүрдүүлэх,<br>- Биет бус соёлын өвийн сургалт, сурталчилгааг сайжруулах,<br>- Биет бус соёлын өв тээгчдийн төрөл бүрийн уралдаан тэмцээн зохион байгуулж хэвших,<br>- Биет бус соёлын өв тээгчдийн шавь сургалтыг бий болгох тусгай "хөтөлбөр"-үүд боловсруулж, санхүүжилтийн асуудлыг шийдэх, |

| А. | Эрсдэл | Нөлөөллийн үйлдлүүд | Төрөл | Хамрах хүрээ | Үргэлжлэх хугацаа | Магадлал | Үр дагавар | Үр дагаврын түвшин | Эрсдлийн ангилал | Эрсдэл хариуцагч | Хийгдэх ажлууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 7 | Байгаль хамгаалах уламжлалт арга, ёс заншил үгүй болно. | Хотжилт бий болж, хүн ам олширсноор байгаль орчны байдал муудна. | Шууд бус | Шууд нөлөөллийн сумд | ОТ уурхай ажиллах туршид | эрсдэлтэй | Байгаль орчин, бэлчээр нутгаа хамгаалах уламжлалт ёс мартагдах, | Дунд зэрэг | II | -Олон нийт -ТББ -Иргэн | -Иргэдийн экологийн боловсролыг дээшлүүлэх сургалт, сурталчилгааг сайжруулах, -Байгаль хамгаалах талаарх нэмэлт хичээлийн хөтөлбөр зохиож боловсруулах, -Байгаль хамгаалах мэдлэг ухааныг судлаж, сурталчлах, -Байгаль хамгаалагчдыг сургах сургалтыг хийх, |
| 8 | Соёлын өвийн эсрэг гэмт хэрэг ихэснэ. | Соёлын өвийг хулгайлах, устгах, зарах нь эрс ихэснэ, Эртний эдлэл гадагш гарах нь ихэснэ. | Шууд/шууд бус | Шууд нөлөөллийн сумд | Энэ үйл ажиллагаа зөвхөн төслийн туршид ч бус түүний өмнө нь ч, дараа нь ч ажиглагдах болно. | эрсдэлтэй | Эд зүйлс алдагдана, Хууль бус малтлага ихэснэ; Дурсгалууд устах гэмтэх аюул ихэснэ. | Дунд зэрэг | II | -Засгийн газар -Парламент - Нутгийн удирдлага – Аж ахуй - Иргэн | -СӨ-ийг бүртгэж, баримтжуулан мэдээллийн сан байгуулах -Онцгой зарим дурсгалыг улс, аймаг, сум орон нутгийн хамгаалалтанд авахуулах -Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгож, хэрэгжилтийг сайжруулах, -СӨ-ийн улсын байцаагчийн эрхийг гэрээгээр гүйцэтгүүлэх ажлыг шийдэх, -СӨ-ийн зөрчил,гэмт хэрэгт оногдуулах торгууль, ялыг чангатгах, |

| A. | Эрсдэл | Нөлөөллийн үйлдлүүд | Төрөл | Хамрах хүрээ | Үргэлжлэх хугацаа | Магадлал | Үр дагавар | Үр дагаврын түвшин | Эрсдлийн ангилал | Эрсдэл хариуцагч | Хийгдэх ажлууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | Шилжилт хөдөлгөөн нэмэгдэж, зарим нутаг дэвсгэр, засаг захиргааны нэгж өөрчлөгдөнө. | Хүн амын шилжилт хөдөлгөөн эрс ихэснэ, Зарим баг, сумын хүн амын тоо багасна. | Шууд/шууд бус | Шууд нөлөөллийн сумд | ОТ уурхай ажиллах туршид | эрсдэлтэй | Зарим сумдын хүн амын тоо хэт цөөрөх аюул бий болно. | Дунд зэрэг | II | -Засгийн газар<br>-Парламент<br>- Нутгийн удирдлага<br>– Уурхай<br>- ТББ | -Шууд нөлөөллийн бүсийн дэд бүтцийг сайжруулах,<br>- Ханбогд болон бусад сумдуудад бизнес эрхлэх боломжийг бий болгох /уурхайд мах, сүүн бүтээгдэхүүн нийлүүлэх/<br>- Шууд нөлөөллийн бүсийн нийгмийн үйлчилгээг сайжруулах,<br>-Хүн ам зүй, гэр бүлийн талаарх бодлогыг б.аймгийн, в.сумын г.уул уурхайн компани боловсруулах, |
| 10 | Байгалийн дархан газруудын хамгаалалт муудна. | Дэлхийн эко системийн гол нутгийн нэг Их говийн дархан газар аюулд өртөнө. Авто зам баригдана. | Шууд/шууд бус | Шууд нөлөөллийн сумд | ОТ уурхай ажиллах туршид | эрсдэлтэй | Дархан газрын ховор ан амьтад устана. Эмзэг хөрс, ургамал нь үгүй болно. | Дунд зэрэг | II | -Засгийн газар<br>-Парламент<br>- Нутгийн удирдлага<br>– Уурхай<br>- ТББ | -Байгалийн дархан газруудад зохистой байгалийн жуулчлал хөгжүүлэх үзэл баримтлалыг боловсруулах,<br>-Байгалийн дархан газруудын сурталчилгааг сайжруулах,<br>-Байгаль хамгаалагчдын сургалт, давтан сургалтыг хийх, |

**Хүснэгт 23 Зэрэг нөлөөллийн үнэлгээ**

| Б. | Боломжууд | Нөлөөллийн үйлдлүүд | Төрөл | Хамрах хүрээ | Үргэлжлэх хугацаа | Магадлал | Үр дүн | Үр өгөөжийн түвшин | Боломжийн түвшин | Боломж хариуцагч | Хийгдэх ажлууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1. | Соёлын өвийн бүртгэл мэдээллийн сан бий болно. | Биет соёлын өвүүд ба биет бус соёлын өвийг тээгчдийг бүртгэж, баримтжуулна. | Шууд | Шууд нөлөөллийн сумд | ОТ уурхай ажиллах туршид | Өндөр боломжтой | Биет ба биет бус СӨ-ийн иж бүрэн мэдээллийн сан бий болно. | Өндөр | IV | -Засгийн газар<br>- Нутгийн удирдлага<br>– Уурхай<br>-Олон нийт | -Биет СӨ-үүдэд хамгаалалтын бүс, хашаа, самбар, зогсоол хийх,<br>-Биет бус СӨ тээгчдийн бүртгэл, бичлэгийг хийх,<br>-СӨ-ийн төрөл бүрийн сургалтууд явуулах, |
| 2. | Соёлын өвийн нарийвчилсан судалгааны ажил сайжирна. | Уурхайн ашиглалтын талбай ба хайгуулын талбайд хайгуул хийнэ. Сумдад түүх-угсаатны зүйн судалгаа хийнэ | Шууд | Шууд нөлөөллийн сумд | ОТ уурхай ажиллах туршид | Өндөр боломжтой | Шууд нөлөөллийн бүс нутгийн судалгаа нэмэгдэнэ. | Өндөр | IV | - ШУА<br>– Уурхай<br>- Нутгийн удирдлага<br>-Олон нийт | -Шууд нөлөөллийн сумдад археологи, палеонтологи, угсаатны зүйн судалгааг төлөвлөгөөтэй явуулах, |
| 3. | Дэлхийн соёлын өвийн бүртгэлд говийн Соёлын өвүүд бүртгүүлнэ. | Говийн байгалийн болон палеонтологийн дурсгалт газруудыг ЮНЕСКО-д бүртгүүлэх, | Шууд | Шууд нөлөөллийн сумд | ОТ уурхай ажиллах туршид | Өндөр боломжтой | Говийн нэр хүнд дэлхийд өснө. | Өндөр | IV | -Засгийн газар<br>- Нутгийн удирдлага<br>– Уурхай<br>-ШУА | -Баянзагийг Дэлхийн соёлын өвд бүртгүүлэх ажлыг хийх,<br>-Гурвансайхан уул ба Говийн Бага дархан газрыг Дэлхийн соёлын өвд,<br>-Тэмээний баярыг Дэлхийн соёлын өвд бүртгүүлэх |
| 4. | Музейн шинэ байр барилга баригдаж, үйл ажиллагаа нь сайжирна. | Даланзадгадад музейн шинэ барилга баригдана, Аймгийн ба сумдын музейн үйл ажиллагаа сайжирна. | Шууд | Шууд нөлөөллийн сумд | ОТ уурхай ажиллах туршид | Өндөр боломжтой | ОУ-ын стандартын музейтэй болно. Сумдын музей шинэчлэгдэнэ. | Өндөр | III | -Засгийн газар<br>- Нутгийн удирдлага<br>– Уурхай | -Даланзадгадад аймгийн шинэ музейн барилга барих,<br>-Шууд нөлөөллийн бүсийн 3 суманд музейн барилга шинээр барих,<br>-Музейн тоног хэрэгслийг шинэчлэх,<br>-Үзмэрийг баяжуулах, |
| 5. | Соёлын төвүүдийн чадавхи сайжирна. | Сумын соёлын төвүүдийн техник хэрэгсэл сайжирна. | Шууд | Шууд нөлөөллийн сумд | ОТ уурхай ажиллах туршид | Боломжтой | Соёлын төвүүд СӨ-ийн бодлогыг хэрэгжүүлэгч гол | Дунд зэрэг | III | -Засгийн газар<br>- Нутгийн удирдлага<br>– Уурхай | -Сумдын соёлын төвийг техник хэрэгслээр хангах,<br>-Соёлын төвүүдэд СӨ-ийн сургалт, сурталчилгаа эрчимтэй явуулах,<br>-Соёлын төвөөс СӨ-ийн |

| Б. | Боломжууд | Нөлөөллийн үйлдлүүд | Төрөл | Хамрах хүрээ | Үргэлжлэх хугацаа | Магадлал | Үр дүн | Үр өгөөжийн түвшин | Боломжийн төвшин | Боломж хариуцагч | Хийгдэх ажлууд |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | газар болж хувирна. | | | | уралдаан тэмцээн олноор зохион байгуулах, |
| 6. | Соёлын өвийн талаар мэдлэг, боловсрол дээшилнэ. | Сурагчдад СӨ-ийн боловсрол олгох нь нэмэгдэнэ. Бүх насны хүмүүст СӨ-ийн зайны сургалт явуулна. | Шууд | Шууд нөлөөллийн сумд | ОТ уурхай ажиллах туршид | Боломжтой | Бүх насны хүмүүсийн соёлын өвийн мэдлэг сайжирна. | Дунд зэрэг | II | -Засгийн газар<br>- Нутгийн удирдлага – Уурхай<br>-ТББ | -Хүүхдийн СӨ-ийн боловсрол нэмэгдүүлэх,<br>-Насанд хүрэгчдэд СӨ-ийн зайны болон албан бус сургалт явуулах, |
| 7. | Жуулчид нэмэгдэж, аялал жуулчлал хөгжинө. | Жуулчид нэмэгдэнэ, Аялал жуулчлалын шинэ төрөл зүйлүүд бий болж эхэлнэ. | Шууд | Шууд нөлөөллийн сумд | ОТ уурхай ажиллах туршид | Боломжтой | Түүх соёлын ба байгалийн дурсгалын сурталчилгаа сайжирна. | Дунд зэрэг | II | -Засгийн газар<br>- Нутгийн удирдлага<br>-Аж ахуйн нэгжүүд<br>-Олон нийт | -Зочид буудал, хоолны газруудыг сайжруулах,<br>-МАА-н аялал жуулчлалыг сурталчлах, |
| 8. | Соёлын өвийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгоно. | СӨ-ийг аялал жуулчлалд үзмэр болгох нь нэмэгдэнэ, Биет бус СӨ-ийг аялал жуулчлалын бүтээгдэхүүн болгоно. | Шууд | Шууд нөлөөллийн сумд | ОТ уурхай ажиллах туршид | Боломжтой | Биет бус СӨ-ийг жуулчдын үзмэр болгоно, | Дунд зэрэг | II | -Засгийн газар<br>- Нутгийн удирдлага<br>-Аж ахуйн нэгжүүд<br>-Олон нийт | -СӨ-ийн аялал жуулчлалыг сурталчлах,.<br>-Биет СӨ-үүдийг сайтар хамгаалалтанд авах,<br>-СӨ-ийг эвдэх, устгах, дамлан зарах явдалтай тэмцэх, |
| 9. | Дэд бүтэц сайжирч, амьжиргааны төвшин нэмэгдэнэ. | Цахилгаан эрчим хүч, харилцаа холбоо, зам тээвэр хөгжинө, Уурхайд ажиллагсадын амьдрал дээшилнэ. | Шууд | Шууд нөлөөллийн сумд | ОТ уурхай ажиллах туршид | Боломжтой | Байнгын эрчим хүчтэй болно. | Дунд зэрэг | II | -Засгийн газар<br>- Нутгийн удирдлага<br>-Уурхай<br>-Аж ахуйн нэгжүүд<br>-Олон нийт | -Засмал зам тавих,<br>-Өндөр хүчдэлийн шугам барих,<br>-Холбоо харилцаа шинэ технологи нэвтрүүлэх, |
| 10. | Уул уурхай, нүүдлийн МАА зэрэгцэн орших үлгэр загвар бий болно. | Уул уурхай нүүдлийн МАА-г тэтгэсэн бодлого баримталж, сүү мах худалдан авдаг болно. | Шууд | Шууд нөлөөллийн сумд | ОТ уурхай ажиллах туршид | Боломжтой | Уурхай МАА-г дэмжих тусгай хөтөлбөр зохионо. | Дунд зэрэг | II | -Засгийн газар<br>- Нутгийн удирдлага<br>-Уурхай<br>-Олон нийт<br>-ТББ | -Сумдад мах боловсруулах жижиг цех байгуулах,<br>-Сумдад сүү, цагаан идээний цех байгуулах, |

*Товчилсон үг хэллэгүүд:* СӨХ = Соёлын өвийн хөтөлбөр; ОТ =Оюу Толгой; **Эрсдлийн шинж байдал/Чиглэл:** PO = эерэг; NE = сөрөг; MI = холимог; DI = шууд; IN = шууд бус; CU = цогц; **Магадлал:** HL = өндөр магадлалтай (дахин давтагдан тохиолдох магадлалтай эрсдэл; жилд 2-с дээш тохиолдох магадлалтай); PR = магадлалтай (тусгаарлагдсан эрсдэл; тохиолдож болох; өөр бусад газар тохиолдож байсан, жилд 1-2 удаа тохиолдох магадлалтай). **Эрсдлийн зэрэглэл:** I = Хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнээс бага байх эрсдэлийг уг ангилалд багтаах ба менежментийн идэвхтэй арга хэмжээ авах шаардлагагүй; II = Зөвшөөрөгдөх хэмжээнд байгаа эрсдлийг энд ойлгох ба идэвхтэй мониторингийн арга хэмжээ авах шаардлагатай; III = Зөвшөөрөгдөх хэмжээнээс давсан эрсдэл. Урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах шаардлагатай; IV: Зөвшөөрөгдөх хэмжээнээс маш ноцтой давсан эрсдэл. Яаралтай арга хэмжээ авах шаардлагатай. **Эрсдэл хүлээгч:** ОТ = Оюу Толгой ХХК; LG = Орон нутгийн засаг захиргаа; NG = Үндэсний хэмжээний яам,агентлагууд.

[a] Эдийн засгийн хувьд үр ашигтай,эерэг нөлөөлөлтэй байх боловч уламжлал өөрчлөгдөх сөрөг нөлөөтэй.

Өмнөговь аймгийн соёлын өвд тулгарч байгаа томоохон эрсдэл бол нүүдэлчний уламжлал болон холбогдох соёл алдагдан түүх шинжлэх ухааны чухал дурсгалууд эвдрэн сүйрсээр байна. Уул уурхайн салбарынхны мэдэж байгаачлан биет бус өвүүдэд гол анхаарлаа хандуулснаас археологи, палеонтологи, түүх соёлын дурсгалууд гэх мэтчилэн биет өвүүд сүйрч байгаа нь гол эрсдэлүүд болж байна.

Бүх оролцогчид Рио Тинтогийн Эрсдлийн 4-р шатанд багтдаг нүүдлийн соёл болон биет өвд учирч байгаа эрсдэл нь зөвшөөрөгдөх хэмжээнээс хэтэрсэн тул яаралтай арга хэмжээ авах шаардлагатай байна. Үнэн хэрэгтээ энэ эрсдэл нь улам бүр нэмэгдэн байгаа тул говийн соёл хүн амд сөргөөр нөлөөлөх шинжтэй байна хэмээн үзсэн.

Соёлын чухал ач холбогдолтой биет өв болон нүүдлийн соёл алдагдаж байгаа нь уул уурхайн салбарын үйл ажиллагааны уршиг бөгөөд Өмнөговь аймгийн хэмжээнд уул уурхайн салбар эрчимтэй хөгжиж байгаагаас шалтгаалж байна. оролцогчид уул уурхайтай шууд холбогдохгүй ч соёлын алдагдалд хүргэж байгаа шилжилт нүүдэл болон дэд бүтцийн хөгжил гэх мэтийн бусад шалтгаануудыг ч дурьдаж байна. Оролцогсдын үзэж байгаагаар Оюу Толгойн уурхайн үйл ажиллагаа явагдах үеэр соёлын өвийн алдагдал бүр ч өндөр байгаа бөгөөд эдгээрийг зарим нь нөхөн сэргээгдэж болох ч ихэнх нь мөнхийн алдагдал устгал болж байна. Засгийн газраас бүх шатанд энэ алдагдал устгалын төлөө хариуцлага хүлээлгэх ёстой. Үүний тулд холбогдох хуульд нэмэлт өөрчлөлт оруулж хамгаалалтыг сайжруулах хэрэгтэй. Тэгээд ч эдгээр уул уурхайн компаниуд нь дээрх бүх хохирлыг нөхөх ямар нэгэн алхам хийхгүй  байгаа талаар оролцогчид онцлон хэлж байсан. Оролцогчид орон нутгийн зах зээлийн хөгжүүлэхээс авахуулаад соёлын өвийн тухай мэдээллийн санг байгуулах хүртэл маш олон менежментийн үйл ажиллагааг санал болгож  байсан. Энэхүү менежментийн үйл ажиллагаанууд нь СӨХ-ийн олон нийтийн үйл ажиллагааны хөтөлбөртэй нийцэх ёстой.

Бусад найман эрсдэл нь гол хоёр заншилын өөр өөр хувилбар байдалтай бий болсон. Жишээ нь: Нийгмийн хэв журам алдагдах гэсэн 4 дэх эрсдэл  нь уламжлалт ёс заншил алдагдах болон ариун догшин газрыг шүтэхээ больсонтой холбогдуулан үүсдэг. Энд жагсаан бичсэн эрсдлүүдээс үзвэл оролцогчид нь нийгмийн хамгааллын чиглэлээрх соёлын өв алдагдахтай холбоотой эрсдлийг нилээд авч үзсэн. Гэр бүлийн уламжлалт харилцаа алдагдсантай холбогдуулан гэмт хэргийн тоо нэмэгдэж байгаа талаар олон хүн яриж байсан.

Эрсдэлийн үнэлгээний талаар ярж байгаа хүмүүс чиг хандлагын зэрэгцээ холбогдох эрсдэлийн талаар бас ярисан. Нүүдлийн соёл иргэншил алдагдсантай холбогдуулан биет бус өвийг эзэмшигчдийг тодруулан бүртгэх шаардлага үүссэн. Уул уурхайн салбараас биет бус өвд учирч болзошгүй эрсдэлийг тогтоохын тулд Өмнөговийн түүх, археологи, палеонтологи, угсаатны зүйн чиглэлээр илүү нарийвчилсан судалгаа шинжилгээний ажлыг хийх хэрэгтэй болж байна. Оролцогчдын хэлж байгаагаар уул уурхайн салбар хөгжсөн нь дэлхийн өвийн сангийн жагсаалтад Монголын дурсгалыг оруулах боломжийг нэмсэн явдал юм.

Түүнчлэн олон нийтийн хөтөлбөрүүд хэрэгжүүлэх боломж байгааг бас дурьдсан. Өмнговь аймгийн музейг байгуулах, сумын соёлын төвүүдийн хүчин чадлыг сайжруулах, ерөнхий боловсролын хичээлд соёлын өвийн хичээлийг оруулах гэх мэтийн боломжуудыг 4-6 хэсэгт дурьдсан. Өв уламжлалтай холбоотой аялал жуулчлал хөгжүүлэх боломжийг чиг хандлага гэсэн хэсэгт багтаан соёлын чиглэлээр аялал жуулчлал хөгжүүлэхийн тулд дэд бүтцэд тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай байгааг дурьдсан.

Эрсдэлийн үнэлгээний сургалтын үед ажиглагдсан өөр нэг хачирхалтай зүйл нь оролцогчдын дунд гол чиглэл болон эрсдэлийн талаар нэгдсэн ойлголт байхгүй байсан. Ихэнхи эрсдэлүүд нь нилээд түгээмэл бодит зүйл байсан бол чиг хандлага нь онолын хэлбэртэй байсан. Говийн иргэд болон уул уурхайн салбарын хувьд соёлын өв нь нилээд асуудалтай байгаа гэж бүх оролцогчид үзсэн.

## 9. ДҮГНЭЛТ

**Жеффрей Х. Алтшул, Б. Гүнчинсүрэн, Жон В. Олсен**

Судалгааны ажлын эхний үе шатанд хангалттай мэдээлэл цуглуулан өмнөговь аймгийн СӨХ-г боловсруулах ёстой байсан. Тийм учраас МОУӨБагаас говийн аймгийн археологи, палеонтологи, антропологи, түүхийн сэдвээр ном зохиол судлаж дууссан. Түүнчлэн бид Монголын үндэсний, орон нутгийн болон сумын хэмжээн дэх боловсрол музей соёлын төвүүд аялал жуучлалын салбарын стандартын талаар мэдээлэл цуглуулсан. Энэхүү ажлын хүрээнд үндэсний, орон нутгийн болон сумын хэмжээнд бүртгэгдсэн бүх дурсгалуудыг багтаасан мэдээлэлийн санг үүсгэсэн. Энэхүүү сангийн мэдээллийг ашиглан Өмнөговь аймгийн хэмжээнд байгаа археологийн дурсгалуудын загвары урьдчилан тамааглах боломжтой болсон. Бид дэлхийн хэмжээнд ашиглагдаж байгаа энэ загварын анх удаа Монголд ашиглаж байна.

Бидний баримтжуулсан мэдээллээс орчин үеийн Өмнөговь аймгийн соёлын өвийн талаарх мэдээлэлд дутуу хангалтгүй байгаа зүйлүүдийг олж мэдэх боломжтой байна. эдгээр дутуу зүйлийн үндсэн дээр Өмнөговь аймагт хийх хээрийн судалгааны ажлыг төлөвлөх боломжтой. Нийтдээ төслийн нэгдүгээр үе шатны явцад Өмнөговь аймгаар долоон удаа аялсан. Биет өвийн судалгааны баг хоёр удаа, олон нийтийн хөтөлбөр болон биет бус өвийн судалгааны баг тустай болон хамтран дөрвөн удаагийн аяллыг тус тус хийсэн. МОУӨБагийн нийт гишүүд гадаадын мэргэжилтнүүдээ оролцуулан нэг удаа аялал хийсэн. Цаг уурын тааламжгүй нөхцөлөөс болж палеонтологийн баг нэг удаагийн аяллаа цуцалсан.

Өмнөговь аймгийн нутгаар аялах бүртээ бид орон нутгийн соёл иргэншилийг шинээр харж судалж байсан. Археологийн дурсгалууд болон палеонтологийн олдворуудыг хууль бусаар малтах, дуу мартагдах, уламжлалт хувцас орчин үеийн хувцасаар солигдох, алт мөнгө болон төмрийн дархны уламжлал тасрах гэх мэтчилэнгийн томоохон аюул заналын талаар бид одоо сонсох болсон. Түүнчлэн соёлын өвийн үйл ажиллагааг идэвхитэй дэмжих зорилгоор ерөнхий боловсрол болон соёлын төвүүдийн үйл ажиллагаанд бодит хөрөнгө оруулалтыг хийн эко-туризмыг хөгжүүлэх шаардлагатай байгааг олж мэдсэн. Уул уурхайн салбарыг хөгжүүлэхийн зэрэгцээ орон нутгийн соёлын өвийг хөгжүүлэх шаардлагатай байгааг орон нутгийн албан хаагчид, оршин суугчид, төрийн бус байгууллагууд гэх мэтчилэн хүн болгоноос сонссон.

Уул уурхайн компаниуд нь одоогийн байдлаар Соёлын Өвийг Хамгаалах Тухай Монгол Улсын Хууль болон бусад холбогдох хууль тогтоомжуудыг дагаж мөрдөн аливаа малтлага судалгааг ивээн тэтгэж өөрсдийн хөрөнгөөр хийлгэн үйл ажиллагааныхаа явцад эвдэж гэмтээхээс сэргийлэх шаардлагатай. Харамсалтай нь энэ журмыг хангалттай дагаж мөрдөхгүй байна. Одоогийн байдлаар уул уурхайн лиценз авсан компаниудын дөнгөж гурван хувь нь л дээрх хуулийн заалтыг дагаж мөрдөж байна. Ингэж хууль мөрдөхгүй байгаагийн гол шалтгаан нь олон янз боловч соёлын өвийг хамгаалах талаар тодорхой арга хэмжээ авч холбогдох хууль тогтоомжийг өөрчлөх шаардлагатай гэдэг нь тодорхой байна.

Нэгдүгээр шатанд бид өнгөрсөн болон орчин үеийн соёлын өвийн талаар хангалттай мэдээлэл цуглуулсанаа энэ тайланд хавсаргав. Бид соёлын өвийг хамгаалах ёстой гэдгээ мэдэж байна. Энэ хамгаалах ажлыг зохион байгуулах системийг тодорхойлох ёстой. Тийм болохоор СӨХ-г боловсруулах цаг нь иржээ.

# 10. ХАВСРАЛТ 1: ДУТАГДАЛТАЙ БАЙДЛЫН ШИНЖИЛГЭЭ

STATISTICAL RESEARCH, Inc.
ARCHAEOLOGY • ANTHROPOLOGY • HISTORY • HISTORIC ARCHITECTURE

2010 оны 10-р сарын 7

Хэнд: Оюу Толгой ХХК-ны Соёлын Өвийн Хөтөлбөр хариуцсан ажилтан О.Цэрэннадмид

Хэнээс: Доктор Жефф Алтшул, Монгол Олон Улсын Өвийн багийн удирдагч, тэргүүлэх судлаач

Доктор Б.Гүнчинсүрэн, Монгол Олон Улсын Өвийн багийн ахлагч, тэргүүлэх судлаач

Доктор Жон Олсен, Монгол Олон Улсын Өвийн багийн ахлагч, тэргүүлэх судлаач

**Утга: Цаашид сайжруулбал зохих асуудлын шинжилгээ**

Уг тайлан нь Оюу Толгой ХХК (ОТ)-ын Соёлын Өвийн Хөтөлбөрийн нэмж хийх шаардлагатай судалгааг тодруулсан дүгнэлтүүдийг нэгтгэсэн баримт бичиг юм. Энэхүү тайланг 2010 оны 9-р сарын 28-нд ОТ ХХК-нд танилцуулсан "Өмнөговь аймаг болон ОТ төслийн соёлын өвийн төлөвлөгөө" нэртэй илтгэлд суурилан бэлтгэсэн ба уг илтгэлийн хуулбарыг ОТ компанид хүргүүлсэн болно.

Тайлангийн эхэнд Өмнөговь аймаг дахь соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын өнөөгийн нөхцөл байдал болон зорьж буй чиглэлийн талаар авч үзсэн ба түүний дараа одоогийн нөхцлийг хэрхэн сайжруулах,эерэг болгож өөрчилөх талаар хэлэлцсэн болно. Мөн түүнчлэн биет болон биет бус өв, олон нийтийн хөтөлбөрийн хувьд СӨХ-ийг боловсруулахад зайлшгүй хийгдэх хэрэгтэй судалгаануудын талаар тайлангийн төгсгөлд дурьдсан.

**Соёлын өвийн хадгалалт,хамгаалалтын өнөөгийн нөхцөл байдал**

Өмнөговь аймаг нь соёлын баялаг уламжлалтай явж ирсэн төдийгүй одоо ч эдгээр өв уламжлалууд өвлөгдсөөр байна. Гэсэн хэдий ч уг бүс нутагт уул уурхайн үйл ажиллагаа эрчимтэй хөгжиж эхэлснээр уг соёлын өвүүдэд аюул занал учраад байгаа бөгөөд тодорхойгүй тооны археологийн болон палеонтологийн дурсгалт газрууд эвдэж сүйтгэгдэж байна. Шилжилт хөдөлгөөн ихэссэнээр соёлын дурсгалууд, динозаврын яс зэрэг нь хууль бусаар тоногдон зарагдах болсон. Малчид,нутгийн иргэд уул уурхайн холбогдол бүхий ажлын байрнуудад илүү татагдах болсноос гадна гаднаас ирэх шилжилт хөдөлгөөн ихэссэний улмаас Өмнөговь аймгийн уламжлалт амьдралын хэв маяг өөрчлөгдөж байна.Хүн ам ийнхүү гэнэт олноор нэмэгдэж байгаа үзэгдлийг зогсоох нь нутгийн иргэдийн хувьд тийм ч амар бус юм.

Иргэд,нутгийн удирдлагууд уг асуудлуудад сэтгэл зовниж явдаг нь бидний сум,аймагт хийсэн бүх уулзалтуудын үеэр ажиглагдаж байсан. Уулзалтуудын явцад тодорхой болсон нэг зүйл нь  соёлын өвтэй холбоотой хууль эрхзүйг дагах сонирхолгүй гэхээсээ илүүтэй соёлын өвийн хууль тогтоомжийн хэрэгжилт өөрөө сул байдаг нь ажиглагдсан юм.  Хэдийгээр Монголын соёлын өвийг хамгаалах тухай хууль нь уул уурхайн компаниудыг өв уламжлалыг хадгалж хамгаалахыг шаарддаг боловч, одоогоор уул уурхайн үйл ажиллагаа явуулах зөвшөөрөл авсан компаниудын зөвхөн 3.7 хувь нь соёлын өвийн судалгаа хийсэн. Монгол Улс нь Дэлхийн Өвийн Конвенци(1971), Ус намгархаг газрыг хамгаалах Рамсарын конвенци(1971) болон биет бус соёлын өвийг хамгаалах ЮНЕСКО-гийн конвенци (2003) зэрэг хэд хэдэн конвенцид нэгдэн орсон тул өв соёлоо хамгаалах, энэ үйлст нутгийн иргэдийг татан оролцуулах үүрэг амлалт хүлээсэн юм. Иймд эдгээр хууль тогтоомж,конвенцуудыг хэрэгжүүлэх явцыг зайлшгүй сайжруулах шаардлагатай.

## Санал болгож буй соёлын өвий хамгаалах бүтэц

Бид Монголын соёлын өвийг хамгаалах хууль эрхзүйн шинэ бүтцийг санал болгож байгааг Хавсралт Зураг 1-с харна уу. Уг ажлын эхний алхам болгон соёлын өвийн хадгалалт,хамгаалалтын зөвшөөрөл өгөх ажлыг хэрэгжилтээс нь салгаж авч үзэх нь зүйтэй гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл дан ганц нэг байгууллага холбогдох хууль тогтоомжийг биелүүлэхийг шаардаж, зохих судалгааг хийж, гарсан үр дүнг нь зөвшөөрч,баталгаажуулах нь тохиромжтой бус хувилбар юм. Бидний санал болгож буй төлөвлөгөө нь одоо байгаа бүтэц тогтолцоо буюу БСШУЯ-ны Соёл Урлагийн газар соёлын өвтэй холбоотой асуудлыг хариуцдагыг хэвээр хадгалах. Харин ингэхдээ соёлын өвийн асуудал эрхэлсэн,өөрөөр хэлбэл соёлын өвийн бодлого боловсруулж,зөвшөөрөл өгөх үүрэг бүхий хэлтэсийг Соёл Урлагийн газрын дэргэд байгуулж,үйл ажиллагааг жигдрүүлэх.

Ашигт малтмалын хайгуул хийх, ашиглалтад оруулах зөвшөөрөл авахын тулд тухайн этгээдийн бүрдүүлж өгсөн материалыг Ашигт Малтмалын Хэрэг Эрхлэх Газраас БСШУЯ-ны Соёл Урлагийн газарт хүргүүлж, улмаар Соёл Урлагийн Газар нь түүнийг шалгаж, зөвшөөрөл олгон зохих ёсны соёлын өвийн хураамж тогтооно. Соёлын өвийн хураамжийг тухайн жил бүр шинэчлэн тогтоох ба Засгийн Газрын Хэрэг Эрхлэх Газарт төлснөөр энэ нь БСШУЯ-ны Шинжлэх Ухаан, Технологийн газраар дамжин Шинжлэх Ухааны Академид очно. Ингэснээр Шинжлэх Ухааны Академи гурван хэлтэс бүхий Говь Судлалын Төвийг (уг төв Даланзадгадад байрлаж болох юм) байгуулах боломжтой болно. Түүхийн хэлтэс нь ам дамжиж ирсэн түүхийн чиглэлээр хэрэгжиж буй төслүүдийг хариуцах бөгөөд хамгаалалтад орсон Өвт газруудын жагсаалтыг гаргана. Археологи, палеонтологийн хэлтэс нь Өмнөговь аймаг дахь уул уурхайн болон бусад дэд бүтцийн улмаас сүйдэх магадлалтай биет соёлын өвүүдийг тодорхойлж,үнэлж,сэргээнэ. Гуравдахь нь Улаанбаатарт аваачих шаардлагагүй Өмнөговь аймгаас олдсон шинжлэх ухааны олдворуудыг хадгалах газар байх болно. Уул уурхайн том төслүүдийн хувьд маш олон журам,хуулиудыг дагаж мөрдөх шаардлагатай болдогийн дээр ШУА эдгээр бүх ажлуудад оролцдог нь бидэнд ажиглагдсан. Иймд уг байдлыг арилгахын тулд бидний дэвшүүлж буй санаа нь эдгээр хэлтэст тухайн өвийн үнэ цэнийг тогтоох, зохих хадгалалт хамгаалалтын арга хэмжээ авах эрх бүхий, мэргэжлийн түвшинд бэлтгэгдсэн, нэг болон түүнээс дээш тооны археологич юмуу палеонтологич мөн курст сууж сертификат авсан мэргэжлийн бус ажилчидтай байх хувилбар юм. ШУА нь аймгийн төв болон сумдад олон нийтийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Даланзадгад дахь Өмнөговийн музейг соёлын өвийн сангаас санхүүжүүлнэ (музейн үзмэр, сургалтын материал, наадам зэрэг).

Оюу Толгой төслийн соёлын өвийн хөтөлбөр нь уул уурхайн аж үйлдвэрт чиглэгдэж байгаа учраас бид Эрдэс Баялаг, Эрчим Хүчний Яамнаас тавигддаг шаардлагуудыг мөн давхар анхаарах үүрэгтэй. Мөн бусад яамдууд ч энэ үйл хэрэгт оролцож, Монголын бусад аймгуудад энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэх нь зүйтэй.

Дээрх тогтолцоог бий болгохын тулд Монголын хуульд зохих өөрчлөлтүүдийг оруулах шаардлагатай. Бид соёлын өвийн хуульд соёлын өвийн асуудлаар зөвшөөрөл авах зарчмыг тусгах шаардлагатай бөгөөд зөвшөөрөл, лиценз олгодог бусад хууль тогтоомжуудад ч гэсэн үүнийг тусгах нь зүйтэй. Соёлын өвийн зөвшөөрөлтэй холбоотой санхүүгийн асуудлын зохицуулалтыг сайтар хийх ёстой ба ингэснээр уг санд төвлөрсөн мөнгө өөр бусад зорилгод бус дан ганц соёлын өвийн хадгалалт,хамгаалалтад зарцуулагдах боломж бүрдэнэ.Мөн Монголын соёлын өвийг хамгаалах хуульд хамаарагдаж байгаа дурсгалуудад археологийн дурсгалт газруудыг багтаах, эртний эдлэл, үлэг гүрвэлийн чулуужсан ясыг хууль бусаар малтаж, худалдаалах явдалд олон улсын хэм хэмжээний дагуу шийтгэл оногдуулж байх асуудлыг оруулах хэрэгтэй. Эцэст нь Монголыг Соёлын эд зүйлсийг хууль бусаар импортлох, экспортлох, өмчлөх эрхийг шилжүүлэхийн эсрэг ЮНЕСКО-гийн Конвенци (1970) болон Хууль бусаар хил гаргасан Соёлын эд зүйлсийн тухай ЮНИДРАУТ-ын Конвенцид (1995) нэгдэн орохыг уриалж байна.

Соёлын өвийн хууль,тогтоомж хэрэгжилтийн ач холбогдлын талаар ойлголтын зөрүү байгаа тохиолдолд л хууль эрхзүйн өөрчлөлтийг хийнэ. Анхаарах ёстой хамгийн чухал зүйл нь уул уурхайн үйл ажиллагааг дэмжихийн зэрэгцээ Монгол дахь соёлын өвийг хамгаалах асуудлын зөв зохицол,балансыг олох явдал юм. Учир нь эдгээр 2 асуудлууд аль аль нь  чухал боловч яг одоогийн нөхцөлд соёлын өвийг хамгаалах хууль тогтоомжуудыг биелүүлэхээсээ илүүтэйгээр уул уурхайн үйл ажиллагааг дэмжих хандлага давамгайлж байна. Харин Өмнөговийн аймгийн иргэд,ТББ-ууд, орон нутгийн удирдлагууд, музей,соёлын төвийн удирдлагуудын хувьд уг асуудалд санаа зовниж явдагаа илэрхийлж байсан тэдийгүй одоогийн нөхцөл байдлыг өөрчилж,хадгалалт,хамгаалалтад илүү их анхаарал тавих ёстой гэж үздэгээ илэрхийлж байсан. Иймд ОТ ХХК болон ШУА-ын хувьд дээр дурьдсан хууль эрхзүйн өөрчлөлтүүдийг хийх боломжтой орон нутгийн шийдлийг олж,бусад аймгуудын хувьд жишиг бий болгох боломж бүрдэнэ.

Хууль эрхзүйн орчны өөрчлөлт,сайжруулалт хэрхэн хийгдэхээс үл хамааран соёлын өвийн чиглэлээр ажилладаг маш олон мэргэжилтнүүд Монгол улсад хэрэгтэйн дээр археологич,палеонтологич, олон нийтийн хөтөлбөрийн мэргэжилтнүүд, музейн эрхлэгчид зэрэг хүмүүсийг бүх түвшинд сургах нь нэн тэргүүнд хийгдэх шаардлагатай ажлуудын нэг юм. Мөн түүнчлэн Өмнөговь аймгийн энгийн иргэд дээр дурьдсан салбаруудын аль нэгийн талаар мэдлэгтэй байх нь уул уурхайн салбарт соёлын өвийн мэргэжилтнээр ажиллах боломж бүрдүүлнэ.

### Соёлын Өвийн Элементүүд

Биет өв: Биет өвийг археологийн, палеонтологийн болон хөшөө дурсгал гэж гурав ангилна. Эдгээрийн эхний хоёр нь Өмнөговь аймаг буюу Оюу Толгойд хадгалагдаж байна. Даланзадгад хот болон сумдад барьж буй бүтээн байгуулалт нь архитектурын гайхамшиг, түүхийн ач холбогдлын шалгуурт төдийлөн нийцэхгүй байна. Өмнөговь аймаг дахь хамгийн сэтгэл хөдлөм архитектурын шийдлүүд нь уул уурхайн орчинд одоо баригдаж буй барилгууд бөгөөд одоогоор хэдий залуу байгаа боловч хэсэг хугацааны дараа магадгүй түүхийн дурсгалт барилгууд болохыг үгүйсгэх аргагүй.

Өмнөговь аймагт 600 гаруй археологийн дурсгалууд олдсон бөгөөд эдгээрийн ихэнх нь уул уурхайн төслүүд эхлүүлэхтэй холбогдон хийгдсэн хайгуул судалгаагаар илэрсэн юм. Оюу Толгойн ашиглалтын талбайд л гэхэд 120 орчим дурсгалууд илэрсэн. Өмнөговьд олдсон археологийн олдворууд нь булш, эртний орд газрууд, хадны зураг, эд өлгийн зүйлс, хад чулуун бунхан, малчдын оторлодог болон ан ав хийдэг газрууд байна. Эдгээр дурсгалууд нь цаг хугацааны хувьд шинэ чулуун зэвсгийн үеэс эхлэн түүхийн бусад үеүүдийг хамарсан байна.

Эдгээр мэдээллүүдийг ашиглан, өөрсдийн туршлага дээрээ тулгуурлан Доктор Гүнчинсүрэн, Амартүвшин, Олсен нар археологийн дурсгалт газруудын байршлыг тодорхойлох загварыг бий болгосон. Бид одоо GIS буюу газарзүйн мэдээллийн систем ашиглан энэ загварт логик дүгнэлт хийж байна. Энэ загварыг зөвхөн тухайн дурсгалын байршилд тулгуурлан хийдэг мэдрэг байдлын загвартай харьцуулан судлах болно.

Дор дурьдсан мэдээллийн сангийн дутагдалтай байдлаас шалтгаалан эдгээр загварууд нь төдийлөн нарийвчлал сайтай болж чадахгүй гэж бид таамаглаж байна. Үүнд:

- Өмнөговь дахь археологийн дурсгалуудын маш бага хэсэг нь бүртгэгдсэн буюу судлагдсан
- Уул уурхайн ордууд ашиглалтанд орсон буюу ашиглалтанд орохоор төлөвлөгдөж байгаа Өмнөговь аймгийн зүүн хэсэгт археологийн хайгуул судалгаа сайн хийгдсэн. Мөн Даланзадгад хотын баруун хэсэгт бага хэмжээний судалгаа хийгдсэн.

Зөвхөн газрын гадарга дээр ил гарсан археологийн дурсгалуудыг судалсан.

Эдгээр дутагдлыг арилгахын тулд, уг загварыг сайжруулахад туслах зарим нэг археологийн хээрийн судалгаа хийхийг бид санал болгож байна. Ерөнхийдөө уг хээрийн судалгаа нь Өмнөговь аймгийн баруун хэсгийн байгалийн өөр өөр нөхцөлтэй хэсгүүдэд шугаман трансектын судалгаа хийх маягаар явагдана. Мөн шарил,дурсгал агуулж байх магадлалтай алювийн хурдасны хэсэг,дэнжүүд болон элсэн манхны хэсгүүдэд очиж цэгэн судалгаа хийнэ.

20-р зууны эхэн үеэс хойш палеонтологичид Өмнөговь аймагт судалгаа явуулж ирсэн. Энэ бүс нутаг нь динозаврын чулуужсан ясаараа алдартай. Чулуужсан яс нь Оюу Толгойн ашиглалтын талбайд байгаа болох нь сүүлийн үеийн олдворуудаас харагдаж байна. Учир нь дан ганц динозаврын ясанд анхаарлаа хандуулснаас бусад палеонтологийн олдворууд нь орхигдсон буюу дутуу судлагдсан байна. Судлагдаагүй орхигдсон бүрдлүүдэд бүх төрлийн хэлбэр,формацтай микро болон макро чулуужсан үлдэгдлүүд, мөн мезойкийн үеийн амьтдын бичил чулуужсан яс зэрэг орно. Дөрөвдөгчийн цэрдийн үеийн геологийн хайгуул судалгаа төдийлөн хийгдээгүй.

Өмнөговь аймаг дахь палеонтологийн олдворуудын талаарх мэдээлэл хомс байна. Гэвч бага хэмжээний хээрийн судалгаагаар уг байдлыг нөхөх аргагүй. Иймд бид тухайн газарт анхаарлаа хандуулж сайтар баримтжуулах хэрэгтэй. Ерөнхийдөө палеонтологийн судалгаатай холбоотой хууль эрхзүйн орчныг дагаж мөрдөх ажил нь археологийн судалгаатай харьцуулахад маш хол орхигдсон. Палеонтологийн дурсгалууд төлөвлөсөн судалгааны ажлын үед гэхээсээ илүүтэйгээр санамсаргүй байдлаар олдох нь их байдаг. Иймээс маш олон дурсгал олдсон хэдий ч мэдээлэгдэлгүй орхигддог. Соёлын өвийн хөтөлбөрт бид бусад улс орнуудын тэргүүн туршлага, мэргэжлийн палеонтологичдын туршлага дээр тулгуурлан судалгаа явуулах, дурсгалыг баримтжуулах, малтлага, дүн шинжилгээ хийх хэм хэмжээг тогтоохоор төлөвлөж байна.

Биет бус өв: Соёлын өвийн хөтөлбөрийн хүрээнд ном зүйн судалгаа болон анхан шатны хээрийн судалгаа явуулсан бөгөөд эндээс Өмнөговь аймгийн биет бус өвийн тэргүүлэх ач холбогдол бүхий 6 хэлбэрийг тогтоосон. Эдгээр нь тухайн орон нутгийн хүмүүсийн хувьд тэдний соёл,зан заншил хэрхэн өөрчлөгдөж буйг тодорхойлох хэмжүүр болно гэж үзсэн антропологийн сэдвүүд юм. Үүнд:

- Соёлын үнэ цэнэ ач холбогдол бүхий дурсгалт газрын нэршил болон байршил
- Өвт газрууд
- Гар урлал
- Хэл
- Аман уламжлал
- Дуу хуур,түүхүүд

Эдгээр хэлбэр тус бүр дээр мэдээлэл цуглуулсан хэдий ч СӨХ-ийг боловсруулахад шаардлагатай зарим нэг мэдээлэл,судалгаа дутагдалтай байсаар байна. Үүнийг арилгах хоёр арга замыг бид санал болгож байна. Нэгдүгээрт, биет бус өвийн байршлыг харуулсан газрын зураг хийнэ. Оюу Толгой төслийн нөлөөллийн бүсэд байгаа дөрвөн сумын дурсгалт газрууд болон гар урлалын бүтээгдэхүүний тархалтыг харуулсан суурь газрын зураг хийнэ. Хоёрдугаарт, СӨХ-ийн салшгүй хэсэг болох баримтжуулалтын ажлыг эхлүүлэх болно. Энэ хүрээнд аман уламжлал, дуу хуур, хэл, нутгийн аялгын талаарх мэдээллийг цуглуулах болно. Хээрийн судалгаа нь орон нутгийнханд төдийгүй үндэсний хэмжээнд улмаар олон улсад чухал ач холбогдол бүхий биет бус соёлын өвүүдийг тогтоох, соёлын  хувьсал өөрчлөлтөд үнэлгээ хийх, тэдгээр өвүүдийг хадгалж хамгаалах арга механизм боловсруулах зорилготой.

Олон нийтийн хөтөлбөр: Бид олон нийтийн хөтөлбөрийг музейн судалгаа ба өвийн аялал жуулчлал гэж хоёр хувааж авч үзнэ. Эдгээр нь тус бүрдээ олон нийтийн ойлголтыг дээшлүүлэх, боловсрол олгох асуудлыг багтаана.

Өмнөговь аймгийн сум болон аймгийн төвд музей болон соёлын төвүүд байдаг. Энэ нь шинэ тогтолцоо бий болгохын оронд одоогийн тогтолцоог сайжруулахад чухал ач холбогдолтой. Олон нийтийн оролцоотойгоор биет болон биет бус соёлын өвийн талаарх мэдлэг ойлголтыг өөрчлөх болно. Гэвч эдгээр байгууллагууд нь хөрөнгө санхүү, нөөц бололцоогоор дутмаг байна. Хамгийн гол нь сум, аймгийн музейнүүд нь үндэсний болон аймгийн музейн ажилчдын боловсруулсан мэдээллийг олон нийтэд хүргэх “дээрээсээ доошоо”  хандлагыг ашигладаг. Үзмэрүүд нь олон талт, туршилтын чанартай байхаасаа илүү тогтсон нэгэн хэвийн байна.

Түүх, соёл, уламжлалын асуудлыг музейд төвлөрүүлэхээс илүүтэйгээр хүмүүс өөрсдийн болон бусдын өнгөрсөн ба одоогийн түүх,соёлыг судлах,таних боломжтой төвүүдэд шижүүлэх хэрэгтэй.  Ингэхийн тулд бид олон нийтийн оролцоотойгоор биет болон биет бус соёлын өвийн талаарх мэдлэг ойлголтод өөрчлөлт хийх хэрэгтэй байна.

Уг өөрчлөлтийг хийхэд доорх зүйлс шаардлагатай. Үүнд:

- Музейн судалгаа, олон нийтийн боловсрол, удирдлагаар мэргэшсэн мэргэжилтэн
- Үзмэрүүдийн баяжуулалт (биет болон биет бус)
- Галлерей, үзэсгэлэн, үзмэрүүд
- Ном товхимол, лекцүүд
- Наадам, соёлын арга хэмжээ

Монголд музейн ажилтнуудыг сургах мэргэжшүүлэх шаардлагатай байна. Өөрийн улсдаа сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэхийн зэрэгцээ, бусад хөгжилтэй улс орны музейтэй хамтран ажиллаж, сүүлийн үеийн технологи, арга хандлагыг нэвтрүүлэх нь зүйтэй. Эцэст нь Өмнөговь аймгийн иргэд өөрсдийн соёлыг хамгийн сайн мэдэх тул аливаа үзэсгэлэн болон соёлын арга хэмжээнд тэдний уг мэдлэгийг тусгах нь хамгийн чухал гэдгийг музейн холбогдох хүмүүс ойлгох ёстой. Мөн олон нийтийн санал бодлыг тусгах гэдэгт сургуулийн сургалтын хөтөлбөрт оруулах, лекц, ном товхимолуудыг түгээх болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр нэвтрүүлэх зэрэг багтана.

Хэдийгээр бид Өмнөговь аймгийн төвийн болон сумдын музей, соёлын төвүүдийн бүтцийн дүн шинжилгээнд сэтгэл ханамжтай байгаа боловч СӨХ-ийг боловсруулахад шаардлагатай зарим ойлголцлын дутагдлууд байсаар байна. Ялангуяа доорх мэдээллүүдийг тодруулахын тулд бид Өмнөговь аймгийн музей болон соёлын төвүүдийг судлах шаардлагатай байна. Үүнд:

- Ажилчдын туршлага, ур чадварыг үнэлэх
- Үзмэрүүдийг судлах
- Олон нийтийн аливаа нэгэн хөтөлбөр хэрэгжиж буй тохиолдолд энэ талаар судлах
- Цаашид хэрэгжүүлэх олон нийтийн хөтөлбөрийн төрөл,чиглэлийг тодорхойлох
- Өмнөговь аймгийн музей болон соёлын төв хоорондын одоогийн уялдаа холбоог гаргах

Өвийн аялал жуулчлал нь Өмнөговь аймагт дөнгөж хөгжиж эхэлж байна. Зам, дэд бүтэц, үзмэрүүд дутагдалтай байгаа нь аялал жуулчлалыг хязгаарлаж байна. Уг бүсэд аялал жуулчлал хөгжих боломжтой хэдий ч уул уурхайн хөгжлийг даган олон хүмүүс ирж суурьшиж байна. Уул уурхайн хөгжилтэй уялдаатайгаар зам, онгоцны буудал, зочид буудал, бусад дэд бүтэц сайжрах болно. Эцэс нь Монголчуудын,тэр дундаа Өмнөговь аймгийн иргэдийн амьжиргааны түвшин дээшлэх болно(ялангуяа уул уурхайн үйл ажиллагаа явагдаж буй хэсэгтээ). Иймд уг бүс нутаг дахь аялал жуулчлалыг хөгжүүлэхийн зэрэгцээ говийн байгалийг хамгаалж ажиллах нь нэн тэргүүний ажлуудын нэг юм.

Өвийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд давуу болон дутагдалтай талууд, боломж, аюул заналын аль аль нь бий. Давуу талуудад цөл, үлэг гүрвэлийн чулуужсан яс, тэмээ, түүхийн болон археологийн дурсгалууд орох бол дутагдалтай талууд нь хатуу ширүүн уур амьсгал, аялал жуулчлалын богино улирал, дэд бүтэц муу, дурсгалуудын хооронд хол зайтай зэрэг болно. Нэгэнт аялал жуулчлалын салбар боловсронгуй болоогүй учраас, энд маш олон боломжууд байна. Аялал жуулчлалыг даган бий болж буй боломжууд нь иргэдийн амьдралын хэв маягт сөргөөр нөлөөлөх учиргүй.

Зорьсон төлөвлөлт,арга замын дагуу аялал жуулчлалыг хөгжүүлэхийн тулд ойрын хугацаанд, нутгийн иргэд, тур операторууд, зочид буудал, жуулчны бааз, өвийн мэргэжилтнүүд болон засгийн газрын төлөөлөгчдийн хоорондын түншлэлийг байгуулах шаардлагатай. Нутгийн иргэдтэй сайтар харилцаатай ажилладаг төслүүдийг дэмжих хэрэгтэй хэдий ч уг төслүүд нь тухайн бүсийг хамгаалах олон улсын жишигт нийцэж ажиллах ёстой. Цаашид,дан ганц Өмнөговь аймаг төдийгүй Монгол улс бүхэлдээ жуулчлалыг хөгжүүлэх уг цогц хандлагыг ашиглах нь зүйтэй. Ерөнхийдөө, Монгол улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө хэрэгтэй байна.

Өвийн аялал жуулчлал нь Өмнөговь аймгийн эдийн засгийн гол хүчин зүйл юм. Соёлын өвийн хөтөлбөр нь энэ салбарыг хөгжүүлэхэд туслах болно. Ингэхийн тулд бид дараах арга хэмжээг авах шаардлагатай байна.

- Аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжит дурсгалт газруудыг тогтоох
- Аялал жуулчлалын боломжийг үнэлэх загвар бий болгох
- Хүлээн зөвшөөрч болох өөрчлөлтийн хязгаарыг тогтоох

СӨХ-ийг боловсруулахад шаардлагатай хийгдэх судалгаа,тэдгээрийн үр дүнгийн талаар та бүхэнд танилцуулахдаа бид үргэлж баяртай байх болно.

Та бүхэнд асуулт,санал байвал бидэнтэй холбогдоорой.




**Хавсралт зураг 1: Шинээр санал болгож буй бүтэц**

# 11. ХАВСРАЛТ 2: НОМ ЗҮЙН ЖАГСААЛТ

**Археологи**

## I. ЕРӨНХИЙ БҮТЭЭЛҮҮД


1) **Баяр Д**. *Монгол оронд археологийн судлал үүсэн бүрэлдэхэд Орос Зөвлөлтийн эрдэмтдийн оруулсан хувь нэмэр* // SH. t 23. f.11. - УБ., 1984. – тал 83-91.

Орос Зөвлөлтийн эрдэмтэд монгол орны археологийн дурсгалыг хэдий үеэс судалсан хийгээд монгол оронд археологийн судлал үүсч хөгжихөд зөвлөлтийн эрдэмтдийн оруулсан хувь нэмрийн талаар өгүүлжээ.

2) **Дорж Д.***Монгол-Зөвлөлтийн археологийн хамтарсан ажиллагаа* // ШУА. [1] 2. - УБ., 1971. – тал 20-21.

1969 онд Монголд явуулсан археологийн судалгааны ажлын талаар өгүүлжээ.

3) **Дорж Д**. *БНМАУ-ын нэн эртний түүхийн зарим асуудал* // ШУАМ. [1] 4. -УБ., 1975. – тал 16-23.

Монгол улсын нутаг дэвсгэр дээр хүн анх нутаглах болсон үеийг Дундговь аймгийн Гурвансайхан сумын нутаг Ярх уулын чулуун зэвсгийн дурсгалтай холбон тайлбарласан байна.

4) **Дорж Д**. *МАХН-ын XVIII их хурал, монголын археологи* // SA. t X. f.1. -УБ., 1982. – тал 3-5.

Монголын археологийн 1981-1985 оны судалгааны товч тойм.

5) **Дорж Д**. *Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан экспедици, үр дүн зорилт* // ШУАМ. [1] 3. - УБ., 1984. – тал 89-96.

МЗТСХЭ-ийн хийж гүйцэтгэсэн ажлын үр дүн, ач холбогдол, цаашдын зорилтын талаар өгүүлжээ.

6) **Дорж Д**. *Төв, Умард, Зүүн умард Азид хүн нутаглах болсон үе шат* // ОУМЭ-ийн V их хурал. 3-р боть. - УБ., 1992. – тал 3-6.

Төв, Умард Азид хүн нутаглах болсон үе шатыг чулуун зэвсгийн дурсгалын тархалттай холбон тайлбарлажээ.

7) **Дорж Д**. *Палеоэкологические условия эпохи антропогенеза Монголии* // SA. t XIII. f. 1. - УБ.,1992.

Монголд хүн үүсэх үеийн эртний байгал газар зүйн нөхцөл байдлын талаар өгүүлжээ.

8) **Доржсүрэн Ц**. *Манай орон эрт цагт* // ШУТ. [1]3. - УБ., 1958. – тал 33-38.

Энэ өгүүлэлд Монголын археологийн дурсгалуудыг он цагийн өргөн хүрээлэлд хамруулан дэлгэрэнгүй авч үзсэн байна.

9) **Доржсүрэн Ц.***Археологийн судалгаа (эрдэм шинжилгээний бүтээлийн эмхтгэл)*. - УБ., 2004.

10) **Деревянко А.П**. *Монгол-Зөвлөлтийн түүх соёлын хамтарсан экспедици, хэтийн төлөв* // ШУА. ¹ 6. - УБ., 1987. – тал 31-33.

МЗТСХЭ-ийн хийж гүйцэтгэсэн ажлын тухай өгүүлжээ.

11) **Лхагвасүрэн Х**. *Металлурги боловсруулалтын асуудалд* // SM. t XIV. f.15. - УБ.,1989. – тал 110-114.

12) **Майдар Д**. *К изучению истории и культуры кочевых народов Монголии* // SM. t. V. f. 3. - УБ., 1978. – тал 25-30.

Монголын нүүдэлчдийн түүхийг судлах асуудлыг хөндөн тавьсан байна.

13) **Наваан Д**. *Эртний хүмүүсийн ул мөр*. - УБ., 1960.

14) **Наваан Д**. *Гурван голын шинжилгээний ангийн шинэ олдвор* // ОҮМУ. ¹11. УБ., 1966. – тал 22.

Дөрвөлжин булш, түрэг (VI-VIII зуун) болон монголын үеийн булшнаас олдсон шинэ олдворуудыг тодорхойлон нийтэлжээ.

15) **Наваан Д**. *Мянган дурсгалын эх орон*. - УБ., 1970.

Монголын археологийн дурсгалуудын тухай шинжлэх ухааны хялбаршуулсан товхимол.

16) **Наваан Д**. *Эртний судлал* // ШУА. ¹1. - УБ., 1971. – тал 25-27.

Монголын археологийн товч тойм.

17) **Наваан Д**. *Эртний монголын түүхийн дурсгалууд*. - УБ., 1980.

Монголын эртний түүхийн дурсгалуудын тухай шинжлэх ухааны хялбаршуулсан ном.

18) **Нацагдорж Н**. *Монголчуудын зэвсэг үйлдвэрлэх уламжлал* // ШУАМ. ¹3-4. УБ., 1994. – тал 86-92.

Археологийн судалгаагаар олдсон бүхий л үеийн зэвсгийн зүйлсийн талаар товч дурдаад төмөрлөг боловсруулдаг болсноор цэргийн зэвсэг үйлдвэрлэх шатанд ахиц гарчээ гэж үзсэн байна.

19) **Новгородова Э.А.** *Древняя Монголия (Семантика и новая хронология памятников)* // ОУМЭ-ийн 5-р их хурал. 3-р боть. - УБ., 1992. – тал 209-213.

Монголын археологийн дурсгалуудын он цагийн хамаарлын асуудлыг хөндөн авч үзжээ.

20) **Окладников А.П.** *Монголын ард түмний эртний түүхийн замналаас* // ШУА. ¹ 6.- УБ., 1981. – тал 9-14.

МЗТСХЭ-ийн Монголын чулуун зэвсэг, хадны зургийн дурсгалуудыг судалсан судалгааны ажлын талаар өгүүлжээ.

21) **Окладников А.П., Сэр-Оджав Н.** *БНМАУ-д явуулсан археологийн шинжилгээний тухай. 1960 онд явуулсан эртний судлалын шинжилгээний ажлын тухай* // ШУАМ. ¹2. - УБ., 1961. – тал 61-67.

Монгол-Зөвлөлтийн хамтарсан археологийн экспедицийн хийж гүйцэтгэсэн хээрийн шинжилгээний ажлын тухай өгүүлжээ.

22) **Пэрлээ Х.** *Монголын археологийн тухай товчхон* // ОҮМУ. ¹ 8. -УБ.,1963. – тал 21-22.

23) **Пэрлээ Х**. *Монголын суурьшлын түүхийн зарим асуудлыг археологийн дурсгалаар судалсан нь* // ОУМЭ-ийн II их хурал 2-р боть. - УБ., 1973. –тал 36-39.

24) **Пэрлээ Х.** Монголын суурьшлын түүхийн зарим асуудлыг археологийн дурсгалаар судалсан нь // ОУМЭ-ийн II их хурал 2-р боть. - УБ., 1973. –тал 36-39.

Монгол улсын нутагт орших зарим хот балгадын судалгааны ажлын талаар өгүүлжээ.

25) **Пэрлээ Х**. *Монголын гурван тулгуурт ширмэн тогоо* // ШУАМ. ¹ 1. -УБ., 1975. – тал 27-33.

Археологийн хайгуул судалгааны явцад монгол орны хангай, говиос олдсон ширмэн эдлэл түүн дотроос ширмэн тогооны талаар өгүүлсэн байна.

26) **Пэрлээ Х**. *Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь*. - УБ., 1976.

Рашаан хаданд дүрсэлсэн эртний тамгадыг нийтэлж, тэдгээрийг монголчуудын болоод бусад олон овог ястны овгийн тамга, малын тамга тэмддэгтэй харьцуулан дүйлгэж нэгтгэн дүгнэсэн нэгэн сэдэвт суурь бүтээл.

27) **Пэрлээ Х**. *Монгол аймгуудын нэн эртний дээдсийг нүүдэлчдийн дундаас хайх нь* // ШУА. ¹ 1. - УБ., 1977. – тал 64-67.

Археологийн олдвор хэрэглэгдэхүүн, баримт, сурвалж бичгийн мэдээ баримт, овгийн нэр, тамга, сүсэг бишрэлээр нь монголчуудын эртний өвөг дээдсийг судлан олж тогтоож болох тухай өгүүлжээ.

28) **Пэрлээ Х**. *К вопросу родовых тамг и знаков монголов* // ОУМЭ-ийн III их хурал. 1-р боть. - УБ., 1979.

Овгийн тамга тэмдгийн талаар өгүүлсэн байна.

29) **Пэрлээ Х**. *Монголын нүүдэлчдийн металлурги, металл боловсруулалтын асуудалд* // SA. t. X. f.4. - УБ., 1982. – тал 48-73.

Монголын ард түмний металл боловсруулах арга ажиллагааны талаар археологийн хэрэглэгдэхүүн, сурвалж бичгийн мэдээг үндэслэн өгүүлжээ.

30) **Сэр-Оджав Н**. *БНМАУ-д явуулсан археологийн ажлын тухай* // ШУТ. [1]2. - УБ., 1958. – тал 50-59.

Монголын археологийн дурсгалуудын тоймыг үечлэн авч үзжээ.

31) **Сэр-Оджав Н.** 1960 онд явуулсан эртний судлалын шинжилгээний ажлын тухай // ОҮМУ. [1]1. - УБ., 1961. – тал 20-21.

1960онд явуулсан археологийн хээрийн шинжилгээний ажлын тухай өгүүлжээ.

32) **Сэр-Оджав Н**. *40 жилд БНМАУ-д хийсэн эртний судлалын шинжилгээ* // SA. t. II. f. 1. - УБ., 1963. – тал  3-18.

Монголын археологийн судалгааны товч тойм.

33) **Сэр-Оджав Н**. *Монголын археологичид 1967 онд* // ШУАМ. [1]2. УБ., 1968. – тал 54-65.

Монголын археологчдын 1967 онд шинээр олдсон дурсгалуудын талаар товч өгүүлжээ.

34) **Сэр-Оджав Н**. *Археологические памятники Монголии* // СМ. [1]7. - УБ., 1967. – тал 27-28.

1960 он хүртэлх Монголын археологийн судалгааны тухай дэлгэрэнгүй өгүүлжээ.

35) **Сэр-Оджав Н**. *Археологическая наука в МНР* // ОУМЭ-ний II их хурал. 2-р боть. - УБ., 1973. – тал 139-192.

Монголын археологийн судалгааны ажлын үр дүнгийн талаар өгүүлжээ.

36) **Сэр-Оджав Н, Окладников А.П.** *БНМАУ-д явуулсан археологийн шинжилгээний тухай* // ШУАМ. [1] 2. - УБ., 1961. – тал 61-67.

Монголын археологийн судалгааны товч тойм.

37) **Сэр-Оджав Н**. *Монголын эртний түүх.* - УБ., 1977.

Монголын эртний түүхийн тойм.

38) **Сэр-Оджав Н**. *Некоторые проблемы древней истории Монголии* // ОУМЭ-ийн IV их хурал. 1-р боть. - УБ., 1985. – тал  301-304.

Археологийн судалгааны тухайн үеийн ололт амжилт, тулгамдсан асуудлын тухай өгүүлсэн байна.

39) **Сэр-Оджав Н**. *Монголын эртний түүхийн зарим чухал асуудалд* // ШУАМ. [1]1. – УБ., 1986. – тал 62-68.

Түүхийн хүрээлэнгээс эрхлэн гаргах гэж байсан Монголын түүхийн таван боть зохиолтой холбогдуулан монголын эртний түүхийн зарим чухал тулгамдсан асуудлыг хөндөн тавьсан байна.

40) **Сэр-Оджав Н**. *Монголын эртний түүхийн нэгэн агшинд* // ШУА. [1]4. УБ., 1988. – тал 37-42.

Монголын чулуун зэвсэг, хүрэл зэвсгийн үеүүдийн товч тойм.

41) **Сэр-Оджав Н**. *Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл*. УБ., 2003.

42) **Цэвээндорж Д**. *Нэгэн үед хамаарагдмааргүй археологийн дурсгал* // ШУА. 1977, [1] 6. – тал 70-75.

Дөрвөлжин хашлага дугуй хүрээтэй зосон зураг, буган чулуун хөшөө, дөрвөлжин булшны нэгэн үед холбогдох эсэх талаарх асуудлыг хөндөн тавьжээ.

43) **Цэвээндорж Д**. *Библиографии по археологии МНР* // SA. t VII. f.4. - УБ., 1977. – тал 68-95.

Монголын археологийн 1942-1975 оны ном зүй.

44) **Цэвээндорж Д**. *К вопросу происхождения звериного стиля Центральной Азии* // ОУМЭ-ийн III их хурал. – УБ ., 1979. – тал 274-277.

Археологийн дурсгалууд дахь амьтныг загварчлан урлах арга барилын тухай өгүүлжээ.

45) **Цэвээндорж Д**. *Монголын мал аж ахуйн гарал үүслийн тухай* // ШУА. - 1988. [1]5. – тал 44-48.

Хадны зургийн хэрэглэгдэхүүн дээр тулгуурлан мал аж ахуйн гарал үүслийн он цагийг тогтоож болох талаар өгүүлжээ.

46) **Цэвээндорж Д**. *Монгол оронд төмөрлөг боловсруулж эхэлсэн он цагийн тухай асуудалд* // ДДС. - 1989. [1]1. – тал 119-123.

Баянхонгор аймгийн Баянлиг сумын Зоог, Зуухаас олдсон хүдэр хайлуулж байсан зуухын талаар нийтэлжээ.

47) **Цэвээндорж Д**. *Овгийн зарим тамганы гарал үүслийн тухайд* // ШУАМ. -1989. [1] 2. – тал 33-37.

Судалгааны ажлын үр дүнгээс үзэхэд анчид малчдын амьдралд амьтны мөр их үүрэгтэй байсныг дурдаад зарим амьтдын мөрний дүрсийг тамга болгон овгийн байгууллын хөгжлийн явцад хэрэглэж байсан гэжээ.

48) **Цэвээндорж Д**. *Монголын археологийн судалгаа* // SA. t XIV. f.2. - УБ., 1994. – тал 117-148.

Монголын археологийн судалгааны тойм.

49) **Цэвээндорж Д.** *Horse in Mongoian history* // SA. t XVI. f.6. - УБ., 1996. –тал 82-88.

50) **Цэвээндорж Д.** *Монголын эртний урлагийн түүх.* - УБ., 1999. - 326 хуудас, зурагтай.

Урлаг анх үүссэн дээд палеолитийн үеэс Төв Азийн нүүдэлчдийн дунд анхны төр улс байгуулагдсан МЭӨ III зууныг хүртэлх үеийн Монголын эртний урлагийн түүхийг хадны зураг, буган хөшөө, чимэглэх урлагийн дурсгалд тулгуурлан судалсан судалгааны нэгэн сэдэвт зохиол.

51) **Цэвээндорж Д.** *Монголын археологийн судалгаа-I(Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл) 1973-1982*. - УБ.,2002

52) **Цэвээндорж Д.** *Монголын археологийн судалгаа-II (Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл) 1983-1992*. - УБ.,2003.

53) **Цэвээндорж Д.** *Монголын археологийн судалгаа-III(Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл) 1993-1997*. - УБ.,2004

54) **Цэвээндорж Д.** *Монголын археологийн судалгаа-IY (Эрдэм шинжилгээний өгүүлэл, илтгэлийн эмхэтгэл) 1998-2002*. - УБ.,2004

55) **Цэвээндорж Д., Гарамжав Т.** *Монгол оронд эрт цагт зэс олборлож байсан асуудалд*//SA. t XIX. f.3. - УБ., 1999. – тал 17-25.

Монгол улсын нутгаас олддог эртний зэсийн ухмалууд, зэсийн хүдэр хайлуулж байсан зуух, тэдгээрийн ойр орчмоос олддог чулуун зэвсгийн талаар өгүүлжээ.

56) **Цэвээндорж Д., Хосбаяр Т**. *Дулааны говийг археологи, геологийн талаар дахин судалсан нь* // SA. t XI. f.3. - УБ., 1982. – тал 22-48.

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын нутаг Дулааны говийн археологийн дурсгалуудыг судалсан хийгээд уг нутгийг геологийн талаас нь судлан байгалийн аятай таатай нөхцөлтэй учир мезолитын сүүл үеэс эхлэн олон зууны турш хүмүүс амьдарч байсныг баталсан байна.

57) **Эндрюс Р.Ч.** Эртний хүний мөрөөр (Монголд хийсэн аялал). Улаанбаатар, 2010

58) **Эрдэнэбаатар Д., Амартүвшин Ч.***Монголчуудын ашигт малтмал эрхлэлтийн түүх.* - УБ.,1999.

Монголчуудын ашигт малтмал эрхлэлтийн түүхийг археологийн дурсгалууд дээр тулгуурлан үечлэн авч үзжээ.

59) **Эрдэнэбаатар Д. Мөнхсайхан Г**. *Эртний металлийн бүтцийн харьцуулсан судалгаа* // SA. t XIX. f.6. - УБ., 1999. – тал 53-63.

Сүүлийн жилүүдэд Монгол нутгаас олдсон хүрэл эдлэлийн бүтцэд хийсэн физик химийн шинжилгээнд тулгуурлан бусад хөрш зэргэлдээх орнуудаас олдсон хүрэл эдлэлийн бүтэц найрлагтай харьцуулан судалсан судалгааныхаа талаар өгүүлжээ.

60) **Andrews R.Ch.** Digging for the roots of our Family. //Asia. 1921. vol. 21. № 5

61) **Andrews R.Ch.** Politics and Paleontology //Asia. 1922. vol. 22. № 5

62) **Andrews R.Ch.** Setting out for the buried treasures of Asia. //Asia. 1923 vol. 23, № 4

63) **Andrews R.Ch.** Winter cooled order for fossil. //Asia. 1923. №11

64) **Andrews R.Ch.** Where the Winter cooled order for fossil. //Asia. 1923. № 11

65) **Andrews R.Ch.** Where the dinosaur Hid ist eggs. //Asia. 1924. vol. 24. № 6

66) **Andrews R.Ch.** On the trail of ancient man. N. Y.; L., 1926

67) **Andrews R.Ch.** The new conquest of Central Asia. //Natural History of Central Asia. 1932. vol. 1

68) **Andrews R.Ch.** The Meet your ancestor. A biography of primitive man. N.Y., 1932

69) **Andrews R.Ch, Matthew W.D.** Gobi-a desert Norder-House. //Asia. 1922. vol.22. № 12

*70)* **Fairservis W.A.** Archaeology of the Southern Gobi of Mongolia. Durham, 1993

71) **Osborn H.F.** Proving Asia the mother of continents. //Asia. 1922. vol. 22, № 9

72) **Osborn H.F.** Why Central Asia. //Natural History. 1926. vol. 26. № 3

73) Third asiasts expedition in Mongolia. //Asia. 1922. № 11

## II. ЧУЛУУН ЗЭВСГИЙН ҮЕ

74) **Васильевский Р.С**. *Культура леваллуа-мустьерского времени Монголии и их среднеазиатские аналогии* // ОУМЭ-ийн IV их хурал. 3-р боть. - УБ., 1985. – тал 420-422.

Монгол нутгаас олдсон дунд палеолитын үеийн дурсгалуудын талаар өгүүлжээ.

75) **Васильевский Р.С., Ларичев В.Е**. *Местонахождение Баян-Нур и его место верхнепалеолитических культур Восточной и Северной Азии. //* ОУМЭ-ийн V их хурал. – УБ., 1992. – тал 107-112.

Баяннуураас олдсон чулуун зэвсгийн дурсгалуудыг нийтлэн энэ суурины Зүүн болон Хойд Азийн дээд палеолитын үеийн дурсгалуудын дотор эзлэх байр суурьны талаар өгүүлсэн байна.

76) **Гүнчинсүрэн Б**. *Дөрөвдөгч галавын дээд үеийн Монгол орны эртний газар зүй* // SA. t. (I) XXI. УБ., 2003

77) **Деревянко А.П., Дорж Д., Васильевский Р.С., Ларичев В.Е., Петрин В.Т., Девяткин Е.В., Малаева Е.М.** Палеолит и неолит Монгольского Алтая. Новосибирск, 1990

78) **Деревянко А.П., Олсен Д., Цэвендорж Д., Петрин В.Т, Зенин А.Н., Кривошапкин А.И., Ривс Р.У., Девяткин Е.В, Мыльников В.П**. Археологические исследования Российско-Монгольско-Американской экспедиции в Монголии в 1995 г. Новосибирск, 1996;

79) **Деревянко А.П., Олсен Д., Цэвэндорж Д., Петрин В.Т, Зенин А.Н., Кривошапкин А.И., Ривс Р.У., Николаев С.В., Мыльников В.П**, **Гунчинсурэн Б., Цэрэндагва Я.** Археологические исследования Российско-Монгольско-Американской экспедиции в Монголии в 1996 г. Новосибирск, 1998;

80) **Деревянко А.П., Петрин В.Т., Цэвээндорж Д., Васильевский Р.С., Ларичев В.Е., Девяткин Е.В., Зенин А.Н., Гладышев С.А.** Палеолит и неолит Северного побережья Долины Озер. Новосибирск, 2000

81) **Деревянко А.П., Кривошапкин А.И., Петрин В.Т, Ларичев В.Е.** Палеолит хребта Арц-Богдо. – Новосибирск, 2000

82) **Деревянко А.П., Зенин А.Н., Олсен Д., Петрин В.Т., Цэвэндорж Д.** Палеолитические комплексы Кремневой долины (Гобийский Алтай). Новосибирск, 2002

83) **Деревянко А.П., Олсен Ж., Цэвээндорж Д., Петрин В.Т.** *Периодизация и хронология палеолита в Монголии* // SA. t XVIII. f.2. - УБ., 1998. – тал 8-18.

Монгол орны нутгаас олдсон палеолитын дурсгалуудыг үечлэн, он цагийн нарийн хамаарлыг авч үзсэн байна.

84) **Дорж Д.** *БНМАУ-ын нэн эртний түүхийн зарим асуудал* // ШУАМ. 1975. [1]4. – тал 16-23.

Зохиогчийн тодорхойлсноор Монгол нутагт хүн анх нутаглаж ирсэн тухай асуудлыг шийдвэрлэхэд Дундговь аймгийн Ярх уулаас олдсон доод палеолитын үеийн дархны газар чухал ач холбогдолтой болсон байна. Эндээс олдсон хөдөлмөрийн багаж зэвсэг болох гилбэр зэвсгүүд нь Монголийн түүхийн он цагийг 300 мянган жил болгосон төдийгүй Монгол орны чулуун зэвсгийн үеийн соёл багаж зэвсгийн хэв загвар нь бусад палеолитын үеийн соёл иргэншлээс хоцрооогүй байсныг гэрчилж байна хэмээн үзжээ.

85) **Дорж Д**. *Нижный палеолит Монголии и его место в древнем каменном веке Центральной Азии* // ОУМЭ-ийн III их хурал. - УБ., 1976.

Монголын доод чулуун зэвсгийн Төв Азийн чулуун зэвсгийн үеийн дурсгалуудын дотор эзлэх байр суурийг авч үзжээ.

86) **Дорж Д**. *Монголын доод палеолитын тухай асуудалд* // ШУАМ. [1]3. - 1977.

Монголын доод палеолитын түүхэн хөгжлийн асуудлыг тухайн жилүүдэд шинээр олдсон суурингуудын олдвор хэрэглэгдэхүүнд тулгуурлан авч үзжээ.

87) **Дорж Д.***Мезолит Монголии и проблема этнической общенности Центральной и Северной Азии.* // ОУМЭ-ийн IV их хурал. - УБ., 1985.

Монголын мезолитын үеийн асуудлыг хөндөн тавьжээ.

88) **Дорж Д**. *Из истории исследования палеолита Монголии.* // SH. t. 24. f.8. - УБ., 1990. – тал 65-87.

Монголын палеолитын судалгааны тойм.

89) **Дорж Д., Цэвээндорж Д**. *Монголын палеолит.* – УБ ., 1978.

Археологийн судалгаа шинжилгээ, хайгуулын ажлын хэрэглэгдэхүүн дээр тулгуурлан бичсэн нэгэн сэдэвт зохиол. Монголын палеолитын үеийн соёлын үе шаттай хөгжилтийг Ярх уул, Оцон мааньт, Цахиурт, Орог нуур, Шивэр уул, Буянт Ухаа, Сонгино, Харганатын ам, Арц Богд, Мойлтын ам зэрэг газруудаас олдсон палеолитын үеийн олдворуудад түшиглэн харуулжээ.

90) **Доржсүрэн Ц.** *БНМАУ-ын нутаг дахь чулуун зэвсэг судлалын байдал.* – УБ., 1957.

Энэхүү товхимолд чулуун зэвсгийн үеийн дурсгалыг палеолит, мезолит, неолит гэсэн 3 ангилалд хамруулан авч үзжээ.

91) **Доржсүрэн Ц.***Улсын Төв Музейд байгаа чулуун зэвсгийн зүйлс.* - УБ., 1959.

92) **Окладников А.П***Первобытная Монголия* // SA. t.III. f. 8-10. - УБ., 1964. – тал 3-23.

Монгол нутгаас олдсон доод болон дунд палеолит, неолитын үеийн дурсгалуудын талаар өгүүлжээ. Монголын чулуун зэвсгийн үеийн нэгэн онцлог нь хөгжлийн нэг шатнаас нөгөө шатанд зугуухан дэвшин орсон явдал гэсэн байна.

93) **Окладников А.П.**_Новые данные по древней истории Монголии_ // ОУМЭ-ний II их хурал. I боть. - УБ. 1973. – тал 347-353.

Монголын археологийн судалгааны гол гол үйл явдлыг товч өгүүлсэн байна.

94) **Окладников А.П., Дорж Д**. _Памятники каменного века на юге МНР_ // SA. t. VII. f.1. - УБ., 1977. – тал 3-13.

Энэ өгүүлэлд 1971-1972 онд Дундговь, Өмнөговь аймгийн нутгаас олдсон чулуун зэвсгийн үед холбогдох хэд хэдэн бууц суурингуудын он цагийг тогтоожээ.

95) **Олсен Ж., Ривс Р., Цэвээндорж Д. Деревянко А.П.**_1995 онд Монголд хийсэн палеолитын судалгааны ажлын тайлан (англи хэлээр)_ // SA. t 16. f.2. - УБ., 1996. – тал 11-14

1995 онд Монгол-Орос-Америкийн хамтарсан чулуун зэвсгийн судалгааны ангийн хийж гүйцэтгэсэн ажлын талаар өгүүлжээ.

96) **Сэр-Оджав Н**. _К вопросу периодизаций палеолита Монголии._ – УБ 1963.

Монгол-Зөвлөлтийн археологчдийн олж илрүүлсэн олдвор хэрэглэгдэхүүн дээр тулгуурлан зохиогч Монголын палеолитын үеийн дурсгалуудын нэгдсэн үечлэлийг гаргасан байна.

97) **Сэр-Оджав Н.** _Монгол орны неолитын үеийн тухай_ // ШУХ. ЭШ. Бүтээл. ¹1. - УБ. 1956. – тал 3-6.

Монголын неолитийн үеийн судалгааны товч тойм.

98) **Сэр-Оджав Н.** _Монголын чулуун сүхийн тухай_ // ШУАМ. 1962. ¹2. –тал 71-73.

Хийсэн арга барил, хэв шинжээр нь чулуун сүхийг зохиогч хагалах арга барилаар болон холтчих маягаар хийсэн гэж 2 ангилан авч үзжээ.

99) **Сэр-Оджав Н.**_1960 онд явуулсан эртний судлалын шинжилгээний ажлын тухай_ // ОҮМУ. 1961. ¹1. – тал 20-21.

Өмнөговь аймгийн Оцон маань, Эрдэнэзуугийн орчмоос олдсон палеолитын, Баянзаг боллон Туул голын хөндийн неолитын үеийн болон Туул голын сав дагуух Их Алаг, Дөрвөлжин, Их тэнгэрийн амны хадны зургийн дурсгалыг тоймлон нийтлэжээ.

100) **Цэрэндагва Я.** _Дунд палеолитоос дээд палеолитод шилжсэн шилжилтийн асуудалд_ // SA. t XX. f.1. - УБ., 2000. – тал 4-8.

Дунд палеолитоос дээд палеолитод шилжсэн шилжилтийн асуудлыг авч үзжээ.

101) **Цэрэндагва Я.** *Монголын палеолитын судалгаанд соёлт давхарга бүхий дурсгалуудын гүйцэтгэх үүрэг* // Хар сүлд. ¹1. - УБ., 2002. – тал 45-56.

Монголын палеолитын судалгаанд соёлт давхарга бүхий дурсгалуудын гүйцэтгэх үүргийн талаар авч үзжээ.

102) **Цэрэндагва Я.** *Монголын палеолитын томоохон дурсгалууд тэдгээрийн судалгааны өвөрмөц онцлогийн тухай* //Монгол-Солонгосын эрдэм шинжилгээний II симпозиумын илтгэлийн эмхтгэл. 2004. – тал 187-210.

Монгол нутгаас олдсон палеолитын дурсгалуудын өвөрмөц онцлогийн асуудлыг хэд хэдэн томоохон дурсгалын жишээн дээр тайлбарласан байна.

103) **А.П.Деревянко, А.Н.Зенин, Д.Олсен, В.Т.Петрин, Д.Цэвээндорж.** Палеолитические комплексы Керемневой Долины (Годийский Алтая). // Каменный век Монголии. Новосибирск, 2002

## III. ХҮРЭЛ БА ТӨМӨР ЗЭВСГИЙН ТҮРҮҮ ҮЕ

104) **Амартүвшин Ч**. *Эгийн гол дахь дөрвөлжин булшны судалгааны зарим асуудал* // Монгол-Солонгосын эрдэм шинжилгээний анхдугаар симпозиумын илтгэлийн эмхтгэл. - УБ., 2003. – тал 83-100.

105) **Батсайхан З.** *Монголын хүрлийн үеийн дурсгалуудын он цаг ба угсаатны үйл явц* // SH. t XXIX. f.9. - УБ., 1996. – тал 43-53.

106) **Батчулуун С**. *Хүрлийн үеийн монголчуудын зураг дүрслэлийн хийсвэрлэл* // ШУАМ. ¹ 3-4. - УБ.,1994. – тал 93-100.

Буган чулуун хөшөөн дээр тулгуурлан хүрлийн үеийн хүмүүсийн зураг дүрслэлийн хийсвэрлэлийг авч үзэн, тэр үеийн хүмүүсийн сэтгэхүй, хийсвэрлэлийг "тэнгэр шүтэхтэй" холбон тайлбарлажээ.

107) **Волков В.В.** *Бронзовый и ранный железный век северной Монголии.* – УБ., 1969. - 148 хуудас, зурагтай.

Хүрэл болон төмөр зэвсгийн түрүү үеийн олдвор хэрэглэгдэхүүний ангилал, түүхэн тойм зэргийг өгүүлсэн нэгэн сэдэвт зохиол.

108) **Волков В.В.** *Из историй изучения памятников бронзового века Монголий* // SA. t.III. f. 9. - УБ., 1969. – тал 25-93.

Монголын хүрэл зэвсгийн үеийн түүх соёлын тойм. Зохиогч Монголын түрүү үеийн болон хожуу хүрэл зэвсгийн үеийн дурсгалуудыг ангилан ялгаж, Монголын карасук хэлбэрийн соёл нь дөрвөлжин булшны соёлоор солигдсон хэмээн үзсэн байна.

109) **Волков В.В.** *Өмнөговиос олдсон хүрэл хутга* // ШУТ. 1959. ¹1. – тал 55-57.

Аргалийн толгойн дүрс бүхий бариултай хүрэл хутгийг тодорхойлон бичиж түүнийг МЭӨ XIII-X зууны үед хамруулсан байна.

110) **Волков В.В.** *Основные проблемы изучения бронзового и раннего железного века МНР* // Олон улсын монголч эрдэмтэний II их хурал. I боть. - УБ. 1973. – тал 91-94.

Монгол улсын хүрэл болон төмөр зэвсгийн түрүү үеийн түүхийн онолын чиглэлийн хэд хэдэн асуудлыг хөндөн авч үзжээ.

111) **Волков В.В**. *Оленные камни Монголии*. - УБ., 1981.

Монгол нутгаас олдсон Буган хөшөөний талаархи нэгэн сэдэвт зохиол.

112) **Наваан Д.** *Төв музейн хүрэл зэвүүд* // SA. t. III f. 4. - УБ., 1965. – тал 23-28.

Улаанбаатар хотын Төв музейд хадгалагдаж байгаа 68 сумны хүрэл зэвийг тодорхойлон ангилжээ.

113) **Наваан Д.** *Монголын дөрвөлжин булш* // SA. t. V. f. 4. - УБ., 1972. – тал 32-54.

Энэ өгүүлэлд дөрвөлжин булш, буган хөшөө, хадны зургийн ангилал он цагийн хамаарлын асуудлыг авч үзсний зэрэгцээ тэдгээрийн Монголын хүрэл зэвсгийн үеийн түүхэнд эзлэх байр суурийг хөндөн тавьжээ.

114) **Наваан Д.** *Дорнот Монголын хүрэл* // ШУА. 1972. ¹2. – тал 90-92.

Дорнод аймгийн ОНС музейд хадгалагдаж байгаа хүрэл олдворуудыг нийтэлжээ.

115) **Наваан Д.** *Бронзовый век Монголии в историй Центральной Азии* // Роль кочевых народов в цивилизации Центральной Азии. - УБ., 1974. –тал 211-213.

Энэ өгүүлэлд Монголын хүрлийн үеийн соёлын хэд хэдэн үндсэн шинжийг тодорхойлон Монголын хүрлийн үеийн овгууд эдийн болон оюун санааны ололтоороо Төв Азийн соёл иргэншлийн хөгжилд үлэмж хувь нэмрээ оруулжээ гэж дүгнэсэн байна.

116) **Наваан Д.** *Дорнот монголын хүрлийн үе*. - УБ. 1975.

Хүрлийн үед холбогдох дурсгалууд болон дөрвөлжин булшны судалгаанд тулгуурлан Дорнод Монголын хүрэл зэвсгийн үеийн оршин суугчдын эдийн болон оюун санааны амьдралын асуудлыг тусгасан нэгэн сэдэвт зохиол.

117) **Новгородова Э.А.***К вопросу о древних связах Монголии и Сибири //* SA. t. IV. f. 3. - УБ., 1965. – тал 15-21.

Шавар ваар сав, хутга, зүүлт зэрэг олдворуудад хийсэн дүгнэлтэд түшиглэн чулуун зэвсгийн үед Монгол Сибирь хоёрын хооронд бүрэлдсэн харилцаа холбоо нь хүрэл зэвсгийн үед улам бэхжин зузаарчээ гэж үзсэн байна.

118) **Сэр-Оджав Н, Долгорсүрэн Д.** *Дундговь аймаг хүрлийн үед* // SA. t.IV. f. 9. - УБ., 1964. – тал 1-40.

Дундговь аймгийн музейд хадгалагдаж байгаа хүрэл эдлэлүүдийг дэлгэрэнгүй тодорхойлон ангилал хийж он цагийг нь тогтоожээ.

119) **Пэрлээ Х**. Өмнөговь-Өвөрхангай аймгуудын говь талын нутгаар эртний судлалын хайгуул хийсэн нь. Эртний судлал-угсаатан зүйн бүтээл. УБ.,1963.

120) **Эрдэнэбаатар Д**. *Origin of the Mongolian Saving "Breaking a Flint Over One`s Head" (Толгой дээр цахиур хагалах хэмээхийн учир) //* Corea Mongol symposium. - УБ., 1994.

Хүрлийн үеийн дөрвөлжин булшны оршуулгын зан үйлд багтах толгойн хажууд цахиур чулуу дагалдуулах ёсны тухай өгүүлжээ.

121) **Эрдэнэбаатар Д.** *Монголын Үндэсний Түүхийн Музейд хадгалагдаж буй хүрэл эдлэлүүд* // Музей судлал (SM). t. I (IV). f. 1. – тал 4-11.

МҮТМ-д хадгалагдаж буй хүрэл хутга, сүх, оолийг холбогдох зургийн хамт тодорхойлон нийтэлжээ.

122) **Эрдэнэбаатар Д**. *Монгол нутаг дахь дөрвөлжин булш хиригсүүрийн соёл.* УБ., 2002.

123) **Эрдэнэбаатар Д., Доржханд С.** *Монголын нүүдэлчдийн хүрлийн үеийн төмөрлөг боловсруулах арга, ажиллагааны тухайд* // SA. t 17. f.6. - УБ., 1997. – тал 73-81.

## IV. ЭРТНИЙ УЛСУУД

124) **Амартүвшин Ч.,Гантулга Ж., Гарамжав Д**. Мангасын хүрээ хэмээх нэгэн шороон хэрмийн тухай. АН. t. X. f.5. УБ.,2005.

125) **Батсайхан З**. *Хүннү нумын хийцийн тухай.* // SA. t 13. f.7. - УБ., 1992. – тал 69-76.

126) **Батсайхан З**. *Умард Сюннүгийн түүхэн зарим он цагийн тухай.* // Corea Mongol symposium. МСХЭШ-II. - УБ., 1993. – тал 220-227.

Энэ өгүүлэлд Умард Хүннүгийн түүхэнд холбогдох зарим он цагийг тодруулан хүннүгийн түүхийг хүнну их гүрний үе, хүнну улсын үе гэж зааглаж үзэх үндэстэйг дурдсан байна.

127) **Батсайхан З**. *Дорнод Сюннүгийн түүхйн зарим асуудалд* // SH. t. 27-28. f.1. - УБ., 1994.

Энэ өгүүлэлд Дорнод Хүннүгийн түүхийн зарим асуудлыг хөндөн тавьсан байна.

128) **Батсайхан З**. *Хүнну нарын шүтлэг бишрэлийн тухай төсөөлө*л // МСХЭШ-2. 1995.

129) **Батсайхан З**. *Агт морь, адууны тоног хэрэглэл (хүнүгийн хэрэглэгдэхүүнээр)* // МУИС-ийн ЭШБ. [1]3 (127). УБ., 1997.

130) **Батсайхан З**. Төв Азийн нүүдэлчдийн түүхийн зарим асуудал // МУИС-ийн ЭШБ. Археологи, антропологи, угсаатан судлал. [1]187 (13). УБ., 2002. – тал 31-35.

131) **Батсайхан З.***Хүнну (Археологи, угсаатны зүй, түүх)*. УБ.,2003.

132) **Батсайхан З., Саруул И.***Хүннүгийн зэр зэвсэг* // МУИС-ийн ЭШБ. [1]4 (133). УБ., 1998.

133) **Наваан Д**. *Хүнну судлал өнөө үед* // ШУА. 1989. –тал 68-70.

Хүннүгийн археологийн дурсгалыг судалсан байдлыг товч дүгнээд, 1988 онд Ховд аймгийн Манхан суманд малтсан Хүннүгийн язгууртны булшнаас гарсан эд өлгийн зүйлсийн талаар өгүүлжээ.

134) **Төрбат Ц.** Эртний нүүдэлчдийн оршуулгын дурсгалын нэгэн чухал элемент // SE. t. XII. f. 14. - УБ., 2000. – тал 290-298.

135) **Төрбат Ц.** *Эртний нүүдэлчдийн оршуулгын зан үйлийг судлах арга зүйн асуудалд (хүнну булшны жишээн дээр)* // Түүхийн сэтгүүл. t. 3. f. 18. - УБ., 2002. – тал 7-15.

136) **Төрбат Ц.** *Эртний монголчуудын оршуулгын дурсгалын зүг чиг* // SA. t.I (XXI). f. 6. - УБ., 2003. – тал 66-68.

Эртний монголчуудын оршуулгын дурсгалын зүг чигийн талаар өгүүлжээ.

137) **Төрбат Ц.***Хүннүгийн жирийн иргэдийн булш*. - УБ.,2004.

## V. ЭРТНИЙ УЛСУУД

138) **Баяр Д.***Монголын төв нутаг дахь түрэгийн хүн чулуу.* - УБ.,1997.

Монголын төв нутагт буй хүн чулуудыг тодорхойлон нийтэлсэн нэгэн сэдэвт зохиол

139) **Сэр-Оджав Н**. *Эртний түргүүд. (VII-VIII зуун)* // SA. t. V. f. 2. - УБ., 1970. 115 хуудастай.

Түрэгийн археологийн дурсгал, түүхэн тойм, үечлэлийн талаар өгүүлсэн нэгэн сэдэвт зохиол.

## VI. ЭРТНИЙ МОНГОЛЧУУД

140) **Амартүвшин Ч.** *Монголчуудын дэгрээ тамганы үүсэл хувирлын тухай асуудалд* // SA. t XX. f.9. - УБ., 2000. – тал 130-137.

Дэгрээ тамганы үүсэл хувирлыг археологийн биет олдворуудтай харьцуулан үзжээ.

141) **Базарсүрэн Ж**. *Чингис хааны зэр зэвсэг*. - УБ., 2000.

142) **Баяр Д., Эрдэнэбат У.** *Харамсалтайгаар сүйтгэгдсэн ховор нэгэн олдворын тухай* // Манай Монгол. - УБ., 2000. – тал 29-30.

143) **Баяр Д., Эрдэнэбат У.** *Монголын эзэнт гүрний үед холбогдох нэгэн ховор дурсгал* // SA. t. XX. f.8. - УБ., 2000. – тал 100-129.

Өмнөговь аймгийн Ноён сумын нутаг Цагаанханангийн агуйгаас олдсон XIII-XIV зууны үед холбогдох хадны оршуулгаас үлдэж хоцорсон зарим нэгэн эд өлгийн дурсгалыг нийтэлжээ.

144) **Волков В.В.** *Эртний монгол булш* // ШУАМ. ¹4. - УБ., 1962. – тал 66-67.

Өмнөговь аймгийн Манлай сумын нутаг Хар-Аргалант хэмээх газарт малтсан XIV-XVI зууны үеийн булшны олдвор хэрэглэгдэхүүнийг нийтэлсэн байна.

145) **Лхагвасүрэн Х**. *Дундад зууны (XIII-XIV) монголчуудын оршуулгын зарим асуудал* // ШУАМ. ¹4. - УБ., 1986. – тал 162-168.

Энэ өгүүлэлд МЗХТСЭ-ийн Монгол орны нутгаас урьд өмнө мэдэгдээгүй 60 гаруй оршуулгын цогцолборууд олсныг дурдаад эдгээр дурсгалууд нь XIII-XIV зуунд хамаарч байгаа талаар бичжээ.

146) **Лхагвасүрэн Х**. *Шинээр олдсон XII-XIII зууны монголчуудын булшууд* // ШУАМ. ¹1. - УБ., 1989. – тал 68-76.

Энэ өгүүлэлд монгол орноос олдсон монголын үед холбогдох зарим булшуудыг тодорхойлсон байна.

147) **Лхагвасүрэн Х**. *Монгол булшны судалгааны асуудалд* // ШУАМ. ¹1. - УБ., 1987. – тал 87-94.

Монгол булшны судалгааны байдлыг бичсэн байна.

148) **Пэрлээ Х**. *12-13-р зууны үеийн тулгат тогоо* // ШУ. ¹3. - УБ., 1950. – тал 30-31.

Монгол нутгаас олдсон төмрийн түрүү үе болон хүннүгийн үеийн тогоог харьцуулан судлаж, хүннүгийн үеийн тогоо XII-XIII зууны монголчуудад уламжлагдан иржээ гэсэн дүгнэлтэд хүрчээ.

149) **Төрбат Ц. Батсайхан З.** *Эртний монголчуудын археологийн дурсгалыг судлах асуудалд* // МУИС-ийн ЭШБ. - УБ., 1997. – тал 140-146.

## VII. ЭРТНИЙ ХОТУУД

150) **Намжил Т**. *Хүнннүгийн үеийн хот барилгын конструкцын зарим асуудал.* // SA. t VII. f.18. - УБ., 1977. – тал 137-146.

Энэ өгүүлэлд Хүннүгийн үеийн хот суурины хөгжилт, барилгын конструкцын хөгжлийн зарим асуудлыг археологийн материалд тулгуурлан бичсэн байна.

151) **Пэрлээ Х**. *Монголын барилгын ухааны түүхээс* // ШУ. ¹1. - УБ., 1960.-тал 36-38.

Зохиогч бичгийн болон археологийн мэдээ баримтад түшиглэн Монголд эрт дээр үеэс өөрийн гэсэн өвөрмөц барилгын ухаан хөгжиж байсныг батлан харуулаад зогсоогүй нүүдэлчдэд өөрийн гэсэн уран барилга, хот байгуулах арга ухаан байгаагүй гэсэн онолыг няцаасан байна.

152) **Пэрлээ Х**. *Монголын сөнөсөн хот суурины түүхийн асуудалд.* - УБ., 1956. 9 хуудастай.

153) **Пэрлээ Х**. *Хүн нарын гурван хэрмийн үлдэц.* - УБ., 1957.

Зохиогчийн 1952 онд малтан шинжилсэн Гуа дов, Бүрхийн дөрвөлжин, Тэрэлжийн дөрвөлжингийн олдвор хэрэглэгдэхүүнийг нийтэлсэн байна.

154) **Пэрлээ Х.** Монгол ард улсын эрт дундад үеийн хот суурины товчоон. – УБ., 1961. 157 хуудастай.

Нэгэн сэдэвт зохиол. Монгол орны нутаг дэвсгэрээс олдож мэдэгдээд байгаа хот суурины үлдэгдлийг зохиогч хүнну, түрэг, кидан, эртний монгол, феодалын бутралын гэсэн үеүдэд хуваан авч үзсний зэрэгцээ тэдгээрийн үүсэл хөгжлийн түүхийг авч үзэн Монгол дахь феодалын харилцаанд хот суурин голлох үүрэг гүйцэтгэж байсан хэмээн дүгнэсэн байна. Археологийн болон түүхийн сурвалжид тулгуурлан монголчууд зөвхөн нүүдэлчин байсан гэдэг онолыг бүрэн няцаасан байна.

155) **Пэрлээ Х.** *Өмнөговь, Өвөрхангай аймгуудад эртний судлалын хайгуул хийсэн нь* // SA. t. II. f. 2. - УБ., 1963. – тал 27-35.

Нэр бүхий аймгуудын нутаг дэвсгэрээс олдсон эртний хотуудын тухай өгүүлжээ.

156) **Пэрлээ Х**. *1965 оны археологийн шинжилгээний олдвороос* // SH. t. VI. f. 10. - УБ., 1967. – тал 93-106.

Өвөрхангай аймгийн нутгаас олдсон хэд хэдэн эртний хот суурины үлдэгдлийн талаар бичжээ.

157) **Цэвээндорж Д., Батсайхан З., Төрбат Ц**. *Сюннүгийн хот суурины асуудалд* // ШУАМ. ¹ 3-4. - УБ., 1994. – тал 86-98.

1990 онд Өмнөговь аймгийн Номгон сумын нутагт орших Баянбулагийн туурийг малтахад гарсан олдворыг тодорхойлон нийтэлж, уг хотын туурь нь сурвалжид бичигдсэн байдаг Жао Синь балгас байж магадгүй гэж үзсэн байна.

## VIII. ХАДНЫ ЗУРАГ

158) **Гарамжав Д**. *Хан уулын хадны зураг* // SA. t.11. f. 7. - УБ., 1986. – тал 72-84.

Өмнөговь аймгийн Ханхонгор сумын нутаг Хан уулын хадны зургийг нийтэлжээ.

159) **Дорж Д.** *Монгол орны хад чулуун дээрхи зураг сүгийн зүйл* // SH. t. II. f. 3-8. - УБ.,1962. – тал 75-88.

Монгол орноос олдсон хадны зургийн ангилал болон урьд өмнө олдсон ханы зургийн хамаарах он цагийн асуудлыг дахин тодруулан авч үзжээ.

160) **Дорж Д**. *Монголын хүрлийн хадны зураг* // SA. t. II. f. 3-8. - УБ., 1963. – тал 9-15.

МЭӨ 1200-1000 оны үед холбогдох Их Тэнгэрийн ам, Гачуурт, Талж голоос олдсон хадны зургийг нийтэлж холбогдох он цагийн хамаарлыг хутганы зургаар тодруулжээ. Зохиолчийн өгүүлснээр энэ төрлийн хадны зураг нь Монголоос Байгал болон Байгалийн чанадад дамжин тархжээ.

161) **ДоржД**. **НовгородоваЭ.А**. *ПетроглифыМонголии.* - УБ. 1975, ч. 1. 231 хуудастай.

Нэгэн сэдэвт зохиол. Монголын хадны зургийн судалгааны тойм, ангилал, үечлэлийн талаар өгүүлжээ.

162) **Санжмятав Т**. *Тэмээний нэгэн зургийн тухай* // ШУА. ¹2. УБ., 1982. - тал 36-38.

Өмнөговь аймгийн Ноён сумын Ихэр гашууны хадны зургийн тухай өгүүлж, тэр дотроос тэмээний зурганд тодорхойлот өгч дүгнэлт хийжээ.

163) **Санжмятав Т.***Монгол нутгаас шинээр олдсон эртний тэрэг* // ШУАМ. ¹4. - УБ., 1982. – тал 44-52.

Энэ өгүүлэлд МЗТСХЭ-ийн хээрийн судалгааны ажлын явцад олж илрүүлсэн эртний тэрэгний зургийн тухай өгүүлж, он цагийн хамаарлын асуудлыг хөндөн тавьсан байна.

164) **Санжмятав Т.***Монголын хадны зураг*. – УБ., 1995.

165) **Цэвээндорж Д**. *Хадны сийлмэл зургийн шинэ дурсгалууд* // SE. t.5. f.5. УБ., 1977. – тал 73-118.

166) **Цэвээндорж Д.**, **Цэрэндагва Я., Гүнчинсүрэн Б., Гарамжав Д.***Жавхлант хайрханы хадны зураг*. - УБ., 2004.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Жавхлан хайрханы хадны зургийг бүхэлд нь тодорхойлон нийтэлсэн нэгэн сэдэвт зохиол.

## IX. БИЧГИЙН ДУРСГАЛУУД

167) **Болд Л**. *БНМАУ-ын түрэг бичээсийг судалсан байдал* // ШУАМ. ¹3. - УБ., 1986. – тал 65-88.

Энэ өгүүлэлд Монгол нутгаас олдсон түрэг бичээсүүдийг нийтэлж Монголын нутаг дэвсгэрзөвхөн монголчуудын соёлын өлгий төдийгүйТөв Азийн бусад нүүдэлчдийн өлгий хэмээн дүгнэсэн байна.

168) **Болд Л**. *Монгол нутаг дахь хадны бичээс (Түрэг бичээсийн дурсгал).* – УБ., 1990.

## X. ТЭМДЭГЛЭЛ БА ШҮҮМЖ

169) **Баяр Д.** *Эртний говийн тухай тэмдэглэл* // ШУА. - 1989. ¹ 3. - тал 71-75.

170) **Баяр Д**. *Мянган дурсгалын өлгий* // ШУА. ¹ 2. - УБ., 1994. – тал 44-46.

## XI. ТАЙЛАН, ЭХ ХЭРЭГЛЭГДЭХҮҮН

171) **Амартүвшин** нар, 2006 – Амартүвшин Ч., Гүнчинсүрэн. "Айвенхоу Майнз Монголия Инк" компанийн Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь Оюу толгойд шинээр баригдах нисэх онгоцны буудлын талбайд хийсэн археологийн хайгуул судалгааны ажлын тайлан. АХГБСХ. Улаанбаатар.

172) **Батсайхан** - 1990 - Батсайхан З. Өмнөговь аймагт малтлага хийсэн тухай тайлан. АХГБСХ. Улаанбаатар.

173) **Гантулга** нар, 2007 – Гантулга Ж., Алдармөнх П. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Оюу толгой дахь "Айвенхоу Майнз Монголия Инк" ХХК-ны "Heruga" ашиглалтын талбайд хийсэн хайгуул судалгаа. АХГБСХ. Улаанбаатар.

174) **Ерөөл-Эрдэнэ** нар, 2005 – Ерөөл-Эрдэнэ Ч., Гантулга Ж. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Оюу толгой дахь "Айвенхоу Майнз Монголия Инк" ХХК-ны ашиглалтын талбайд хийсэн хайгуул судалгаа. АХГБСХ. Улаанбаатар.

175) **Гүнчинсүрэн** нар, 2002 – Гүнчинсүрэн Б., Цэрэндагва Я., Амартүвшин Ч. Өмнөговь аймгийн нутагт ажилласан археологийн хээрийн шинжилгээний ангийн тайлан. АХГБСХ. Улаанбаатар.

176) **Гүнчинсүрэн** нар, 2005 – Гүнчинсүрэн Б., Амартүвшин Ч., Ерөөл-Эрдэнэ Ч., Гантулга Ж. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь "Айвенхоу Майнз Монголия инк" компанийн "Оюу толгой" ашиглалтын талбайд хийсэн археологийн хайгуулын ажлын тайлан. АХГБСХ. Улаанбаата**р.**

177) **Хүрэлсүх** нар, 2005 – Хүрэлсүх С., Мөнхтулга Р. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь Дэмчигийн хийдэд хийсэн малтлага судалгааны тайлан. АХГБСХ. Улаанбаатар.

178) **Цэвээндорж** нар, 2001 – Цэвээндорж Д., Гүнчинсүрэн Б., Цэрэндагва Я. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг Оюу толгой дахь "Айвенхоу Майнз Монголия Инк" ХХК-ны ашиглалтын талбайд хийсэн хайгуул судалгаа. АХГБСХ. Улаанбаатар.

179) **Цэвээндорж** нар, 2003 – Цэвээндорж Д., Гүнчинсүрэн Б., Цэрэндагва Я. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг "Айвенхоу Майнз Монголия инк" компанийн лиценз бүхий талбайд гүйцэтгэсэн археологийн хайгуул судалгааны тайлан. АХГБСХ. Улаанбаатар.

180) **Цэвээндорж** нар, 2003 б – Цэвээндорж Д., Гүнчинсүрэн Б., Цогтбаатар Б., Амартүвшин Ч. Өмнөговь аймгийн Манлай сумын нутаг "Айвенхоу Майнз Монголия инк" компанийн ашиглалтын талбай Хармагтайд гүйцэтгэсэн археологийн малтлага судалгааны тайлан. АХГБСХ. Улаанбаатар.

181) **Цэвээндорж** нар, 2005 – Цэвээндорж Д., Гүнчинсүрэн Б., Амартүвшин Ч., Цогтбаатар Б. Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутаг дахь "Айвенхоу Майнз Монголия инк" компаний ашиглалтын талбайд хийсэн археологийн малтлага судалгааны ажлын тайлан. АХГБСХ. Улаанбаатар.

## XII. Бусад

182) Сүхийн Дамбий. Ёлын ам, Говь Гурван сайхан мину. Улаанбаатар, 2002

183) Арслангийн Цоож. Он жилүүдийн урсгалд. Улаанбаатар, 2006.

184) Өмнөговь аймгийн Архивын албаны тавин жилд. Даланзадгад, 2007

185) Амгалангийн Цоож. Баянборынхон. Даланзадгад, 2006

186) С.Ваанчиг. Өмнөговь аймгийн байгаль, газар зүй, ашигт малтмал. Даланзадгад, 2005

187) Л.Гантогтох. Сэврэй нутгийн бүсгүйчүүд. Улаанбаатар, 2006.

188) Балжиннямын Зандраа. Өмнийн говийн бүсгүйчүүд. Даланзадгад, 2005

189) Үржээгийн Батням. Зурхайн үзлэг зурлага ба бурханы шашны зарим зан үйлийн товчоон. Улаанбаатар, 2009.

190) Нутгийн удирдлагын шинэчлэл арван таван жилд. Эмхтгэсэн А.Цоож. Улаанбаатар, 2007.

191) Д.Баатар. Монголын уламжлалт ёс заншлаа дээдэлье. Улаанбаатар, 2002.

192) А.Цоож. Ардын уламжлалт анагаах увидас. Улаанбаатар, 2007.

193) А.Цоож. Говийн санхүүчид. Улаанбаатар, 2006.

194) А.Цоож. Миний Даланзадгад. Даланзадгад, 2007.

195) Б.Зандраа. Нэгдлийн дарга нар – Өмнийн говийн. Улаанбаатар, 2008.

196) А.Цоож. Сэтгэлд шингэсэн Сэврэй нутаг. Улаанбаатар-Даланзадгад, 2006

197) Б.Лувсан. Монгол тэмээ товчоон. Улаанбаатар, 2004.

198) Оюу толгой төслийн нийгэм, эдийн засгийн нөлөөллийн үнэлгээ (Эцсийн тайлан) Оюу толгой ХХК, Бодлого судлалын төв, Хүн амын сургалт, судалгааны төв. Улаанбаатар, 2009.

199) Өмнөговь аймгийн нийгэм, эдийн засаг, байгаль орчны суурь судалгаа 2008. Атлас.

200) Өмнөговь аймгийн суурь судалгаа 2008. //Өмнөговь аймгийн нийгэм-эдийн засаг, байгаль орчны суурь судалгаа. Өмнөговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал, Засаг даргын тамгын газар, Судалгаа хөгжлийн сан. Улаанбаатар, 2008

## Палеонтологи

### Монгол хэлээр

1. Барсболд Р. Монгол орны эртний амьтан ургамлын олдвор, олдворт газрыг хамгаалах асуудалд. *Түүх соёлын үл хөдлөх дурсгал хамгаалагчдад*, Улаанбаатар, 2008, х. 100-108
2. Барсболд Р. Монгол орны эртний амьтан, ургамлын судалгаа. *Монгол нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалт*. Улаанбаатар, 2008. х. 42-49
3. Барсболд Р. Монголын үлэг гүрвэлийн олдворын хосгүй үнэт жишгүүд болон тэдгээрийн шинжлэх ухааны ач холбогдол нь." Монгол улсын шинжлэх ухаан 108 боть", Монгол орны эртний амьтан ургамал, 33-р боть, х.167-196
4. Цогтбаатар Х. Палеонтологийн дурсгалын хадгалалт хамгаалалт, зорилт. *Монгол нутаг дахь түүх соёлын үл хөдлөх дурсгалын хадгалалт хамгаалалт*. Улаанбаатар, 2008.х. 134-142
5. Цогтбаатар Х. Монгол орны эртний амьтан ургамлын олдворыг хамгаалах асуудалд. *Түүх соёлын үл хөдлөх дурсгал хамгаалагчдад*, Улаанбаатар, 2008, х. 108-111
6. Цогтбаатар Х. Чулуужсан модны талаар мэргэжлийн байгууллагаас дүн шинжилгээ хийсэн ажлын тайлан. *Түүх соёлын үл хөдлөх дурсгал хамгаалагчдад*, Улаанбаатар, 2008, х.129-131
7. Цогтбаатар Х. Монголын орнитопод (шувуун хөлт) үлэг гүрвэл." Монгол улсын шинжлэх ухаан 108 боть", Монгол орны эртний амьтан ургамал, 33-р боть, 2009. х.197-225
8. Цогтбаатар Х. Үл хөдлөх соёлын өв-палеонтологийн дурсгалт газрын өнөөгийн байдал. *"Соёлын өв" сэтгүүл*. 2009. №3 Хуу.11
9. Цогтбаатар Х. Монгол орон эртний шим ертөнцийн өлгий нутаг. Байгаль орчин, амьдрал сэтгүүл 2010, № 4(19). х. 6-12
10. Хосбаяр П. Монгол орны мезозой ба кайнозойн эриний эртний газарзүй, уур амьсгал. ШУА-ийн Геологи, эрдэс баялгийн хүрээлэнгийн бүтээл №15, 2005, х.1-184

### Орос хэлээр

11. Барсболд Р. Стратиграфическое расчленение и корреляция верхнемеловых континентальных отложений МНР. Тр. Геол. ин-та АН МНР, 1970, с.30-38
12. Барсболд Р. Новый позднемеловой орнитомимид из МНР. Палеонтол. журн., 1988, №1, с. 122-125
13. Братцева Г.М., Новодворская И.М. Споры и пыльца из нижнемеловых отложений местонахождения Хурэн-Дух, МНР. Тр. ССМПЭ, Вып.2, с.205-209

14. Ефимов М.Б. Хампсозаврид из нижнего мела Монголии. В кн. : Ископаемая фауна и флора Монголии. М.: Наука 1975, с. 84-93. (Тр.ССМПЭ; Вып.2).

15. Ефимов М.Б. Чойрия (Champsosauridae) из раннего мела Хамарин Хурала, МНР. В кн.: Фауна мезозоя и кайнозоя Монголии. М.: Наука, 1979, с. 56-57. (Тр.ССМПЭ; Вып.8)

16. Ефимов М.Б. Новые позднемеловые параллигаторы Монголии. - В кн.: Ископаемые позвоночные Монголии. М.: Наука, 1981, стр.26-28.(Тр. ССМПЭ; Вып. 15)

17. Ефимов М.Б. Обзор ископаемых крокодилов Монголии. - В кн.: Ископаемые рептилии Монголии. М.: Наука, 1983, стр.76-96. (Тр.ССМПЭ; Вып.24)

18. Ефимов М.Б. Хампсозавриды Центральной Азии -В кн. : Ископаемые рептилии Монголии. М.:Наука 1983, с. 67-75. (Тр.ССМПЭ; Вып.24).

19. Ефимов М.Б. Ископаемые крокодилы и хампсозавры из Монголии и СССР. М.: Наука 1988, с. 1-108. (Тр.ССМПЭ; Вып.36)

20. Ефремов И.А. Некоторые замечания по вопросам исторического развития динозавров. - Тр. ПИН АН СССР, 1954, т.48, с.126-141

21. Ивахненко, М.Ф и Курзанов С.М., Геологическое строение и возраст местонахождений Удан-сайр и Шара-Цав. Тр. ССМПЭ, Вып.34, 1988, с. 100-105

22. Калугина Н.С. Раннемеловое озеро Манлай. Тр.ССМПЭ., Вып.43, 1980, с. 1-115

23. Курзанов С.М. Авимимус и проблема происхождения птиц. Ископаемые рептилии Монголии. М.: Наука 1983, с. 104-109. (Тр.ССМПЭ; Вып.24)

24. Курзанов С.М. Новый род протоцератопсид из позднего мела Монголии. Палеонтол. журн. 1991, №4, с.85-91

25. Курзанов С.М. Гигантский протоцеатопсид из верхнего мела Монголии // Палеонтол. журн. 1992, №3. с.81-93

26. Курзанов С.М. Новый позднемеловой карнозавр из Ногон-Цава, Монголия. Тр. ССМПЭ, 1976, Вып.3, с. 93-104 (Палеонтология и биостратиграфия Монголии)

27. Курзанов С.М., Банников А.Ф. Новый завропод из верхнего мела МНР // Палеонтол. журн. 1983. № 2, с. 90-97

28. Малеев. Е.А., Новый анкилозавр из верхнего мела Монголии. Докл. АН СССР, Вып.87, №2, с. 273-276

29. Маринов Н.А. Стратиграфия Монгольской Народной Республики. Изд-во АН СССР, 1957, с.266, Ленинград

30. Мартинсон Г.Г. О стратиграфии Юрских и Меловых отложений Монголии. Известия АН СССР, Серия геологическая, 1973, №12, с.89-95

31. Мартинсон Г.Г., Сочава А.В., Барсболд Р. О стратиграфическом расчленении верхнемеловых отложений Монголии. Докл. АН СССР, т. 189, № 5, 1969, с. 1081-1084

32. Синица С.М. Позднемезозойские местонахождения органических остатков в Западной Монголии. Тр. ССМПЭ (Насекомые в раннемеловых экосистемах Западной Монголии), Вып.28, 1986, с. 7-44

33. Синица С.М. Юра и нижный мел Центральной Монголии. Тр. ССМПЭ, Вып.42, 1993, с.1-236

34. Сочава А.В. Стратиграфия и литология верхнемеловых отложений Южной Монголии.- Тр. ССМГЭ, 1975, Вып.13, с. 113-182

35. Твердохлебов В.П., Цыбин Ю.И. Генезис верхнемеловых местонахождений динозавров Тугрикин-Ус и Алаг-Тэг. Фауна и биостратиграфия Мезозоя и Кайнозоя Монголии, Тр. ССМПЭ, Вып.1, 1974, с. 314-319

36. Цыбин Ю.И., Курзанов С.М. Новые данные о верхнемеловых местонахождениях позвоночных района Байшин-Цав. -В кн.: Фауна Мезозоя и Кайнозоя Монголии. М. Наука, 1979, с.108-112 (Тр.ССМПЭ; Вып. 8)

37. Шишкин, М.А. Лабиринтодонт из позднего Юры Монголии. Палеонтол. журн., 1991 (1), с. 81-95

38. Шувалов В.Ф. Мезозойские отложения юго-восточной части Монгольского Алтая.- В кн.: Геология мезозоя и кайнозоя Западной Монголии. М., 1970 Тр. ССМНИГЭ, №2, с.7-18

39. Шувалов В.Ф. О геологическом строении и возрасте местонахождений Хобур и Хурэн-Дух. Фауна и биостратиграфия Мезозоя и Кайнозоя Монголии, Тр. ССМПЭ, Вып.1, 1974, с. 296-304

40. Шувалов В.Ф. Стратиграфия мезозоя центральной Монголии. В кн. Стратиграфия мезозойских отложений Монголии. Тр. ССМНИГЭ. Вып.13, 1975, с. 50-112

41. Шувалов В.Ф. Палеогеография и история развития озерных систем Монголии в юрское и меловое время // Мезозойские озерные бассейны Монголии. Л.: Наука, 1982. с.18-100

42. Шувалов В.Ф., Трусова Е.К. Новые данные о стратиграфическом положении позднеюрских и раннемеловых конхострак Монголии. Тр. ССМПЭ, Вып.3, 1976, с.236-265

43. Шувалов В.Ф., Чхиквадзе В.М. Новые данные о позднемеловых черепахах Южной Монголии. Тр. ССМПЭ., Вып. 2, 1972, с.214-229

**Англи хэлээр**

44. Bakhurina, N. N. and Unwin, D. M., 1995: A survey of pterosaurs from the Jurassic and Cretaceous of the former Soviet Union and Mongolia. *Historical Biology*, vol. 10, p.197–245.

45. Chiappe, L. M., Suzuki, S., Dyke, G. J., Watabe, M., Tsogtbaatar, K., and Barsbold, R., 2007: A new enantiornithine bird from the Late Cretaceous of the Gobi Desert. *Journalof Systematic Palaeontology*, vol. 5, no. 2, p. 193–208.

46. Dashzeveg, D., Dingus, L., Loope, D. B., Swisher III, C. C., Dulam, T., and Sweeney, M. R., 2005: New stratigraphic subdivision, depositional environment and age estimate for the upper Cretaceous Djadokhta Formation, southern Ulan Nur Basin, Mongolia. *American Museum Novitates*, no. 3498, p. 1–31

47. Dingus, L., Loope, D. B., Dashzeveg, D., Swisher III, C. C., Minjin, Ch., Novacek, M. J., and Norell, M. A., 2008: The Geology of Ukhaa Tolgod (Djadokhta Formation, Upper Cretaceous, Nemegt Basin, Mongolia). *American MuseumNovitates*, no. 3616, p. 1–40

48. Eberth, D.A., 1993: Depositional environments and facies transitions of dinosaur-bearing Upper Cretaceous redbeds of Bayan Mandahu (Inner Mongolia, China). *Canadian Journalof Earth Sciences*, vol. 20, no. 10/11, p. 2196–2213

49. Fastovsky, D. E., Badamgarav, D., Ishimoto, H., Watabe, M. and Weishampel, D. B., 1997: The paleoenvironments of Tugrikin-Shireh (Gobi Desert, Mongolia) and aspects of the taphonomy and paleoecology of *Protoceratops* (Dinosauria; Ornithishichia). *Palaios*, vol. 12, no. 1, p. 59–70

50. Gradzinski, R., 1970: Sedimentation of dinosaur-bearing Upper Createaceous deposits of the Nemegt Basin, Gobi Desert. *Palaeontologia Polonica*, vol. 21, p. 147–229.

51. Gradzinski, R. and Jerzykiewicz, T., 1972: Additional geogrpahical and geological data from the Polish-Mongolian Palaeontological Expeditions. *Palaeontologia Polonica*, vol. 22, p. 17–32.

52. Gradzinski, R. and Jerzykiewicz, T., 1974a: Sedimentation of the Barun Goyot Formation. *Palaeontologica Polonica*, vol. 30, p. 1–146.

53. Gradzinski, R. and Jerzykiewicz, T., 1974b: Dinosaur- and mammal-bearing aeolian and associated deposits of the Upper Cretaceous in the Gobi Desert (Mongolia). *SedimentaryGeology*, vol. 12, p. 249–278.

54. Gradzinski, R., Kielan-Jaworowska, Z. and Maryanska, T., 1977: Upper Cretaceous Djadokhta, Barun Goyot and Nemegt formations of Mongolia, including remarks on previous subdivisions. *Acta Geologica Polonica*, vol. 27, no. 3, p. 281–318.

55. Graham, S. A., Hendrix, M. S., Barsbold, R., Badamgarav, D., Sjöstrom, D. J., Kirschner, W. and McIntosh. J. S., 1997: Discovery and occurrence of the oldest known dinosaur (Late Jurassic) in Mongolia. *Palaios*, vol. 12, p. 292–297.

56. Grimaldi, D., De Souza Amorim, D., and Blagoderov, V., 2003: The Mesozic family Archizelmiridae (Diptera: Insecta). *Journal of Paleontology*, vol. 77, no. 2, p. 368–381.

57. Gubin, Y. M. and Sinitza, S. M., 1996: Shar Teg: a unique Mesozoic locality of Asia. *In*, Morales, M. *eds*., The Continental Jurassic. *Museum of Northern Arizona Bulletin*, vol. 60, p. 311–318.

58. Hicks, J. F., Brinkman, D. L., Nichols, D. J. and Watabe, M., 1999: Paleomagnetic and palynologic analyses of Albian to Santonian strata at Bayn Shireh, Burkhant, and Khuren Dukh, eastern Gobi Desert, Mongolia. *Cretaceous Research*, vol. 20, p. 829–850

59. International Subcommission on Stratigraphic Classification of IUGS International Commission on Stratigraphy (Salvador, A. ed.), 1994: *International Stratigraphic Guide - a Guideto Stratigraphic Classification, Terminology, and Procedure,2nd Edition*, 207 p. Geological Society of America, Boulde.

60. Ito, M., Matsukawa, M., Saito, T., and Nichols, D. J., 2006: Facies architecture and paleohydrology of a synrift succession in the Early Cretaceous Choyr Basin, southeastern Mongolia. *Cretaceous Research*, vol. 27, p. 226–240.

61. Jerzykiewicz, T., 2000: Lithostratigraphy and sedimentary settings of the Cretaceous dinosaur beds of Mongolia. *In*, Benton, M. J., Shishkin, M. A., Unwin, D. M. and Kurochkin, E. N. *eds*., *The Age of Dinosaurs in Russia andMongolia*, p. 279–296. Cambridge University Press, Cambridge.

62. Jerzykiewicz, T. and Russell, D. A., 1991: Late Mesozoic stratigraphy and vertebrates of the Gobi Basin. *CretaceousResearch*, vol. 12, p. 345–377.

63. Kurochkin, E. N. and Barsbold, R., 2000: The Russian - Mongolian expeditions and research in vertebrate palaeontology. *In*, Benton, M. J., Shishkin, M. A., Unwin, D. M. and Kurochkin, E. N. *eds*., *The Age of Dinosaurs in Russiaand Mongolia*, p. 235–255. Cambridge University Press, Cambridge.

64. Loope, D.B., Dingus, L., Swisher, C.C., III and Minjin, C., 1998: Life and death in a Late Cretaceous dune field, Nemegt Basin, Mongolia. *Geology*, vol. 26, no. 1, p. 27–30.

65. Matsumoto, R., Suzuki, S., Tsogtbaatar, Kh. and Evans, S. E., 2009: New material of the enigmatic reptile Khurendukhosaurus (Diapsida: Choristodera) from Mongolia. *Naturwissenschaften*, vol. 96, no. 2, p. 233–242.

66. Mikhailov, K. E. Classification of fossil eggshells of amniotic vertebrates. *Acta Palaeontologica Polonica*,1991 vol. 36, no. 2, p. 193–238

67. Nichols, D. J., Matsukawa, M., and Ito, M., 2006: Palynology and age of some Cretaceous nonmarine deposits in Mongolia and China. *Cretaceous Research*, vol. 27, p. 241–251.

68. Norman, D. B., 1998: On Asian ornithopods (Dinosauria: Ornithischia).1. Iguanodon orientalis Rozhdestvenskii, 1952. *Zoological Journal of the Linnean Soceity*, vol. 116, no. 3, p. 303–315.

69. Osmólska, H. and Roniewicz, E., 1970: Deinocheiridae, a new family of theropod dinosaurs. *Palaeontologia Polonica*, vol. 21, p. 5–19.

70. Perle, A., Norell, M. A. and Clark, J., 1999: A new maniraptoran theropod - *Achillobator giganticus* (Dromaeosauridae) - from the Upper Cretaceous of Burkhant, Mongolia. *Contributions of the Mongolian-American PaleontologicalProject*, no. 101, p. 1–105.

71. Rozhdestvenskii, A. K., 1952: Discovery of iguanodonts in Mongolia. *Doklady Akademii Nauk SSSR*, vol. 84, no. 6j, p. 1243–1246.

72. Saiki, K. and Okubo, A., 2006: Lower Cretaceous flora of the Choyr Basin, Mongolia. *Cretaceous Research*, vol. 27, p. 252–261.

73. Shuvalov, V. F., 2000: The Cretaceous stratigraphy and palaeobiogeography of Mongolia. *In*, Benton, M. J., Shishkin, M. A., Unwin, D. M. and Kurochkin, E. N. *eds*., *The Ageof Dinosaurs in Russia and Mongolia*, p. 256–278. Cambridge University Press, Cambridge.

74. Shuvalov, V. F. and Stankevich, E. S., 1977: Late Cretaceous ostracods and stratigraphy of the Baishin Tsav region of Southeast Monglia. *Trudy Sovmestnoi Sovetsko-Mongol'skoi Paleontologicheskoi Ekspeditsii*, vol. 3, p. 127–136.

75. Sukhanov, V. B., Danilov, I. G., and Syromyatnikova, E. V., 2008: The description and phylogenetic position of a new nanhsiungchelyid turtle from the Late Cretaceous of Mongolia. *Acta Palaeontologica Polonica*, vol. 53, no. 4, p. 601–614.

76. Suzuki, S., Chiappe, L. M., Dyke, G. J., Watabe, M., Barsbold, R. and Tsogtbaatar K., 2002: A new specimen of Shuvuuia deserti Chiappe et al., 1998 from the Mongolian Late Cretaceous with a discussion of the relationships of Alvarezsaurids to other theropod dinosaurs. *Contributions in Science*, no. 494, p. 1–18.

77. Suzuki, S. and Watabe, M., 2000a: Report on the Japan - Mongolia Joint Paleontological Expedition to the Gobi desert, 1995. *Hayashibara Museum of Natural Sciences ResearchBulletin*, vol.1, p.45–57.

78. Suzuki, S. and Watabe, M., 2000b: Report on the Japan - Mongolia Joint Paleontological Expedition to the Gobi desert, 1998. *Hayashibara Museum of Natural Sciences ResearchBulletin*, vol. 1, p.83-98.

79. Suzuki, S. and Narmandakh, P., 2004: Change of the Cretaceous Turtle Faunas in Mongolia. *Hayashibara Museum ofNatural Sciences Research Bulletin*, vol. 2, p.7–14.

80. Tsogtbaatar Kh. A new hadrosaur (Reptilia, Ornithischia) from the Upper Cretaceous, Djadokhta Formation of Mongolia. Mongolian Geoscientist, No.9, 1998, Abstracts; "Problems of Biostratigraphy" Meeting in 1998, p.52

81. Tsogtbaatar Kh., Watabe M., 2003 Preliminary results of field works on the Upper Jurassic and Lower Cretaceous dinosaur localities in 2002. Mongolian Geoscientist No.19 pp.39

82. Tsogtbaatar Kh. Spatio-temporal distribution of Mongolian Hadrosaurids "Khurel Togoot" Seminary, Geology and Geography section, Abstracts. Ulaanbaatar, pp. 65-67

83. Tsogtbaatar Kh. The Mongolian Hadrosauroids: Their Phylogenetic relationships and Biogeographical Implication. Mongolian Geoscientist No.29: pp.11-13

84. Tsogtbaatar Kh. Evolution of Late Cretaceous Hadrosauroids (Ornithopoda, Ornithischia, Dinosauria) in Mongolia. Kagoshima University, Japan, 2008. pp.1-268

85. Tsogtbaatar Kh., Chinzorig Ts. Mongolian Hadrosauroids: Paleobiogeography, Dispersal and Environmental Relationships. Proceeding of the Sixth Korea-Mongolia Joint Seminar on Environmental Changes of North East Asia, 2007 pp.66-72

86. Tsogtbaatar Kh., Watabe M.Phylogenetic position of derived ornithopods of Early Late Cretaceous (Baynshire and Djadokhta Age) in Mongolia. Journal of Vertebrate Paleontology, 2008. Vol.28, Supplement to No.3 , p.153

87. Watabe, M. *Report of excursion to dinosaur fossil bearing localities in the eastern part of the Gobi desert*.JICA Ulaanbaatar Office, 2002

88. Watabe, M. New dinosaur ovifauna from the Upper Cretaceous vertebrate fossil locality, Abdrant Nuru, Central part of the Gobi desert, Mongolia. *Hayashibara Museumof Natural Sciences Research Bulletin*, 2004. vol. 2, p. 15–27.

89. Watabe, M., and Fastovsky, D.E. Diverse dinosaur habitats of Djadokhta age (late Cretaceous) in the Gobi desert, Mongolia. Journal of Vertebrate Paleontology, vol.19, supplement to no. 3, 1999. p.83A

90. Watabe, M., Fastovsky, D.E., Hicks, J.F., Johnson, K., Nichols D.J., and Tsogtbaatar Kh., in prep.: Geology, paleontology, and chronology of a dinosaur fossil locality: Khermeen Tsav and relationship between sedimentary facies and vertebrate faunal assemblages.

91. Watabe, M. and Suzuki, S. Report on the Japan - Mongolia Joint Paleontological Expedition to the Gobi desert, 1993. *Hayashibara Museum of Natural Sciences ResearchBulletin*,2000. vol. 1, p. 17–29

92. Watabe, M. and Suzuki, S., Report on the Japan - Mongolia Joint Paleontological Expedition to the Gobi desert, 1994. *Hayashibara Museum of Natural Sciences ResearchBulletin*,2000. vol. 1, p. 30–44

93. Watabe, M. and Suzuki, S., 2000c: Report on the Japan - Mongolia Joint Paleontological Expedition to the Gobi desert, 1996. *Hayashibara Museum of Natural Sciences ResearchBulletin*, 2000. vol. 1, p. 58–68

94. Watabe, M. and Suzuki, S., 2000d: Report on the Japan - Mongolia Joint Paleontological Expedition to the Gobi desert, 1997. *Hayashibara Museum of Natural Sciences ResearchBulletin*, 2000, vol. 1, p. 69–82

95. Watabe, M. and Suzuki, S., 2000e: Cretaceous Fossil Localities and a List of Fossils Collected by the Hayashibara Museum of Natural Sciences and Mongolian Paleontological Center Joint Paleontological Expedition (JMJPE) from 1993 through 1998. *Hayashibara Museum of Natural SciencesResearch Bulletin*, 2000. vol. 1, p. 99–108

96. Watabe, M. and Tsogtbaatar, Kh. Report on the Japan - Mongolia Joint Paleontological Expedition to the Gobidesert, 2000. *Hayashibara Museum of Natural SciencesResearch Bulletin*, 2004. vol. 2, p. 45–67

97. Watabe, M., Tsogtbaatar, Kh., Ichinnorov, N. and Barsbold, R. Report on the Japan - Mongolia Joint Paleontological Expedition to the Gobi desert, 2001. *Hayashibara Museumof Natural Sciences Research Bulletin*, 2004 vol. 2, p. 69–96

98. Watabe, M., Tsogtbaatar, Kh., Uranbileg, L. and Gereltsetseg, L. Report on the Japan -Mongolia Joint Paleontological Expedition to the Gobi desert, 2002. *HayashibaraMuseum of Natural Sciences Research Bulletin*, vol. 2004. 2, p.97–122

99. Watabe, M., Tsogtbaatar, Kh. and Barsbold, R. First discovery of a theropod (Dinosauria) from the Upper Jurassic in Mongolia and its stratigraphy. *PaleontologicalResearch*, 2008. vol. 12, no. 1, p. 27–36

100. Watabe, M., Tsogtbaatar, Kh., Suzuki, S. and Saneyoshi M. Geology of dinosaur-fossil-bearing localities (Jurassic and Cretaceous: Mesozoic) in the Gobi Desert: Results of the HMNS-MPC Joint Paleontological Expedition. *Hayashibara Museum of Natural Sciences Research Bulletin*, 2010 vol.3, pp.41-118

**Түүх, Соёл**

1. Монголын нууц товчоон. Монгол хэлнээ орчуулсан Ц.Дамдинсүрэн.УБ., 1990
2. Рашид ад-дин. Судрын чуулган. I, II, III дэвтэр. Орос хэлнээс орчуулсан Ц.Сүрэнхорлоо. УБ., 2003
3. Хадын үндэсний их Шар тууж. Хэвлэлд бэлтгэсэн Ш.Чоймаа.УБ., 2006
4. Саган сэцэн. Эрдэнийн товч. Хэвлэлд бэлтгэсэн М.Баярсайхан. УБ., 2006
5. Галдан туслагч. Эрдэнийн эрих хэмээх түүх болой. Хэвлэлд бэлтгэсэн Ж.Гэрэлбадрах. УБ.,2010
6. Д.Майдар. Монголын архитектур ба хот байгуулалт. УБ.,1972
7. Монгол ард улсын угсаатны судлал, хэл шинжлэлийн атлас. Атласыг ерөнхийлэн эрхэлсэн Б.Ринчин. УБ.,1979 тэргүүн, дэд боть.
8. И.Ринчинханд. Түвдэнгийн Бор. Даланзадгад. 1984
9. С.Лувс анцэрэн, Г.Юндэнбазар. Өмнөговь аймгийн хураангуй түүх. тэргүүн дэвтэр. Даланзадгад. 1991
10. С.Лувс анцэрэн, Г.Юндэнбазар. Өмнөговь аймгийн хураангуй түүх. дэд дэвтэр. Даланзадгад. 1991
11. Ц. Бат-Өлзий. Их говийн домогт хүмүүс. Даланзадгад. 1991
12. Д.Цэвэээнжав. Өмнөговь аймгийн Ханбогд сумын түүхэн тойм. УБ., 1992
13. С. Тогоохүү. Галбын говийн бахархал. УБ., 1995

14. Г.Юндэнбазар. Өмнөговь аймгийн анхдагч. Хамгийн хамгийн хамгийн. УБ., 1999

15. Ц.Загдсүрэн. Өмнийн цэнхэр говь Даланзадгад. УБ., 2001

16. С.Тогоохүү, М.Дамдинсүрэн. Галбын говийн бахархал: дурсамж, тэмдэглэл. Өмнөговийн аймгийн Ханбогд сумын 80 жилд. УБ., 2001

17. Д.Баатар. Монголын уламжлалт ёс заншлаа дээдэлье. УБ., 2002

18. С.Дамбий. Ёлын ам, Говь Гурван сайхан мину. УБ., 2002

19. Э. Эрдэнэ. Улаан цав. УБ., 2003

20. Ц.Галбадрах. Миний говийнхон. Өмнөговь аймгийн Баян-Овоо сумыг байгуулсны 80 жилийн ойд зориулав. УБ., 2004

21. Б.Лувсан. Монгол тэмээ товчоон. Улаанбаатар, 2004.

22. Г.Чулуун. Өндөр богд. (Заг, Сүүжийн говь). Өмнөговь аймгийн Баян-Овоо, Номгон сумын 80 жилийн ойд зориулав. УБ., 2004

23. С.Ваанчиг. Өмнөговь аймгийн байгаль, газар зүй, ашигт малтмал. Даланзадгад. 2005

24. Б.Зандраа. Өмнөговь аймгийн бүсгүйчүүд. Даланзадгад. 2005

25. Ц.Амгалан. Их говийн хүчтэнүүд. УБ., 2006

26. Л.Гантогтох. Сэврэй нутгийн бүсгүйчүүд. УБ., 2006

27. А.Цоож. Он жилүүдийн урсгалд. УБ., 2006

28. А. Цоож. Баянборынхон. Даланзадгад. 2006

29. А.Цоож. Говийн санхүүчид. УБ., 2006

30. А.Цоож. Сэтгэлд шингэсэн Сэврэй нутаг. Сэврэй сум байгуулагдсны 80 жилийн ойд зориулав. Улаанбаатар-Даланзадгад. 2006

31. Г.Сүхбаатар. Сэврэй нутгийн бүсгүйчүүд. Сэврэй сумын 80-н жилийн ойд зориулав.УБ., 2006

32. Ц.Лувсанцэрэн. Хадган цэнхэр говь мину. The Blue southern gobi. УБ.,2006

33. Б. Тогтох, Н.Шүрхүү, Д.Ойдовдорж. Өмнийн цэнхэр говийнхон. Аймаг байгуулагдсны 75 жилийн ойд зориулав. УБ., 2006

34. Нутгийн удирдлагын шинэчлэл арван таван жилд. Эмхтгэсэн А.Цоож. УБ. 2007

35. Өмнөговь аймгийн Архивын албаны тавин жилд. Даланзадгад. 2007

36. А.Цоож. Миний Даланзадгад. Даланзадгад. 2007

37. А.Цоож. Ардын уламжлалт анагаах увидас. УБ., 2007

38. Б.Зандраа. Нэгдлийн дарга нар – Өмнийн говийн. УБ., 2008

39. Л. Мажаа. Бидний бахархал. II. Батмөнх даян хааны мэндэлсний 545 жил, Говийн догшин хутагт Данзанравжаагийн мэндэлсний 205 жилийн ойд зориулав. УБ., 2008

40. Б.Зандраа. Манай говийн чулуу. УБ., 2009

41. Ү. Батням. Зурхайн үзлэг зурлага ба бурханы шашны зарим зан үйлийн товчоон. УБ., 2009.

42. Х.Агваан. Говь Гурван Сайханы минь нөмөр. УБ., 2009

43. С.Тогоохүү. Галбын говийнхон. (түүхэн тайлбар толь) УБ., 2010

44. Khanbogd. Photo album. Photography by G.Badamsambu. Ulaanbaatar.2010

**Товчилсон үгийн жагсаалт**

АХГБСХ-Археологийн хүрээлэнгийн гар бичмэлийн сан хөмрөг

ДДС-Дорно дахины судлал (сэтгүүл)

ДУ-Дүрслэх урлаг (сэтгүүл)

М- Монголия (журнал)

МУ-Монгол улс (сэтгүүл)

МСХЭШС-Монгол Солонгосын хамтарсан эрдэм шинжилгээний симпозиум

ОҮМУ- Орчин үеийн монгол улс (сэтгүүл).

СМ- Современная Монголия (сэтгүүл)

ТХ- Түүхийн хүрээлэн

ХЗ-Хэл зохиол (сэтгүүл)

ХЗС-Хэл зохиол судлал (сэтгүүл)

ШУ-Шинжлэх ухаан (сэтгүүл)

ШУА-Шинжлэх ухаан амьдрал (сэтгүүл)

ШУАМ- Шинжлэх ухааны академийн мэдээ (сэтгүүл)

ШУТ- Шинжлэх ухаан техник (сэтгүүл)

ШУХБ- Шинжлэх ухааны хүрээлэнгийн бүтээл.

ШУХХ- Шинжлэх ухааны хүрээлэнгийн хэвлэл

ЭШБ- Эрдэм шинжилгээний бүтээл.

CSM- CORPUS SCRIPTORUM MONGOLORU

SA- STUDIA ARCHAEOLOGICA (Археологийн судлал)

SE -STUDIA ETHNOGRAPHICA (Этнографийн судлал)

SM- STUDIA MONGOLICA (Монгол судлал)

SH -STUDIA HISTORICA (Түүхийн судлал)

t.-tomus (боть)

f.-fasciculus (дэвтэр)

# 12. ХАВСРАЛТ 3. ӨМНӨГОВЬ АЙМАГТ БУЛШЛАГДСАН ДУРСГАЛТ ГАЗАР ОЛДОХ МАГАДЛАЛЫГ ТОДОРХОЙЛОХ ГЕОАРХЕОЛОГИ ЗАГВАР

**Жеффрей А. Хомбург**

Геологийн үйл явцын улмаас археологийн дурсгалуудад нөлөөлөл үүсдэг. Эдгээр геологийн үйл явц нь: 1-рт, урсгал дагуух үерээр үүссэн хурдас, 2-рт элсэн манханы үүсэлт, 3-рт хүндийн хүчнээс улбаалж толгодын доод хэсэгт хурдас үүсэх зэрэг байж болно. Үер, салхи болон хүндийн хүчнээс үүссэн хурдсуудыг аллювал,аэолиан, коллувиал гэж харилцан нэрлэдэг. Коллувиал хурдас үүсэх олон нөхцөл байдаг бөгөөд эдгээр нь нил угаагдал, хөрсний угаагдал, газрын гулсалт зэрэг байж болно. Зарим тохиолдолд орчин үеийн хөгжил дэвшилүүд нь археологийн дурсгалуудыг булах тохиолдол гардаг ба үүнд газар шороо ухах, зөөх зэргээр өмнөх гадаргууг булдаг. Тиймээс, археологийн таамаглах загвар бүтээн эдгээр булагдсан дурсгалуудыг судлах нь нэн чухал юм. Булагдсан  археологийн дурсгалуудын тархалтын үнэлгээ, судалгааг археологийн болон хүрээлэн буй орчны хайгуул эсвэл топографын мэдээн дээр үндэслэсэн газар дээрхи археологийн дурсгалуудын таамаглалын дагуу хийдэг байна.

Соёлын өвийн хөтөлбөрүүд болон таамаглалын археологийн загварууд нь булагдсан археологийн дурсгалуудад анхаарлаа хандуулах болсон.

Тиймээс, геоархеологчид нь магадлалын зургийг өмнөх геологийн судалгаа, нээлтэн дээр үндэслэн хийдэг. Харамсалтай нь, Оюу Толгой төслийн хүрээний булагдсан археологийн дурсгалуудын боломжит зургийг хийх боломжгүй, учир нь геологийн өндөр нягтралтай зургууд нь зөвхөн чулуулагын геологид төвлөрсөн байна мөн дөрөвдөгч үеийн геологийн зураглал хангалттай байхгүй. Беспаловын [1964] аймгийн хэмжээний хөрсний судалгааны тайлан буй ч орон нутгийн хөрсний зураг байдаггүй. Гео-археологичидоор булшлагдсан дурсгалуудын магадлалын зураг хийгдэсний дараа урьдчилсан сорилтын малтлагууд хийгддэг (суваг) бөгөөд тухайн хуримтлалуудыг радиокарбон, гэрлийн болон бусад аргуудаар он цагийг нь тогтоож болдог. Ийм аргаар хийгдсэн булшлагдсан дурсгалын зургийг олон зорилгоор ашиглаж болно. Жишээлбэл, булшлагдсан дурсгалын зураг нь дурсгалуудыг төлөвлөгдсөн газар шорооны ажлын сүйтгэлээс урьдчилан сэргийлж археологийн сорилт эсвэл хяналт тавихад шаардлагатай. Булшлагдсан дурсгалын зураг хийх ажил нь их хугацаа авах магадлалтай учир Өмнөговь аймагт урьд хийж байсан хөрсөн дээрхи дурсгалуудын зураг дээр үндэслэн булшлагдсан дурсгалын зураг хийх бололцоотой юм. Булшлагдсан дурсгалын зургийг өндөр нягтралтай геологийн болон хөрсний зураггүйгээр үйлдэх нь бүр их цаг авдаг тул булшлагдсан дурсгалын зураг хийх ажил нь өнөөгийн судалгааны хүрээнд тохиромжгүй юм.

Үүний оронд булшлагдсан дурсгалын ерөнхий санаан дээр үндэслэсэн загварыг, төслийн хүрээний нутаг дэвсгэрт зориулан хийсэн болно. Энэхүү загварыг эхний ээлжинд хайгуул судалгаан дээр үндэслэн доктор Жеффрей Хомбург хийсэн. Мөн энэхүү загварыг СӨХ-ийн бусад судлаачдын тусламжтайгаар төслийн газар нутаг болон зэргэлдээх газар нутагтай танилцан байх үед хийсэн юм.

Ерөнхийдөө, хайгуул судалгааны үед хийгдсэн геоархеологийн үнэлгээ нь төслийн газар нутагт булшлагдсан дурсгал байх боломж тун бага эсвэл байхгүй хэмээн заасан ба учир нь энэхүү газар нутаг нь геологийн хувьд харьцангүй өндөр, нам уулаар хууваагдсан сав газар байрлах ба энд дурсгал оршин байх боломж тун бага.

Археологийн булагдсан дурсгалууд байх боломж байгаа тул дор товч авч үзэв.

Булагдсан дурсгалууд байх боломж Дөрөвдөгч газрын тогтоцоор хязгаарлагддаг ба үүнд Голоценоос дунд Плейстоцен хүртэл ордог байна. Хагас сая жилийн настай газрын тогтоц нь булагдсан дурсгалуудтай хамгийн их холбоотой юм. Говийн ундны усны хомсдолоос үүдэн, булагдсан археологийн дурсгалууд нь усны эх үүсвэрийн дагуу байх боломж маш өндөр байгаа нь гайхах зүйл биш юм.

Булагдсан археологийн дурсгалууд нь доор байрласан газарт байх боломжтой юм. Төслийн газарт хийсэн хайгуул судалгааны үеэр эдгээр байгалын тогтоцуудын жишээг баримтжуулав, үүнд: (1) үер болон хөрс суух үед овоорсон шороо (Зураг 3.1, Зураг3.2, Зураг3.3); (2) дэвүүр хэлбрийн овойлт (Зураг 3.4); (3) элсэн манханаар хучигдсан газар (Зураг3.5, Зураг3.6, Зураг3.7); (4) өндөрлөг хэсгийн доод хэсэгт үүссэн овооролтын ховилууд. Өнөөгийн хатсан нуурын эрэг нь булагдсан дурсгал байх бололцоотой бас нэгэн газар юм. Гэсэн хэдий ч хайгуулын үед ийм төрлийн газар илрээгүй юм.

**Зураг 3.1 Үерийн усаар хэлбэржсэн аллювийн дэнж (1)**



**Зураг 3.2. Үерийн усаар хэлбэржсэн аллювийн дэнж (2)**



**Зураг 3.3. Үерийн усаар хэлбэржсэн аллювийн дэнж (3)**



Зураг 3.4. Аллювийн хурдас



Зураг3.5. Элсэн манханаар хучигдсан талбай (1)



**Зураг3.6. Элсэн манханаар хучигдсан талбай (2)**



**Зураг3.7. Элсэн манханаар хучигдсан талбай (3)**



Зураг3.8 дээр налуугийн ангилалын загварыг харуулж байгаа ба энэ нь булагдсан дурсгал илрүүлэхэд бас хамаатай юм. Энэхүү налуугийн ангилал нь Руегийн ажил дээр үндэслэгдсэн юм, үүнд: оргил, мөр хэсэг, ар хэсэг, доод хэсэг ба ёроол хэсэг ордог. Эдгээр налуугийн (бэл) елемендүүд нь геоморфологийн үйл явцтай холбоотой тул дурсгалыг булахад хүргэдэг. Тэдгээр нь дурсгалуудыг таан илрүүлхэд хэрэгтэй юм. Налуу бүрийн елементед давамгайлдаг геоморфологийн үйл явцуудыг доор харуулав:

(1) оргил хэсэг – усны шүүлт ба хөрс үүсэлт, (2) мөр хэсэн – элэгдэл; (3) ар хэсэг – элэгдэлд орсон хурдасын зөөлт; (4) хөл хэсэг – хурдасуудын овоорол; (5) ёроол хэсэг – Шаварын хурдасын овоорол (Хүснэгт 3.1). Булагдсан археологийн дурсгалууд нь бэлийн доод болон ёроол хэсгийн хурдасанд дарагдсан байх боломжтой юм. Хөрсөн дээрхи дурсгалууд нь бэлийн дунд хэсэг болон оргил хэсэгт төвлөрсөн байх боломжтой ба энэ нь доод хэсгийг бодвол илүү суурь сайтай байдаг байна.

Бэлийн доод хэсгүүд, овоолсон ба дэвүүр хэлбрийн сайр ялангуяа унды усны ойролцоох газарууд нь булагдсан дурсгал агуулах өндөр боломжтой юм. Бэлийн доод хэсэг буюу дунд доод хэсэгүүд нийлэх хэсэг, хөндийн зах хэсэг болон илүү орчин цагийн сайруудад байх боломж дунд зэрэг байдаг. Харин өндөлөг хэсэг буюу оргил, дунд болон арын хэсэгт байх боломж бага ба эдгээрт хөрсөн дээрхи дурсгалууд тохиолдодог байна. Эцсийн үнэлгээ ба археологийн сорилтын малтлага эсвэл хяналт явуулхаас өмнө мэргэжлийн геоархеологичоор хайгуул судалгаа хийлгэх шаардлагатай.

**Зураг3.8. Налуугийн ангилалын загвар**




Figure 8. Idealized valley cross section showing Ruhe's slope elements (after Schoenberger et al. 2002).

Археологийн дурсгалууд хадгалагдах өндөр магадлалтай газар нутагт үерийн усны судлууд, жалга гуу гэх мэтийн урсгал усны үйлчлэлээр үүссэн ус хадгалагдаж байсан газрууд орно. Археологийн дурсгалууд хадгалагдах дундаж магадлалтай газар нутагт сүүлийн үед үүссэн гуу жалга болон хажуу ирмэгүүд зэрэг багтана. Элсэн манханнууд нь маш идэвхитэй урсгал усны нөөцөд оршин тогтнож байгаа тохиолдолд өндөр магадлалтай газар нутагт, өөр газар орших байга тохиолдолд дундаж магадлалтай газар нутагт тус тус хамаарна. Археологийн дурсгалууд хадгалагдах бага магадлалтай газар нутагт өргөгдсөн газрууд уулын хажуу хормой гэх мэтчилэн археологийн олдворууд элэгдэх буюу зөөгдөх магадлалтай газрууд багтана. Аливаа археологийн малталт болон шалгалт хийх хэрэгцээг үнэлэхээсээ өмнө тухайн газарт геоархеологийн үнэлгээ хийж тухайн газарт хөрс хөндөх үйл ажиллагаа явуулах шаардлагатай эсэхийг тогтооно.

## *Ашигласан материалууд*

**Bespalov, N. D.**1964Soils of Outer Mongolia (translated from Russian). Published for the U.S. Department of Agriculture and the National Science Foundation, Washington, D.C. by the Israel Program for Scientific Translations. Academy of the USSR Committee of Sciences of the Mongolian Peoples Republic, Proceedings of the Mongolian Commission No. 41, Izdatel'stvo Akademii Nauk SSSR, Moskva, originally published in 1951.

**Gunchinsuren, B., Ch. Amartuvshin, and J. W. Olsen**2010 Thoughts toward a predictive "expert" model of archaeological sites locations in Ömnögov aimag. Unpublished paper, on file, Mongolian Academy of Science, Institute of Archaeology, Ulaanbaatar, Mongolia.

**King, L. C.**1957 The uniformitarian nature of hillslopes. Transactions of the Edinburgh Geological Society 17: 81-102

**Ruhe, R. V.**1975 Geomorphology. Houghton Mifflin, Boston, Massachusetts.

**Schoenberger, P. J., D. A. Wysocki, E. C. Benham**2002 Field Book for Describing and Sampling Soils. U. S. Department of Agriculture, National Soil Survey Center, Lincoln, Nebraska.

Хүснэгт 1. голлох геоморфологийн процесууд болон янз бүрийн давхрага элементүүдэд археологийн дурсгал хадгалагдах магадлал

| . Давхарга элемент | Голлох геоморфологийн процессууд | Археологийн дурсгал хадгалагдах магадлал, боломжит дурсгалууд |
|---|---|---|
| Уулын оргил | Өнгөн давхаргын элэгдэл | Археологийн олдворууд ил харагдах |
| | Хөрс усанд эвдрэх | Олдвор шороотой холилдох |
| | Педогенез | Археологийн олдвор болон дурсгалууд хөрсөн дээр гарч ирэх |
| Уулын хажуу | Өнгөн давхаргын гүн элэгдэл | Археологийн олдворуудын нягтрал нэмэгдэх |
| | Хөрсний нүүдэл | Археологийн олдвор болон дурсгалууд хөрсөн дээр гарч ирэх. Археологийн олдвор болон дурсгалууд хөрсний элэгдэлээс болж хэсэг шороонд дарагдан үлдэх |
| Уулын бэл | Хөрс шорооны нүүдэл | Археологийн олдворуудын нягтрал багасах |
| | Хөрсний нүүдэл, элэгдэл, гулгалтаас шалтгаалан их хэмжээний газар нүүх | Археологийн олдвор болон дурсгалууд хөрсөн дээр гарч ирэх. Хөрсний элэгдэл болон шилжилтээр археологийн олдворууд нүүх. |
| Уулын хормой | Далд нүүдэл | Археологийн дурсгалууд хөрсөн доор байх боловч ил гарч ирэх тохиолдол бий. |
| | Их хэмжээний биет нүүх буюу усанд угаагдснаас шалтгаалан ил гарч ирэх | Археологийн олдворуудын нягтрал нэмэгдэх |
| | Педогенез | |
| ёроол | Хөрсний нүүдэл | Археологийн олдворуудын нягтрал багасах |
| | | Археологийн олдвор болон дурсгалууд хөрсөн доор байх боловч зарим тохиолдолд гадаргуу дээр ил гарч ирэх боломжтой. |

## 13. ХАВСРАЛТ 4. БИЕТ ӨВИЙН СУДАЛГААНЫ БАГИЙН 2010 ОНЫ 11-Р САРЫН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

**Оюу толгой төслийн "Соёлын өвийн хөтөлбөр" төслийн биет өвийн судалгааны хэсгийн тайлан** (2010 оны 11-р сарын 11-20)



**доктор, профессор Б.Гүнчинсүрэн**
**доктор, дэд профессор Ч.Амартүвшин**

### Удиртгал

Соёлын өвийн хөтөлбөр боловсруулах төслийн хүрээнд нөлөөллийн бүс нутгуудыг дотор нь гурван ангилалд хуваан авч үзсэн билээ. Энэ удаад нөлөөллийн гуравдугаар бүс буюу тус аймгийн баруун талын сумдуудад ажиллав. Энэхүү ажлын зорилгыг доорх байдлаар тодорхойлов.

- Тус компани хөтөлбөр боловсруулах уралдааны гүйцэтгэх ажлын тодорхойлолтонд (2009 оны 11-р сарын 16-ний өдөр) Ханбогд, Баян-Овоо, Манлай, Даланзадгад сумд болон Өмнөговь аймаг багтаж болно хэмээн санал болгож байсантай уялдуулан манай багийн бүрэлдэхүүн өөрсдийн төлөвлөгөөндөө Өмнөговь аймгийн үлдсэн 11 сумын эрсдэлийг ямар нэгэн хэмжээгээр тодорхойлох талаар тусгасан билээ.
- Монгол улсад түүх-соёлын дурсгалын хадгалалт хамгаалалт, бүртгэл мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг үе шаттайгаар хийж байсан боловч харамсалтай нь Өмнөговь аймгийн нутагт ийм төрлийн ажил тун хангалтгүй байсаар байна. Энэ байдлыг бид төслийн нэгдүгээр шатны эхний ажил болох Номзүйн судалгаа болон мэдээллийн сан бүхий газрын зургийн урьдчилсан судалгааны хүрээнд тодорхой харуулсан юм.

- Шат дараалсан судалгааны дараагийн хэсэг бол өөрсдийн боловсруулсан загвар дээр тулгуурлан тухайн бүс нутагт түүх-соёлын дурсгалын байршлыг урьдчилсан байдлаар таамаглаж, түүнийг газар дээр нь шалгах хээрийн судалгааг хийх шаардлагатай байна. Энэ нь Оюу толгой компаниас үл хамааралтай ч бусад уул уурхай, барилга байгууламжийн ажлын явцад гарч болзошгүй эрсдэлийг бууруулахад чухал нөлөөтэй юм.
- Биет өвийн судалгааны багийн гишүүд говийн бүсэд хийсэн судалгааны туршлага дээр үндэслэн 10 хүчин зүйлд тулгуурлан загварыг гаргасан болно. Эдгээр загварт жишээлбэл, ширгэсэн гол, горхи, нуурын хөндий болон ширгээгүй гол, нуурын сав, үнэт чулуу олзворлож байсан газар, ойр орчмын өндөрлөг уул, газар усны оноосон нэр зэрэг зүйлс багтаж байна.
- Урьдчилсан байдлаар гарсан соёлын өвийн бүртгэл - зураглал дээрээс харахад Өмнөговь аймгийн зүүн хэсэгт дурсгалууд шигүү тархсан мэт харагдаж байгаа боловч энэ нь үнэн хэрэг дээрээ ийм биш байгаа нь ойлгомжтой билээ. Говийн бүс нутагт эртнээс нааш хүн жигд тархан суурьшиж байсан нь гарцаагүй бөгөөд Өмнөговийн баруун нутгууд ч гэсэн түүх соёлын дурсгал олон байгаа нь тодорхой юм.
- Энэхүү хээрийн судалгааны хугацаа давчуу тул олон дурсгал бүртгэх бололцоогүй хэдий ч өөрсдийн хийсэн загварыг шалгах, томоохон дурсгалыг баримтжуулах талаар анхааран ажиллах болно.

**Хээрийн судалгааны багийн ажлын явц**.

Энэхүү хээрийн судалгааны ажил хоёр хэсэг болон ажиллав. Үүнд, **Нэгдүгээр баг** – *Б.Гүнчинсүрэн, Ц.Болорбат, Б.Эрдэнэ*, *Жолооч*, **Хоёрдугаар баг** - *Ч.Амартүвшин, Г.Галдан, Ц.Амгалантөгс*, *Жолооч* нийт 8 хүний бүрэлдэхүүнтэй ажиллав. Хоёр баг болон ажиллахаар төлөвлөсөн шалтгаан нь a) энэ хээрийн судалгааны ажил нь Өмнөговь аймгийн баруун бүс нутгуудаар буюу нөлөөллийн нэгдүгээр бүсээс гаднах сумдуудаар ажиллах учир олон км замыг туулж, үзэж танилцах дурсгал олон байгаатай холбоотой; b) Мөн хөтөлбөр боловсруулах багийн нэгэн тулмагдаад байгаа асуудал бол орон нутагт байгаа "Зөвлөх хороо"-ны гишүүдтэй биечлэн уулзаж, тэднээс албан ёсны зөвшөөрөл авах ажил юм. Үүнийг нэгдүгээр багийн бүрэлдэхүүн өөр маршрутаар явж гүйцэтгэнэ; c) Өмнөговь аймгийн нутаг өргөн уудам, сум хоорондын болон шалгах газруудын зай хол байгаагаас нэг машинтай, цөөн хүнтэй ажиллабал хугацаа их алдана, мөн олон км замыг туулах болно.



**Судалгааны багийн бүрэлдэхүүн**
**(Баруун гар талаас Ц.Амгалантөгс, Д.Молор, Г.Ганзориг, Б.Гүнчинсүрэн, Б.Эрдэнэ, Ц.Болорбат, Г.Галдан, Ч.Амартүвшин)**

**11-р сарын 11-ний өдөр.** Б.Гүнчинсүрэн, Ч.Амартүвшинээр ахлуулсан баг Улаанбаатар хотоос хөдөлнө. Нэгдүгээр баг Улаанбаатараас зүүн тийш хөдлөн Чойр хот – Манлай – Ханбогд – Баян-Овоо гэсэн маршрутаар аялана. Тэд энэ өдөртөө Манлай суманд очиж Зөвлөх багийн бүрэлдэхүүнд орсон гишүүнтэй уулзаж зөвшөөрөл аваад цааш хөдлөн Ханбогд суманд очиж хононо. Хоёрдугаар баг баруун урагш гаран Дундговь аймгийн нутгаар дамнан Өмнөговь аймгийн Цогт-Овоо сумын нутагт очиж хоноглов.

**11-р сарын 12-ний өдөр.** Нэгдүгээр багийнхан Ханбогд сумаас "Зөвлөх баг"-ийн бүрэлдэхүүнд орсон гишүүнээс зөвшөөрөл гарын үсэг аван цааш хөдлөн Баян-Овоо сумын нутгийг зорьж мөн тус сумаас сонгогдсон Зөвлөх багийн гишүүнээс зөвшөөрөл аван шууд Даланзадгад хот руу хөдөлнө. Хоёрдугаар багийн гишүүд Цогт-Овоо сумаас урагш 35-36 км зайтай орших Тахилгат толгой хэмээх уулыг эргэн тойрныг шалган нийт 4 дурсгал шинээр илрүүлэн бүртгэв. Цааш хөдлөн Даланзадгад хотоос зүүн хойш орших Хан уул орчимтой танилцаж нийт 45 дурсгал бүртгэв.

**11-р сарын 13-ны өдөр.** Нэгдүгээр багийнхан Даланзадгад хотод байгаа Зөвлөх багийн гишүүдтэй уулзаж зөвшөөрөл гарын үсгийг авах ажлыг гүйцэтгэв. Харин хоёрдугаар багийнхан Хүрмэн сум орчим буюу Зүүн Сайханы нуруунд ажиллав. Хайгуулаар нийт 10 дурсгалыг илрүүлэн олсон.



*Хайгуулын багийнханы өдрийн хоол*



*Хайгуулын хоёрдугаар багийнхан Хан уул орчимд*



*Хайгуулын нэгдүгээр багийн судалгааны ажлын үед*



*Хайгуулын хоёрдугаар багийн судалгааны ажлын үед*

**11-р сарын 14-ний өдөр.** Нэгдүгээр багийн бүрэлдэхүүн Зүүн Сайханы нуруугы орчимд дахин хайгуулын ажлыг гүйцэтгэж нийт 7 дурсгал илрүүлэн олов. Харин Хоёрдугаар багийн бүрэлдэхүүн Баруун Сайханы нуруу орчимд хайгуулын ажлыг гүйцэтгэн нийт 9 дурсгал илрүүлэн олов.

**11-р сарын 15-ны өдөр**. Хоёр багийн бүрэлдэхүүн Даланзадгад хотоос баруун тийш хоёр салан хөдөлсөн. Нэгдүгээр багийнхан Өмнөговь аймгийн урд талын сумдын нутгаар аялана. Энэ өдөр шууд Номгон сум руу хөдөлж тэнд буй Хараат хэмээх уулыг шалгаж, оройдоо Даланзадгад хотод ирж хоноглов. Харин хоёрдугаар багийнхан Өмнөговь аймгийн хойд талын сумдын нутгаар аялах бөгөөд тэд шууд Мандал-Овоо сумын нутаг руу хөдлөв. Энэ сумын нутгаас нийт **111111** дурсгал илрүүлэн олсон. Мандал-Овоо сумаас баруун урагш Булган сумын нутаг руу хөдлөв.

**11-р сарын 16-ны өдөр**. Нэгдүгээр багийнхан Даланзадгад хотоос хөдлөн Баян-Далай, Хүрмэн сумын нутагт ажиллаж нэг дурсгал илрүүлэн олов. Хоёрдугаар багийнхан Булган сумаас баруун урагш хөдлөн Цахиуртын хөндий, Баянзаг, Эрэгийн хоолой гэсэн чулуун зэвсгийн дурсгалуудтай танилцан Хүрмэн Дулаан уул орчимд бүлэг дурсгал шинээр олон цааш Сэврэй сумын нутаг руу хөдлөв.

**11-р сарын 17-ны өдөр**. Нэгдүгээр багийнхан Баяндалай сумаас хөдөлж Ноён сумын нутаг хүртэл аялаж тэндээ хоноглов. Тэд зам зууруу нийт 12 дурсгал илрүүлэн олсон байна. Хоёрдугаар багийхан Сэврэй сумын ойр орчимд хайгуулын ажлыг хоёр хоног гүйцэтгэв. Тахилгат, Үйзэн, Хонгор элс зэрэг газруудад хайгуулын ажлыг гүйцэтгэн нийт 8 дурсгал илрүүлэн олов.

**Хавсралт 1: Хээрийн судалгааны явцад шалгах газруудын байршил, солиболцол**

| № | Газрын нэр | |
|---|---|---|
| 1 | Тахилга уул | Ноён сумаас баруун урагш 10-12 км |
| 2 | Тахилга уул | Ноён сумаас зүүн тийш 30 км |
| 3 | Тахилга уул | Ханхонгор сумаас хойш 10 км |
| 4 | Тахилгат толгой | Цогт-Овоо сумаас урагш 34-36 км |
| 5 | Тахилгат уул | Гурвантэс сумаас баруун урагш 18 км |
| 6 | Тахилгат уул | Сэврэй сумаас баруун баруун тийш 13-15 км |
| 7 | Халбас уул | Ноён сумаас 35-38 км |
| 8 | Атгар | Баяндалай сумаас урагш 90 км |
| 9 | Хараат | Номгон сумаас баруун урагш 42-44 км |
| 10 | Бага Аргалант | Хүрмэн сумаас урагш 22-24 км |
| 11 | Их Аргалант | Хүрмэн сумаас баруун урагш 32-33 км |

11-р сарын 18-ны өдөр. Нэгдүгээр багийнхан Ноён сумын нутагт буй Тахилгат уул, Халбас гэсэн нэртэй газруудыг шалган цааш Гурвантэс сумын нутаг руу хөдлөв. Тэд хайгуулын явцад нийт 33 дурсгал илрүүлэн олов. Хоёрдугаар багийнхан Сэврэй сумаас баруун тийш хөдөлж Гурвантэс сумын нутаг руу хөдлөв. Зам зуур нийт 1 дурсгал илрүүлэн олов. Гурвантэс сумын нутагт очин баруун урагш 18 км зайтай орших Тахилгат уулыг шалгаж нийт 3 дурсгал илрүүлэн олов.

11-р сарын 19-ний өдөр. Хоёр багийн бүрэлдэхүүн Гурвантэс сумын нутгийн хойд хэсгийн хайгуулыг гүйцэтгэн цааш Өвөрхангай аймгийн Арвайхээр хотын зүг хөдлөв.

11-р сарын 20-ны өдөр. Өвөрхангай аймгийн Арвайхээр хотоос Улаанбаатар хотын зүг хөдлөж, хээрийн судалгааны ажил өндөрлөв.

**Хайгуул судалгаа**

1-1. Гурвансайханы нурууны баруун урд талд уулын энгэрт голдоо чулуугүй, дугуй хэлбэрийн дараастай нэгэн булш бий. Хэмжээ 2.0 м.

1-2. Голдоо чулуугүй, дугуй хэлбэрийн дараастай булш байх ба дараас чулууны зүүн хойд хэсэг нь эвдэрсэн байдалтай байна. Хэмжээ 2.2 м.

1-3. Энэхүү дурсгалын дараас чулууг хөдөлгөсний улмаас хэлбэр нь тодорхойгүй болжээ. 3.6x3.0 м хэмжээтэй байна.

1-4. Том чулуун дараас бүхий дугуй хэлбэртэй булш. Дараас чулууд нь зүүн хойд тал руугаа бага зэрэг таржээ. Хэмжээ 2.4 м.

1-5. Голдоо чулуугүй, дугуй хэлбэрийн дараастай булш. Хэмжээ 2.3 м.

1-6. Том чулуун дараас бүхий дугуй хэлбэртэй булш. Дараас чулууны зүүн тал руу чулуу цувуулан тавьсан байна. Хэмжээ 1.9 м

1-7. Уг дурсгалын зарим дараас чулуу нь мэдэгдэхгүй болсон байх ба мэдэгдэж буй байдлаараа 2.7 м голчтой байна.

1-8. Жижгэвтэр чулуун дараас бүхий дугуй хэлбэртэй булш. Дараас чулуу нь баруун тал руугаа бага зэрэг тарсан байдалтай. Хэмжээ 1.9 м.

1-9. Голдоо чулуугүй, дугуй хэлбэрийн жижгэвтэр чулуун дараастай булш. Дараас чулууг хөндсөн байдал ажиглагдаж байна. Хэмжээ 2.0 м.

1-10. Баяндалай сумын төвөөс баруун талд олон салбар бүхий намхавтар уулс бий. Эдгээр уулсын дунд хойноос урагш чиглэсэн хуурай сайр буй. Хуурай сайрын зүүн талын нэг намхан толгойн баруун энгэрт оршино. Голдоо чулуугүй, дугуй хэлбэрийн дараастай булш. Зарим дараас чулуудыг авч урд тал руу нуржээ. Хэмжээ 3 м.

1-11. Өмнөх дурсгалаас хойш 2.5 км зайд оршино. Том том чулуун дараас бүхий дугуй хэлбэртэй булш. Голын дараас чулуудыг авч захаар нь тойруулан тавьсанаас үзвэл тоногдсон байх магадлалтай. Хэмжээ 6.3 м.

1-12. Өмнөх дурсгалаас баруун хойш 0.9 км зайд оршино. Том том чулуугаар дугуй хэлбэрийн хашлага хийж, хүрээ чулуунаас бага хэмжээтэй чулуу овоолон даржээ. Хэмжээ 3.0 м

1-13. Гонзгой чулуудыг хэвтүүлэн дөрвөлжин хашлага хийж, дотор талыг жижгэвтэр чулуугаар дарсан дөрвөлжин булш. Хэмжээ 4.0х3.0 м.

1-14. Өмнөх дурсгалаас хойш 4 м зайд хавтгай том чулуудыг эгнүүлж босгон дөрвөлжин хашлага үйлдэж, голыг нь жижгэвтэр чулуудаар дарсан дөрвөлжин булш. Уг дурсгалын урд болон баруун талын хашлага мэдэгдэхгүй болжээ. Хэмжээ 2.0х1.3 м.

1-15. Өмнөх дурсгалаас баруун хойш 15 м зайд том гонзгой чулуугаар дөрвөлжин хашлага үйлдэж, голыг жижгэвтэр чулуугаар дарсан дөрвөлжин булш буй. Түүний хойд талын хашлага чулуу мэдэгдэхгүй болсон байх ба зүүн хашлаганы дунд хэсэгт том чулуу босгосон байна. Хэмжээ 4.3х3.8 м.

1-16. Өмнөх дурсгалаас баруун хойш 1.8 км зайд голын зарим дараас чулуудыг авч хойд талд нь тавьсан байх ба голдоо бага зэрэг хонхойсон байдалтай дугуй хэлбэртэй булш байна. Хэмжээ 2.2 м.

1-17. Өмнөх дурсгалаас хойш 4 км зайд том том чулуун дараас бүхий зууван дугуй хэлбэртэй булш бий. Хэмжээ 1.5х0.9 м.

1-18. Өмнөх дурсгалын баруун талд холгүйхэн дугуй хэлбэрийн дараастай булш буй. Хэмжээ 1.1 м.

1-19. Ноён сумын төвөөс урагш олон салбарласан уулсын дунд, хойноос урагш чиглэсэн сайрын зүүн эргийн нэг жижиг толгойн байруун урд энгэрт том чулуун дараас бүхий дугуй хэлбэртэй булш бий. Хэмжээ 2.1 м.

1-20. Сумын төвөөс урагш тал газар Халбас нэртэй өндөр дөрвөлжин уул бий. Түүний баруун хойд талд голдоо чулуугүй, дугуй хэлбэртэй дараас бүхий том хэмжээтэй булш байна. Уг дурсгалын урд хэсэг нь 1.5 м хэмжээтэй үүдэвчтэй. Хэмжээ 10.5 м.




*GIS програмын тусламжтай хийсэн урьдчилсан таамаг зураглал*

- *Дурсгал олдох магадлалтай газар*

1-21. Тахилга уулаас урагш олон салбар уулсын урд дор жижиг дэнж дээр том хавтгай чулуудыг эгнүүлж босгон дөрвөлжин хашлага хийж, голыг жижиг чулуудаар дарсан дөрвөлжин булш бий. Уг дурсгалын баруун болон урд талын хашлага мэдэгдэхгүй болсон байх ба хашлага чулууны гаднах дараас нилээд тархжээ. Хэмжээ 4.3x2.8 м.

1-22. Өмнөх дурсгалын өмнө талд том том хавтгай чулуун дараастай, зууван дугуй хэлбэртэй булш бий. Хэмжээ 1.4x0.8 м.

1-23. Хадны зургийн дурсгал. Тахилга уулаас урагш олон салбар уулсын өмнө талын оройгоороо толигор хүрэн хад бүхий уулнаа хадны зургийн дурсгал буй.

1-24. Хадны зураг бүхий уулын урд энгэрт том хавтгай чулуудыг эгнүүлж босгон дөрвөлжин хашлага хийж, дотор талыг зууван урт чулуудаар дарсан дөрвөлжин булш буй. Уг дурсгал нь голдоо бага зэрэг хонхойсон байна. Хэмжээ 2.9x2.6 м.

1-25. Өмнөх дурсгалын зүүн талд холгүйхэн том хавтгай чулуудыг эгнүүлж босгон дөрвөлжин хашлага хийж, дотор жижгэвтэр чулуудаар дарсан дөрвөлжин булш бий. Уг дурсгалын дөрвөн талын хашлага чулуу нь унасан байна. Хэмжээ 3.3х3.2 м.

1-26. Өмнөх дурсгалын зүүн хойд талд холгүй урд талын хашлага мэдэгдэх төдий, ихэд эвдэрсэн нэгэн дөрвөлжин булш буй.

1-27. Ноён сумын төвөөс баруун урагш өндөр хүчдэлийн шонгийн чанх урд 2 м орчим зайд нэг дөрвөлжин булш байна. Уг дурсгалын хашлага болон дараас чулуудыг авч өмнө талд нь овоолсон байх ба өндөр хүчдэлийн шон зоох од өртгөдсөн бололтой. 1-28. Өмнөх дурсгалаас урагш холгүйхэн өндөр хүчдэлийн шугамын зүүн урд том том чулуун дараас бүхий дугуй хэлбэртэй булш буй. Дараас чулууд нь тарсан байдалтай. Хэмжээ 2.1 м.

1-29. Өмнөх дурсгалаас урагш холгүйхэн орших жижигхэн довцог дээр голдоо бага зэрэг хонхойсон, том том чулуун дараас бүхий дугуй хэлбэртэй булш бий. Голын дараас чулуудыг авч гадагш шиджээ. Хэмжээ 1.7 м.

1-30. Хуурай сайрын зүүн эрэгт баруун хойноос зүүн урагш чиглэсэн 16 ширхэг балбал чулуу буй. Балбал чулуудын хоорондын зай харилцан адилгүй бөгөөд нийт урт нь 60 м орчим байна.

1-31. Өмнөх дурсгалаас баруун тийш нэгэн жижиг толгой дээр оршино. Голдоо чулуугүй, дугуй хэлбэрийн дараастай булш буй. Хэмжээ 1.7 м.

1-32. Өмнөх дурсгалын баруун талд голдоо чулуугүй, дугуй хэлбэрийн дараастай булш буй. Зарим дараас чулууд хөндөгдсөн байна. Хэмжээ 1.6 м.




*Хайгуулаар илэрсэн дурсгалын тархалт*

1-33. Өмнөх дурсгалын баруун талд голдоо чулуугүй, зууван дугуй хэлбэрийн булш буй. Хэмжээ 2.1x1.6 м.

1-34. Том чулуун дараастай, жижгэвтэр булш. Хэмжээ 0.9 м.

1-35. Том чулуун дараастай, зууван хэлбэртэй, жижиг булш. Хэмжээ 1.2x0.9 м.

1-36. Өмнөх дурсгалаас зүүн тийш холгүйхэн том том дараас бүхий зууван дугуй хэлбэртэй булш буй. Хэмжээ 1.2x0.9 м.

1-37. Өмнөх дурсгалын зүүн тийш 3 м зайд голдоо чулуугүй, зарим дараас чулуу нь мэдэгдэхгүй болсоны улмаас гурвалжин мэт харагдах байгууламж бий.

1-38. Өмнөх дурсгалаас баруун урагш 8 м зайд голдоо чулуугүй, дугуй хэлбэрийн дараастай булш буй. Голоор нь тасалсан мэт чулуу суулгажээ. Хэмжээ 5.8 м.

1-39. Энд нилээд дурсгал нийлсэн байдалтай байна. Зүүн талаас нь эхэлж дугаарласан болно. A). Голдоо чулуугүй, дугуй хэлбэрийн дараастай булш. Уг дурсгалын зүүн талд зарим дараас чулууг авч овоолжээ. Хэмжээ 3.6 м. B). Өмнөх дурсгалын баруун талд нь наалдсан голдоо чулуугүй, дугуй хэлбэрийн дараастай булш бий. Хэмжээ 2.4 м. C). Өмнөх дурсгалын баруун талд нь наалдсан голдоо чулуугүй, дугуй хэлбэрийн дараастай булш бий. Хэмжээ 3.4 м. D). Өмнөх дурсгалын баруун талд нь наалдсан голдоо чулуугүй, дугуй хэлбэрийн дараастай булш бий. Хэмжээ 1.5 м. I). Өмнөх дурсгалын баруун талд нь наалдсан голдоо чулуугүй, дугуй хэлбэрийн дараастай булш бий. Хэмжээ 4.0 м

1-40. Хадны зургийн дурсгал.

1-41. Хадны зураг бүхий уулын зүүн дор том чулуун дараастай, зууван дугуй булш буй. Хэмжээ 1.3х1.0 м.

1-42. Хойд болон урд хэсгээрээ том том чулуутай, дугуй дараас бүхий булш. Хэмжээ 2.9 м.

1-43. Өмнөх дурсгалаас баруун тийш 3 м зайд голдоо чулуугүй, дугуй хэлбэрийн дараастай булш бий. Хэмжээ 2.0 м.

1-44. Зүүн хойд талдаа бусдаасаа том нэг чулуутай, дугуй хэлбэрийн дараастай булш. Хэмжээ 3.0 м.

1-45. Өмнөх дурсгалаас баруун тийш холгүй голдоо чулуугүй, том том чулуун дараастай булш бий. Зарим дараас чулуудыг авч гадагш тавьсанаас хэлбэр тодорхойгүй болжээ.

1-46. Том хавтгай чулуудыг эгнүүлж босгон дөрвөлжин хашлага хийж, дотор талыг жижиг чулуудаар дүүргэжээ. Хойд хашлаганаас бусад нь мэдэгдэхгүй болсон байх ба томоохон хавтгай дээр нь 2 янгир, согоо дагуулсан буга, мөн үл мэдэгдэх дүрс сийлсэн байна. Хэмжээ 4.8х3.2 м.

1-47. Өмнөх дурсгалын хойно байх дөрвөлжин булшийг хашлага чулууны дотор талаар нь 1.8х0.8 м хэмжээтэй талбайгаар 90 см гүн хүртэл ухаж тоносон байна.

1-48. Өмнөх дурсгалын зүүн талд орших дөрвөлжин булшны хашлага чулуудыг авч шидсэн учир хэмжээ авах боломжгүй болжээ.

1-49. Хадны зургийн дурсгал.

1-50. Том том чулуун дараас бүхий дугуй хэлбэртэй булш. Зарим дараас чулуудыг авч баруун урд тал руу нь шиджээ. Хэмжээ 1.6 м.

1-51. Өмнөх дурсгалаас баруун урагш холгүйхэн том том чулуун дараас бүхий дугуй хэлбэртэй булш байх ба зарим дараас чулууг гадагш шидсэнээс зууван мэт болжээ. Хэмжээ 3.2х2.4 м.

1-52. Ноён сумаас Гурвантэс сум орох замд баруун хойноо овоотой уулын ард голд нь болон дөрвөн талд нь бусдаас том чулуун тавьсан бөгөөд дөрвөлжин хэлбэрийн дараастай булш.

**2-1**. Цогт-Овоо сумаас урагш Тахилт толгой хэмээх уулын урд энгэрт дугуй хэлбэртэй нэгэн булш бий. Голч 450 см.

**2-2**. Цогт-Овоо сумын Тахилт толгойн урд энгэрт нэгэн дөрвөлжин хэлбэртэй булш бий. Хэмжээ 550х300 см.

**2-3**. Цогт-Овоо сумын Тахилт толгойн баруун урд талд хоёр булш бий. 1-р булшны дараасны хэмжээ 300x200 см, 2-р булшны дараасны хэмжээ 600 см.

**2-4**. Цогт-Овоо сумын Тахилт толгойн урд талд барзгар хадтай уулын налуу энгэрт дугуй хэлбэртэй нэгэн булш бий.

**2-5**. Даланзадгад хотоос зүүн хойш орших Хан уул хэмээх тэгш оройтой том уулын баруун талд цуварсан гурван жижиг толгой бий. Энэхүү гурван толгойг Гурван шовгор хэмээн нутгийнхан нэрлэнэ. Уулыг тойруулан янз бүрийн хэлбэртэй чулуун байгууламжийг хийсэн байхаас гадна уулын орой дээрх хадан дээр хадны зураг сийлсэн байна.

**2-6**. Хан уулын баруун урд талд жалганы амсар дээр нэгэн булш бий.

**2-7**. Хан уулын баруун урд суганд гурван ширхэг жижиг зууван дугуй булш бий.

**2-8**. Даланзадгад хотоос баруун урагш орши Гурвансайханы нурууны баруун хойд төгсгөл хэсэгт уулын налуу энгэрт нэгэн булш бий.

**2-9**. Өмнөх дурсгалаас холгүй өөр нэгэн булш бий.

**2-10**. Хуурай сайрын эрэг дээр дөрвөлжин хэлбэрийн нэгэн чулуун байгууламж бий.

**2-11**. Гурвансайханы нурууны хойд энгэрт том дараас чулуутай жижиг хэмжээтэй дөрвөн чулуун байгууламж бий.  1-р чулуун байгууламж 400 см, 2-р чулуун байгууламж 250x400 см, 3-р чулуун байгууламж 350 см, 4-р чулуун байгууламж 650 см тус тус болно.

**2-12**. Гурвансайханы нурууны зүүн хойд энгэрт 18x20 м хэмжээтэй дөрвөлжин хүрээтэй, 12 м голчтой дугуй дараастай нэгэн хиргисүүр бий. Хиргисүүрийн хойд талдаа 6 ширхэг том дагуул байгууламжтай, баруун талдаа 7 ширхэг жижиг дагуул байгууламжтай.

**2-13**.  Хиргисүүр байсан энгэрийн баруун талд орших нарийн амын зүүн талаар олон тооны чулуун дарааст байгууламжууд бий. Дөрвөлжин хэлбэрийн чулуун байгууламж нь голдоо чулуугүй байх ажээ.

**2-14**. Намхан толгойн урд энгэрт зэрэгцээ хоёр дугуй булш байна. 1-р булшны хэмжээ 800x400 см, 2-р булшны голч 350 см тус тус болно.

**2-15**. Өмнөх дурсгалаас холгүйхэн нэгэн хиргисүүр бий. Дугуй хүрээтэй, голын овгор хүрээ рүүгээ шахсан байдалтай. Хүрээний голч 12 м, овгорын голч 9.5 м.

**2-16**. Дугуй хүрээтэй 500 см голчтой нэгэн булш бий.

**2-17**. Дугуй хүрээтэй, голдоо чулуугүй нэгэн булш бий. Голч 200 см.

**2-18**. Уулын урд энгэрт 180 см голчтой нэгэн чулуун байгууламж бий.

**2-19**. Хүрмэн сумын төвөөс 14 км зайд Гурвансайханы нурууны урд энгэрт нэгэн сүмийн турь бий.  Энэхүү сүмийг шаргал өнгийн түүхий тоосгоор хийсэн байна.

**2-20**. Хоёр намхан уулын хоорондох онь хөтөл дээр өргөргийн дагуу байрласан зэл чулуу бий. Зэл чулууны урт ойролцоогоор 120 м. Мөн түүний урд талд нь дугуй чулуун байгууламж, зүүн талд нь өөр нэгэн дөрвөлжин чулуун байгууламж бий.

**2-21**. Мандал-Овоо сум руу урд талаас нь орох замын зүүн талд 200х300 см хэмжээтэй нэгэн булш бий.

**2-22**. Булган сумаас чанх баруун тийш 50 орчим км зайд орших Хүрмэн дулаан уулын урд энгэрт олон тооны булш оршуулгын дурсгал бий. Үүнд, дугуй хүрээтэй хиргисүүр, хадны зураг, голдоо чулуугүй цагираг хэлбэрийн чулуун дараастай булш, хадны зураг, чулуун хороо зэрэг зүйлс багтана.

**2-23**. Сэврэй сумын зүүн талд орших Зөөлөнгийн нурууны энгэрт, Хонгорын элсний урд талд дугуй хүрээтэй нэгэн булш бий.

**2-24**. Сэврэй сумын баруун талд орших Тахилгат уулын урд энгэрт нэгэн булш бий.

**2-25**. Тахилгат уулын урд талд намхан толгойн урд зууван дугуй нэгэн булш бий.

**2-26**. Өмнөх булшнаас баруун хойш холгүйхэн өөр нэгэн дөрвөлжин хэлбэрийн нэгэн булш бий.

**2-27**. Тахилгат уулын урд намхан гүвгэрийн энгэрт дугуй хүрээтэй, голдоо чулуугүй нэгэн булш бий. Булшны голч 200 см.

**2-28**. Намхан уулын урд энгэрт том чулуугаар хүрээ хийсэн голдоо чулуугүй нэгэн булш бий.

**2-29**. Үйзэн хэмээх барсгар хадтай жижиг толгой дээр олон тооны хадны зураг бий.

**2-30**. Тахилгат уулын урд баруун тийш харсан жижиг дэл хаднаа цуварсан морьтой хүмүүсийг дүрсэлсэн хадны зураг бий. Нутгийнхан энэ дурсгалыг "Гурван баатарын зураг" хэмээн нэрлэнэ.

**2-31**. Сэврэй сумаас Ноён сум орох замын баруун талд том хэмжээтэй хүрмэн чулуугаар тойруулан хашлага хийсэн дөрвөлжин хэлбэрийн нэгэн булш бий.

**2-32**. Өмнөх дурсгалаас баруун урагш холгүй 350 м үргэлжилсэн зэл чулуу бий. Зэл чулууг хүрмэн чулуу ашиглан хийжээ.

**2-33**. Гурвантэс сумын зүүн талд уулын налуу энгэрт дөрвөлжин хэлбэрийн (шоргоолжин) нэгэн булш бий.

**2-34**. Гурвантэс сумаас урагш Тахилт уулын зүүн урд талд налуу энгэр дээр нэгэн булш бий.

**2-35**. Гурвантэс сумаас хойш гүн жалганы хойд эрэг дээр дугуй хүрээтэй хоёр булш бий. Уг хоёр булш нь голдоо чулуугүй, хотгор.

**2-36**. Булган сумын нутаг Баянзагийн неолитийн чулуун зэвсгийн суурин бий.

**2-37**. Булган сумын нутаг Цахиуртын хөндий хэмээх неолитийн үеийн чулуун зэвсгийн суурин бий.

**2-38**. Булган сумын нутагт Эрэгийн хоолой хэмээх неолитийн үеийн чулуун зэвсгийн суурин бий.

**2-39**. Хүрмэн сумын төвөөс урагш 20 гаруй км зайд намхан толгойн урд энгэрт өргөргийн дагуу цуварсан гурван ширхэг чулуун байгууламж бий. Чулуун байгууламжуудын нийт урт 700 см, өргөн 350 см.Өмнөх дурсгалаас холгүйхэн өөр нэгэн чулуун байгууламж байна. Дугуй дараастай, голдоо цөөн хэдэн чулуутай. Голч 150 см. Гүехэн жалганы баруун талд дөрвөлжин хашлагатай нэгэн чулуун байгууламж бий. Чулуун байгууламжийн хэмжээ 250х200 см. Хашлагыг үйлдэхдээ ойролцоох уулнаас авчирсан цагаан шаргал өнгийн хавтгай хадаар хийсэн байна.Өмнөх дурсгалаас 20 м зайтай тарсан дараас чулуутай дугуй чулуун байгууламж бий. Байгууламжийн хэмжээ 260х350 см. Уулын өвөрт налуу энгэр дээр дөрвөлжин хашлагатай нэгэн булш бий. Дараас чулуу нилээн эвдэрсэн боловч хэлбэр тодорхой мэдэгдэнэ. Хэмжээ 270х250 см.

## Хавсралт 2: Хайгуулын нэгдүгээр багийн илрүүлсэн дурсгалын товч мэдээлэл

| № | Дурсгалын дугаар | Дурсгалын хэлбэр | Хамаарагдах сум | Газрын нэр |
|---|---|---|---|---|
| 1 | 1-1 | Дугуй дараастай булш | Даланзадгад | Гурвансайхан |
| 2 | 1-2 | Дугуй дараастай булш | Даланзадгад | Гурвансайхан |
| 3 | 1-3 | - | Даланзадгад | Гурвансайхан |
| 4 | 1-4 | Дугуй дараастай булш | Даланзадгад | Гурвансайхан |
| 5 | 1-5 | Дугуй дараастай булш | Даланзадгад | Гурвансайхан |
| 6 | 1-6 | Дугуй дараастай булш | Даланзадгад | Гурвансайхан |
| 7 | 1-7 | - | Даланзадгад | Гурвансайхан |
| 8 | 1-8 | Дугуй дараастай булш | Хүрмэн | - |
| 9 | 1-9 | Дугуй дараастай булш | Хүрмэн | - |
| 10 | 1-10 | Дугуй дараастай булш | Баяндалай | - |
| 11 | 1-11 | Дугуй дараастай булш | Баяндалай | - |
| 12 | 1-12 | Дугуй дараастай булш | Баяндалай | - |
| 13 | 1-13 | Дөрвөлжин булш | Баяндалай | - |
| 14 | 1-14 | Дөрвөлжин булш | Баяндалай | - |
| 15 | 1-15 | Дөрвөлжин булш | Баяндалай | - |
| 16 | 1-16 | Дугуй дараастай булш | Баяндалай | - |
| 17 | 1-17 | Дугуй дараастай булш | Баяндалай | - |
| 18 | 1-18 | Дугуй дараастай булш | Баяндалай | - |
| 19 | 1-19 | Дугуй дараастай булш | Ноён | - |
| 20 | 1-20 | Дугуй дараастай булш | Ноён | Халбас |
| 21 | 1-21 | Дөрвөлжин булш | Ноён | Тахилга уул |
| 22 | 1-22 | Дугуй дараастай булш | Ноён | Тахилга уул |
| 23 | 1-23 | Хадны зураг | Ноён | Тахилга уул |
| 24 | 1-24 | Хадны зураг | Ноён | Тахилга уул |
| 25 | 1-25 | Дөрвөлжин булш | Ноён | Тахилга уул |

| № | Дурсгалын дугаар | Дурсгалын хэлбэр | Хамаарагдах сум | Газрын нэр |
|---|---|---|---|---|
| 26 | 1-26 | Дөрвөлжин булш | Ноён | Тахилга уул |
| 27 | 1-27 | Дөрвөлжин булш | Ноён | Тахилга уул |
| 28 | 1-28 | Дугуй дараастай булш | Ноён | Тахилга уул |
| 29 | 1-29 | Дугуй дараастай булш | Ноён | Тахилга уул |
| 30 | 1-30 | Зэл чулуу | Ноён | Тахилга уул |
| 31 | 1-31 | Дугуй дараастай булш | Ноён | Тахилга уул |
| 32 | 1-32 | Дугуй дараастай булш | Ноён | Тахилга уул |
| 33 | 1-33 | Дугуй дараастай булш | Ноён | Тахилга уул |
| 34 | 1-34 | - | Ноён | Тахилга уул |
| 35 | 1-35 | Дугуй дараастай булш | Ноён | Тахилга уул |
| 36 | 1-36 | Дугуй дараастай булш | Ноён | Тахилга уул |
| 37 | 1-37 | - | Ноён | Тахилга уул |
| 38 | 1-38 | Дугуй дараастай булш | Ноён | Тахилга уул |
| 39 | 1-39 | Дугуй дараастай булш | Ноён | Тахилга уул |
| 40 | 1-40 | Хадны зураг | Ноён | Тахилга уул |
| 41 | 1-41 | Дугуй дараастай булш | Ноён | Тахилга уул |
| 42 | 1-42 | Дугуй дараастай булш | Ноён | Тахилга уул |
| 43 | 1-43 | Дугуй дараастай булш | Ноён | Тахилга уул |
| 44 | 1-44 | Дугуй дараастай булш | Ноён | Тахилга уул |
| 45 | 1-45 | - | Ноён | Тахилга уул |
| 46 | 1-46 | Дөрвөлжин хашлагатай, хашлаган дээр зурагтай | Ноён | Тахилга уул |
| 47 | 1-47 | Дөрвөлжин | Ноён | Тахилга уул |
| 48 | 1-48 | Дөрвөлжин | Ноён | Тахилга уул |
| 49 | 1-49 | Хадны зураг | Ноён | Тахилга уул |
| 50 | 1-50 | Дугуй | Ноён | Тахилга уул |
| 51 | 1-51 | Дугуй дараастай булш | Ноён | Тахилга уул |
| 52 | 1-52 | Дөрвөлжин | Ноён | Тахилга уул |

| № | Дурсгалын дугаар | Дурсгалын хэлбэр | Хамаарагдах сум | Газрын нэр |
|---|---|---|---|---|
| | | хэлбэрийн булш | | |

Хавсралт 3: Хайгуулын хоёрдугаар багийн илрүүлсэн дурсгалын товч мэдээлэл

| № | Дурсгалын дугаар | Дурсгалын хэлбэр | Хамаарагдах сум | Газрын нэр |
|---|---|---|---|---|
| 1 | 2_1 | Дугуй дараастай булш | Цогт-Овоо | Тахилт толгой |
| 2 | 2_2 | Дөрвөлжин хэлбэртэй булш | Цогт-Овоо | Тахилт толгой |
| 3 | 2_3 | Дугуй болон дөрвөлжин дараастай хоёр булш бий. | Цогт-Овоо | Тахилт толгой |
| 4 | 2_4 | Дугуй дараастай булш | Цогт-Овоо | Тахилт толгой |
| 5 | 2_5_1 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 6 | 2_5_2 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 7 | 2_5_3 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 8 | 2_5_4 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 9 | 2_5_5 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 10 | 2_5_6 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 11 | 2_5_7 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 12 | 2_5_8 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 13 | 2_5_9 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 14 | 2_5_10 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 15 | 2_5_11 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 16 | 2_5_12 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 17 | 2_5_13 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 18 | 2_5_14 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 19 | 2_5_15 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 20 | 2_5_16 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 21 | 2_5_17 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 22 | 2_5_18 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 23 | 2_5_19 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 24 | 2_5_20 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 25 | 2_5_21 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 26 | 2_5_22 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 27 | 2_5_23 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 28 | 2_5_24 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 29 | 2_5_25 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 30 | 2_5_26 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 31 | 2_5_27 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 32 | 2_5_28 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 33 | 2_5_29 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 34 | 2_5_30 | Булш | Даланзадгад | Хан уул |

| № | Дурсгалын дугаар | Дурсгалын хэлбэр | Хамаарагдах сум | Газрын нэр |
|---|---|---|---|---|
| 35 | 2_5_31 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 36 | 2_5_32 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 37 | 2_5_33 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 38 | 2_5_34 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 39 | 2_5_35 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 40 | 2_5_36 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 41 | 2_5_37 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 42 | 2_5_38 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 43 | 2_5_39 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 44 | 2_5_40 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 45 | 2_5_41 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 46 | 2_5_42 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 47 | 2_5_43 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 48 | 2_6 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 49 | 2_7 | Булш | Даланзадгад | Хан уул |
| 50 | 2_8 | Булш | Даланзадгад | Гурвансайхан |
| 51 | 2_9 | Булш | Даланзадгад | Гурвансайхан |
| 52 | 2_10 | Булш | Даланзадгад | Гурвансайхан |
| 53 | 2_11 | Дөрвөлжин хэлбэрийн булш | Даланзадгад | Гурвансайхан |
| 54 | 2_11_1 | Булш | Даланзадгад | Гурвансайхан |
| 55 | 2_11_2 | Булш | Даланзадгад | Гурвансайхан |
| 56 | 2_11_3 | Булш | Даланзадгад | Гурвансайхан |
| 57 | 2_11_4 | Булш | Даланзадгад | Гурвансайхан |
| 58 | 2_12 | Хиргисүүр | Даланзадгад | Гурвансайхан |
| 59 | 2_13_1 | Чулуун байгууламж | Даланзадгад | Гурвансайхан |
| 60 | 2_13_2 | Чулуун байгууламж | Даланзадгад | Гурвансайхан |
| 61 | 2_13_3 | Чулуун байгууламж | Даланзадгад | Гурвансайхан |
| 62 | 2_14 | Дугуй болон дөрвөлжин дараастай булш | Даланзадгад | Гурвансайхан |
| 63 | 2_15 | Хиргисүүр | Даланзадгад | Гурвансайхан |
| 64 | 2_16 | Дугуй хүрээтэй чулуун байгууламж | Даланзадгад | Гурвансайхан |
| 65 | 2_17 | Дугуй хүрээтэй чулуун байгууламж | Даланзадгад | Гурвансайхан |
| 66 | 2_18 | Чулуун байгууламж | Даланзадгад | Гурвансайхан |
| 67 | 2_19 | Сүмийн турь | Хүрмэн | Гурвансайхан |
| 68 | 2_20 | Зэл чулуу | Хүрмэн | Гурвансайхан |
| 69 | 2_21 | Булш | Мандал-Овоо | - |
| 70 | 2_22_1 | Хиргисүүр | Булган | Хүрмэн дулаан уул |
| 71 | 2_22_2 | Хадны зураг | Булган | Хүрмэн дулаан |

| № | Дурсгалын дугаар | Дурсгалын хэлбэр | Хамаарагдах сум | Газрын нэр |
|---|---|---|---|---|
| | | | | уул |
| 72 | 2_22_3 | Булш | Булган | Хүрмэн дулаан уул |
| 73 | 2_23 | Дугуй дараастай булш | Сэврэй | Зөөлөнгийн нуруу |
| 74 | 2_24 | Булш | Сэврэй | Тахилгат |
| 75 | 2_25 | Булш | Сэврэй | Тахилгат |
| 76 | 2_26 | Дөрвөлжин хэлбэрийн булш | Сэврэй | Тахилгат |
| 77 | 2_27 | Булш | Сэврэй | Тахилгат |
| 78 | 2_28 | Булш | Сэврэй | Тахилгат |
| 79 | 2_29 | Хадны зураг | Сэврэй | Тахилгат/Үйзэн |
| 80 | 2_30 | Хадны зураг | Сэврэй | Тахилгат |
| 81 | 2_31 | Дөрвөлжин хэлбэрийн булш | Сэврэй-Ноён | - |
| 82 | 2_32 | Зэл чулуу | Сэврэй-Ноён | - |
| 83 | 2_33 | Дөрвөлжин (шоргоолжин) | Гурвантэс | - |
| 84 | 2_34 | Булш | Гурвантэс | Тахилгат |
| 85 | 2_35 | Дугуй хүрээтэй хоёр булш | Гурвантэс | Тахилгат |
| 86 | 2_36 | Чулуун зэвсгийн суурин | Булган | Баянзаг |
| 87 | 2_37 | Чулуун зэвсгийн суурин | Булган | Цахиуртын хөндий |
| 88 | 2_38 | Чулуун зэвсгийн суурин | Булган | Эрэгийн хоолой |
| 89 | 2_39_1 | Булш | Хүрмэн | - |
| 90 | 2_39_2 | Булш | Хүрмэн | - |
| 91 | 2_39_3 | Булш | Хүрмэн | - |
| 92 | 2_39_4 | Булш | Хүрмэн | - |
| 93 | 2_39_5 | Булш | Хүрмэн | - |
| 94 | 2_39_6 | Булш | Хүрмэн | - |

## Дүгнэлт

Энэхүү хээрийн судалгааны явцад Цогт-Овоо, Даланзадгад, Ханхонгор, Хүрмэн, Баяндалай, Булган, Сэврэй, Ноён, Гурвантэс гэсэн 9 сумын нутгаас нийт 146 дурсгал илрүүлэн олов. Эдгээр дурсгалууд нь Говь-Алтайн нурууны зүүн төгсгөл хэсэгт буюу Булган, Баяндалай, Даланзадгад, Хүрмэн сумыг дамнан орших Гурвансайханы нуруу, Сэврэй, Баяндалай сумын нутагт орших Зөөлөнгийн нуруу, Ноён, Гурвантэс сумын нутагт орших Тосон бумбын нуруу, Эрдэнэ нуруу, Гурвантэс сумын нутагт орших Нэмэгтийн нурууны салбар уулсаар оршино. Энэ нь бидний урьдчилан боловсруулсан загвартай зарим талаар тохирч байснаас гадна дээрх 9 сумын 5 суманд Тахилгат, Тахилга гэсэн нэртэй уул байгааг анзаарч эдгээрийг шалгахад 4 тохиолдолд олон тооны археологийн дурсгалтай болох нь тогтоогдсон юм. Цаг агаарын байдлаас шалтгаалан Ханхонгор сумын нутагт буй Тахилга уулыг энэ удаад шалгаж чадсангүй.

Бидний хайгуулын ажил нь цаг хугацааны хувьд ялимгүй оройтож, уулархаг газруудаар цас үргэлжлэн орсон тул нарийвчлан шалгах боломжгүй байснаас гадна нийт үргэлжлэх хугацаа бага байсныг энд дурдах нь зүйтэй. Энэ байдалтай уялдуулан хайгуулын арга зүйг нэн энгийн буюу машинаар хийх арга зүйг сонгон ажилласан ч чамлахааргүй үр дүн гарлаа.

Говийн бүсэд археологийн дурсгалын тархалт харьцангүй таруу байдаг нь газарзүйн орчинтой шууд холбоотой боловч дурсгалууд нь томоохон уул, нуруу, тогтмол болон ширгэдэг гол, нуур, худаг усны ойролцоо байгааг өөрсдийн урьдчилсан таамаг судалгаа, биечлэн хийсэн хайгуулын явцад тодорхой болгов. Эдгээрээс цаашид суурь судалгааны ажлыг үргэлжлүүлэн сумын болон аймгийн тусгай хамгаалалтанд авахаар олон дурсгалтай газрууд нилээд хэд бий. Үүнд, Даланзадгад сумын нутаг орших Хан уулын орчмын хүрэл зэвсгийн үед холбогдох дурсгалууд, Гурвансайханы нурууны зүүн умард талын хүрэл зэвсгийн үед холбогдох хиргисүүрийн цогцолбор дурсгал, Сэврэй сумын Тахилт буюу Үйзэнгийн хадны зураг, Ноён сумын Тахилт орчимын хадны зургууд багтаж байна (Хавсралт зураг 1-23, 1-40, 1-49, 2-29, 2-30-1, 2-30-2). Говийн бүс нутагт хадны зургийн дурсгал нилээд элбэг тархсан байдаг боловч бидний олсон зарим нь дүрслэл, арга барилын хувьд нилээд онцлогтой Баруун Алтайн бүс нутгийн хадны зургийн дурсгалуудтай ижил байгааг тэмдэглэх нь зүйтэй.

Бидний тэмдэглэсэн дурсгалуудаас хамгийн сонирхол татаж байгаа зүйл бол Гурвансайханы нурууны хиргисүүрийн дурсгал юм (Хавсралт зураг 2-15). Энэхүү дурсгал нь МЭӨ II мянган жилийн дунд үеэс МЭӨ I мянганы дунд үед холбогдох бөгөөд тархалтын хүрээ нь Өмнөд Сибирь, Уулын Алтай, Төв Монголын нутгийг хамаарна.

Говийн бүс нутагт хиргисүүрийг бүтээгчид амьдарч байгаагүй бөгөөд энэ бүс нутагт тухайн үед өөр овог аймгууд амьдарч байсан хэмээн судлаачид үздэг байна. Ийнхүү Гурвансайханы нуруунд гадаад хэлбэрийн хувьд бусад бүс нутгийн хиргисүүртэй ижил дурсгал байгаа нь тухайн дурсгалын тархалтыг нилээд өмнөд тал руу тэлж өгч байна.

**Хавсралт 4: Нэгдүгээр багийн илрүүлсэн дурсгалын гэрэл зураг**



1-01



1-02



1-03



1-04





1-05

1-06





1-07

1-08





1-03

1-10





1-11

1-12



1-13



1-14



1-15




1-16




1-17




1-18




1-19



1-20



1-21




1-22



1-23



1-24



1-25



1-26



1-27



1-28



1-29



1-30



1-31



1-32



1-33



1-34




1-35




1-36



1-37



1-38



1-39



1-40




1-41




1-42



1-43



1-44



1-45



1-46



1-47



1-48



1-49




1-50



1-51



1-52

**Хавсралт 5: Хоёрдугаар багийн илрүүлсэн дурсгалын гэрэл зураг**



2-1



2-2



2-3



2-4





2-5

2-6





2-7

2-8





2-9

2-10





2-11-1

2-11-2



2-11-3



2-11-4



2-11-5



2-12



2-13



2-14



2-15



2-16



2-17



2-18



2-19



2-20



2-21



2-22 Дурсгалын ерөнхий байдал



2-22-1



2-22-2



2-22-3



2-22-4



2-23



2-24



2-25



2-26



2-27



2-28



2-29



2-30-1



2-30-2



2-31



2-32



2-33



2-34



2-35



Баянзагийн чулуун зэвсгийн суурин 2-37



Эрэгийн хоолойн чулуун зэвсгийн суурин 39-1



39-2



39-3



39-4



39-5

# 14. ХАВСРАЛТ 5. СОЁЛЫН ӨВИЙН ДУРСГАЛ ОЛДОХ ҮЕД БАРИМТЛАХ ЖУРАМ

Оюу Толгой ХХК нь Оюу Толгой төсөл хэрэгжиж байгаа нутаг дэвсгэр дээр буй түүх, соёлын уламжлалт өв соёл, ялангуяа нутгийн иргэдийн өв соёлд чухал ач холбогдол өгч, хүндэтгэн үздэг.

Оюу Толгой ХХК нь уул уурхайн олборлолтын бүхий л үе шатанд тухайн нутаг дэвсгэрт буй түүх-соёлын дурсгалт газар, үнэт зүйлсийг хадгалж хамгаалж, сэргээн засварлах үүрэг хүлээсэн бөгөөд ингэхдээ нутгийн иргэд, бусад оролцогч талуудын холбоо харилцааг бэхжүүлж, холбогдох хууль, тогтоомжийг дагаж мөрдөнө.

Тиймээс тус компани соёлын өвийг үнэлэх, хадгалж хамгаалахад дотоод менежментийн бүтэц, олон нийтийн хөтөлбөрийг багтаасан Соёлын өвийн менежментийн цогц тогтолцоо (СӨМЦТ) боловсруулан хэрэгжүүлж байна. Энэхүү Соёлын өвийн олдвор олдох үед баримтлах журам нь СӨМЦТ-ний нэг хэсэг юм.

### Зорилго

Өмнө нь бүртгэгдээгүй бөгөөд Оюу Толгой төслийн бүтээн байгуулалтын ажлын явцад илэрсэн соёлын өвийн дурсгалууд, ялангуяа археологийн болон палеонтологийн дурсгалт зүйлсийг устгаж гэмтээлгүй, аварч хамгаалах, хуулийн дагуу зохих арга хэмжээ авах.

### Хамрах хүрээ

Энэхүү журам нь газар хөндөж байгаа аливаа ажиллагааг оролцуулаад Оюу Толгой төслийн бүх шатанд мөрдөгдөнө. Тухайлбал, уул уурхайн ашиглалтын талбай (хашаан дотор), бусад дэд бүтэц, тухайлбал,

- Ус дамжуулах шугам
- Зам
- Эрчим хүч дамжуулах шугам
- Онгоцны буудал
- Хайгуул хийгдэж буй талбай

Энэ журмыг бүх ажил олгогчид болон гүйцэтгэгчид мөрдөнө.

## 1. Соёлын өвийн илэрч болон төрлүүд болон олдож болох байршил

Оюу Толгой төслийн бүсэд 100 гаран археологийн дурсгал олдоод байна. Эдгээр дурсгалуудыг дараах 7 төрөлд хувааж болно:

1. Чулуун зэвсгийн үеийн дурсгалууд
2. Чулуун хөшөөнүүд
3. Чулуун байгууламжууд (дөрвөлжин, гурвалжин, бөөрөнхий зэрэг)
4. Ваарны хагархай
5. Хасын төрлийн гялгар гөлгөр бутархай чулуунуудын бөөгнөрөл
6. Чулуун овоо
7. Бүртгэгдсэн болон бүртгэгдээгүй чулуун дурсгал

Археологийн дурсгалууд нь голын эрэг, горхины цутгал зэрэг усны олдоц бүхий газраас ихэвчлэн олддог. Мөн улирлын болон түр  зуурын чанартай жижиг нуурын эрэг орчмоор олддог. Гантиг, цахиур, хас зэрэг сайн чанарын чулуулаг бүхий газрууд нь эртний хүмүүсийн үлдээсэн дурсгалт зүйлсээр арвин байдаг. Эцэст нь байгалийн алслагдмал болон өвөрмөц тогтоц (мөсөн уул, өнгөт хад, агуй зэрэг) нь монголчуудад чухал ач холбогдолтой. Тухайн газар нутгийг тэмдэглэх зорилгоор Овоо босгодог бөгөөд Буддын шашны хувьд чухал ач холбогдолтой бөөгийн зан үйл хийгддэг.

Оюу Толгой төслийн газар нутагт ихэвчлэн палеонтологийн дурсгал олддог. Эдгээр үлдэгдлүүд нь цагаан хөх, цар бор болон үнсэн саарал өнгөтэй жижиг толгод, намхан цохиог үүсгэсэн байдаг. Нийт зузаан нь 20-50 м байдаг. Эдгээр үлдэгдлүүд нь бусад геологийн тогтоцуудтай үелж тогтсон байдаг. Динозаврын үений яс болон бусад сээр нуруутнууд нь эдгээр геологийн тогтолцуудтай хамт оршдог. Зарим элсэн тогтоцууд нь динозавр, яст мэлхий зэрэг янз бүрийн сээр нуруутнуудын ясны үлдэгдлүүдийг агуулсан байдаг.

Энэхүү газар нь динозаврын дурсгал оршиж байдгаараа өвөрмөц юм. Динозаврын өндөгний хальсны үлдэгдэл, матрын яс, яст мэлхийн бүрхүүл нь энэ бүс нутагт ихээхэн тааралддаг. Сээр нуруутан болон сээр нуруугүй амьтдын үлдэгдэл балар эртнийх байдаг.

Оюу толгой төслийн газар нутагт байж болох сээр нуруутнууд:

Орнитопод – хоёрдогч хадрозауройд

Сигнозаур - (*Enigmosaurus mongoliensis, Erlikosaurus andrewsi, Segnosaurus galbinensis*)

Dromaeosaurid (*Achillobator giganticus*)

Ornithomimid (*Garudimimus brevipes*)

Sauropoda- fam.gen.et sp. Indet and *Quaesitosaurus orientaslis*

Ankylosauria (*Talarurus plicatospineus*)

Dinosaur eggs and nest (Elongatoolithid oomorph, Dictyoolithid oomorph)

Сээр нуруутан, сээр нуруугүй болон ургамлын чулуужсан үлдэгдлүүдээр арвин байдаг Доод цэрдийн үеийн дурсгалдууд Манлай сумын төвөөс зүүн хойд зүгт 6 км-т оршдог. Эдгээр нь шувууны өд, шавьж, навчин хөлтэй хавч, загас, болон ургамлын чулуужсан үлдэгдлээр элбэг байдаг. Загасны чулуужсан үлдэгдэл мөн энд хадгалагдаж байдаг бөгөөд эдгээр амьтдын биеийн зөөлөн хэсэг нь занаран суурин дээр наалдсан байдаг. Динозаврын хөлийн мөр энд мөн элбэг байдаг бөгөөд хэлбэр, хэмжээ нь янз бүр байдаг.

## 2. Үр нөлөө

Газар шорооны бүх төрлийн үйл ажиллагаа нь археологийн болон палеонтологийн дурсгалуудад нөлөөлж болно. Эдгээр үйл ажиллагаа гэдэгт, нь уул уурхай болон, түүний хүрээнд баригдсан дэд бүтэц (амьдрах байр, авто зам, төмөр зам, усны суваг, муу усны хоолой болон дамжуулах шугам), геологийн өрөмдлөг, ус гаргах, хог хаягдал зайлуулагч, өрөмдөх, малтах зэрэг хайгуулын үйл ажиллагаа зэргийг хамруулна.

## 3. Холбогдох хууль, журам

Энэхүү журам нь СӨМЦС-ийн нэг хэсэг бөгөөд дараах үндэсний болон олон улсын хууль тогтоомжинд нийцүүлэн гаргасан болно.

Олон Улсын:

- НҮБ-ын харт, конвенц
- ОУВС-гийн стандарт 8: Соёлын өв ба удирдамж

Үндэсний хууль:

- Соёлын өвийн хууль, 1996
- Соёлын өвийг хамгаалах хууль 2004

- Эрдэс баялгийн тухай хууль, 2009
- Газрын баялгийн тухай хууль, 1988
-

## 4. Хариуцлага

Энэхүү журмыг СӨМЦС-ийн хүрээнд Олон нийтийн харилцаа болон тогтвортой хөгжлийн (ОНХТХ) хэлтсээс боловсруулан мөрдүүлж байгаа бөгөөд Оюу Толгой төслийн хүрээнд бүртгэгдээгүй байгаа соёлын өвийн менежментийн стандарт юм.

ОНХТХ-ийн хэлтсийн ахлах менежер нь энэхүү журмыг оруулан СӨМЦС-ийг хэрэгжүүлэх үүрэг хүлээнэ.

Оюу Толгой ХХК-ийн Гүйцэтгэх захирал нь энэхүү журмыг баталж, Оюу Толгой төсөл дээр ажиллаж байгаа ажил олгогчид, гүйцэтгэгчид энэхүү журмын хүрээнд хүлээсэн үүргээ нийтээрээ дагаж мөрдөж байгаа эсэхийг хариуцна.

Төслийн менежментийн баг нь Оюу Толгой төсөл дээр ажиллаж байгаа бүх ажил олгогчид, гүйцэтгэгчид энэхүү журмын хүрээнд хүлээсэн үүрэг хариуцлагаа ухамсарлаж, дагаж мөрдөж байгаа эсэхийг хянах үүрэгтэй. Мөн ОНХТХ-ийн хэлтсийг удирдлага, зохион байгуулалтаар хангана.

Энэ журмын хүрээнд тодорхойлогдсон үйл ажиллагааг газар дээр нь хэрэгжүүлэхийг ОНХТХ-ийн хэлтсийн Соёлын өвийн хөтөлбөрийн зохицуулагч хариуцна.

## 5. Ажилчид, гүйцэтгэгчдийг сургах

Соёлын өвийг хамгаалах хууль болон Соёлын өвийн олдвор олдох үед баримтлах журмыг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагын талаар анхан шатны мэдлэг олгох сургалтыг бүх ажилтнуудад олгоно. Соёлын өвийг олж тогтоох болон энэхүү журмыг ашиглах талаар төслийн ажилчид, гүйцэтгэгчдэд тусгай сургалт явуулна.

1. Газар шороонь ажилд оролцож байгаа бүх ажилтнууд болон удирдагчид
2. ОНХТХ болон байгаль орчны ажилтнууд

Сургалт нь дараах сэдвийг хамарна:

- Соёлын өвийн дурсгал, түүний байршлыг тогтоох
- Соёлын өвийн олдвор олдох үед баримтлах журам
- Соёлын өв болон түүнийг сүйтгэсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлагын талаар холбогдох хуулийн тайлбар.

6. **Хэрвээ Соёлын өвийн олдвор олдвол**: (Хүснэгт хавсаргав)
   - Газар шорооны ажилчид олдвор олдсон тохиолдолд ажиллагаагаа зогсоож, удирдлагадаа шуурхай мэдэгдэх нь зүйтэй.
   - Удирдлага нь 24 цагийн дотор ОНХТХ-ийн хэлтсийн болон СӨХ-ийн зохицуулагч (О. Цэрэннадмид), "Оюу Толгой" төслийн байгаль орчны байцаагч (С. Дорждэрэм) нарт мэдэгдэнэ. Мэдээлэл нь дараах зүйлсийг агуулсан байна:
     - Соёлын өвийн дурсгалын төрөл (тодорхойлолт, зураг)
     - Байршил (GPS координатуудын тодорхойлолт)
     - Өдөр, хугацаа, тайлагнаж буй хүний мэдээлэл
     - Соёлын өвийн олдвор олдох хийгдэж байсан ажлын мөн чанар
   - Байгаль орчны ажилтан болон СӨХ-ийн зохицуулагч нь Соёлын өвийн олдвор олдсон газрын эргэн тойронд 30 метрээс дотогш хүн нэвтрүүлэхгүй байх
   - Талбайд машинтай орохыг хориглох. Энэхүү журмыг хэрэгжүүлэх үүднээс л зөвхөн нэвтэрнэ.
   - Нэвтрэхийг хориглосон талбайд соёлын өвийн мэргэжилтнүүд дүгнэлт гаргах хүртэл аливаа үйл ажиллагаа эрхлэхийг хориглох
   - Тухайн газар дээр ажилласны дараа Соёлын өвийн зохицуулагч и-мэйлээр ОНХТХ-ийн хэлтсийн ахлах менежер болон Төслийн менежментийн багт мэдэгдэх. Мөн орон нутгийн удирдлага, цагдаагийн хэлтэст мэдэгдэж утсаар нэг өдрийн дотор, албан бичгээр 1-2 ажлын өдрийн дотор мэргэжлийн байгууллагаас судлаачдыг дуудах.

## 7. Соёлын өвийн өндөр мэдрэмжтэй бүс нутаг

Соёлын өвийн дурсгал байж болох өндөр болон дунд зэргийн магадлалтайг нь тогтоосон төслийн бүс нутгуудын хувьд "Оюу Толгой" ХХК нь газар шорооны ажилд хяналт тавих чадварлаг археологич, эсвэл палеонтологичийг томилон ажиллуулна. Энэ хүрээнд соёлын өв хадгалагдаж байгаа болон хадгалж байх магадлалтай бүс нутагт газар шорооны ажлыг зогсоох эрхтэй.

## 8. Оршуулгын газар, хүний араг яс, оршуулгын эд зүйлс

Хүний араг ясыг онцгойлон үзнэ. Тухайн хүний амьдарч байсан үеийг тогтоох оролдогыг хийнэ. Хэрвээ тийм зүйл олдвол, түүнийг устгалгүй судлах боломжийг олгоно. Гарал үүслийг нь тогтоосны дараа уг оршуулга болон холбогдох эд зүйлсийг шилжүүлэн байрлуулах боломжийг зөвлөлдөнө. Хэрвээ 5 өдрийн дотор гарал үүсэл нь тогтоогдохгүй бол энэхүү дурсгалыг “Оюу Толгой” төслийн аюулгүй бүсэд шилжүүлж, хадгална. Хэрвээ 30 өдрийн дотор олдохгүй бол түүнийг балар эртний үе (тухайлбал, Хүрлийн үе) гэж үзнэ. Энэхүү дурсгал болон холбогдох эд зүйлсийг ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн холбогдох дүрэм журмын дагуу хадгалж хамгаална.

## 9. Шийтгэл

Энэхүү журмыг дагаж мөрдөөгүй тохиолдолд дараах шийтгэл оногдуулна:

Хувь хүн:

- Эхний шийтгэл – Албан ёсны сануулга
- Хоёрдахь шийтгэл – нэг долоо хоногоор хорих
- Гуравдахь шийтгэл – ажлаас халах

Хувь хүн нь эртний эд өлгийн зүйлсийг (археологийн болон палеонтологийн) хууль бусаар авбал, түүнийг нэн даруй ажлаас халах бөгөөд холбогдох эрүүгийн болон иргэний хуулийн дагуу зохих байгууллагад шилжүүлнэ.

Гүйцэтгэгч :

Эхний шийтгэл – албан ёсны сануулга

Хоёрдахь шийтгэл – 5,000 ам.долларын торгууль

Гуравдах шийтгэл – Гэрээг цуцлах

## 15.ХАВСРАЛТ 6: ПАЛЕОНТОЛОГИЙН ХЭЭРИЙН АЯЛЛЫН ТАЙЛАН

Оюу толгойн Соёлын өвийн хөтөлбөр боловсруулах ажлын хүрээнд биет өвийн судалгааны палеонтологийн хэсгийн хээрийн судалгааг зохион байгуулсан болно. Судалгааны багийн бүрэлдэхүүнд ШУА-ийн Палеонтологийн төвийн лабораторийн эрхлэгч, доктор професор Х. Цогтбаатар, эрдэм шинжилгээний дэд ажилтан, магистр Ц. Чинзориг, туслах ажилтан бөгөөд жолоочоор Б. Майнбаяр, Ч. Баярдорж нар багтан ажиллав. Хээрийн судалгааг 2011 оны 4 сарын 22-ноос 2011 оны 5 сарын 5 хүртэл нийт 14 хоног Оюу толгой төслийн шууд болон шууд бус нөлөөллийн бүс болох Ханбогд, Баян-Овоо, Манлай, Булган сумдын нутгаар явуулав.

### 1. Ханбогдын районд хийсэн судалгаа:

Палеонтологийн олдворт газар нь Монгол улсын хамгаалалтад байх түүх соёлын үл хөдлөх дурсгалд ордог бөгөөд Байшин цав, Хуурай цав, Өрөлбэ, Амтгай, Шар цав зэрэг олдворт газрууд нь Монгол Улсын Засгийн газрын 2008 оны 175 дугаар тогтоолоор Улс, аймаг, нийслэлийн хамгаалалтад байх түүх соёлын үл хөдлөх дурсгалын жагсаалтад орсон газрууд юм. Палеонтологийн олдворт газрууд нь археологийн дурсгалт газраас өргөн уудам талбайг хамарсан байдаг, олдвор нь жилээс жилд илэрч гарсаар байх магадлал өндөртэй, өнөөдөр илрээгүй байвч маргааш олдвор олдох боломжтой байдаг зэрэг онцлогтой. Мөн олдвор агуулагч хурдсын үе давхаргын унал ба суналт (dip and strike)-аас үүдэлтэй олдвор агуулагч үе нь газрын гадаргууд ойр, эсвэл газрын гүнд байх тохиолдол элбэг байдаг. Энэ онцлогоос шалтгаалж палеонтологийн эрэл хайгуул нь хугацаа зарцуулж, нэг газрыг олон дахин шинжилж байж дүгнэлт гаргахыг шаарддаг.

Оюу толгой төслийн үйл ажиллагаа явуулж байгаа газраас хамгийн ойр орших Өрөлбэ худаг орчмын олдворт газрууд болон түүний орчмын илэрцүүдэд судалгаа явуулав. Энэ бүсэд илэрсэн тунамал хурдсын бүх илэрцүүдэд гүймэл эрэл хайгуул хийж, эртний амьтны зарим нэгэн чулуужсан олдворыг олж илрүүлэв.

Богино хугацаанд гадаргуугийн эрэл хайгуул хийхэд гадрозавройд, алектрозавр зэрэг үлэг гүрвэл, эртний матарын толгойн ясны хэсэг зэрэг олдож байгаа нь цаашид олдвор илрэх өндөр боломжтой, өмнөх жилүүдэд ажиллаж байх үетэй харьцуулахад олдворын илэрц эрс нэмэгдсэн болох нь тогтоогдож байна.

Оюу толгойн Соёлын өвийн ажилтнаас авч үзсэн дэд бүтцийн ус хангамжийн шугам хоолойн зургаас харахад энэ олдворт газар нь Гүний хоолойн ус дамжуулах хамгийн зүүн үзүүрийн цооног болон насос станц байгуулахаар төлөвлөж байгаа газарт хамрагдаж байна. Энэ олдворт газар нь дээр дурдсан улсын хамгаалалтад бүртгэгдсэн палеонтологийн үл хөдлөх дурсгалд багтдаг байна.

Өрөлбэ орчмын олдворт газрын хамгаалалтын бүсийн хилийн цэгийг тогтоов.

**Байшин цав**

Энэ олдворт газар давтан эрэл хайгуулыг хийж, шинээр илэрсэн олдворуудыг шалгаж, хамгаалалтын хил хязгаарыг тогтоов. Эндээс орнитомимозавр, гадрозавройдын олдвор илэрсэн байсныг нь заримыг нь бэхжүүлэлт хийж, буцааж булж хадгалсан болно.

**Хуурай цав**

Энэ олдворт газар нь дээрх Байшин цав олдворт газраас холгүй орших бөгөөд энд мөн эрэл хайгуул хийж, уг олдворт газрын өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийлээ. Эндээс мөн үлэг гүрвэлийн гол төлөөлөгчдийн чулуужсан ясны олдвор ихээр илэрсэн байна. Бэхжүүлэлт хийж, буцааж булж хадгалав.

**Шар цав**

Үлэг гүрвэлийн гишгэж үлдээсэн мөр хадгалагдсан газар. Энэ олдворыг 1995 онд анх олж нээснээс хойш газар дээр нь хамгаалж чадаагүйгээс хүний болон байгалийн хүчин зүйлээр элэгдэж, эвдэрч хэмхэрсэн байна. Нэг хэсэг ойр орчмын суурин газруудаас хүн ихэд очиж үздэг байсан бөгөөд хамгаалалтын асуудлыг шийдтэл хүн очуулахгүй байх орон нутгийн шийдвэр гарсан болովч одоо хэр хүн тасардаггүй бололтой.

**Амтгай**

Уг олдворт газрын хамгаалалтын бүсийн хилийн цэгийг тогтоов.

**Их шунхат**

Энэ олдворт газар нь насны хувьд энэ бүс нутаг дахь бусад олдворт газруудаас илүү залуу цаг үеийнх гэж үздэг. Эндээс бусад олдворт газруудтай харьцуулахад олдвор ховор боловч олдож байсан олдвор нь маш сонирхолтой. Говийн бүсийн баруун хэсгээс олддог үлэг гүрвэл олддог.

**Оюу толгой орчимд хийсэн хайгуул судалгаа.**

Оюу толгойн одоо байгаа хашааны гадна талаар эргэн тойронд нь палеонтологийн эрэл хайгуул хийв. Хаягдлын далан хийх ажил явагдаж байгаа газрын улаан хүрэн өнгөтэй хурдасны асгадсаас эртний амьтны олдворыг тохиолдлоор олж илрүүлэв. Уг даланг машинтай тойрч явж байгаад ганцхан цэг дээр зогсч эрэл хийхэд хүнд механизмаар ухаж, ачиж, зөөж, түрж бий болгосон далангийн шорооны бутарсан хэсгээс хоёр ч удаа эртний амьтны чулуужсан олдвор олдсон нь анхаарал татаж байна.

Олдсон олдворыг технологийн дагуу гипсэн ороолт хийж (gyptape) авлаа. Уг олдворыг ШУА-ийн Палеонтологийн төвийн лабораторид техник боловсруулалтыг 5 өдрийн туршид хийж, эртний амьтны чулуужсан ясыг эх хурдаснаас нь салгах ажлыг гүйцэтгэв.

Боловсруулалтын ажлын дараа уг олдвор нь жижиг махан идэшт үлэг гүрвэлийн хойд хөлний метатарзалын дистал хэсэг, хурууны үеүд, зарим хумсны хамт гарсан байна. Уг олдворыг цаашид нарийвчлан харьцуулах судалгаа хийх шаардлагатай. ОТ сайтын газар шорооны ажил хийгдэж байгаа газруудын өнгөн хөрсний 1-19 метрийн гүн дэх улаан, улаан хүрэн өнгийн шаварлаг элсжингийн үеэс үлэг гүрвэлийн олдвор гарах өндөр магадлалтай гэж үзэж байна.

**Баян-Овоогийн Налих дахь чулуужсан модны олдворт газар**

Налих орчмын чулуужсан модны олдворт газар эрэл хайгуул хийж, хэд хэдэн газар том хэмжээтэй чулуужсан мод хадгалагдсан болохыг тогтоосон бөгөөд илрүүлэлт хийхэд сонирхолтой олдвор олдох бүрэн бололцоотой.

**Налих**

Баян-Овоо сумын төв дээр үзмэр болгон байрлуулсан аварга том мод олдсон.
Чулуужсан модны олдворт газрын хамгаалалтын бүсийн хилийн цэгийг тогтоов.

**Баян заг, Төгрөгийн ширээ орчимд хийсэн хайгуул судалгаа**

Эдгээр олдворт газруудад дахин эрэл хайгуул хийж, үндсэн болон ойр орчмын илэрцүүдийн тархалтын хил заагийг тогтоох ажлуудыг хийлээ. Уг ажлыг гүйцэтгэж байх явцад хэд хэдэн газраас эртний амьтны чулуужсан олдворыг олж илрүүлсэн бөгөөд авран хамгаалах шаардлагатай зарим олдворыг малтлага хийж авав. Хээрийн судалгааны явцад Баян загийн Хүрэн цав орчмоос протоцератопсын толгойн яс болон мөн амьтны их биеийн ясны хэсгийг олж толгойн ясыг нь гипсэн ороолт хийж авав. Мөн түүнээс холгүй протоцератопсын зулзагын ясыг олж, жиптэпээр ороож авав.

Булган сумын удирдлагууд болон Баян заг дээр кэмпийн үйл ажиллагаа явуулдаг аялал жуулчлалын зарим компаний хүмүүстэй уулзаж, Баян заг орчимд палеонтологийн чиглэлээр шинжлэх ухааны аялал жуулчлал (scientific tour)-ыг хөгжүүлэх нөхцөл боломжийн талаар судалгаа хийв.

Хожуу Цэрдийн галавын Жодохтын цаг үе (Campanian)-ийн эртний амьтан ургамлын олдворт газар-Баянзагийн хамгаалалтын бүсийн хилийн цэгийг тогтоов.

**Төгрөгийн ширээ ба Алаг тээг олдворт газар**

Эдгээр олдворт газрууд нь Баян загаас баруун хойш 30 орчим км-т оршдог бөгөөд хурдас хуримтлал, эртний орчин болон эртний амьтны цогцолборын хувьд Баянзагтай холбоотой.
Төгрөгийн ширээ орчимд богино хугацаанд эрэл хайгуул хийхэд хоёр цэгээс үлэг гүрвэлийн олдвор олдсон бөгөөд нэг олдвор нь илрүүлэлт хийх тохиолдолд нилээд бүрэн бүтэн байх боломжтой олдвор болох нь батлагдав. Протоцератопсын толгойн ясны торгон орой нь цухуйж байсан нь цаашид илрүүлэхэд түүний их биеийн яс нь үргэлжлэн хадгалагдсан байх магадлал өндөр байв. Түүнийг бэхжүүлэлт хийгээд буцааж булж хадгалсан болно.

Төгрөгийн ширээ олдворт газраас хойш 3-4 км-т Алаг тээг хэмээх олдворт газар байдаг бөгөөд тэр олдворт газрын эртний орчин нь Төгрөгийн ширээ олдворт газраас хэдийгээр нэг цаг үеийнх боловч өөр голын үүсэлтэй учир энэ бүс нутагтаа сонирхол татдаг, олддог олдвор нь өөр байдаг зэрэг онцлогийг нь харгалзан энэ 2 олдворт газрын хамгаалалтын бүсийн хилийн цэгийг Төгрөгийн ширээ олдворт газартай нэгтгэн тогтоов.

Дүгнэлт

Энэхүү хээрийн судалгаагаар Оюу толгойн шууд болон шууд бус нөлөөлийн бүс дэх палеонтологийн олдворт газрууд, тэдгээрээс үлэг гүрвэлийн олдворт газруудыг олны хөлөөс хамгаалах, заримыг нь бодлоготойгоор аялал жуулчлалын зорилгоор ашиглаж, эзэнтэй болгох шаардлагатай байгаа нь харагдаж байна.

ОТ төслийн СӨХ-ийн хүрээнд ирээдүйд Палеонтологийн чиглэлээр урт хугацаанд хийвэл зохих ажлууд:

1. Шууд нөлөөллийн бүсэд хамааргдах Ханбогдын районд тархсан Цэрдийн галавын илэрцүүд нь Монгол орны хожуу Цэрдийн түрүү үе буюу Баян ширээгийн цаг үе (Pre-Campanian)-ийн амьтан ургамлын чулуужсан үлдвэр олддог олдворт газруудын хамгийн тулгуур хэсэг юм. Энэ цаг үе нь Төв Азийн эртний экосистемийн судалгаанд чухал байр суурь эзэлдэг. Иймд палеонтологийн үл хөдлөх дурсгал болох эдгээр олдворт газруудыг хамгаалах сонгодог тогтолцоог бий болгох
2. Хожуу Цэрдийн Баяншираэгийн олдворт газруудад түшиглэн эртний байгаль орчин, эртний экосистемийг сэргээн дүрсэлсэн геопарк байгуулах
3. Баян-Овоо сумын Налих хэмээх газарт хадгалагдсан аварга том чулуужсан модыг газар дээр нь мэргэжлийн байгууллагаар эрэл хайгуул, судалгаа, малтлага хийлгэж, чулуужсан модны үзэсгэлэнг газар дээр нь хийж, аялал жуулчлалын түшиц газар байгуулах
4. Манлай, Ханбогд сумын нутгийн зааг дээр орших үлэг гүрвэлийн мөр, зам, жимийн ховор олдворыг түшиглэн газар дээр нь музей байгуулах

Тайлан бичсэн ШУА-ийн Палеонтологийн төвийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор Х.Цогтбаатар

# 16. ХАВСРАЛТ 7. БИЕТ БУС ӨВИЙН БАГИЙН БАРИМТЖУУЛАЛТ

## ҮЛГЭР, ДОМОГ, АМАН ТҮҮХҮҮД

(Эдгээр бүх үлгэр,домгуудыг бичиж авч,буулгасан болно.)

- Гэсэр гэлэн ба Говь шанхын гурван уртын дууны түүх
- Сунтаг Дарханы түүх
- Өндөр Лувсан дарханы түүх
- Ганжирваа хувилгааны түүх
- Хачиг уулын түүх
- Налих, Тогой хайрханы түүх
- Үнэгэд хайрханы түүх
- Зовхи Балдандоржийн түүх
- Дархан Доржийн тухай түүх
- Ундайн голоор нутагтай, Оцонгийн заставын нэгэн цэргийн бууны замгийг хийж өгсөн. Ганцхан кодыг нь гаргаж чадахгүй юм байна гэж хэлж байсан гэсэн.
- Бух хайрханы домог

УРТЫН ДУУНУУД

Ханбогд сумын иргэн Авираагаар:

- Эрэглэнгийн дээгүүр
- Гүйдэл сайт үрээн зээрд
- Шар талын цэцэг
- Жамбал гуай

Баян-Овоо сумын иргэн Л. Батаагаар:

1. Ар хөвч
2. Төрийн товчоо
3. Говийн өндөр

4. Шавь хурлын магнай

5. Өндрийн өвс уртын дуунуудыг дуулан бичлэг үйлдэн баримтжуулсан болно.

Мөн Ханбогд сумаас төрөн гаран алдар, түүхтэй хүмүүсийн намтарыг Батсүх, Сайхан-гомбо нараар хэлүүлэн тэмдэглэсэн.

## СОЁЛЫН ӨВ ТЭЭГЧДИЙН ЖАГСААЛТЫГ ДАРААХ БАЙДЛААР ҮЙЛДЭВ.

| | Нэр | Нас | Мэргэжил, эрхэлж буй ажил | Байршил, нутаглаж буй газар | Тээж буй өв |
|---|---|---|---|---|---|
| **1** | Энхбаясгалан, Бямбасүрэн | 39, 32 | Малчин | Манлай сум | Хоовон Ширнэнгийн хонхор ба Зааны овооны тухай мэдээлэл |
| **2** | Сугир | 67 | Дархан | Манлай сумын төв | Модны дархан, модон хувин, хөхүүр урладаг |
| **3** | Жуулхүү | 70 | Тэтгэвэрт | Манлай сумын төв | Ширмэл ширдэг, дуглуур, тойрог хийж урладаг |
| **4** | Өөлий | 57 | Засаг даргын орлогч | Манлай сумын төв | Манлай сумын газар ус, домог түүхийн талаарх мэдлэгийг тээгч |
| **5** | Шагдарсүрэн | 60 | Малчин | Манлай сум, Өгөөмөр баг | Мэргэн вангийн хошууны сүүлчийн засаг ноён Содномдоржийн зээ хүү, түүний барьж байсан хөөргийг хадгалж байдаг |
| **6** | Алтангэрэл, Галаа | 30, 42 | Малчин | Манлай, Өгөөмөр баг | Хонхорын овоо, бууцны тухай мэдлэг |
| **7** | Сүхбаатар | 64 | Татварын байцаагч | Баян-Овоо, Харзаг баг | Энэ нутгийн ураг удмын түүх, газар ус, хүмүүсийн тухай мэдлэгийг тээгч, уртын дууны түүвэр болон түүхэн сурвалж хадгалдаг. |
| **8** | Бунтэн | 65 | Малчин | Ханбогд, Жавхлант баг | Ундайн ус, бууцны талаар түүх болон |

| | Нэр | Нас | Мэргэжил, эрхэлж буй ажил | Байршил, нутаглаж буй газар | Тээж буй өв |
|---|---|---|---|---|---|
| | | | | | Ханбогд сумын бэлчээр, мал аж ахуйн тухай мэдлэгийг тээгч |
| 9 | Бандиа | 70 | Малчин | Ханбогд, Жавхлант баг | Ханбогд сумын шагайн харвааны түүх, уламжлал болон газар усны мэдлэгийг тээгч |
| 10 | С. Батсүх | 72 | Малчин | Ханбогд, Жавхлант | Өөрөө ерөөл зохиож хэлж байсан, Сунтаг, Уран базарын хийцийн цоож, аягыг хадгалдаг |
| 11 | Ц. Алтангэрэл | 31 | Малчин | Ханбогд, Жавхлант | Өндөр Лувсангийн хийцийн бугуйвчийг 7 наснаасаа хойш зүүж эдэлж буй. |
| 12 | Цээнзэн | 78 | Малчин | Баян-Овоо, Харзаг баг | Энэ бүс нутгийн уртын дууны ая дэгийг тээгч. Түүний хөвгүүд модон, төмөр оньсон тоглоом урладаг |
| 13 | Рашням | 72 | Малчин, байгаль хамгаалагч | Баян-Овоо, Харзаг баг | Сумын газар усны талаарх мэдлэгийг тээгч, Сунтаг дарханы төмрийн дарханы багаж зэмсгийг хадгалагч |
| 14 | Сүхээ | 61 | Малчин, Рашням гуайн эхнэр | Баян-Овоо, Харзаг баг | Онц хилчин, мөр мөшгөх ухааныг эзэмшсэн |
| 15 | Л. Батаа | 78 | Малчин | Баян-Овоо, Налих баг | Долоон шар загийн хийд, түүх, домог их мэддэг хүн, мөн өөрийн цуглуулсан уртын дууны түүвэр хадгалж байна. |
| 16 | Цэдэн-Иш | 74 | Малчин | Баян-Овоо, Налих баг | Налихийн хийдэд багадаа шавилж байсан тул энэ хийдийн түүх, зан үйлийн тухай мэдлэгийг тээгч |

| | Нэр | Нас | Мэргэжил, эрхэлж буй ажил | Байршил, нутаглаж буй газар | Тээж буй өв |
|---|---|---|---|---|---|
| **17** | Д. Бямбаа | 72 | Тэтгэвэрт | Даланзадгад сум | Уртын дууны ая дэгийн талаарх мэдлэгийг тээгч |
| **18** | Ү. Батням | | | | |
| **19** | Төмөртогоо | 68 | Тэтгэвэрт | Даланзадгад сум | Өмнөговь аймгийн шатрын ур хийцийн төлөөлөл болох шатрыг хадгалж буй |
| **20** | Борхүү | 57 | Малчин | Ханбогд, Жавхлант баг | Мөнгөний дарханы ур ухааныг сурч мөнгөн аяга хийдэг |
| **21** | Авираа | 64 | Тэтгэвэрт | Ханбогд сумын төв | Ханбогдын хуучны уртын дуучдаар энэ нутгийн дэг аялгуу заалгаж суралцсан, уртын дуулдаг хүн. |

## 17. ХАВСРАЛТ 8. ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ХАНБОГД СУМАНД СОЁЛЫН ӨВИЙН ХӨТӨЛБӨРИЙН СУДАЛГААГААР АЖИЛЛАСАН ТАЙЛАН

**(2010 оны 7-р сарын 31-с 8-р сарын 9 хүртэл)**

**Ажилласан бүс нутаг**: Оюу толгой төслөөс хэрэгжүүлж буй соёлын өвийн хөтөлбөрийн хүрээнд Өмнөговь аймгийн Ханбогд сум, Манлай сумын нутагт биет бус соёлын өвийн судалгааг хийсэн болно. Уг бүс нутаг нь Оюу толгойн уурхайн нөлөөлөлийн бүсэд багтах нутаг юм.

**Судалгааны баг:** судалгааны багт доктор, дэд проф С.Чулуун, доктор, дэд проф Ж.Гэрэлбадрах, жолооч н.Дорж нар оролцсон болно. С.Чулуун тухайн орон нутгийн биет бус соёлын өв (*уртын болон ардын дуу, хууч, домог, үлгэр, шашин шүтлэг, овоо тахилга, өөрийн соёлоо хэрхэн харж буй, аман түүх*), малчдын бэлчээр нутаг ашиглалт (*мал-малчин-бэлчээр*), ураг төрлийн харилцаа (*овгийн сэргээлт, өрх гэрийн бүтэц, ургийн бичигтэй эсэх*), өрх гэрийн тогтолцооны асуудлаар (*өрх гэрийн гишүүдийн ажил үүргийн хуваарь, айл өрхийн тогтолцоо, өдөр тутмын болон улирлын хөдөлмөр зохион байгуулалтын хэлбэр*), Ж.Гэрэлбадрах аялал жуулчлал, музейн чиглэлээр судалгаа хийж холбогдох баримт материалыг

**Судалгааны хугацаа:** 2010 оны VII.31-VIII.09 хүртэл нийт 10 хоног ажилласан болно. Энэ хугацаа нь нийт 80 цаг Өмнөговь аймгийн Ханбогд, Манлай сумын нутагт ажилласан юм. Энэ хугацаа нь Ханбогд сумын Баян, Номгон, Жавхлант, Гавилууд багийн нутаг, Манлай сумын төвд ажиллахад зориулагдав. Ойролцоогоор нэг багийн нутагт 2 өдөр ажилласан юм.

**Судалгааны багийн зорилго:** Энэ удаагийн хээрийн судалгааны баг нь уламжлалт аж ахуй хөтлөлт, байгаль орчин ба соёлд гарч буй өөрчлөлт, уламжлалт ураг төрлийн сүлжээ, айл өрхийн тогтолцоо, зан заншил, шүтлэг бишрэл, бүс нутгийн соёлын ялгаатай байдлын тухай асуудлаар материал цуглуулахаар ажилласан болно. Мөн бидний энэ удаагийн хийсэн гол ажил бол Оюу толгой төслийн хүрээнд хийгдсэн соёлын өвийн хөтөлбөрийг Ханбогд сумын иргэдэд танилцуулах, нутгийн иргэдээс мэдээлэл авах, түүх, соёлын өв соёлтой холбоотой болоод Оюу толгой, ард иргэдийн хоорондын харилцааны талаар судлан шинжлэхийг зорьсон болно.

**Ажилласан байдал:**

Бид 7 сарын 31-ны өдөр өглөө 8 цагт Улаанбаатар хотоос хөдлөн Чойр хотоос баруун зүгт салах Ханбогдын замаар явж орой 20 цагийн үед Ханбогд сумын төв хүрсэн юм. Эрхэс хэмээх буудалд бууж 8 сарын 1-нд эхлэх ажлын төлөвлөгөөг боловсруулан Баян багийн хуралд оролцох тэнд соёлын өвийн хөтөлбөрийг танилцуулахаа төлөвлөж, Оюу толгойн Орон нутаг дахь хэлтэсийн мэргэжилтэн Бат-Эрдэнэтэй утсаар холбогдож сумын тамгын газрын дарга Хүрлээтэй хамт явахаар тохиролцсон болно.

Миний хувьд дараах байдлаар ажлын төлөвлөгөөгөө төлөвлөсөн юм. Үүнд:

- Ханбогд сумын дөрвөн багт соёлын өвийн хөтөлбөрийг танилцуулах, ард иргэдээс санал авах, тэдний хандлагыг мэдэх,
- Баг тус бүрээс 3-аас доошгүй малчин өрхийн гишүүдээс ярилцлага авах, багийн төвийн сахиул эсвэл багийн иргэдийн хурлын дарга, засаг дарга нарын хэн нэгнээс ярилцлага авах,
- Баг тус бүрийн мал маллагааны ерөнхий байдал, хэрвээ малжилын өвөрмөц, ялгаа онцлог байвал түүнийг анхаарах
- Малчдад тулгарч буй бэрхшээл, Оюу толгойн тухай ойлголт, уурхайтай харилцах байдлыг тандан судлах
- Түүх, соёлын өвөрмөц, өв соёл болоод зан үйлийн аливаа шинж байдлыг тээгч нартай уулзах гэсэн байдлаар төлөвлөж ажилдаа орсон юм.





**Баян багт:** Өглөөд бид 11 цаг хүртэл сумын төв дээр ажиллаад Баян багийн зүг хөдлөв. Энэ баг бол сумын төвөөс зүүн хойш 56 км-т орших Алаг баян хэмээх уулын энгэрт оршино. Баян баг явах замдаа Хөөврийн хоолойд нутаглах Сүхээ хэмээх 58 настай малчин эмэгтэйд очив. Тэрээр өөрийн ач болоод хамгийн бага охины хамт амьдарч байна. Түүний нөхөр нь 2001 онд гэнэтэд нас барсанаас хойш Сүхээ гуай өрх толгойлох болсон бөгөөд одоо байгаа охиноо 8 дугаар анги төгсгөөд сургуулиас нь гаргасан ажээ. Харин бусад хүүхдүүд нь сумын төв болон хотод ажил хийдэг гэнэ. Ялангуяа сумын төвд нэг охин нь үсчин хийдэг бөгөөд түүнийгээ олонтоо ярих аж. Хүүхдүүдийнх нь өөрийнтэй нь нийлсэн нийт 200 гаруй тэмээтэй бөгөөд тэмээний ашиг шимийнхээ тухай бас бидэнд өгүүлэв. Бид Сүхээ гуайн өгүүлэхээр Баян баг нь тэмээгээрээ ихээхэн алдартай баг аж. Сумын 4 багаас хамгийн олон тэмээтэй, "*тэмээний нутаг*" гэж нэрлэж байв. Тус багийн малчид зуны улиралд Баян багийнхаа хөөврийн хоолой, хойшоо Баруун зүүн Богд хавиар нутагладаг бөгөөд өвөл Алаг Баян уулandaa илүү нутаглаж байсан байна. Харин энэ багт үхэр бараг маллахгүй бөгөөд ерөөс үхэр бараг үгүй байсан тухай өгүүлэв. Бусад багтай харьцуулахад аж ахуйн хувьд нэгээхэн сонирхолтой зүйл нь Ханбогд сумын 4 баг нь голлон эрхлэх аж ахуйн хувьд ихээхэн онцлогтой байна. Бэлчээр ашиглалтын бас нэгээхэн асуудал нь худаг юм. Худгийн усны нөөц ховордсон нь Оюу толгойтой холбоотой гэж тайлбарлаж байна. Сүүлийн үед Оюу толгойгоос усны нөөцийн түвшинг тогтоох зорилгоор тусгай хяналтын сувагуудыг байрлуулсаныг бидэнд үзүүлсэн юм. Энэ худаг бол Загийн хоолойн гар худаг юм. Гар худаг бүрийн хажууд усны түвшин тогтоох хоолой тавьсныг тайлбарлахдаа иргэд "*манай хамаг усыг л авах гэж байгаа бололтой*", "*бид ч яваандаа усгүй болох байхаа*", "*аан хэн мэдэхэв*" гэх мэтээр учрыг үл мэдэх хариу өгөвч ямар нэгэн хардлага байнга илэрч байв. Бид тэмээ нь өссөн айлын байдалтай танилцахаар тус багийн хамгийн олон тэмээтэй малчдын нэг Цоггэрэлийнд үдийн 16 цагийн орчимд очив. Тэднийх 40 орчим ботго уясан бөгөөд сургуулийн хүүхдүүд нь ирсэн туслаж байна. Гэрийн эзний ярихаар ойролцоогоор 200 гаран тэмээтэй, түүнээс 60 орчим ботго байгаа, бид хаяая цаг аятайхан бол ботгоо уядаг (*ботго зэлэлхийг хэлнэ С.Ч)* хэмээв. Тэдний эхнэрийн ээж хамт амьдрах бөгөөд жилийн 4 улиралын туршид хоёр хүүхдээ даган амьдрана. Хүнсэндээ тэмээний махыг хэрэглэхээс гадна сүүгээр нь "*айраг*", "*ааруул*", "*цагаа*", "*божмог*" зэрэг нэр төрлийн цагаан идээг өөрсдөө бэлтгэнэ. Ингэний сүүгээр хийсэн хоормогыг сүүлийн үед эмчилгээний зориулалтаар хэрэглэх болсон тул сумын төв юм уу суурин газар орвол зарж борлуулах явдал ихсэжээ. Мөн хавартаа тэмээний ноос ойролцоогоор нэг тэмээнээс 6-8 кг ноос авч түүнийгээ тушаадаг бөгөөд энэ нь "*нэг үгээр хэлбэл ямаатай газрынхан ноолуураа борлуулж жилийнхээ хэрэгцээг олдог шиг л зүйл юм даа*" хэмээн өгүүлж байв. Тэмээний ноос бол "*амжиргаагаа сайжруулах*", "*банкны өрөө төлөх*", "*хүүхдийн сургалтын төлбөрөө төлөх*" зэрэгт зориулагддаг жилдээ олж буй цорын ганц үндсэн орлогын эх үүсвэр болжээ. Үүнээс гадна ерөнхийдөө энэ

багийн хувьд шилжилт хөдөлгөөн нэлээд явагдсан байна. Энэ бригадын хувьд орон нутгийн биет бус соёлын өв (*уртын болон ардын дуу, хууч, домог, үлгэр, шашин шүтлэг, овоо тахилга, өөрийн соёлоо хэрхэн харж буй, аман түүх*)-ийн хувьд хэд хэдэн жишээг тэмдэглэж болно. Уртын дуу дуулдаг хүн хуучин цагт нэлээд олон байсан төдийгүй *түмний эх* болон *бусад уртын дууг дуулахыг хүсэж байгаа* боловч одоо бараг үгүй болсон байна. Домог хуучийн хувьд газар усны болоод хэлмэгдүүлэлтийн үеийн хэдэн орон нутгийн чанартай хууч яриаг бидэнд өгүүлж байв.

Гэхдээ *тодорхой хугацаагаар* саатсан тохиолдолд илүүтэй энэ чиглэлийн мэдээлэлийг авч чадахаар байна. Малчдын бэлчээр нутаг ашиглалт (*мал-малчин-бэлчээр*)-ийн хувьд хамгий томоохон асуудал бол ус байна. Ойролцоогоор ус, худгийн нөөцөө дагаж малчид айл саахалт буух, ус хэрэглэх зарчим нэгэнт тогтсон бололтой. Худгийн усны нөөц малын өсөлт, айл саахалтай асуудалд ихээхэн нөлөө үзүүлж буйг тэдний ярианаас мэдэж болно. Ураг төрлийн харилцаа (*овгийн сэргээлт, өрх гэрийн бүтэц, ургийн бичигтэй эсэх*)-ны хувьд өрх толгойлсон эмэгтэйчүүд харьцангүй бага бөгөөд энэ багт "*яая гэсэн ядуу айл бараг үгүйээ*" хэмээн бидэнд багийн засаг дарга болон бидэнд газарч хийсэн малчин Сүхээ мэдээлсэн юм. "*Овог сэргээхэд ерөнхийдөө бол зарим хүмүүс мэдэж байсан", "зарим нь тэр үед нь л авчихсан юм", "тэр үед буруу авчихсан одоо тэгэж байгаад нэг солиулна зөв болгоно*" гэх зэргээр мэдээлж байв. Ургийн бичиг хөтөлөх тухай дээр нь үед багийн дарга мэдээлж байсан гэвч түүнийг хэрэгжүүлсэн айл бараг үгүй бололтой.

Хөдөлмөр зохион байгуулалтын хувьд өрхийн санхүү аж ахуйг үндсэндээ эхнэр нь мэдэх бөгөөд нөхөрийн хувьд мал болоод гадуурх ажлаа хийх нь чухал гэнэ. Энэ багийнхан өөрийн гэсэн шүтдэг уултай бөгөөд энэ уулыг Алагбаянгийн уул гэнэ. Энэ уулын хамгийн өндөрлөг газар болох нэгэн толгойг тахьдаг аж. Энэ уулын тахилга жил бүрийн 6 сард болдог. Нутгийн ардууд өөрсдийн хөрөнгийг нийлүүлэн уг овооны тахилгыг хийнэ. Уг тахилга нь үндсэндээ бороо оруулахын тулд эсвэл нутгийн сайн сайхны төлөө хийгддэг аж. Өрх гэрийн тогтолцооны асуудлаар (*өрх гэрийн гишүүдийн ажил үүргийн хуваарь, айл өрхийн тогтолцоо, өдөр тутмын болон улирлын хөдөлмөр зохион байгуулалтын хэлбэр*)-ийн хувьд энэ удаад тусгайлан судалсангүй. Тийм цаг ч байсангүй. Соёлын өвийн дурсгалын хувьд Алаг баянгийн хийдийг сумын захиргаанаас соёлын өвийг хамгаалах зорилгоор хамгаалалтад авч тусгай хаяг хадсан байна.

Номгон багт: 8 сарын 2 нд бид Номгон багийн нутагт ажиллав. Номгон баг нь сумын төвөөс зүүн болон зүүн урагш 76 км-т оршино. Бид Номгон багийн нутагт малчин өрхүүдийн хөдөлмөрийн хуваарь, бэлчээр ашиглалт, шүтлэг бишрэлийн талаарх судалгаанд анхааралаа хандуулсан юм. Бид малчин Бумцэнд болон Банди нарынхаар орож бэлчээр ашиглалт, овгийн сэргээлт, ижилсэл, тахилга шүтээний





талаарх мэдээлэл авахыг зорьсон юм. Энэ баг бол сумынхаа хамгийн том багийн нэг бөгөөд алдарт Галбын говь орших тул нутгийн малчдын "бахархалтай нутаг", "хамгийн сайхан нутаг" хэмээн бахархалыг үзүүлж байв. Номгон багийн хувьд 1990 оноос хойш шилжилт хөдөлгөөн ихээхэн явагдсан тул багийн хүн ам эрс багассан аж. Багийн хурал үдийн хойно 7 цагийн үед эхэлдэг бөгөөд энэ нь хэд хэдэн шалтгаантай нутгийн ардууд өгүүлсэн юм. Гол нь "малчид малаа услаж, бэлчээрт малласаны дараа олон хол газраас ирдэг", "орой ирж хуралдаад эндээ хоночихдог юм, орой л цуглахгүй бол амжидгүй юм, ингээд сурчихсан юм эрт очоод нэмэргүй", "оройдоо заримдаа концерт тоглолт үзүүлж, бүжиг болдог болохоор бас залуус орой цуглаад бүжиг, концерт үзээд маргааш өглөө нь хуралдаад тардаг" гэх зэргээр хариулт өгч байв. Ямартай ч бид 19.20-ийн үед Номгон багийн төв дээр ирэхэд хурал эхлэх болсон байлаа. Үүний урд өдөр нь Баян багийн хуралыг өдөр эрт болох байх гэж бодож эрт очих шахсан бид энэ удаад цаг алдсангүй. Хурлын эхэнд Оюу толгой ХХК-наас Санждорж, Сугар нар тус кампаниас явуулж буй бүтээн байгуулалт ба орон нутгийн иргэдийн хоорондын харилцаа, шинээр төлөвлөгдөж буй ажлуудын талаар 45 минут танилцуулж малчдын санал хүсэлтийг сонссоны дараа миний бие тус багийн иргэдэд "Соёлын өвийн хөтөлбөрийг" танилцуулав. Иргэдийн хувьд ихээхэн тааламжтай хүлээж авсан бөгөөд чухам юу хийх гэж буйг их л сониучирхан харж байв. Харин төдий л олон асуулт тавьсангүй. Та нар тэгээд жилийн хугацаанд олон удаа ирэх үү, соёлын өвийг ингэж анхаарч буй нь ихээхэн чухал юм даа гэх зэрэг энгийн асуулт ба хариултыг хариулж байв. Тус багийн иргэдийн голлон тахьдаг уул бол Галбын говийн өмнө орших "Номгон хан" уул юм. Нутгийн ардууд тахихаас гадна энэ нутгаас төрж гарсан зарим нэр нөлөөтэй хүмүүс бас ирж тахих явдал нэлээд байдаг гэнэ. Галбын говь ба Номгон уулаа бид ямар ч тохиолдолд шүтэн биширч байдаг ба цаашид ч хамгаалан хадгалах болно гэдэг дээр иргэд санал нэг өгүүлж байв.  Гэхдээ одоо уг ууланд жаахан алт гарснааХүмүүс тэр хавьд алт малтаад ер өөдлөөгүй юм гэнэ. Бэлчээр ашиглалтын хувьд сүүлийн жилүүдэд айл цөөн болсон тул харьцангүй томоохон асуудал үгүй аж. Өвөлдөө баруун зүүн Хасар хэмээх уулын хавьд нутаглах бөгөд намар Галбын говь хаиар нэлээд нутагладаг аж. Бид Номгон багийн малчдын аж ахуй хөтлөлтийг анзаарахын тулд хэд хэдэн өвөлжөө болон намаржааны газраар орсон юм. Үндсэндээ өвөлжөө сонголт бол нөмөр газрыг төдий л их бараадаагүй боловч газрын байцын хувьд нэлээд нөөлөгдүү нөмрыг бараадсан, уулын чулуугаар дугүй хүрээлэн барьсан бөгөөд өвлийн хүйтэнд мал хайрахаас сэргийлж чулуун хорооны дотор талыг дагуулан хөрзөн өржээ. Харин хорооны өндөр ойролцоогоор 1-1.5 м хэмжээтэй бөгөөд үүдэвч нь хаалгагүй нээлттэй байна. Малын тоооны хувьд ойролцоогоор 300-700 мал дундаж нь байна. Жишээлбэл хамгийн олон малтай өрх Ц.Сайхандэлгэр тэмээ 70, адуу 20, үхэр 80, хонь 198, ямаа 634, З.Цог тэмээ 50, адуу 71, үхэр 52, хонь 79, ямаа 444, И.Намсрайжав тэмээ 121, адуу 17, үхэр 36, хонь 129, ямаа 367 зэрэг сүргийн бүтэцтэй байна. Эндээс харахад сүүлийн жилүүдэд монгол оронд өрнөсөн ямаа өсгөсөн үйл явц энэ багийн хувьд нэлээд тод үзүүлэлтийг харуулж байна. Ямаа өсгөсөн шалтгаан нь зах зээлийн хэрэгцээндээ нэмэр болох, ямаа хурдан өсдөг амьтан, ямаа маллахад амар гэсэн хариултыг өгсөн юм. Гэхдээ ямаа өссөнөөс болж бэлчээрт асуудал үүсэж буй тухай малчид ямар нэгэн асуудлыг өгүүлсэнгүй.

Харин биет бус соёлын өвийн хувьд урдтын дуу, морин хуурийн соёл харьцангүй бусад багаас илүүтэй хадгалагдсан шинжтэй байна. Найр наадам эхлэхэд заавал уртын дуугаар эхэлдэг ба хэдэн жилийн өмнө 3-4 уртын дуу дуулдаг хүн байсан бол одоо бараг үгүй болж буй тухай хэмээн иргэд хариулж байна.

**Жавхлант баг:** 8 сарын 3-нд Жавхлант багт ажиллав. Жавхлант баг бол сумын төвөөс баруун урагш зүгт бас 60 гаран км-т оршино. Тус багийн нутаг бол Оюу толгой болон таван толгой ХХК-ны үйл ажиллагаанд хамгийн их өртөж буй бүс нутаг юм. Тус багийн нутгаар дээрх хоёр ХХК-ны тээврийн зам өнгөрдөг юм. Энэ нь уурхай болоод малчдын хооронд нэлээд өргөн хүрээтэй маргаан үүсгэж байна. Уурхайн зүгээс өгч буй тайлбар нь "бидний энэ зам бол Оюу толгойг Гашуун сухайтын хилийн боомттой холбож буй 105 км засмал зам байгаа юм. Энэ замын чиглэлийг бид биш Байгаль орчны яам өөрөө шийдвэр гаргаж бидэнд ирүүлсэн. *Узүүлэв.* Таван толгойтой нэг зам тавих боломжгүй юм. Бид бол нэлээд судлаж байж энэ замыг тавьсан гэж бодоод байгаа. Та бүхэнд ямар нэгэн асуудал байвал бид уламжлая" хэмээсэн бол орон нутгийн иргэдийн зүгээс "манай нутгийг бидний саналыг харгалзалгүй сүйтгэж дууслаа. Та нар л энэ замын чиглэлийг зааж өгсөн биз дээ. Түүнээс бус тэр яам тамгын газрынхан юугаа мэддэг юм. Ер нь бид бол зам тавихыг татгалзаагүй. Харин хаагуур тавих бэ? гэдгийг л асууж байж шийдсэн бол дээр байсан юм. Та нар нэг ажил эхлэхээрээ биднээс асуудаггүй. Бүр эхлээд явчихсан хойноо л хэлдэг. Ингэхээ боль" гэх зэргээр багийн хурал дээр маргаан өрнөж байв.

Энэ багийн иргэдийн эрхлэх аж ахуйн хувьд ямаа болон тэмээг голлон эрхэлдэг аж. Уг багийн нутагт хамгийн сайхан бөгөөд тэдний бахархалтай нутаг "умдайн гол" хэмээх хайлаасан ойтой газар байна. Умдайн гол нь "*хуучин бороо сайтай жил бол 1 сар урсдаг байсан гол, манай нутгийнхан зундаа энэ голоо бараадаж л зусдаг байсан. Одоо гол болоод манай хайлаасыг ч бүр энэ зам яваад дуусгаж байнаа*" хэмээх хариултыг хүн бүрээс сонссон юм. Ерөнхийдөө Оюу толгой болоод Жавхлант багийн малчдын хооронд нэлээд зөрчил байгаа нь уг судалгаагаар харагдаж байв. Бид уг багийн дарга Ширнэнгийн гэрт очиж тэдний аж ахуй хөтлөлт, гэр бүлийн хөдөлмөр зохион байгуулалтын талаар мэдээлэл цуглуулсан юм.

**Гавилууд баг:** 8 сарын 4-нд Гавилууд багт ажиллав. Гавилууд хэмээх нь сумын баруун хойд зүгт орших гурамсан уулыг нутгийнхан ийнхүү нэрийднэ. Чухам гавилууд хэмээх нь ямар утгатайг тайлбарлах хүн олдсонгүй. Гавилууд баг нь хонь, адууны нутаг болох нь тодорхой харагдаж байв. Биднийг Гавилууд багийн зүг явах үед ихэнх айлд хүн алга байв. Учир нь тэр өдөр Гавилууд багийн хурлан морины сунгаан болж байсан юм. Тиймээс ихээнх гэрийн эзэд болон залуус тус хурдан морины баярт явжээ. 16 цагийн үед Гавилууд багийн төв дээр ирэхэд бараг хүн цуглаагүй байсан нь дээрх баяртай



холбоотой. Багийн дарга нь бидэнд өөрийн багаа танилцуулж, нутгийн иргэдийн итгэлийг хүлээж энэ багийн засаг даргаар 2006 оноос ирж ажиллаж байгаа гэнэ. Урд нь цэргийн ангид дарга байсан гэнэ. Багийн тохижилт зэрэг нь нэлээд чамбай сайн болжээ. Бусад багтайгаа харьцуулахад.

Тэрээр өөрөө орон нутгийнхаа үүх түүхийг сонирхдог цуглуулдаг хэмээн бидэнд ярьсан бөгөөд нэгэн судрыг сонирхлуулсан байна. Тус багийн иргэдийн шүтлэг бишрэлтэй газар ус, түүний тахилгын асуудлыг сонирхон материал цуглуулсан юм. Энэ багийнхны хувьд багийн төвөөс урд зүгт 10 орчим км-т орших Мөнх толгойг тахиж шүтдэг юм байна. Багийн нийт гишүүд 1000 төгрөгнөөс эхлэн 40.000 мянга хүртэл төгрөг хандивлаад 360.000 төгрөг гаргаж, хэдэн ямаа, айраг, ааруул зэргийг нийлүүлэн овоогоо тахисан байна. Энэ нь тэднийг хамтын шүтлэгийн нэгээхэн хэлбэр бий болгон хэрэгжүүлж байна. Үүнээс гадна тус багийн нутагт болж буй нэгэн сонирхолтой нийгмийн үзэгдэл бол бөөгийн мөргөл *шашин хэмээн хэлнэ нутгийнхан*\  гэнэ. Сүүлийн 3 жилд ойролцоогоор 14 хүн бөө мөргөлтөн болсон гэнэ. Энэ нь тухайн нутагт лам байхгүй, хүмүүс тулгамдсан үедээ асуух лавлах зүйлгүйгээс, манай нутгийн нэг хүүхэн бөө болж нутагтаа ирээд хүмүүсийг онгодоо хүлээж авах хэрэгтэй гэснээс болсон гэж өгүүлж байлаа.

Миний бие сумын төв дээрх гандан хийд, болоод соёлын төвийн үйл ажиллагаатай 2 өдөр танилцаж, уг хийдийн хамба лам Тэгшбаяртай ярилцаж, энэ нутгийн шашны үйл ажиллагааг нэлээд ажигласан болно. Мөн тус сумын хамгийн ахмад хүмүүсийн нэгтэй уулзаж түүний багийн амьдрал, энэ нутгийн аж ахуй соёлын онцлог, амьдралынх нь түүхээс яриулж тэмдэглэл болон бичлэг хийж авав.

**Судалгааны дүгнэлт:**

2010 оны 7 дүгээр сар 31-нээс 8 сарын 9 хүртэл Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт угсаатан, нийгэм-соёлын хүн судлалын судалгааны ажлаар ажиллаад дараах хэдэн саналыг гаргаж тавьж байна. Үүнд:

- Ханбогд сумын биет бус соёлын өвийг судлахдаа бусад орон нутгийн ижил соёлтой харьцуулан, онцлог болоод ялгаатай талыг нь гаргах
- Ханбогд сумын мал-малчин-бэлчээр гурвын харилцааны бүтэцийг гаргах
- Ханбогд сумын шүтлэг бишрэлд гарч буй өөрчлөлтийг судлах

Мөн Ханбогд сумын иргэдийн уул уурхай болоод бүтээн байгуулалтын талаарх ойлголт, уул уурхайн зүгээс малчдын талаарх ойлголтын ялгаа, зөрчилийн учир холбогдолыг нягтлан гаргаж судлах явдалтай холбоотой материалуудыг бид энэ удаагийн хээрийн судлагаагаараа цуглуулсан болно. Мөн гэр бүлийн харилцаа, ураг төрлийн хоорондын уялдаа холбоо, хөдөлмөр зохион байгуулалт зэргийг нягтлан судлах хэрэглэгдэхүүн цуглуулж авсан болно. Эдгээр нь Оюу толгой ХХК-наас тус бүс нутгийн соёлын өвийн хөтөлбөрийг явуулахад үндсэн хэрэглэгдэхүүн болж чадах болов уу.

# 18. ХАВСРАЛТ 9. БИЕТ БУС ӨВИЙН 2010 ОНЫ 10-Р САРЫН ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

**С.Чулуун (PhD), П.Лхам (PhD горилогч), Биет бус өвийн багийн мэргэжилтнүүд**

**АГУУЛГА**

Хээрийн шинжилгээний зорилго, арга зүй

Хамарсан газар нутаг өрх, айл

1. **БИЕТ БУС ӨВИЙН ХҮРЭЭГ ТОДОРХОЙЛОХ АРГА ЗҮЙ, ХЭМЖҮҮР**
   - 1.1 Биет бус өвийн ангилал
   - 1.2 Үнэлгээ хэмжүүр, зэрэглэл
2. **БИЕТ БУС ӨВИЙН ТОДОРХОЙЛОЛТ**
   - 2.1 Дарханы урлал
     - 2.1.1 Дарханы цавуу хийх технологи
     - 2.1.2 Мөнгөн гоёл чимэглэл, бугуйвчны урлал
     - 2.1.3 Дархан хүний 3 цээр
     - 2.1.4 Үйсэн иштэй хутга хийх технологи
     - 2.1.5 Үе дамжсан хөөрөг
   - 2.2 Уртын дуу, ерөөл магтаал
   - 2.3 Цулхир, бажууны гурил хийх арга ухаан
   - 2.4 Тамганы соёл
   - 2.5 Монгол гэрийн урлал
   - 2.6 Гэр ахуйн уламжлалт сав хэрэглэл
   - 2.7 Гэрийн тавилга, засал
   - 2.8 Дуглуур, тойрог хийх арга ухаан
   - 2.9 Бурхан тахил, шүтээн
   - 2.10 Хүнс хоол
   - 2.11 Овог ургийн нэр, ураг төрлийн хэлхээ холбоо
   - 2.12 Чулуун гэр болон бусад тоглоом
   - 2.13 Шагайн харваа
   - 2.14 Говьчуудын хорио цээрийн ёс
   - 2.15 Шашин, бөө мөргөл
3. **БЭЛЧЭЭРИЙН МАЛ АЖ АХУЙ ЭРХЛЭН АМЬДРАХ АРГА УХААН**
   - 3.1 Уламжлалт соёлын дэг журам ба бэлчээрийн мал аж ахуй эрхлэн амьдрах сонголт
   - 3.2 Бэлчээр устай холбоотой мэдлэг ухаан
   - 3.3 Мал маллагааны арга ухаан

3.4 Малын хашаа хороо
3.5 Хоточ ноход
3.6 Мөр хөөх ухаан, мөрч

4. **ӨВТ ГАЗРУУДЫН ЖАГСААЛТ**
5. **СОЁЛЫН ӨВ ТЭЭГЧДИЙН ЖАГСААЛТ**
6. **АМАН ТҮҮХ, ДОМОГ ХУУЧ ЯРИА**
7. **ГАЗАР УСНЫ НЭРИЙН ГАЗРЫН ЗУРАГ**
8. **ҮР ДҮН, САНАЛ**

8.1 Биет бус өвийн үнэлгээ
8.2 Ямар биет бус өвүүд бодит хэрэглээтэй байна вэ?
8.3 Ямар биет бус өвүүд мартагдан орхигдож байна вэ?
8.4 Ямар замаар биет бус өв дамжин залгамжлагдаж байна вэ?

Хавсралт

## ОЮУ-ТОЛГОЙ ТӨСЛИЙН СОЁЛЫН ӨВИЙН ХӨТӨЛБӨРИЙН БИЕТ БУС ӨВИЙН 10 ДУГААР САРЫН ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Оюу-Толгой төслийн үйл ажиллагаа хэрэгжиж байгаатай холбоотойгоор Өмнөговь аймгийн Манлай, Ханбогд, Баян-Овоо, Даланзадгад сумдын соёлын өвийг хамгаалж, хадгалж уламжлуулах хөтөлбөрийг боловсруулахад түүнд хамрагдах биет бус өвүүдийг тодруулах гол зорилготой 2010 оны 10 дугаар сарын 23-наас 30-ныг хүртэлх хугацаанд биет бус өвийн хээрийн шинжилгээ хийгдэв.

### Хээрийн шинжилгээний зорилго, арга зүй

9 дүгээр сард зохион байгуулагдсан олон улсын судлаачдын багтай хамтарсан хээрийн шинжилгээний тодруулсан ажлууд болох

- Газар усны нэрийн газрын зураг
- Өвт газруудын газрын зураг

Соёлын өв тээгчдийн бүртгэлийг хийж гүйцэтгэхээс гадна энэ бүс нутаг дахь соёлын биет бус өвийн хүрээг тодорхойлох зорилготой ажиллав. Биет бус өвийн хүрээ гэсэн ойлголтыг бид доорх байдлаар тодорхойлж буй болно.

1. Ямар биет бус өв, мэдлэг ухаан, зан заншил, зан үйл өнөөдөр хэрэглэгдэж байна, тэдгээрт гарч буй өөрчлөлт
2. Ямар биет бус өв алдагдан орхигдож байна, шалтгаан, нөхцөл
3. Ямар биет бус өвийг бүс нутгийн удирдлага болон олон нийт үнэ цэнэтэй хэмээн үзэж байна.

Мөн түүнчлэн биет бус өвийг тодорхойлоход арга зүйн хувьд орон нутгийнхны ойлголт, төсөөллийг суурь болгон өнөөдөр тэдний бодитойгоор хэрэглэж байгаа болон, үнэлж ач холбогдол өгч буй өв соёл, мэдлэгийн хүрээгээр биет бус өвийг тодорхойлох чиг хандлагаар ажилласан. Харин тэдний дурдаж байгаа өв, мэдлэг нь яагаад тэдний хувьд чухал болохыг угсаатан судлал, нийгмийн антропологийн онол арга зүйн үүднээс холбогдох судалгаа, дүн шинжилгээ хийж ажиллах юм.

## Хамарсан газар нутаг, өрх айл

Ийнхүү биет бус өвийн хүрээг тодорхойлох болон төлөвлөгдсөн ажлуудаа гүйцэтгэхийн тулд тухайн сум орон нутгийн

1. Орон нутгийн удирдлага, өв соёлын холбогдох ажилтнууд
2. Түүх, соёл, өвөө мэддэг хэмээн олон нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн хүмүүс
3. Тусгайлан сонгоогүй айл өрх гэсэн 3 хүрээгээр ажиллав.

7-9 дүгээр сарын хугацааанд Ханбогд суманд эхний 2 бүлгийн хүнтэй уулзаж ярилцсан тул энэ удаа онцлон Жавхлант багийн Хөөврийн гол, Хулгарын усны айл өрхүүдэд ажиллав. Харин Манлай, Баян-Овоо, Даланзадгад сумдад олны дунд соёлын өвийг тээгчид хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн, гол төлөөлөгчид буюу 2 дахь бүлэгт ажиллав. Манлайд Өгөөмөр, Далай, Жаргалан багаас тус тус нэг өрх дээр очиж ажиглалт судалгаа хийсэн.

Энэхүү хээрийн шинжилгээний үр дүнд:

1. Биет бус өв, тээгчдийн жагсаалт
2. Өвт газруудын жагсаалт
3. Газар усны нэрийн газрын зураг
4. Аман түүх, домог хууч ярианы тэмдэглэл зэргийг урьдчилсан байдлаар гаргав.

## 1. БИЕТ БУС ӨВИЙН ХҮРЭЭГ ТОДОРХОЙЛОХ НЬ

Нийгэм, соёлын антропологийн үзэл онолын үүднээс, аливаа соёлын аж ахуй, үйлдвэрлэл, болон нийгмийн хэлхээ холбоо, ураг төрлийн харилцаа нь суурь дэг журам болж бусад соёлын үзэгдлүүд түүнээс урган гарсан байдаг. Онолын хувьд бид бэлчээрийн мал аж ахуй эрхлэх нь Өмнөговь аймгийн энэ бүс нутаг дахь уламжлалт соёлын суурь дэг журам гэж үзэж байна. Социалист орчин үежилт болон засаг захиргааны орчин үеийн тогтолцооны үр дүнд уламжлалт ураг төрлийн харилцааны нийгмийн үүрэг нэлээдгүй буурсан гэж судлаачид үздэг. Гэвч суурь судалгааны явцад "ургийн баяр" хэмээх зан үйл, ургийнхны тахьдаг овоо байгаа нь ураг төрлийн хэлхээ холбоог дахин эргэн харах шаардлагатайг харуулж байна.

### 1.1 Биет бус өвийн ангилал

Биет бус өв нь мэдлэг ухаан, арга техник, зан заншил, эдийн соёл гэсэн 3 хэсгээс бүрдэж байна.

**Мэдлэг ухаан**

1. Дарханы урлал: төмрийн, модны, мөнгөний дарханы 3 үеийн хийц
2. Цулхирын гурил, бажууны гурил, цай хийх
3. Жин тээх соёл
4. Ингэ хөөслөх
5. Шагайн харваа
6. Хооллолт, дэг
7. Говийн уртын дуу

**Зан заншил**

8. Говьчууд хорио цээрийн ёс: Тэмээний махыг бузар гэж үздэг, бүйлс түлдэггүй, хүүхдийн чулуун тоглоомыг нутагтаа орхиж нүүдэггүй, дархан хүний гурван цээр, оронгоны эвэр тээсэн тэмээ хээл хаядаг,
9. Даллаганы уутанд хийдэг зүйлс
10. Хараал, зүхлийн үг
11. Онцлог үг хэллэг
12. Хүн тавьдаг газар
13. Хурдан морины уралдаан, сунгааны газар

**Эдийн соёл**

14. Малын тамга
15. Монгол хувцас, дээл, малгайн урлал
16. Дуглуур, тойрог ширэх ухаан
17. Чулуун тоглоом, модон ба цутгамал тоглоом

## 1.2Үнэлгээ, хэмжүүр, зэрэглэл

Хээрийн шинжилгээ, судалгааны явцад тодруулсан дээрх биет бус өвийг тодорхойлж үнэлгээ өгч хөтөлбөр боловсруулахдаа бид:

I. **БИЕТ БУС ӨВ БУЮУ МЭДЛЭГ УХААН ДАМЖИН ХАДГАЛАГДАХ АРГА ЗАМ:**
1. Тээгч
2. Мэдлэгийн эх сурвалж, болон уламжлагдан дамжих арга зам (гэр бүл, нэг нутгийнхны дунд, сургууль, сургалтаар)

**II. БИЕТ БУС ӨВИЙН ҮНЭ ЦЭНЭ, АЧ ХОЛБОГДОЛ**
1. Тархац (газар нутаг)
2. Хамрах хүрээ (хүмүүс)
3. Өнөөгийн хэрэглээ, цаашдын хандлага

Ач холбогдол, үнэ цэнэ (Хэнд хэрэгтэй байна, хэн үнэ цэнэ өгч буй) гэсэн 6 хэмжүүрээр авч үзэх юм.

| Биет бус өвийн нэр, код | | Биет бус өвийн тодорхойлолт, мэдээллийн сан | Хэмжүүр, зэрэглэл | | |
|---|---|---|---|---|---|
| Биет бус өв уламжлагдан хадгалагдах арга зам | Тээгч (мэдлэг ухааны мэдлэгийг тээгч болон урлал бүтээлийг хадгалагч) | | Өндөр | Дунд | Доод |
| | Мэдлэгийн эх сурвалж ба уламжлагдан дамжих арга зам | | Уламжлалт | Шинэ | Тодорхойгүй |
| Биет бус өвийн үнэ цэнэ ач холбогдол | Тархац | | Шууд нөлөөллийн бүс | Шууд бус нөлөөллийн бүс | Нийт Өмнөговь |
| | Хамрах хүрээ | | Нэг сум, ураг төрлийнхөн | Шууд нөлөөллийн бүс | Нийт Өмнөговь |
| | Өнөөгийн хэрэглээ, цаашдын хандлага | | Бодит хэрэглээтэй | Мартагдаж буй | Хэрэглээ үгүй |
| | Ач холбогдол үнэ, цэнэ | | Өндөр | Дунд | Доод |

1. Биет бус өв

Биет бус өв уламжлагдан хадгалагдах арга зам

2. Тээгч (мэдлэг ухааны мэдлэгийг тээгч болон урлал бүтээлийг хадгалагч)
   Өндөр
   Дунд
   Доод
3. Мэдлэгийн эх сурвалж ба уламжлагдан дамжих арга зам
   Уламжлалт
   Шинэ
   Тодорхойгүй

Биет бус өвийн үнэ цэнэ ач холбогдол

4. Тархац
   Шууд нөлөөллийн бүс
   Шууд бус нөлөөллийн бүс
   Нийт Өмнөговь
5. Хамрах хүрээ
   Нэг сум, ураг төрлийнхөн
   Шууд нөлөөллийн бүс
   Нийт Өмнөговь
6. Өнөөгийн хэрэглээ, цаашдын хандлага
   Бодит хэрэглээтэй
   Мартагдаж буй
   Хэрэглээ үгүй
7. Ач холбогдол үнэ, цэнэ
   Өндөр
   Дунд
   Доод

## 2. БИЕТ БУС ӨВ

### 2.1Дарханы урлал

Өмнөговь аймаг нь Ноён-Сэврэйн хийц хэмээгдэх онцлог дарханы урлалтай бөгөөд судалгааны 4 сумын нутагт энэхүү дэг сургуулийн салаа салбар болон мөн дарханаараа нэрлэгдсэн олон хийц тархжээ.

Өнөөдөр энэ бүс нутагт төмөр, мөнгөний дарханы 3 үеийн ур хийц уламжлал, бүтээл урлал хадгалагдаж байна.

I-II үе нь 19 дүгээр зууны сүүлээс-1970-аад оныг хамрах бөгөөд төмрийн дархан Сунтаг, мөнгөний дархан өндөр Лувсан, модны дархан Дорж нар 1930-90-ээд оны үед амьдарч байжээ. Уран Ням Монгол улсын сайн малчинд дурсгадаг байсан мөнгөн хувин, мөнгөн хуц, эцэг малын баримтлыг цутгаж хийж байсан. Чойбалсангийн үед Дарханы зэрэг гэж байсан ба энэ бүс нутгаас уран Санж Монгол улсын гавьяат дархан цол хүртэж байжээ. Дархан тарган Даржаа, мөнгийг маш нимгэн болгож аяга урладаг байсан бол дархан Жамяандорж мөнгөн аяганд утас ороож хээ тавьдаг байжээ. Мөн Сунтаг дархан, Уран Базар, Пэрэнлэй, Мөнгөн Чимид, Уран-Бөгтөр-Ганган Осор, зургаан хуруу Банзрагч, Гунжаа Ням, Угалзын Хэцийн уран Төмөр зэрэг дархчуудын хийц гэж яригдаж байна. Баян-Овоо сумын өндөр настан Цэдэн-Иш гуай Сунтаг дарханы урласан 40 гаруй жил болж буй цоожийг хадгалж буй бол түүний ач хүү Раш түүний төмрийн дарх хийдэг багажнуудыг хадгалж байна.

> *"Сунтаг дархан Номгон Хүрмэний заагийн хүн, авдар хөөрөгтэй байсан, төмрийн хатыг маш гайхамшигтай тааруулдаг төмрийн ширээлт, цуултыг маш сайн хийдэг дархан байсан. Нэг хүн Сунтаг дарханаас тэмээ хяргах хайч хийлгээд ирлэх билүү асуухад 2 жил ирлэлтгүй тэмээ хяргана гэсэн байна. Гэтэл үнэхээр гурав дахь жилдээ хугараад унасан гэдэг. Энэ нь махан төмрийн дунд ирэнд нь бритва шиг нарийн иртэй ган суулгасан байсан, махан төмөр нь шамрахаар ир нь гараад байсан байна. Мөн мах, мод, төмрийн хутга хийдэг. Төмрийн хутга нь галын хайчийг хуйлруулаад зордог хутга хийдэг хүн байсан. Эмнэлгийн барилга барьхад хэдэн дархан хүнийг авчруулж, Сунтаг дарханд хуучин байшингийн хадаастай хар моднуудыг өгөхөд шуудайтай багаж авчраад хадаасыг нь гялтайтал харуулдаж, урт хадаасыг нь цавчиж хаяад гөлиийтөл нь харуулдсан. Бусад дархanууд нь очиж үзэхэд сүхний ир нь маш хурц хэвээрээ байжээ."*[23]

[23] Даланзадгад сумын дархан Ү. Батнямын ярианаас. 2010 оны 10 дугаар сарын 28-ний өдөр, Даланзадгад хот.



Баян-Овоо сумын иргэн Раш төмрийн дархан Сунтагийн ач хүү бөгөөд түүний төмрийн дарханы багаж хэрэгслийг хадгалж байна.



Сунтаг дарханы хэрэглэж байсан гэрийн хана ,гутлын шөвөг, төмрийн хасуур, хуурай



Баян-Овоо сумын өндөр настан Цэдэн-Иш Сунтаг дарханы хийсэн цоожийг 40 гаруй жил хэрэглэж байна.

Мөн Ханбогд сумын Хулгарын усанд нутагладаг Батсүх гуай Уран Базарын мөнгөн аяга, Сунтаг дарханы цоож, тулга зэргийг өвлөн хадгалж байна.



Ханбогд сумын Хулгарын усанд нутагладаг Сайхансамбуугийн Батсүх



Уран Базарын хийцийн мөнгөн аяга



С. Батсүх гуайн хадгалж буй тулга

III үе нь мөнгө, төмрийн дарханы өмнөх үеийн ур хийц, чадварыг өвлөн авч дарх хийж буй Ханбогд сумын Жавхлант багийн Жаргалсайхан, Борхүү, Даланзадгад сумын Батням, Баян-Овоо сумын Шархүү дарханы шавь нар болох Алтангэрэл, Баттөр, Батбуян нар байна.

### 2.1.1 Ноён-Сэврэйн хийцийн онцлог

Даланзадгад сумын иргэн Батням Ноён-Сэврэйн хийцийн дарханы урлалыг эзэмшин хөгжүүлж улмаар олон арван шавь төрүүлэн гаргасан байна. Батням гуай Ноён-Сэврэйн хийц гэдгийг тодорхойлохдоо:

*"Ноён-Сэврэйн хийц нь мөнгөний орц өндөртэй, тиймээс хэдэн үе дамжин хэрэглэх боломжтой байдаг. Мөнгөн аяга хийхэд залгалгүй, мөнгөө бүрж давуулж нугалан хийдэг онцлогтой. Яагаад Ноён-Сэврэйн хийц хэмээгдэх энэхүү дарханы урлал энэ бүс нутагт хөгжсөнтэй холбоотой нэгэн хууч яриа байдаг. Урьд энэ нутгийнхан Шинжаан Уйгур руу жин тээдэг байжээ. Эзнээ гол Шивээ хүрэнгийн боомт гараад баруун тийш хилийн дагуу 500-600 км явж Харлаг тагийн нуруу Тэнгэр уулын ар ёроолд Бар хөл хот, Баруун-Зуу гэдэг мөргөлийн газарт том мөнгөний уурхай байсан байна. Тэндэхийн хүмүүс маш ядуу арьс шир, идэж уух, өмсөх юм байхгүй. Тийшээ жинд явах замд Үзмэн уул гэдэг маш их зэрлэг үзэмтэй газраар явна. Тэндэхийн хүмүүс үзмийг шороотой хольж хаяагаа манадаг. Морины таханд үзэм шавчихаад явуулдаггүй байсан гэж байгаа. Миний авга намайг багад ярьдаг байсан. Тэр үед нууцаар жин тээж худалдаа хийдэг байсан, одоогийнхоор бол контрабанд хийж байсан байна. Ах маань жин тээж ирээд бидэнд үзэм авчирч өгөөд хүнд үзүүлэлгүй газар унагалгүй идээрэй гэж их захьдаг байсан. Уурхайн ажилчдад цалин гэж гулууз мөнгө өгдөг, түүгээрээ жинчдээс хямд үнээр ноос, нэхий зэргийг сольж аваг. Дээрх мөнгөөрөө юм хийж зардаг болсноор мөнгөний дархчуул олон болсон. Тэгээд мөнгөний орц өндөртэй Ноён-Сэврэйн хийц гэж хөгжсөн бололтой байдаг. Энэ нь 1800-аад оны үеэс эхэлсэн. Ноён-Сэврэй одоогийн Гурван-Тэсэд маш олон дархан урчууд байсан. Ноён нутгийн баруун талын хүн ардын зураач Долгорын Маньбадар. Түүнийг уран зурагт сургасан Долгорын Гэндэнсамба гэдэг хүн, Уранманьдэр гэдэг удмын дархчуул байсан. Мөн Дархан Санж, Дархан Түвдэн, Дархан Базар г.м. Халхын дөрвөн хийц гэж байдаг. Үүнд:*

*Далай шонхор вангийн хийц- төмөр эдлэлийн хийц*

*Боржигин хийц*

*Хэнтийн Батноровын хийц*

*Дарьганга хийц орно*

*Засагт ханы хийц— Ховд завхан чиглэлийн хийц"*



Дархан Ү.Батням















### 2.1.2 Дарханы хөөрөг

Тулман хөөрөг, ямааны арьсан, амыг нь онгойлгож хийгээr дүүргээд буцаж амыг нь хавчдаг.

Авдран— Зөвхөн модон дөрвөлжин хайрцагаар хийдэг, дөрвөлжин хажуугийн колопыг татаж хийгээр дүүргэдэг

Салхин— Ярьдаг цагаан хоолой, хөөрөгний хярсан дээр галаа түлж, төмрөө хийчихээд салхины аясыг дагаж байрлуулдаг. Хүчтэй салхи бүгдийг нь хайлуулдаг учир салхи ширүүн байвал зөрүүлж тавина. Сэвэлзүүр салхинд маш сайн болдог. Нөгөө хоёроосоо хамаагүй хүчтэй.

### 2.1.3 Ноён-Сэврэй хийцийн гөлөм, хазаар, дөрөө

**Гөлөм**: Нэг тал нь элэгдэхээр сольж тавьж болдог, учир нь доголыг дээр доор нь тааруулж хийдэг. Мөн нэвт оёдолтой, булигаарыг нь нэвт шивж оёод цаад талд нь мөн булигаар тавьдаг. Угалзны хамар нь элэгдсэн ч хээ нь хэвээрээ байдаг, өндөр булигааран хамар нь хээгээ хамгаалдаг.

**Хазаар**: цутгуу товруутай, бөгжтэй,сурвалж, арлыг цутгуураар хийдэг

**Жийжүү дөрөө** гэдэг нь төмөр дөрөөнд гуулиар хээ суулгасан хээтэй байдаг.

**Аяга**: Дэшингний ирмэг дээгүүр утас тавьж хажлаад цаана нь бад тавина. Бад гэдэг нь бадам гэсэн утгатай бурханы доор байдаг бадамаас арай өөр. Их гарын мөнгөн аяга 18 лан. Ач холбогдол нь насан туршдаа болон үе залгамжилан хэдэн үе дамждаг.

### 2.1.4 Үйсэн иштэй хэт хутга хийх технологи

Даланзадгад сумын дархан Ү. Батням "үйсэн иштэй хутга нь маш бат бөх байдаг онцлогтой. Манайхны дархчууд хийдэг байсан. Хусны үйсийг норгож нарийхан зүсээд хутганы ишийг ороодог. Норгосон үйсийг шахаж, дахин ороож хатаах гэх мэтээр хийсээр маш сайн чанарын иш хийдэг арга байдаг. Одоо үйсэн иштэй хутга ховордсон байна. Хусны нимгэн хальсыг дэвтээж хутганы ишний нарийн гозгор төмөрлүү шахаж усыг нь дүүргээд нүдэж давтаад хэд хоног байлгаад дахин хийж давтаж өөг нь засаж зүлгэн хийдэг. Энэ нь хэзээ ч хугарч, шамрана гэж байхгүй. Дээр үед богц нь хүртэл мөнгөн чимэгтэй байсан.

Ноён Сэврэй хийцийн үндсэн чанар нь үе дамжин хэрэглэгдэх".

Ханбогд сумын малчин Борхүү:

*"Мөнгөн аяга хийдэг дархан Борхүү гуайнд очиход нүүдэл нь таарсан ч бидэнтэй хуучлав. Нэг мөнгөн аяга бол 3 үе болдог. Харин миний аяга бол 4 омойлох / үе / хүрэх байх. Харин хүүхдүүд аяганы амсарыг хазчихдаг болохоор халтардаж өнгө алддаг. Харин миний аяга бол амсар зузаан болохоор хонхойж, халтар болохгүй. Манлай суманд Шархүү гэдэг мужаан байдаг байсан. 1960 онд хийлгэсэн түүний хаалга 20 жил болоход одоо хүртэл гажаагүй ээ. Тооно нь үйлдвэрийн тооныг бодвол 2 дахин нугалмаар сайн хийцтэй. Дашдондог гэдэг 60 гаруй насны ширээ хийдэг буурал бий."*

Тэрээр мөнгөн аяганы амсарыг, жигд углуургадаж, мөнгө, мод 2-ыг ямарч завсар орохгүй суулгаад, аяганыхаа ёроолыг нь бадмалсан хээ гаргаж цохидог. Ингэж 2 давхар мөнгийг уулзуулж, бадам цэцгийн хэлбэр гарган цохисон байна. Аяганы ёроолд зузаан мөнгө хийх хэрэгтэй. Харин сүүлийн үед хүмүүс мод, мөнгө 2-ийн дунд туглага, элс, зэс зэргийг дэвсэн мөнгөн дээрээ цутгаж хийдэг болсон бололтой. Харин энийг шалгаж үзэхийн тулд модон дээр зөөлөн юм тавиад доош харуулан цохиж үзэхэд, хөндийрч сонсогддог.

### 2.1.5 Дарханы цавуу хийх технологи

"Баян-Овоогийнхон 5 янзын ширээр 5 янзын цавуу хийдэг байсан. Шар, хар, хүрэн цавуу. Хүний биен дээр наалддаг, наалддаггүй. Арьс ясаа өөх, тосгүй болгоод урь идүүлээд 3-7 хоног, хавар урь идүүлээд жижиглээд овооны хөтөл газар дээр том тогой тавиад, хөрөөр чанана. Буцалгаж түлэхгүй, хольц хийхгүй удаан буцалгаж 24-36 цаг чанадаг. Өнгө тогтон хар, шар болж ирэх үед нь үе үе юм нааж үзнэ. Одоо боллоо гэж үзэх үедээ гаргаж, хөргөөд аваад модон хэвэнд хийгээд хатаагаад авчихна. Хэвгүй байх юм бол бутлаад уутанд хийчихнэ. Давс, хужиргүй хамгийн сайн ус, уулын ус авч хийнэ. Хачгийн уулны ус, Налихын Хачигт, Дэлгэр сүүж, Хөхтолгой, баруун зүүн Дэрс зэрэг газарт сайн ус бий"[24].

### 2.1.6 Мөнгөн гоёл чимэглэл, бугуйвчны урлал

Өндөр Лувсангийн давтагдашгүй онцлог хийцтэй мөнгөн бугуйвчийг

өнөөдөр Ханбогд, Баян-Овоо сумынхан үе дамжуулан эдэлж хэрэглэж байна. Бидний хээрийн шинжилгээний явцад Ханбогд сумын өндөр настан Бандиа гуайн гэргий, залуу малчин Алтангэрэл, Баян-Овоод мөн хэд хэдэн хүмүүс энэхүү бугуйвчийг зүүсэн байсантай таарав. Өндөр Лувсангийн хийцийн энэ бугуйвчийг эдгээр хүмүүс багадаа аав ээж болон дээдсээсээ өвлөн авчээ. Тухайлбал Алтангэрэлийг 7 нас хүрэхэд нь ээж нь энэхүү бугуйвчийг анх зүүж өгсөн байна. Мөн нэлээд мөнгө цутгаж хийсэн хоёр мөнгөн бөгжийг мөн багаасаа зүүсэн, одоо мөнгө нь барагдаад нимгэн болоод байна гэж ярьж байв. Иймд Ноён-Сэврэйн хийц хэмээн алдаршсан энэ нутгийн мөнгөний урлал нь үе дамжуулан хэрэглэхэд эдэлгээ дааж хадгалагддаг тэр хэрээрээ өвөг дээдэс, өв соёлын тухай мэдээ, уламжлалыг тээж чаддаг байна.

[24] Баян-Овоо сумын иргэн Сүхбаатарын ярианаас. 2010 оны 10 дугаар сарын 27.



Ханбогд сумын Улаан толгойн усанд залуу малчин Ц. Алтангэрэл өндөр Лувсангийн хийцийн бугуйвчийг эдэлж хэрэглэж байна.





### 2.1.7 Дархан хүний 3 цээр

“Дархан хүн хутга, цоож, тамгыг олноор хийдэггүй, 1 тамга бодын үнэтэй, хуурай өгдөг, цоож хармын сэтгэл тээдэг тул цээрлэдэг.”[25]

“1970-аад оны үед Өмнөговьд банк ухсан маш том хэрэг гарсан юм. Хулгайчийг тодруулж чадалгүй арав гаруй жил болсон бөгөөд тухайн үеийн төмрийн сайн дархан уран Санжийг сэрдэж байсан юм. Банкний төмөр цоожийг гагцхүү уран Санж л хайлуулж эвдэж чадна гэж үзэж байжээ. Гэвч хожим нь Ангараг гэдэг тагнуулын албанд ажиллаж байсан Цогт-Овоогийн хүн авсан болох нь тогтоогдсон юм.”[26]

[25] Ханбогд сумын иргэн дархан Борхүүгийн ярианаас, 2010 оны 10 дугаар сарын 26-ний өдөр.
[26] Баян-Овоо сумын иргэн Сүхбаатарын ярианаас, 2010 оны 10 дугаар сарын 27-ний өдөр

Дарханы урлал сэргэсэн нь зах зээлтэй холбоотой гэж хэлж болохоор байна. Учир нь үе дамжсан дархчууд бус шинээр сурч эзэмшсэн тохиолдол бас байна. Тухайлбал Борхүү гуай дархан удамтай биш боловч өөрөө сурсан. Түүнийг Л. Батаа гуай "би тийм дархан мэдэхгүй юм байна, хүнээс жаахан юм сурсан" юм гэнэлээ хэмээн хүлээн зөвшөөрөхгүй байгаагаа илэрхийлж байв. Өөрөөр хэлбэл удам дамжсан мэдлэгийг тухайлбал удам дамжсан дарханы мэдлэгийг хүлээн зөвшөөрч шинээр сурсныг үл таашаах хандлага байна.

### 2.1.8 Үе дамжсан тамхины хөөрөг

Үе дамжсан түүхтэй эд зүйлсийг хадгалж, эдэлж хэрэглэж явах нь Монголчуудын соёлын нэгэн чухал хэсэг байдаг. Ялангуяа нэр хүндтэй төр нийгмийн зүтгэлтэн, эсвэл өвөг дээдсээсээ уламжлан ирсэн хөөрөг барих нь Монгол эрчүүдийн соёл бахархлын нэгэн хэсэг билээ. Бид үүнийг онцлон дурдаж байгаа нь чухам ийм өвийн зүйлсээр биет бус өвийн мэдлэг, түүх дамжин тээгдэж байдаг хэмээн үзэж буйтай холбоотой. Ирсэн зочин гийчинтэй хөөргөө барьж тамхилах зуураа хөөрөгнийхөө гарал үүсэл, түүх, домог, залгамжлалыг ярьдаг. Тэрхүү яриа тухайн хөөрөгний эзний талаарх ойлголт төсөөллийг бий болгодог. Өвөг дээдэс, эрхэн залгамжлан хадгалж яваа нь тухайн хүний нийгмийн байр суурь, ухаан, нурууг илтгэн харуулна. Тухайлбал Манлай суманд аж төрж буй Шагдарсүрэн гуай нь алтан ургийн хүн бөгөөд түүнд сүүлчийн хошууны засаг ноён төрийн сайд дээдсийнх нь хөөрөг хадгалагдаж байна. Социализмын үед тэрээр алтан ургийн хүн гэдгээ нууж, дарж явах цаг байсан тул өвөг дээдсийнхээ ч түүхийг сайн мэдэхгүй, түүхийн номноос үүвэр түүвэр ойлголт авчээ. Гэвч түүнд өвөг эцгээс нь ээжээр нь дамжин ирсэн хөөрөг хадгалагдаж байна.

| | | |
|---|---|---|
|  | <br>Ханбогд сумын дархан Борхүүгийн хөөрөг | <br>Баян-Овоо сумын иргэн Л. Батаагийн хөөрөг |

Л. Батаа "Миний барьж байгаа хөөрөг нь Дандар эмч гэдэг хүний хөөрөг. Хүмүүс ярихдаа, далайн ёроолд 1000 жил болсон мөс гэж ярьдаг. Энэхүү хөөрөгийг "Хэсүүжин" гэж нэрлэдэг. Шүрэн толгойтой хүрэн хөөргө. Гартаамаар голцуу хөөрөг хийдэг. Бөгж, бугуйвч, ээмэгний шигтгээг мөн хийдэг. Манай нутагт энэхүү чулуугаар Лувсан гэдэг хүн юм хийдэг байсан. Хавчийн зүүн урд талаас их олддог."

### 2.2 Уртын дуу,ерөөл магтаал

Энэ бүс нутаг дахь уртын дууны уламжлал, дэгийн талаар Баян-Овоо сумын иргэн Сүхбаатар, Цээнзэн, Л. Батаа, Даланзадгад сумын Д. Бямбаа нартай ярилцав. Сүхбаатар гуай тайж удамтай хүн бөгөөд дээдсээсээ өвлөн авсан уртын дууны түүвэр хадгалж байна. Тэрээр ярихдаа *"социализмын үед үзэл сурталд харш хэмээн дуулагдаж байгаагүй, олонд түгж дэлгэрээгүй олон сонирхолтой дуунууд энэ түүвэрт багтсан байдаг. Мөн зарим уртын дууны үгийг зориудаар болон санамсаргүйгээр өөрчлөн гажуудуулж дуулж ирсэн болохыг мэдэж болохоор байна."*

Цээнзэн гуайнхан ах дүүгээрээ хуурч, уртын дууч улс бөгөөд түүний дүү нь төрийн хан хуурч Цэрэндорж гуай ажээ. Тэрээр 2010 оны 9 дүгээр сард Энержи Ресурс компаниас Цогт-Овоо суманд зохион байгуулсан "Говь-Шанхын гурван уртын дууны тэмцээн"-нд оролцож гуравдугаар байр эзэлсэн тухайгаа хуучилахын хамт Говь-Шанхын гурван дууны домог, ая дэгийн онцлогийн тодруулав. "Говь Шанхын гурван дуу гэдэг нь энэ нутгийн Гэсэр лам хэмээх хүний зохиосон гурван дуу юм. Эдгээр нь "Өндрийн сайхан", "Хулч бор", "" . Одоо Өндрийн сайхан-ы аяыг зөв дуулах хүн байхгүй болсон байна. Тус тэмцээн болохын өмнөх өдөр бүх оролцогчид бэлтгэл хийсэн. Би Өндрийн сайхан-ыг дуулахад зарим сэргэлэн залуучууд бичиж аваад давтаж бэлтгэсэн байсан. Гэсэн ч олигтой аяыг нь олж чадахгүй байна. Ер нь говийн уртын дууны уламжлал тасрах гээд байна шүү".

*"Шанхайн Ар ширээ шавхадай "гэдэг газар "Гэсэр" Гэлэн гэдэг баян хүн байсан. " Гэсэр" гэлэнийн хурдан хул морь байжээ. "Гэсэр" гэлэн сангийн далайн хажууд хүнтэй муудан, хүн алсан хэрэгт ороод байв. Тэрээр тэр өдөртөө хул морио барьж унаад богдийн хүрээ орсон гэдэг. Тэгээд хүрээнд очиж хятадийн пүүс дээрэмдэж байгаад баригдсан учир тэнд хүн алсан байх учиргүй гээд хулгайлсан хэргийнхээ мөнгийг төлж гарч ирсэн домогтой. Домогт гарч байгаа хул мориний тухай 3 дуу төрсөн."Хурдан сайхан, Өндөр өвс, Хулч морь"*

Л. Батаа гуайд түүний өвөө нь уртын дуу зааж өгчээ. Эхлээд уртын дууны үгийг цээжлүүлж эргэн шалгадаг байжээ. Хожим найр, хуриман дээр тэдгээр дуунуудын аяыг сонсохоор үгийг мэддэг тул амархан ая хөг нь орж ирж байсан гэж ярьж байв. Тэрээр өөрийн сонирхлоор энэ нутагт дуулагддаг байсан уртын дууны үгийг цуглуулж нэгэн дэвтэр болгоод байгаа бөгөөд боломж гарвал хэвлүүлмээр байна гэв.

Сүүлийн 20 гаруй жил юм харахаа больсон тэрбээр багын дууны үгийг сайн цээжилдэг сургуулиараа дууны үгийг хүнд хэлж бичүүлдэг нэгэн ажээ. Биднийг ярилцаж байх зуур намайг бич гээд "Ертөнцийн гурван завхай" гэсэн гурван цуврал дууны үгийг дуудаж, домог түүхийг хэлж өгөв. (Батаа гуайн уртын дууны түүвэр  зээ охин Отгонцэцэгт байдаг, түүний утас 88308219)Тэрээр Түмний эх, Өндрийн өвс, Хулч морь, Шавь хурлын магнай "Шашин төрийн дуу", Төрийн товчоо / хүүхдийн дуу/, Түмний эх /хурдан морины дуу/-ы үгийг бидэнд хэлж бичүүлэв.

Д. Бямбаа гуай мөн Говь Шанхын гурван дууны тэмцээнд оролцогч бөгөөд мөн Даланзадгад сумын 3 дугаар сургууль дээр уртын дууны дугуйлан хичээллүүлж байна.

Могойт бригадын  иргэн: Уртын дууны өв сан нь монгол оронд байдагаараа  оцлогтой. Манайд Говь шанхийн алдарт дуучин Ханшин боол гэдэг агуу дуучин хүн байлаа. Норовдорж  нэгдлийн дарга олон жил хийсэн хүн. Таванжин. Зургаанжин Банзрагч.Ч.Бат-өлзий зэрэг олон дуучид байгаа. Адилбиш захиралтай сургууль бий тэрэнд би дугуйлан хичээлүүлдэг юм.

Говь Шанхын уртын дууны дэг, уламжлалыг өвлөн тээгчид

| | | |
|---|---|---|
|  |  |  |
| **Баян-Овоо сумын иргэн Хөх хадны бууцанд нутаглаж буй Цэнзэн** | **Баян-Овоо сумын иргэн Л. Батаа** | **Даланзадгад сумын иргэн Д. Бямбаа** |

Ханбогд сумын төв дээр аж төрөн сууж буй Авираа гуай энэ нутагт ирээд тэр үеийн уртын дуучдаар дуулах ухааныг суралцжээ. Мөн тэрээр хоолойн цуур хэмээх нэн онцгой ур чадварыг эзэмшсэн. Тэрээр "Эрэглэнгийн зоо" зэрэг дуу дуулж, хоолойн цуурын аялгуу бичүүлэв.

Ханбогд сумын иргэн Цэдэнгомбо, Идэрцог ерөөл хэлдэг ба Хулгарын усны Сайхансамбуугийн Батсүх гуай сум, орон нутгаа магтсан өөрийн зохиосон ерөөлөө хэлэв."

Дуламсүрэнгийн Авираа гуай Өмнөговь аймнийн Ханхонгор сумын нутгийн уугуул иргэн. Харин одоо Ханбогдын суугуул иргэн болсон. Анх 1964 онд сувилагчаар ирээд 27 жил ажилласан.

*"Би уртын дууг анх Малжиг гуайгаас сурсан. Ер нь энэ нутгийн ардаас сурсан гэж хэлж болно доо. Данзанравжаагийн зохиол "Эрэглэнгийн дээгүүр" дууг Малжиг гуайгаар заалгаж байсан бол "Гүйдэл сайт үрээн зээрд " дууг, хадам эгч Ийжийхүү гэдэг хүн надад анх зааж өгч байлаа. "Шар талын цэцэг " дууг Улзанаар заалгасан. Энэхүү дуунуудыг манай нутгаас өөр газар дуулж байгаагүй. Миний нэг дуу радиогийн алтан сан хөмрөгт одоо болтол хадгалагдаж байгаа. Би өөрийнхөө дуулсан дууг одоо сонсдог юм. Тэр үед би залуу байждээ" гээд инээв. Данзанравжаагийн зохиосон дууг болохоор Дорноговь сэргэлэнтээд авчихсан юм байлгүй дээ. "Эрэглэнгийн дээгүүр" дууны хоёр түрлэгийг би мэднэ. Харин энэ дууны үгийг нь сайн мэддэг Надмид гэдэг өвгөн байж байгаад өөд болчихсон юм. Тэр өвгөн бүр, уртын дууны түүвэртэй хөгшин байсан. Намайг бичиж аваарай гээд л байсан би ч яахав" чоно үүрэндээ гэгчийн үлгэрээр" бичиж авахгүй байсаар байгаад энэ дээ хө.*

### 2.3 Цулхир, бажууны гурил хийх арга ухаан

| | | |
|---|---|---|
|  **Баян-Овоо сумын өндөр настан Цэдэн-Иш гуай цулхир түүж, цулхирийн будаа, гурил хийж байна.** |  **Түүж, хатаасан цулхир** |  **Цулхирийн будаа** |

Дэлхийн II дайны үед гурил, будаа хомс байсан цагт говийнхон цулхирын гурил хэрэглэж байжээ.

Ханбогд сумын Улаан толгойн усанд нутаглаж буй залуу малчин Цэцгээгийн Алтангэрэл, түүний эхнэр Насан-Өлзий нарын ээж Цэдэнхүү гуай, Баян-Овоо сумын Л. Батаа, Раш гуай нар бидэнд цулхирын гурилыг түүх, хатаар, будаа, гурил хийх арга ухааны талаар нарийвчлан ярьж өгсөн юм.

Тогоо хайрханы баруун Хавтгай хярд цулхир их ургадаг. Савар, гадараар шигшдэг. Гуулин байдаг. Кортсон бурхантсан, шарласан хүнд унд хийж өгдөг.

Рашням гуай цулхирын гурилын тухай ярихдаа: "Малын арьсыг дэлгэж нөгөө цүлхэгрийнхээ үрийг ойчуулж салхинд цайруулж халсыг нь хийсгэж улаан шаргал идээ гаргана. Хоол ундандаа хэрэглэх гурил хийнэ. Том том, бүдүүн бүдүүн ургана. Ер нь бол бороо ихтэй жил их ургана. Тогоонд ус хийж, шигшүүрт хийж зайлахад шороо нь үлдэнэ. Хоол ундандаа эм болгон хэрэглэнэ. Модон ууранд хийж гурил болтол нь нүднэ. Шар өвчинд уудаг гоёотой хольж иддэг. Шар өвчинд сайн. Эх дэлхийгээс авах юм ч их бий. Цулхирийг хуурдаг.

"Лянги " нүдүүр бутлагч маш их удаан чанадаг бас маш их шээс хүргэдэг. Бас таван цулыг угаадаг. Цүлхэгрийг тарихад маш их ус хэрэгтэй.

Бажууны гурилыг мазаалай их иддэг. Гишүүний навч буюу Бажуун гэж хэлж болно. Бас ногтруу шувуу дуртай.

*Л. Батаа цулхирийн гурилын тухай:*

*"Цулхирыг эхэлж түүгээд, том шилмүүсийг нь шигшдэг. Шигшүүрийг модон хүрээг олон янзаар хийсэн байдаг. Малын арьсаар ч хийдэг. Түүн дээрээ цулхираа хийж шигшинэ. Тэр будаа шиг гоожиж байдаг. Цулхир нь будаа шиг бөөрөнхий, дугуй хэлбэртэй, ухаа улаан өнгөтэй. Цулхираа зэрлэгээс салгасаны дараа том ширмэн тогоонд хийж шар тос, өөхөн тос хийж хуурна. Тэгээд маш удаан буцалгасны дараа цулхир болоод ирхээрэй шаргалтаад хатуураад ирнэ. Одоо тэгээд хатуурсан цулхираа модон ууранд хийж нүдэж нутаглана. Одоогийнхоор бол арвайн гурил юм. Түүнээр унд хийхийн тулд буцалж буй цайнд хийж самраад байхад элс нь шанаганд үлдэнэ. Үлдсэн үлдэгдлийг нь хаячихаад цайгаа сүлнэ. Цулхирын гурил их түүдэг айлууд ширмэл эсгийг даавуугаар өнгөлөөд, том эсгий уут бэлтгэдэг. Энэ нь 2 талдаа зэс гогцоотой байдаг. Намар түүж өвөл, хавар, зунжингаа иддэг байв. Цулхир нь ногоо анх гарах үед үндэслэдэг."*

*"Ямааны сайхан самбар дээр цулхирийг шигшинэ. Янгирын өргөстэй эврээр хийсэн, үзүүрийг цоолж 2-3 алд модонд хаддаг. Цулхирыг янгирын эврээр цохиж балбахад, цулхирыг будаа нь ялгардаг. Ямааны арьсыг хулсан дээр татаж дэлгээд. Халуун шөвгөөр цоолоод шүүр хийнэ. Идээ нь ойчихоор нүх гаргаад шигшинэ. Цулхирыг түүхийгээрээ ханайд шуухаанд сайн. Цулхирыг болгохдоо, ширмэн тогоонд хийгээд, үхрийн өрөм, тэмээний таваг хийж хуурна. Элгэнд маш сайн."*

**Хонины шарилжны будаа**

Хонин шарилжны будааг нь цагаан будааны оронд хэрэглэж болно. Цулхирын гурилыг бодвол маш зөөлхөн. Хонин шарилжийг хураахдаа, нэг тал руу нь налуулаад, хатуу юмаар дараад хатаана. Бас хонин шарилж нь түүхийгээрээ ханиаданд сайн. Бурхантсан буюу кортсон хүнд цулхирийн гурил өгвөл сайн байдаг.

**Бажууны гурил**

Бажууныг түүж хатаан ууранд хийж нүдээд гурил болгож хуймаг хийж иддэг. Цагаан гурил болдог, хуймаг гэдэг нь гамбиртай адил хавтгай боов юмаа.

Буурцаг, далайн хар Хятадаас ирдэг байсан.

**Бусад хүнс, эмийн ургамал**

Алтны ар, Чихэр өвс, Няндуужин /юмдүүжин/ Халгай, Бажууны буурцаг, Шар дашиг, Хужир гэх мэт ургамлыг хатаагаад нүднэ. Баян-Овоо сумын Хонхор ууланд чихэр өвс ургадаг. Баян-Овоо сумын Үнэгэдэд цөсний чулуу хайлгадаг Гиваан гэдэг чулуу байдаг.

## 2.4 Малын тамганы соёл

Монголчуудын нүүдлийн бэлчээрийн мал аж ахуйн нэгэн томоохон соёл бол малын тамга юм. Судалгааны бүс дэхь малчин өрх айлууд малын тамга хэрэглэсээр байна. Тухайлбал Манлай сумын малчин Батсүх гуай нүдтэй, амтай загасан тамга, Баян-Овоо сумын малчин Рашням П үсгийн хэлбэртэй тамга хэрэглэж буй ба түүний эхнэрийн тал дан саран тамгатай айл байжээ. Саран товруутай товхтой буйл, туухай, уйлан тамга, дан саран, чандмань зэрэг тамга энэ бүс нутагт өргөн тархжээ.

|  |  |
|---|---|
| **Баян-Овоо сумын малчин С. Батсүхийн уйлан тамга** | **Баян-Овоо сумын малчин Рашнямын П үсэг хэлбэрийн тамга** |

**2.5 Монгол гэрийн урлал**

Монголчуудын уламжлалт "хуруу тооно"-ыг хийж урлах арга ухаан өнөөдөр тасраад байгаа бөгөөд Баян-Овоо сумын залуу малчин дээдсээсээ уламжилсан хуруу тоонотой гэрт амьдарч байна.



"Хуруу тооно" Баян-Овоо сумын малчин



Өвөрхангай аймгийн Уянгын хийцийн шинэ гэр, Ханбогд сумын малчин Лэнтэнгийнх.

Шинэ гэр барьсан айл өрхүүд гол төлөв Улаанбаатар, Өвөрхангайн Уянгын гэрийг худалдан авч хэрэглэж байна. Энэ бүс нутаг мод ховортойгоос гэр урлах нь бага модны дархчуудын зөвхөн захиалгаар хааяа нэг маш цөөнийг урладаг байна.

### 2.6 Гэр ахуйн уламжлалт сав хэрэглэл

Ингэний айраг буюу хоормог исгэх модон хөхүүрийг малчин айл өрхүүд хэрэглэж байна. Манлай сумын иргэн өндөр настан Дашням гуай модон хөхүүр, хувин хийж байна. Модон хувин, хөхүүрийн хэрэгцээ, мөн түүнийг үйлдвэрлэгчид байна.



### 2.7 Гэрийн тавилга, засал

Малчин өрх айлууд гол төлөв гэрт амьдарч байна. Манлай сумын залуу малчин Галаа өвөлжөөн дээрээ байшин барин сууж байсан. Гэрийн тавилга, дотоод засал чимэглэл нь ерөнхийдөө уламжлалт байдлаа хадгалсан буюу гэрийн баруун, зүүн талаар төмөр болон модон ор, хойморт хээтэй модон авдар, аяганы эрэгнэг, зуух, цайны явган ширээ зэргээс бүрдэж байна. Бидний буусан ихэнхи айлууд Хятадын 14 инчийн хар зурагт, нарны зай хураагуууртай байлаа. Энэ намраас олон суваг гардаг антенн хэрэглэхэд сар бүр татвар төлөх болсон тухай малчид дурдаж байв. Мотоцикл, Excel машинтай айлууд цөөнгүй байна.







Баян-Овоо сумын залуу малчин Ц. Мөнхбат, Гүн хар хэмээх газар өвөлжиж байгаа нь.

## 2.8 Дуглуур тойрог хийх арга ухаан

Манлай сумын Жуулхүү гуай эхнэрийн хамт уламжлалт эсгий ширдэгийг ширж борлуулж байна. Өмнөговийнхон гэрт дэвсэж хэрэглэдэг энэхүү ширдэгийг дуглуур, тойрог хэмээн нэрлэдэг байна. Гар аргаар хийдэг учир их хэмжээгээр хийж борлуулах явдал байхгүй шинэ гэр барьж буй хүмүүсийн хүсэлт, захиалгын дагуу цөөн тоогоор хийдэг байна.

Даланзадгад сумын Д. Бямбаа гуай "урьд дуглуур, тойруулгыг Түмэннаст, зоос, угалз, ханан сүлжээ зэрэг хээтэй хийдэг байсан. Хүрэн одончуугаар захалдаг их бөх байдаг. Ахарын эсгий буюу сайн эсгийгээр хийдэг байсан" хэмээн ярив.



Манлай сумын төв, Жуулхүү гуай эхнэрийн хамт ширмэл ширдэг ширж байгаа нь



## 2.9 Бурхан тахил, шүтээн

Шашингүйн үзэл давамгайлсан социалист орчин үежилтийн үед Монголчууд шүтдэг бурхан тахилаа ил тавьж шүтэж тахих эрхгүй байсан боловч 1990-ээд оноос шүтэх бишрэх эрх чөлөөтэй болсноор айл бүр бурхан тахилтай болсон гэхэд ташаа болохгүй билээ. Судалгааны бүс дэхь айл өрхүүд Алтангэрэл судар  болон Очирваань бурханыг залж тахиж байна. Эдгээр бурхан шүтээнүүд нь гол төлөв өвөг дээдсээсээ уламжлан авсан байх ба шашин хориотой байх үед далд хийж нууж байгаад гаргаж ирсэн байх нь олонтой байна.



Ханбогд сумын Хулгарын ус хэмээх газар өвөлжиж буй малчин С. Батсүхийн бурхан тахил



Баян-Овоо сумын малчин, уртын дууч Цэнзэн гуайн бурхан тахил





## 2.10 Хүнс хоол

*Унд* нь Өмнөговийн энэ бүс нутаг дахь өдрийн үндсэн хоол, хүнсний нэг бөгөөд будаатай цайнд түүхий мах эсвэл борц хийж буцалгаж бэлтгэдэг. Манлай сумын малчин Энхбаясгалангийн гэргий Бямбасүрэн "унд идэхгүй бол өдөр ч өнгөрөхгүй шүү дээ" хэмээн инээж байв.

*"Тогоон дотроо өөх будаа хийн хуурч, цайгаа нэлээн өтгөн чанаж бэлэн болгоно. Цай шингэн байвал цай амтгүй хярам болно. Будаагаа маш сайн хайрвал амттай сайхан болдог. Будаагаа хуураад тусгайлан бэлдсэн цайгаа, шар болтол хуурсан будаан дээрээ хийж сүлнэ, / цайгаа эхлээд сүлэх юм бол улаан өнгө суунa / мөн тэгээд жижиглэж бэлдсэн махаа дээрээс нь хийж жигд галаар 20-25 минут буцалгаж болгоно."*



Өглөө гол төлөв цай боорцог идэж, өдөр ундаа хийдэг. Өдөр унд хийж идсэн зарим үед орой заавал махан хоол хийдэггүй. Хоормог, цай уугаад болчих нь байдаг гэнэ. Хоол хүнсэнд мах, гурил, цагаан будаа зэргээр унд, шөлтэй хоол, цуйван, бууз, хуушуур гол төлөв хийж хэрэглэж байна.

## 2.11 Овгийн нэр, ураг төрлийн хэлхээ холбоо

Баян-Овоо сумын Сүхбаатар "Баян-Овоо суманд Улаан даавуу, Өндөр мануул (Боржигин), Ёохчууд (түрэг гарлын овог) гэсэн ердөө л 3 овог бий, гэтэл 120-30-аад овог тэмдэглэгдээд байгаа. Миний бодлоор 1990-ээд оноос хойш овгийг буруу тогтоосон. Энэ нь үндэсний аюулгүй байдалд харшлах аюултай. Ер нь бол овог тогтоосон нь зөв. Дундговийн Эрдэнэдалай 5 овгийнхон байдаг. 3 үе дотроо суусан хүмүүс алаг мариа. Шинийн 3-ний дотор ордоггүй алаг мариа хүмүүс дээр орж золгодоггүй."



Баян-Овоо сумын ургийн хэлхээ холбоог Сүхбаатар гуай судалж үндсэн 3 овгоос гаралтай хэмээн үзэж байна.



Ханбогд сумын тэмээчин Отгоолой Удайд овгийн хүн бөгөөд Удайд овгийнхон тахьдаг өөрийн овоотой ажээ.

## 2.12 Чулуун гэр болон бусад тоглоом

Ханбогд сумын малчин Бандиа, Бүнтэн, Баян-Овоо сумын малчин Цэдэн-Иш нарын үр хүүхдүүд нь багадаа тоглож байсан чулуун тоглоомын газрууд одоо хүртэл хадгалагдаж байна. Тэд ярихдаа "одоогийн хүүхдүүд чулуун гэр барьж тоглох явдал байхгүй болсон, бидний багад болон 1960-70 он хүртэл тоглодог байсан. Тэдгээрийн үлдэц одоо тарж бутарсан буйр байна" гэв.



Баян-Овоо сумын иргэн Төмөртогтохын багадаа тоглож байсан чулуун тоглоомын буурь



Баян-Овоо сумын малчин, өндөр настан Цэензэн гуай болон түүний хөвгүүд эвлүүлдэг модон болон төмөр утсан тоглоом хийж чаддаг, мөн багадаа тоглож өссөн байна. Мөн малчин айл өрх бүрт шагайн тоглоом байгаа ажээ. Гэвч шагайгаар тоглох нь түгээмэл биш болсон байна. Манлай сумын малчин Энхбаясгалангийн охидууд шагай шүүрэх, морь уралдуулах зэрэг тоглоом тоглодог гэж хэлж байна.








Цэензэн гуайн хөвгүүд модон болон төмөр утсан тоглоом өөрсдөө хийж тоглодог байсан ба өнөөдөр үр хүүхдүүд нь ч бас тоглож байгаа юм байна.

## 2.13 Шагайн харваа

Монголын уламжлалт шагайн харваан тоглоом нь 1990-ээд оноос хойш тоглоом болон спортын төрөл хэлбэрээр өргөн дэлгэрсэн билээ. Ханбогд сумын малчин Бандиа гуай сумын шагайн харваа шигшээ багт орж олонтоо тэмцээн уралдаанд орсон бөгөөд олон шавь нартай гэнэ.



Ханбогд сумын малчин Бандиа гуай



Бандиа гуай Ханбогд сумын шагайн харвааны багийн гишүүн ажээ.



## 2.14 Говьчуудын хорио цээрийн ёс

Говьчуудын хорио цээрийн ёсны судалгаа цаашид үргэлжлэх бөгөөд энэ удаагийн хээрийн шинжилгээгээр тэмээний махтай холбоотой цээрүүд, бурханы өмнө тэмээний мах гаргадаггүй байсан болон чулуун тоглоомыг нутаг дээрээ хаяж нүүдэггүй, ороонгоны эврийг болгоомжтой хэрэглэх буюу тэмээнд ачиж болдоггүй, хэрэв ачвал тэмээ хээл хаядаг, бүйлс түлдэггүй зэрэг хорио цээрийн зан үйлийг тодруулав.

Бандиа гуай хуучилахдаа хүүхдийн чулуун тоглоомыг нутаг дээрээ хаядаггүй Манлайд Долио Мятав гэдэг хүн хүүгийнхээ 2 тэмээ тоглоомыг хаяснаас хүү нь ухаан солиотой болсон гэж ярьцгаадаг юм. Мөн тэмээний махыг ихэд сэжиглэж  тэмээ алдаг айлд орохоос цээрлэж, сэжиглэдэг байсан гэв.

Хонины толгойг өвдөг дээрээ тавьж байж муулдаг, уул довын орой дээр бие засдаггүй, хэцээс хэцэд явж байгаа аргал, зээр, гөрөөсийг агнадаггүй.

## 2.15 Шашин, бөө мөргөл

Энэ бүс нутагт Монголын бусад нутаг газар оронтой адил 18-20 дугаар зууны эхэн үед бурханы шашин өргөн дэлгэрч олон сүм хийд байгуулагдсан байсан. 1990-ээд оноос хойш Ханбогд сумын Дэмчигийн хийд, Өлгийн хийд үйл ажиллагаа сэргээгээд байна. Ханбогд сумын төв дээр Пунцагтэгчилэн хийд мөн үйл ажиллагаа явуулж байна. Баян-Овоо, Манлай сумынхан хувьсгалаас өмнө Цогт-Овоо нутаг дахь Шанхын хийд рүү очиж цам, майдар эргэх зан үйлд оролцдог байсантай холбоотой олон түүх, хууч яриа байна.

Мөн Баян-Овоо сумынхан Налих, Долоон шар загийн хийдтэй холбоотой олон түүх, уламжлалаа хадгалж байна. Тухайлбал бидний уулзаж ярилцсан Л. Батаа, Цэдэн-Иш нар Долоон Шар заг, Налихийн хийдэд шавилж байсан байна. Баян-Овоо сумын гол тахилгатай байсан овоодын сан судрыг мэддэг хүн үгүй болсон тул одоо дахин тахих боломжгүй болсон гэж Л. Батаа гуай үзэж байв. Мөн 3 багийн гол тахилгатай овоод нь урьд хошууны засаг ноён Долоон шар заг хийдийн номтой ламтай муудалцсанаас тэрээр гурван хараал булсан газар гэсэн тайлбар хэлж байв.

Ханбогд суманд 20 гаруй бөө тодроод байна. Орой бүр бөө нарын онгод дуудлагын зан үйл болж байна. Гол төлөв залуу, энэ нутгаас тодорсон бөө нар гэнэ. Манлай суманд Ханбогдоос бөө нар ирж шинэ овоог тахилга шүтээн болгосон байв. Цэцгээ, Гүнж гээд 20 гаруй бөө нар дээр нэмэгдэж дахин шинээр 7 бөө тодорч байна. Бид Очир хэмээх бөөтэй уулзах хүсэл тавьсан боловч холын хүнийг хүлээж авахгүй гээд уулзаж чадсангүй. Дараа дараагийнхаа хээрийн шинжилгээгээр нарийвчлан тодруулах болно.



Ханбогд сумын төв дээр Пунцагтэгчилэн хийд



Пунцагтэгчилэн хийдийн лам Тэгшжаргал

# 3.БЭЛЧЭЭРИЙН МАЛ АЖ АХУЙ ЭРХЛЭН АМЬДРАХ АРГА УХААН

## 3.1 Уламжлалт соёлын суурь дэг журам ба бэлчээрийн мал аж ахуй эрхлэн амьдрах сонголт

Бэлчээрийн мал аж ахуй эрхлэн амьдарч буй малчин айл өрхийн хувьд амьдралын энэ хэв маягаа цаашид үргэлжлүүлэхэд байгаль орчны өөрчлөлт, отор хийх бэлчээр нутаг хомс, мал эмнэлгийн үйлчилгээ баталгаатай бус, малын үржлийг зохицуулах боломж хязгаарлагдмал, зах зээлд ойр байхын тулд сумын төв, хилийн боомтын эргэн тойронд нутаглах зэрэг бэрхшээлтэй асуудал тулгарч байгаа ажээ. Гэвч бэлчээрийн мал аж ахуй эрхлэх нь залуу гэр бүлийн хувьд амьдрах нэг томоохон нөөц, сонголт гэж үзэгдэж байна. Үе дамжсан малчдаас гадна боломжит нөөц, сонголт хэмээн үзэж мал маллах нь түгээмэл болсон байна. Мал маллагааны арга туршлагыг өгүүлсэн ном товхимол тараагдаж байна.

Үе дамжсан малчид мал маллагааны арга туршлага, мэдлэг ухааны хувьд амьдралын боломжит сонголт хэмээн анхлан мал мал маллаж байгаа айл өрхөөс зуслан, өвөлжөөний газар нь үе дамжин уламжлан авахаас эхлэн давуу талтай байна. Үүнийг даган олон мэдлэг ухаан дамжин хадгалагдах боломжтой болдог.

Залуу малчин өрх айлууд хүүхдүүддээ сайн боловсрол олгохын тулд сумын төвд хүүхдээ сургуульд ороход хэн нэг нь 1 -2 дугаар анги хүртэл нь хардаг байна. "Олон хүүхэдтэй болох сонирхолгүй (хүүхэд өсгөхөд хамаг залуу насаа зарцуулж хөгжлөөс хоцормооргүй байна" хэмээн Манлай сумын залуу малчин Алтангэрэл, түүний эхнэр нар өгүүлж байв. Зарим залуу малчин өрх айл зуданд малаа алдаж хорогдуулсан тохиолдолд, сумын төв орж амьдрах замыг сонгож байгаа ажээ.

Ихэнхи залуу малчин гэр бүл аль нэг талаасаа үе дамжин ирсэн бууцыг залгамжлан авч нутаглаж байна. Харин үе дамжсан бууц, бэлчээргүй хэн нэгэн мал маллах шийдвэр гаргахад шинэ бэлчээр бууц олж авах боломж бага байна.

Бэлчээрийн мал аж ахуй эрхлэн амьдарч буй малчин Монгол хүн гэдэг уламжлалт соёлыг гол тээгч юм. Монголын төв ба хангайн бүсэд бэлчээрийн даац хэтэрч байгаатай харьцуулахад энэ бүс нутагт бэлчээрийн даац хэтрэх, бэлчээрийн маргаан бага байна. Мөн бууцаа өв залгамжлан авах замаар харьцангуй удам дамжсан малчдыг тэтгэх тогтолцоо оршиж байна гэж үзэж болохоор байна.



Манлай сумын залуу малчин гэр бүл Алтангэрэл, эхнэрийн хамт



Манлай сумын залуу малчин Галаа бууцандаа байшин барин сууж байна.

Бэлчээр, устай холбоотой мэдлэг ухаан

Манлай сумын иргэн өндөр настан Адьяа гуай энэ сумын бэлчээр, өвс ургамлын тухай нарийн мэдлэгийг тээгч юм.

Адъяа гуай ярихдаа:

*"Энд нэлээн загууд байсан. Хөндий, голийн дундуур байсныг хүн амьтан түлсээр байгаад дуусчихсан. Урд хавиараа нэлээн залуу загууд их арвин байгаасай гэж боддог юм. Хангийн ус гэдэг ус бий. Харгана, бут ихтэй тийм л газрууд байдаг. Толийн худаг хэмээх хулан ухаж гаргасан сайн ус байдаг. Баруун урагшаа шавагын төрөл, үндэс сайтай зөөлөн шороо ихтэй (хавар, намар шороо ихтэй) байдаг. Таана бориг нийлүүлж малын тэжээл хийдэг."*



Манлай сумын иргэн өндөр настан Адьяа гуай энэ сумын бэлчээр, өвс ургамлын тухай нарийн мэдлэгийг тээгч юм.

### 1.3 Мал маллагааны арга ухаан

Социализмын үед Ханбогд сумын 4 багийг дөрвөн төрлийн малыг төрөлжүүлэн өсгөх байдлаар зохион байгуулжээ. Одоо энэхүү тогтолцоо үндсэндээ задраад байна. Жавхлант багийн малчин Бүнтэн гуай "би насаараа багийн дарга хийсэн, 7 хоногт багаа тойрч, ахуй амьдралыг нь үзэж явдаг байлаа. Харин одооны багийн дарга нар бараг үзэгдэхгүй юм. Гавилууд багийг 1962 онд хонь, адууны чиглэлтэй болгосон. Энэ үед зохиомол хээлтүүлгийг анх хийж байсан юм.

Баян-Овоо сумын малчин Рашням гуай "5 жилд буураа сольж байх ёстой, гэтэл энэ алдагдаад байна" гэв.

Засгал хэмээх говийн ургамлаар ямаа тэжээхэд маш сайн, борлон ямаанд хавар өгвөл барагтай бол үхэхгүй. Мөн улаан бударгана, засгал хоёр бол ямар ч шороонд улддэг зудын сайн ургамал.

### 1.4Малын хашаа хороо

Судалгааны бүс дэхь малчин өрх айлууд чулуун хороо бүхий бууц зонхилж байна. Манлай сумын нутгийн малчин Гэндэнсүрэнгийн Энхбаясгалангийнх хөрзөнгөө ховхолж түлш, хороондоо хэрэглэхээр бэлтгэсэн байна. Энэ бүс нутгийнхан хөрзөнг "хөр" хэмээн нэрлэнэ. Харин энэ жил хөрзөнгийн чанар муудсан гэж малчид ярьж байв. Өнгөрсөн жил их зуд болж малын тэжээл гэх юмгүй болоод Хятадаас хар хөх өнгийн багсармал орж ирсэн. Түүнийг идсэнээс хойш малын баас муудсан гэж байлаа.



Манлай сумын залуу малчин Алтангэрэлийн бууц




Манлай сумын малчин Энхбаясгалангийн бууц




Ханбогд сумын малчин Батсүх гуайн бууц

### 3.5 Хоточ нохой


Манлай сумын малчин Энхбаясгалангийн бууцан дээр


Ханбогд сумын малчин Лэнтэнгийн хоточ нохой


Малчин Лэнтэнгийн улаан халтар хоточ банхар

| | | |
|---|---|---|
|  Баян-Овоо сумын Цээнзэн гуайн хоточ нохой |  |  |
|  Баян-Овоо сумын Рашням гуайн хоточ нохой |  |  Манлай сумын төвийн нохой |

**1.6 Мөр хөөх ухаан, мөрч**



Баян-Овоо сумын иргэн, гавьяат хилчин Сүхээ 1982 онд Монгол улсын өмнөд хилийг зөрчсөн Хятад улсын иргэний мөрөөр мөшгиж олж илрүүлсэн хүн бөгөөд тэрээр мөр мөшгих ухааны талаар олон сонирхолтой мэдлэг ухаан, чадварыг эзэмшсэн хүн ажээ.

Сүхээ гуай БНМАУ-ын онц хилчин, Рашнямын гэргий

*"Манай улсын хилийг маш олон хүмүүс зөрчдөг. 1991 оны 12 сарын 20 –нд хил давсан хятад эмэгтэйн эрэл хайгуул эхэлсэн. 12 сарын 27-ны өдөр "Номгон" сумын нутагт хөлдөөд үхчихсэн байсныг нь олсон. Мөр хайхдаа олон хүн биш ээ. Харин газар орноо сайн мэддэг ганц хоёр хүн байхад болно. Харин хүний гутлийн хойд өсгийн хэлбэр нь хулангийн тууртай адилхан гардаг. Харин уул,  хадан дээр мөр бол харцангуй хялбар байдаг. Өдөр шөнийн мөр ялгахад амар байдаг. Аргач үгүй шүү дээ шөнө явсан хүний мөр тээгэлж унасан нь их байдаг"* гэж хуучлав.

**Жин тээх соёл**

Л. Батаа гуай: Жинд арьс нэхий тээгээд л гарч өгнө дөө. 12 тэмээ нэг хүнд ноогдоно. Нэг удаа 4-5 хүн явдаг. Хүн олон тусмаа тэмээ олон явна Тэгэхээр нэг их олон хүн явдаггүй юм. Айл бүрээс 2 тэмээ эсвэл 5 хомтой тэмээ өгдөг байсан.

## ӨВТ ГАЗРУУДЫН ЖАГСААЛТ

| | Өвт газрын нэр | Мэдээллийн эх сурвалж | Холбогдох зан үйл, хорио цээр |
|---|---|---|---|
| 1 | Өндөр Богд уул | Өөлий, малчин Алтангэрэл, Галаа | Шүтэж дээдэлдэг уул |
| 2 | Хонхорын овоо | Малчин Алтангэрэл | Тахьдаг овоо |
| 3 | Зааны овоо | Малчин Энхбаясгалан | |
| 4 | Жавхлант уул | Малчин Бүнтэн, Бандиа | |
| 5 | Ханбогд уул | Малчин Бүнтэн, Бандиа | |
| 6 | Номгон уул | Малчин Бүнтэн, Бандиа | Өнгөрсөн жил Баясгалан, Сайхандэлгэр нар тахиулсан. |
| 7 | Гялаантойром | | |
| 8 | Их Өлзийт | Малчин Алтангэрэл, Галаа | |
| 9 | Их Овоот | Малчин Алтангэрэл, Галаа | |
| 10 | Мааньтын овоо | | |
| 11 | Алаг дэлийн овоо | | |
| 12 | Шавагийн дуулга (Догшин гурван дуулга) | | |
| 13 | Хачивцийн дуулга | | |
| 14 | Далайн дуулга | Жавхлант багийн малчин Бүнтэн | Овоо тахьдаггүй |
| 15 | Хүрэн хайрхан овоо | Малчин Отгоолой | |
| 16 | Бор хошууны овоо | Энгэр баг модонд нутаглагч малчин Лэнтэн | |
| 17 | Толийн ус | Энгэр баг модны Хөөвөр хэмээх газарт нутаглагч малчин Бандиа | Хулан гаргасан ус хэзээ ч ширгэдэггүй |
| 18 | Ямаат улааны агуй | Жавхлант баг | Баян-Овоогоос Шаабаатар зэрэг хүмүүс ирж тахьдаг. |
| 19 | Тогоо хайрхан | Малчин Рашням | Могой багаас тахьдаг. |
| 20 | Шархадны бууц | Малчин Рашням | Догшин газар |
| 21 | Үнэгэд, Сэрүүн хайрхан | Малчин Л. Батаа | |
| 22 | Цагаан-Овоо | Сүхбаатар | Могой багийн хүн тавьдаг газар |
| 23 | Шар Дэл | Сүхбаатар | |
| 24 | Хадан цохионы дэнж | Сүхбаатар | Баян-Овоо сумын хүн тавьдаг газар |
| | Зүүн Толь | Сүхбаатар | |
| 25 | Хар-Овоо | Сүхбаатар | |
| 26 | Долоон шар загийн хийдийн туурь | Малчин Л. Батаа | |
| 27 | Налихийн хийдийн туурь | Малчин Цэдэн-Иш | |

| | Өвт газрын нэр | Мэдээллийн эх сурвалж | Холбогдох зан үйл, хорио цээр |
|---|---|---|---|
| 28 | Шувуун нумт овоо | Малчин, байгаль хамгаалагч Рашням | Чингис хааны тахьж байсан дайны сүр хүчийн овоо гэдэг. Лам ирээд сэржим тавьхад улам шороо тавиад байдаг. Рашням гуай өөрөө Мангуд овгийн хүн гэнэ. |
| 29 | Бух хайрхан | Л. Батаа гуай | Догшин хайрхан тахих хүн таардаггүй догшин газар |
| 30 | Ашиг хайрхан | Малчин Ц. Мөнхбат | Харзаг багаас тахьдаг |
| 31 | Хөх овоо | Малчин Ц. Мөнхбат | Налих багийн тахьдаг овоо |
| 32 | Өлзийт хайрхан | Малчин Л. Батаа | Ганжирваа хувилгаан тахьдаг байсан, мөн хүүхдийн овоо ч гэж нэрлэгддэг. |



Манлай сумын нутаг дахь шилийн сайн эр Ширнин хоовонгийн адуугаа нууж байсан хонхор.



Ханбогд сумын залуу малчин Ц. Алтангэрэлийн удмынхны тахьдаг Мааньтын овоо



Ханбогд, Жавхлант багийн нутаг дахь



Ханбогд, Жавхлант баг, догшин гурван Дуулга хайрхан.



Баян-Овоо, Харзаг баг, Рашням гуайн бууцны ойролцоох Шувуун нумт овоо



Баян-Овоо, Налих баг



Баян-Овоо сумын Налих багийн Үнэгэд хайрхан. Сэрүүн хайрхан ч гэж нэрлэдэг догшин хайрхан.

**Зааны овоо**

Зааны овоон дээр байдаг өвөрмөц хонхорын дэргэд ирээд байна. Нутгийн ардуудын домог яриагаар бол Шилийн сайн эр Ширнэн Хоовон гэгч өөрийн адуугаа энд авчирч нуудаг байсан гэж нутгийн ардууд домоглох нь олонтой таарч байлаа. Харин энэ газрыг 2-3 жилийн өмнөөс тусгайлан "овоо" босгож нэлээн хүндэтгэлтэй ханддаг болсон байна. "Сүүлийн үед нэлээд их элс дүүрч хонхор нь улам л багассаар байна" гэж нутгийн ард Г.Энхбаясгалан бидэнд өгүүлэв.

Өмнөговь аймгийн Манлай сумын засаг даргын орлогч Өөлий:

- "Манай сум нэг онцлогтой юм. Тэр онцлог нь гэвэл газар нутгаа их шүтдэг". Манай сум нь баруун талдаа Их Бага Өлзийт уултай, зүүн талдаа Их, Бага Өлзийт уултай, ингээд дөрвөн Өлзийт уулын дунд ажиллаж амьдарч байна. Өмнө талдаа нутгийн босго үүд хаалга болсон Сүм, Суварга уултай. Харин манай Манлайчууд, манлайлан тэргүүлэн явах гэсэн утгатайгаар энэ нутгийг шүтээн болгон дээдэлсээр ирсэн. Тийм ч учраас тэргүүлэн манлайлах зорилготой явдагаа. Миний бодлоор /өвт/ газар гэдэг нь манай нутгийнхны шүтэж дээдэлдэг уул усыг хэлж болох юмаа. Би дөрвөн уулыгаа өвт газар гэж үздэг". Нэгэн домог ярианд: Манай нутагт өвгөн ноёны тухай нэгэн домог яриа байдаг. Өөрийн нутаг орноо шүтэж амьдрахтай холбоотой. Манай сумын төвийг ундаалдаг "Үйзэн" усны талаар домогт гардаг. Нэгэн эцгийн гурван хүү эцэгтээ худаг гаргаж өргөн барьдаг. "Үйзэн, Бүрхээстэй , Хавхаастай " гэсэн гурван худаг гаргаж эцэгтээ өргөн барив. Эцэг нь:
- Үйзэн гэдэг нь үй түмэн их хангайг үеийн үед ундаалж байх худаг юм байна.
- Бүрхээстэй гэдэг нь бүхнийг хангаж байх худаг юм байна.
- Хавхаастай гэдэг нь харин дарагдвал эргэж олдохгүй худаг юм байна гэж хэлсэн.
- Харин тэр үүднээс "Үйзэн" нь хошуугаас аймаг дамнан олон зуун жил биднийг ундаалж байна. "Үйзэн" нь Далай багийн нутагт, " Бүрхээстэй нь Жаргалантад, Хавхаастай нь одоо олдохгүй байна. Манай сумын нутгийн босго болсон Сүм, Суварга болсон хоёр уул маань Гавъяат жүжигчин Дашранзан гуайн аялгуулан хэлж бичсэн "Уулган шар"-ын домогт гардаг. Уулган шар тэмээний толгойг зүүн урагш харуулж тависнаас болж "Галба"-ын говийн тэмээг олон болсон гэдэг. Тэр тэмээний толгойг гадны судлаачид аваад явчихсан гэж ярьдаг. Харин Галбын говийн тэмээг олон болсон гэдэг нь мөн л "Өвт " уулыг шүтэж байсантай холбоотой болов уу. Энэ домогт Сүм, Суварга, Хан Богд уулуудын нэр бий.

- Мөн баруун уулын ардаас тэмээний чулуужсан өвчүү олдсон гэдэг. Тэр чулуужсан өвчүүний толгой болон дотор толгойны хальс нь яг харагдаж байсан гэдэг. Харин тэр чулуужсан өвчүү нь одоо бодоход "цахиур" чулуу байсан болов уу гэж бодож байна.

Баян-Овоо сумын байгаль хамгаалагч Рашням гуайн 1930 онд байгуулсан шонгийн мод нь одоо хүртэл Өгөөмөр нутагт байдаг. Тэр шонгийн модыг хүмүүс хайрлаж хамгаалдаг. Тэр шонгийн модны хажуугаар манжийн зам баларч бүдгэрсэн ч одоо хүртэл харагддаг. Сайн ажих юм бол жингийн зам нь тод харагддаг. Энэ нутагт "Борцагаан " гэдэг уулыг шүтдэг. Шүтээнээ хүндлэн нэрийг нь дэргэд нь дууддаггүй. Оюу толгой, Могойтын ам гэдэг газарууд бий.

**Долоон шар загийн хийд**

Л. Батаа: "Долоон Шар заг " гэдэг газар суудаг байсан. Би чинь 1920 оны хүүхэд, 7 настай байхдаа шавилан суудаг байсан. Манай хамба ламыг Ганжир лам гэдэг байсан. Би чинь 2 төрлийн хөдөлгөөн үзсэн. 4 төрийн нүүр үзэж байна. Манай хийдэд 100 гаруй лам нар суудаг байсан".

Л. Батаа: Долоотын хийд 1000 ламтай, Налхайн хийд 1000 ламтай, зүүн хойно нь Ламын дугана, Уртын хийд, Баруун суваргын хийд, Цэцээ сумын хийд, гэж байсан.

Ганжир хувилгааныг Сангийн далайн баруун тийш Ихэнзээгийн говь гэдгээс залж ирсэн. Эрдэнэ хувилгааны хойд дүр, сүүлийн хувилгаан нь " Алдуул" Дамиран гэдэг хүн байсан.

**Цэдэн-Иш Налихийн хийдийн талаар:**

Налхайн хийдэд гуч, дөчөөд лам хуварга байсан. Хийд нь Лхам бурханыг сахиусаа болгон залдаг байжээ. Монголын зүүн хойд зүгт их тал байдаг. Цаад талд нь өргөн шар хад байдаг. Өргөн шар хадны дотор үхрийн нүдний чинээ жоохон рашаан байдаг. Зүүн хойд талд нь аварга могойн ам байдаг. Түүнийг аварсаг болохоор Бямба бурханыг тахьдаг болсон. Өглөө болгон сан уншдаг байсан.

Зостын жас, Хайлан жас, Ламын чогын жас гэж байсан. Хойд талд нь "Лавиран" байв. Энэ нь жижиг сүм байв. Жонжийн овоог тахихдаа арван цагаан морьтой хүмүүс очоод, дараа нь арван хар морьтой хүмүүс очоод нар зөв, нар буруу тойрдог байсан. Овоон дээр яг юу хийдэг байсныг би мэдэхгүй ээ.

Налхайн хийдийн сахиус нь явчихлаа гэж хүмүүс ярилцдаг байсан. Тэр нь од харваж байгаа юм шиг харагдсан гэж хүмүүс ярьдаг.

1930 онд Хөх зурхай, лоовон, цорж, унзад нарыг цувруулан барьж авч явсан. Өмнөговийн аймгийн төвд болон Могонтын сангийн аж ахуйд аваачдаг байсан. Тэнд очсон хүмүүс эргэж ирдэггүй байсан. Өмнөговиос урагшаа Ламын овоо гэж байсан. Тэндээс ламын эд зүйлс их олддог байсан. Цүлхэгрийн гурилыг улаан идээ гаргаж авч саванд хийн хадгалдаг байсан. Хоол хүнс муудахад ихэвчлэн хэрэглэдэг.

| | Нэр | Нас | Мэргэжил, эрхэлж буй ажил | Байршил, нутаглаж буй газар | Тээж буй өв | Өвийн эх сурвалж, дамжсан арга зам |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Алтангэрэл, Бямбасүрэн | 39, 32 | Малчин | Манлай сум | Хоовон Ширнэнгийн хонхор ба Зааны овооны тухай мэдээлэл | Өвөг дээдэс нутгийнхан, энэ хавьд нутагладаг |
| 2 | Сугир | 67 | Дархан | Манлай сумын төв | Модны дархан, модон хувин, хөхүүр урладаг | Үе дамжсан мэдлэг |
| 3 | Жуулхүү | 70 | Тэтгэвэрт | Манлай сумын төв | Ширмэл ширдэг, дуглуур, тойрог хийж урладаг | Үе дамжиж, нутгийнхнаас асууж сурч эзэмшсэн |
| 4 | Өөлий | 57 | Засаг даргын орлогч | Манлай сумын төв | Манлай сумын газар ус, домог түүхийн талаарх мэдлэгийг тээгч | Нутгийн ахмадуудаас асууж сураглаж мэдсэн |
| 5 | Шагдарсүрэн | 60 | Малчин | Манлай сум, Өгөөмөр баг | Мэргэн вангийн хошууны сүүлчийн засаг ноён Содномдоржийн зээ хүү, түүний барьж байсан хөөргийг хадгалж байдаг | Нутгийнхан болон ном зохиолоос |
| 6 | Алтангэрэл, Галаа | 30, 42 | Малчин | Манлай, Өгөөмөр баг | Хонхорын овоо, бууцны тухай мэдлэг | Эцэг эхээсээ бууцаа залгамжлан авсан |
| 7 | Сүхбаатар | 64 | Татварын байцаагч | Баян-Овоо, Харзаг баг | Энэ нутгийн ураг удмын түүх, газар ус, хүмүүсийн тухай мэдлэгийг тээгч, уртын дууны түүвэр болон түүхэн сурвалж хадгалдаг. | Тайж удамтай хүн ба дээдсээсээ уламжилсан ном, судартай. |

| | Нэр | Нас | Мэргэжил, эрхэлж буй ажил | Байршил, нутаглаж буй газар | Тээж буй өв | Өвийн эх сурвалж, дамжсан арга зам |
|---|---|---|---|---|---|---|
| 8 | Бунтэн | 65 | Малчин | Ханбогд, Жавхлант баг | Ундайн ус, бууцны талаар түүх болон Ханбогд сумын бэлчээр, мал аж ахуйн тухай мэдлэгийг тээгч | 20 гаруй жил багийн дарга хийж байсан |
| 9 | Бандиа | 70 | Малчин | Ханбогд, Жавхлант баг | Ханбогд сумын шагайн харвааны түүх, уламжлал болон газар усны мэдлэгийг тээгч | Байгаль хамгаалагчаар олон жил ажилласан |
| 10 | С. Батсүх | 72 | Малчин | Ханбогд, Жавхлант | Өөрөө ерөөл зохиож хэлж байсан, Сунтаг, Уран базарын хийцийн цоож, аягыг хадгалдаг | Түүний ах Цэдэнгомбо Ханбогд сумын гол ерөөл хэлдэг хүн |
| 11 | Ц. Алтангэрэл | 31 | Малчин | Ханбогд, Жавхлант | Өндөр Лувсангийн хийцийн бугуйвчийг 7 наснаасаа хойш зүүж эдэлж буй. | Түүний ээж нь бугуйвчийг бэлэглэсэн. |
| 12 | Цэнзэн | 78 | Малчин | Баян-Овоо, Харзаг баг | Энэ бүс нутгийн уртын дууны ая дэгийг тээгч. Түүний хөвгүүд модон, төмөр оньсон тоглоом урладаг | Гэр бүлээрээ дуучин, хуурчин улсууд |
| 13 | Рашням | 72 | Малчин, байгаль хамгаалагч | Баян-Овоо, Харзаг баг | Сумын газар усны талаарх мэдлэгийг тээгч, Сунтаг дарханы төмрийн дарханы багаж зэмсгийг хадгалагч | Сунтаг дарханы ач хүү багадаа төмрийн хөөрөг дарж өгч байсан. Үе дамжсан мэдлэг |
| 14 | Сүхээ | 61 | Малчин, Рашням | Баян-Овоо, Харзаг баг | Онц хилчин, мөр мөшгөх | Өөрөө сурч эзэмшсэн |

| | Нэр | Нас | Мэргэжил, эрхэлж буй ажил | Байршил, нутаглаж буй газар | Тээж буй өв | Өвийн эх сурвалж, дамжсан арга зам |
|---|---|---|---|---|---|---|
| | | | гуайн эхнэр | | ухааныг эзэмшсэн | |
| 15 | Л. Батаа | 78 | Малчин | Баян-Овоо, Налих баг | Долоон шар загийн хийд, түүх, домог их мэддэг хүн, мөн өөрийн цуглуулсан уртын дууны түүвэр хадгалж байна. | Багадаа хийдэд шавилж байсан, нутгийнхнааса а түүх, домог сонсож мэдсэн. |
| 16 | Цэдэн-Иш | 74 | Малчин | Баян-Овоо, Налих баг | Налихийн хийдэд багадаа шавилж байсан тул энэ хийдийн түүх, зан үйлийн тухай мэдлэгийг тээгч | Нутгийнхан болон бага насны туршлага |
| 17 | Д. Бямбаа | 72 | Тэтгэвэрт | Даланзадгад сум | Уртын дууны ая дэгийн талаарх мэдлэгийг тээгч | Уртын дуу дуулдаг хүмүүс дээр очиж заалгаж сурсан |
| 18 | Ү. Батням | | | | | |
| 19 | Төмөртогоо | 68 | Тэтгэвэрт | Даланзадгад сум | Өмнөговь аймгийн шатрын ур хийцийн төлөөлөл болох шатрыг хадгалж буй | |
| 20 | Борхүү | 57 | Малчин | Ханбогд, Жавхлант баг | Мөнгөний дарханы ур ухааныг сурч мөнгөн аяга хийдэг | Нутгийн сайн дархан улсууд дээр очиж асууж сураглаж сурсан |
| 21 | Авираа | 64 | Тэтгэвэрт | Ханбогд сумын төв | Ханбогдын хуучны уртын дуучдаар энэ нутгийн дэг аялгууг заалгаж суралцсан, уртын дуулдаг хүн. | Ханбогд сумын уртын дуучдаар заалгаж сурсан. |

Тодруулах бусад өв тээгчдийн тухай мэдээлэл:

Даланзадгадын Насандэлгэр хэмээх хүнд Өндөр Лувсангийн хийцийн 2 аяга бий

Ханбогдын Цэдэндамба гэдэг цоож хийдэг хүн бий.

Баян-Овоо сумын зүүн талд Чимэдцэрэн гэдэг хүнд мөнгөн саагуу байдаг.

Ганжирваа хувилгаанаас Өндөр Лувсанд өвлөгдсөн мөнгөн аяга аймгийн музейд байгаа.

Монгол дээл хийдэг Жамбал гэдэг хөгшин бий.

Богдын оёдолчны оёсон "Чандмань" одоо манай музейд байдаг. "Чандмань"-ийг сайн ажвал зүү ороож шагласан байдаг.

Манлай сумынхан Далай багийн төв дээр сахиул хийдэг Цэцэгжаргал хэмээгч эмэгтэй урьд сонсогдоогүй шинэ уртын дууг нэгэн тоглолтон дээр дуулж байсан гэж нутгийнхан нь ярьж байв.

Ханбогдод "Дархан" Хэрлэн гэдэг мундаг дархан байсан гэж нутгийн настай хүмүүс ярьдаг юм.

Баян-Овоо суманд гартаамаар толгой хийдэг байсан. Цэвээнжав гэдэг хүнд бий сумаас 40 км-т байдаг.

Даланзадгад сумын Амгалангийн эмээд гартааман бугуйвч бий.

Нэрийн өөрчлөлт

- Дэлийн бууц-Чойгийн толгой
- Замын хөөвөр-Шинэ дунд
- Хар толгой-Хуучин дунд
- Хөх үзүүр-Сүлжээний гуанз



## 2. АМАН ТҮҮХ, ДОМОГ, ХУУЧ ЯРИАНЫ ТЭМДЭГЛЭЛ

Гэсэр Гэлэн ба Шанхын гурван уртын дууны түүх

Сунтаг Дарханы түүх

Өндөр Лувсан дарханы түүх

Ганжирваа хувилгааны түүх

Хачиг уулын түүх

Налих, Тогой хайрханы түүх

Үнэгэд хайрханы түүх

Зовхи Балдандоржийн түүх

Дархан Доржийн тухай түүх

Ундайн голоор нутагтай, Оцонгийн заставын нэгэн цэргийн бууны замгийг хийж өгсөн. Ганцхан кодыг нь гаргаж чадахгүй юм байна гэж хэлж байсан гэсэн.

Хүний уурга тасарахад цавуугаар наасан огт тасраагүй гэнэ.

Бух хайрхны тухай домог

Л. Батаа : Бух хайрхан, Ашиг хайрхан 2 хайрханыг тахьдаг байв. Хүүхдийн Овоо нь голын баруун талд сумын төвийн дэргэд Суварган хайрханы зүүн талд хүүхдийн овоо гэж тахьдаг байсан. 16- гаас доош насны хүүхэд барилдаж байнд нь даага өгдөг байсан.

Ихэр Ёндон баригдаад явчихсан гэж гэлэн хэлэв. Баригдаж явж ирээд Өөд болсон "Жаал" гэлэн гэж байсан. Нэг нь "Гөлөг"Гэндэн гэж байсан. Дандаа ядуу хоосон лам нарыг баривчлаагүй. 4 гэлэн тахилга үйлдэж байна гэдэг нь бүх хуваргын хурал хурж байна гэж үздэг байсан. Ашиг хайрханы нэрийн учрыг сайн мэдэхгүй. Ганц дөрвөлжин шоо шиг овоо байсан. Бух хайрхан гэдэг маш догшин, барагын хүнд таардаггүй маш догшин хайрхан гэж ярьдаг.

Бух хайрхан гэдэг нь өвөлд цус шиг өнгөтэй болдог . Бух хайрханы ард талд нь Ихэр хайрханы өмнө талд хүүхдийн овоо байдаг. Уул усны домог гэвэл урагш нь нэг хятад хүн үхэр тууж явж байгаад бухаа алдчихсан. Хярлаад гараад явчихаад ер олдоогүй гэнэ. Үхрийн нурууг таслая гээд тэр хятад хашаатын өвөр талд байдаг ганц чулууны голоор үхэр орох юм байна гээд ганц бул чулуу өвөртлөөд явчихсан. Гэвч бух нь олдоогүй болохоор нь чулууг нь буцаагаад тавьсан чинь өнөөх бух нь хаднаас гарч ирсэн гэдэг. Бух хайрханыг тахисан хүн таардагүй гэдэг гэнэ лээ. "Долоот"-ын хувилгаан Ганжир лам мэргэн Донгоо гэдэг хүнээр мэргэлүүлэн "Хачид" 70 гарсан 80 шахсан Дамиран гэсгүү, нутгийн өвгөнөөр тахиулсан гэдэг. Ганжир ламын багш нь байсан. Энийг 3 хүн тахисан. "Долоот"-ын нэг лам ирээд тахисан өдрөөс эхлээд нутгийн ардыг могой хатгасан. Энэ хүн таарахгүй нь гээд 7 хоногийн дараа бас нэг ламаар тахиулсан, тахисан өдрөөс нь эхлээд малыг нь чоно бариад эхлэсэн гэнэ. Тэгээд бас болохгүй нь гээд Дамиран гэсгүүгээр тахиулсан гэдэг. Энэ хайрхан оройдоо нэг их том талбайтай л даа. Том их асар аваачиж бариулаад, ор дэр аваад хэвтчихсэн гэсэн. Цаг их муудсан үед улсуудын унагыг уяулаад, цагаан морь заавал түрүүлэх ёстой гэж айлдсан. Энэ нутгийн өвгөн Бор Сохор Дон гэдэг хүний ганц цагаан морь байсныг нь уяж, оромдон түрүүлүүлсэн. Долоон бүдүүн эр хонь гаргуулж, 20-30 шүдлэн алуулсан. Хайлуур, Төөлүүр дүүрэн архи авчруулж найр хийсэн.

"Ганжир " ламын багш нь болохоор "Долоот"-ын лам нар бөндөгнөж байсан гэнэ лээ. Тэгээд овоогоо тахьдаг юм билүү гэсэн чинь "хувиа" хувааж бай гээд өөрөө орой дээр нь гараад ганц "сөр" тавиад орхитол үүл битүүрээд ирсэн гэдэг.

Удалгүй бороо асгартал, морио яах вэ? Гэж нэг хүн асуутал:

Тохмыг нь татаад Бухтын өмнүүр хөөчих гэжээ. Тэгтэл хонио яах вэ? лам гуай гэтэл

Нөгөөтөх чинь майхныхаа үүдээр гарч сэржим өргөөд

Хонио эрэх хэрэггүй, доошоо бууж найранд оч гэжээ.

Уулын бэлд бороонoор бөх барилдаж, найрлаж байх үед нөгөө лам уулын орой дээр ганцаараа үлдсэн гэдэг. Энэ найр 7 хоног үргэлжилсэн. Долоо хоногийн дараа "мал хэцүүдлээ ламтан гуай" гэхэд

-Та нар долоо хоног мах идээ биз дээ. Одоо хонь малаа олцгоо гэв.

Маш гайхалтай нь ганц ч малын хорогдолгүй малаа олцгоожээ. Тэгтэл нэг саваагүй хүн асууж гэнэ.

Ганц ч малын хорогдолгүй байх юм. Юу болов гэтэл нөгөө лам чинь

Гайхлын амыг зууруулчихсан юм гээд шороо цацаж байв.

Ганжир ламын тахьдаг Өлзийт хайрхан дахин тахигдаагүй байсан. Би 1995 онд Дорноговь аймагт Чадамбаа хувилгаанд очсон чинь хүүхдийн овоог болон Ганжир ламын Их Өлзийтийг тахиул. Нутаг оронд чинь амар тайван ирнэ гэсэн. Өлзийт хайрханыг сүүлд Чоймбол дарга тахиулсанаас хойш дахин тахиагүй.

Домог

Баруун Хөтөл уулын өвөрт Идэр аваргыг 9 настай байхад "жас " буугаад түүнийг янгир босго гээд 4 талд нь арц, хадагтай янгир босгож тависан. Хэдэн хүүхэд гүйлгэж, "Хөтөл уулын дэнж дээр индэр босго" гэтэл зуух шиг том гурван үхэр чулуу аваачиж тавихыг нь харсан, түүний нагац ах :Би ийм хүүтэй юм байна. Хөтөл ууланд дандаа даага уралдуулж, хүүхэд барилдуулж байя гэжээ. Түүнээс хойш Идэр тахисан гэж домоглосон.

Намдагсан адууны хийморийн судар, Найман гэгээ лусын судар,

Домог:

Гэсэр гэлэнг үзэж чаддаггүй Усан бэтэгт нэгэн хүн байжээ. Гэсэр гэлэнтэй таарах л юм бол дандаа хэрүүл гуйж, загнаж явдаг байсан гэнэ. Нэг өдөр Гэсэр гэлэн морио услаад зогсож байхад нь ирээд хэрүүл өдөөд байхаар нь, мордохдоо уурганыхаа бөгсөөр цүлхийж буй гэдэс рүү нь ёвроод орхитол нөгөө хүний усан гэдэс нь хагарч, нөгөө хүн чинь Гэсэр гэлэн намайг алчихлаа гэж хавийн амьтанд хэлжээ. Дэлгэрхангайн тамганы даа Гэсэр гэлэнг барих гэж байгааг мэдсэн Номхон бор гэдэг хүүхэн Гэсэр гэлэнд ирж хэлжээ. Дэлгэрхангайн хойд талд түүний гэр байхад Номхон бор хүүхэн ирж: -" Чамайг Дэлгэрхангайн тамганы даа ирж барина гэж байна. Чамайг Сангийн далайн хойд эрэг дээр хүн алсан гэж ярьж явна" гэжээ.

Тэгтэл Гэсэр гэлэн бүх үнэнийг хэлсэнд Номхон бор:

за тэгвэл чи яв. Адуунаасаа хул морио барьж унаад Богдын хүрээ ор. Гэсэр гэлэн гэртээ орж хадаг, ембүү аван өвөртлөөд хоёул мордов.

Тэгээд Дэлгэрхангайн тамганы даа- ийн гадаа Номхон бор үлдээд, Гэсэр гэлэн цааш давхисаар үүр цайх үеэр Богдын хүрээ орж ирсэн. Богдыг цайгаа уугаад сууж байхад Гэсэр гэлэн орж ирэн мөргөөд, эрхээ унагаахад: Богд эзэн

Энэ хүн эрхээ юунд унагав? хэмээн асуухад

Учир явдлаа ярьж өгвөл, гурав хоног энд байсан гэсэн бичиг хийж өгчээ. Сайн морь эзнээ авардийн учир:

Гэсэр гэлэн буцаж явахад замд нь холбоотой хонь тааралдаж, мориныхоо амыг татасхийтэл морь нь харайгаад гарчихав. Эргээд хартал нэг хүн гэрийн хажууд даллаж байхыг харан очвол, өвгөн хөгшин хоёр сууж байлаа. өвгөн хараагүй учир:

Хаа хүрч яваа. Ямар нутгийнх болохыг нь асуув.

Шанхай гэж хариулахад

Танайх нүүрстэй юу гэж асуув.

Тиймээ. Таван толгой гэдэг газар бий гэхэд

Тийм байхаа. Хөндий цээж дүүлэн хаяа, дөрвөн цөгц, хурдан морь гарах түүхтэй юм шүү дээ гэж сохор өвгөн хэлсэн гэдэг.

Өвгөн хул морио хулгайд алдаж магадгүй шүү. Онгоцоо хоослоод байгаарай гэжээ. Гэсэр гэлэн нутагтаа очсон даруйдаа морио хулгайд алдаж, өдөр бүр онгоцоо хоослоод орхидог байв. Нэг өдөр явуулын бадарчин зам зуур саатах үедээ өнөөх онгоцыг дүүргэж орхиод явчихжээ. Гэтэл хул морь ус уугаад босоогоороо үхсэн байжээ. Үүнийг үзсэн Гэсэр гэлэн өөрийн мориндоо харамсаж, "Өндөрийн өвс" дууг зохиожээ.

Хачигт гэдэг газар

1820-оод оны Хуй Хуугийн дайн орж ирэх үеэр амьтан хүн энд шигдэн нуугдаж байсан. 1919, 1921 онуудад  гамин цувах үед Долоотын сүмийн хүмүүс ч гэсэн 2 Хачигтад хуваагдан нуугдсан. "Хадахад, Хөрөхөд "-д зүүн талд нь Галбын ууланд дүрвэж шигдэж байсан. Хачигт уул хэзээний Хачигт нэртэй байсан. 1820 онд Хуй Хуугийн цэрэг өмнөөс орж ирээд, манай ардуудыг хядчихсан юм гэнэ лээ. Тэд жад сэлмээр зэвсэглэсэн дандаа гуйлгачид байсан.

Налихийн хийдийн" Гурван Гэдрэг"  гэдэг  овоо бий. Гурван сайхан, Буурай хэц, Гэдрэг хэц. Энэ гурав бол шугам шиг тэнцүүхэн хэц юм. Уртын Баян нуруу, Хар Хорин, Хатан голоос дандаа өөдөөгөө явдаг. Аянчид явсаар байгаад Бэтэргийн улаан давааг давахад "Гурван сайхан " харагддаг.  Би 1945 оноос эхлээд жинд явдаг байлаа. 1931-1932 онуудад "хүнс" буусан. Оросын будаа, гурил 1930 онд буугаад, аймаг бүр жинд явах болсон. Нэг айл 3 аттай байвал 2-ыг нь хөлсөлж авч явдаг байсан. 1940 онд би анх сургуульд ороод, монгол дээлтэй, лам хувцастай хүүхдүүд суралцаж байлаа.

Бидэнд гутал гэж байсангүй. Ямаан баартак, ямааны арьсыг хөлдөө углан, хөлийнхөө хэлбэрт тааруулан оёдог байсан. Тэрийг тайлалгүй урагдаж дуустал явдаг байсан. Би 12 настай болтлоо өмсдөг байсан. 1941 онд "крилл" үсгийг заалгаж , бид нар "хөндлөн хөгжил" гэж хошигнодог байлаа.

## 3. ХЭЭРИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ҮР ДҮН

8.1  Биет бус өвийн үнэлгээ
8.2 Ямар биет бус өвүүд бодит хэрэглээтэй байна вэ?
8.3 Ямар биет бус өвүүд мартагдан орхигдож байна вэ?
8.4 Ямар замаар биет бус өв дамжин залгамжлагдаж байна вэ?
Мэдлэгийг тээгчдийн бүтэц өөрчлөгдөж байна уу

## БИЕТ БУС ӨВИЙН ҮНЭЛГЭЭ

| | | Биет бус өв уламжлагдан хадгалагдах арга зам | | Биет бус өвийн үнэ цэнэ, ач холбогдол | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **Өвийн нэр** | **Уг өвийг тээгч** | **Мэдлэгийн эх сурвалж, ба уламжлагдан дамжих арга зам** | **Тархац** | **Хамрах хүрээ (ямар хүмүүсийн дунд хэрэглэгдэж буй)** | **Өнөөдөр хэрэглэгдэж буй эсэх цаашдын хандлага** | **Ач холбогдол, үнэ цэнэ (Хэн үнэ цэнэ өгч буй)** |
| 1 | **Дарханы урлал** | Үе дамжсан дархан, дархчуудаас асууж сураглаж суралцсан шинэ дархан, сургалтанд сууж суралцах хэлбэр бий болсон | Уламжлалт үе дамжсан дархчууд байхгүй Ү. Батням гуай сургалт дамжаагаар зааж сургаж байна. | Үе дамжуулан өвлөх мөнгөн аяга, мөнгөн бугуйвч зэрэг нь судалгааны бүсэд өргөн тархсан байна. | Үүнийг тогтооход хэцүү, үе дамжуулан эд хэрэглэх сонирхолтой хүмүүс | Дарханы урлал өнөөдөр өндөр хөгжиж байна. Учир нь эмээл, хазаар, гөлөм хийх урлалын зэрэгцээ мөнгөн аяганы дарх өргөн хөгжиж байна. | Мөнгөн аяганд үнэ цэнэ өгөх байдал өндөр байна. Мөн сайн дарханы ур хийцийг үнэлэх байдал өндөр, гэвч хуучны дарханы хийцүүдээ сэргээх бус шинэ хэв маяг орж ирж байна. |
| 2 | **Уртын дуу, ерөөл магтаал** | Цэвэнзэн, Батаа, Бямбаа, Авираа | Удам дамжсан бага, залуудаа сайн дуучдаар заалгасан | 4 сум тус бүрт 1-2 хүний хүрээнд | Маш цөөн тээгчдийн дунд | Өнөөдөр уртын дуу сонирхох дуулах ялангуяа урьд нь дуулагдаж байгаагүй үг нь гажуудсан дууг эхээр нь сэргээн дуулах сонирхол өндөр байна. | Уртын дуу дуулж буй хүмүүс энэ өв мартагдах гэж байгаад маш их санаа зовж их ач холбогдол өгч байна. Мөн Бямбаа гуай сургуулийн хүүхдүүдэд зааж байна. |

| | | Биет бус өв уламжлагдан хадгалагдах арга зам | | Биет бус өвийн үнэ цэнэ, ач холбогдол | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3 | **Цулхир, бажууны гурил хийх арга ухаан** | Гол төлөв өндөр настай хүмүүс. Тухайлбал Батаа, Рашням, Бүнтэн, Цэндээхүү зэрэг | Багадаа ээж аавынхаа хийж байхыг харж байсан өөрсдөө хийж үзэж байсан хүмүүс | 4 сумын нутагт мэддэг хүмүүс байна. | Өндөр настан өөрсдөө хийж, идэж хэрэглэж байсан хүмүүс | Өнөөдөр ямар ч хэрэглээгүй болсон. Будаа, гурил ховор үед болон эмчилгээний зориулалтаар хэрэглэж байсан. | Говь нутгийн хүнс, эмчилгээнд хэрэглэж болох ургамлын талаарх мэдлэгийн чухал хэсэг. Хүмүүс бага мэдэж байна. |
| 4 | **Тамганы соёл** | Малчин өрх айл бүр гол төлөв удам дамжин ирсэн малын тамга хэрэглэж байна. | Малчин айл өрх бүрт шаардлагатай тул аль асууж тодруулах замаар аль нэгэн тамгыг өвлөж авах нь давамгай байна. | 4 сумын нутагт тэгш тархсан. | Малчин өрхийг нийтэд нь хамарна. | Өндөр хэрэглээтэй. | Өв уламжлалын өндөр ач холбогдолтой. |
| 5 | **Монгол гэрийн урлал, хэрэглээ Гэр ахуйн уламжлалт сав хэрэглэл, тавилга засал Дуглуур, тойрог хийх арга ухаан** | Малчин айл өрхүүд гол төлөв гэрт сууж байна. Гэрийн урлал бараг байхгүй, ширдэг тойрог, дуглуур, модон хувин савыг цөөн хүн урлаж байна. | Гэрт сууж буй нөхцөлд гэрийн тухай мэдлэг дамжих нөхцөл бий болж буй боловч ширмэл ширдэг дэвссэн айл ховор, энэ талаарх мэдлэг дамжих нөхцөл үгүй байна. Зах зээл бага гар ажиллагаа их нөхцөлд мартагдах магадлал ихсэж байна. | 4 сумын нутагт тэгш тархсан. | Нийт малчин өрхүүдийг хамарна. | Цөөн тооны залуу малчин өрх бууцан дээрээ байшин барьж | Монгол гэрт амьдрах, уламжлалт тавилга хэрэгсэл хэрэглэх нь өндөр ач холбогдолтой боловч өнөөдөр уламжлалт байдлаар засах хандлага бага нүүдэл, хэрэглээний байдалтай байна. |
| 6 | **Бурхан тахил, шүтээн** | Дийлэнхи айл өрх бүр | Өвөг дээдсээсээ өв уламжлан авах ба лам залж шинээр | 4 сумын нутагт тэгш | Нийт айл өрхүүдийг хамарна. | Өндөр шаардлага хэрэглээтэй | Өндөр ач холбогдолтой. |

| | | Биет бус өв уламжлагдан хадгалагдах арга зам | | Биет бус өвийн үнэ цэнэ, ач холбогдол | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | бурхан тахил залж байна. | тархсан | | | |
| 7 | **Хүнс хоол** | Малчин айл өрх уламжлалт хоол, хүнсээ хэрэглэж байна. | Малчин айл гэрт өсөхөөсөө сурч эзэмшдэг. | 4 сумын нутагт тэгш тархсан. | Нийт айл өрхүүдийг хамарна. | Сумын төвд шилжин амьдрахад хоолны дэглэм өөрчлөгдөх хандлага байдаг. | Мах, гурилаас гадна хүнс хоолонд хэрэглэгдэж байсан олон ургамлын тухай мэдлэг мартагдаж буй. |
| 8 | **Овог ургийн нэр, ураг төрлийн хэлхээ холбоо** | Баян-Овоо сумын Сүхбаатар гуай зэрэг цөөн хүмүүс сонирхож судалдаг. | Өвөг дээдсээсээ уламжлалн сонсож мэдэх боловч овог сэргээхэд шинээр зохиох тохиолдол олон байсан. | 4 сумын нутаг | Овог сэргээх үйл явцтай холбоотойгоор бүх айл өрхийг хамарсан. | Иргэний үнэмлэх дээр бичигдэхээс өөр бодитой хэрэглээ байхгүй. | Зарим ураг төрлийнхөн ач холбогдол өгч ургийн баяр тэмдэглэж буй. |
| 9 | **Чулуун гэр болон бусад тоглоом** | 70-80-аад он хүртэл малчин айл өрхийн хүүхдүүд чулуун гэр барьж тоглох явдал байсан. Одоо бараг мартагдсан. | Нутаг усныхаа хүрээнд зан заншил уламжлал, түүх домог яриа сонсож сурч эзэмшдэг. | 4 сумын нутагт | Малчин айл өрхүүдэд чулуун тоглоомын буйр байх магадлалтай. | Бараг мартагдсан. | Нүүдлийн ахуй ёс заншлыг хүүхдүүдэд ойлгуулах чухал ач холбогдолтой өв. |
| 10 | **Шагайн харваа** | Ханбогд сумын Бандиа гуай зэрэг сонирхогчид | Нутаг усныхан болон сайн шагай харвадаг хүмүүсээр заалгаж сурдаг. | 4 сумын нутагт өргөн дэлгэрсэн. | Сонирхон хичээллэгч хүмүүсийн хүрээнд байдаг. | Өнөөдөр өндөр түгэн дэлгэрч тархсан. | Монгол эр хүний ёс намбыг зааж сургадаг өндөр ач холбогдолтой өв. |
| 11 | **Говьчуудын хорио цээрийн ёс** | Мал аж ахуй эрхлэн амьдарч буй хүмүүс | Малчин амьдрал ахуйн хүрээнд сурч эзэмшдэг | 4 сумын нутагт | Нийт малчин өрх айлууд | Хорио цээрийг баримтлах нь бага болж буй. | Тухайн нутаг орны соёлын утга, бэлгэдлийн тэмдэг |

| | | Биет бус өв уламжлагдан хадгалагдах арга зам | | Биет бус өвийн үнэ цэнэ, ач холбогдол | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | уламжлалт хорио цээрийн ёсыг баримтлах нь түгээмэл. | | | | | агуулгыг тээдэг учраас чухал ач холбогдолтой |
| 12 | **Шашин, бөө мөргөл** | Сүсэгтэн олон ба шашны хэрэг эрхлэгч хүмүүс | Бурхан тахил шүтээнийг өвөг дээдсээсээ өв уламжлан авдаг, ба нэг сумынхан бие биенээсээ сонсож дуулж мэддэг. | 4 сумын нутагт, Ханбогдод Манлай, Баян-Овоо сумтай харьцуулахад олон бөөтэй байна. | Энэ бүс нутгийн олон нийтийг хамарч байна. | Өнөөдрийн хэрэгцээ, шаардлага өндөр болсон. Хүмүүс адил хэм хэмжээ, үзэл санаанд нэгдэж, ижилсэх сонирхолтой байдаг. | Тухайн нутаг орны гол үзэл санааг илэрхийлдэгээрээ өндөр ач холбогдолтой. |

### ***8.1*** *Ямар биет бус өвүүд бодит хэрэглээтэй байна вэ?*

Бидний хээрийн шинжилгээгээр олонхийн ач холбогдол өгч дурдсан биет бус өвүүдийг 1-р хэсэгт боловсруулж гаргасан хэмжүүр үзүүлэлтээр хэмжиж үнэлэхэд мал аж ахуй эрхлэн амьдрах сонголт, дархны урлал, шашин бөө мөргөл, шагайн харваа зэрэг биет бус өвүүдийн хэрэглээ ба дамжин залгамжлагдах байдал идэвхтэй байна. Эдгээр өвүүдийн онцлог нь дийлэнхи нь шинэ нөхцөлд дасан зохицсон өөрчлөлт бүхий байна. Нэгдүгээрт тухайн өв зах зээл дээр эрэлт хэрэгцээтэй ба түүнд зохицсон мэдлэг нь дамжих зохион байгуулалттай  болж чадсан байна. Тухайлбал дарханы урлал нь мөнгөн аяга, эмээлийн гөлөм, мөнгөн хазаарын эрэлтээс хамааран өргөн цар хүрээтэй хөгжиж байна. Дарханы урлал нь гол төлөв удам дамжсан цөөн тооны дархчуудын хүрээнд өөрийн дарханы арга технологийг нууцлах замаар өөрийн хийц, зах зээлийг бий болгох хүрээнд байсан бол Даланзадгад сумын дархан Ү. Батням энэхүү уламжлалт аргын харин ч эсрэг буюу сургалт, дамжаа хичээллүүлэх замаар 70 гаруй залуу дархчуудыг бэлтгэж, Ноён-Сэврэйн мөнгөний орц өндөртэй хийдэг уламжлалыг хадгалан хөгжүүлж байна. Энэ нь удам дамжсан цөөн мэргэшсэн хүмүүсийн хүрээнд өөрийн арга технологоо нууцлах заамаар өөрийн хийц дэг сургуулийг бий болгон бусдаас ялгарч зах зээлээ бий болгон оршин тогтнож байсан биет бус өв-Дархны урлал олонхийн мэддэг олноор үйлдвэрлэсэн, арга технологийг нийтэд ил болгох замаар улам хөгжиж буй тохиолдол байна.

Үүнээс дүгнэж үзэхэд биет бус өвийн тухай нарийн мэдлэг мэдээлэл бий болж олон нийтэд тархан түгэх тусмаа түүний зах зээл, эрэлт хэрэгцээ, хөгжүүлэх сонирхол нөхцөл үүсч байгаа нь харагдаж байна.

Уламжлалт цөөнхи мэргэжилтнүүдийн мэдлэг олонхийн болох

Олон нийтэд түгээх замаар түүний сонирхол, хэрэглээ, зах зээлийг бий болгох гэсэн бүтэц харагдаж байна.

Мөн үүнтэй адил уламжлалт Монголчуудын шагайн харваа нь залуучууд нэг дор цугларч бие биетэй уулзаж харилцах, улмаар түүгээр дамжуулан нарийн ёс дэгийг эзэмшүүлдэгээрээ ихэд түгэн дэлгэрч байгаа олон нийтийн тоглоом зугаа цэнгэл болж байна. Тиймээс энэхүү тоглоомын хамрах хүрээг өргөтгөж, давтамжийг олшруулах нь үүнтэй холбоотой өв соёлыг хадгалах арга зам болох юм.

### *8.2 Ямар биет бус өвүүд мартагдан орхигдож байна вэ?*

Мартагдан орхигдож буй өв соёл нь Говьчуудын хорио цээрийн ёс байна. Өмнөх хорио цээр баримтлагдахгүй буюу шинээр тайлбарлагдаж шинэ хорио цээр үүсч байна. Тиймээс угаасаа хорио цээрийг уламжлалт ба алдагдан өөрчлөгдөж байна хэмээн үзэх боломжгүй байх магадлалтай. Тухайлбал Баян-Овоо сумын 4 багийн тахиж буй овооны талаар Батаа гуай хувьсгалаас өмнө засаг ноён нэгэн чадалтай ламтай нуугаад хараал булсан газар тиймээс догшин болсон гэж үзэж байна. Мөн тэрээр ихэнхи тахилгатай уул, овооны зориулалтын сан тахилгын судар нь байхгүй болсон тул дахин тахих боломж байхгүй харин хорио цээртэй болгоод орхих нь зүйтэй хэмээн үзэж байв. Энэ нь зан үйл хийж байсан газрууд зөв зохистой хийхгүйгээс догшин цээртэй хэмээн болж хувирдаг байдал ажиглагдаж байна. Өөрөөр хэлбэл хорио цээр гэдэг нь өмнөх уламжлал, зан үйл алдагдсан тохиолдолд буруу гажуу хийхээс болгоомжлох байдлаар үүссэн байдал харагдаж байна.

Иймд мартагдан, алдагдаж буй биет бус өв нь 1-рт холбогдох мэдлэг, мэдээлэл нь байхгүй болсон, тиймээс хэрэглэх боломжгүй болж орхигдож буй шинж чанартай байна. Мөн говь нутгийн уртын дуу мартагдах дээрээ тулж байна хэмээн Цээнзэн гуайн хэлж буй нь энэ нутагт дуулагдаж байсан дуунууд мартагдсан, дууны үг нь байвч ая дан нь мартагдсантай холбоотой байна. Цээнзэн гуай өөрөө уртын дуу дуулахдаа 60-аад оны үед хэвлэгдэн гарсан уртын дууны түүврийг хэрэглэж байсан гэж хэлж байв. Өөрөөр уртын дууг мөн хэн нэгэн сайн дуучнаас сурсан бус ном зохиол болон хүмүүсээр заалгаж сурсан байна.

Иймд биет бус аливаа өвийн талаарх мэдлэг, мэдээлэл байхгүй тээгч цөөрөхөд мартагдан орхигдох байдалд хүрч байна.

### *8.3 Биет бус өв залгамжлагдан хадгалагдах ямар арга замууд оршиж байна вэ?*

Мал аж ахуй эрхлэн амьдрах хэв маяг гол арга зам боловч бизнесийн боломжит сонголт хэмээн үзэж мал маллах тохиолдолд уламжлалт биш хэрэгсэл, арга замыг ашиглах хандлагатай байна.

# 19. ХАВСРАЛТ 10. ОЛОН НИЙТИЙН ХЭСГИЙН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ЗОРИЛГО

**Ж. Гэрэлбадрах**

## 1. “Оюу толгой” төслийн “Соёлын өвийн хөтөлбөр”-ийн Олон нийтийн хөтөлбөрийн судалгааны хэсгийн хээрийн ажил (2010 оны 7-р сарын 7-ноос 17-ныг хүртэл)

Судалгааны багийн бүрэлдэхүүнд “Соёлын өвийн хөтөлбөр”-ийн судалгааны багийн судлаач, МУБИС-ийн Монголын түүхийн тэнхмийн багш, доктор, профессор Ж. Гэрэлбадрах, Үндэсний Төв Архивын эрдэм шинжилгээний ажилтан Ш. Эрдэнэбат, Тоёота Ланд Круйзер машины жолооч Г. Дорж нар оролцон ажиллав.

Өмнөговь аймгийн наадам ба “Оюу толгой” төслийн наадмын харьцуулсан судалгааны ажил хийхдээ монголчуудын уламжлалт баярын нэг болох Улсын наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхэд ямар өөрчлөлт, шинэчлэл гарч буйг доорхи зүйл тус бүрээр гүнзгийрүүлэн судлав. Тэдгээр нь,

- Наадмын уламжлал хэрхэн хадгалагдаж буйг бөх, хурдан морь, наадамчдын хувцаслалт, соёлын бусад арга хэмжээн дээр тулгуурлан гаргах,
- Наадмыг бусад баяр, уламжлалт зан үйлтэй харьцуулан тэдний зэрэг зиндаа, ач холбогдлыг тодорхойлон үнэлж дүгнэх зэрэг юм.

Судалгааны ажлын дэлгэрэнгүй тайланг Хавсралт 5-с харна уу.

## 2. “Оюу толгой” төслийн “Соёлын өвийн хөтөлбөр”-ийн Олон нийтийн хөтөлбөр, Биет бус өвийн судалгааны хэсгийн хээрийн ажил (2010 оны 07-р сарын 31-нээс 8-р сарын 09-нийг хүртэл)

Судалгааны багийн бүрэлдэхүүнд Олон нийтийн хөтөлбөрийн судлаач МУБИС-ийн Монголын түүхийн тэнхмийн багш, доктор, профессор Ж. Гэрэлбадрах, Биет бус соёлын өвийн судлаач, ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн захирал доктор, профессор С. Чулуун, Тоёота Ланд Круйзер машины жолооч Г. Дорж нар оролцон ажилласан юм.

Ханбогд сумын Гавилууд, Баян, Жавхлант, Номгон дөрвөн багийн хуралд оролцож “Оюу толгой” төслийн “Соёлын өвийн хөтөлбөр” хэрэгжиж байгаагийн утга учир, ач

холбогдлыг тайлбарлан таниулах хийж гүйцэтгэв. Мөн тус сумын нутагт буй байгалийн болон түүх соёлын дурсгалт газруудыг үзэж, аялал жуулчлал хөгжүүлэх боломжийн талаарх судалгаа хийсэн юм. Бас сумын Соёлын соёлын төв, "Галба" музейн үйл ажиллагаатай танилцаж, Соёлын өвийн талаарх бодлого, үйл ажиллагааны талаар санал бодлоо солилцов.

Дэлгэрэнгүй тайлан Хавсралт 6-д байгаа болно.

**3. "Оюу толгой" төслийн "Соёлын өвийн хөтөлбөр"-ийн Олон нийтийн хөтөлбөрийн судалгааны хэсгийн хээрийн ажил (2010 оны 11-р сарын 21-нээс 11-р сарын 28-ны өдөр хүртэл)**

Судалгааны багийн бүрэлдэхүүнд "Соёлын өвийн хөтөлбөр"-ийн "Олон нийтийн хөтөлбөр"-ийн судлаач доктор, профессор Ж. Гэрэлбадрах, төслийн туслах ажилтан Ш. Эрдэнэбат, Тоёота Ланд Круйзер машины жолооч Т. Болдбаатар нар оролцон ажиллав.

Уг судалгааны ажлын зорилго ашигт малтмалын том орд газрууд нээгдэж эхэлж буй цаг үед Монголын говь нутагт уламжлалт соёлын өвийг хадгалах, хамгаалах талаар орон нутгийн засаг захиргаа ямар бодлого баримталж буй, тэр талаарх "Олон нийтийн хөтөлбөр"-ийг боловсруулахад тэдний санаа оноог тусгахад чиглэж байв. Энэ ажлын хүрээнд доорхи зүйлүүдийг хийж гүйцэтгэлээ.

- Өмнөговь аймгийн Орон нутгийг судлах музей ба Соёлын төв, Хөгжимт драмын театрын үйл ажиллагаатай танилцсан,
- Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газрын дэргэдэх Байгаль орчин, Аялал жуулчлалын газраас аймгийн аялал жуулчлалын талаар явуулж буй ажилтай нь танилцаж, аймгийн аялал жуулчлалын өнөөгийн байдлыг судалсан.
- Ханбогд, Манлай, Баян-Овоо сумдын сургуулийн захирал болон түүх-газарзүйн багш нартай уулзаж, орон нутгийн Соёлын өвийн талаарх "Олон нийтийн хөтөлбөр"-ийн талаар санал бодлоо солилцсон,
- Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газрын дэргэдэх Боловсрол, Соёлын газраас Соёлын өвийн талаар явуулж буй ажилтай нь танилцаж, дүгнэлт боловсруулсан,
- Өмнөговь аймгийн Ханбогд суманд аялал жуулчлалын ямар төрлийг (байгалийн, дэлхийн энергийн төв, шашны, мал аж ахуйн, түүх-соёлын гэх зэрэг) хэрхэн бий болгох, хөгжүүлэх боломжийн талаар анхан шатны санал дүгнэлтийг гаргасан,

- Ханбогд суманд аялал жуулчлал хөгжүүлэх боломжийг тодорхойлох хүрээнд сумын төвийн зочид буудлын тоо, багтаамж, үйлчилгээний чанар, жуулчны баазын хүчин чадал, ажиллах улирал, дөрвөн багийн төвийн жижиг буудлыг хэрхэн ашиглах талаар анхан шатны судалгааг хийсэн
- Ханбогд суманд болох “Мянган ботгоны баяр”-ыг үзэж танилцан судалсан байна.

# 20. ХАВСРАЛТ 11. НААДМЫН СУДАЛГААНЫ ЯВЦЫН ТАЙЛАН

**“Оюу толгой” төслийн “Соёлын өвийн хөтөлбөрийн” судалгааны багаас Өмнөговь аймгийн Даланзадгад, Ханбогд суманд хийсэн биет бус соёлын өвийн судалгааны ажлын товч тайлан**

2010 оны 7-р сарын 16
Улаанбаатар

Монгол улсын говийн нутагт ашигт малтмалын том орд газрууд нээгдэж байгаатай холбоотойгоор монголчуудын нэгэн чухал биет бус соёлын өв уламжлалт баярын нэг болох Үндэсний Их баяр-наадмыг тэмдэглэж ирсэн түүх, уламжлалд ямар өөрчлөлт гарч буй, эсэхийг Өмнөговь аймаг болон “Оюу толгой” төслийн наадмын жишээн дээр гаргахад эл бичил судалгааны ажлын үндсэн зорилго оршиж байв.

“Оюу толгой” төслийн “Соёлын өвийн хөтөлбөрийн” судалгааны багийн судлаач, МУБИС-ийн Монголын түүхийн тэнхмийн багш, доктор, профессор Ж.Гэрэлбадрах, төслийн туслах ажилтан, Үндэсний Төв Архивын эрдэм шинжилгээний ажилтан Ш.Эрдэнэбат, Тоёота Ланд Круйзер машины жолооч Г.Дорж нар 7-р сарын 8-13-нд Өмнөговь аймгийн Даланзадгад, Ханбогд сумдад ажиллав.

Монголчуудын уламжлалт баярын нэг болох Улсын наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх нь өөрчлөгдөж буй, эсэхийг доорхи хэдэн зүйлээр гүнзгийрүүлэн авч үзэхэд,

- Өмнөговь аймгийн наадмын далайцыг барилдах бөх (128 бөх, өсвөрийн 32 бөх), шагай харваачид (6 хүнтэй 6 баг, нийт 36 харваач), сур харваач (насанд хүрэгчид эр-8, эм-6 нийт 14, хүүхэд хөвгүүн-9, охин-4 нийт 13, бүгд 27 харваач), уралдах морьдын (азарга-47, их нас-51, хязаалан-50, шүдлэн-68, соёолон-55 , даага-42, бүгд 313 морь) тоонд тулгуурлан үзвэл бусад аймгуудтай ерөнхийдөө адил (хурдан морины тоо арай цөөн байгааг эс тооцвол) төвшинд байна.
- “Оюу толгой” төслийн наадам бөх (64 бөх), шагайн харваа (7 хүнтэй 4 багийн 28 харваач), үндэсний сур (эр-35, эм-7 харваач) гэсэн 3 төрлөөр явсан нь 10 цагт эхэлж, 17 цагт дуусгах 1 өдрийн шахуу хөтөлбөртэй нь холбоотой ажээ. Мөн 40 сум (хана-20, хасаа-20) харвах ёстой сурын харваанд ердөө хана 8 сум харваж байгаа нь арай цөөн байна. Ядахдаа хана харвааны 20 сумыг гүйцэд харваж байвал сайн юм. Хурдан морь уралдуулдаггүй нь бас шахуу хөтөлбөртэй нь холбоотой бололтой. Чухам хурдан морь уралдуулдаггүйгээр бусад наадмаас ялгагдана. Бусад үзүүлэлтээрээ сумын наадмын хэмжээнд хүрч байна.

- Өмнөговь аймгийн наадамд гаднаас ирж оролцож буй хүмүүс болон наадамчдын тоог яг нарийн гаргах бололцоогүй байсан бөгөөд наадамчдын хэлж байгаагаар урьд жилүүдтэй адил юм. Харин "Оюу толгой" төслийн наадамд 20 орны 2500 орчим хүн оролцсон нь урьд өмнөх жилээс илүү байна. Энэ нь "Оюу толгой" төслийн ажилтан, ажилчдаас гадна Ханбогд сумын хүмүүс олноороо ирж оролцсонтой холбоотой. Наадамд 163 машин техник ирсэн нь Өмнөговь аймгийн наадмаас ч илүү байгаа бөгөөд тэрхүү багахан талбайд их техник цугларсан нь говийн эмзэг хөрс, бэлчээрийг талхлах сөрөг талтай байж болох нь харагдав.

- Өмнөговь аймгийн наадмын бай шагнал ерөнхийдөө бусад аймгийн наадмын төвшинд, "Оюу толгой" төслийн наадмын бай шагнал сумын наадмын хэмжээнд байна. Харин "Оюу толгой" төслийн наадамд бөх, шагайн харваанд медаль, мөнгөн шагнал өгөөд сурын харваачдад дан мөнгөн шагнал өгдөг нь үндэсний спортын нэг төрлийг ялгаварласан мэт сэтгэгдэл төрүүлнэ.

- Өмнөговь аймгийн наадмын төсөв зардлын ихэнхи хэсэг аймгийн төсвөөс гарч байгаа бол соёлын бусад арга хэмжээг (Үдшийн цэнгүүн-VII.9), ("Миний нутгийн дуун" хүндэтгэлийн концерт-VII.10) "Тавантолгой" компани ивээн тэтгэж явуулав. "Оюу толгой" төсөл өөрийн наадмын зардлыг бүрэн дааж гаргасан бөгөөд наадамчин олны тав тухыг хангах бүх төрлийн үйлчилгээг (хүн суух олон асар, майхан, амралтын гэр, цэвэр ус, айраг, боловсон жорлон, олон төрлийн хоол унд, хогийн сав, цэвэрлэгээ гэх мэт) маш сайн зохион байгуулж, Улаанбаатар хотоос тусгайлан "Модерн номадс" рестораныг хүртэл авчирсан байна. Архигүй наадам нь бусад сум, аймгийн наадамд үлгэр болохуйц байна. Соёлын бичил арга хэмжээ, зарим нэг урлагийн тоглолт хийдэг бол наадам илүү сайн, чанартай, сонирхолтой болох талтайг цаашид анхаарах буй за.

- "Оюу толгой" төслийн наадам Ханбогд сумынхны, тэр дотроо хүүхдүүдийн хүсэн хүлээдэг баяр наадам болох нь тэдний олноороо ирсэн байдал болон яриа, сэтгэгдлээс харагдаж байна. Хэрэв энэ наадам дараа жил дахин болно гэвэл хүүхдүүдийн дунд хөгжөөнт тоглоом, уралдаан зохиовол дан ганц хоол унд идэж уух гэж ирдэг хүслийг нь арай өөр утга учиртай болгох юм.

- "Оюу толгой" төсөл хэрэгжихээс өмнөх наадмын үеийн зуншлагын байдал өнөө цагт "Оюу толгой" төслийн үйл ажиллагаанаас болж өөрчлөгдөөгүй байна. Харин энэ нь байгаль, цаг уурын байдлаас хамааралтай байгаа нь өвөл хатуу болсон хэдий ч зун эрт бороо орсноор зуншлага харьцангуй сайн байгаагаас харагдаж байна.

- Улсын баяр наадмаар үндэсний хувцсаа өмсөх явдал Өмнөговь аймагт ч (300 хүний дунд 49 хүн монгол дээл, цамц өмссөн), “Оюу толгой” төслийн наадамд ч тун бага байв. “Оюу толгой” төслийн ажилтан, ажилчдын дотор монгол хувцастай хүн бараг байхгүйтэй адил байсан бол гадаадын мэргэжилтнүүд олноор монгол цамц өмссөн байсан нь монголчууд бидэнд нэгийг бодох хэрэгтэйг харуулж байна.
- Наадам тарсны дараа олон наадамчид Ханбогд хайрханы Баяжихын агуй, Эхийн умай, Дэмчигийн хийд зэрэг шүтлэгт газруудад очихдоо их хэмжээний архи, усны сав, хоол ундны үлдэгдэл хаяж шүтэж дээдэлдэг газраа бохирдуулдаг нь бусад аймаг, суманд төдий л нийтлэг байдаггүй муу үйлдэл юм. Тэдгээр газруудыг тогтмол цэвэрлэж байх, тэнд хог хаяхыг хориглосон, энэ нь байгалиа бузарлаж байгаа жинхэнэ нүгэл болохыг бичсэн ухуулах самбарууд хийж босговол зүйтэй байна.

Өмнөговь аймгийн болон “Оюу толгой” төслийн наадам (хурдан морины уралдаан байхгүйг эс тооцвол) ерөнхийдөө уламжлалт баяр наадмын хэв шинжийг харуулсан монгол наадам хэвээр байна.

Товч тайлан бичсэн, доктор, профессор Ж.Гэрэлбадрах

## 21. ХАВСРАЛТ 12. НААДМЫН СУДАЛГААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

2010 оны 8-р сарын 15

Монгол улсын говийн нутагт ашигт малтмалын том орд газрууд нээгдэж байгаатай холбоотойгоор монголчуудын нэгэн чухал биет бус соёлын өв уламжлалт баярын нэг болох Үндэсний Их баяр-наадмыг тэмдэглэж ирсэн түүх, уламжлалд ямар өөрчлөлт гарч буй, эсэхийг Өмнөговь аймаг болон "Оюу толгой" төслийн наадмын жишээн дээр гаргахад эл бичил судалгааны ажлын үндсэн зорилго оршиж байв.

"Оюу толгой" төслийн "Соёлын өвийн хөтөлбөрийн" судалгааны багийн судлаач, МУБИС-ийн Монголын түүхийн тэнхмийн багш, доктор, профессор Ж.Гэрэлбадрах, төслийн туслах ажилтан, Үндэсний Төв Архивын эрдэм шинжилгээний ажилтан Ш.Эрдэнэбат, Тоёота Ланд Круйзер машины жолооч Г.Дорж нар 7-р сарын 8-13-нд Өмнөговь аймгийн Даланзадгад, Ханбогд сумдад ажиллав.

А. Өмнөговь аймгийн наадам



Өмнөговь аймгийн наадмын тухайд гэвэл, жил бүр 7-р сарын 11-12 бус, харин 7-р сарын 9-10 хооронд аймгийн наадмаа хийж тогтжээ. Энэ жил Их Монгол улс байгуулагдсны 804 жил, Ардын хувьсгалын 89 жилийн ой, Өмнөговь аймаг байгуулагдсны 79 жилийн ойн баяр наадмыг энэ 2 хоногт тэмдэглэн өнгөрүүлэв.

2010 оны 7-р сарын 9-ний 10 цагт Аймгийн төв цэнгэлдэхийн голд зассан жижиг тавцан дээрээс засаг дарга Ж.Бадраа наадмын үйл ажиллагааг нээж үг хэлсний дараа Монгол улсын төрийн дуулал эгшиглэж, төрийн далбааг аймгийн 10 шилдэг хүн–ажилтан, сурагч, ажилчин мандуулав. Үүний дараа наадмын талбай дээр 40 минутын хүндэтгэлийн концертыг аймгийн Хөгжимт драмын театрын жүжигчид тоглов. Концертын хөтөлбөр Морин хуурын дөрвөл, Захчин бүжиг, Алтайн магтаал, "Амар жаргалант" дуу, "Би монгол эр хүн" дуу, "Үүлэн бор" сурагчдын морин хуурын чуулгын тоглолтоос бүрдэж байв.

Бөхийн талбай дахь Монгол улсын төрийн далбааг бөхчүүд, сурын ба шагайн харваачид тойрж хүндэтгэв. Аймгийн төв цэнгэлдэхэд хуран чуулсан наадамчин олны дотор үндэсний хувцсаа өмссөн хүн тун цөөн байгаа нь ажиглагдав. Тухайлан төв асрын зүүн талд сууж буй 350 орчим хүнийг бүртгэн үзэхэд тэдний 49 нь хүн дээлтэй байсны олонхи настай хүмүүс байна. Монгол цамцтай 16 хүний ихэнхи нь эмэгтэйчүүд байна. Энэ бүхнээс монголчууд нийтээрээ үндэсний хувцсаа өмсөх нь багасч байгаа, тэр дундаа баяр ёслолоор илүүтэй их өмсдөг байсан нь хүртэл урьд өмнөхөөс бага болж байгаа, энэ нь даяаршлын нөлөө хувцас хунар дээр хүртэл тусч байгааг харуулж байгаа багахан боловч баримт болох юм.

Үндэсний бөх. Концертын дараа үндэсний бөхийн барилдааны 1-ийн даваа эхлэв. Нийт 256 бөх барилдаж байгаагаас 4 бөх Өвөрхангай, Архангай, Дундговиос ирсэн бөгөөд бусад Өмнөговь аймгийн бөх, мөн аймгийн цэргийн ангийн байлдагчид байв. Эхний өдөр 1 ба 2-ын даваа болж, 18 цаг гээд дуусав. Наадмын хоёрдахь өдөр үндэсний бөхийн 3-7 даваа болж дууссан юм. Бөхийн бай шагнал,

1 давсан бөх – 5000 төг (1.5 литрын ус буцалгагч)

2 давсан бөх – 10000 төг (2.5 литрын төмс шарагч)

3 давсан бөх – 20000 төг

4 давсан бөх – 40000 төг

5 давсан бөх – 60000 төг

6 давсан бөх – 100000 төг

Үзүүрлэсэн бөхөд – 150000 төг

Түрүүлсэн бөхөд – 200000 төгрөг юм. Барилдаанд 1-6 давсан бөхийн байг мөнгөөр бус эд зүйлээр өгч байв.



Мөн өсвөрийн 32 бөх барилдсан бөгөөд тэдэнд олгосон бай шагнал нь

1 давсан бөхөд 3000 төг

2 давсан бөхөд 5000 төг

3 давсан бөхөд 10000 төг

4 давсанүзүүр бөхөд 40000 төг

5 давж түрүүлсэнд 50000 төгрөг ажээ. Түрүүлсэн бөхчүүдэд алт, үзүүрлэсэн бөхчүүдэд мөнгөн медаль, өргөмжлөл, цолны энгэрийн тэмдэг, үнэмлэх, шөвгөрсөн бөхчүүдэд мөнгөн медаль, өргөмжлөл тус тус өгөв.

Наадмын эхний өдөр цэнгэлдэхэд 400 ба 800 метрийн хөнгөн атлетикийн уралдаан болж, түрүүлсэн тамирчдад 9000, 7000, 5000 төгрөгийн шагнал олгов. Шагналын сан нь 200000 төгрөг ажээ. Мөн 150000 төгрөгийн шагналын сантай шатрын тэмцээн явагдав.

Үндэсний сурын харваа. Аймгийн төв цэнгэлдэхийн зүүн захад сурын талбай бий. Тэнд эрэгтэй, эмэгтэй харваачид хана харвааны 20 сум, хасаа харвааны 20 сум нийт 40 сум, хүүхэд хана харваа 20 сум, хасаа харваа 12 сумыг, нийт 32 сумыг 2 өдөрт харвав. Эрэгтэйчүүд 75 метр, эмэгтэйчүүд 65 метрт, хүүхдүүд наснаасаа шалтгаалан 35-65 метрийн (6-9 нас 35 метр, 9-12 нас 45 метр, 12-16 нас 55 метр, 16-18 нас 65 метр) хооронд харвадаг билээ. Аймгийн наадамд харваж буй харваач бүр монгол дээл, малгай өмссөн байгаа нь үндэсний уламжлалаа сайн хадгалж байгаагийн нэг илрэл юм.

Хана харваа гэдэг нь хасааг 3 давхарлан өрсөн нийт 60 хасаанаас бүрддэг бол хасаа харваа нь хасааг 2 давхарлан 32-оор өрсөн байдаг. Хана ба хасаа харвааны зурхайн зай 2.5 метр байдаг. Тэр дотор сум унаад гулсаж онохыг тооцдог юм.



Өмнөговь аймгийн наадамд эрэгтэй 8, эмэгтэй 6, хүүхэд 13 (9 хөвүүн, 4 охин) оролцов. Нилээд олон харваач жил бүр хойшоо улсын наадамд явдаг. Энэ жил мөн явсан ажээ. Энэ жилийн хүүхдийн хөвүүдийн харваанд оноо тэнцэж "товх харвав". "Товх харвах" гэдэг нь харваж дууссаны дараа оноо тэнцсэн 2 харваач харвасан газраасаа 1 алхам ухраад 16-18 хасаагаар өрсөн хасаанд нэг нэг сум тавьна. Хоёул оновол дахин нэг алхам ухраад харвана. Хэн оносныг нь ялсанд тооцно.

Аймгийн наадмын сурын харваанд түрүүлсэн хүнд "аймгийн мэргэн" цол, алтан медаль, өргөмжлөл, 150000 төгрөг, 2-т орсон хүнд мөнгөн медаль, өргөмжлөл,100000 төгрөг, 3-т орсонд хүрэл медаль, өргөмжлөл, 80000 төгрөг, эхний гурван байр эзэлсэн хүүхдэд алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, 20000, 15000, 10000 төгрөг өгөв. Харваач нарт оносон оноогоор нь онооны мөнгө өгдөг. Уг нь хэн хэд оносноороо авах ёстой боловч сурын харвааны комисс нийт харваач дундаа хуваагаад адил тэгш тараадаг ажээ. Энэ жилийн онооны мөнгө нийтдээ 80000 төгрөг байсан ажээ. Тэд үүнийг "шорооны мөнгө" хэмээн нэрлээд заншжээ.

Хурдан морь. Энэ жил Өмнөговь аймгийн баруун талын сумдаар зуншлага тааруу байсан тул морьдын тоо харьцангуй цөөн байв. Морь барианы газар, аймгийн наадмын морины комисс аймгийн төвөөс баруун хойш мод үржүүлгийн газрын хойно байрлана. Морь барианы газрын хоёр талаар шохой асгаж, олон модон жижиг багана босгон олсоор холбосон нь хүн, мал, машин оруулахгүй, наадамчид эгнэн зогсоод морьд хэрхэн орж ирж байгааг харах аятай боломж олгожээ.

Морь гарааны газар баруунтаа байх бөгөөд тэнд морь гарааны тусгай хэрэгсэлтэй болсон тул морь түрүүлж гарах, булхайцах, будлиан хийх ямар ч боломжгүй болгосон нь нэн сайшаалтай. Наадмын эхний өдөр буюу 7-р сарын 9-ний үдийн өмнө азарга ба их насны морь, үдийн хойно хязаалан ба шүдлэн морины уралдаан болсон бол наадмын хоёрдахь өдөр 7-р сарын 10-ны үдийн өмнө соёолон ба дааганы уралдаан тус тус болж дууссан билээ. Уралдсан морьдын тоог нас бүрээр хэлбэл,

Азарга – 47 (23 км.)

Их нас – 51 (26 км.)

Хязаалан – 50 (18 км.)

Шүдлэн – 68 (14 км.)

Соёолон – 55 (23 км.)

Даага – 42 (21 км.) ажээ.

Аймгийн уяач, малчдын олонхи суран тоног хэрэглэл–хазаар, чөдөр, аргамжаа хэрэглэх нь багасч, цагаан мяндас, даавуу, олс зэргээр хийх нь олширсон байна. Ганцхан шүдлэн морьдыг шүдлэж бүртгэн гаргаж байхыг ажиглахад нийт 68 мориноос 20 нь монгол эмээлтэй, бусад нь "Жокей" хэмээх урд ба хойд бүүрэггүй, урдаа бариултай, европ маягийн эмээлтэй байв. Энэ нь хурдан морины уралдааны тоног хэрэглэлд гадны нөлөө ихээр тусах болсны нэг жишээ болж байна.

Уралдахаар ирсэн хурдан морьд болон уяачдын унасан морьдыг харахад ихэнхи нь (3 морьтой хүний 2) хятадын хар, саарал, цагаан өнгийн реминээр хазаар хийсэн байх ба эмээлийн жирэм, чөдөр, ногт, жолоо, цулбуураа мөн тийм эдээр хийсэн байв. Хурдан мориныхоо гөхлийг улаан өнгийн цахилгааны лентээр боосон уяач хүртэл байсан юм.

Малчдын дунд өвөл идшинд хэрэглэсэн үхрийн ширээ боловсруулан сур хийж, түүгээрээ хазаар, чөдөр, ногтоо хийдэг уламжлал алдагдсан бололтой байна. Чөдрөө олсоор хийсэн хүнээс яагаад ийм юмаар чөдөр хийснийг асуухад бороонд нороод хатдаггүй гэсэн юм. Уг нь энэ бол асуудал биш бөгөөд бороонд норсон суран эдлэлийг өөхөн тосоор тосолж зөөлрүүлэн бөх бат хэвээр нь хэрэглэж ирсэн уламжлалтай бий. Зөвхөн Өмнөговь аймагт ч бус, Булган аймгийн Баян-Агт сум, Архангай аймгийн Тариат сумын наадмыг үзэж байхад ч сураар биш реминээр хийсэн эмээл, хазаартай морьтой хүн олон байсан билээ.

Эндээс үхрийн ширийг боловсруулан сур хийх ажил багасахын хэрээр сурын хэрэглээ багасч байгааг түвэггүй харж болно. Гэхдээ сур хэрэглэх явдал ор алга болоогүй, бага хэмжээгээр боловч бий. Тухайлбал, Дундговь аймгийн Адаацаг суманд үхрийн бүтэн ширээр хийж элдсэн сур бага насны адууны үнэ, алд сур 2000 төгрөг хүрч малчид ихээр авч байсан юм. "Сайн морь, сайхан эмээл, хазаар эр хүнийг чимдэг" гэдэг үг Өмнөговь аймагт зарим талаар утгаа алдаж эхэлжээ. Мөнгөн эмээл, хазаартай хүн цөөн харагдсан нь энэ нутагт эдэлж хэрэглэж байгаагүй биш байгаагаа хэрэглэхээ больсон, эсэхүл хуучин эдлэл үнэтэй байдгаас зарж үрсэн зэрэгтэй холбоотой бололтой.

Хурдан морины уралдаанд түрүүлж, айрагдсан морьдын шагнал,

| | Түрүү | Аман хүзүү | 3 | 4 | 5 |
|---|---|---|---|---|---|
| Азарга | 220.0 | 170.0 | 120.0 | 120.0 | 120.0 |
| Их нас | 220.0 | 170.0 | 120.0 | 120.0 | 120.0 |
| Соёолон | 220.0 | 170.0 | 120.0 | 120.0 | 120.0 |
| Хязаалан | 170.0 | 120.0 | 70.0 | 70.0 | 70.0 |
| Шүдлэн | 170.0 | 120.0 | 70.0 | 70.0 | 70.0 |
| Даага | 170.0 | 120.0 | 70.0 | 70.0 | 70.0 |

Баян ходоод 30.0 x 6 нас бүрт шалгаруулсан байна. Уг нь хуучин уламжлал бол зөвхөн дааган дээр баян ходоодыг шагнадаг байсан билээ.



Айрагдсан морь бүхэнд медаль хадах улаан өнгийн магнайвч өгөх бөгөөд түрүүлсэн моринд алтан медаль, аман хүзүүдсэн моринд мөнгөн медаль, айрагдсан 3 морь бүрт хүрэл медаль өгч байв. Хурдан морины нас бүрт айргийн тавaас гадна 6-20-т давхисан морьдыг барьж байлсан бөгөөд байг нь 6-10 давхисан морьдод 30.0 төгрөг, 10-20 давхисан морьдод 5000 төгрөгөөр бодож, заримд нь хадаг, радио хүлээн авагч өгсөн байна.

Аймгийн наадмын хурдан морины комиссын нарийн бичгийн дарга Цогбадрахтай хийсэн ярилцлага–бичлэгийг бас хавсаргав.

Мөн уралдаж буй морьдыг олон машин дагадаг урьдын буруу зуршил хэвээр байгаа нь харагдаж байлаа. Зөвхөн шүдлэн насны морьдын уралдааныг 17 машин дагасан нь арай л ихэдсэн тоо юм.

Шагайн харваа. Аймгийн цэнгэлдэх хүрээлэнгийн зүүн хэсэгт 2 том асарт шагайн харваа явагдав. Багийн харваа ба цуваа харваа гэсэн хоёр төрлөөр өрсөлдөв. Зургаан хүнтэй 6 баг оролцон харвав. Баг бүр нэг орлогчтой тул нийт 7 харваачтай. Өмнөговь аймгийн 3 багийн шагайн харваачид Улсын наадамд явсан гэнэ.





Шагайг 9 тохой газар буюу 4.70 метр зайнаас бугын эврийн угаар хийсэн дөрвөлжин ясан шагай–сумаар 15 хасаа-шагайг харвадаг. Нэг ээлжинд 4 хүн (өөр багийн 2, 2 нийт 4) сууж, 4, 4 сум тавьж ээлжлэн 2 багийн тамирчид өөрийн багийн 15 ба нөгөө багийн 15 хасааг дуустал нь харваж ялагчаа тодруулна. Баг бүр хоорондоо тулж харвасаар тэмцээний авгаргаа шалгаруулна. Дараа өдөр нь хувийн цуваа харваа болов.

Шагайн харваачдыг ажиглаж байхад залуучууд хашлага бүхий сумаар харваж байхад настайчууд нь их төлөв чагт бүхий нум сумаар шагай харваж байв. Энэ нь настай хүний гар, хурууны бяр муудсантай холбоотой юм. Ихэнхи харваач монгол дээл эсвэл цамц өмссөн байсан нь сайшаалтай. Шагай харваач Еринпэл гэдэг өвгөнөөс ярилцлага авч бичлэг хийв. (бичлэг).

Өмнөговь аймгийн наадмын шагайн харвааны бай шагнал гэхүл,

Багийн харваа:

I. 210.0 төг (30.0x7 хүн), медаль, өргөмжлөл

II 140.0 төг (20.0x7 хүн) медаль, өргөмжлөл

III 70.0 төг (10.0x7 хүн) медаль, өргөмжлөл

Цуваа харваа:

I. 1 хүн 30.0 төг, медаль, өргөмжлөл

II 1 хүн 20.0 төг. медаль, өргөмжлөл

III 1 хүн 10.0 төг. медаль, өргөмжлөл



Мөн тусгай шагналаар 2 харваачийг тус бүр 15000 төгрөгөөр байлав.

Өмнөговь аймгийн наадмын төдийгүй нийт Монгол улс даяар "Эрийн гурван наадам" бус, "Эрийн дөрвөн наадам" хийдэг болсоор 10 орчим жил болж байна. Монгол наадмын дөрөвдэх төрөл нь шагайн харваа ажээ. Шагайн харваа наадмын хөтөлбөрт багтах болсноор ийм өөрчлөлт орсон билээ.

Соёлын бусад арга хэмжээ. Өмнөговь аймгийн наадмын соёлын арга хэмжээ сайн болдог юм байна. 7-р сарын 9 буюу наадмын эхний өдрийн орой 19-21 цагт аймгийн Хөгжимт драмын театрт Хос дууны уралдаан болж өнгөрөв. Түүний дараа Т.Борын талбайд 22 цагаас Үдшийн цэнгүүн эхэлж, 01 цаг хүртэл үргэлжлэн гурвантаа их хэмжээний салют буудав. Уг цэнгүүний тайз засалт, гэрэлтүүлэг, хөгжим, өсгөгч зэрэг нь их сайн байсан бөгөөд энэ бүхнийг нүүрсний "Таван толгой" компани, захирал Уламбаяр авч өгсөн гэнэ. Наадмын цэнгүүний бүх зардлыг тус компани гаргаж, ивээн тэтгэсэн ажээ.

Хөгжимт жүжгийн театрын тоглолт 7-р сарын 10-ны орой 20-22 цагт, 7-р сарын 11-нд мөн театрт "Миний Монголын дуун" хүндэтгэлийн концерт тус тус болов. Улсын баяр наадмаар 4 удаа урлагийн том хэмжээний арга хэмжээ зохион байгуулж байсан аймгийг миний бие урьд өмнө нь үзээгүй тул Өмнөговь аймгийн наадмын соёлын арга хэмжээ гүнзгий сэтгэгдэл төрүүлэв. Хөгжимчид, дуучдын тоглох ба дуулах чадвар хотынхоос дутахааргүй түвшинд, байнгын бэлтгэлтэй байгаа нь харагдаж байлаа.

Б. "Оюу толгой" төслийн наадам

Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт үйл ажиллагаа явуулдаг "Оюу толгой" төслийн наадам 2010 оны 7-р сарын 11-ний өдөр сумын төвөөс баруун урд зүгт 27 км зайд орших Оорцогийн хөндийн хойд цохио, мөн Аман усны баруун хойд цохио гэж нэрлэдэг байсан газар болов. Наадам өглөө 11 цагт эхэлсэн бөгөөд маргааш нь буюу 7-р сарын 12-нд ажилтай тул 17 цаг гэхэд дууссан байх ёстой ажээ.

Тэнд "Оюу толгой" төслөөс хэдэн жилийн өмнө буюу 2007 онд 5 ханатай гэр–28, 8 ханатай гэр–1, 12 ханатай гэр улаан халзтай гэр нэгийг барьсан тул газрын нэр өөрчлөгдөж, "Арван хоёр ханат" гэж нэрлэх болсон байна. Уг газар урьд нь ямар нэртэй байсныг наадамчдаас асуухад мэдэх хүн ховор байсан бөгөөд урд хөндийг нь Оорцогийн хөндий гэдэг гэхээс өөрөөр мэдэх хүн гарахгүй байв. Энэ бол газрын уламжлалт нэр уул уурхайн хөгжлийг дагаад хувирч өөрчлөгдөж эхэлж байгаагийн нэгэн жишээ болно. Тухайн газрыг уул нэрээр нь нэрлэж занших нь зүйтэй байна. Уг газрын язгуур нэрийн талаар сумын иргэн Мөнхөө гуайтай хийсэн ярилцлага хийв. (бичлэг)

Уг наадамд "Оюу толгой" төсөл, түүнтэй хамтран ажилладаг компаниудын ажилтан ажилчид, Ханбогд сумын иргэд оролцсон юм. Бөхийн талбайд мандуулсан гадаад улсуудын төрийн далбаа болон гадаад улсын мэргэжилтэн–наадамчдыг тоолоход дэлхийн 21 орны төлөөлөгч оролцсон өвөрмөц наадам болсон юм. Гадны улсын мэргэжилтнүүд үзэгчийн байр сууринаас оролцсон ба цөөн тооны хүмүүс үндэсний сурын харваанд оролцсныг хэлэх хэрэгтэй.





Наадам үндэсний бөх, сурын харваа, шагайн харваа гэсэн гурван төрлөөр болдог ажээ. Наадмыг нэг өдөрт багтаах ёстой байсан тул хурдан морины уралдааныг угаасаа явуулдаггүй гэнэ. Зүй нь 6 насны морь уралдуулах боломжгүй бол Монгол наадмыг ёсыг бодож хамгийн бага нас болох дааганы уралдааныг зохион байгуулж байвал сайн сан.

Наадам 10.55-д эхэлж, ажилтан ажилчдын баярын жагсаал болов. Үүнд "Оюу толгой" төсөл болон түүнд хамтран оролцдог 12 компаний төлөөлөл болсон 12-15 хүн тугаа барьж оролцон, наадмын талбайн голд жагсав. Тэдгээр нь,

| | |
|---|---|
| -Оюу толгой, | -"Бамбай" хамгаалалтын алба |
| -Флюр | -Редпат Монголия |
| -Хасу мегаватт | -Геомандал |
| -Майор дриллинг | -Моннис |

-Тоёото -Хаанзаа

-МЕК -Барилга корпораци зэрэг юм.

Баярын жагсаалын дараа Их Монгол улс байгуулагдсны 804, Ардын хувьсгалын 89 жилийн ойн наадмыг нээж "Оюу толгой" төслийн гүйцэтгэх дэд ерөнхийлөгч С.Гарсиа, дэд ерөнхийлөгч Санждорж нар нээж тус тус үг хэлэв. Жагсагчид наадмын талбайгаас гарч, Монгол улсын төрийн дууллын эхний бадаг эгшиглэсний дараа "Эрдэнэ засгийн унага" дуу дуулаад үндэсний бөхийн барилдааны 1-ийн даваа эхлэв. (бичлэг).

Наадмын гурван талбай зассаны томд нь үндэсний бөхийн барилдаан, түүний зүүнтээх талбайд үндэсний сурын харваа, хойд талын багахан асарт шагайн харваа тус тус явагдав. Талбай бүрийн хоёр талаар үзэгчид суух сандал бүхий саравчийг тусгайлан зассан бөгөөд асар бүрд идээ засч, айраг сөгнөж, үйлчилгээний хүмүүс ажиллуулжээ. Уралдаан тэмцээн бүрийг хариуцан зохион байгуулах хүнийг "Оюу толгой" төслөөс тусгайлан томилж ажиллуулсан бүлгээ.

"Оюу толгой" төслийн наадам 16.45-д төслийн дэд ерөнхийлөгч Санждорж түрүүлж, үзүүрлэсэн бөх, эхний гурван байр эзэлсэн сурын ба шагайн харваан тамирчдад шагналыг гардуулснаар өндөрлөж, үйлчилгээний ажилчид наадамчдын тарьсан хог хаягдлыг цэвэрлэхээр үлдэв.



Үндэсний бөх. Нийт 64 бөх барилдснаас том цолтой нь аймгийн заан Ш.Цэдэв, аймгийн заан З.Наранбаатар хоёр байв. Уг барилдаанд "Оюу толгой" төсөлд хамтран ажилладаг олон компаниудын ажилчин залуучуудаас барилдсан бөгөөд тэдний дунд аймгийн цолтой 1, сумын цолтой 4 бөх барилдсан юм. Мөн Ханбогд сумаас зарим бөхчүүд хоцорч ирсний улмаас барилдаж чадаагүй юм.

Тэнд барилдаж буй ажилчин залуучуудын багагүй хэсэг зодог шуудаг өмсөлгүй зөвхөн далбаатай өмд өмсөөд барилдаж байна. Харин бөхийн комиссоос заавал зодог шуудагтай гарч барилдахыг удаа дараа шахаж шаардаж байсныг сайшаан тэмдэглэж байна. Дараа жилээс эхлэн "Оюу толгой" төслийн наадамд заавал зодог шуудаг, далбаа өмссөн хүнийг барилдуулна гэсэн хатуу заалт тогтоовол Монгол бөхийн барилдааны дэг жаягийг сахихад чухал нөлөөтэй юм.

"Оюу толгой" төслийн үндэсний бөхийн бай шагнал нь,

1 давсан бөх – 5000 төгрөг

2  давсан бөх –10000 төгрөг

3 давсан бөх – 15000 төгрөг

4 давсан бөх – 20000 төгрөг (шөвгөрсөн 2 бөхөд нэмэж 50000 төгрөг)

Үзүүр бөх – 160000 төгрөг

Түрүү бөх – 200000 төгрөг байв. Бөхийн бай шагнал их ч биш, бага ч биш хэвийн төвшинд байна. Шагналын их өндөр болговол наадмын утга учир алдагдаж, мөнгөний төлөөх буруу тэмцэл явагддаг сөрөг талтайг болгоох буй за.

"Оюу толгой" төслийн наадмын бөхийн барилдаанд Өмнөговь аймгийн Баяндалай сумын харьяат, аймгийн начин Эрхэмзориг түрүүлж, Хэнтий Баянмөнх сумын харьяат, аймгийн заан Наранбаатар үзүүрлэв.

<u>Шагайн харваа.</u> "Оюу толгой" төслийн шагайн харвaанд 6 харваач, 1 орлон харвагчтай 4 багийн нийт 28 харваач оролцов. Ноднин жилийн наадмаар хувийн цуваа харваа болсон бол энэ жилийн наадмаар багийн харваа ба хувийн цуваа харваа хоёр болсон билээ.

Тэдгээр 4 багийн 3 нь Ханбогд сумын, 1 нь "Оюу толгой" төслийн баг ажээ. "Оюу толгой" төслийн багт Өмнөговь аймагт хэдэнтээ түрүүлж "гоц мэргэн" цол авсан 2 харваач байв. Түүний нэгтэй хийсэн ярилцлага бий. (бичлэг).

Багийн харваанд

Ханбогд сумын баг 20000 төг x 7=140000 өргөмжлөл, алтан медаль

"Оюу толгой" баг 15000 төг x 7=105000 өргөмжлөл, мөнгөн медаль

Ханбогд сумын баг 10000 төг x 7=70000 өргөмжлөл, хүрэл медаль авсан бол хувийн цуваа харваанд эхний гурав орсон харваачдад өргөмжлөл, алт, мөнгө, хүрэл медаль 30000, 20000, 10000 төгрөгний шагнал өгсөн гэв.

Шагайн харваачдын багагүй хэсэг монгол цамц, малгайтай байсан бол түүнээс дутуугүй хүмүүс энгийн, европ хувцастай, богино өмдтэй хүртэл байв. Нэгэнт шагай харваа үндэсний спорт мөн бол түүнд оролцогчид монгол хувцастай байх ёстой гэсэн шаардлагыг дараа жилийн наадмаас эхлэн тавьж байх нь зүйтэй юм.

Үндэсний сур. "Оюу толгой" төслийн үндэсний сурын харвааанд орох хүн олон байсан боловч эхэлж нэрээ бүртгүүлсэн эрэгтэй 35, эмэгтэй 7 хүн орж харвав. Тэдний ихэнхи "Оюу толгой"-гоос ирсэн наадамчид байв. Уламжлал ёсоор эрчүүд 75 метр, эмэгтэйчүүд 65 метрийн зайнаас харвав. Уг нь хана харвааанд 20 сум, хасаа харвааанд 20 сум бүгд 40 сум харваж ялагчийг тодруулах ёстой байсан боловч цагийн давчуу байдлаас шалтгаалсан хэмээн хүн тус бүрээр 8 сум харвуулав. Ноднин жилийн наадмаар бол нэг хүнийг 12 сум харвуулсан гэнэ. Дараа жил "Оюу толгой" төсөл наадам хийвэл сурын харвааг өглөө эрт эхлүүлж хана ба хасааг харвааг бүрэн харвуулж байвал сайн бөгөөд энэ нь уламжлалаа хадгалах тал дээр анхаарч байгаагийн нэг илрэл болох ёстой.

Ханбогд сумаас ирж сурын харвааны шүүгч хийж буй, сумын сурын холбооны нарийн бичгийн дарга Жаргалаас товч ярилцлага авав. (бичлэг). Эрэгтэй 3-р байр, эмэгтэй мөн 3-р байрын төлөө оноо тэнцсэн тул "товх харваж" байж шалгаруулав. Ингэхдээ сурын дүрмийн дагуу хойш 1 алхам ухруулсангүй, хуучин байран дээрээс нь харвуулсан нь харваачдын чадварыг харгалзан үзсэн хэрэг болов уу.

Үндэсний сурын харвааанд эрчүүдээс "Оюу толгой" төслийн ажилчин, эмэгтэйчүүдээс Ханбогд сумын хүн тус тус түрүүлэв. Харваачдад (эр ба эм тусад нь) өгсөн бай шагнал нь

Өргөмжлөл, 30000 төгрөг

Өргөмжлөл, 20000 төгрөг

Өргөмжлөл, 10000 төгрөг байв.

Сурын харваан дээр зайлшгүй анхаарах хэдэн зүйл байгаагийн эхнийх нь үндэсний дээл хувцас, малгай өмсөхгүй харваж байгаа явдал юм. Тэр битгий хэл богино өмдтэй хүн хүртэл сур харваж байгаа нь үндэснийхээ баяр наадмыг үл хүндэтгэсэн хэрэг болно.

Сур харваа нэгэнт үндэсний спорт мөн тул үндэсний дээл, малгай өмссөн хүн харваж байх ёстой байдаг бөгөөд энэ дэг жаягийг заавал мөрдөж байх хэрэгтэйг дараа дараагийн наадамд анхаарах нь зүйтэй. Үндэсний сураар зөвхөн монголчууд төдийгүй гадны мэргэжилтнүүд хүртэл сонирхон харваж байгаагаас харахад дараа жилийн наадмын сурын харвааанд оролцох хүмүүсийн тоо нэмэгдэх байдалтай байна.

Хоёрдахь зүйл нь бөх, шагайн харвaанд медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал өгч байгаа атлаа сурын харвaанд өргөмжлөл, мөнгөн шагнал өгөөд орхиж байгаа нь үндэсний спортын нэг төрлийг илт гадуурхсан буруу явдал юм. Үүнийг дараа жилийн наадамд засах хэрэгтэй. Гуравдахь нь цөөн хэдэн сум харвасан болж оромдох бус, дүрмийн дагуу сумыг аль болох гүйцэд тоонд нь хүргэж харвуулж байх талаар арга хэмжээ авалтай. Дөрөвдүгээрт, "Оюу толгой" төслөөс эрхлэн 15 нум, 75 сум (1 нумд 5 сум байхаар бодож) захиалан хийлгэж авах (Хүдэрчулуун мэргэн нум сум хийдэг. Утас–99192800) хэрэгтэй юм байна. Ингэхгүй байгаагаас олон хүн Ханбогд сумаас авчирсан цөөн хэдэн нум, сумаар ээлжлэн харваж их цаг үрж байгаа нь харагдав.

Иймээс сурын харвааны төрөлд анхаарлаа зохих хэмжээгээр хандуулж, уламжлалт ёс журмаар явуулах арга замыг эрэлхийлж, тодорхой зардал гаргах хэрэгтэй юм байна.

Наадмын үйлчилгээ. "Оюу толгой" төслийн наадамд Өмнөговь аймгийн Ханбогд сумын иргэд, "Оюу толгой" төслийн ажилчид оролцсон юм. Наадамчдын ая тухтай байхад зориулан 12 ханатай халзтай том гэрт караоке, шатар, амралтын ор, ширээ сандал зассан ба түүнд наадамчид чөлөөтэй орж гарч байв. Энэ жил анх удаа Улаанбаатар хотоос "Модерн номадс" сүлжээ ресторан ирж 8 ханатай гэрт хуушуур хийж наадамчдад үнэгүй үйлчлэв. Монгол  наадмыг хуушуургүйгээр төсөөлшгүй байдаг тул "Оюу толгой" төслөөс энэ тал дээр зориуд анхаарч авчирсан байна. Наадмын талбай дээр иргэд юм худалдан авч идэх шаардлага байгаагүй бөгөөд бүх юмыг "Оюу толгой" төслөөс үнэгүй хангаж тарааж байв.

“Оюу толгой” төслийн хүнсний хангалтыг хариуцсан CIS компанийн ажилчид гадаа зассан гурван хэсэг газар зайдас, тахианы мах шарж, хонины махыг чанаж хачирлан өгч байв. Наадамчин олны тав тухыг хангах бүх төрлийн үйлчилгээг (усан оргилуур, майхан, амралтын гэр, цэвэр ус, чихэр, идээ, айраг, боловсон жорлон, хогийн сав, цэвэрлэгээг) сайн зохион байгуулж байв.

Наадмын машины зогсоол болон үйлчилгээнд нийт 163 машин ирснээс УАЗ-469 машин-22, мотоцикль-59, том оврын автобус-15, жийп машин –67 байв. Тийнхүү тэрхэн хэсэгхэн газарт ахадсан машин техник цугларсан тул говийн эмзэг хөрс бэлчээрийг талхлах аюултай болохыг цаашдаа анхаарах биз ээ.

“Оюу толгой” төслийн наадам нь 5 дахь жилдээ болж байгаа бөгөөд дараа жилээс орон нутгийг хамрахгүй, зөвхөн компани дотроо явагдахаар болсон тухай ажилчид болон нутгийн иргэд ярьж байв. “Хасу мегавит” компанийн ажилчин залуусын яриагаар ажилчдын тоо өсч байгаа учраас дараа жил наадмаа компани дотроо явуулах болж байгаа гэнэ. Уг яриа үнэн худлыг мэдэхгүй бөгөөд дараа жил наадмаа гадна хийсэн ч, дотроо хийсэн ч ялгаагүй хамгийн гол нь Монгол үндэсний наадмын уламжлалт дэг журам, дүрмийг ягштал баримталж байх нь чухал юм.



Наадам тарсны дараа наадамчид зүүнтэй холгүй орших Ханбогд хайрханы Баяжихын агуй, Эхийн умай зэрэг газруудад очихдоо их хэмжээний архины шил, ус, ундааны сав, хоол ундны үлдэгдэл хаяж шүтэж биширдэг газраа бохирдуулсан байсан юм. Тэр бөөн хогноос 50 кг-ийн гурилын шуудайгаар усны сав, архины шил түүж Улаанбаатарын хаягдал эд зүйл авдаг цэгт авчирч тушаахад хуванцар сав 2 кг–1000 төг, архины шил 12 ш–400 төгрөг болсон юм. Бидний авснаас 4 дахин их хог үлдсэн нь ямархан хэмжээний хог овоолсныг мэдэж болно.

**В. Дүгнэлт**

Монголчуудын уламжлалт баярын нэг болох Улсын наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх нь өөрчлөгдөж буй, эсэхийг Өмнөговь аймгийн ба Оюу толгой төслийн доорхи хэдэн зүйлээр гүнзгийрүүлэн авч үзээд дүгнэхэд,

-Өмнөговь аймгийн наадмын далайцыг барилдах бөх (256 бөх, өсвөрийн 32 бөх), шагай харваачид (6 хүнтэй 6 баг, нийт 36 харваач), сур харваач( насанд хүрэгчид эр-8, эм-6 нийт 14, хүүхэд хөвүүн-9, охин-4 нийт 13, бүгд 27 харваач), уралдах морьдын (азарга-47, их нас-51, хязаалан-50, шүдлэн-68, соёолон-55 , даага-42, бүгд 313 морь) тоонд тулгуурлан үзвэл бусад аймгуудтай ерөнхийдөө адил (хурдан морины тоо арай цөөн байгааг эс тооцвол) төвшинд байна.

"Оюу толгой" төслийн наадам бөх (64 бөх), шагайн харваа (7 хүнтэй 4 багийн 28 харваач), үндэсний сур (эр-35, эм-7 харваач) гэсэн 3 төрлөөр явсан нь 10 цагт эхэлж, 17 цагт дуусгах 1 өдрийн шахуу хөтөлбөртэй нь холбоотой ажээ. Хурдан морь уралдуулдаггүй нь бас шахуу хөтөлбөртэй нь холбоотой бололтой. Чухам хурдан морь уралдуулдаггүйгээр бусад наадмаас ялгагдана. Бусад үзүүлэлтээрээ сумын наадмын хэмжээнд хүрч байна.



-"Оюу толгой" төслийн наадамд Монгол наадмын уламжлалыг бага боловч хадгалах үүднээс зургаан насны морьдыг нэг өдөр уралдуулах боломжгүй тул ёсыг бодож ядахдаа хамгийн бага нас болох дааганы уралдааныг дараа жилээс эхлэн зохион байгуулж байвал сайн юм. Ингэвэл нүүдэлчин монголчуудын наадмыг уламжлалт ёсыг хадгалах талаар бусад уул уурхайн компаниудад үлгэр болно. Учир нь мөн оны 8-р сарын дундуур Цогтцэций сумын нутагт болсон "Енержи Ресорс" компаний наадам хурдан морь, сур харваагүй, дан ганц үндэсний бөх барилдсан наадам болсон билээ. Энэ буруу хандлагыг өөрчлөхөд "Оюу толгой" төслийн наадам цаашид үлгэр жишээ болох ёстой болов уу.

-Өмнөговь аймгийн наадамд гаднаас ирж оролцож буй хүмүүс болон наадамчдын тоог яг нарийн гаргах боломжгүй байсан бөгөөд наадамчдын хэлж байгаагаар урьд жилүүдтэй адил юм. Харин "Оюу толгой" төслийн наадамд 20 орны 2500 орчим хүн оролцсон нь урьд өмнөх жилээс илүү байна. Энэ нь "Оюу толгой" төслийн ажилтан, ажилчдаас гадна Ханбогд сумын хүмүүс олноороо ирж оролцсонтой холбоотой. Наадамд 163 машин техник ирсэн нь Өмнөговь аймгийн наадмаас ч илүү байгаа бөгөөд тэрхүү багахан талбайд их техник цугларсан нь говийн эмзэг хөрс, бэлчээрийг талхлах сөрөг талтай байж болох нь харагдав.

-Өмнөговь аймгийн наадмын бай шагнал ерөнхийдөө бусад аймгийн наадмын түвшинд, "Оюу толгой" төслийн наадмын бай шагнал сумын наадмын хэмжээнд байна. Харин "Оюу толгой" төслийн наадамд бөх, шагайн харваанд медаль, мөнгөн шагнал өгөөд сурын харваачдад дан мөнгөн шагнал өгдөг нь үндэсний спортын нэг төрлийг ялгаварласан мэт сэтгэгдэл төрүүлнэ.

-"Оюу толгой" төслийн наадмын үндэсний сур ба шагайн харваанд оролцогчдын ихэнхи монгол хувцсаа өмсөхгүй, тэр бүү хэл богино өмдтэй байгаа ноцтой алдаа дутагдал байгааг залруулан заавал монгол дээл, хувцастай байвал оролцуулах шаардлага тавьдаг болох хэрэгтэй нь харагдлаа. Үндэсний хувцас өмсөх нь зарим хүний нүдэнд наанаа хэлбэр мэт харагдаж болох талтай боловч өнөө цагт үндэсний уламжлалт наадмыг утга учиртай болгож буй, наадмын нэгэн салшгүй эд хэсэг нь болж байгаа билээ.

-Үндэсний сурын харвааны тэмцээнийг аль болох бүрэн гүйцэд явуулж байх саналыг тавьж байна. Учир нь энэ наадамд хана харвааны 20 сум, хасаа харвааны 20 сумаас ердөө хана харвaанд 8 сум тавьсан нь арай цөөн байна. Бүр болохгүй их цаг авдаг гэж үзэж байгаа бол хана харваанд 20 сумыг гүйцэд харвуулж болох юм. Үүний тулд дээр өгүүлсэн санал ёсоор "Оюу толгой" төсөл өөрийн гэсэн нум, сумыг захиалан хийлгэж болох талтай.

-Монголын уламжлалт "Эрийн гурван наадам" гэдэг ойлголт шагайн харваа наадмын хөтөлбөрт орох болсон болон эмэгтэйчүүд нум сум харвах болсноор өөрчлөгдөж, Өмнөговь аймгийн наадам 4 төрлөөр, "Оюу толгой" төслийн наадам 3 гурван төрлөөр, эмэгтэйчүүд оролцсон "эрийн" бус "жирийн наадам" болсон байна.

-Өмнөговь аймгийн наадмын төсөв зардлын ихэнхи хэсэг аймгийн төсвөөс гарч байгаа бол соёлын бусад арга хэмжээг (Үдшийн цэнгүүн-VII.9), ("Миний нутгийн дуун" хүндэтгэлийн концерт-VII.10) "Тавантолгой" компани ивээн тэтгэж явуулав. "Оюу толгой" төсөл өөрийн наадмын зардлыг бүрэн дааж гаргасан бөгөөд наадамчин олны тав тухыг хангах бүх төрлийн үйлчилгээг (хүн суух олон асар, майхан, амралтын гэр, цэвэр ус, айраг, боловсон жорлон, олон төрлийн хоол унд, хогийн сав, цэвэрлэгээ гэх мэт) маш сайн зохион байгуулж, Улаанбаатар хотоос тусгайлан "Модерн номадс" рестораныг хүртэл авчирсан байна. Архигүй наадам нь бусад сум, аймгийн наадамд үлгэр болохуйц байна. Дараа жилээс соёлын бичил арга хэмжээ, зарим нэг урлагийн тоглолт хийдэг бол наадам илүү сайн, чанартай, сонирхолтой болох талтайг цаашид анхаарах буй за.

-"Оюу толгой" төслийн наадам Ханбогд сумынхны, тэр дотроо хүүхдүүдийн хүсэн хүлээдэг баяр наадам болох нь тэдний олноороо ирсэн байдал болон яриа, сэтгэгдлээс харагдаж байна. Хэрэв энэ наадам дараа жил дахин болно гэвэл хүүхдүүдийн дунд хөгжөөнт тоглоом, уралдаан тэмцээн, сумын хүүхдийн бөхийн барилдаан зэргийг зохиовол дан ганц хоол унд идэж уух гэж ирдэг хүслийг нь арай өөр утга учиртай болгох юм.

-"Оюу толгой" төсөл хэрэгжихээс өмнөх наадмын үеийн зуншлагын байдал өнөө цагт "Оюу толгой" төслийн үйл ажиллагаанаас болж өөрчлөгдөөгүй байна. Харин энэ нь байгаль, цаг уурын байдлаас хамааралтай байгаа нь өвөл хатуу болсон хэдий ч зун эрт бороо орсноор зуншлага харьцангуй сайн байгаагаас харагдаж байна.

-Улсын баяр наадмаар үндэсний хувцсаа өмсөх явдал Өмнөговь аймагт ч (300 хүний дунд 49 хүн монгол дээл, цамц өмссөн), "Оюу толгой" төслийн наадамд ч тун бага байв. "Оюу толгой" төслийн ажилтан, ажилчдын дотор монгол хувцастай хүн тун (цөөн бүсгүйчүүд гоёлын дээл өмссөн) бага байсан бол гадаадын мэргэжилтнүүд олноор монгол цамц өмссөн байсан нь монголчууд бидэнд нэгийг бодох хэрэгтэйг харуулж байна.

-Наадам тарсны дараа олон наадамчид Ханбогд хайрханы Баяжихын агуй, Эхийн умай, Дэмчигийн хийд зэрэг шүтлэгт газруудад очихдоо их хэмжээний архи, усны сав, хоол ундны үлдэгдэл хаяж шүтэж дээдэлдэг газраа бохирдуулдаг нь бусад аймаг, суманд төдий л нийтлэг байдаггүй муу үйлдэл юм. Тэдгээр газруудыг тогтмол цэвэрлэж байх, тэнд хог хаяхыг хориглосон, энэ нь байгалиа бузарлаж байгаа жинхэнэ нүгэл болохыг бичсэн ухуулах самбарууд хийж босговол зүйтэй байна.

Өмнөговь аймгийн болон "Оюу толгой" төслийн наадам (хурдан морины уралдаан байхгүйг эс тооцвол) ерөнхийдөө уламжлалт баяр наадмын хэв шинжийг харуулсан монгол наадам хэвээр байна. Цаашид анхаарах зүйл цөөнгүй буйг дээр өгүүлснийг анхаарах буй за.

Тайлан бичсэн, доктор, профессор Ж.Гэрэлбадрах

## ХАВСРАЛТ

Хүмүүсээс авсан ярилцлага–бичлэг

Өмнөговь аймгийн Уяачдын холбооны нарийн бичгийн дарга, ЗХ-ний 167-р ангийн офицер Цогбадрах

Сайхан наадаж байна. Уяачдын хувьд урьд өдөр нь бороо орчихсон чийгэн дээр морьдын давхил сайн байна. Энэ жилийн наадмын хувьд зохион байгуулалт сайжирсан. Энэ жил уяачдын холбоо санаачлаад аймагтаа морь гарааны төхөөрөмжийг сайжруулсан. Улсын баяр наадамд хэрэглэдэг төхөөрөмжтэй адилхан. Өмнөх жилүүдэд туршилтын маягаар 2 жил хэрэглэсэн. Морин уралдаан хэрүүл шуугиангүй сайхан болж байна. Уяачдын хувьд адууны хурдыг сайжруулах талаар нилээн идэвхи санаачлага гаргаж байгаа. Бизнесмен Бардуузын Батаа гэх мэт хүмүүс. Говийн хурдыг шилмэл байдлаар гаргах үүднээс манай нутгийн бизнесмен залуучууд оролцож байгаа. Таван толгой компаны гүйцэтгэх захирал нь Уяачдын холбооны тэргүүн хийдэг. Говь Шанхын хурд ирэх жил зохион байгуулагдана. Сүүлийн үед хурдан морьд өвөл, зунгүй тэжээлийн байдалд орсон.

Өмнөговь аймгийн Хүрмэн сумын харьяат аймгийн заан Чинзориг

Сайхан наадаж байна. Улаанбаатар хотод бэлтгэл сургуулилтаа хийдэг залуучууд, улсын цолтой бөхчүүд хотод бэлтгэлд гарсан. 10 хэдэн сая төгрөгөөр ивээн тэтгэж сар бэлтгэл хийсэн. Аймгийн цолтой бөхчүүд, залуучууд "Айраг"-ийн амралтанд бэлтгэлд гаргасан. Аймгийн засаг дарга, бөхийн холбооны тэргүүн Бадраа ивээн тэтгэж зардал мөнгийг нь дааж бэлтгэлд гаргасан. Таван толгой, Оюу толгой наадам хийлээ гээд очиж барилдахад бай шагналын хувьд муу хувь хүн наадам хийхээс доогуур өгдөг. Холоос зорьж очиход 100-гаад мянган төгрөг өгдөг тэр нь тэгээд шатахуундаа тааraад дуусдаг. Очсон зардлаа бараг олж чаддаггүй. Ер нь бөхчүүдийг, спортыг үнэлэх үнэлэмж муу. Гурвантэс сумынхан Тавантолгойн наадамд очиж барилдлаа гэхэд зардлаа ч нөхөж чаддаггүй. Төрийн (аймгийн) тахилгатай наадам боллоо гэхэд түрүү бөхөд 20000 төгрөг нэг хүний өдрийн хоолны мөнгө л өгдөг. Манай аймаг "Ажнай" гэдэг бөхийн дэвжээтэй болсон. Манай аймгийн бөхчүүд жил ирэх тусам сайжирч аль ч аймгийн бөхчүүдтэй барилдахад бэлэн болсон. Бөхчүүдийг ивээн тэтгэхэд Таван толгой, Ажнай компаниуд нилээн зүтгэл гаргадаг.

Даланзадгад сумын иргэн шагай харваач Яринпэл

Энэ жилийн наадам сайхан болж байна. Манай баг 1 хожоод 2 хожигдсон. Энэ жилийн наадмын онцлог нь гаднаас олон бөх ирж байна. Бороо ногоо тэгширсэн сайхан зун болж байна. Аймгийн наадам 9,10-нд болж байгаа нь морь, бөхөө улсын наадамд явуулах гэж ингэсэн болов уу. Цөөхөн жил ингэж хийсэн. Ноднингийн наадам 9,10-нд болсон. Шагайн харвaанд нийт 6 баг оролцож байгаа. Ноднин 9 баг оролцсон. Уламжлалын дагуу явж байгаа нь мэдэгдсэн юм алга. Би 20 жил шагай харваж байна. Бай шагналын хувьд урьд жилүүдийнхтэй адилхан. Алт, мөнгө, хүрэл медаль, 200000 төгрөг. Аймгийн наадамд 4 дэх жилдээ харваж байна. Энд тэнд хөдөө сумдаар явж харвадаг. Зарим жил улсын наадамд явж харвадаг. Мужаан хийж байсан. Одоо тэтгэвэртээ гарсан.

Ханбогд сумын Жавхлант багийн малчин Мөнхөө

Зуншлага сайхан байна. Оюу толгой төслийн наадмыг 3 дахь жилдээ үзэж байна. Наадам болж буй газрыг Оорцогийн хөндийн хойд цохио гэж нэрлэдэг байсан. Аман усны баруун хойд цохио. Манайх энэ нутгаар нутагладаг байсан. Сайхан наадам болж байна. Морь л алга. Аймгийн наадамтай зэрэгцсэн болохоор морь байхгүй байгаа байх. Оюу толгой төсөл эхэлснээс хойш тоос шороо ихэссэн. Нүүрсний замаас болоод. Бусад талаар гайгүй. Оюу толгой төслийн зүгээс Жавхлант багийн малчдад тусламж үзүүлж байгаагүй.

Өмнөговь аймгийн Ханбогд сумын Гавилууд багийн засаг дарга Улам-Ундрах Нутгаасаа гараад 30 гаруй жилийн дараа нутагтаа ирлээ. Оюу толгойн наадмыг анх удаа үзэж байна. Урьд нь бэсрэг наадмуудыг үзэж л байсан. Оюу толгойн наадам бол том наадам тэгэхдээ сумын наадмыг бодвол өвөрмөц онцлогтой наадам гэж хэлж болох байх. Нутагт маань бороо хур их оройхон ордог болсон байна. Гандуу байдаг болсон байна. Арга ч үгүй байх. 30 жил гэдэг бол их хугацаа, дэлхийн цаг уурын дулааралтай холбоотой халуун болчихсон байна, хур тунадас унахаа больчихсон байна. Цөлжилт ихээхэн нэмэгдсэн, ард түмний хөл хөдөлгөөн ихээхэн нэмэгдсэн байна. Шинжлэх ухаан, техник технологийн дэвшил ихээр орж ирсэн байна. Ингээд үзэхээр Ханбогд сум хөгжлийнхөө ид үед тулж ирсэн байна. Цаашид үсрэнгүй хөгжил ойрхон байна. Галт тэрэг нэгэнт хөдөлчихжээ гэж хэлж болохоор байна. Миний хувьд хилийн цэрэгт 30 гаруй жил алба хаасан. Өмнөговь, Замын-Үүд, Улаанбаатар, Увс зэрэг газруудад алба хаасан. Хамгийн сүүлд Увс аймгийн Баруунтуруун суманд хилийн хулгайг зогсоох зорилгоор байгуулсан хилийн заставыг байгуулалцаж 2 жил ажилласан. Оюу толгой төслийн зүгээс сум орон нутагт эмнэлэг барьж өгсөн, шүдний иж бүрэн кабинет, багийн засаг дарга нарт иж бүрэн компьютер, эмнэлгийн машин, хүүхдийн сургалтын төлбөрийг нь хариуцдаг. Дэмчигийн хийдийг сэргээсэн гэх мэтийн тусламж дэмжлэгийг үзүүлсэн. Тусламж дэмжлэг гэхээсээ Хүнну, Сүннүгийн үеэс малаа адуулж хариулж ирсэн том мал аж ахуй, том уул уурхай хоёр хэрхэн зэрэгцэн орших вэ гэдгийг шийдвэрлэх хэрэгтэй болсон. Энэ нь ойр зуурын ганц машинаар туслах, эмнэлэг барих асуудал биш юм. Цоо шинэ юм хэрэгтэй. Манай Монгол улсад мал аж ахуй XIII зуунаас тэрнээс ч өмнө тэргүүлэх салбар байсан. Өнөөдөр ч хэвээрээ байна. ДНБ-ийн 80 гаруй хувийг үйлдвэрлэдэг хэвээрээ. Манай түүхий эдийг дангаараа гаргадаг том салбар бол энэ. Дэлхийн хэмжээнд экологийн цэвэр бүтээгдэхүүн гаргадагаараа бэлчээрийн мал аж ахуй ганцхан Монголд байгаа. Энийгээ яаж авч гарах вэ? яаж энэ том уул уурхайтай зэрэгцэн орших вэ? гэдгийг ярих цаг нэгэнт болсон. Энэ дээр төрөөс малчдын талаар баримтлах бодлого, "Монгол мал" хөтөлбөр гэх мэтийн томоохон төсөл хөтөлбөрүүд явагдаж байгаа боловч говь нутагт бий болж байгаа энэ томоохон уул уурхайн талаар хараахан дурьдагдахгүй байна. Швейцарын хөгжлийн агентлаг гэх мэтийн томоохон төсөл хөтөлбөрүүдээс хот орчмын төсөл нь том хотуудын хот орчмын бэлчээрийг цөөлөөд, тэндэхийн малчдын бүлэг, фермерүүдийг байгуулаад явж байна. Эрдэнэт 1970 хэдэн онд байгуулагдсан үндсэндээ 40 орчим жил болж байна. Өнөөдөр Эрдэнэтийг тойрсон асуудал ерөөсөө шийдэгдээгүй. Мал аж ахуйн асуудал, тоосжилт, уул уурхай бол хотоос өөр тэр асуудал шийдэгдээгүй явсаар 40 жил болчихсон байна. Гэтэл дахиад 2 том уул уурхай нээгдэж байна. Таван толгой, Оюу толгой. Эдгээр асуудлыг хамт нэн даруй зэрэгцүүлэн авч явахгүй бол болохгүй. Нэг хүн хохироод ч юм уу, нэг хэсэг мал хохирсны дараагаар ингэхгүй бол болохгүй нь гэж манай монголчууд ярьдаг. Юмны дандаа хойно хөдөлж эхэлдэг. Зэрэгцүүлэн авч явах шаардлагатай гэж үзэж байна. Наадам маань урьд урьд жилүүдийг бодвол илүү өргөн дэлгэр болж байна гэж хэлж болно. 18 орны орны хүмүүс бужигнаж байна. Урьд нь Канад, Америк, Австрали, Хятад гэх мэтийн цөөхөн орны хүмүүс ирдэг байсан. Мөн 21 аймгийн хүмүүс наадаж байна. Урьд Ханбогдын хүмүүс наадаг байсан байх өнөөдөр 21 аймгийн хүмүүс наадаж байна. Сумын наадамтай жиших ч арга

алга, аймгийн наадамтай жиших ч арга алга том наадмаа гэж хэлж болно. Энэ жил зуншлага маш сайхан болж байна. Өвөл маш хахир хатуу болсон хүйтний эрч 12-р сарын 19-ний өдрөөс эхэлж чангарсан. Мал зудын байдалтай маш удаан байсан. Олон мал хорогдсон. Харин зуд зулагтай гэж ярьдаг. Хавар эрт цаг сайжирсан, 4 сар гээд бороо ороод, 4, 5 сард маш сайхан бороо орсон, малын үхэл зогссон. Хүн малын зоо тэнийж үлдсэн нь сайхан таргалж ноос, ноолуурын үнэ өссөн. Ханбогдод тэмээ, ямааны аж ахуй голлон эрхэлдэг. Улаанбаатарт өмнөх жил 19000 төгрөг байсан бол энэ жил 57000 төгрөг хүрсэн. Гэхдээ манай Өмнөговьт ноолуур 57000 төгрөг хүрээгүй хамгийн дээд тал нь 47000 төгрөг хүрсэн. Тэмээний ноос  6200 төгрөг хүрсэн. Хонины ноос урьд нь 100 төгрөг байдаг байсан бол энэ жил 400 төгрөг хүрсэн. Ямар ч байсан малаас гарах түүхий эдийн үнэ өссөн. Энэ нь байгаль цаг уур дэлхийн хүнд өгөөж баялагаа өгөхийн зэрэгцээ, мал аж ахуй сэргээд, үлдсэнд нь сайхан хандсан. Байгаль цаг уур ингэж сайхан болсон нь үүлэнд зориудаар нөлөөлж бороо оруулсан л байх, нутгийн ард түмэн уул овоогоо тайж тахьсан. Энэ нь нэг талын байгаль хамгаалалын том уламжлал. Ийм ийм хүчин зүйлээс болж сайхан зун болж байна. Одоохондоо бороо жаахан тасарчихаад байна. Нар  буцаж байна, наадам өнгөрч байна одоо бороо орох байх.

Ханбогд сумын Ханбогд бөхийн дэвжээний дасгалжуулагч, аймгийн начин Эрхэмбат

Сайхан наадаж байна. Оюу толгойн наадам энэ жил тав дах удаагаа зохион байгуулагдаж байна. Энэ жилийн наадамд аймгийн төв, хөдөө сумдаас маш олон цолтой бөх ирж барилдсанаараа онцлог бөхчүүд 10.00 цагаас бүртгэл явагдаад дуусcанаас хойш маш олон цолтой бөхчүүд, Ханбогд сумын бөхчүүд хоцорч ирсэнээс болж барилдаж чадаагүй. Түрүү жилүүдийн барилдаанд түрүү, үзүүр, их шөвөгт үлдсэн бөхчүүдэд 120000, 100000, 80000 төгрөгийн шагнал өгдөг байсан. Энэ жилийн барилдаанд яаж өгч байгааг мэдэхгүй байна.

Хасу мегавит компаний ХХАА-ны ажилтан Баатарцогт

Би Оюу толгой төслийн наадмыг 4 жил зохион байгуулж байна. Энэ жилийн наадмын онцлог бол урьд жил гэрээ батлагдаагүй гээд хүн цөөхөн цомхон наадам болдог байсан. Энэ жил гэрээ батлагдсан. Төсөл өргөжсөн олон хүнтэй өргөн дэлгэр наадам болж байна. Урьд жилүүдийг бодвол бай шагналын хувьд өссөн. Бүх хүндээ хүртээмжтэй шагналыг олгосон. Оюу толгой төсөл наадмын бүх зардалыг дааж, зохион байгуулж орон нутгийн иргэдийг хамтад нь баярлуулдаг.

Ханбогд сумын сурын холбооны тэргүүн Жаргал

Нар хур тэгширсэн сайхан наадам болж байна. Эрэгтэй-35, эмэгтэй-8 харваач оролцсон. Харваачдын оноо мэргэн байна. Урьд жилийнхээс олон хүн оролцлоо. Зохион байгуулалт сайн байна.  Гадаад хүмүүс харваж байна.

Оюу толгой төслийн ажилчин Ганцоож

Энэ жилийн наадам сайхан болж байна. Зуншлага сайхан байна. Багийн харвaанд багаараа 2-р байранд орсон. Хувийн цуваа харваанд 1-р байранд орсон. Аймгийн гоц мэргэн цолтой. Тасралтгүй 5 удаа түрүүлсэн.

Ханбогд сумын дунд сургуулийн 7-р ангийн сурагч Ганбадрах

Сайхан наадам болж байна. 3 дахь жилдээ үзэж байгаа. Хүн, машин 2 их байна. Идэж, уух юм гайгүй байна. Ноднин бас гайгүй байсан. Манай ах дараа жил наадам болохгүй гэж хэлсэн.

Ханбогд сумын зарим хүмүүс хэрхэн баяжсан бэ ?

"Оюу толгой"  орд газар нээгдсэнээс хойш Ханбогд сумын иргэдийн амьдрал эрс  сайжирч айл болгон 2 давхар байшинтай, машинтай болсон гэж бид ойлгож байдаг. Энэ нь багагүй нөлөөтэй байгаа боловч сумын хэсэг хүмүүс алттай газрын шороо ухаж баяжсан ажээ.

Баяндалай сумын харьяат сумын заан Г.Энхтайваны ярьснаар бол, сумын иргэд сумын төвөөс урагш орших “Ирак толгой” гэдэг газар зөвшөөрөлгүйгээр алт ухаж, гаргасан шороо чулуугаа мөнгөн ус, цианит натриар бариулж алтаа зардаг байсан. Алт зарж олсон мөнгөөрөө амьдралаа сайжруулж, давхар тоосгон байшин барьж, жийп машин авч унах болсон. Тэдгээр хүмүүсийн ухсан алттай газар гэхэд л газар доор чиргүүлтэй машин эргэхээр асар том хонгил үүсгэсэн байсан гэнэ. Мөн ингэж ухахдаа тэсрэх бодис хүртэл ашигладаг байсан ба ухсан нүхэндээ дарагдаж амь насаа алдах, бэртэж гэмтэх үзэгдэл гарч байжээ. Сүүлд нь мэргэжлийн хяналт, цагдаагаас хүмүүс ирж тэр газрыг дэлбэлж нураагаад булсан. Түүнээс хойш харин сумынхан Оюу толгой нөлөөгөөр олонхи нт ажилтай болж, үйлчилгээ үзүүлж тэр хэрээр амьдрал нь сайжирч байгаа нь үнэн юм хэмээн өгүүлэв.

Гэсэр гэлэнгийн хул морины домог

Одоогийн Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг Их Шанх уул, Ширээгийн усаар нутагтай Гэсэр гэлэн гэж хурдан хул морьтой хүн байжээ. Гэсэр гэлэн хул морио унаад Их Хүрээнд очих гэж нутгаасаа орой гараад өглөө гэхэд Туул голын хөвөөнд хүрдэг байжээ. Гэтэл нэгэн удаа хул морио шилийн хулгайчид алджээ. Хул морь Ширээгийн уснаас өөр ус уудаггүй тул миний морь заавал гүйж ирнэ. Гүйж ирэхдээ ихэд цангах тул гэнэт ус уугаад үхэж магадгүй худгийн онгоцондоо ус битгий үлдээж байгаарай гэж нутгийхандаа захижээ. Гэтэл нэгэн бадарчин Ширээгийн усанд үдлээд цай чанаж ууж байтал гэдсээ татсан нэгэн сайхан морь ирэхэд нь усалжээ. Ингээд хул морь гэнэт их ус уугаад босоогоороо үхсэн байна. Тэрнээс хойш энэ нутгийхан “бадарчин явсан газар балагтай, батгана суусан газар өттэй” гэж ярьдаг болжээ.

## 22. ХАВСРАЛТ 13. ОЛОН НИЙТИЙН ХӨТӨЛБӨРИЙН ХЭЭРИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН

"Соёлын өвийн хөтөлбөр"-ийн Олон нийтийн хөтөлбөрийн судалгааны багаас Өмнөговь аймагт хийсэн судалгааны ажлын тайлан

2010.12.4 Улаанбаатар хот

Судалгааны зорилго: Өмнөговь аймгийн Засаг даргын тамгын газрын Боловсрол Соёлын газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газруудын үйл ажиллагаа, Ханбогд суманд болох "Мянган ботгоны баяр"-ыг үзэж танилцах, Баян-Овоо, Ханбогд, Манлай сумдын сургуулийн захирал, багш нартай уулзаж, "Соёлын өвийн хөтөлбөр"-ийн олон нийтийн хөтөлбөрийн талаар санал бодлоо солилцож, дүгнэлт гаргалгаа хийхэд судалгааны зорилго оршино.

Судалгааны багийн бүрэлдэхүүн: "Оюу толгой" төслийн "Соёлын өвийн хөтөлбөр"-ийн судалгааны багийн "Олон нийтийн хөтөлбөр"-ийн судлаач доктор, профессор Ж.Гэрэлбадрах, төслийн туслах ажилтан Ш.Эрдэнэбат, Тоёота Ланд Круйзер машины жолооч Т.Болдбаатар нар оролцон ажиллав.



Судалгааны ажлын хугацаа: Энэхүү судалгааны эхний үе буюу хээрийн судалгааг 2010 оны 11-р сарын 21-нээс 11-р сарын 28-ны өдөр хүртэл 8 хоногийн хугацаатай Өмнөговь аймгийн нутагт явуулав. Судалгааны хоёрдахь үе болох баримт сэлтийг боловсруулж тайлан бичих ажил Улаанбаатар хотод 11-р сарын 29-нөөс 12-р сарын 5-ны хооронд явагдав.

Ажлын уулзалт:

2010 оны 11-р сарын 22-нд Боловсрол, Соёлын газрын даргын үүрэг гүйцэтгэгч Ч.Буянчуулган, соёлын мэргэжилтэн О.Уламцэцэг нартай уулзаж, тус газрын бүтэц, үйл ажиллагаа болон Соёлын өвийг хадгалах, хамгаалах, сурталчлах талаар ямар бодлого явуулж буй, "Оюу толгой" төслөөс хэрэгжүүлэх "Соёлын өвийн хөтөлбөр"-т ямар санаа оноо тусгуулах саналтай байгааг асууж ярилцав.

Тэдний санал гэхүл, БСГазарт ганц соёлын мэргэжилтэн, 13 боловсролын мэргэжилтэнтэй. Бүх зүйл боловсрол руу чиглээд соёл орхигдох сөрөг талтай байгаа. Иймд Боловсрол, Соёлын газрын дэргэд "Соёлын өвийн сургалт, сурталчилгааны танхим" байгуулбал их сайн байна. Уг танхимд соёлын сургалт сурталчилгаа, хурал зөвлөлгөөнөө хийдэг байх юм. Энэ талаар улс, аймгийн төсвөөс хөрөнгө гаргах боломж муу байгаа тул "Оюу толгой" төслөөс үүнд тодорхой хөрөнгө зардал гаргаж шийдэж өгвөл тун сайн байна.

"Соёлын өвийн төв"-өөс ирүүлсэн зааврын дагуу аймгийн Засаг даргын газрын дэргэд "Соёлын өвийг хамгаалах салбар зөвлөл" байгуулж, тэргүүн нь Боловсрол, соёлын газрын дарга байх ёстой. Гэтэл Өмнөговь аймагт энэ зөвлөлийг ёс журмын дагуу бус, харин БСГ-ын дэргэд 9 хүнтэй байгуулж, тэргүүнээр нь соёл хариуцсан мэргэжилтэн ажиллаж байна. Энэ байдлыг засах хэрэгтэй байгаа ажээ.

Өмнөговь аймгийн "Алтан говь", "21-р суваг" телевизүүдээр урьд өмнө БСГ-аас эрхлэн сард нэг удаа явуулж байсан "Түүхэн өв соёл" нэвтрүүлгийг сэргээн үргэлжлүүлэхэд "Оюу толгой" төслөөс тодорхой дэмжлэг үзүүлэхийг хүсч болох юм. Соёлын өвийн талаарх сургалтыг сумдын Соёлын төвийн ажилтнуудад зориулан жил бүр тогтмол хийж байх саналыг "Оюу толгой" төсөлд тавьбал зүгээр байна.

Монгол улсад хэрэгжиж буй "Морин хуур, уртын дуу" үндэсний хөтөлбөр, "Монгол хөөмийн үндэсний хөтөлбөр", "Үндэсний соёлын өвийн мэдээллийг тоон системд оруулах, хадгалах хөтөлбөр", "Түүх соёл үл хөдлөх дурсгалыг хамгаалах, сэргээн засварлах үндэсний үндэсний хөтөлбөр"-үүдийн зорилтуудтай уялдуулан Өмнөговь аймаг дахь хэрэгжилтэд нь уул уурхайн компаниудын дэмжлэг их хэрэгцээтэй байна. Учир уг үндэсний хөтөлбөрүүдэд хөрөнгө санхүүгүй байдаг тул аймаг, сумын төсвийн хөрөнгөнөөс илүүчлэн арга хэмжээ зохион явуулах боломж хомс байдагт оршдог юм.

Даланзадгад сумын 1-р бүрэн дунд сургууль дээр очиж захирал Д.Оюунчулуунтай уулзаж, Олон нийтийн хөтөлбөрийн талаар түүнтэй санал солилцов. Тус сургууль дээр хэрэгжүүлж буй "Хүн болох багаасаа" гэдэг хөтөлбөрт нутгийнхаа түүх, соёлын дурсгалыг танин мэдэх, түүнийг хайрлан хамгаалах талаар тусгаж байгаа ажээ. Тэрбээр аймгийн орон нутаг судлах музейд сургуулийн сурагчдын түүхийн ба газарзүйн зарим хичээлийг зааж байх тусгай хөтөлбөр боловсруулах нь чухал хэмээн үзэж байна. Сургуулийн сурагчдын дунд үндэсний спортын (сур харваа, бөх, шагайн харваа) төрлийг хөгжүүлэх секц дугуйлангуудыг олноор байгуулах нь зүйтэй хэмээж байв.

Өмнөговь аймгийн сумын сургууль бүрд газарзүй ба түүхийн кабинетийг сайтар тохижуулах ажлыг Соёлын өвийн хөтөлбөрт багтаах нь зөв гэсэн түүний санал их зөв санагдав. Учир нь газарзүйн кабинетэд тухайн сумын байгаль орчин, эрдэс баялаг, өвс, ургамал, ан амьтан зэрэг зүйлсийг бүрэн багтаах бол түүхийн кабинетэд сумын нутагт буй биет өв–палеонтологийн, түүхийн, соёлын, шашны дурсгалт газрууд, биет бус өв болох ардын ёс заншил, мал аж ахуйн эд зүйл, тоног төхөөрөмж, дуу хөгжим, тоглоом наадгай зэргийг тусгана. Энэ хоёр кабинетээр дамжуулан сурагчид говь нутгийнхаа Соёлын өвийн талаар тодорхой мэдлэгтэй болж, түүнийг хайрлан хамгаалах сэтгэлгээ суулгахад чухал ач тустай хэмээн бодож байна. Мөн Өмнөговь аймгийн сумын сургуулиудад "Ёс заншлын өргөө" байгуулан ажиллуулж байвал залуу үеийнхэнд уламжлалт биет бус өвийг зохих хэмжээгээр хадгалах үлдэхэд багагүй тустай юм.

Даланзадгад сумын байгаль, нийгмийн ухааны гүнзгийрүүлсэн сургалттай 3-р бүрэн дунд сургуульд очиж, сургалтын менежер Л.Энх-Өнөртэй "Олон нийтийн хөтөлбөр"-ийн талаар ярилцав. Түүний хүсэлт бол 1-11 ангиудад бүтэн жилийн турш ордог "Иргэний боловсрол" хичээлд юу заах ерөнхий зөвлөмж ирдэг, агуулга нь тодорхой бус байдаг. Тиймээс уг хичээлээр ямар сэдэв орох талаар бага, дунд, ахлах анги гэсэн 3 шатлалтай хөтөлбөрийг сургууль бүр өөрсдөө боловсруулаад ордог. Тус сургуульд энэ хичээлийн зарим цагт Соёлын өвийн талаар ордог байна. БСШУЯ-аас "Иргэний боловсрол" хичээлийн агуулгыг тодорхой болгосон шийдвэр гаргахгүй бол сургууль бүр өөр өөрөөр ордог тул Соёлын өвийн талаар хичээл орох нь газар бүр алдаг оног байж болох талтай. Энэ байдлыг удаалгүйгээр даруй жигдлэх хэрэгтэй ажээ.

Өмнөговь аймгийн Байгаль орчин, Аялал жуулчлалын газрын дарга О.Бадарч, мэргэжилтэн Н.Бурмаа нартай уулзаж тус газрын бодлого, үйл ажиллагаа, аймгийн аялал жуулчлалын өнөөгийн байдлын талаар санал бодлоо солилцов. Тус газар сумдын байгаль хамгаалагчдаа оруулаад нийт 23 хүнтэй ажээ. Өмнөговь аймаг бусад аймгуудыг бодвол харьцангуй эрт буюу 1963 оноос эхлэн аялал жуулчлал, жуулчны баазын үйл ажиллагаа явуулж иржээ. Өмнөговь аймагт аялал жуулчлалыг хөгжүүлэх "Мастер төлөвлөгөө 2007-2021" боловсруулсан байна. Аймгийн хэмжээнд 2008 онд 23 жуулчны бааз, 2009 онд 22 жуулчны бааз, 2010 онд 19 жуулчны бааз үйл ажиллагаагаа явуулжээ. 2009 онд францчууд хамгийн ихээр ирсэн ба мөн говьд Итали жуулчид ихээр ирдэг байна.

2010 онд зочид буудал, жуулчны баазын зэрэглэл тогтооход тус аймгийн жуулчны баазууд хоол, ариун цэврийн өрөө, халуун усны үйлчилгээгээр бусад аймгийн жуулчны баазуудаас илүү гэдэг үнэлгээ авсан. Мөн жуулчны баазуудад 1, 2-р цэцгийн зэрэглэл тогтоожээ. Аймгийн аялал жуулчлалын газрын зураг хэвлүүлжээ. Мөн улсын хилийн дагуу аялал жуулчлал зохион байгуулахаар хилийн албаны хүмүүстэй тохирч, "Тооройн аялал", "Адал явдалт аялал" зэрэг зүйлийг зохион байгуулахаар болсон ба энэ нь судалгааны шатандаа явж байгаа юм байна.

Өмнөговь аймгийг аялал жуулчлалын хэдэн бүсэд хуваажээ. Төв, зүүн, баруун гэсэн төвийн бүсээ 1, 2-р бүс гэж хуваасан. Зүүн бүсэд Манлай, Ханбогд, Цогтцэций сум орох ба уг бүсэд уул уурхайг хөгжүүлнэ. Төвийн бүсэд Булган, Хүрмэн, Ханхонгор, Баяндалай, Номгон, Мандал-Овоо, Цогтцэций, Цогт-Овоо сумдыг оруулсан бөгөөд аялал жуулчлалыг хөгжүүлнэ. Баруун бүсэд Ноён, Сэврэй, Гурвантэс сум оржээ. Эл бүсэд аялал жуулчлал, уул уурхайг хөгжүүлнэ гэж "Мастер төлөвлөгөө"-нд тусгаад байгаа ажээ.

Өмнөговь аймаг байгаль, түүх соёлын дурсгалт 9 гайхамшгаа тодруулсан байна. Эдгээр нь

Гурван тэс сумын нутагт орших Хэрмэн цав, Зуун мод, Зулганай

Сэврэй сумын нутагт орших Хонгорын элс, Сэврэй хайрхан, Чоно шургуул

Ноён сумын нутагт орших Ноён богд хайрхан, Толь хад, Саран хөндий




Булган сумын нутагт орших Баянзаг, Төгрөгийн ширээ, Торгоны зам

Ханхонгор сумын нутагт орших Ёлын ам, Мухар шивэрт, Дүнгэнээгийн ам, Тосонгийн ам, Шатын ам

Мандал-Овоо сумын нутагт орших Алгуй улаан цав

Номгон сумын нутагт орших Сангийн далайн хийд

Манлай, Ханбогд сумдын нутагт орших Үлэг гүрвэлийн мөр, Дэмчигийн хийд, Галбын говь

Ноён, Сэврэйн хийцийн мөнгөн эдлэл зэрэг юм.

Дээрхи газруудын олонхи нь байгалийн дурсгалт газрууд байх бөгөөд түүх, соёлын дурсгалт газруудыг цөөн оруулсан нь өрөөсгөл болжээ. Гэхдээ дан ганц байгалийн аялал жуулчлалыг барих нь учир дутагдалтай. Уламжлалт байгалийн аялал жуулчлал дээр нэмэн өөр шинэ төрлийг бий болгох хэрэгтэй юм.

Өмнөговь аймгийн аялал жуулчлалын нөгөө нэг бүтээгдэхүүн бол палеонтологийн дурсгал юм. Аймгийн ИТХ-аас санаачлан Булган сумын нутагт буй Баянзагийн хажууд "Үлэг гүрвэлийн парк", "Палентлогийн эрдэм шинжилгээний хүрээлэн" байгуулах ажил хийх гэж буй тус газар дэмжиж бэлтгэл ажлаа эхлээд байгаа ажээ. "Говь тур" аялал жуулчны баазын захирал Д.Эрдэнэбаттай уулзаж "Үлэг гүрвэлийн парк"-гийн талаар саналыг нь сонсоход Баянзагийг үзэхээр ирсэн гадаадын жуулчдаас авсан санал асуулгаас харахад үүнийг сонирхох хүн гараагүй бөгөөд жуулчид арай өөр юм үзэх хүсэлтэй байгаа ажээ. Түүний оронд олдвор олдсон газруудыг ил музей болгох байдлаар жуулчдад үзүүлэх, тэнд хүн явж үзмэр үзэх зам болон явж болохгүй газрыг нарийн зааж тэмдэглэвэл зөв хэмээж байв.

2010 оны 11 сарын 23-ны өдөр Өмнөговь аймгийн Төв номын сангийн захирал Б.Батсаруул, ажилтан А.Одончимэг нартай уулзаж ярилцав. Тус номын сан 10 ажилтан, -хүүхдийн уншлагын танхим, -нийтийн уншлагын танхим, -гэрээр ном олгох танхим, -хөгжлийн мэдээлэл-сургалтын төв, -номын фонд гэсэн 5 нэгжтэй. 84000 орчим номоор ажлын 5 өдөр үйлчилдэг. Анх 1944 онд байгуулагдсан номын сангийн барилга одоо багадаж, номын фондын өрөө багтахаа больсон, номын тавиур хуучирсан тул нягтруулсан шүүгээ авах хэрэгтэй байгаа ажээ. Цаашдаа шинэ байр барих хэрэгтэй бөгөөд одоогоор энэ талаар аймгийн болон улсын төлөвлөгөөнд тусгасан, газар талбайгаа үзэж бэлдсэн юмгүй байна.

2000-2006 онуудад Соросын сангийн дэмжлэгтэйгээр Фургон машинтай “Явуулын номын




сан” ажиллуулж сумдад 7 хоногийн хугацаатай ажилладаг байсан нь их үр дүнтэй байсан. Одоо машин эвдрээд зогссон. Энэ ажлыг сэргээн зөвхөн сумдад бус, уул уурхайн хотхонуудад шинэ номоор үйлчлэх ажлыг хийхэд уул уурхайн компаниуд тус дэм үзүүлбэл сайн байна.



Өмнөговь аймгийн Хөгжимт жүжгийн театрын үйл ажиллагаатай танилцаж, дарга Д.Гомбосүрэнтэй ярилцав. Тус театр анх 1959 онд Соёлын ордон нэртэй байгуулагдсан бөгөөд нийт 52 ажилтантай. Хөгжмийн анги, дууны анги, бүжгийн анги, захиргаа аж ахуйн анги бүтцэд хуваагдана. Төлөвлөгөөт уран бүтээлийн зэрэгцээ улсын ба сум, байгууллага, компанийн ой, гадаад арга хэмжээ зэрэг тоглолт тасрахгүй явагддаг. Жилдээ бүх сумдад 1-2 удаа заавал тойрж тоглолт явуулдаг ажээ. Хүүхдэд зориулсан тусгай сургалт явуулдаггүй боловч жүжигчид морин хуур, бүжиг, төгөлдөр хуур, ёочин хөгжмийн шавь сургалт явуулж байна. Уламжлалт урлагийг дэмжих сурталчлах зорилгоор язгуур урлагийн “Ёл” хамтлагийг 8 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Монголын 16 угсаатны бүлгийн хувцас, хөгжмийн зэмсгийг хийж эхлээд байна.

Мөн уламжлалт соёлын өвийг сэргээх нэгэн чухал зүйлийг сэдэж эхлээд байгаа нь Номгон сумын нутагт, Сангийн далай хийдэд байсан Цам бүжгийн дэг сургуулийг сэргээх ажил юм. Тэр талаар 20 орчим сая төгрөгийн төсөл хийгээд “Оюу толгой” компанид санал тавиад байгаа. Цамын бүжгийн баг, хувцсыг сэргээх зураг, эскиз, макет зэргийг гаргаж, танилцуулга хийхэд бэлдэж байна. 2011 оны хавраас шинэ Даланзадгадын нутагт 5.1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр 1000 үзэгчийн багтаамжтай шинэ театрын барилгын ажил эхлүүлэхэд бэлэн болоод байна.

2010 оны 11-р сарын 23-нд Өмнөговь аймгийн музейн эрхлэгч Отгонтуяатай уулзаж ярилцав. Тус музей 9 ажилтантай. Музейн хэтийн төлөвлөгөөндөө тэмээ, ашигт малтмал, палеонтологи гэсэн үндсэн 3 зүйлээр үзмэрээ баяжуулахаар ажиллаж байна. Тус музей нь үндсэн музей, Тэмээний үзэсгэлэн, Ёлын аманд байрлах Байгалийн музей гэсэн гурван хэсгээс бүрддэг. Үндсэн музей нь палеонтологи, түүх, угсаатны зүй, шашин гэсэн үндсэн 4 танхим, 2500 орчим үзмэртэй. Музейн одоо байрлаж байгаа байр хуучирч муудсан тул 3 тэрбум төгрөгийн өртөгтэй шинэ байр бариулахаар зураг төслийг нь хийлгэж, газрын асуудлыг нь шийджээ.



Тэмээний үзэсгэлэнг энэ оны 10-р сарын 22-нд нээжээ. Зүүн Сайхан уулын Ёлын аман дахь Байгалийн музей нь амьтан, ургамлын төрөл зүйлийн үзмэртэй, жуулчид ихээр сонирхон үздэг газар юм. Хөдөө сумдад явуулын үзэсгэлэн зохион байгуулах боломжтой боловч төсөв зардал их гардагаас тэр болгон явж чаддаггүй байна. Жилд 4,5 сая төгрөгийн үзмэр худалдан авах төсөвтэй.

Түүний хэлсэн саналууд гэвэл, үзмэрийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, аялал жуулчлалын чиглэлийг музейтэй холбож, ирж буй жуулчдын хөтөлбөрт музейн үзмэрийг оруулж өгвөл илүү үр дүнтэй. Соёлын өвийн талаар музейн ажилтнуудад сургалт зохион байгуулах хэрэгтэй. Уул уурхайн компаниуд хайгуул ба ашиглалтын явцад илэрсэн олдворынхоо дээжээс орон нутгийн музейд өгч үзмэрийг нь баяжуулж байх. Сумдын музейтэй хамтран явуулын үзэсгэлэн зохион байгуулах ажлыг хийхэд уул уурхайн компаниуд тусламж үзүүлбэл сайн байна зэрэг юм.

2010 оны 11 сарын 24-ний өдөр Баян-Овоо суманд ажиллав. Сумын Соёлын төвийн үйл ажиллагаатай танилцаж, эрхлэгч Б.Жүрмэддоржтой Соёлын өвийн хөтөлбөрийн Олон нийтийн хөтөлбөрийн талаар санал солилцов. Тус Соёлын төв 250 хүн суух танхимтай бөгөөд эрхлэгч, бүжгийн багш, хөгжмийн багш, номын санч, тасалбар түгээгч (орон нутаг судлах кабинетээ давхар хариуцдаг) гэсэн 5 ажилтантай. Морин хуур, даралтат хөгжим, бүжиг, ерөөл магтаал, уртын дуу гэсэн 5 дугуйлан явуулдагт 36 хүүхэд суралцаж байна.

Түүний тавьж буй санал гэхүл, тус сумын хамгаалалтад биет соёлын өв 8 газар байгаа нь



бүгд түүх, соёлын дурсгалт газрууд байна. Биет бус соёлын өвийг тээгч 6 хүнийг бүртгээд байна. Тэдгээр хүмүүсийн дуулсан уртын дуу, хуурдсан ая аялгуу, хэлсэн ерөөл магтаалыг видео бичлэг хийх авах, биет бус өвийн гэрэл зураг, видео бичлэгийг үйлдэж, хувилан хадгалах ажил хийх шаардлагатай байгаа ажээ. Энэ ажлыг хийвэл тэдгээрийг Соёлын төвд хадгалж, сургалт дугуйланд хэрэглэх төдийгүй сумын сургуулийн сургалтад өргөн ашиглах бололцоо бүрдэх юм.

Сумын соёлын төв нь соёлын өвийн сургалт сурталчилгааны гол газрын нэг болох тул соёлын өвийн талаарх ном хэвлэл, дүрс бичлэг, үзүүлэн, сургалтын тараах ном гарын авлага, гэрэл зураг зэргийг мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор хийж, хэвлүүлэн хувилж тараадаг байвал Соёлын өвийг хамгаалахад их тустай ажил болно. Энэ ажлыг орон нутаг өөрөө хийх санхүүгийн болон мэргэжлийн чадвар дутагддаг билээ.

Баян-Овоо сумын Орон нутаг судлах музей дүнзэн байшинд байрлаж байгаад 2002 он галд өртөж шатснаар ихэнхи үзмэр нь үгүй болсон. Одоо байргүй тул Соёлын төвийн хувцас солих өрөөнд Орон нутаг судлах кабинет гэсэн нэрээр байгаа. Тусдаа байртай болбол доторх үзмэрүүдийг нутгийн иргэдээс олж цуглуулж болно хэмээн төлөвлөж байна. Баян-Овоо, Номгон сумдын нутгийн зааг Хөрхийн нурууны төгсгөлийн зүүн урд биед байсан хүн чулуу хэдэн жилийн өмнө үерийн улмаас шороонд дарагдаж алга болсныг хайж олох зардал мөнгө олддог бол сайн ажээ.

Баян-Овоо сумын Б.Доржийн нэрэмжит 9 жилийн сургуульд очиж, захирал Ц.Нарантуяа, сургалтын менежер О.Нандинцэцэг нартай Олон нийтийн хөтөлбөрийн талаар уулзаж ярилцав. Тус сургууль 12 багш, бага ангийн 5, дунд ангийн 3 нийт 8 бүлэг, 204 хүүхэдтэй.




“Иргэний боловсрол” хичээлийн хөтөлбөрт байгаль орчин, түүх соёлын дурсгалт газруудын тухай тусгаж өгвөл сайн байна. Уг хичээлийг заахад багш нарт гарын авлага, үзүүлэн таниулах материал дутмаг байдгаас заахад хүндрэлтэй байдаг. Мөн “Төсөлт ажил” хичээлийн сэдэв сонголтонд бас Соёлын өвийн зарим нэг зүйлийг оруулж болно. Сумын сургуулиудад сургалтанд ашиглах техник тоног төхөөрөмж дутагдалтай байдаг тул дан ганц аман яриагаар Соёлын өвийн талаар заах нь учир дутагдалтай.



Сургуулиудад “Соёлын өвийн танхим” байгуулж өгвөл тэнд уламжлалт соёлын өвийг сурагчдад зааж сурталчлах хичээл, төрөл бүрийн сургалтыг явуулахад чухал ач тустай юм. Түүх-газарзүйн багш нарт Соёлын өвийн талаар сургалт зохион байгуулж багш нараа эхлээд сургагч багш маягаар бэлтгэвэл илүү үр дүнд хүрнэ. Эхлээд багш нараа бэлтгээд дараа нь хүүхдүүддээ заах хэрэгтэй байх. Сургалтын хэрэглэгдэхүүнийг гэрэл зураг, видео бичлэг, кино маягаар хийж үзүүлвэл хүүхдүүдийн сонирхлыг илүү татна.

Уламжлалт соёлын өвийн дунд байгаа хүмүүс болох хөдөө мал маллаж байгаа залуучуудад Соёлын өвийн боловсрол олгох нь чухал хэрэгтэй байна. Ингэхдээ сард нэг удаа болдог багийн хурал, жил бүрийн “Авто техникийн улсын үзлэг” зэрэг залуучууд хөдөөнөөс олноор цуглардаг үеэр сургалт тогтмол явуулдаг байх хэрэгтэй. Тэдэнд сумын сургууль бүрд байдаг “Албан бус боловсролын” багш нарыг түшиглэн биет ба биет бус соёлын өвийн тухай, тэдгээрийг хайрлан хамгаалах талаар сургалт зохион байгуулах шаардлагатай. Бас багийн дарга, байгаль хамгаалагч нарт мөн энэ төрлийн боловсрол олгох нь зүйтэй.

2010 оны 11-р сарын 25-нд Ханбогд суманд ажиллав. Баян багийн төв дээр болсон “Мянган ботгоны баяр”-ыг үзэж танилцав. Баян баг анх 1984 онд мянган ботго бойжуулсан баярыг тэмдэглэж байжээ. Хоёрдахь удаад 2008 онд Мянган ботгоны баяр хийсэн бол гуравдах удаад энэ жил 1331 ботготой болсны баяраа хийж байна. Нэг баг 1000 давсан ботго нэг жилд бойжуулна гэдэг бол их том амжилт юм. Баярын үйл ажиллагааг зохион байгуулах 8 хүнтэй комисс байгуулжээ.

Эл "Мянган ботгоны баяр"-ыг хийхэд "Ажнай" корпораци, түүний ерөнхийлөгч Бат-Эрдэнэ 7 сая 900 мянган төгрөгөөр ивээн тэтгэсэн байна. Мөн багийн малчин айл өрх бүр сүү, ингэний айраг, чанасан мах, боов боорцог авчирчээ. Саяхан тус багийн төв дээр Соёлын төвийн барилгын шавыг тавих ёслол барьсан. Нийт 50 сая төгрөгийн өртөгтэй энэ барилгын 70 хувь болох 35 сая төгрөгийг тус сумын нутагт газрын тосны хайгуул хийж буй Хятадын компани гаргахаар болсон байна.



"Мянган ботгоны баяр"-т 50 гаруй автомашин, 300 орчим хүн, 100 гаруй тэмээ оролцов. Баярын арга хэмжээ 8.30 цагт хурдан тэмээний уралдаанаар эхэлж, 19 цагийн баярын босоо хүлээн авалтаар өндөрлөсөн юм. Явагдсан арга хэмжээнүүд гэвэл, хурдан тэмээний уралдаан, шилмэл буур шалгаруулах тэмцээн, шилмэл тайлаган буур шалгаруулах тэмцээн, сүүтэй ингэ шалгаруулах тэмцээн, хурдан торомны уралдаан, шилмэл ат шалгаруулах тэмцээн, шилмэл ингэ шалгаруулах тэмцээн, сайхан тэмээтэй хос шалгаруулах тэмцээн зэрэг юм. Хурдан тэмээ 10 км-т, хурдан тором 6 км-т тус тус уралдсан бол шилмэл буур, тайлаган буур, ат шалгаруулахдаа тэдний биеийн өндрийг гол болгов. Их сүүтэй ингийг шалгаруулахдаа сааж 2100 мг, 2000 мг, 1600 мг сүү гарсан ингэнүүдийг тэргүүн байр эзлүүлсэн билээ.

Тэмцээний шагналыг хэлвэл,

Шилмэл буур. 1. Алтан медаль, өргөмжлөл, 130000 төг, хадаг

2. мөнгөн медаль, өргөмжлөл, 110000 төг, хадаг

3. хүрэл медаль, өргөмжлөл, 80000 төг, хадаг

Шилмэл тайлаган буур .1. Алтан медаль, өргөмжлөл, 130000 төг, хадаг

2. мөнгөн медаль, өргөмжлөл, 110000 төг, хадаг

3. хүрэл медаль, өргөмжлөл, 80000 төг, хадаг

Шилмэл ингэ. 1. Алтан медаль, өргөмжлөл, 130000 төг, хадаг

2. мөнгөн медаль, өргөмжлөл, 110000 төг, хадаг

3. хүрэл медаль, өргөмжлөл, 80000 төг, хадаг

Сүүтэй ингэ. 1. Алтан медаль, өргөмжлөл, 130000 төг, хадаг

2. мөнгөн медаль, өргөмжлөл, 110000 төг, хадаг

3. хүрэл медаль, өргөмжлөл, 80000 төг, хадаг

Хурдан тэмээ.1.Алтан медаль,өргөмжлөл,230000 төг, хадаг



2. мөнгөн медаль, өргөмжлөл, 180000 төг, хадаг

3. мөнгөн медаль, өргөмжлөл, 130000 төг, хадаг

4. хүрэл медаль, өргөмжлөл, 110000 төг, хадаг

5. хүрэл медаль, өргөмжлөл, 80000 төг, хадаг

Хурдан тором.1.Алтан медаль,өргөмжлөл,230000төг, хадаг

2. мөнгөн медаль, өргөмжлөл, 180000 төг, хадаг

3. мөнгөн медаль, өргөмжлөл, 130000 төг, хадаг

4. хүрэл медаль, өргөмжлөл, 110000 төг, хадаг

5. хүрэл медаль, өргөмжлөл, 80000 төг, хадаг

Шилмэл ат. 1. Алтан медаль, өргөмжлөл, 130000 төг, хадаг

2. мөнгөн медаль, өргөмжлөл, 110000 төг, хадаг

3. хүрэл медаль, өргөмжлөл, 80000 төг, хадаг

Сайхан хос. 1. Алтан медаль, өргөмжлөл, 130000 төг, хадаг

2. мөнгөн медаль, өргөмжлөл, 110000 төг, хадаг

3. хүрэл медаль, өргөмжлөл, 80000 төг, хадаг

Шагнал гардуулах ёслол өөрийн гэсэн дэгтэй болж өнгөрөв. Уралдаанд шалгарсан тэмээний медалийг тэдний ногтонд уяж, эздийг нь улаан хивс дээр сөхөрч суулгаад бусад шагналыг өгч ингэний айраг амсуулж байгаа нь 1-т, тэмээгээ хүндэтгэж байгаа хэрэг, 2-т, айргийг зогсоогоор удаггүй заншилтай холбоотой ажээ.



Хүнс хөдөө аж ахуйн яамны сайдын жуух бичгээр гурван тэмээчнийг шагнасныг Баян багийн засаг дарга Г.Мягмаржав гардуулав. "Оюу толгой" төслийн удирдагчид ирж хөдөө нутагт тэмээ маллаж буй залуу тэмээчдийг дэмжих зорилгоор 3 хүнд (нэг малчинд



өргөмжлөл, мөнгөн аяга, 200000 төгрөг, 2 малчинд тус бүр өргөмжлөл, мөнгөн аяга, 100000 төгрөг) тусгай шагнал олгосон нь зөв зүйтэй арга хэмжээ болсон билээ. Мөн CIS компанийн удирдлага Баян багийн төвд хэрэглэх техник хэрэглэл бэлэглэсэн юм. Бас "Шинэ Ханбогд" ТББайгуулага өөрийн шагналыг олгов. "Мянган ботгоны баяр"-т сумын Соёлын төв 2 цагийн концерт тоглов.

Тэмээтэй холбоотой баярыг зөвхөн Ханбогд суманд хийдэг гэж ойлгож болохгүй. Өмнөговь аймгийн ихэнхи сумд "Тэмээний баяр" жил бүр хийдэг. "Оюу толгой" төслийн шууд нөлөөллийн бүс нөгөө хоёр сум болох Баян-Овоо суманд "Тэмээний баяр"-ыг жил бүрийн 3-р сарын 1-нд сумын төв дээр 3 багийн хурал нэгдсэн хурал хийх үеэрээ хийдэг уламжлалтай бол хойд хөрш Манлай суманд мөн жил бүрийн 3-р сарын 1-нд "Тэмээний баяр" хийдэг уламжлал тогтоод удаж байна. Мөн "Тэмээн поло"-н сум, аймаг, улсын аварга шалгаруулах тэмцээн Өмнөговь аймагт болоод нилээн хэдэн жилийн нүүр үзэж байгаа билээ. Өмнөговь аймгийн энэ жилийн "Тэмээний баяр" 10-р сарын 23-нд Даланзадгадад болсон юм.

Тэмээний баяр, ботгоны баяр бол говь нутгийн монголчуудын тэмээний соёлтой холбогдон 1980-ад оны үеэс бий болсон өвөрмөц баяр тул үүнийг цаашид дэмжиж байх хэрэгтэй юм. Тэмээний эдгээр баяруудаар дамжуулан тэмээний тоо толгойг өсгөх, тэмээчдийг дэмжих зэрэг арга хэмжээг явуулж болно. "Оюу толгой" төслөөс шууд нөлөөллийн бүсийн нөгөө хоёр сум болох Баян-Овоо, Манлай сумдад дараа жилийн тэмээний баяраар Ханбогдод өгсөнтөй адил шагналыг адилхан өгөх нь хэрэгтэй хэмээн үзэж байна.

2010 оны 11 сарын 26-нд Ханбогд сумын Соёлын төвийн эрхлэгч Нарангэрэлтэй уулзаж, соёлын төвийн үйл ажиллагаа болон Соёлын өвийн хадгалалт, хамгаалалт, сургалт-сурталчилгааны талаар санал солилцов. Тус Соёлын төв эрхлэгч, хөгжмийн багш, бүжгийн багш, номын санч, музейн ажилтан (тасалбар шалгагчийг хамт) 5 ажилтантай. Хөгжим, бүжиг, морин хуурын дугуйлан ажиллуулдаг бөгөөд 40 хүүхэд суралцдаг байна. Соёлын төв нь 200 гаруй хүний суудалтай. 2008 онд гадаадын хөрөнгө оруулалтаар 500 хүний суудалтай соёлын төв баригдсан боловч гүйцэтгэгч байгууллага муу хийснээс болоод ашиглалтанд ороогүй ажээ. Тус сумын музей нь 600 гаруй үзмэртэй. 1994 онд музей, хийд хоёрыг хамтад зэрэг барьсан. 2008 онд сүмээсээ салгаж тусгай байртай болгожээ.

Сумын Засаг даргын захирамжаар сумын хамгаалалтанд авсан 34 газар байдгаас Дэмчиг, Рийтэр, Цагаан толгой, Цогзол, Бага мод, Баян, Агуйн гэсэн 7 хийдийн туурь бий. Соёлын төвөөс санаачлан "Оюу толгой" төслөөс 2,8 сая төгрөг авч, дурсгалт газруудын 33-т машины зогсоол, 24-т самбар, 12-т чулуун гортиг хийсэн байна.




Дурсгалуудын хамгаалалтыг сайжруулах хэрэгтэй байгаа ажээ. Сумын хэмжээнд 28 газрын булшийг очиж үзэхэд бүгдийг нь хууль бусаар малтсан байсан. Ханбогд хайрхан, Галбын ууланд байдаг цагаан чулуутай 108 толгойг бүгдийг нь тэсрэх бодисоор тэсэлчихсэн. Тэрбээр энэ хууль хэрэгт тус сумын иргэд оролцсон хэмээн үзэж байна. Түүх соёлын дурсгалт газруудыг орон нутгийн малчдын оролцоотойгоор, урамшуулал олгох замаар хамгаалах хэрэгтэй. Нутаг орноо гэсэн, түүх соёлын дурсгалт газраа хамгаалах сэтгэлтэй их хүмүүс байдаг. Ингэхдээ улиралд нэг удаа цалин олгох ч юм уу эдийн засгийн талаар дэмжих нь зүйтэй гэсэн саналтай байна. Бусад сумын адил Соёлын өв тээгчдээс мэдээ баримтжуулж авах дуу хураагуур, камер, дурсгалт газруудын байршлыг зөвөөр тогтоох GPS байдаггүй ажээ.

Ханбогд сумын бүрэн дунд сургуулийн захирал Д.Ганбат, сургалтын менежер Б.Төмөрбаатар нартай уулзаж Олон нийтийн хөтөлбөрийн талаар санал солилцов. Нийт 736 хүүхэдтэй, 50 гаруй багш ажилтантай. "Оюу толгой" төслөөс 2004 онд сургуульд фургон машин бэлэглэсэн, сургуулийн гадуур хашаа, хайс барьж, багшийн хөгжлийн төвд 6 ширхэг иж бүрэн компьютер бэлэглэжээ. "Иргэний боловсрол" хичээлээр сум орон нутгийн түүх соёлын дурсгалт газруудын тухай хүүхдүүдийг ойлголттой болгох. Соёлын өвийн тухай гарын авлага, хэрэглэгдэхүүн ховор байдаг багш нарыг соёлын энэталаар сургалтанд хамруулж зохих мэдлэгтэй болгох хэрэгтэй ажээ.

Ханбогд сумын төв дээр буй зочид буудлын урьдчилсан судалгааг хийв. Сумын төвд гурван буудал буй нь "Уужим-Од" ХХК-ний "Эрхэс" зочид буудал, "ДТМ" ХХК-ний "Баян-Эрдэнэ" зочид буудал, "Хан дизель" ХХК-ний мэдэлд буй Ханбогд сумын зочид буудал юм. Ханбогд сумын хэмжээнд жуулчин болон албан ажлаар яваа хүмүүс буух орны тоо тун бага байгаа нь уг судалгаанаас харагдаж байна.

"Шинэ Ханбогд" төрийн бус байгууллагын Удирдах зөвлөлийн тэргүүлэгч гишүүн. С.Сандагсүрэнтэй уулзаж ярилцав. Тэргүүн бөгөөд удирдах зөвлөлийн дарга Б.Эрдэнэ-Очир юм. Энэ нь 2006 онд байгуулагдсан, нийгэмд үйлчилдэг төрлийн байгууллага юм. Хариуцлагатай уул уурхайг бий болгох, Ханбогд сумыг хөгжүүлэх үндсэн зорилготой ажээ. Удирдах зөвлөл нь 11 хүнтэйгээс 3 нь Улаанбаатарт, 1 нь Даланзадгадад, бусад нь Ханбогдод амьдардаг. Уг байгууллагын олон ажил төрлийн нэг бол Соёлын өвийн ажил юм. Хоёр жилийн өмнө Лхагвасүрэн, Балжинням нартай хамтран сумын түүх соёлын дурсгалт газруудаар явж, тэр тайлангаа Соёлыг төвд хүлээлгэн өгсөн. "Иргэний боловсрол" хичээлээс тусгай танхимаас гадуурх сургалтаар "Түүх, соёл, шашин, уламжлалт зан заншлын" талаар тусгай анги тус бүрд өөр өөр хичээлийн хөтөлбөр боловсруулж, 12 сарын 1-нээс орохоор төлөвлөж байгаа. Заах багш нарт урамшуулал олгох гэж буй байна. "Шинэ Ханбогд"-ын дараа "Жавхлант нутаг" ТББ, саяхан "Их говийн ус хамгаалал" ТББ байгуулагдан ажиллаж байна.

2010 оны 11-р сарын 27-нд Манлай суманд ажиллахдаа Соёлын төв, Орон нутаг судлах музейн үйл ажиллагаатай танилцаж, эрхлэгч Д.Отгонбаттай Соёлын өвийн хөтөлбөрийн Олон нийтийн хөтөлбөрийн талаар санал бодлоо солилцов. Манлай сумын соёлын төв бусад сумдын адил 5 орон тоотой. 152 хүн орох танхимтай. Номын сан, орон нутаг судлах музей нь тусдаа багавтар байшинд оршдог. Морин хуур, ардын хөгжим, даралтат хөгжим, бүжгийн дугуйлан явуулдаг. Тэдгээрт 20 гаруй хүүхэд явдаг. Тус сумын хамгаалалтад биет соёлын 17 өв байдаг. Биет бус соёлын өв тээгч 23 хүний бүртгэлтэй. Зарим соёлын биет



бус өвүүд устаж байгаа нь харамсалтай. Ингэ хөөсөлдөг, хонь тойголдог хүмүүс цөөрч байна. Эдгээр хүмүүсийн яриа, дууг дүрсжүүлэн хадгалах хэрэгтэй байна. Соёлын өвийг баримтжуулж авах дуу хураагуур, видео бичлэг, гэрэл зургийн аппарат, GPS, ноутбуук, проектор зэрэг техник хэрэгсэл огт байдаггүй ажээ.

Түүний хэлсэн саналууд гэвэл, Манлай сум 2002 онд анх “Тэмээн поло”-ны тэмцээн зохион байгуулснаас хойш одоог хүртэл улсын аваргын тэмцээнд байнга эхний 3 байранд орж байна. Өмнөговь аймагт 85000 тэмээгээр улсад тэргүүлж удаах аймаг нь 26000 тэмээтэй байдаг ажээ. Тэмээний соёлыг улам бүр хадгалахын тулд “Тэмээн поло” болон өндөр бай шагналтай тэмээний уралдааныг нас бүрээр (тором, тайлаг, ат, буур) жил бүр зохиож байх нь зүйтэй. Ингэвэл тэмээ сургах, эдлэх ашиглах явдал их сайжрах юм.

Үндэсний хувцасны асуудал их санаа зовоож байгаа тул Манлай суманд долоо хоногийн 1 дэх өдөр бүр үндэсний хувцас өмсдөг сайхан уламжлал тогтсон. Энэ байдлыг бодлогоор дэмжих тал дээр зарим нэгэн арга хэмжээг авах хэрэгтэй. Тэр нь үндэсний хувцас-малгай, дээл, хантааз, хүрэм, гуталны уралдааныг жил бүр явуулж, шагналыг нь уул уурханй компаниуд өгдөг бол сайн байна.

Монголын уламжлалт соёлын өвийг хадгалж, хамгаалах, сурталчлахад төрөл бүрийн уралдаан их тустай, түлхэц болохуйц арга хэмжээ болдог. Сумын морин хуурчдын, уртын дуучдын, бие биелгээний, суран хазаар-чөдөр-ногтны, морин хуур урлаачдын уралдааныг зохиож, бай шагнал олгодог бол хүмүүс их идэвхждэг. Учир нь сумын засаг дарга болон соёлын төвд тийм уралдаан зохиох ямар ч төсөв санхүү байдаггүйд оршино.

Манлай сумын Д.Нанзад баатрын нэрэмжит бүрэн дунд сургуулийн захирал Ц.Ганхүлэгтэй уулзаж, Олон нийтийн хөтөлбөрийн талаар саналаа солилцов. Тус сумын сургууль нь 42 багш ажилтан, 396 хүүхэдтэй. Иргэний боловсрол хичээл 7 хоногт 1 цаг ордог. Олон бүлэг сэдвийг хамарсан ямар ч үр бүтээлгүй өнгөрдөг. Сургалтын хөтөлбөрт Монголын түүх, соёл, зан заншлын тухай хичээлийг иж бүрнээр нь заах хэрэгтэй байна. Хүүхдүүдийн хэл, эдийн соёл их өөрчлөгдөж байна. Монгол бахархал, монгол соёлыг мэддэг хүн ховордож байгаа нь харамсалтай байна.

Долоо хоног бүрийн 1 дэх өдөр болгон "Монгол хувцасны өдөр" болгож заншаад байна. Шилжилт хөдөлгөөнөөр өөр аймгуудаас хүмүүс их ирэх болсноор нутгийн аялгууны хэл мартагдаж байна. Хүүхдүүдэд үндэсний бахархлыг бага наснаас нь суулгах хэрэгтэй. Сумын цэцэрлэг сургуулиудад "Ёс заншлын өргөө" байгуулж хүүхдүүдийг түүх, уламжлалт ёс заншлын ойлголт өгдөг байвал зүгээр юм. Соёлын өвийн талаар янз бүрийн төсөл хөтөлбөрүүд байдаг боловч амьдрал дээр хэрэгжихдээ муу байдаг. Сургууль дээрээ "Ёс заншлын өргөө" байгуулахаар төсөл боловсруулсан. Үүнд 8 сая төгрөг хэрэгтэй байгаа. Байгалийн үзэсгэлэнт, түүхийн дурсгалт газруудыг малчдын нөхөрлөл, хоршоо байгуулах замаар хамгаалах хэрэгтэй байна. Эдийн засгийн талаар нь урамшуулах хэрэгтэй.

Соёлын өвийн тухай малчид, иргэд мэдээлэл хомс байдаг тул сургалт зохион байгуулж тодорхой ойлголттой болговол сайн. Соёлын өвийг хамгаалах сурталчлахад гол зүйл нь санхүүгийн асуудал юм. Цэцэрлэгийн хүүхдийн тоглоомуудыг монгол тоглоом болгож тэднийг эх орноо хайрлах үзэл санаа суулгавал сайн юм. Сургуульд үндэсний хөгжим дутагдалтай байдгийг цаашид анхаарвал сайн ажээ.

Манлай сумын Засаг дарга Сугир, Засаг даргын орлогч, соёлын өвийг тээгч Д.Өөлий нартай уулзаж санал бодлоо солилцов. Тэд Манлай сумын нутагт ургадаг бүх төрлийн бут, ургамлын зургийг авч дүрсжүүлэн нэрийг нь бичиж, эмийн ургамлаар ялгаж хүүхэд залуучуудад таниулах, эмэгтэй хүний савны өвчинд сайн гэгдэх орсон буурын бохийг мэргэжлийн байгууллагууудар шинжлүүлж эдийн засгийн эргэлтэнд оруулах нь зүйтэй хэмээн үзэж байв.

Тэдний тавьж буй саналууд гэхүл, т үүх соёлын дурсгалт газруудын хамгаалалтыг орон





нутгийн малчдад хариуцуулж, эдийн засгийн талаар урамшуулал олгох, Манлай сумын нутаг Сүм Суварганы ууланд (Хоёр богд уул ч гэдэг) нутгийханы аман яриагаар таван ханатай гэрийн буурины чинээ хүрэл тогоо байсан нь шороонд дарагдаж алга болсныг илрүүлж, эрдэм шинжилгээний эргэлтэнд оруулах ажлын санхүүжилтыг "Оюу толгой" төслөөс гаргавал их сайн буй ажээ.

Дээрх судалгааны ажлын төгсгөлд гарч буй санал дүгнэлтүүд нь,

-Жил бүрийн төгсгөлөөр Өмнөговь аймгийн нутгийн удирдлагын байгууллага, соёлын мэргэжилтнүүд, сумдын иргэдийн төлөөлөл, уул уурхайн компаниуд гэсэн 4 талын яриа хэлэлцүүлэг хийж Соёлын өвийн хадгалалт, хамгаалалт, сурталчилгааны талаарх тухайн жилийн ажил байдлаа хэлэлцэн дүгнэж, дараа жилийн ажлын зорилтоо нарийвчлан тодорхойлдог ажлыг тогтмолжуулах хэрэгтэй юм байна. Энэ бол Соёлын өвийн талаарх тогтвортой бодлого, үйл ажиллагааны нэг чухал хэсэг болох юм.

-БСШУЯ-д бүрэн дунд сургуулийн бага, дунд, ахлах ангиудад орох "Иргэний боловсрол" хичээлийн хөтөлбөрт хүүхдийн насны онцлогт тохируулан Монгол орны болон тухайн сум нутаг орны байгаль орчин, түүх соёлын дурсгал, уламжлалт ёс заншил, хоол унд, хувцас хунар, нүүдлийн мал аж ахуйн соёл зэргийг танин мэдүүлэх, хайрлан хамгаалах талаар хичээл оруулдаг болгон тогтоож улс орон даяар мөрдүүлэх саналыг СӨХ-ийн Олон нийтийн хөтөлбөрийн хүрээнд албан ёсоор тавихыг санал болгож байна.

-"Монгол хувцасны үндэсний хөтөлбөр" боловсруулж улс орон даяар мөрдүүлэх нь чухал болох нь Өмнөговь аймагт уул уурхайн салбар ихэд хөгжиж, үндэсний хувцас өмсөх явдал их багасч байгаагаас харагдаж байна. "Оюу толгой" төслийн шууд нөлөөллийн Манлай суманд уламжлал болсон долоо хоногийн 1 дэх өдөр бүр үндэсний хувцас өмсдөг сайхан уламжлалыг Ханбогд, Баян-Овоо суманд нэвтрүүлэх нь зүйтэй юм. Хэдийгээр жилд 1 удаа албан газар, сургуульд "Монгол хувцасны өдөр" болдог ч энэ нь санасан хэмжээнд хүрэхгүй байна. Шууд нөлөөллийн бүсийн 3 сум тус бүрд жил бүр үндэсний хувцасны уралдаан (загварын хувцас бус) зохиож байхыг санал болгож байна. Мөн Өмнөговь аймгийн үндэсний хувцасны наадам, үндэсний хувцасны өдөр жил бүр зохиоход дэмжлэг үзүүлэх хэрэгтэй ажээ.

-"Оюу толгой" төслийн шууд нөлөөллийн бүсийн Ханбогд, Манлай, Баян-Овоо сумдын хамгаалалт ба бүртгэлд буй биет өв болон биет бус өвийг тээгч хүмүүсийн талаарх мэдээллийн иж бүрэн мэдээлийн сан байгуулах хэрэгтэй байна. Түүнд видео бичлэг, гэрэл зураг, газрын зураг, газарзүйн нарийвчилсан цэг тогтоох зэрэг ажлууд багтана. Энэ ажлыг хийхэд шаардагдах дуу хураагуур, гэрэл зургийн аппарат, видео бичлэгийн аппарат, байрлал тогтоох GPS, проектор, компьютер, зурагт зэрэг техник хэрэгслээр хангах ажлыг "Оюу толгой" төслөөс зохион байгуулбал их үр дүнтэй ажил болох юм.

-"Оюу толгой" төслийн шууд нөлөөллийн бүсийн сум бүрт сумын морин хуурчдын, уртын дуучдын, бие биелгээний, суран хазаар-чөдөр-ногтны, араг-савар, морин хуур урлаачдын уралдааныг зохиож жил бүр зохиож хэвшүүлэх, мөн Өмнөговь аймгийн хэмжээгээр зохион байгуулдаг болохыг санал болгож байна. Эдгээр төрөл бүрийн уралдаан нь уламжлалт соёлын өвийг хадгалж, хамгаалах, сурталчлахад маш их тустай, түлхэц болохуйц арга хэмжээ болох нь харагдаж байна.

-"Оюу толгой" төслийн шууд нөлөөллийн бүсийн сумын цэцэрлэг, сургуулиудад "Ёс заншлын өргөө" байгуулж тохижуулан хүүхдэд бага наснаас нь эхлэн уламжлалт соёлын өвийг мэдүүлэх, сурталчлах уурхай болгох хэрэгтэй юм байна. Мөн шууд нөлөөллийн бүсийн сургуулиудад а. Түүхийн, б. Газарзүйн гэсэн хоёр кабинетийг бүрэн тохижуулж, сум орон нутгийн түүх соёлын дурсгалууд болон байгаль орчин, хөрс, өвс ургамлын талаар бүрэн мэдлэг ойлголт өгөх, сургалт явуулахад орчныг бүрдүүлж өгөх хэрэгтэй юм байна.

-Соёлын өвийн тухай боловсролыг дан ганц танхимын сургалтаар олгох нь учир дутагдалтай байдаг тул сумдын сургуулиудын албан бус боловсролын багш нарыг түшиглэсэн "Соёлын өвийн зайны сургалт" гэсэн хөтөлбөр боловсруулан хөдөөгийн бүх насны иргэдэд соёлын өвийн тухай боловсрол олгох нь зүйтэй гэсэн саналыг тавьж байна.

Тайлан бичсэн: Ж.Гэрэлбадрах

# 23. ХАВСРАЛТ 14. СӨХ БОЛОВСРУУЛАХ ТӨСЛИЙН МЭДЭЭЛЛИЙН ХУУДАС

Оюу Толгой

## БАРИМТЫН ТОВЧООН 1

Оюу Толгой

### Оюу Толгой төслийн Соёлын өвийн хөтөлбөр боловсруулах төсөл

**Өмнөговь аймгийн ирээдүйн хөгжилд соёлын өвийг хамгаалах ач холбогдол**

Говь нутагт олон сая жилийн туршид амьдрал үргэлжилсээр ирсэн бөгөөд энэхүү газар нь эргэн тойрон намгаар хүрээлэгдсэн асар том далай тэнгис байсан хэмээхэд өнөөдөр итгэхэд хэцүү ч энэ газар шороо 200-60 сая жилийн тэртээ аварга том үлэг гүрвэлүүдийн эзэмшилд байсныг гэрчлэх тэдгээрийн өндөг, яс зэрэг олдворууд илрэн олддогоороо дэлхийд алдаршсан.

Хүн төрөлхтөний түүхэн хөгжлийн явцад зэрлэг амьтдыг гаршуулсан нь тэдний амьдралд томоохон өөрчлөлтийг бий болгон амьдралын нүүдэлчин хэлбэрийг хөгжүүлсэн. Энэхүү нүүдэлчин овог аймгуудын эзэнгүй зэлүүд газрыг хоромхон хугацаанд өөрийн болгон эзэмшиж чадах уян хатан нийгмийн бүтэц нь хожмын Монголын Эзэнт гүрнийг байгуулахад хамгийн чухлаар нөлөөлсөн зүйлүүдийн нэг болсонтой маргах аргагүй юм.

Сүүлийн жилүүдэд тулгарч буй асуудлуудын нэг бол малчдын нүүдлэхүй хэв маяг нь орчин үеийн амьдралын хэв маягаас шалтгаалан өөрчлөгдөж байгаа явдал юм. Монголчууд XX зууны ихэнх хугацаанд өөрсдийн уламжлан ирсэн зан заншил, түүх соёл, шашин шүтлэгээ дээдлэх нь хязгаарлагдмал байсан.

Өнөөдөр хэдийгээр уламжлалт түүхэн соёл, хуучин бүхнээ сэргээх боломжтой болсон боловч дахин өөр хүчин зүйл, асуудлууд тулгарч эхлээд байна. Говь нутагт явагдаж буй эдийн засгийн хөгжил дэвшил нь нутгийн уугуул иргэдэд шинэ боломжуудыг нээж өгөх хэдий ч бидний хамгийн үнэт зүйл болох түүхэн өв соёл маань хадгалагдан, хамгаалагдан, үлдэж байгаа эсэхэд тун болгоомжтой хандах ёстой юм.







## ӨВ СОЁЛ ГЭЖ ЮУ ВЭ?

Өв соёл гэдэг бол бид бүхний өнгөрсөн үетэй холбоотой хамгийн чухал зүйл юм. Эдгээрт:

- Археологийн дурсгалт газрууд
- Түүхэн байшин, барилгууд
- Палеонтологийн дурсгалт газрууд

зэргийг багтаан авч үзэж болно.

Мөн соёлын өв гэдэгт биет өвөөс гадна хүмүүсийг хооронд нь болон үе удамд нь холбож өгч байдаг дараах биет бус өвүүд ч давхар багтана. Үүнд:

- Хэл
- Ёс заншил
- Баяр ёслолууд
- Өвт газрууд
- Нүүдэлчдийн амьдралын хэв маяг

зэргийг хамруулан ойлгоно.

SUSTAINABILITY    THE UNIVERSITY OF ARIZONA



## ЯАГААД СОЁЛЫН ӨВ ЧУХАЛ ВЭ?

Бид өөрсдийгөө хүн гэдгээ тодотгохын тулд өв гэсэн ойлголтыг хэрэглэдэг. Энэ нь биднийг өнгөрсөн үетэй холбож, өнөөдрийг утгатай болгож, ирээдүйд маань газарчилдаг чухал зүйл гэдгийг хүн бүхэн мэднэ. Өв соёлоо алдах нь тухайн үндэстнийг үнэт зүйлсгүй болгосноор залуучууд нь уламжлалаа умартаж, өвөг дээдэс нь тодорхой үүрэг гүйцэтгэхээ болин уламжлалт ёс заншил, хэм хэмжээ алдагдаж харин гэмт хэрэг, архидалт, нийгмийн задрал газар авах сөрөг нөлөөтэй билээ.

Уламжлалт өв соёлоо хамгаалж авч үлдэнэ гэдэг нь нийгэм, эдийн засгийн хөгжлөө царцанги байдалд оруулна гэсэн санаа огтхон ч биш юм. Харин ч говь нутгийн эрдэс баялгийн арвин их нөөц нь эдийн засгийн өсөлтийг бий болгон нийгмийн өөрчлөлтийг авч ирэх нь тодорхой билээ. Гэвч эдийн засгийн хөгжлийг даган ирсэн шинэ оршин суугчид өөрсдийн уламжлал, хэл, шашны ёс заншил зэрэг зүйлсээ хамтдаа авч ирэх нь ойлгомжтой юм. Ингэхлээр ийм их хурдацтай хөгжлийн үед уугуул иргэд өөрсдийн уламжлал ёс заншилаа хэвээр хадгалан үлдэх нь энэ цаг үед тохиолдож буй маргаангүй маш том шалгуур юм.

## БИД ЮУ ХИЙЖ ЧАДАХ ВЭ?

Бидэнд маш сайн төлөвлөсөн төлөвлөгөө хэрэгтэй. Ялангуяа эдийн засгийн хөгжилтэй уялдуулан бус, орон нутаг, улс орны хувьд амин чухал соёлын өвүүдийг хамгаалах Хөтөлбөр бидэнд хэрэгтэй. Монгол-Олон Улсын Баг (МОУБ) нь Оюу Толгой ХХК-ийн захиалгаар уг Соёлын Өвийн Хөтөлбөрийг боловсруулахаар сонгогдон ажиллаж эхлээд байна. Бид хөтөлбөр боловсруулах ажлын судалгааг гурван гол хэсэгт хуваасан нь биет бус өвийн судалгаа, биет өвийн судалгаа, олон нийтийн хөтөлбөрийн судалгааны ажлууд юм. Эхний 2 хэсгийн тухайд эдгээр нь маш тодорхой биет өв дурсгал, уламжлал ёс заншил зэргийг судалдаг бол гурав дахь судалгааны хэсгийн хувьд соёлын өвийн талаарх ойлголтыг сургууль, музейгээр дамжуулан хүмүүст хэрхэн ойлгуулах боломжтой талаар болон өвийн аялал жуулчлалыг хөгжүүлэн эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлэх арга замыг судлана.

## БИД ХЭН БЭ?

"Монгол-Олон Улсын Өвийн Баг" нь "Соёлын Өвийн Хөтөлбөр" боловсруулах чиглэлээр ажиллах Монголын болон олон улсын судлаачдыг нэгтгэсэн баг юм. Төслийн удирдагчаар ШУА-ийн Археологийн Хүрээлэнгийн эрдэмтэн нарийн бичгийн дарга доктор (Ph), профессор Б. Гүнчинсүрэн ажиллаж байна. Харин, "Биет өвийн дурсгал судлах судалгааны хэсэг"-ийг ШУА-ийн Археологийн хүрээлэнгийн Авран хамгаалах археологийн секторын эрхлэгч, доктор (Ph), дэд профессор Ч. Амартүвшин, "Биет бус өвийн дурсгал судлах судалгааны хэсэг"-ийг ШУА-ийн Түүхийн хүрээлэнгийн захирал, доктор (Ph), дэд профессор С. Чулуун, "Олон нийтийн хөтөлбөрийн судалгааны хэсэг"-ийг доктор (Ph), дэд профессор Ж. Гэрэлбадрах нар тэргүүлэн ажиллаж байна.

## ТАНЫ ОРОЛЦОО ЮУ БАЙХ ВЭ?

Аль дурсгалууд хамгаалагдах шаардлагатай, шүтлэг бишрэлтэй холбоотойгоор нутгийн ямар хэсгүүдийг, уламжлалыг хамгаалан авч үлдэх нь чухал болох, өв уламжлалаа үр хойчдоо хэрхэн өвлүүлж үлдээх, зааж сургах талаар таны санал манай судлаачдад нэн чухал билээ. Манай баг СӨХ-ийг 2011 оны 7-р сард боловсруулж дуусах ба энэ хугацаанд уг ажлын хүрээнд Өмнөговь аймгийн нутагт төрөл бүрийн уулзалтуудыг зохион байгуулж байна.

Энэхүү уулзалтуудад идэвхитэй оролцож, өөрсдийн байр суурийг илэрхийлж, бидэнтэй байнга хамт байхыг та бүхнээс хичээнгүйлэн хүсэж байна.

*Төслийн талаар илүү дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл бидэнтэй доорх утсаар холбогдоно уу.*

*Ч.Амартүвшин : 9912 0733; Б.Гүнчинсүрэн : 9905 7280*

## 24. ХАВСРАЛТ 15. СӨХ-ИЙН ЗӨВЛӨХ ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

### СОЁЛЫН ӨВИЙН ХӨТӨЛБӨРИЙН ЗӨВЛӨХ ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХАМРАХ ХҮРЭЭ

**1.0 ЗОРИЛГО:**

1.1 Зөвлөх хороо нь "Оюу Толгой" компаний Соёлын өвийн хөтөлбөр (СӨХ)-ийг боловсруулахад оролцох, хяналт тавих боломжийг талуудад олгоно.

1.2 Зөвлөх хороо нь нутгийн иргэд, соёлын өвийг хадгалж хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй талууд, СӨХ-ийг боловсруулах явцад үнэлгээ хийж, олон нийтэд зөвөлгөө өгч, мэдээлэлээр хангах чиглэлээр ажиллаж буй бусад оролцогчдын эрх ашгийг хамгаалах үйлсэд хувь нэмрээ оруулна.

**2.0 ЭРХ ҮҮРЭГ**

2.1 Зөвлөх хороо нь СӨХ боловсруулах явцад үнэлгээ хийх, СӨХ-ийн зөвлөх баг (Монголын Олон Улсын Өвийн Баг (МОУӨБ))-т зөвлөгөө өгөх, олон нийттэй харилцах, мэдээллээр хангах гэсэн үндсэн гурван үүрэг хүлээнэ.

a) СӨХ боловсруулах явцад үнэлгээ хийх:
- СӨХ-ийг боловсруулах хувилбаруудад бие даасан үнэлгээ хийх. Үнэлгээг хийхдээ олон улсын стандарт, тухайн нутаг орны үнэт зүйлсийг харгалзан үзэх нь зүйтэй.
- Тухайн хувилбаруудын төсөл, хөтөлбөрүүд тогтвортой хэрэгжих нөхцлийг бүрдүүлэхэд чиглүүлэх;
- Төсөл, хөтөлбөрүүдийн санхүүжилтийн эх үүсвэрт үнэлгээ хийх, төсөл, хөтөлбөрүүдэд дэмжлэг үзүүлэх байгууллага, санхүүжүүлгийн эх үүсвэрийг бүрдүүлэх; Зөвлөх хороо нь СӨХ-ийг боловсруулж дуусахаас өмнө тухайн төсөл, хөтөлбөрүүд зохион байгуулалтын болон санхүүгийн талаас тогтвортой хэрэгжихэд шаардлагатай аливаа зөвшилцөлд хүрсэн байх, эсвэл гэрээний нөхцөлд тодорхой тусгаж өгсөн байх нөхцлийг бүрдүүлэх;
- "Оюу Толгой" төслийн нөлөөллийн бүс дэх соёлын өвийн хадгалалт, хамгаалалтын байдалд хяналт үнэлгээ хийх арга замыг судлах;

b) Зөвлөх багт зөвлөгөө өгөх:
- Биет болон биет бус соёлын өвийн асуудлаар зөвлөгөө өгөх;
- Олон нийтийн хөтөлбөрийн асуудлаар зөвлөгөө өгөх;
- Шаардлагатай гэж үзвэл судалгааны аргазүй, зорилго, агуулгын талаар зөвлөмж гаргах;

c) Олон нийтийг мэдээллээр хангах:
- Судалгааны үр дүнг түгээх:
    - 1) Өмнөговь аймгийн нутгийн иргэд, тэдгээрээр дамжуулан бусад оролцогч талуудад
    - 2) үндэсний болон олон улсын түвшинд

- Шаардлагатай үед ашигтай түншлэлийн харилцааг бий болгоход туслах, ялангуяа хувийн хэвшил, төрийн байгууллага, иргэний нийгэм болон бусад байгууллагуудын хооронд

## 3.0 ГИШҮҮНЧЛЭЛ

3.1 Зөвлөх хорооны бие даасан, эрх бүхий байгууллага бөгөөд үүргээ биелүүлж, зорилгодоо хүрэх чадавхи бүхий бүтэц, зохион байгуулалттай байна. Гишүүнчлэл нь өвийн мэргэжилтнүүд, Өмнөговь аймгийн иргэд, төрийн болон иргэний нийгмийн байгууллын төлөөлөгчдөөс бүрдэнэ. Гишүүн нь монгол хүн байна.

3.2 Сайн дурын үндсэн дээр гишүүнээр элсэх бөгөөд гишүүн бүр гишүүнчлэлээсээ татгалзах эрхтэй. Гишүүдийн олонхийн саналаар Зөвлөх хороог тарааж болно.

3.3 Зөвлөх хорооны гишүүдийн тоо 15-аас хэтрэхгүй байна. Засгийн газын агентлагууд, үндэсний судалгааны байгууллагуудын төлөөллийг гишүүнээр элсэхийг урина. Бусад байгууллага, орон нутгийн төлөөллийн тэнцвэртэй байдлыг хангана.

3.4 Зөвлөх хорооны даргын эрх мэдэл судалгааны тайланг эцэслэх хүртэл хүчинтэй байх болно. "Оюу Толгой" ХХК шаардлагатай гэж үзвэл гишүүдийн саналаар хугацааг сунгаж болно.

3.5 Зөвлөх хорооны дарга бүрэн эрхийн хугацаагаа дуусахаас өмнө саналаараа огцорч болно.

3.6 Зөвлөх хорооны гишүүн нь хорооны даргад эхэлж мэдэгдэлгүйгээр хурал тасалсан тохиолдолд Хорооны дарга бусад гишүүдийн саналаар түүнийг гишүүнчлэлээс хасч, өөр хүн томилох шийдвэр гаргана.

3.7 Гишүүнээс гадна хөндлөнгийн мэргэжилтнүүдийг тодорхой асуудлаар шийдвэр гаргах явцад оролцуулахаар Зөвлөх хорооны хуралд урьж оролцуулж болно

3.8 Зөвлөх баг Зөвлөх хорооны хурлыг зохион байгуулах, Зөвлөх хорооны үйл ажиллагааг дарга болон гишүүдэд хурдан шуурхай тайлагнаж, хамтран ажиллах үүрэг хүлээнэ

3.9 Зөвлөх хороон нь хорооны өдөр тутмын харилцаа, бичиг баримт боловсруулах үүрэг бүхий нарын бичгийн даргыг сонгоно

3.10 Зөвлөх хорооны гишүүнчлэл нь хэдий сайн дурынх ч гэсэн бүх гишүүд ажлын нөхцөл, цалин хөлсний асуудлаар гэрээ байгуулна

## 4.0 ЗӨВЛӨХ ХОРООНЫ УДИРДЛАГА

4.1 Зөвлөх хороог Зөвлөх баг удирдах бөгөөд дараах үүрэг хүлээнэ:

- Зөвлөх хорооны гишүүдийг бүрдүүлэх;
- Зөвлөх хорооны хурал зохион байгуулах, шаардлагатай мэдээлэл бэлтгэх, түүнийг хорооны дарга, гишүүдэд тараах, хурлын үр дүнг тайлагнах, Зөвлөх хорооноос даалгасан ажлыг гүйцэтгэх;
- Зөвлөх хорооны хурлын хөтөлбөр боловсруулж, тэмдэглэл хөтлөх;
- Зөвлөх хорооны албан ёсны уулзалтуудыг хүлээгдэж буй үр дүнг дарга болон бусад гишүүдэд тодорхой ойлгуулах;
- Хурал бүрийн дараа хурлын тэмдэглэлийг бүх гишүүдэд цаг тухайд нь тараах;

## 5.0 ХУРАЛ

5.1. Зөвлөх хорооны бүх гишүүд, Зөвлөх баг "Оюу Толгой" ХХК-ны холбогдох хүмүүсийг хамруулсан хурал гурван удаа зохион байгуулна. Эхний хурал 2010 оны сүүлээр болно. Хоёрдахь хурал 2011 оны эхээр болно. Гуравдахь болон сүүлийн хурал СӨХ боловсруулж дуусахаас өмнө зохион байгуулагдана.

5.2. Мөн Хорооны дарга болон гишүүдийн хүсэлтээр хурал зохион байгуулж болно.

5.3. Зөвлөх хорооны дарга хурлаар зарим асуудлыг хэлэлцэхэд гадны төлөөлөгчдийг оролцуулж болно.

5.4. Зөвлөх хорооны гишүүд нь хуралд оролцохын зэрэгцээ, хурлын чөлөө цагт ажил үүргээ гүйцэтгэнэ.

5.5. Зөвлөх хорооны гишүүд нь хурал дээр хэлэлцсэн асуудал, аливаа мэдээллийн нууцыг чанд хадгалах бөгөөд тухайн асуудал гишүүдийн гуравны хоёрын саналаар баталгаажиж, цаасан дээр шийдвэр гарахаас өмнө нийтэд түгээж болохгүй.

5.6. Зөвлөх хорооны хурал бүрийн дэлгэрэнгүй тэмдэглэлийг бичиж "Оюу Толгой" ХХК-ны архивт шилжүүлнэ. Мөн гишүүдийн олонхийн шийдвэрээр эсвэл "Оюу Толгой" ХХК-тай зөвшилцсөнөөр нийтэд мэдээлж болно.

## 6.0. ШИЙДВЭР ГАРГАХ

6.1. Зөвлөх хорооны гишүүн бүр эрх тэгш байх бөгөөд үзэл бодолоо чөлөөтэй илэрхийлэх эрхтэй.

6.2. Тодорхой ажлыг хийж гүйцэтгэхтэй холбоотой Зөвлөх багт шууд үүрэг өгөх эрхгүй ч гэсэн Зөвлөх хороо нь зөвлөмж гаргах, зөвлөгөө өгөх эрхтэй. Зөвлөмж, асуулт, шүүмжлэл зэргийг хурлын тэмдэглэлд бүрэн тэмдэглэж, хурлын дараа 15 хоногийн дотор Зөвлөх багаас түүний хариуг нь өгсөн байна.

6.3. МОУӨБ нь Зөвлөх хорооны хурлын эцсийн тайлан, зөвлөмж, дэмжих бичиг эсвэл шүүмжлэл зэргийг монгол, англи хэл дээр үйлдэн "Оюу Толгой" ХХК-аар дамжуулан нийтэд нээлттэй болгоно.

## 7.0. ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

7.1. Зөвлөх хорооны хурлын товыг Зөвлөх баг товлож, хурал болох хугацаа, хөтөлбөр, бусад мэдээллийг бүх гишүүдэд хүргүүлнэ.

7.2. Зөвлөх хорооны хурал нь Улаанбаатарт эсвэл Өмнөговь аймагт зохион байгуулагдана.

7.3. Хэрэв шаардлагатай гэж үзвэл, Зөвлөх хорооны гишүүдтэй тохиролцсоны үндсэн дээр гадны төлөөлөгчдийг тусгай хуралдаанд оролцуулна.

7.4. Зөвлөх хорооны хурлын хөтөлбөрийг хурлын дараа ажлын хоёр хоногт багтаан боловсруулна.

## 25. ХАВСРАЛТ 16. СОЁЛЫН ӨВИЙН ХӨТӨЛБӨР БОЛОВСРУУЛАХ ЗӨЛДӨХ ХОРООНЫ УУЛЗЛАТЫН ТЭМДЭГЛЭЛ

### 1. Соёлын Өвийн Хөтөлбөр боловсруулах Зөвлөх Хорооны уулзалтын тэмдэглэл

**Огноо:** **2010 оны 12-р сарын 16-ны өдөр**
**Уулзалтын байр:** Улаанбаатар хот, Моннис цамхаг, Оюу Толгой компани, 6-р давхар

**Хуралд оролцогсод:**

| | | | |
|---|---|---|---|
| Б.Артаг | Зөвлөх хорооны гишүүн | н.Сандагсүрэн | Зөвлөх хорооны гишүүн |
| Р.Барсболд | Зөвлөх хорооны гишүүн | Ж.Саруулбуян | Зөвлөх хорооны гишүүн |
| Ц.Бат-Өлзий | Зөвлөх хорооны гишүүн | Х.Сугир | Зөвлөх хорооны гишүүн |
| Х.Батболд | Зөвлөх хорооны гишүүн | Н.Уртнасан | Зөвлөх хорооны гишүүн |
| Т.Галбаатар | Зөвлөх хорооны гишүүн | А.Цоож | Зөвлөх хорооны гишүүн |
| Б.Дэндэвсамба | Зөвлөх хорооны гишүүн | Д.Цэвээндорж | Зөвлөх хорооны гишүүн |
| Ц.Отгонтуяа | Зөвлөх хорооны гишүүн | Б.Түвшинбаяр | Зөвлөх хорооны гишүүн |
| Б.Гүнчинсүрэн | МОУӨБ | Л.Пүрэвдулам | МОУӨБ |
| Ч.Амартүвшин | МОУӨБ | Эйми Секстон | МОУӨБ |
| Х.Цогтбаатар | МОУӨБ | О.Цэрэннадмид | ОТ ХХК |
| С.Чулуун | МОУӨБ | н.Батзориг | ОТ ХХК |
| Ж.Гэрэлбадрах | МОУӨБ | С.Нэргүй | Хурлын чиглүүлэгч |

**Хуралд оролцож амжаагүй:** Ч.Куланда (Зөвлөх хорооны гишүүн)

**Хурлын протокол:**

| № | Хурлын хөтөлбөр |
|---|---|
| 1. | Зөвлөх хорооны хурлыг нээж ОТ компаний төлөөлөгч үг хэлэх<br>Хуралд оролцогсод өөрсдийгөө танилцуулах |
| 2. | “Соѐлын Өвийн Хөтөлбөр (СӨХ) гэж юу вэ?” (Илтгэгч – Б.Гүнчинсүрэн)<br>a) ОТ болон соѐлын өвийн хөтөлбөр боловсруулах төслийн танилцуулга<br>b) СӨХ боловсруулах төслийн зорилго<br>c) ОТ СӨХ-ийн талаарх хүмүүсийн бодол, Монгол улс дахь соѐлын өвийн өнөөгийн нөхцөл,байдал |
| 3. | Зөвлөх багаас хүлээж буй хүлээлт (Илтгэгч – Б.Гүнчинсүрэн)<br>a) Зөвлөх багийн үүрэг,зорилго. Зөвлөх багийн ажиллах хүрээ,үүрэг,зорилтыг тодорхойлсон бичиг баримтыг танилцуулав. |
| 4. | СӨХ төслийн талаар (Илтгэгч – Б.Гүнчинсүрэн)<br>a) СӨХ боловсруулах төслийн судалгааны багууд |
| 5. | Биет өвийн судалгааны багийн ажлын явц<br>• Археологи (Илтгэгч – Ч.Амартүвшин)<br>  • Соѐлын өвийн хадгалалт,хамгаалалтын талаар дурьдсан Монгол улсын хууль тогтоомжууд<br>  • Монгол улсын хэмжээнд олгогдсон уул уурхайн лицензүүд,эдгээр лицензийн талбайн хэдэн хувьд археологийн малтлага,судалгаа хийгдээд байгаа талаар<br>  • Соѐлын өвийг хамгаалахад юу дутагдаж байна вэ? |

| | |
|---|---|
| | • Оюу Толгой орчимд 2003-2010 онуудад хийгдсэн авран хамгаалах судалгааны тойм<br>• СӨХ-ийг боловсруулах ажлын хүрээнд бид юу хийж байна вэ? Ном зүйн судалгаа, мэдээллийн сан,газрын зураг боловсруулах,хээрийн судалгаа,мэдээллийг дүгнэх г.м<br><br>• Палеонтологи (Илтгэгч – Х.Цогтбаатар)<br>  • ОТ нөлөөллийн бүсүүд<br>  • ОТ орчмын палеонтологийн гол дурсгалт газрууд |
| 6. | *2-5 дугаар дахь илтгэлүүдийн асуулт,хариултын хэсэг* (Чиглүүлэгч – С.Нэргүй)<br>*Хэлэлцүүлэг*<br>• “Advisory Board” гэдгийг Монгол хэл рүү хэрхэн буулгах вэ?<br>  ○ Advisory Board гэдэг үгийг “Зөвлөх хороо” гэж хэрэглэх дээр тогтов.<br>  ○ МОУӨБагийг цаашид “Зөвлөх баг” гэж нэршихээр тогтов.<br>• Нөлөөллийн бүс,нөлөөллийн сум гэсэн ойлголт: СӨХ боловсруулах явцад уг ойлголтыг нэгтгэн,нэг нэршил дээр тогтох хэрэгтэй (палеонтологийнхон нөлөөллийн бүс гэсэн үгээр явж байгаа бол археологийн судлаачид нөлөөллийн сумд гэсэн ойлголт хэрэглэж байна.)<br>• ОТ төслийн хувьд дараах 4 сумдыг өөрсдийн шууд нөлөөллийн талбайд тооцдог. Эдгээр нь: Ханбогд, Манлай, Баян-Овоо,Даланзадгад. Иймд ОТ компаний тендерийн материалд тодотгож өгсний дагуу (1) дээрх 4 сумд (2) Өмнөговь аймаг (3) Монгол улс гэсэн байдлаар манай баг нөлөөллийн судалгааг хийж байна.<br>• Зөвлөх багийн гишүүд соѐлын өвийн хамгаалалтыг сайжруулахад (1) соѐлын өвийг хадгалж,хамгаалах талаарх сургалтыг бүх нийтэд хүртээмжтэй болгох; (2) хуулийг чангатгах,хуулийн өмнө бүгд эрх тэгш байх гэдэгтэй санал буй хэдий ч  гурав дахь арга зам зайлшгүй байх хэрэгтэй гэж үзэж байгаагаа илэрхийлсэн боловч энэ нь чухам юу байх хэрэгтэй талаар тодорхой зүйл хэлээгүй.<br>• Зөвлөх багийн бүрэлдэхүүнд Өмнөговь аймгийн бүх сумдаас төлөөлөл оруулах талаар: ОТ компаний тендерийн материалд 4 сумыг онцгойлон шууд нөлөөллийн бүс гэж байсан тул бид эдгээр сумдын төлөөллийг зөвлөх багийн бүрэлдэхүүнд багтаасан. Гэсэн хэдий ч нутгийн иргэдтэй хийх зөвлөлдөх уулзалтыг үүнээс өргөн хүрээнд хийж буйн зэрэгцээ сум бүрийн төлөөлөлтэй уулзаж,ярилцсан.<br>• Дурсгалуудыг олж бүртгэх талаар. Сум,орон нутаг,улсын хэмжээнд бүртгэсэн эсэх?  Хээрийн судалгааны үед хаана,ямар дурсгалууд байгаа талаар ерөнхий судалгаа хийж байсан бөгөөд СӨХ боловсруулах хөтөлбөрийн хүрээнд хайгуулын лиценз ашиглалтын лиценз болох үед эдгээр дурсгалуудыг нэг бүрчлэн судлах шаардлагатай гэсэн санал зөвлөмжүүдийг боловсруулна. Дурсгалуудын талаар СӨХ боловсруулах судалгааны ажлын мэдээллийн санд бүртгэж авсан. |
| 7. | Биет бус өвийн багийн ажлын явц (Илтгэгч – С.Чулуун)<br>• Биет бус өвийн судалгааг үндсэн 3 хүрээнд хийсэн ба эдгээр нь соѐлын өвийн хөтөлбөрийн биет бус өвийн хэсгийг боловсруулахад суурилж, улмаар хамруулах биет бус өвүүдийг тодруулах, өвт газар, газар усны нэр, биет бус өв тээгчдийн жагсаалт, газрын зураг гаргах, Монголын соѐлын суурь дэг журам, биет бус тээгдэх нөхцөл болсон бэлчээрийн мал аж ахуй эрхлэн амьдрах нөхцлийн талаар суурь судалгаа явуулах болно.<br>• Биет бус өвийн судалгаа явуулсан арга зүй<br>• Шууд ба шууд бус нөлөөллийн бүс дэх нутгийн олны ач холбогдол, үнэ цэнэ өгч биет бус өвүүдийг тодорхойлох |
| 8. | 7 *Асуулт,хариултын хэсэг* (Чиглүүлэгч – С.Нэргүй)<br>*Хэлэлцүүлэг* |

| | |
|---|---|
| | • Дараах биет бус өвүүдийгмаш сайн анхаарч судлах. Үүнд:гар урлал,хөгжмийн зэмсгүүд,мөн дан ганц уртын дуу төдийгүй ардын дуу,үлгэр,домгууд.<br>• Нутгийн иргэдийн онцолж буй биет бус өвүүдийг 13 ерөнхий ангилалд хуваасан бөгөөд дээрх бүгд эдгээр ангилалд багтсан.<br>• Биет бус өвийн судалгаа нь Монголд шинэ тутам хөгжиж байгаа бөгөөд уг төслийн судалгааны хувьд биет бус өвийн судалгаа ерөнхийдөө зөв чиглэлд явж байна гэдгийг зөвлөх хорооны гишүүд онцолж байсан.<br>• Биет бус өвийн судалгааны аргазүйн талаарх асуудал хөндөгдсөн бөгөөд судлаач С.Чулуун антропологийн судалгааны аргазүйн нэг онцлог нь тухайн судлаач ярилцагчийнхаа яриаг таслалгүй,үзэл бодлыг нь хүндэтгэн сонсох нь гол баримтлах зүйл гэдгийг онцолж,тайлбарласан.<br>• Уул уурхайн үйл ажиллагаа болон бусад шалтгааны улмаас газар усны нэр маш их өөрчлөгдөж байгаа. Ялангуяа уул уурхайн компаниуд өөрсдийн лицензийн талбайн нэрийг дураар өгдөг ба хууль эрхзүйн орчны шинэтгэлийн ажлын хүрээнд газар усны нэрийг дураар өөрчилж болохгүй гэдгийг тодорхой тусгаж,шаардах хэрэгтэй гэсэн саналыг зөвлөх хорооны зарим гишүүд гаргаж байсан. |
| 9. | Олон нийтийн хөтөлбөрийн ажлын явц (Илтгэгч – Ж.Гэрэлбадрах)<br>• ОТ СӨХ-ийн олон нийтийн хөтөлбөрийн судалгааны явц,зарим үр дүнгүүд<br>• “Оюу толгой” төслийн ажлын явцад уламжлалт соёлын өвийн тухайд үүсч бий болох эерэг болон сөрөг нөлөөллийн талаар Өмнөговь аймгийн олон нийтийн санаа зовоож байгаа зүйлс<br>• Орон нутгийн музей,соёлын төвүүд болон аймгийн аялал жуулчлалын газруудтай танилцаж,уулзалтууд хийсэн<br>• Хээрийн судалгаа |
| 10. | *9 Асуулт,хариултын хэсэг* (Чиглүүлэгч – С.Нэргүй)<br>*Хэлэлцүүлэг*<br>• Говийн их,бага дархан газрууд нөлөөллийн сумдад багтаж байгаа эсэх талаар зөвлөх хорооны гишүүд сонирхсон ба Ханбогд сумын урд хэсэг нь Говийн бага дархан газарт багтдаг. |
| 11. | Цайны завсарлага |
| 12. | Соёлын өвийн талаарх хууль эрхзүйн одоогийн орчин (Илтгэгч – Б.Гүнчинсүрэн)<br>• Соёлын өвийн хууль, эрхзүйн орчин<br>• Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ,конвенциуд<br>• Соёлын өвийн хадгалалт,хамгаалалттай холбоотойгоор хууль,эрхзүйн орчинд хийгдэх шаардлагатай өөрчлөлтүүд |
| 13. | Монголын соёлын өвийн шинэ бүтэц (Илтгэгч – Б.Гүнчинсүрэн)<br>• МОУӨБагийн санал болгож буй соёлын өвийн хууль,эрхзүйн шинэ бүтэц,тогтолцоо |
| 14. | 12-13 *Асуулт,хариултын хэсэг* (Чиглүүлэгч – С.Нэргүй)<br>*Хэлэлцүүлэг*<br>• МОУӨБагийн санал болгож буй шинэ бүтэц яагаад ч бүтэхгүй гэж ихэнх гишүүд үзэж байсан бөгөөд учир нь:<br>a. Олон газраас зөвшөөрөл авах хэрэгтэй болно;<br>b. Олон газар,даргаас зөвшөөрөл авах шаардлагатай болох тул аливаа шинэ төсөл эхлэх гэж маш удна,цаг их авна гэж зөвлөх хорооны гишүүд үзэж байсан.<br>• Одоо байгаа хууль тогтоомжийн хэрэгжилт маш хангалтгүй байгаа. Жишээ нь: Ашигт малтмалын хуулийн дагуу лицензийн төлбөрийн 50 хувь улсын төсөвт,25 хувь аймгийн төсөвт,үлдсэн 25 хувь нь сумын төсөвт орох ѐстой байдаг боловч харамсалтай нь хуулийн уг заалт бодит амьдралд хэрэгжихгүй байгаа. Хэрэв уг хуулийн заалт хэрэгждэг бол аймаг,сум өөрийн авч буй хувийн тодорхой хэсгийг соёлын өвийн хадгалалт,хамгаалалтад зарцуулахад |

| | |
|---|---|
| | болохгүй зүйл байхгүй. |
| 15. | Зөвлөх хорооны дотоод зохион байгуулалт<br>• Уг асуудлыг хэлэлцэх үед ОТ ХХК болон МОУӨБагийн төлөөлөл байгаагүй болно. |
| 16. | Зөвлөх хорооны зүгээс ОТ ХХК болон МОУӨБагт өгөх тайлан (Чиглүүлэгч – С.Нэргүй)<br>*Хэлэлцүүлэг*<br>• Зөвлөх хорооны гишүүд Б.Түвшинбаярыг даргаар,Ц.Отгонтуяаг нарийн бичгийн даргаар сонгосон болохоо хэлсэн.<br>• Аливаа нэгэн дэд хороогүй байх ба бүх асуудлыг нийт гишүүдийн дунд хэлэлцэнэ. |
| 17. | Дараагийн алхамууд (Чиглүүлэгч – С.Нэргүй)<br>• МОУӨБагийн дараагийн хийгдэх ажлууд:<br>i. Нэгдүгээр үе шатны тайлан дээр ажиллаж байна<br>ii. Уг хурлаас гарсан санал,зөвлөмжүүдийн дагуу зохих өөрчлөлтүүдийг хийнэ. Үүнд: хууль эрхзүйн орчныг сайжруулах диаграм анхны байдлаар гараад байгааг өнөөдрийн хурал дээр танилцуулсан ба үүнтэй холбоотой зөвлөх хорооны гишүүдийн саналыг авч,сайжруулах,өөрчилөх.<br>• Зөвлөх хорооны санал,зөвлөмжүүд:<br>i. СӨХ боловсруулалт нь 5 эсвэл 10 жилийн төлөвлөгөөтэй,1 жилийн хийгдэх ажлын хөтөлбөр,төсөвтэй,мөн уян хатан байдлаар хийгдэх ѐстой гэсэн саналыг зөвлөх хорооны гишүүд гаргасан.<br>• Зөвлөх хорооны гишүүд төслийн талбайд очиж үзэх хүсэлт гаргасан. Зөвлөх хорооны дараагийн уулзалт 2011 оны 2-р сард Өмнөговь аймгийн Ханбогд сумын нутагт болно. Төслийн талбайтай танилцаж болох эсэх талаар ОТ компанитай ярилцах. |
| 18. | Хурлын хаалт. |

## 2. Соёлын Өвийн Хөтөлбөр боловсруулах Зөвлөх Хорооны уулзалтын тэмдэглэл

**Огноо:** 2011-03 сарын 21
**Байршил:** Өмнөговь аймгийн Ханбогд сум

**Оролцогчид:**

| | |
|---|---|
| Б.Артаг | Зөвлөх хороо |
| Сандагсүрэн | Зөвлөх хороо |
| Ц.Бат-Өлзий | Зөвлөх хороо |
| Ж.Саруулбуян | Зөвлөх хороо |
| Х.Батболд | Зөвлөх хороо |
| Х.Сугир | Зөвлөх хороо |
| Оюунчулуун | Зөвлөх хороо /Баян Овоо сумын з/д Батболдыг 1 дэх өдөр орлосон./ |
| Н.Уртнасан | Зөвлөх хороо |
| Б.Дэндэвсамба | Зөвлөх хороо /Засаг даргыг орлож засаг даргын орлогч/ |
| Д.Цэвээндорж | Зөвлөх хороо |
| Ц.Отгонтуяа | Зөвлөх хороо |
| А. Цоож | Зөвлөх хороо |
| Б.Гүнчинсүрэн | МОУӨБ |
| Л.Пүрэвсүрэн | МОУӨБ |

Ч.Амартүвшин МОУӨБ
Эйми Секстон МОУӨБ
н.Цогтбаатар МОУӨБ
О.Цэрэннадмид ОТ
С.Чулуун МОУӨБ
н.Батзориг ОТ
Ж.Гэрэлбадрах МОУӨБ

**Хүрэлцэн ирж амжаагүй хүмүүс:**
Ч.Куланда,
Т.Галбаатар,
Р.Барсболд,
Б.Түвшинбаяр (Зөвлөх хороо)

## Тэмдэглэл:

| | |
|---|---|
| | Бодит өвийн судалгааны багийн ахлагч Ч. Амартүвшин оролцогчдод Соёлын Өвийн хөтөлбөр боловсруулах зөвлөх багийн 2-р уулзалтанд оролцохоор хүрэлцэн ирсэнд талархал илэрхийлээд уулзалтыг нээлээ.<br>Нээлтийн үеэр Ч. Амартүвшин уулзалтанд оролцогчдыг тухайлбал судалгааны олон улсын багийн ахлагч Жефф Алтшүл, зөвлөх багийн гишүүн Баян-Овоо сумын засаг даргын зөвлөлийн гишүүн Оюунчулуун нарыг тус тус танилцууллаа.<br>Тэрээр соёлын өвийн хөтөлбөр боловсруулах төслийн зорилго, төслийн хамрах хүрээ, төсөл боловсруулах ажлын үйл явц, ололт амжилт, тайлан болон судалгааны багийн цаашдын ажлын төлөвлөгөөний талаар тодохой илтгэл тавилаа. |
| | Уулзалтын гол зорилгыг танилцууллаа.<br>1- шатны тайлан буюу соёлын өвийн өнөөгийн бодит байдлын үнэлгээн дээр оролцогчдын санал дүгнэлтийг авах замаар судалгааны тайлангийн ажлын чанар, агуулгыг сайжруулах<br>Биет, биет бус болон олон нийтийн хөтөлбөрийн багуудаас гаргасан ойрын, дунд, урт хугацааны ажлын төлөвлөгөөг эрэмбэлэх тал дээр зөвлөлийн гишүүдийн санал дүгнэлтийг авч, цаашдын ажилдаа тусгаж ажиллах<br>Соёлын өвийн хөтөлбөрийн хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөний бүтэц, элементүүдийг хорооны гишүүдэд танилцуулан санал дүгнэлт авах |
| | Бодит өвийн судалгааны багийн ахлагч Ч. Амартүвшин уулзалтын зорилгын хүрээнд дараах чиглэлээр тодорхой илтгэл тавилаа.<br>Баг тус бүрийн ойрын, дунд, урт хугацаанд хийх ажлын төлөвлөгөөг танилцуулж, цаашид авч хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай үйл ажиллагаануудыг танилцууллаа. Уг илтгэлд одоогийн мөрдөж буй хуулийг өөрчлөх шаардлагууд, хөтөлбөрийг боловсруулах ажлын цаг хугацааны хүчин зүйлс, Өмнөговь аймагт орчин үеийн эрэлт хэрэгцээнд нийцсэн соёлын төвийг байгуулах арга зам, Засгийн газрын агентлагуудын түвшинд соёлын өвийн мэргэжилтнүүдийг бэлтгэх, чадваржуулах хэрэгцээ шаардлага, Оюу Толгой төслийн Монголын Соёлын өвийг хамгаалах хууль тогтоомжтой нийцэж ажиллах боломж, ОТ төслийн удирдах шатны менежерүүдэд соёлын өвийг хамгаалах чиглэлээр удирдамж боловсруулан өгч үйл ажиллагаандаа мөрдлөг болгож ажиллах саналын талаар зэрэг хөтөлбөр боловсруулах ажлын ойрын болон дунд хугацааны ажлын төлөвлөгөө<br>урт хугацаанд хийгдэхээр төлөвлөгдөж буй хуулийн биелэлтэнд хяналт тавьж мөрдөж ажиллах, соёлын өвд нөлөөлөх уул уурхай бусад аливаа үйл ажиллагаанд мөрдөж ажиллах зарчим шаардлагуудыг боловсруулах, Өмнөговь аймгийн дутмаг |

| | |
|---|---|
| | судлагдсан бусад сумуудын нутаг дэвсгэрт археологи, палентологийн судалгааг үргэлжлүүлэн явуулах ажлын санал, биет бус өвийн хувьд биет бус өвийн элементүүдийг хөгжүүлэх хөхүүлэн дэмжихэд чиглэгдсэн соѐлын өвийн цогц хөтөлбөрийн шаардлага<br>Олон нийтийн хөтөлбөрийг тогтворжуулах талаар хэлэлцүүлэг<br>Насанд хүрэгчдэд зориулсан соѐлын өвийн хөтөлбөрийн талаар хэлэлцүүлэг<br>Соѐлын өв дээр түшиглэсэн аялал жуулчлал зэрэг асуудлыг хөндөж ярилаа.<br>Мөн түүнчлэн соѐлын өвийн хүрээнд хийгдэх ажлын төлөвлөгөөний 7 элементийг тус бүрээр нь оролцогчдод танилцууллаа. Уг илтгэлд соѐлын өвтэй холбоотой төрийн бодлого, соѐлын өвийн хөтөлбөрийг санхүүжүүлэх бүтэц тогтолцоо, Соѐлын өвийг хамгаалах төвийн холбогдох хууль тогтоомж, олон улсын конвенцийг дагаж мөрдөх арга зам, биет өвийн судалгааг үргэлжлүүлэн явуулах нэгдсэн мэдээлэлийн сан байгуулан ажиллуулах, биет бус өвийн бүртгэл, хадгалалт, хамгаалалт, ашиглалт, бага болон насанд хүрэгчдийн боловсролыг нэмэгдүүлэх, талуудын оролцоо зөвлөгөө, орон нутгийн чадавхийг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг хамруулсан. |
| | Судалгааны баг тус бүрээс Соѐлын өвийн хөтөлбөр боловсруулах төслийн 1-р шатны үйл ажиллагааны тайланг тавилаа.<br>Олон нийтийн хөтөлбөрийн судалгааны багийн тайлан /багийн ахлагч Ж.Гэрэлбадрах/ Энэ тайланд судалгааны ажлын урьдчилсан дүн, ируудүйд хийх ажлын төлөвлөгөө, олон нийтийн боловсролыг насны ангилалаар явуулах арга замууд, оролцогч талуудын хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтын арга замууд, мэргэжилтэн бэлтгэх, сургалтын талаар товч танилцууллаа.<br>Биет бус өвийн судалгааны багийн танилцуулга / Судалгааны багийн ахлагч Чулуун/ Энэ тайланд биет бус судалгааны багийн сүүлийн хагас жилийн үйл ажиллагааны тайлан, судалгааны 7 үндсэн үе шатанд хийгдсэн үйл ажиллагаа, 150 орчим соѐлын биет бус өвийг шинээр ба дахин тодруулж гаргасан жагсаалт зэргийг танилцууллаа.<br>Биет өвийн судалгааны багийн тайлан /бодит өвийн судалгааны багийн ахлагч Ч. Амартүвшин/ Энэ илтгэлд судалгааны явцад хийгдсэн үйл ажиллагаа, ашигласан ном зүй, судалгааны материалууд, судалгааны аргачлал, цаашид хийх ажил, судалгаанаас гарсан санал зөвлөмжийн талаар товч танилцууллаа. |
| | Олон нийтийн хөтөлбөрийн судалгааны багийн илтгэлтэй холбоотой санал дүгнэлтүүд<br><br>Энэ судалгааны ажилд ахмадын байгууллагуудыг өргөнөөр оролцуулах замаар ахмад үеийн хүмүүсийнхээ түүх, ѐс заншил,уламжлалын талаар өргөн цар хүрээтэй мэдлэг мэдээлэлийг өвлөн авах нь зүйтэй санагдаж байна. Нийт 14 сум ахмадын өргөөтэй. Энэ тал дээр ахмадын байгууллагын боломж бололцоо асар их байдаг.<br>ЕБС-д заах багшлах боловсон хүчнийг бэлтгэх ажил чухал. Сургуулийн нийгмийн ухааны багш, музейн ажилтан, номын санч нарыг хүүхдүүдэд соѐлын өвийн боловсрол олгоход хамтад нь бэлтгэвэл зөв гэж бодож байна. Энэ чиглэлээр чадварлаг багш нарыг өргөнөөр хамруулах<br>Соѐлын өвийн талаар байгаль хамгаалагчид, багийн дарга нарын мэдлэг туйлын дутмаг байдаг. Тиймээс тэдэнд зохих хэмжээний мэдлэг боловсрол олгох ажлын төлөвлөгөөндөө тусгавал сайн .<br>Музей, сургуулиудын хоорондын хамтын ажиллагааг сайжруулах асуудал чухал байна. Зайн сургалтыг сумын түвшинд явуулах нь зөв. Түүнчлэн ахмадуудыг энэ ажилд дайчлах, тэдний хүч чармайлтыг ашиглах хэрэгтэй.<br>Биет бус өвийг онцгой анхаарах ѐстой. Энэ нь хүнээ дагаад алга болж устдаг зүйл. Өнөөдөр бидэнд хүн ам зүйн шилжилт хөдөлгөөний суурь судалгаа хийх хэрэгтэй гэж санагдаж байна. Соѐлын өвийн талаар заах хүн хүч бидэнд үлдэж байна уу үгүй юу. Орчин үеийн техник, технологийг ашиглан амьдралын чанарыг сайжруулахын зэрэгцээ соѐлын элементүүдийг нь хадгалж үлдэх арга байна уу гэдгийг бас бодох хэрэгтэй. |

| | |
|---|---|
| | Өнөөдөр энэ орон нутагт бүгд л уул уурхайн салбарт ажиллах сонирхолтой болжээ. Малаа маллаад нүүдлийн соел иргэншлийг дагах хүсэлтэй идэр насны хүмүү их цөөрчээ. Соѐлын өвийг хадгалж хамгаалахад аймгийн музей чухал үүрэг гүйцэтгэх ѐстой гэж бодож байна.<br>ОТ-н нөлөөлөлийн сумдад тодорхой стандартад нийцсэн музей байгуулах болон музейн боловсон хүчнийг бэлтгэх асуудалд аймгийн засаг даргын тамгын газраас анхаарч тодорхой үе шаттай арга хэмжээ авч ажиллах хэрэгтэй байна.<br>Соѐлын төвөөс олгож буй санхүүжилт маш бага энэ чиглэлээр үйл ажиллагааг санхүүжүүлэх боломж бараг байхгүй<br>Соѐлын өвөө сайтар хамгаалж байгаа олон улсын бодит жишээтэй газар дээр нь очиж танилцах замаар мэдлэг, туршлага мэдээлэл солилцох чухал байна. Жишээ нь: Өвөрмонгол, Халимаг гэх мэт |
| | Биет бус өвийн судалгааны багийн илтгэлтэй холбоотой санал дүгнэлтүүд<br><br>Судалгаанд үндэслээд ямэр биет бус өвийн хөтөлбөрүүдийг боловсруулан хэрэгжүүлэх боломжтой байгааг сайтар тодруулбал зүгээр байна.<br>Тодорхой биет бус өвүүдийг төрөөс бодлогоор дэмжих хэрэгтэй байна. Соѐлын биет бус өвийн бүтээгдэхүүний эдийн засгийн хөшүүргийг тодорхой бодлогоор дэмжиж өгвөл сайн.<br>Соѐлын өвийн талаар ойлголт мэдлэгийг сургалтын програмд оруулах нь зөв санал байна.<br>Овог ургын нэр, ургийн хэлхээ холбооны талаар дурдлаа. Иргэний үнэмлэх дээр бичигдсэн ургийн овог бараг 30-40 хувь нь оноогүй буруу байна. Иймээс цахим үнэмлэх гарах үед энэ асуудлыг дахин авч үзэж үнэн зөв мэдээлэл оруулах хэрэгтэй байна..<br>Бэлчээрийн өвс ургамлыг таниулах заах ажлыг эрчимжүүлэх нь маш зөв байна. Өнөөдөр идэр насны малчдын дунд бэлчээрийн ургамлаа мэдэхгүй хүн маш олон болжээ.<br>Ахмадуудаа амьд сэрүүн байгаа дээр нь ахмадын байгууллагаа дэмжиж туслаад энэ судалгааг хамтран зохион байгуулах<br>Биет бус өвийн элементүүдийг CD, DVD дээр бичээд үлдээмээр байна. Биет бус өв нь хүнээс хүнд уламжлагдан үлддэг тул шавь төвтэй сургалтын аргыг хэрэглэх нь үр дүнтэй. |
| | Биет өвийн судалгааны багийн үйл ажиллагааны тайлантай холбоотой санад дүгнэлтүүд<br>Аймгийн ЗДТГ-ийн шууд удирдлага дор соѐлын судалгааны төвийг байгуулах нь зүйтэй.<br>Соѐлын өвөө хамгаалах ажил дээр орон нутгийн өөрөө удирдах байгууллагын оролцоо туйлын чухал байдаг.<br>Судалгаанд олон талын оролцоог дэмжих асуудлыг ярьж байна. Гэхдээ аль тал юу хийх ажил үүргийн чиглэлийг маш сайтар боловсруулан гаргах хэрэгтэй<br>Орон нутаг бүр биет, биет бус өвийн судалгааны төв, музей, эрдэм шинжилгээний төв, чадварлаг сайтар бэлтгэгдсэн мэргэжилтнүүд маш чухал байна.<br>Орон нутагт хийсэн судалгааны ажилд нийт судалгааны ажлын цагийн 1/3-г зарцуулсан.<br>Манай нутагт байгалийн өвөөр дэлхийн өвд орох хэд хэдэн газар бий. Энэ асуудалд анхаарах хэрэгтэй байна.<br>Тухайн орон нутагт тохирсон бүтээлч өвийн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж өгөх хэрэгтэй байна.<br>Өмнөговь аймгийн бүхий л суманд соѐлын өвийн загвар боловсруулж хэрэгжүүлэхэд их хүн хүч, хугацаа орно. Иймээс эхний ээлжинд шууд нөлөөлөлд буй 4 сумандаа соѐлын өвийг хамгаалах загвар хөтөлбөр боловсруулаад хэрэгжүүлэх нь зөв байна.<br>Соѐлын өвийг хадгалах хамгаалах ажил зөвхөн Оюу Толгой компаний ажил биш ээ. |

| | |
|---|---|
| | Энэ ажилд тухайн орон нутгийн засаг захиргаа, төрийн бус байгууллага, үйл ажиллагаа явуулж буй бусад компаниуд бүгд нэгдэж оролцох хэрэгтэй байна.<br>Өмнөговь аймгийг тэмээгүйгээр төсөөлж болохгүй.  Тэмээг өсгөж үржүүлэхийг дэмжсэн олон төрлийн өндөр шагнал урамшуулалтай тэмцээн уралдаан явуулах талаар санал оруулбал зүйтэй байна. Жишээ нь хамгийн сүүтэй ингэ шалгаруулах, тэмээний сүүг боловсруулах жижиг дунд оврын боловсруулах цех байгуулан түүхий эдийг боловсруулан уул уурхайн компаниудын ажилчдын хоол хүнсэнд нийлүүлэх боломжийн талаар тайландаа тусгавал сайн байна.<br>Уул усны нэр, нэршлийг ашигт малтмалын лиценз авахдаа дуртай нь өөрчлөн нэрлэх болжээ. Иймээс уламжлалт нэршлийг хэрэглэх практикийг лиценз олголтонд анхаарах талаар хуульд санал оруулах нь зүйтэй байна.<br>Эхний ээлжинд энэ 3 судалгааг ОТ энэ 4 суманд хийлээ. Цаашдаа энэ судалгааг бусад суманд үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниуд явуулах тал дээр орон нутаг шаардаж ажиллах талаар санал нэммээр байна.<br>Судалгаа хийлээ, цаашид хэрхэн хадгалж хамгаалах менежментийг маш тодорхой болгох хэрэгтэй байх. Энэ тал орхигдох гээд байдаг. |
| | Уулзалтыг хааж судалгааны багийн ахлагч Ч. Амартүвшин үг хэлж маргааш болох соѐлын өвийн эрсдлийн үнэлгээний уулзалтын талаар товч танилцуулга хийлээ. |